Зураг 226. Ойн эзэмшлийн төлөвлөлт .....	447
Зураг 227. Аймгийн ойн дагалт баялгийн тархалт, нөөц .....	449
Зураг 228. Цахир мандалт уулын агнуурын бүс нутаг .....	451
Зураг 229. Аймгийн авто замын газар .....	454
Зураг 230. Завхан аймгийн шугам сүлжээний газар .....	460
Зураг 231. Авто болон төмөр замын төлөвлөлт .....	464
Зураг 232. Авто болон төмөр замын газрын төлөвлөлт, хэрэгжүүлэх хугацаагаар ..	465
Зураг 233. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийн төлөвлөлт /2015-2030 он/ .....	469
Зураг 234. Шугам сүлжээний газрын төлөвлөлт .....	473
Зураг 235. Завхан аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн байдал ..	476
Зураг 236. Улсын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт .....	478
Зураг 237. Аймгийн тусгай хамгаалалтад авах газрын төлөвлөлт .....	479
Зураг 238. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газрын төлөвлөлт .....	480
Зураг 239. Алдархаан сумын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт .....	485
Зураг 240. Асгат сумын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлтийн зураг .....	487
Зураг 241. Баянтэс сумын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлтийн зураг .....	488
Зураг 242. Баянхайрхан сумын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт .....	490
Зураг 243. Дөрвөлжин сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	497
Зураг 244. Завханмандал сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт ..	502
Зураг 245. Идэр сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	506
Зураг 246. Их-Уул сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	507
Зураг 247. Нөмрөг сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	510
Зураг 248. Отгон сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	512
Зураг 249. Сантмаргац сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	515
Зураг 250. Сонгино сумын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт .....	517

Зураг 251. Тосонцэнгэл сумын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт.....	521
Зураг 252. Түдэвтэй сумын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт .....	523
Зураг 253 Тэлмэн сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	533
Зураг 254. Тэс сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт.....	537
Зураг 255. Ургамал сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	540
Зураг 256 Цагаанхайрхан сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт ...	546
Зураг 257 Цагаанчулуут сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт.....	550
Зураг 258 Цэцэн-Уул сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	551
Зураг 259. Улиастай сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт.....	553
Зураг 260 Шилүүстэй сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	555
Зураг 261 Эрдэнэхайрхан сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт...	558
Зураг 262 Яруу сумын тусгай хамгаалалттай газар нутгийн төлөвлөлт .....	560
Зураг 263. Завхан аймгийн тусгай хэрэгцээний газрын өнөөгийн байдал .....	579
Зураг 264 . Завхан аймгийн аймаг дундын отрын бэлчээрийн одоогийн байдал.....	579
Зураг 265. Завхан аймгийн тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт .....	580
Зураг 266. Баруун бор толгой уурхайн дүйцүүлэн хамгаалалт хийх газар .....	582
Зураг 267. Баян-Айргийн уурхайн дүйцүүлэн хамгаалалт хийх газар .....	583
Зураг 268. Баруун шувуун уурхайн газрын дүйцүүлэн хамгаалалт хийх газар.....	583
Зураг 269. Зүрхийн хуудас уурхайн дүйцүүлэн хамгаалалт хийх газар .....	584
Зураг 270. Дэвтээр нуур уурхайн дүйцүүлэн хамгаалалт хийх газар .....	584
Зураг 271. Цавдан уурхайн дүйцүүлэн хамгаалалт хийх газар .....	585
Зураг 272. Од уурхайн дүйцүүлэн хамгаалалт хийх газар .....	585

# **НЭГ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЕ ШАТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

## **1.1 АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ**

1. Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь заалт
2. УИХ-ын 2001 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 57 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”
3. УИХ-ын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”
4. УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт, дунд хугацааны зорилтот хөтөлбөр”
5. УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” хөтөлбөр”
6. Газрын харилцаа геодези зурагзүйн газрын даргын 2013 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан “Газар өмчлөлийг эрчимжүүлэх чиглэл”
7. Геодези, зурагзүйн ажлын жишиг үнэ /БД81-103-06/
8. Зураг төслийн ажлын жишиг үнэ /БД 81-16-12/
9. Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021 он/
10. Завхан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 1 дүгээр сарын 8-ний өдрийн 6 дугаар тогтоол “Завхан аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр /2016-2020 он/”
11. Баруун бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 2006 он

## **1.2 ЗОРИЛГО**

Энэхүү газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зорилго нь Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах, шинжлэх ухааны үндэстэй нутагшил суурьшлын тогтолцоог сайжруулах, экологид ээлтэй, эдийн засгийн хувьд бие даасан, гадаад дотоодын харилцаа сайтай орчин үеийн газрын менежментийг хөгжүүлэхэд оршино.

Завхан аймгийн нутаг дэвсгэрт олон талт газар ашиглалтыг хөгжүүлж иргэд тав тухтай, аюулгүй, тайван орчинд аж төрж, эрүүл хүнсээр хангагдаж, сэтгэл санаагаар түвшин амгалан амьдрах боломжийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, ногоон эдийн засгийн хөгжил, өсөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Завхан аймгийн тогтвортой хөгжлийн газрын харилцааны удирдлагыг төгөлдөршүүлэх замаар бизнес эрхлэгчдээ дэмжин, хамтран ажиллаж, ажлын шинэ байр бий болгоход шинэ загвар бүхий газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж Завхан аймгийн иргэн бүрийг тогтвортой орлоготой байлгахад энэхүү газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний үндсэн зорилго оршино.



### 1.3 ЗОРИЛТ

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зорилгод хүрэхийн тулд дараах дэд зорилтуудыг тодорхойлж байна.

1. Газар ашиглалтын тогтвортой загварыг бий болгох
2. Газрын зах зээлийг дэмжих дэд бүтцийг сайжруулах
3. Завхан аймагт газрын харилцааны талаар тулгамдаж буй асуудлыг багасгах замаар газрын нөөц хуваарилалтыг сайжруулах
4. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэн газрын зах зээлийг хөгжүүлэх
5. Иргэдэд хүртээмжтэй нийгмийн үйлчилгээ, эрүүл аюулгүй орчныг бий болгох
6. Нэгдмэл харилцан уялдаа бүхий САЙН засаглал
7. Хөгжсөн дэд бүтэц- Суурьшлын оновчтой тогтолцоо бий болгох
8. Хүчтэй эдийн засаг-технологи- аялал жуулчлал бизнесийн төв

“Завхан-2033” хөтөлбөр дэх дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагааны стратегиудыг санал болгож байна.

### 1.4 ЗОРИЛТУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

Зорилт	Үйл ажиллагааны стратеги
<b>Зорилт 1</b>  Газар ашиглалтын тогтвортой загварыг бий болгох	1-1 Газар ашиглалтын тэргүүн ээлжинд хөгжүүлэх чиглэл, төрөл, тархалтыг тодорхойлох
	1-2 Газрын нөөц нөхцөлийг байгалийн болон ландшафт тогтоцын даац чадавхи боломжинд тулгуурлан газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилсан төлөвлөлтийн загварыг бий болгох
	1-3 Газар хадгалан хамгаалах бүс нутгийг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлон Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний сүлжээг өргөжүүлэх
	1-4 Газар ашиглалтын хориглох төрөл, чиглэлийг гаргах. <i>/Ураны хайгуул судалгаа г.м/</i>
	1-5 Бэлчээрийн болон ундны усны эх үүсвэрийн хангамжийг нэмэгдүүлэх
<b>Зорилт 2</b>	2-1 Газрын энгийн зах зээлээс цогц зах зээл рүү шилжихэд төрийн

Газрын зах зээлийг дэмжих дэд бүтцийг сайжруулах	<p>2-2 дэмжлэг туслалцаа үзүүлэх Цахим засаглал хөтөлбөрийн хүрээнд иргэдийн авдаг үйлчилгээг цахимжуулах</p> <p>2-3 Газар ашиглалтын олон төрөлт үйл ажиллагааг хөгжүүлэх</p> <p>2-4 Албан бус газар ашиглалтын хэмжээг тодорхойлон тэдгээрийг албан газар ашиглалтын системд оруулах</p>
<b>Зорилт 3</b> Газрын нөөц хуваарилалтыг сайжруулах	<p>3-1 Газрын дахин төлөвлөх бүс нутгийг тодорхойлж дахин төлөвлөлтөд хамруулах /Улиастай хот г.м/</p> <p>3-2 Усалгаатай тариаланг хөгжүүлэх нөөц нөхцөлийн төлөвлөлт хийх</p> <p>3-3 Хадлангийн талбайн нөөц нөхцөлийн төлөвлөлт хийх</p> <p>3-4 Бэлчээрийн менежментийг төгөлдөршүүлэх</p>
<b>Зорилт 4</b> Газар өмчлөлийг эрчимжүүлэх	<p>4-1 Газар өмчлөлийн хэрэгцээг сум бүрээр тодорхойлох</p> <p>4-2 Өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тодорхойлж үе шаттайгаар өмчлүүлэх төлөвлөгөө гаргах</p> <p>4-3</p>
<b>Зорилт 5.</b>  Иргэдэд хүртээмжтэй нийгмийн үйлчилгээ, эрүүл, аюулгүй орчныг бий болгох	<p>5-1 Ногоон байгууламж</p> <p>5-2 Цэнгэг ус, эрүүл хөрс</p> <p>5-3 Дөрвөн улирлын цэнгэг агаар</p> <p>5-4 Идэвхитэй амьдарлын хэв маяг</p> <p>5-5 Аюулгүй амгалан орчинг бүрдүүлэх</p> <p>5-6 Эрүүл мэндийн үйлчилгээ</p> <p>5-7 Боловсролын үйлчилгээ</p> <p>5-8 Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ</p>
<b>Зорилт 6.</b> Нэгдмэл харилцан уялдаа бүхий САЙН засаглал	<p>6-1 Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах</p> <p>6-2 Эрх зүйн орчныг сайжруулах</p> <p>6-3 Иргэд-төрийн уялдаа холбоог сайжруулах</p> <p>6-4 Улиастай хотын гадаад харилцааг хөгжүүлэх</p> <p>6-5 Газрын далд зах зээлийг арилгах</p>
<b>Зорилт 7.</b> Хөгжсөн дэд бүтэц – суурьшлын оновчтой тогтолцоо	<p>7-1 Сумдыг 24 цагийн найдвартэй эрчим хүчний системтэй болгох</p> <p>7-2 Аймгийн хатуу хучилттай болон сайжруулсан авто замын сүлжээг сайжруулах</p> <p>7-3 Бүс нутгийн бүлэг суурингын тогтолцоог төгөлдөржүүлж эдийн засгийн дэд бүтцийг бий болгох /мах сүү, экспорт г.м/</p> <p>7-4 Улиастай хотын инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх</p> <p>7-5 Хүн амыг орон сууцаар хангах</p>
<b>Зорилт 8.</b> Хүчтэй эдийн засаг бизнес, аялал жуулчлалын төв	<p>5-1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих</p> <p>5-2 Жижиг дунд үйлдвэрлэл-бизнес эрхлэгч болон гарааны бизнесийг дэмжих</p> <p>5-3 Хөрөнгө оруулалтыг дэмжинэ</p> <p>5-4 Шинжлэх ухаан технологийн хөгжлийг дэмжих</p> <p>5-5 Жуулчдад ээлтэй, соёлын давтагдашгүй өв бүхий хот</p> <p>5-6 Аялал жуулчлалын бүс нутгийн маршрутыг бий болгож олон төрөлт аялал жуулчлалыг бий болгох</p>

Үйл ажиллагааны стратеги	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Хэмжээ	Хугацаа	Шаардагдах хөрөнгө (сая.төг)	Хөрөнгийн эх үүсвэр	
<b>ЗОРИЛТ 1. Газар ашиглалтын тогтвортой загварыг бий болгох</b>							
Газар ашиглалтын тэргүүн ээлжинд хөгжүүлэх чиглэл, төрөл, тархалтыг тодорхойлох	Байгалийн аялал жуулчлал амралтын газрын бүс нутгаар Отгон, Эрдэнэхайрхан, Тэлмэн сумдын сонгогдсон бүс, нутаг дэвсгэр	ш	74	<2022 <2028 <2033	733 873 984	Улсын Улсын Улсын	
	Тэмээ-бог малын хосолмол төрөлжилтөөр Дөрвөлжин, Ургамал, Завханмандал, Сантмаргац, Эрдэнэхайрхан	-	-	-	-	-	
	Сарлаг-бог малын хосолмол төрөлжилтөөр Нөмрөг, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Отгон	-	-	-	-	-	
	Бог мал-Монгол үхрийн хосолмол төрөлжилтөөр Сонгино, Түдэвтэй, Баянхайрхан, Асгат, Баянтэс, Тэс, Цагаанчулуут	-	-	-	-	-	
	Уул уурхайн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд Дөрвөлжин	-	-	-	-	ААН	
	Улиастай хот нь бизнес, боловсрол, банк санхүү, аялал жуулчлалын төв байна.	-	-	-	-	-	
	ХАА-н үйлдвэр технологийн парк, цогцолбороор Тэлмэн, Тэс, Алдархаан сум	ш	1 1 1	<2022 <2028 <2033	1225000 490000 490000	Улсын Улсын Улсын	
	Газар хадгалан хамгаалах бүс нутгийг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлон Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний сүлжээг өргөжүүлэх	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний өргөтгөлд 10 байршил	мян.га	1042,5 305,9 122,0	<2022 <2028 <2033		Улс, төсөл хөтөлбөр, аймаг
	Орон нутгийн (аймгийн) тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний өргөтгөлд 10 байршил	мян.га	305,9 126,0 16,3	<2033 <2028 <2033		Аймаг, төсөл хөтөлбөр	
	Орон нутгийн (сумын) тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний өргөтгөлд 145 байршил	мян.га	625,9 550,1 272,3	<2022 <2028 <2033		Сум, төсөл хөтөлбөр	
Газар дүйцүүлэн хамгаалалтын арга	га	12374	2018-2038	-	ААН		



	хэмжээг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан болон авах нутаг дэвсгэрээс сонгож авна.					
Газар ашиглалтын хориглох, төрөл чиглэлийг гаргах	Орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар тусгагдсан бүх байршилд уурхайн хайгуул, ашиглалтын зөвшөөрөл олгохгүй	сая.га	1,2	2018-2033	-	Сум
Газрын нөөц нөхцөлийг байгалийн болон ландшафт тогтоцын даац чадавхи боломжинд тулгуурлан газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд суурилсан төлөвлөлтийн загварыг бий болгох	Завхан аймгийн нутаг дэвсгэрийн бэлчээрийн зориулалттай газрыг бүхэлд нь бэлчээрийн даац чадавхид тохируулах бүс нутгаар	сая.га	6,9	2022-2038		
	Бэлчээрийн хог ургамал, хортон мэрэгчидтэй тэмцэх	мян.га	2300	<2022 <2028 <2033	6613 2795 2093	
	Бэлчээрийг элсний нүүлтээс хамгаалах	га	592	<2022 <2028 <2033	201 332 473	
	Тэжээлийн нөхцөлийг сайжруулах		1687,5		8400	
	Чөлөөлөн сэлгэх	мян.га	738,5	2018-2033	700	
Бэлчээрийн болон ундны усны эх үүсвэрийн хангамжийг нэмэгдүүлэх	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх	ш	311	<2022 <2028 <2033	1612 1677 1687	Улсын Улсын Улсын
	Хүн амын усан хангамжийг нэмэгдүүлэх	ш	12	2018-2033	216	Улсын
	Хөв цөөрөм	ш	32	<2022 <2028 <2033	1500 2400 900	Улсын Аймгийн Төсөл хөтөлбөр

Хүснэгт 2. ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний нэгдсэн менежментийн төлөвлөгөө /зорилт 2, 3/

Үйл ажиллагааны стратеги	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Хэмжээ	Хугацаа	Шаардагдах хөрөнгө (сая.төг)	Хөрөнгийн эх үүсвэр
<b>ЗОРИЛТ 2. Газрын зах зээлийг дэмжих дэд бүтцийг сайжруулах</b>						
Газрын энгийн зах зээлээс цогц зах зээл рүү шилжихэд төрийн дэмжлэг тусалцаа үзүүлэх	Landmanager программ хангамжийн найдвартай үйл ажиллагааг хангах, техникийн шинэчлэл хийх	багц	1	<2022	350	Аймаг
	Нээлттэй газрын дуудлага худалдааг тогтмол зохион байгуулах	багц	1	<2022	150	Аймаг
Цахим засаглал хөтөлбөрийн хүрээнд иргэдийн авдаг үйлчилгээг цахимжуулах	Газрын талаар иргэдээс авах хүсэлт, өргөдлийг цахимаар хүлээн авах, нээлттэй шийдвэрлэх	багц	1	<2028	500	Аймаг

	Усалгаатай тариаланг хөгжүүлж байнгын ажлын байрыг 4,4 мянгаар нэмэгдүүлнэ.	мян.га	68,0	2018-2033	2600	Улс
Газар ашиглалтын олон төрөлт үйл ажиллагааг хөгжүүлэх	Улсын аялал жуулчлалын маршрутыг нэмж гадаад дотоодын жуулчдыг татаж жилд 100 мянгаас доошгүй жуулчид хүлээн авна	маршрут	10	2018-2033	2600	Аймаг, ААН
Албан бус газар ашиглалтын хэмжээг тодорхойлон тэдгээрийг газар ашиглалтын системд бүртгэлжүүлэх	Газар эзэмших, ашиглах гэрчилгээ, гэрээгүй боловч газар дээрээ үйл ажиллагаа явуулж буй нэгж талбарын судалгааг гаргах, хориглох нөхцөл горимд ороогүй тохиолдолд газар олголт хийх	-	-	2018-2033	150	Аймаг
<b>ЗОРИЛТ 3. Газрын нөөц хуваарилалтыг сайжруулах</b>						
Газрын дахин төлөвлөлтийн бүс нутгийг тодорхойлж дахин төлөвлөлтөд хамруулах	Улиастай хотын "АРАЛ" хэсгийг дахин төлөвлөлтөд хамруулж инженерийн шугам сүлжээнд холбогдсон нягтшил сайтай холимог төв бүхий цомхон хот бий болгоно.	га	134	2018-2033	17500	Аймаг
Усалгаатай тариалан хөгжүүлэх нөөц нөхцөлийн төлөвлөлт хийх	Алдархаан, Баянтэсийн усалалтын системийг засварлаж ашиглалтад оруулах	0.7	2022	1500	Аймгийн төсөв	

Хүснэгт 3. ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний нэгдсэн менежментийн төлөвлөгөө /зорилт 4, 5/

Үйл ажиллагааны стратеги	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хугацаа	Шаардагдах хөрөнгө (сая.төг)	Хөрөнгийн эх үүсвэр
<b>ЗОРИЛТ 4. Газар өмчлөлийг эрчимжүүлэх</b>						
Газар өмчлөлийн хэрэгцээг сум тус бүрээр тодорхойлох	Улиастай суманд 95%, Тосонцэнгэл 93%, Тэс 89%, Алдархаан 75%, Идэр 91% нь газар өмчилж авах хэрэгцээтэй байна.					
Өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тодорхойлж үе шаттайгаар өмчлүүлэх төлөвлөгөө гаргах	Улиастай, Тосонцэнгэл, Тэс, Тэлмэн, Алдархаан, Идэр сумдын нутаг дэвсгэрт гэр бүлийн хэрэгцээнд газар өмчлүүлнэ.	мян.га	9,3	2018-2033	30	Аймаг
<b>ЗОРИЛТ 5. Иргэдэд хүртээмжтэй нийгмийн үйлчилгээ, эрүүл аюулгүй орчныг бий болгох</b>						
Ногоон байгууламж	Улиастай хотын цэвэр усны эх үүсвэр болох Богдын гол, Чигэстэй голын татам нугыг иргэдийн амрах, зугаалах ногоон бүсээр төлөвлөв.	га				
Цэнгэг ус эрүүл хөрс	Улиастай хот болон дэд төвүүдийн цэвэр усны хүртээмжийг сайжруулж оршин суугчдийг 24/7 ус авах боломжийг	ш	5	2018-2022	50	Улсын

	бүрдүүлэх. Ус түгээх байрыг автоматжуулах					
	хогийг 3 төрөлд буюу энгийн хог, хуванцар, болон шил гэсэн төрлүүдэд хогийг ангилж сурах компани ажлыг хэрэгжүүлэх бөгөөд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай дахин боловсруулах үйлдвэрүүдийг ажиллагаанд оруулна. Шинээр бага оврын цэвэрлэх байгууламж барина. Төв цэвэрлэх байгууламжид техник технологийн шинэчлэл хийж, хүчин чадлыг өргөтгөн, орчны болон хөрсний бохирдлыг бууруулах ажлыг хийнэ. Энэхүү ажлын хүрээнд хувийн хэвшлийг оролцуулах, гадаадын зээл, тусламжийг татах чиглэл баримтална.	үйлдвэр	1	2022-2028	1800	Улсын
		Байгууламж	1	2022-2028	2500	Улсын
Дөрвөн улирлын цэнгэг агаар	Нягтшил сайтай цомхон хотыг цогц төлөвлөлтийн онолд суурилан хөгжүүлж авто машины хамаарал багатай хот болгох	-	-	-	-	Аймаг
	Барилгын дулаан алдагдлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн орчин үеийн ЭКО хот болох хөгжлийн чиглэлийг баримтлана.	-	-	-	-	
Идэвхитэй амьдарлын хэв маяг	Гадаад, дотоодын жуулчид Улиастай хотод аюулгүй зорчих, шаардлагатай мэдээлэл, тусламжийг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх	-	-	-	-	
	Жуулчдыг татах урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах, жуулчдын сонирхлыг татахуйц экстрэм аялалыг зохион байгуулан сурталчлах	-	-	-	-	
	Богдын гол, Чигэстэйн голын эрэг дагуу амралт зугаалгын бүс гаргаж амралтын өдрүүдийг эрүүл орчинд өнгөрөөдөг болох боломжийг бүрдүүлэх.	-	-	-	-	
Амьдарлын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх	Цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд ойртуулах, гэмт хэрэг, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	-	-	-	-	
	Улиастай хотын агроүйлдвэрлэлийн бүсэд эрүүл, найдвартай хүнсээр хангах нөхцөл бүрдүүлэх	-	-	-	-	

Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ	Нээлттэй мэдээллийн системтэй болох	-	-	-	-
	Үйлчилгээний соёл, хурдыг дээшлүүлж, хүнд суртлыг багасгана.	-	-	-	-
	Төрийн зүгээс иргэдэд шаардлагатай баримт бичгүүд, мэдээ мэдээллийг авах үйл ажиллагааг хялбаршуулж цахимжуулна.	-	-	-	-

Хүснэгт 4. ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний нэгдсэн менежментийн төлөвлөгөө /зорилт 6/

Үйл ажиллагааны стратеги	Арга хэмжээ	Хэмжээ (мян.га)	Хугацаа	Шаардагдах хөрөнгө (сая.төг)	Хөрөнгийн эх үүсвэр
<b>ЗОРИЛТ 6. Нэгдмэл харилцан уялдаа бүхий сайн засаглал</b>					
Төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	Аймгийн ЗДТГазар түүний харьяа байгууллагууд (ХАА-н газар, байгаль орчин аялал жуулчлалын газар, газрын алба, ТҮК г.м) нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан өөрсдийн харьяалалын ажил, үйлчилгээ, зохион байгуулалтыг жил бүр шат дараатайгаар үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт суулган хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.	-	-	-	-
	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний өргөтгөлийг ерөнхий төлөвлөгөөнд тусгаснаар цаашид хөгжүүлэх	-	-	-	-
	Байгууллага хоорондын мэдээлэл солилцоог сайжруулснаар иргэнээс шаардах баримт бичгийг цөөлнө.	-	-	-	-
Эрх зүйн орчныг сайжруулах	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам	-	-	-	-
	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох журам	-	-	-	-
	Ашиглалтын шаардлага хангахгүй нийийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам	-	-	-	-
Иргэд-төрийн уялдаа холбоог сайжруулах	Газар дахих төлөвлөлтөөр хөгжүүлэхээр төлөвлөгдсөн бүс нутагд иргэдийн оролцоог хангах	-	-	-	-
	Газар сайжруулах арга хэмжээ төлөвлөгдсөн бүс нутагт иргэд газарт хөрөнгө оруулах, сайжруулах	-	-	-	-

арга хэмжээ авах төсөл хөтөлбөрийг тэргүүн  
ээлжинд санхүүжүүлүүлэх

Хүснэгт 5. ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний нэгдсэн менежментийн төлөвлөгөө /зорилт 7, 8/

Үйл ажиллагааны стратеги	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хугацаа	Шаардагдах хөрөнгө (сая.төг)	Хөрөнгийн эх үүсвэр
<b>ЗОРИЛТ 7. Хөгжсөн дэд бүтэц-суурьшлын оновчтой тогтолцоо</b>						
Аймгийн хатуу хучилттай болон сайжруулсан авто замын сүлжээг сайжруулах	Тосонцэнгэл-Улиастай хатуу хучилттай зам ашиглалтад оруулах	км	861	<2022	861300	Улсын
	Тэлмэн-Увсын чиглэлийн хатуу хучилттай зам ашиглалтад оруулах			<2022		
	Улиастай-Говь-Алтай чиглэлийн хатуу хучилттай зам ашиглалтад оруулах			<2028		
	Улиастай-Улаагчны хар нуурын хатуу хучилттай авто зам			<2033		
Шилэн кабелиар бүх сууринг хангах	Отгон сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох			<2022		Улсын төсөв
<b>ЗОРИЛТ 8. Хүчтэй эдийн засаг бизнес, аялал жуулчлалын төв</b>						
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Төслийн эцсийн хугацаанд 8123 шинэ ажлын байр бий болно.					
Жижиг дунд үйлдвэрлэл-бизнес эрхлэгч болон гарааны бизнесийг дэмжих	10 төрлийн 138 үйлдвэр, үйлчилгээг бий болгоно.		нэгж	138		
Жуулчдад ээлтэй, соёлын давтагдашгүй өв бүхий хот	Засмал зам холбогдсоноор дотоод гадаадын жуулчдын урсгал нэмэгдэнэ					
Аялал жуулчлалын бүс нутгийн маршрутыг бий болгож олон төрөлт аялал жуулчлалыг бий болгох	Аялал жуулчлалын маршрутыг нэмэгдүүлэх, маршрутын дагуу жуулчны баазыг нэмэгдүүлэх	тоо	120	2033		Орон нутгийн болон хувийн хэвшил

# ХОЁР. ЗАВХАН АЙМГИЙН СУУРЬ НӨХЦӨЛИЙН СУДАЛГАА

## 2.1 ЗАВХАН АЙМГИЙН УУР АМЬСГАЛ

Завхан аймгийн нутаг бол хангай, хээр, говь цөл хослосон Монгол орны бусад нутагтай харьцуулахад чийг – дулааны хангамж сайтай, бэлчээрийн мал аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой нутаг юм. Аймгийн нутагт агаарын температурын хэлбэлзэл өндөр эх газрын эрс тэс, хахир хатуу уур амьсгалтай. Газар орны уур амьсгалын эх газарлаг байдлыг илэрхийлдэг.

$$K_{\text{конрад}} = \frac{1.7A}{\sin(\varphi + 10)}$$

Конрадын индекс - ийн утга 62-80 орчим байдаг. Энд А – жилийн хамгийн хүйтэн, дулаан сарын дундаж температурын зөрөө буюу температурын жилийн агууриг,  $\varphi$  – газар нутгийн өргөрөг. Конрадын индекс Улиастайд 62, Цэцэн Уулд 64 байдаг бол Идэр, Тэсийн голын дагуу оршдог ихээхэн хүйтэн уур амьсгалтай Тосонцэнгэл, Баянтэст 77-79 хүрнэ.

Гэхдээ уур амьсгалын эрс хурдтай өөрчлөлт болоод өнгөрсөн зууны ерээд оноос мал сүргийн тоо толгой нь түргэн өссөн, мал маллах уламжлалт арга ажиллагаа тодорхой хэмжээгээр алдагдаж байгаа зэрэгтэй уялдан бэлчээрт үзүүлэх дарамт их болсоноос ургамал бүрхэвч, хөрсний үржил шим, биологийн олон янз байдал, нэг үгээр хэлбэл экосистемийн бүтээмж буурах хандлагатай байна.

Завхан аймаг одоохондоо улс орны эдийн засагт тун бага жин эзэлж байгаа боловч хөгжлийн ихээхэн ирээдүйтэй юм. Чухам ийм учраас уур амьсгалын хувирал, өөрчлөлтийг тооцон байгаль орчиндоо нийцсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх нь бүс нутгийн тогтвортой хөгжлийн нэг үндэс билээ.

### 2.1.1 Уур амьсгалын горим

Судалгаанд тус аймгийн нутаг дэвсгэр дээр ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа цаг уурын ажиглалтын цэгүүд – цаг уурын өртөө (станц), харуулын хэмжилтийн олон жилийн өгөгдөл ашиглав. Хүснэгтэд аймгийн цаг уурын өртөө, харуулын үндсэн тодорхойлолтыг үзүүлэв.

Хүснэгт 88. Завхан аймгийн цаг уурын ажиглалтын цэгүүд

Сум	Өртөө, харуулын нэр	Байгуулагдсан сар/өдөр/он	өргөрөг	уртраг	Далайн түвшнээс дээших өндөр, м - ээр
Шилүүстэй	Шилүүстэй	1/1/1961	46.8	97.2	2173
Цагаанчулуут	Цагаанчулуут	1/1/1962	47.13	96.66	2143
Отгон	Отгон	1/12/1999	47.12	95.57	2155
Цагаанхайрхан	Цагаанхайрхан	1/1/1975	47.5	96.88	1817
Дөрвөлжин	Дөрвөлжин*	15/12/1961	47.38	95	1389
Алдархаан	Алдархаан	1/1/1961	47.63	96.7	1682
Улиастай	Улиастай	1/12/1936	47.45	96.51	1767
Эрдэнэхайрхан	Эрдэнэхайрхан	1/1/1975	48.1	95.7	1887
Яруу	Яруу	1/1/1974	48.12	96.8	2096

Идэр	Идэр	1/1/1964	48.25	97.37	1966
Завханмандал	Завханмандал	9/1/2009	48.3	95.12	1440
Ургамал	Ургамал	1/1/1969	48.51	94.28	1272
Сантмаргац	Сантмаргац	1/1/1963	48.6	95.47	1572
Тэлмэн	Тэлмэн	1/1/1965	48.67	97.6	1810
Цэцэн-Уул	Цэцэн-Уул	1/9/1975	42.48	96.46	1933
Тосонцэнгэл	Тосонцэнгэл	1/12/1963	48.44	98.17	1725
Их-Уул	Их-Уул	1/1/1962	48.72	98.8	1658
Сонгино	Сонгино	1/1/1961	48.98	95.92	1819
Нөмрөг	Нөмрөг	1/11/1993	48.56	96.47	1851
Түдэвтэй	Түдэвтэй	1/1/1975	49	96.63	1773
Баянхайрхан	Баянхайрхан	1/1/1974	49.33	96.36	1868
Баянтэс	Баян-Уул	1/1/1962	49.41	96.22	1424
Тэс	Тэс	1/1/1975	49.62	95.8	1284

Тайлбар. \* - Энэ өртөө хуучин Дөрвөлжин сумын Таван толгойн бригад дээр ажиллаж байснаа 1975 онд одоогийн сумын төв байгаа газарт нүүж ирсэн.

Цаг уурын харуул дээр 1 хүн ажилладаг учраас ажиглалтын тасалдал ихтэй, нөгөө талаар хоногт Улаанбаатарын цагаар 08, 14, 20 цагт буюу зөвхөн өдрийн гэрэлтэй цагт цомхотгосон хөтөлбөрөөр хэмжилт хийдэг учраас уур амьсгалын хэмжигдэхүүний бодит утга гаргаж авахад хүрэлцээ муутай. Тухайлбал “Завхан аймгийн уур амьсгалын эмхэтгэл – УБ., 1987” – д сар, жилийн дундаж температурыг энэхүү 3 хугацааны хэмжилтийн мэдээг шууд дундажлах аргаар гаргаж өгсөн учраас бодит байдлаас нэлээд зөрүүтэй (зундаа дулааруулж, өвөлдөө хүйтрүүлж) өгсөн байдаг. Бас нэг анхаарах зүйл бол цаг уурын харуулууд дээр хур тунадасны хэмжээг бодит байдлаас нэлээд багасгаж өгсөн байдаг. Ийм учраас аймгийн уур амьсгалын энэхүү тодорхойлолтыг цаг уурын үндсэн өртөөдийн мэдээлэл дээр голчлон түшиглэж гаргасан бөгөөд цаг уурын харуулын мэдээг зөвхөн туслах байдлаар ашигласан болно.

#### Агаарын дулаан хүйтэн:

Аймгийн нутагт жилийн дундаж агаарын температур  $-0.5 \dots -7.5^{\circ}\text{C}$  – ийн хооронд хэлбэлзэнэ.


Хүснэгт 2. Сар, жилийн агаарын дундаж температурын олон жилийн дундаж (1961-1990 оны хэвийн хэмжээ буюу норм)

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Улиастай норм	-22.6	-20	-10.3	0.6	8.5	14	15	13.3	7.1	-1.3	-13.2	-20.4	-2.4
1991-2016 он	-22.9	-18.7	-9.5	2.2	8.9	15	17.2	14.6	7.9	-0.7	-11.9	-19.8	-1.5
Тосонцэнгэл норм	-32	-29.1	-17.9	-2.4	7	12.4	13.8	11.8	5.6	-4.1	-18.6	-27.8	-6.8
1991-2016 он	-31.4	-26.8	-14.8	0.4	7.6	13.6	15.8	13.1	6.1	-2.9	-16.2	-27	-5.2
Баян Уул норм	-31.8	-29.2	-18.1	-2.2	8.2	14	15.4	13.2	6.4	-3.2	-17.8	-28.7	-6.2
1991-2016 он	-30.9	-27.1	-16.5	0.1	8.5	15	17.4	14.5	7.2	-2.4	-16.6	-26.5	-4.8
5 толгой 1962-1974 Дөрвөлжин 1975- 1990 он	-23.6	-20.5	-6.6	3.2	11.8	17.6	19	17	9.7	0.9	-10.7	-21.8	-0.3
1991-2016 он	-24.6	-19.8	-8	3.2	11.6	17.4	18.9	17.1	11.2	2.2	-10.8	-20	-0.1
1991-2016 он	-24.1	-18.3	-5.9	5.2	12.2	18.6	20.9	18.2	11.3	2.1	-9.3	-19.2	1
Цэцэн Уул 1976- 1990 он	-27.2	-24.3	-16.6	-3.2	5.6	10.7	12.3	10.5	4.8	-3.7	-17.3	-23	-6
1991-2016 он	-27.3	-23.6	-14.8	-1.6	5.9	11.8	14.3	11.5	4.7	-4	-14.9	-23.5	-5.1

Алдархаан*	-22.8	-20	-9.4	2.4	9.2	14.9	15.6	14.5	9.2	-0.1	-12.4	-19.8	-1.6
Баянхайрхан*	-26	-23.5	-16.3	-3	6.4	11.8	12.9	11.2	6	-2.4	-14.6	-22.7	-5
Завханмандал*	-24.7	-20.8	-8.2	2.5	10.8	17.1	17.9	15.5	8.9	0.8	-10.3	-21.9	-1
Идэр*	-26	-22.9	-13.5	-2.2	6.6	11	12	10.3	5.5	-3.3	-14.5	-21.3	-4.9
Их Уул*	-31.7	-28.9	-18	-2.9	6	12.3	14.2	12	6.4	-3.3	-17.7	-28.4	-6.7
Нөмрөг*	-29	-25.5	-16.2	-1.5	6.5	12.6	12.8	11.1	5.8	-3.4	-15.7	-24.7	-5.6
Отгон*	-32.6	-29.1	-17.2	-3.5	5.5	10.8	12.3	10.6	4.9	-4.5	-19.1	-28.6	-7.5
Сантмаргаз*	-27.3	-24.8	-13.3	-0.1	8.2	14.6	16.1	14.2	8.2	-1.1	-14	-23.8	-3.6
Сонгино*	-24	-21.3	-14.4	-3	4.9	10.9	12.6	10	4.5	-5	-14.5	-21.8	-5.1
Түдэвтэй*	-30	-26.2	17.8	-2.7	6.7	12	13.2	11.3	5.8	-3.4	-17.7	-26.5	-3.3
Тэлмэн*	-31.3	-27	-17	-1.1	7.4	12.1	13.7	11.1	5.6	-4.2	-18.7	-27.4	-6.4
Тэс*	-29.8	-27.9	-16.8	0	9.2	15	16.2	14.6	8.1	-2.2	-17.1	-26.4	-4.7
Ургамал*	-26.1	-22	-9	3.3	12.1	18	19.4	17.4	10.9	2.8	-10.5	-22	-0.5
Цагаанхайрхан*	-20.9	-17	-10.8	0.7	8.1	13.5	15.3	13.7	8.1	2.8	-12	-17.6	-1.3
Цагаанчулуут*	-19.7	-17.4	-10.3	-1	5.5	11.5	13	10.8	6.5	-0.6	-12.2	-17.8	-2.6
Шилүүстэй*	-21.6	-19	-10.9	-1.1	6.7	12.2	14.8	11.8	5.6	-2.8	-13	-19.5	-3.1
Эрдэнэхайрхан*	-18.7	-17.2	-10.1	0.2	8.2	14	14.8	13.6	7.8	-3.4	-10	-16	-1.4
Яруу*	-28	-24.8	-17.5	-4.2	4.7	10.2	11.6	9.8	5.4	-4.7	-16.8	-24	-6.7

Тайлбар: \* - цаг уурын харуулуудын сарын дундаж агаарын температурын нормыг 3 хугацааны ажиглалтын мэдээг 8 хугацааны мэдээнд хөрвүүлэх үржвэр ашиглан засварлаж гаргав.

Цаг уур өртөөдийн сар, жилийн дундаж агаарын температурын утгыг 1961-1990 оны норм утга болон 1991-2016 оны дундаж гэсэн 2 янзаар өгсөн нь дэлхийн уур амьсгалын дулааралт энэ нутагт хэр зэрэг илэрч байгааг харуулах зорилготой юм. Цаг уурын бүхий л өртөө, харуулууд сумын төв бараадан голын дэнж, нам газарт байрлах учраас агаарын температурын газарзүйн хуваарилагдлыг бодит байдлаар үзүүлэхгүй талтай. Иймд жилийн дундаж агаарын температурын газарзүйн хуваарилагдлыг ГИС ашиглан зурагласныг зурагт үзүүлэв.




Зураг 1. Жилийн дундаж агаарын температурын газарзүйн тархац

Агаарын температурын газарзүйн хуваарилагдалд уулзүй (орографи) – н болон өргөргийн нөлөө давхар илэрч байна. Өөрөөр хэлбэл өргөрөг ихсэх тутам хүйтрэх,




нөгөө талаар газар өндөрсөх тутам температур буурах зүй тогтол зэрэгцэн илрэнэ. Зургаас үзвэл өндөр уулын ян сарьдагаар жилийн дундаж температур  $-10^{\circ}\text{C}$ - аас ч хүйтэн байдаг бололтой.



Монголд жилийн хүйтэн улиралд газрын гадарга цацрагийн дулаан алдалтаар ихээхэн хөрдөг учраас агаараасаа хүйтэн болж газраас дээшлэх тутам дулаардаг буюу цаг уурын шинжлэх ухааны хэллэгээр агаарын температурын тонгоруу үе давхарга (инверси) тогтдог.


Зураг 2. 1-р сарын дундаж агаарын температурын газарзүйн хуваарилагдал

Иймд уулс хоорондын хөндий, гол мөрний голдрил дагуу хүйтэн, өндөр ууландаа дулаан байдаг. Харин жилийн дулаан улиралд болоод ирэхлээр агаарын температурын өндрийн хуваарилагдал ердийн байдалдаа ойртох буюу газраас дээш 100 м өгсөх тутамд  $0.5 - 0.6^{\circ}\text{C}$  – аар сэрүүсдэг. Үүнийг 1 ба 7 дугаар сарын дундаж температурын газарзүйн тархац харуулна.




Зураг 3. 1-р сарын дундаж агаарын температурын газарзүйн хуваарилагдал /АНУ-ын мэргэжилтэнүүдийнхээр/

Өвлийн улирлын агаарын температурын хуваарилагдлыг өргөн зайцаар зурсан учраас уулзүйн нөлөө нэлээд бүдгэрч харагдаж байгаа учраас 3 дугаар зурагт 1 дүгээр сарын үнэмлэхүй хамгийн бага температурын дундажийн газарзүйн хуваарилагдлыг АНУ –ын Орегоны их сургуулийн мэргэжилтнүүдийн зурсан байдлаар давхар үзүүлэв



Зураг 4. 7-р сарын дундаж агаарын температурын газарзүйн хуваарилагдал

Харин 7 дугаар сарын хувьд температурын хуваарилагдалд уулзүйн нөлөө тод харагдаж байх юм. Завханы нутагт Монгол нутагт ажиглагдсан хамгийн нам температур энэ 2016 оны 1 дүгээр сарын 28-нд цаг уурын Отгон өртөөнд ажиглагдсан нь Увс аймгийн Зүүн говь суманд 1976 оны 12 дугаар сарын 31 –нд тэмдэглэгдсэн үнэмлэхүй минимумийн хэмжээнд хүрсэн байна.



Диаграмм 1. Жилийн дундаж агаарын температурын олон жилийн явц


Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн дэвсгэр дээр Монгол нутагт дулааралт эрчимтэй явагдаж байна. Цаг уурын өртөөдөр дундажласан агаарын температурын

олон жилийн явцаас үзвэл хугацаа хойшлох тутам дулааралт улам эрчимжиж байна. 1 дүгээр хүснэгтэнд үзүүлсэн сарын бүрийн дундаж температурын норм утга ба 1991-2016 оны дундажийг жишээд харахад бүс нутагт жилийн дундаж температур 1961 – 1990 оны норм утгаасаа  $0,9 - 1,6^{\circ}\text{C}$  – аар дулаарсан, тэгэхдээ их хүйтэн байдаг газруудаараа илүү эрчимтэй дулааралт явагдсан байна.

Жилийн дундаж байдлаар сүүлийн 55 гаруй жилийн дотор энэ бүс нутагт  $1,65^{\circ}\text{C}$  - ын дулааралт явагдаж байна. Дулааралт жилийн бүх саруудад явагдаж байгаагийн дотор зуны улиралд арай эрчимтэй ажиглагдаж байх аж.

#### Ургамлын дулаан хангамж:


Бэлчээрийн ургамал ургалтын хугацааны дулааны нөөцийг хоногийн дундаж агаарын температур  $5^{\circ}\text{C}$  – аас дээш температурын нийлбэр илэрхийлнэ. Уулархаг нутагт хоногийн дундаж агаарын температур хавар 5 дугаар сарын эхний 10 хоногт  $5^{\circ}\text{C}$  – ийн даван дулаарч 127-148 хоног орчим үргэлжлээд 9 дүгээр сарын 2 дугаар арав хоногт дуусах бөгөөд энэ хугацаанд 1300 – 1500 градусын дулаан хуримтална. Харин говь тал нутгаараа 4 дүгээр сарын дундаас 10 дугаар сарын эхний арав хоног хүртэл 142-175 хоног үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд 1500-2500 градусын дулаан хуримтална.



Зураг 5. 5 градусаас дээш нийлбэр температурын газарзүйн тархац

Уур амьсгалын дулааралттай холбоотойгоор ургамал ургалтын хугацаа 2 долоо хоног орчмоор уртасч, мөн хугацаанд хуримтлах дулааны нөөц нэмэгдэж байна. Жишээлбэл: Дөрвөлжинд 1991-2016 онд  $5^{\circ}\text{C}$  -аас дээшхи дулааны нийлбэр 1975-1990 оны дунджаас  $147^{\circ}\text{C}$  -аар, нэмэгдсэн байна. Мөн Улиастай  $216^{\circ}\text{C}$  – аар нэмэгдсэн байх юм. Өөрөөр хэлбэл хүйтэн уур амьсгалтай газраа дулааны нөөц илүү эрчимтэй нэмэгдэж байгаа тал буй. Таримал ургамлын дулаан хангамжийг үнэлэхэд хоногийн дундаж агаарын температур  $10^{\circ}\text{C}$  – аас дээш байх хугацаа болон энэ хугацаанд хуримтлах дулааны нөөцийг авч үздэг. Энэ хэмжээнээс дээш температуртай хугацаа хангай талдаа 65-88 хоног байдаг бол говь талын нутгаар 90-120 орчим хоног байх бөгөөд энэ хугацаанд хуримтлах идэвхтэй температурын

нийлбэр уулархаг нутгаар 1000 – 1500<sup>0</sup>С, говь тал хээрийн бүс нутгаар 1500 – 2400<sup>0</sup>С хүрнэ.



Зураг 6. 10 градусаас дээш идэвхитэй температурын нийлбэрийн газарзүйн тархац

Ургамал ургалтын хугацааны дулааны нөөц нэмэгдэж байгаа нь усалгаатай нөхцөлд дулаан их шаарддаг таримал тариалах боломжийг нэмэгдүүлж өгч байгаа сайн талтай боловч үүнтэй зэрэгцээд хүний эрүүл мэндэд таагүй нөлөөлдөг халууны долгион (heat wave) – ы хийгээд ургамлын фотосинтезийг саатуулах өндөр температурын давтагдал болоод эрчим нэмэгдэх саар талтай байж болно.

#### Хур тунадас:

Цаг уурын ажиглалтын цэгүүдийн олон жилийн мэдээгээр Завхан аймгийн нутагт жилдээ 50 – 250 орчим мм хур тунадас ордог.


Хүснэгт 3. Сар, жилийн хур тунадасны олон жилийн дундаж хэмжээ /1961-1990 оны норм/

Цэгүүдийн нэрс	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Улиастай норм	2.2	1.8	4.9	9.3	15	34.1	62.2	48.9	22.7	9.4	4.8	3.3	218.6
1991-2016 он	3.1	3.5	4.9	9.2	16.3	36.9	60.8	45.5	19.4	7.2	5.2	3.7	215.7
Тосонцэнгэл норм	2.8	2.1	4.4	7.9	12.9	41.6	64	48.4	16.5	10.1	6.7	5.8	223.2
1991-2016 он	3	2.9	4.2	9	19.4	38.3	63.8	48.9	22.8	8.9	7.2	5.6	234
Баян уул норм	3.6	2.4	3.4	6.6	11.5	29.6	50.2	42.3	19.3	7.4	5.9	7	189.2
1991-2016 он	3.7	3.8	3.3	6.6	12.5	32.1	56.2	39.4	17.9	8.7	8.6	7.9	200.7
Таван толгой 1962-1974 он	1.7	1.6	2.2	3.8	3.5	13.7	34.9	27.6	8.2	6.8	2.4	1.4	107.8
Дөрвөлжин 1975-1990 он	1.4	1.6	2	3.5	3.9	18.5	32.5	27.6	9.6	5.3	1.9	1.7	109.5
1991-2016 он	1.3	1.6	2	4	5.2	19.4	30.6	21.9	7.2	2.3	2	1.7	99.2
Цэцэн Уул 1976-1990 он	2.1	2.7	4.8	9.2	20.1	38.6	62.8	51	21.7	12.4	8.3	4.4	238.1
1991-2016 он	3.4	3.5	5.6	9.6	17.8	36.6	63	49.4	22.2	8.6	6.6	5.2	231.5
Алдархаан*	1.5	0.4	2.8	6.3	6.4	28.2	33.5	34.5	14.8	5.5	2	1.9	137.8
Баянхайрхан*	4.2	2.5	5.4	7.1	10.8	36.9	53.5	52.8	9.1	12.5	7.6	6	208.4
Булнай*	2.2	2.7	2.9	7.6	10.1	34.5	56.1	45.2	17	9.6	6.6	4.8	199.3

Завханмандал*	0.7	0.6	1.4	4.1	5.2	18.9	25	34.5	7.6	2.2	2.8	1.5	104.5
Завханмандал 2010-2016 он	2.1	2.8	3.6	5.5	7	28.7	29.3	32.9	16.2	2.9	5.8	2.3	139.1
Идэр*	3	1.2	5.6	7.8	10.8	45.8	55.7	45.2	15.6	5.2	3.7	2.3	201.9
Их Уул*	1.8	1.1	2.4	4.5	10	23.1	44.7	30.5	7	6.4	2	4.4	137.9
Нөмрөг*	1.1	2.9	3.3	7.9	7.8	21.5	52.5	25.9	8.5	5.5	4.8	4.2	145.9
Нөмрөг 2000-2016 он	2.4	1.9	3.1	5.9	11	26.7	56.9	39	13.6	4.7	5.3	3.5	174
Отгон*	1	0.8	1.9	10.8	4.7	22.6	48.1	36.2	6.9	2	1.8	0.8	137.6
Отгон 2000-2016 он	2.3	3.2	2.6	6.5	14.2	38.4	43	31.5	10.8	4.7	3.2	3.4	163.8
Сантмаргаз*	0.4	0.9	2.7	5.6	7.5	25.6	41.7	42.8	10.2	2.6	1.1	1.3	142.1
Сонгино*	1	0.9	5.6	7.9	15.8	41.3	61.2	44	17.4	6.7	3.8	1.4	207
Түдэвтэй*	2.9	3.1	5.7	12.5	16.2	38.4	60.2	56.6	13.5	10	7.9	5.4	232.4
Тэлмэн*	2	2.1	3.8	6.9	9.7	34.7	58.4	37.1	28.2	8.1	3.4	3.3	197.7
Тэс*	4	3.2	4.7	4.5	8.6	18.4	38.4	34.4	34.6	9.8	5.9	3.7	170.2
Ургамал*	0.4	0.4	1.4	3.8	5.1	11.6	19.4	20.6	3	0.8	1.7	1	69.2
Цагаанхайрхан*	2	0.5	3.9	13.3	12.4	26	48.2	31.3	16.9	5.4	5.9	3.8	169.6
Цагаанчулуут*	1.4	1.4	5.2	9.9	6	19.2	36.1	31.8	9.4	4.9	5.2	1.6	132.1
Шилүүстэй*	0.4	0.2	1.2	1.8	3.2	9.9	17.6	12.6	2.2	1.7	0.7	0.4	51.9
Эрдэнэхайрхан*	1.6	2.1	6	17.2	14.2	31.6	69.2	41	10.9	5.8	9.3	3.3	212.2
Яруу*	0.7	0.5	2.4	7.9	8.6	22.5	33.3	31.5	10.2	4.5	3.3	2.4	127.8

Тайлбар: \* Аймгийн уур амьсгалын лавлах бичигт өгсөн нь

Хүснэгтэд цаг уурын харуул байж байгаад цаг уурын өртөө болсон цэгүүдийн хур тунадасны хэмжээг уг өртөө байгуулагдсан оноос нь хойшхи хэмжилтээр нэмэлт байдлаар өгөв. Хүснэгтээс үзэхэд цаг уурын харуулууд дээр хур тунадасны хэмжээг илт бууруулж хэмждэг нь харагдана. Иймээс зөвхөн цаг уурын өртөөдийн мэдээлэлд тулгуурлан хийсэн жилийн нийлбэр хур тунадасны газарзүйн хуваарилагдлыг дараахь зурагт харуулав.



Зураг 7. Жилийн нийлбэр хур тунадасны газарзүйн тархац, мм

Зургаас харвал аймгийн нутгийн хойд хязгаар Тагнийн нурууны зүүн биеэр жилдээ 300-350 мм хур тунадас орж болох ба Хангайн нурууны салбар уулсын салхин дээд

талаар 300-350 мм, харин говь цөлийн бүсэнд ердөө л 50-100 мм хур тунадас ордог байна.

Хур тунадасны хэмжээ жилээс жилд ихээхэн хэлбэлзэх бөгөөд үүнийг хувьсамжийн итгэлцүүр ( $C_v$ ) - ээр нь илэрхийлнэ.

$$C_v = \frac{\sigma}{P}$$

Энд  $\sigma$  – стандарт хазайц,  $P$  – хур тунадасны нийлбэрийн дундаж утга.

Жилийн нийлбэр хур тунадасны хувьсамжийн итгэлцүүрийн дундаж утга бүс нутагт 0.18 (Баянтэс) – аас 0.40 (Дөрвөлжин) – ийн хооронд хэлбэлзэх байдаг боловч 90-ээд оноос хойш уур амьсгалын өөрчлөлтийн явцад нэмэгдэж байгаа юм. Тухайлбал Улиастайд 1961-1990 оны байдлаар 0.28 байснаа 1991-2010 оны хооронд 0.34, Тосонцэнгэлд норм нь 0.24 байснаа 0.37, Баянтэс суманд 0.18 байснаа 0.31 гм нэмэгдсэн нь бэлчээрийн экосистем тогтворгүй төлөв байдал руугаа хувьсан өөрчлөгдөж байна гэсэн үг болно<sup>1</sup>.

Цаг уурын өртөөдөөр дундажласан жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явцыг үзүүлсэн зургаас 1940-2016 оны хооронд хур тунадасны хэмжээ онц өөрчлөгдөөгүй мэт боловч оны заагуудаар аваад үзвэл 1940-1960 оны хооронд нэмэгдсэн, 1961-1990 оны хооронд өсөлтийн хурд буурсан, 1991-2016 оны хооронд нэлээд эрчимтэй буурч байгаа харагдана.




Диаграмм 2. Жилийн нийлбэр хур тунадасны олон жилийн явц

Аймгийн нутагт 1983-2007 оны мэдээгээр зуны улиралд 81-230 орчим цаг, нутгийн зүүн хойд хэсгээр 200-250 цаг, төв хэсгээрээ 150-200 цаг бороо ордог бөгөөд борооны үргэлжлэх хугацаа нь зуны хур борооны нийт хэмжээтэй сайн уялдаатай (корреляцийн коэффициент 0.74-0.90) байна. Ажиглалтын мэдээгээр энэ хугацаанд зуны борооны үргэлжлэх хугацаа буурч байна. Борооны үргэлжлэх хугацаа буурч байгаа нь зүс борооны хувьд тод илрэх бөгөөд харин аадар борооны үргэлжлэх хугацаа нэмэгдэж байгаа юм.

<sup>1</sup> Maria E. Fernandez-Gimenez and Barbara- Allen-Diaz: Testing a non-equilibrium model of rangeland vegetation dynamics in Mongolia - Journal of Applied Ecology 1999, 36,871-885

Ургамал ургалтын хугацаанд (5-8 дугаар сар) нутгийн өмнөд хэсгээр 37-48 өдөр, хойд хэсгээр 40-50 орчим өдөр бороо ордог.

Хур тунадасны горимд гарч байгаа бас нэг өөрчлөлт бол дулаан улирлын нийт хур тунадасны дотор аадар хур тунадасны эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа явдал болно. Бороо бичүүрийн өгөгдөл ашиглан энэ талаар хийсэн ажил байхгүй боловч хоногийн хур тунадасны эрчим нэмэгдэж байгааг харж болно. Цаг уурын өртөөдөд 1961-2016 оны хооронд жилд нэг удаа тохиолдсон хоногийн хамгийн их хур тунадасны хэмжээний олон жилийн явцыг аваад үзэхэд ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Жишээ болгон Баянтэст 1962 оноос хойш л жилд тохиолдсон хоногийн хамгийн их хур тунадасны олон жилийн явцыг диаграммд үзүүлэв.



Диаграмм 3. Жилд тохиолдсон хамгийн их хур тунадасны хэмжээний олон жилийн явц, Баян-Уул өртөөгөөр

Хур тунадасны эрчим нэмэгдэж байгаагаас 90 -ээд оноос хойш хоногийн хамгийн их хур тунадас ажиглагдах хандлага ч бас харагдаж байна.

**Ургамлын чийг хангамж:**

Ургамлын чийг хангамжийг үнэлэхэд үндэсний системийн чийгийн эх үүсвэр болох агаар мандлын хур тунадас ба түүний зарцуулалт болох хөрс – ургамлаас явагдах ууршил буюу нийлбэр ууршицийн харьцааг голдуу авч үзэх болдог. Эрдэмтэд энд олон янзын үзүүлэлтүүд санал болгосон байдаг бөгөөд хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг үзүүлэлтийн нэг бол Зөвлөлтийн (хуучин нэрээр) эрдэмтэн Г.Т.Селяниновын (1958) дэвшүүлсэн ус- дулааны коэффициент /ГТК/ юм.

$$GTK = \frac{\sum P}{0.1 \sum t_{\geq 10^{\circ}}};$$

Энд  $\sum P$  -ургамал ургалтын хугацаанд орсон хур тунадасны хэмжээ,  $\sum t$  -мөн үеийн  $10^{\circ}\text{C}$ - аас дээш температурын нийлбэр, ГТК – ийн олон жилийн дундаж утгаар тухай орон нутгийн чийгшлийн байдлыг дараах байдлаар хуваана:

ГТК 1.6 – аас их буюу тэнцүү бол илүүдэл чийгтэй, цармын бүс,

ГТК нь 1.6-1.3 бол хангалттай чийгтэй, чийглэг ойн бүс


ГТК нь 1,3-1.0 бол чийг дутмаг, ойт хээр,  
 ГТК нь 1,0-0.7 бол хуурайдуу, хээрийн бүс,  
 ГТК нь 0.7-0.4 бол хуурай, хуурай хээрийн бүс,  
 ГТК нь 0.4-0.3 бол ихээхэн хуурай, заримдаг цөлийн бүс,  
 ГТК нь 0.2 ба үүнээс бага бол хэт хуурай, цөлийн бүс гэж ялгана.

Энэ нь мөн байгалийн бүс бүслүүрийн ангилал ч болж чаддаг. Энэ бүдүүвчээр ГТК нь 0.4 – аас бага газарт зөвхөн усалгаатай тариалан эрхэлж болно гэж үздэг. Завхан аймгийн цаг уурын ажиглалтын цэгүүдээр 1961-1990 оны дундажаар тооцоолсон ГТК-ийн утгыг 4 дүгээр хүснэгтэд үзүүлэв. Гэхдээ эх мэдээ нь эргэлзээтэй, ялангуяа ургамал ургалтын хугацааны хур тунадасны хэмжээ нь эргэлзээтэй цэгүүдийг ялган тэмдэглэв. Цаг уурын өртөөдийн мэдээгээр 1991-2011 оны дундаж байдлаар ГТК итгэлцүүр хааш нь (чийгших буюу хуурайших) чиглэлтэй өөрчлөгдөж байгааг харуулах зорилгоор бутархай дор бичив.

Хүснэгт 4. Селяниновын ус дулааны итгэлцүүрийн норм утга

№	Ажиглалтын цэгүүд	ГТК	№	Ажиглалтын цэгүүд	ГТК
1	Алдархаан	0.7*	13	Ургамал	0.2
2	Баянхайрхан	1.3	14	Цагаанхайрхан	0.8
3	Завханмандал	0.4	15	Цагаанчулуут	0.8*
4	Идэр	1.4	16	Шилүүстэй	0.3*
5	Их Уул	0.8*	17	Эрдэнэхайрхан	1.1
6	Нөмрөг	0.9	18	Яруу	1.1
7	Отгон	1	19	Улиастай	1.1/1,0
8	Сантмаргаз	0.8	20	Дөрвөлжин	0.4
9	Сонгино	1.4	21	Цэцэн Уул	1.9/1,6
10	Түдэвтэй	1.4	22	Баянтэс	0.9/1,0
11	Тэлмэн	1.1	23	Тосонцэнгэл	1.3/1,2
12	Тэс	0.6*	<b>Тайлбар: * эргэлзээтэй мэдээлэл,</b>		

Хүснэгтээс үзвэл аймгийн уулархаг нутгаар чийглэг, бусад ихэнх нутгаар чийг дутмаг, үүний дотор өмнөд болон баруун хязгаараар ихээхэн хуурай байдалтай юм. Цаг уурын өртөөдөөр тооцоолсон ГТК – ийн газарзүйн хуваарилагдлын зургаас Завхан аймгийн нутгийг таслан зурагт үзүүлэв.



Зураг 8. Селяниновын ус-дулааны итгэлцүүрийн газарзүйн хуваарилагдал



Газар орны чийглэг/хуурай байдлыг илэрхийлэхэд Оросын Сибирийн хэсэгт өргөн ашигладаг нэг үзүүлэлт нь Мезенцевийн чийгшлийн итгэлцүүр юм. Энэ үзүүлэлт Монгол нутагт ч гэсэн тохирохоор юм.

$$K_{\text{мез}} = \frac{P}{E_M}$$

Энд  $P$  нь жилийн нийлбэр хур тунадас, мм-ээр,  $E_M$  нь жилийн нийлбэр ууршиц буюу дэвсгэр гадаргын ууршуулах чадвар. Үүнийг В. С. Мезенцевийн томъёоны хуваарьт байгаа илэрхийллээр тодорхойлох нь зүйтэй гэж үздэг.

$$K_y = \frac{P}{(0.2 \sum T_{>10^0} + 306)}$$

Энд 306 гэсэн тоо бол сав газрын урсацыг тооцсон тогтмол. Мезенцевийн ангилалаар газар орны чийгшлийн байдлыг нэлээд нарийн ялгасан байдаг.


Хүснэгт 5. Мезенцевийн ангилал

Чийгшлийн зэрэг	Чийгшийн итгэлцүүр	Байгалийн бүс
Гандуу	0,0...0,2	Цөл
	0,2-0,3	Заримдаг цөл
	0,3...0,4	хуурайвтар
Чийг дутмаг	0,4...0,5	Жинхэнэ хээр
	0,5...0,7	Умарт хээр
	0,7...1,0	Ойт хээр
Хангалттай чийгтэй	1,0...1,2	Өргөн навчит ой
Их чийгтэй	1,1...1,5	Холимог ой
	1,5...2,0	Тайга
Илүүдэл чийгтэй	2,0	Тундр

Аймгийн цаг уурын өртөө, харуулуудаар тооцоолсон Мезенцевийн чийгшицийн итгэлцүүрийн утгыг 5 дугаар хүснэгтэд үзүүлэв. Хүснэгтээс харвал аймгийн цаг уурын өртөө, харуулуудын мэдээгээр ихэнх нутаг нь гандуу бүсэд хамаарах, газарзүйн мэдээллийн системээр боловсруулсан зургаас уулархаг бүс нутаг нь л чийг дутмаг бүс нутагт хамаарч байна.


Хүснэгт 6. Мезенцевийн чийгшицийн итгэлцүүрийн норм утга

№	Цэгүүд	$K_{\text{мез}}$	№	Цэгүүд	$K_{\text{мез}}$
1	Алдархаан	0.2	13	Ургамал	0.09
2	Баянхайрхан	0.4	14	Цагаанхайрхан	0.3
3	Завханмандал	0.15	15	Цагаанчулуут	0.25
4	Идэр	0.39	16	Шилүүстэй	0.09
5	Их Уул	0.25	17	Эрдэнэхайрхан	0.37
6	Нөмрөг	0.27	18	Яруу	0.27
7	Отгон	0.27	19	Улиастай	0.38/0.35
8	Сантмаргаз	0.24	20	Дөрвөлжин	0.15/0.12
9	Сонгино	0.4	21	Цэцэн Уул	0.5/0.45
10	Түдэвтэй	0.44	22	Баянтэс	0.33/0.34
11	Тэлмэн	0.27	23	Тосонцэнгэл	0.42/0.41
12	Тэс	0.29			



Зураг 9. Мезенцевийн чийгшицийн итгэлцүүрийн газарзүйн хуваарилалдал

Цаг уурын өртөө харуулуудын 1991-2011 оны мэдээгээр Баянтэсээс бусад сумдын нутгаар мөн л хуурайшил нэмэгдэж байх юм. Мезенцевийн чийгшицийн итгэлцүүрийн олон жилийн хандлагыг Улиастай, Тосонцэнгэл өртөөгөөр зурагт үзүүлэв.



Диаграмм 4. Мезенцевийн чийгшицийн итгэлцүүрийн олон жилийн явц

Зургаас чийгшицийн зэрэг ерөнхийдөө буурч байгаа бөгөөд энэ нь Селяниновын ГТК – ийн явц дээр ч давхар харагддаг.

### 2.1.2 Уур амьсгалын өөрчлөлтөөс хөдөө аж ахуйд учирч болох эрсдэл

**Хэт халалт буюу халууны долгион:**

Бүс нутагт ургамлын дулаан хангамж нэмэгдэж байгаагийн зэрэгцээ халуун өдрийн тоо нэмэгдэж байна. Аймгийн уур амьсгалын лавлахын мэдээгээр өнгөрсөн зууны жараад оноос 80-аад он гартал агаарт  $30^{\circ}\text{C}$  – аас халуун өдрийн тоо говийн сумдаар 9-18 өдөр, үүний дотор Дөрвөлжинд 18 өдөр, бусад нутгаар 10 хоногоос

цөөн, ихэнхдээ 2-6 өдөр орчим байдаг байсан байдаг. Улиастайн 1961-1990 оны мэдээгээр жилдээ 1 өдөр орчим энэ хэмжээнээс давж халдаг байсан атал 1991-2016 оны мэдээгээр 5.1 өдөр энэ хэмжээнээс давж халдаг болсон байна. Дөрвөлжинд 1975-1990 оны дундажаар 7,6 өдөр  $30^{\circ}\text{C}$  – аас давж халдаг байсан бол 1991-2016 оны мэдээгээр 5-9 дүгээр сард жилд дундажаар 20,2 өдөр хэт халдаг болсон байна.

### Агаар мандлын ган:

Ган/зуншлагын байдлыг илэрхийлэхэд янз бүрийн үзүүлэлт буюу ган/зуншлагын индексүүдийг ашигладаг. Гэхдээ ган/зуншлагыг илэрхийлэх үзүүлэлт бол АНУ – д хэрэглэгддэг Пальмерийн индекс (PDSI), ОХУ – д өргөн хэрэглэдэг Селяниновын ус – дулааны индекс - ГТК шиг ургамалжлын бүс бүслүүрийг илтгэдэг шинж чанартай бус тухайн хугацааны (сарын юм уу зуны улирлын) цаг агаарын нөхцлийн гаж байдлыг (аномали нөхцлийг) илэрхийлдэг байх нь зохистой юм<sup>2</sup>. Тухайн нөхцөлд Зөвлөлт – Оросын эрдэмтэн Д. И. Педийн дэвшүүлсэн

$$S_i = \frac{\sum_{i=1}^n \Delta T_i}{\sigma_i} - \frac{\sum_{i=1}^n \Delta P_i}{\sigma_i}$$

гэсэн үзүүлэлтийг ашиглах нь зохистой. Энд  $\Delta T$  – сарын дундаж агаарын температурын нормоосоо хазайх хазайц,  $\Delta P$  – сарын нийлбэр хур тунадасны нормоосоо хазайх хазайц,  $i$  - ажиглалтын цэгүүдийн дугаар,  $\sigma_i$  – сарын дундаж темпероатур, сарын нийлбэр хур тунадасны стандарт хазайц,  $n$  – ажиглалтын нийт цэгийн (өртөөний) тоо.  $S_i$  – ийн утга тэгээс бага бол зуншлагатай, тэгээс их бол гантай гэж үзэх бөгөөд

$2 < S_i < 3$  – дунд зэргийн гантай,

$3 < S_i < 4$  – хүчтэй ган,

$4 < S_i$  – улаан ган

гэж үзнэ. Гэхдээ энэ бол тухайн 1 цэг дээр тооцоо хийхэд барих хязгаар утга. Олон цэг дээр  $S_i$  – г дундажлан авах тул өөр болно.


Гангийн индекс зуны бэлчээрийн ургац, малын зун – намрын амьдын жинтэй сайн хамааралтай байдаг.

Улиастай өртөөн дээрх гангийн  $S_i$  индексийн олон жилийн явцыг аваад үзвэл сүүлийн 76 жилийн дотор гандуу байдал нэмэгдэж ирсэн, ялангуяа ерээд оны сүүлчээс улам ч эрчимжиж байгаа харагдана.

Гэхдээ хугацааны завсарт ялгаад үзвэл дөчөөд оноос ерээд оны хавь болтол ерөнхийдөө чийгших хандлагатай байснаа ерээд оноос өнөө болтол хуурайших хандлага илт давамгайлж байх юм.


Нэг талаас гангийн эрчимшил хийгээд давтагдал нэмэгдэж байгаа, нөгөө талаас ургамал ургалтын эмзэг үе шатанд дулааны дарамт нэмэгдэж байгаа нь бэлчээрийн болон тарималын ургац буурах уур амьсгалын нөхцлийг бүрдүүлж байгаа юм

<sup>2</sup> Нацагдорж Л. Нацагсүрэн Н.2006: Агаар мандлын ган ба хуурай уур амьсгалыг үнэлэх асуудалд-ШУА-ын Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл, дугаар 6, х. 208-226



Диаграмм 5. Ган/зуншлагын индексийн олон жилийн явц /Улиастай өртөөгөөр/

Диаграммаас харахад Улиастай хот орчимд бэлчээрийн хашаалсан талбайн зуны 10 хоног тутмын ургац (ц/га – аар авсан) - ын цуваанаас тухайн жилийн хамгийн их ургацыг нь түүн авсан дүнгээр байгуулсан бэлчээрийн ургацын олон жилийн явцыг үзүүлэв. Яг иймэрхүү хандлага бусад цаг уурын өртөөдөд хийсэн ажиглалтаас ч харагддаг. 1974 оноос хойш Улиастайд бэлчээрийн ургац нэмэгдэж байгаа хандлага харагдаж байгаа нь 13 дугаар зурагт үзүүлсэн гангийн эрчимшил нэмэгдэж байгаа, 8 дугаар зурагт үзүүлсэн хур тунадасны хэмжээний олон жилийн хандлагатай зөрчилдөж байгаа мэт байх юм.



Диаграмм 6. Бэлчээрийн хашаалсан талбайн зуны их ургацын олон жилийн явц /Улиастай өртөөгөөр/

Гэхдээ бэлчээрийн ургацын олон жилийн цувааг 1974-2002 он болон 2003-2015 он гэж 2 тасалж тренд байгуулаад үзвэл хугацааны эхний хагаст 0,2 ц/га 10 жил – ийн хурдтай бууралт, хугацааны 2 дугаар хагаст 0,6ц/га 10 жил – ийн хурдтай өсөлт явагдаж байгаа харагдана. Энэ бол 2008 оноос хойш хур тунадас хэвийн хэмжээ орчимдоо орж байгаа, ургамал ургалтын хугацаа ялигүй уртасч, ашигтай температурын нийлбэр нэмэгдэж байгаатай холбоотой байж мэднэ. Нөгөө талаар хэт бэлчээрлэлт болоод уур амьсгалын өөрчлөлтийн улмаас бэлчээр сукцессэд орж малын идэмжит ургамлын бүрдэл багасч, лууль, шарилж гм. хөл газрын ургамал

зонхилсон бүрдэл бүхий бэлчээрээр солигдож, үүнээс болоод бэлчээрийн ургамлын нийт ногоон масс нэмэгдэж байж магадгүй<sup>3</sup>. Ерөнхийдөө малын тоо толгой ихээхэн нэмэгдэж бэлчээрт үзүүлэх дарамт нэмэгдэж байгаа хийгээд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас аймгийн бэлчээрийн бүтээмж буурч байж магадгүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

### **Агаар мандлын зуд:**

Монгол орны нутаг дэвсгэр дээр хугацаа өнгөрөх тутам идэвхжиж байгаа уур амьсгалын өөрчлөлтийн явцад 2000-аад оны хавиас зудын эрчимшил улам бүр идэвхжиж, үүнийг дагаад том малын зүй бус хорогдол нэмэгдэх хандлагатай байна<sup>4</sup>.

Зуд гэдэг нь бэлчээрийн мал сүрэг өвөл-хаврын улиралд унд ус болон бэлчээр (тэжээл) - ээр удаан хугацаагаар дутагдан эцэж, тураалын туйлд хүрч үхэж хорогдоход хүргэх уур амьсгалын экстремаль нөхцөл юм<sup>5</sup>. Зудын үр дагаврыг одоогоор зөвхөн малын зүй бус хорогдлоор, сүүлийн үед хөдөөгийн ядуурлаар үнэлж байгаа<sup>6</sup> боловч өргөн утгаараа өвсөн тэжээлт амьтдын амьдрах орчин нэлдээ доройтох, тэр байтугай зун-намрын улиралд өөхөө нөөцөлж амжаагүй ичээний амьтдад ч сөргөөр нөлөөлдөг агаар мандлын гаралтай гамшигт үзэгдэл юм. Зуд гэдэг зөвхөн өвөл-хаврын үзэгдэл бус, зун бэлтгэгдэж өвөл-хаврын цагийн хатууд гор нь гардаг үзэгдэл. Иймээс зудыг зун-өвлийн уур амьсгалын аномали байдлыг илэрхийлэх индекс (ган/зуншлагын болон өвлийн өнгийн индекс) - үүдийн хослол утгаар илэрхийлдэг бөгөөд эдгээр нь бэлчээрийн ургац, малын амьдын жин буюу тарга тэвээрэг, малын зүй бус хорогдолтой өндөр хамааралтай байдаг. Зуд болох цаг уурын нөхцлийн үнэлгээг өмнө үзүүлсэн Д. А. Педийн ган/зуншлагын индексийг мөн өвлийн саруудаар тооцоолж өвлийн индекс хэмээн аваад дараа нь зуны индексээс өвлийн индексийг хасч

$$\Delta S = S_{\text{зун}} - S_{\text{өвөл}}$$

ялгаврыг нь зудын индекс гэж авсан болно.

Зурагт 1958 - 1959 оноос 2015-2016 оны хооронд аймгийн хэмжээний том малын зүй бус хорогдлын оны эхэнд байсан малын тоонд эзлэх хувь ба Улиастай, Тосонцэнгэл, Дөрвөлжин гэсэн цаг уурын 3 өртөөгөөр дундажласан зудын индексийн олон жилийн явцыг үзүүлэв.


Том малын зүй бус хорогдол их гарсан жилүүдийг аваад үзэхэд зун нь хэдий гантай, өвөл нь хэдий хатуу байсан бол төдийчнээ зудтай, зарим тохиолдолд зун нь гантай ч өвөл өнтэй, эсвэл зуншлага сайн, харин дараа өвөл нь цаг их хатуурсан байхад зудын индексийн их бус утганд ч малын хорогдол хэвийн хэмжээнээсээ давж гарч болно.

<sup>3</sup> Хамтын бүтээл. Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан (2015) Швейцарийн хөгжлийн агентлагийн “Ногоон алт” төсөл, 2015

<sup>4</sup> Монгол улс: Уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний 2 дугаар илтгэл – УБ., 2014

<sup>5</sup> Natsagdorj.L, Dulamsuren.J 2001 Some aspects of assessment of the dzud phenomena- Papers in meteorology and hydrology UB. 2001. pp. 3-18, Natsagdorj L Sarantuya G. ON THE ASSESMENT AND FORECASTING OF WINTER –DISASTER ( ATMOSPHERIC CAUSED DZUD) OVER MONGOLIA –“the sixth international workshop proceeding on climate change in Arid and Semi-Arid Regions of Asia” Aug. 25-26 .2004 UB.pp 72-88

<sup>6</sup> Байгаль цаг уурын өөрчлөгдөл малчин өрхийн амьжиргаанд хэрхэн нөлөөлснийг судалсан нь: - /НҮБХХ МОН 01/Ю01 төслийн тайлан, УБ., 2003, 112 тал



Диagramм 7. Том малын зүй бус хорогдлын хувь ба зудын индексийн олон жилийн явц /аймгийн дунджаар/

Тайлбар: 1993 оны хаврын их цасны улмаас хорогдсон малын тоог 1992-1993 оны зудын хороглоос ялгаж чадаагүй учраас хасч тооцов

Зудын тоон индексээр баримжаалбал хамгийн эрчимтэй зуд 1967-1968, 1976-1977, 1999-2000, 2000-2001, 2001-2002, 2008-2009, 2009-2010 онуудад тохиолдсон байх юм. Зудын индекс ба том малын зүй бус хорогдлын хамаарал сүргийн бүтэц уламжлалт байдалдаа ойролцоо байсан 1959-2001 оны хооронд  $R = 0.83$  байсан бол сүргийн бүтэц ихээхэн эвдэрсэн 2002-2016 оны хооронд  $R = 0.64$  болж буурсан байх юм.

## 2.2 ЗАВХАН АЙМГИЙН УРГАМАЛЖИЛ, УРГАМЛАН БҮРХЭВЧ

### 2.2.1 Завхан аймгийн ургамалжил

Завхан аймгийн Тэс, Баянтэс, Асгат, Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Нөмрөг, Тэлмэн, Яруу, Идэр, Отгон, Алдархаан, Цагаанчулуут, Цагаан хайрхан, Шилүүстэй зэрэг сумдын нутаг өндөр уулын тагийн болон уулын хээрийн, уул хоорондын хөндийн хээрийн бүсийн ургамалжил зонхилдог. Үүнд:

#### Өндөр уулын тагийн бүслүүрийн ургамалжил:

Завхан аймагт Хангайн нурууны д.т.д. 2700-3200 м-ийн өндөрт өндөр уулын тагийн бүслүүрийн **бушилз-улалжит** нугад Утсан бушилз (*Kobresia filifolia* (Turcz.) Clarke.), Беллардийн бушилз (*Kobresia Bellardii* (All.) Degl.), Хялгасан бушилз (*Kobresia capilliformis* Ivanova.), Сибирь бушилз (*Kobresia sibirica* Turcz.ex Bess.), Одой бушилз (*Kobresia humilis* (C.A. Mey.ex Trautv.) Serg.), Одой бушилз (*Kobresia humilis* (C.A. Mey.ex Trautv.) Serg.), Энгийн бушилз (*Kobresia simpliciuscula* (Wahlbg.) Mack.), Хар толгойторхуу улалж (*Carex melananthiformis* Litv.), Зогдор улалж (*Carex pediformis* C.A.Mey.), Коржинскийн улалж (*Carex Korshinskyi* Kom.), Хар цэцэгт улалж (*Carex melanantha* C.A.Mey.), Цэх түрүүт улалж (*Carex orthostachys* C.A.Mey.), Шонтонт улалж (*Carex rostrata* Stokes.), үетэнээс Тагийн биелэг өвс (*Poa alpina* L.), Алтайн биелэг өвс (*Poa altaica* Trin.), Сунагар биелэг өвс (*Poa attenuata* Trin.), Сибирь биелэг өвс (*Poa sibirica* Roshev.), Монгол Шивэлз (*Ptilagrostis mongholica* (Turcz.Ex Trin.) Griseb.), Юнатовын Шивэлз (*Ptilagrostis Junatovii* Grub.), Тагийн сорной (*Hierochloe alpina* (Sw.)Roem.Et Schult.), Алтайн дааган сүүл (*Koeleria altaica* (Domin)

Kryl.), Улаан ботууль (*Festuca rubra* L.), Алтайн ботууль (*Festuca altaica* Trin.), алаг өвснөөс Төллүүр тарна (*Polygonum viviparum* L.), Гоо дэвхэргийн цагаан (*Arenaria formosa* Fisch.), Тагийн буржгар (*Thalictrum alpinum* L.), Бүтэн навчит хонлин (*Lagotis integrifolia* (Willd.) Schischk.), Цагаан дэгд (*Gentiana algida* Pall.), Тагийн голгэсэр (*Aster alpinus* L.), Цайвар шаргал цагаан түрүү (*Leontopodium ochroleucum* Grub.), Ямаан Сэрдэг (*Saxifraga hirculus* L.), Хүйтний гичгэнэ (*Potentilla gelida* C.A.Mey.), Цав цагаан гичгэнэ (*Potentilla nivea* L.), Гоолиг холтсон цэцэг (*Ranunculus pulchellus* C.A.Mey.), Мөсний хүчингэ (*Oxygraphis glacialis* (Fisch.) Vge.) зэрэг ургамлууд ургадаг.

Ян сарьдгийн орой өөд өгсөх тутам үхэр чулуу, асга нураг ихтэй, мөн газартаа наалдсан намхан сөөгөн ширэнгэд Тошлогонцор Бургас (*Salix berberifolia* Pall.), Зоосон бургас (*Salix nummularia* Anderss.), Хуурамч арц (*Juniperus pseudosabina* Fisch. et Mey.), Хонин арц (*Juniperus sabina* L.), Ирт зожир өвс (*Dryas oxyodonta* Juz.), Мэнгэт зожир өвс (*Dryas punctata* Juz.), Өргөст харгана (*Caragana spinosa* (L.) DC.), Сөөгөн боролзгоно (*Dasiphora fruticosa* (L.) Rydb.), Өргөст тошлой (*Grossularia acicularis* (Smith)Spach.), Гоо улаалзгана (*Ribes pulchellum* Turcz.), Өргөст нохойн хошуу (*Rosa acicularis* Lindl.), Алтайн далан хальс (*Lonicera altaica* Pall.) ургадаг.

Өндөр уулын тагаас уулсын өвөр талын энгэр хажуугаар өвөрмөц маягийн тагийн хээр бүрэлдэн бий болсон байдаг бөгөөд энд Хонин ботууль (*Festuca ovina* L.), Дэргэр биелэг өвс (*Poa subfastigiata* Trin.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.), Сибирь үрээн сүүл (*Trisetum sibiricum* Rupr.), Соргүй согоовор (*Bromus inermis* Leyss.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Нарийн навчит тарна (*Polygonum angustifolium* Pall.), Хялгасан Дэвхэргийн цагаан (*Arenaria cappilaris* Poir.), Бунгийн Яргуй (*Pulsatilla Bungeana* C.A.Mey.), Хэвтээ дэгд (*Gentiana decumbens* L.), Түмэн навчит хувилгана (*Pedicularis myriophylla* Pall.), Шарилж навчит хувилгана (*Pedicularis abrotanifolia* M.B. ex Stev.), Хоёр ишт бэриш (*Bupleurum bicaule* Helm.), Жинхэнэ өрөмтүүл (*Galiun verum* L.), Алтайн согсоот (*Heteropappus altaicus* (Willd.) Novopokr), Маралхай шарилж (*Artemisia tanacetifolia* L.), Агь (*Artemisia frigida* Willd.) зэрэг ургамал ургана.

#### Уулын хээр, хээрийн ургамалжил:

Уулын хээр Завхан аймгийн нутагт умард Хангайд д.т.д. 1000-1200 м –т, өмнөд Хангайд д. т .д. 1400-1500 м орчимд байдаг бөгөөд энд **үетэн-алаг өвст, ботууль-агьт** бүлгэмдэлд үетэн ургамлаас Хонин ботууль (*Festuca ovina* L.), Лени ботууль (*Festuca lenensis* Drob.), Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Шеллийн бутнуур (*Helictotrichon Schellianum* (Hack.) Kitag.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), улалжаас Зогдор улалж (*Carex pediformis* C.A.Mey.), алаг өвснөөс Хялгасан Дэвхэргийн цагаан (*Arenaria cappilaris* Poir.), Торгон гичгэнэ (*Potentilla sericea* L.), Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis* L.), Енисейн шээрэнгэ (*Silene jensseensis* Willd.), Нүцгэн намуу (*Papaver nudicaule* L.), Шар гонтог (*Erysimum flavum* (Georgi) Bobr.), Өндгөрхүү шар дэмэг (*Alyssum obovatum* (C.A.Mey.) Turcz.), Налчгар хэрээн хошуу (*Sibbaldianthe adpressa* (Vge.) Juz.), Алтайн түмэн тана (*Chamaerhodos altaica* (Laxm.) Vge.), Хэвтээ дэгд (*Gentiana decumbens* L.), Хоёр ишт бэриш (*Bupleurum bicaule* Helm.), Жинхэнэ өрөмтүүл (*Galiun verum* L.), Гоо юлт (*Goniolimon speciosum* (L.) Boiss.), Турчаниновын яргуй (*Pulsatilla Turczaninovii* Kryl.et Serg.), Буурал гандбадраа (*Veronica incana* L.), Говийн ганга (*Thymus gobicus* Tschern.), Үетнэрхүү гэсэрдэй (*Arctogeron gramineum* (L.) DC.), Өргөн навчит тайжинс (*Echinops latifolius* Tausch.), Хонгорзуллаг

хонгорзалаа (*Serratula centauroides* L.), Алтайн согсоот (*Heteropappus altaicus* (Willd.) Novopokr), Маралхай шарилж (*Artemisia tanacetifolia* L.), Салбант шарилж (*Artemisia laciniata* Willd.), Агь (*Artemisia frigida* Willd.) зонхилно.

Уулс хоорондын хуурай хөндий ба ухаа толгодот тэгш талаар хуурайсаг үетэн ба алаг өвс зонхилсон **хялганат, хялгана-хазаарганат, хялгана-агьт, хялгана-алаг өвст** бүлгэмдэлд үетэнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Үслиг хялгана (*Stipa capillata* L.) Том цэцэгт дааган сүүл (*Koeleria macrantha* (Ldb.) Schult.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), алаг өвснөөс Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis* L.), Марал навчит гичгэнэ (*Potentilla tanacetifolia* Willd. ex Schlecht.), Бөөнөг гичгэнэ (*Potentilla conferta* Bge.), Амманы сэдэргэнэ (*Convolvulus Ammanii* Desr.), Хэрчлээст бивлэнцэр (*Schizonepeta multifida* (L.) Briq.), Буурал гандбадраа (*Veronica incana* L.), Дагуур хатны цэцэг (*Cymbaria dahurica* L.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Хонгорзуллаг хонгорзалаа (*Serratula centauroides* L.), Алтайн согсоот (*Heteropappus altaicus* (Willd.) Novopokr), буурцагтанаас Юлдэн Тарваган шийр (*Thermopsis lanceolata* R.Br.), шарилжнаас Ишгэн шарилж (*Artemisia dracuncululus* L.), Адамсийн шарилж (*Artemisia Adamsii* Bess.), Агь (*Artemisia frigida* Willd.) зонхилно.

#### **Хээрийн, цөлөрхөг хээрийн бүсийн ургамалжил:**

Завхан аймгийн Ургамал, Завханмандал, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Дөрвөлжин сумдын нутаг хээрийн болон цөлөрхөг хээрийн ургамал зонхилох бөгөөд энд:

**1. Уул толгодын чулуутай бэлчээрт** Монгол өвс-ерхөг-шавагт-харганатай, Монгол өвс-боролзойт-харганатай, Монгол өвс-шавагт, Тэсэг-боролзой-шаваг-харганат, Монгол өвс-харганат бүлгэмдэлд 50 м<sup>2</sup> талбайд 7-26 зүйл, 1м<sup>2</sup> талбайд 2-6 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлан нөмрөгийн бүрхэц 9.0-32.2%, халцгай газар 11.8-29.2%, хад чулуу 37.8-66.4% эзэлж, 2017 оны га –ийн зуны дээд ургац 1.5-2.3 ц/га байна. Дээрх бүлгэмдэлд Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Сайрын хялгана (*Stipa glareosa* P.Smirn.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Цацаглаг биелэг өвс (*Poa botryoides* Trin.), Нангиад түнгэ (*Leymus chinensis* (Trin.) Tzvel.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.) Keng.), үндэслэг ишт ба сонгинолог нэг талтанаас Нарийн цахилдаг (*Iris tenuifolia* Pall.), Таана буюу багалгар сонгино (*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Хөмөл (*Allium mongolicum* Rgl.), Дэлхээ сонгино (*Allium prostratum* Trev.), Потаниний цахилдаг (*Iris Potaninii* Maxim.), Говийн хэрээннүд (*Asparagus gobicus* Ivanova ex Grub.), улалжаас Утсан навчит улалж (*Carex stenophylloides* V.Krecz.), буурцагтанаас Грубовын хунчир (*Astragalus Grubovii* Sancz.), Павловын ортууз (*Oxytropis Pavlovii* V.Fedtsch. et Basil.), Үсэрхэг тарваган шийр (*Thermopsis hirsutissima* Czefr.), Алтан харгана (*Caragana leucophloea* Rojark.), Хавиргалаг гиш (*Vicia costata* Ldb.), алаг өвснөөс Олон наст багдай (*Dontostemon perennis* C.A.Mey.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Хялгасан дэвхэргийн цагаан (*Arenaria cappularis* Poir.), Хоёр ишт бэриш (*Bupleurum bicaule* Helm.), Амманы сэдэргэнэ (*Convolvulus Ammanii* Desr.), Чүйт сүүт өвс (*Euphorbia tschuensis* (Porkh.) Serg.), Сибирь ерөндгөнө (*Vincetoxicum sibiricum* (L.) Decne.), Олон наст багдай (*Dontostemon perennis* C.A.Mey.), Элсний түмэн тана (*Chamaerhodos sabulosa* Bge.), Гоо юлт (*Goniolimon speciosum* (L.) Boiss.), Үсхий нохойн хэл (*Panzeria lanata* (L.) Bge.), Арзгар согсоот



(*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Данхар хависгана (*Scorzonera capito* Maxim.), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), Нарийн цэцэгт юнги (*Youngia tenuicaulis* (Babc.et Stebbins) шарилжнаас Памирын шарилж (*Artemisia pamirica* C.Winkl.), Шардуу шарилж (*Artemisia globosoides*), Агь (*Artemisia frigida* Willd.), Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Шаргал шарилж (*Artemisia rutifolia* Steph. ex Spreng.), Хар шарилж (*Artemisia santolinifolia* Turcz. ex Bess.), Төлөгчдүү боролзой (*Ajania acheleoides* (Turcz.) Poljak.), луультаанаас Дэлхээ тогторгоно (*Kochia prostrata* (L.) Schrad.), Орог тэсэг (*Eurotia ceratoides* (L.) C.A.Mey.), нэн ховор ургамлаас Хөхөвтөр гувшаахай (*Orobancha coerulescens* Steph.), нэг настанаас Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.), Монгол хамхуул (*Corispermum mongolicum* Iljin.), Шоргор лууль (*Chenopodium acuminatum* Willd.), Бөөн цэцэгт цангуу (*Lepidium densiflorum* Schrad.), Цагаалин галуун таваг (*Chiazospermum lactiflorum* Kar.et.Kir.), Ногоон хоног будаа (*Setaria viridis* (L.) P.B.), Үмхий шимэлдэг (*Dracoscephalum foetidum* Bge.), Нэг наст бивлэнцэр (*Schizonepeta annua* (Pall.) Schischk.), Ямаан шарилж (*Artemisia scoparia* Waldst. et Kit.), нүцгэн үртэнээс Нангиад зээргэнэ (*Ephedra sinica* Stap.) ургасан байв.

2. Сөөгтэй бэлчээрт уулын өвөр талаар говийн **Монгол өвс-харганат, Монгол өвс-харганат, өргөст ортуузтай, Монгол өвс-шаваг-харганат** бүлгэмдэлд 50 м<sup>2</sup> талбайд 5-7 зүйл, 1м<sup>2</sup> талбайд 3-5 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлан нөмрөгийн бүрхэц 9.0-32.2%, халцгай газар 11.8-29.2%, хад чулуу 37.8-66.4% эзэлж, 2017 оны га –ийн зуны дээд ургац 1.3-3.58 ц/га байна. Энд талбайд Алтан харгана (*Caragana leucophloea* Rojark.), Бүнгийн харгана (*Caragana Bungei* Ledeb.) зонхилж, үетэнээс Говийн хялгана (*Stipa gobica* Roshev.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.)Keng.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), буурцагтанаас Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), алаг өвснөөс Үсхий нохойн хэл (*Panzeria lanata* (L.) Bge.), Дэлхээ тогторгоно (*Kochia prostrata* (L.) Schrad.), Өтлүүн багдай (*Dontostemon senilis* Maxim.), Хуурамч дэрэвгэр хависгана (*Scorzonera pseudodivaricata* Lipsch.), нэг талтнаас Нарийн цахилдаг (*Iris tenuifolia* Pall.), шарилжнаас Хуурайсаг шарилж (*Artemisia xerophytica* Krasch.), Сиверсийн шарилж (*Artemisia Sieversiana* Willd.), улалжаас Ширэг улалж (*Carex duriuscula* C.A.Mey.), нэг настанаас Үслиг манан-хамхаг (*Bassia dasyphylla* (Fisch.et Mey.) Ktze.) ургасан байв.


Уулын ар талаар хээрийн **Хялгана-агь-харганат, Хялгана-харганат** бүлгэмдэлд 50 м<sup>2</sup> талбайд 5-10 зүйл, 1м<sup>2</sup> талбайд 2-6 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлан нөмрөгийн бүрхэц 25.6-45.4%, халцгай газар 43.2-67.2%, хайрга чулуугүй, 2017 оны га –ийн зуны дээд ургац 4.7-11.9 ц/га байна. Энд үетэнээс Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa* (Trin.)Keng.), Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), сонгинолог ургамлаас Сарвуун сонгино (*Allium anisopodium* Ldb.), буурцагтанаас Алтан харгана (*Caragana leucophloea* Rojark.), Бүнгийн харгана (*Caragana Bungei* Ledeb.), Грубовын хунчир (*Astragalus Grubovii* Sancz.), Өргөст ортууз (*Oxytropis aciphylla* Ldb.), алаг өвснөөс Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), шарилжнаас Шардуу шарилж (*Artemisia globosoides*) Агь (*Artemisia frigida* Willd.), болон шарилж шимэгч ургамал Хөхөвтөр гувшаахай (*Orobancha coerulescens* Steph.) зэрэг ургасан байв.

3. **Хазаар өвс-монгол өвст, Хялгана-алаг өвст, Хялгана-ерхөг -алаг өвст** бүлгэмдэлд 50 м<sup>2</sup> талбайд 4-12 зүйл, 1м<sup>2</sup> талбайд 2-5 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлан нөмрөгийн бүрхэц 21.0-29.2%, халцгай газар 67,2-76.8% эзэлж, бараг

хад чулуугүй, га –ийн ургац зуны дээд ургацад шилжүүлсэнээр (8 сарын 10-20) -2.04 ц/га байна. Энд үетэнээс Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.), Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Гялгар дэрс (*Achnatherum splendens* (Trin.) Nevski.), нэг талтнаас Нарийн цахилдаг (*Iris tenuifolia* Pall.), Сарвуун сонгино (*Allium anisopodium* Ldb.), буурцагтанаас Алтан харгана (*Caragana leucophloea* Pojark.), Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Павловын ортууз (*Oxytropis Pavlovii* B.Fedtsch.et Basil.), алаг өвсөнөөс Олон наст багдай (*Dontostemon perennis* C.A.Mey.), Үсхий нохойн хэл (*Panzeria lanata* (L.) Vge.), Арзгар согсоот (*Heteropappus hispidus* (Thunbg.) Less.), Хонгорзуллаг хонгорзалаа (*Serratula centauroides* L.), буурцагтанаас Шардуу шарилж (*Artemisia globosoides*), Дэгнүүлт шарилж (*Artemisia caespitosa* Ldb.) зэрэг ургамал ургасан байв.

### Элсний ургамлын бүлгэмдэл:

Монгол элсний элсний шарилжит бэлчээр Дөрвөлжин сумын Сээр, Сэрвэн уулнаас дээшхи талбайд Клеменцийн шарилж (*Artemisia Klementzae* Krasch. ex Leonova.), Бөндгөр шарилж (*Artemisia sphaerocephala* Krasch.), Шар шарилж (*Artemisia xanthochroa* Krasch.), Үсхий суль (*Psammochloa villosa* (Trin.) Bor.), Сөөгөн Шимэрс (*Hedysarium fruticosum* Pall.) ургасан хэлбэртэй тааралдана. Монгол элсэнд Завхан голын эргээрх (Шар тохойд) заримдаг сөөгөнцөр-элсний суль бэлчээрт Сөөгөн Шимэрс (*Hedysarium fruticosum* Pall.) Үсхий суль (*Psammochloa villosa* (Trin.) Bor.), болон Сайрын хялгана (*Stipa glareosa* P. Smirn.), хөмөл (*Allium mongolicum* L.) ургана.



Зураг 1. Завхан аймгийн ургамалжилтын зураг

### 2.2.2 Завхан аймгийн байгалийн бэлчээр

Завхан аймгийн байгалийн бэлчээр нь 8330627.25 га, үүнээс мал сүргийг хэрэгцээт тэжээлээр хангах тохиромжтой 6960989.34 га (83.56%) бэлчээр нутаг

байхад бэлчээрт ашиглах боломжгүй мөнх цас, хад, цохио, асга бүхий 1369637.91 га (16.44%) талбай байна.

Монгол орны бэлчээр хадлангийн ангилааны дагуу нийт 244 төрлийн бэлчээр байдгаас Завхан аймагт 180 төрлийн бэлчээрт 70 овог, 350 төрлийн 1200 гаруй зүйл ургамал ургадаг бөгөөд байгалийн бүс бүслүүрийн хуваарилалт, газрын рельеф, экологийн нөхцлийг харгалзан үндсэн 9 бүлэгт хувааж болох юм. Үүнд:

1. Өндөр уулын бэлчээр
2. Дундаж өндөр болон нам уулын хээрийн бэлчээр
3. Өндөр уулын хоорондох нуга хөндийн бэлчээр
4. Нам уул хоорондох нуга хөндийн бэлчээр
5. Тал хээрийн бэлчээр
6. Цөлжүү хээрийн бэлчээр
7. Говь цөлийн элсний бэлчээр
8. Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр
9. Бэлчээрт тохиромжгүй газар

#### Өндөр уулын бэлчээр.

Завхан аймгийн Улиастай хот орчимд болон Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Отгон зэрэг сумдын нутагт Хангай, Тарвагатай, Булнайн нуруудын өндөр уулсын (д.т.д. 2300-3600 м) оройн хэсэгт ойн бүслүүрээс дээш тохиолддог, хаг хөвдөт таг царамын улалж-бушилзат, нугат хээрийн болон чулуурхаг хээрийн дэгнүүлт үетэнт (ботуульт, биелэгт) бүлэг төрлийн бэлчээр зонхилдог. Зөвхөн улалж-бушилзат бэлчээр Завхан аймгийн хэмжээнд 128.2 мян. га талбайг эзэлдэг байна. Дээрх бүлэг төрлийн бэлчээрийн 100 ам метр талбайд 33-45 зүйл ургамалтай, тэдгээр нь өтгөн боловч тачир ургадагын дотор малын идэмж сайтай ургамал 10 гаруй зүйл, 2.0-8.5 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд сайн буюу уураг 11.2%, тослог 3.1% эзэлдэг байна.

Хүснэгт 88. Өндөр уулын бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Утсан бушилз ( <i>Kobresia filifolia</i> (Turcz.) Clarke.)	-	3	4	4	4	4
2	Беллардийн бушилз ( <i>Kobresia Bellardii</i> (All.) Degl.)		4	4	4	4	4
3	Энгийн бушилз ( <i>Kobresia simpliciuscula</i> (Wahlbg.) Mack.)	-	4	4	4	4	4
4	Зогдор улалж ( <i>Carex pediformis</i> С.А.Мей.)	-	-	4	4	4	4
5	Коржинскийн улалж ( <i>Carex Korshinskyi</i> Ком.)	-	4	4	4	4	4
6	Хар цэцэгт улалж ( <i>Carex melanantha</i> С.А.Мей.)	-	-	4	2	2	4
7	Улаан ботууль ( <i>Festuca rubra</i> L.)	-	-	5	4	4	5
8	Ленийн ботууль ( <i>Festuca lenensis</i> Drob.)	-	5	4	5	5	4
9	Хонин ботууль ( <i>Festuca ovina</i> L.)	-	5	4	5	5	4
10	Алтайн биелэг өвс ( <i>Poa altaica</i> Trin.)	-	-	4	4	4	4
11	Сунагар биелэг өвс ( <i>Poa attenuata</i> Trin.)	-	4	4	3	3	4
12	Сибирь биелэг өвс ( <i>Poa sibirica</i> Roshev.)	-	4	4	4	4	4
13	Монгол шивэлз ( <i>Ptilagrostis mongholica</i> (Turcz. Ex Trin.) Griseb.),	-	4	4	-	-	4

**Тайлбар:** Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)

Өндөр уулын бэлчээр нь сарлаг, хайнаг, үхэрийн тохиромжтой бэлчээрийн нутаг бөгөөд мөн бог мал, адууг бэлчээх боломжтой. Үүнд:

- Зун-намрын улиралд сарлаг **үхэрт** нэн тохиромжтой (**33.69%**) бэлчээртэй нутаг Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Яруу, Алдархаан, Отгон сумдад байна.
- Өвөл-хаврын улиралд сарлаг **үхэрт** нэн тохиромжтой (**21.03%**) бэлчээртэй нутаг Баянтэс, Асгат, Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Номгон, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Яруу, Алдархаан, Отгон сумдад байна.

### Дундаж өндөр болон нам уулын хээрийн бэлчээр

Завхан аймгийн Тэс, Баянтэс, Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Номгон, Тэлмэн Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Яруу, Отгон зэрэг Хангайн сумдад 2 –р зэргийн өндөр уулс болон дундаж өндөр уулын оройгоос уулсын өвөр талын энгэр хажуугаар д.т.д. 2000-2700 м –т, Шилүүстэй, Цагаан Хайрхан, Алдархаан, Сантмаргад, Цэцэн уул, Эрдэнэхайрхан зэрэг говь Хангай хосолсон сумдад д. т .д. 1800-2300 м орчимд, Завханмандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг говийн сумдад д. т .д. 1500-2000 м орчимдм **уулын хээрийн дэгнүүлт үетэнт, алаг өвст бүлгийн бэлчээр зонхилдог** бөгөөд энд 100 ам метр талбайд 26-32 зүйл ургамалтай, тэдгээр нь өтгөн боловч дундаас өндөр ургадагын дотор малын идэмж сайтай ургамал 10-аад зүйл, 3.2-7.6 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд сайн буюу уураг 11.4%, тослог 2.7% эзэлдэг байна.

Хүснэгт 1. Дундаж өндөр уулын бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

д/д	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Зогдор улалж ( <i>Carex pediformis</i> C.A.Mey.)	-	-	4	4	4	4
2	Ленийн ботууль ( <i>Festuca lenensis</i> Drob.)	-	5	4	5	5	4
3	Хонин ботууль ( <i>Festuca ovina</i> L.)	-	5	4	5	5	4
4	Саман ерхөг ( <i>Agropyron cristatum</i> (L.) P.B.)	4	5	4	5	5	4
5	Цацаглаг биелэг өвс ( <i>Poa botryoides</i> Trin.)	-	4	4	3	3	4
6	Сунагар биелэг өвс ( <i>Poa attenuata</i> Trin.)	-	4	4	3	3	4
7	Том цэцэгт дааган сүүл ( <i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schult.)	-	4	3	4	4	4
8	Шеллийн бутнуур ( <i>Helictotrichon Schellianum</i> (Hack.) Kitag.)	-	4	4	4	4	4
9	Крыловын хялгана ( <i>Stipa Krylovii</i> Roshev.)	-	4	4	4	4	4
10	Агь ( <i>Artemisia frigida</i> Willd.)	5	4	4	5	5	4

**Тайлбар:** Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)

Дундаж өндөр уулын хээрийн бэлчээр нь сарлаг, хайнаг, үхэрийн тохиромжтой бэлчээрийн нутаг бөгөөд мөн бог мал, адуун сүрэг өсгөх боломжтой. Үүнд:

1. Зун-намрын улиралд сарлаг **үхэрт** тохиромжтойгоос нэн тохиромжтой (**65.6%**) бэлчээртэй нутаг Тэс, Баянтэс, Асгат, Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Номгон, Тэлмэн Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Яруу, Отгон сумдад байхад дундаас тохиромжтой нутаг Шүлүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул, Сантмаргад, Завхан мандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг сумдын нутаг орно.
2. Өвөл-хаврын улиралд сарлаг **үхэрт** тохиромжтойгоос нэн тохиромжтой (**55.6%**) бэлчээртэй нутаг Баянтэс, Асгат, Баянхайрхан, Сонгино, Түдэвтэй, Номгон, Тэлмэн,

Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Яруу, Алдархаан, Отгон сумд байхад дундаас тохиромжтой нутаг Шүлүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан зэрэг сумдын нутаг орно.

### Өндөр уулын хоорондох нуга хөндийн бэлчээр.

Завхан аймгийн Улиастай хот орчимд болон Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Отгон зэрэг сумдын нутагт Хангай, Тарвагатай, Булнайн нуруудын өндөр уулсын (д.т.д. 2300 м хүртэл) ойн бүслүүрээс дээш уулсын хойш чиглэсэн налууувар зоо нуруугаар болон уулын модгүй ар хажууг дагаж уруудсаар уулс хоорондын нарийвтар хөндий хотгорын дов сондуул бүхий чийглэг нуга руу шилжсэн тагийн нугын бушилзат, улалжит, дэгнүүлт үетэнт бүлэг төрлийн бэлчээр зонхилдог. Дээрх бүлэг төрлийн бэлчээрийн 100 ам метр талбайд 30-40 зүйл ургамалтай, тэдгээр нь өтгөн, 20-60 см өндөр ургадагын дотор малын идэмж дундаас сайтай ургамал 15-аас олон зүйл, 10.0-19.0 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд сайн буюу уураг 9.51%, тослог 2.94% байна.

Хүснэгт 2. Өндөр уулын хоорондох нутаг хөндийн бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Утсан бушилз ( <i>Kobresia filifolia</i> (Turcz.) Clarke.)	-	3	4	4	4	4
2	Беллардийн бушилз ( <i>Kobresia Bellardii</i> (All.) Degl.)		4	4	4	4	4
3	Хадны улалж ( <i>Carex rupestris</i> Bell.ex All.)	-	-	4	2	2	4
4	Хар цэцэгт улалж ( <i>Carex melanantha</i> C.A.Mey.)	-	-	4	2	2	4
5	Монгол бутнуур ( <i>Helictotrichon mongolicum</i> (Roshev.) Henr.)	0	4	4	4	4	0
6	Соргүй согоовор ( <i>Bromus inermis</i> Leyss.)	-	4	5	4	4	4
7	Монгол шивэлз ( <i>Ptilagrostis mongholica</i> (Turcz.Ex Trin.) Griseb.),	-	4	4	-	-	4
8	Алтайн ботууль ( <i>Festuca altaica</i> Trin.)	-	2	3	-	2	4
9	Алтайн дааган сүүл ( <i>Koeleria altaica</i> (Domin) Kryl.)	-	4	3	4	4	3
10	Триниусын улаан толгой ( <i>Agrostis Trinii</i> Turcz.)	-	4	4	3	3	4
11	Алтайн биелэг өвс ( <i>Poa altaica</i> Trin.)	-	-	4	4	4	4
12	Сунагар биелэг өвс ( <i>Poa attenuata</i> Trin.)	-	4	4	3	3	4
13	Төллүүр тарна ( <i>Polygonum viviparum</i> L.)	-	4	4	3	3	4
14	Эмийн сөд ( <i>Sanguisorba officinalis</i> L.)	-	5	4	5	5	4
15	Олон-ишт гиш ( <i>Vicia multicaulis</i> Ldb.)	-	4	4	4	4	4
16	Живээхэй шимэрс ( <i>Hedysarium inundatum</i> Turcz.)	-	4	5	4	4	5

**Тайлбар:** Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)

Өндөр уулын нуга хоорондын бэлчээр нь Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Яруу, Алдархаан, Отгон сумдад сарлагт тохиромжтой нутаг юм.

### Нам уул хоорондох нуга хөндийн бэлчээр.

Завхан аймгийн Хангайн сумдын нутагт тааралдах д.т.д. 1600-2000 м хүртэл өндөрт өргөгдсөн нам уулс хоорондын хөндий хотгор, уулын голын татмыг дагасан

дэгнүүлт үетэн, алаг өвст бүлэг төрлийн улаантолгойт-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст, биелэг-үетэн-алаг өвст, алаг өвс-үетэн-ботуулыт төрлийн бэлчээрүүд элбэг.

Улаантолгойт-алаг өвст бэлчээрийн 100 ам метр талбайд 32-40 зүйл ургамалтай, тэдгээр нь өтгөн шигүү боловч тачир ургадагын дотор малын идэмж дундаас сайтай ургамал 15- аас цөөн зүйлтэй, 10.0-19.0 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд сайн буюу уураг 9.05%, тослог 3.95% байна.

Алаг өвс-үетэн-ботуулыт бэлчээрийн 100 ам метр талбайд 30-40 зүйл ургамалтай, тэдгээр нь өтгөн шигүү боловч тачир ургадагын дотор малын идэмж дундаас сайтай ургамал 15-аас цөөн зүйлтэй, 5.0-18.0 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд сайн буюу уураг 9.4%, тослог 3.3% байна.

Хүснэгт 3. Нам уулын хоорондох нуга хөндийн бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Ахарсорт арвай ( <i>Hordeum brevisubulatum</i> (Trin.) link.)	-	5	5	4	4	5
2	Саман ерхөг ( <i>Agropyron cristatum</i> (L.) P.B.)	4	5	4	5	5	4
3	Цацаглаг биелэг өвс ( <i>Poa botryoides</i> Trin.)	-	4	4	3	3	4
4	Алтайн биелэг өвс ( <i>Poa altaica</i> Trin.)	-	-	4	4	4	4
5	Том цэцэгт дааган сүүл ( <i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schult.)	-	4	3	4	4	4
6	Нугын биелэг өвс ( <i>Poa pratensis</i> L.)	5	5	5	5	5	5
7	Дэргэр биелэг ( <i>Poa subfastigiata</i> Trin.)	-	-	5	-	-	5
8	Триниусын улаан толгой ( <i>Agrostis Trinii</i> Turcz.)	-	4	4	3	3	4
9	Илд навчит улалж ( <i>Carex ensifolia</i> (Turcz.ex Gorodk.) V.Kerz.)	-	4	4	-	-	4
10	Судалгүй Улалж ( <i>Carex enervis</i> C.A.Mey.)	-	5	5	5	5	5
11	Ширэг улалж ( <i>Carex duriuscula</i> C.A.Mey.)	3	5	3	5	5	3
12	Төллүүр тарна ( <i>Polygonum viviparum</i> L.)	-	4	4	3	3	4
13	Нумраа хунчир ( <i>Astragalus adsurgens</i> Pall.)	4	4	4	4	4	4
14	Олон-ишт гиш ( <i>Vicia multicaulis</i> Ldb.)	-	4	4	4	4	4

**Тайлбар:** Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)

Нам уулын нуга хоорондын бэлчээр нь Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Яруу, Алдархаан, Отгон сумдад сарлаг, үхэрт тохиромжтой нутаг болохоос гадна бүх сумдын хонь, ямаа, адуун сүрэгт тохиромжтой нутаг болдог. Үүнд:

- Зун-намрын улиралд хонинд тохиромжтойгоос нэн тохиромжтой (73.4%) бэлчээр нутагт Шүлүүстэй, Алдархаан, Сонгино сумдын нутаг бүхэлдээ, мөн Яруу, Идэр, Отгон, Тэлмэн Тосонцэнгэл, Их-Уулын өндөр уулын тагаас бусад уулархаг нутаг, Тэс, Баянтэс, Асгат, Баянхайрхан, Түдэвтэй, Номгон зэрэг сумдын бэлчээрт ашиглах боломжгүй нутгаас бусад газар, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул, Сантмаргад, Завхан мандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг говийн сумдын элсний бэлчээрээс бусад нутаг орно.
- Өвөл-хаврын улиралд хонинд тохиромжтойгоос нэн тохиромжтой (66.6%) бэлчээр нутагт Шүлүүстэй, Цагаанчулуут, Сонгино сумдын нутаг бүхэлдээ, мөн Алдархаан, Яруу, Идэр, Отгон, Тосонцэнгэл, Их-Уулын өндөр уулын тагаас бусад уулархаг нутаг, Тэс сумын бэлчээрт ашиглах боломжгүй нутгаас бусад газар, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Завхан мандал, Ургамал,

Дөрвөлжин зэрэг говийн сумдын элсний бэлчээрээс бусад нутаг орж байхад Баянтэс, Асгат, Баянхайрхан, Тэлмэн, Түдэвтэй, Номгон, Цэцэн-Уул сумдын нутаг хонинд дунд зэргээс тохиромжтой нутагтай байна.

- Зун-намрын улиралд адуунд тохиромжтойгоос нэн тохиромжтой (68.4%) бэлчээр бүх сумдын нутагт өндөр уулын таг, бэлчээрт ашиглах боломжгүй нутаг, элсэн манханаас бусад газарт ялаа шумуул багатай уулын ар зоо, дэнж, уужим тал хөндий байх ба хонины бэлчээртэй ойролцоо байна.
- Өвөл-хаврын улиралд адуунд тохиромжтойгоос нэн тохиромжтой (58.6%) бэлчээр нутаг уулын хормой, уул хоорондох хөндий, голын бургас, бут сөөг, дэрс бүхий нөмөр газар бусад малаас алс байх нь тохиромжтой юм.

#### Тал хээрийн бэлчээр.

Завхан аймгийн Хангайн нурууны өврөөр орших Шүлүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Алдархаан, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Завханмандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг сумдын нутагт Хан Хөхийн нурууны өвөх хүртэлх сумдын нутагт Хялгана-хазаарганат, Хялгана-харганат төрлийн хуурай хээрийн бэлчээр нарийн зурвас байдлаар тохиолддог.

Хялгана-хазаарганат бэлчээрийн 100 ам метр талбайд 12-36 зүйл ургамалтай, тэдгээр нь 20-25 см өндөр ургадагын дотор малын идэмж дундаас сайтай ургамал 10-аас цөөн зүйлтэй, 3.0-11.2 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд дунд зэрэг буюу уураг 7.9%, тослог 3.0% байна.

Хүснэгт 4. Хялгана-хазаарганат хуурай хээрийн бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Крыловын хялгана ( <i>Stipa Krylovii</i> Roshev.)	-	4	4	4	4	4
2	Дэрвээн хазаар өвс ( <i>Cleistogenes squarrosa</i> (Trin.) Keng.)	3	4	4	4	4	-
3	Саман ерхөг ( <i>Agropyron cristatum</i> (L.) P.B.)	4	5	4	5	5	4
4	Цацаглаг биелэг өвс ( <i>Poa botryoides</i> Trin.)	3	4	4	3	3	4
5	Том цэцэгт дааган сүүл ( <i>Koeleria macrantha</i> (Ldb.) Schult.)	3	4	3	4	4	4
6	Нангиад түнгэ ( <i>Leymus chinensis</i> (Trin.) Tzvel.)	4	5	5	4	4	-
7	Ширэг улалж ( <i>Carex duriuscula</i> C.A.Mey.)	3	5	3	5	5	3
8	Тарваган харгана ( <i>Caragana pygmaea</i> (L.) DC.)	5	4	4	4	4	4
9	Хошоон хунчир ( <i>Astragalus melilotoides</i> Pall.)	4	2	2	2	2	2
10	Агь ( <i>Artemisia frigida</i> Willd.)	5	4	4	5	5	4

**Тайлбар:** Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)

Хялгана-харганат бэлчээрийн 100 ам метр талбайд 10-15 зүйл ургамалтай, тэдгээрээс малын идэмж дундаас сайтай ургамал 7-аас цөөн зүйлтэй, 4.7-11.9 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд уураг 5.5%, тослог 1.1% байна.

Хүснэгт 5. Хялгана-харганат хуурай хээрийн бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Крыловын хялгана ( <i>Stipa Krylovii</i> Roshev.)	-	4	4	4	4	4
2	Дэрвээн хазаар өвс ( <i>Cleistogenes squarrosa</i> (Trin.) Keng.)	3	4	4	4	4	-
3	Саман ерхөг ( <i>Agropyron cristatum</i> (L.) P.B.)	4	5	4	5	5	4

4	Хос шүдлэг сонгино ( <i>Allium bidentatum</i> Fish. ex Prokh.),	4	4	3	4	4	4
5	Алтан харгана ( <i>Caragana leucophloea</i> Pojark.)	3	-	-	3	3	-
6	Бүнгийн харгана ( <i>Caragana Bungei</i> Ledeb.)	3	-	-	2	2	-
7	Агь ( <i>Artemisia frigida</i> Willd.)	5	4	4	5	5	4
<b>Тайлбар:</b> Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)							

Тал хээрийн бэлчээр нь Шүлүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Алдархаан, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Завханмандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг сумдын нутагт тэмээ, ямаанд тохиромжтой нутаг болдог. Үүнд:

- Зун-намрын улиралд тэмээнд тохиромжтой (33.3%) бэлчээр нутагт Шүлүүстэй, Цагаанчулуут, Алдархаан, Яруу, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Завхан мандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг сумдын хуурай хээрийн бэлчээр орно.
- Өвөл-хаврын улиралд тэмээнд тохиромжтойгоос нэн тохиромжтой (35.28%) бэлчээр нутаг Шүлүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Алдархаан, Яруу, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Цэцэн-Уул, Завхан мандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг сумдад байна.
- Зун-намрын улиралд ямаанд нэн тохиромжтой (50.67%) бэлчээр Шүлүүстэй, Цагаанчулуут, Алдархаан, Яруу, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Цэцэн-Уул, Завхан мандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг сумдын хуурай хээрт болон бүх сумдын уулархаг нутгийн харганат бэлчээрийг ашиглах нь илүү байна.
- Өвөл-хаврын улиралд ямаанд тохиромжтойгоос нэн тохиромжтой (66.6%) бэлчээр нутаг Шүлүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Алдархаан, Яруу, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Цэцэн-Уул, Завхан мандал, Ургамал, Дөрвөлжин зэрэг сумдын хуурай хээрт болон ихэнх сумдын уулархаг нутгийн харганат бэлчээрийг ашиглах нь илүү тохиромжтой байна.

#### Цөлжүү хээрийн бэлчээр.

Завхан аймгийн Их нууруудын хотгорт багтах Ургамал, Завханмандал, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Дөрвөлжин сумдын нутаг уулын хээр, хуурай хээрээс цөлөрхөг хээрийн бүсэд шилжих завсарын бүс үүсгэх бөгөөд энд цөлжүү хээрийн дэгнүүлт үетэнт (монгол өвст), алаг өвст (таанат), сөөгт (харганат) бүлэг төрлийн бэлчээр зонхилно.

Монгол өвс-харганат бэлчээрийн 100 ам метр талбайд 15-20 зүйл ургамалтай, тэдгээрээс малын идэмж дундаас сайтай ургамал 15 хүртлэх олон зүйлтэй, 3.6-6.76 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд сайн буюу уураг 9.3%, тослог 4.8% байна.

Хүснэгт 6. Монгол өвс-харганат цөлжүү хээрийн бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Крыловын хялгана ( <i>Stipa Krylovii</i> Roshev.)	4	4	4	4	4	-
2	Говийн хялгана ( <i>Stipa gobica</i> Roshev.)	5	5	5	5	5	-
3	Сайрын хялгана ( <i>Stipa glareosa</i> P.Smirn.)	5	5	5	5	5	-
4	Дэрвээн хазаар өвс ( <i>Cleistogenes squarrosa</i> (Trin.)Keng.)	3	4	4	4	4	-
5	Саман ерхөг ( <i>Agropyron cristatum</i> (L.) P.B.)	4	5	4	5	5	4
6	Утсан навчит улалж ( <i>Carex stenophylloides</i> V.Krecz.)	4	3	-	4	4	-
7	Таана буюу багалгар сонгино ( <i>Allium</i>	5	5	3	5	5	-



	<i>polyrrhizum Turcz. ex Rgl.)</i>						
8	Хөмөл ( <i>Allium mongolicum Rgl.</i> )	4	4	3	4	4	-
9	Нарийн цахилдаг ( <i>Iris tenuifolia Pall.</i> )	0	4	0	4	4	0
10	Алтан харгана ( <i>Caragana leucophloea Rojark.</i> )	3	-	-	3	3	-
11	Бүнгийн харгана ( <i>Caragana Bungei Ledeb.</i> )	3	-	-	2	2	-
12	Агь ( <i>Artemisia frigida Willd.</i> )	5	4	4	5	5	4
13	Хуурайсаг шарилж ( <i>Artemisia xerophytica Krasch.</i> )	5	4	4	5	5	-
14	Хуурамч дэрэвгэр хависгана ( <i>Scorzonera pseudodivariata Lipsch.</i> )	4	-	-	4	4	-
<b>Тайлбар:</b> Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)							

Цөлжүү хээрийн бэлчээр нь Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Завханмандал, Ургамал зэрэг сумдын нутагт тэмээ, бог малд тохиромжтой нутаг болдог. Үүнд:

- Зун-намрын улиралд тэмээнд тохиромжтойгоос нэн тохиромжтой (45.4%) бэлчээр нутагийн ихэнхийг Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Завханмандал, Ургамал зэрэг сумдын цөлжүү хээрийн бэлчээр эзэлж байна.
- Өвөл-хаврын улиралд тэмээнд тохиромжтойгоос нэн тохиромжтой (35.28%) бэлчээр нутагийн мөн ихэнх нь Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Завханмандал, Ургамал зэрэг сумдын цөлжүү хээрийн болон элсний бэлчээр эзэлж байна.

#### Говь цөлийн элсний бэлчээр.

Завхан аймгийн нутагт Монгол элс, Бор хярын элс, Сэврэн улааны элс, Улаагчийн элс, Борхын элс, Сулин адаг элс, Ар загийн элс, Хомын элс зэрэг элсэн манхануудтай тул тэдгээрийн нөлөөгөөр нийт аймгийн хэмжээний бэлчээрийн 6.29% элсний нүүлттэй болсон байна. Энэхүү говийн довцог бөөрөг элсний сул бэхэжсэн элсний бэлчээрт үндэслэг ишт үетэнт бүлэг төрлийг сулыт, шимэрс- суль-элсний шарилжит төрлийн бэлчээр зонхилдог.

Сулыт элсний бэлчээрийн 100 ам метр талбайд 8-10 зүйл ургамалтай, тэдгээрээс малын идэмж дундаас сайтай ургамал 8-аас цөөнгүй зүйлтэй, 3.5-5.18 ц/га өвсний ургацтай, түүний 95% -ийг дан ганд хар суль эзэлдэг, ногооны шимт чанарын хувьд дунд зэрэг буюу хуурай бодисын 5.6% уураг, 6.5% тослогтой байна.

Хүснэгт 7. Суль элсний бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Үсхий суль ( <i>Psammochloa villosa (Trin.) Bor.</i> )	5	4	4	3	3	-
2	Говийн хялгана ( <i>Stipa gobica Roshev.</i> )	5	5	5	5	5	-
3	Сайрын хялгана ( <i>Stipa glareosa P. Smirn.</i> )	5	5	5	5	5	-
4	Дэрвээн хазаар өвс ( <i>Cleistogenes squarrosa (Trin.) Keng.</i> )	3	4	4	4	4	-
5	Саман ерхөг ( <i>Agropyron cristatum (L.) P. B.</i> )	4	5	4	5	5	4
6	Хөмөл ( <i>Allium mongolicum Rgl.</i> )	4	4	3	4	4	-
7	Шар шарилж ( <i>Artemisia xanthochroa Krasch.</i> )	4	-	-	-	-	-
8	Цөгцөн хамхуул ( <i>Corispermum patelliforme Iljin.</i> )	4	-	-	-	-	-
<b>Тайлбар:</b> Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)							

Шимэрс-суль-элсний шарилжит элсний бэлчээрийн 100 ам метр талбайд 4-6 зүйл малд дундаас сайн идэмжтэй ургамалтай, 1.1-2.18 ц/га өвсний ургацтай,

ногооны шимт чанарын хувьд дундаас сайн, хуурай бодисын 9.0-12.4% уураг, 6.2% тослогтой байна.

Хүснэгт 8. Шимэрс-сульь элсний шарилжит элсний бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Үсхий суль ( <i>Psammochloa villosa</i> (Trin.) Bor.)	5	4	4	3	3	-
2	Шар шарилж ( <i>Artemisia xanthochroa</i> Krasch.)	3	-	-	3	3	-
3	Бөндгөр шарилж ( <i>Artemisia sphaerocephala</i> Krasch.),	3	-	-	3	3	-
4	Клеменцийн шарилж ( <i>Artemisia Klementzae</i> Krasch. ex Leonova.)	3	-	-	3	3	-

**Тайлбар:** Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)

Говь цөлийн элсний бэлчээр нь Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Сантмаргад, Завханмандал, Ургамал зэрэг сумдын нутагт тэмээ, бог малд тохиромжтой нөөц нутаг болдог. Үүнд:

- Султ бэлчээрийг жилийн 4 улиралд тэмээ ба бог малд ашиглах боломжтой боловч бог малыг зун эхээр юмуу хаврын сүүлчээр тэжээл хомс үед ашиглахад илүү тохиромжтой.
- Шимэрс-сульь-элсний шарилжит бэлчээрийг намар орой юмуу өвөл, хаврын улиралд тэмээ, бог малд ашиглах нь илүү тохиромжтой юм.

**Бүс дундын голын хөндий, нам хотосын нугын бэлчээр.**

Завхан аймагийн нутагт Тэсийн гол, Хачиг гол, Цэргийн гол, Зайгаль гол, Жарганы гол, Жимстэйн гол, Шумуултайн гол, Хуягтын гол, Идэр гол, Хонгорын гол, Дээд, дунд Цэцүүхийн гол, Өртөнийн гол, Дэлгэрэхийн гол, Ямаатын гол, Гунын гол, Жаргалантийн гол, Чигэстэйн гол, Богдын Гол, Завхан гол, Яруугийн гол, Буянт гол, Шар усны гол, Бор бургасын гол, Бумбатын гол, Ширээгийн гол, Төмөрт гол, Галуутын гол, Хүнгүйн гол зэрэг олон голын хөндийгөөр улалжит, үндэслэг ишт үетэнт, дэгнүүлт үетэнт, алаг өвст, мод сөөгт, нягт дэгнүүлт (дэрст), үетэн-жижиг улалжит бүлэг төрлийн бэлчээр зонхилдог.

Үетэн-жижиг улалжит татмын нугын бэлчээрийн 100 ам метр талбайд 10-15 зүйл ургамалтай, тэдгээр нь өтгөн шигүү, харьцангуй өндөр ургадагын дотор малын идэмж дундаас сайтай ургамал 10-аас цөөн зүйлтэй, 15.0-25.0 ц/га өвсний ургацтай, ногооны шимт чанарын хувьд дунд зэрэг буюу уураг 6.4%, тослог 1.4% байна.

Хүснэгт 9. Үетэн-жижиг улалжит татмын нугын бэлчээрийн зонхилох ургамлын идэмж, зун намрын улиралд

№	Ургамлын нэр	Малын төрөл, таван онооны үнэлэлт					
		эмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Сарлаг хайнаг
1	Ахарсорт арвай ( <i>Hordeum brevisubulatum</i> (Trin.) Link.)	-	5	5	4	4	5
2	Нугын биелэг өвс ( <i>Poa pratensis</i> L.)	5	5	5	5	5	5
3	Монгол улаан толгой ( <i>Agrostis mongholica</i> Roshev.)	0	4	4	3	3	0
4	Мөлхөө хиаг ( <i>Elytrigia repens</i> (L.) Desv. ex Nevski.)	-	4	5	4	4	4
5	Курайн улалж ( <i>Carex curaica</i> Kunth.)	-	-	4	4	4	4
6	Судалгүй Улалж ( <i>Carex enervis</i> C.A.Mey.)	-	5	5	5	5	5
7	Жерардийн гол өвс ( <i>Juncus Gerardii</i> Lois.)	-	-	3	-	-	3
8	Сибирь өлөнцөр ( <i>Luzula sibirica</i> V.Krecz.)	-	-	3	3	3	3
9	Эмийн сөд ( <i>Sanguisorba officinalis</i> L.)	-	5	4	5	5	4

10	Олон-ишт гиш ( <i>Vicia multicaulis</i> Ldb.)	-	4	4	4	4	4
<b>Тайлбар:</b> Ургамлын идэмжийг 5 оноогоор үнэлэв. Үүнд: 5 (онц), 4 (сайн), 3 (дунд), 2 (муу) 1 (тааруу), 0 (огт идэхгүй), - (Идэмж нь судлагдаагүй)							

Бүх төрлийн малын зуслангийн бэлчээр нутаг болдог.


### 2.3 ЗАВХАН АЙМГИЙН ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ

Манай орны голууд ихэнхдээ уулынх учраас урсгалын эхэн ба дунд хэсэг нь хавцал маягийн нарийн хөндийгөөр урсаж татам төдий л хөгжөөгүй, харин голуудынн адаг орчмын уудам өргөн хөндийд татмын дэнжүүд сайн ялгарч татмын үйл явц байнга илэрсэн байна.

Голууд том байх тусам татам нь өргөн налгар байна. Голын татмын хамгийн нам, залуу дэнжийг татмын дэнж гэх бөгөөд тэр нь байн байн үерийн усанд автаж жилдээ нэг буюу хэдэн удаа, эсхүл хэдэн жилд нэг удаа усаар дүүрч хэсэг зуур тогтонги устай байдаг жамтай.

Голын үерлэлтийн горим, түүний тэжээлээс шалтгаалж хаврын шар усны, мөсөн голын, зуны хур борооны гэх мэт янз бүр байна. Үерийн усаар зөөгдөж ирсэн хөвмөл эрдэс шорооны зүйлс татмын хөрсний гадарга дээр тунаж хуримталсаар голын хагшаас хурдас бий болдог ажээ.

Ийнхүү аллювийн үйл явцын үр дүн жил бүр татмын гадарга дээр аллювийн нимгэн хурдас тогтож тэр даруйдаа хөрс бүрэлдэх явцад татагдан ордог байна. Энэ учраас аллювийн хөрс эх чулуулгийн шинэхэн хурдсаар байн байн сэлбэгдэж үе давхарга нь дээшээгээ зузаардаг онцлогтой.



Зураг 2. Завхан аймгийн хөрсөн бүрхэвчийн зураг

## Хүснэгт 7. Голын татмын хөрсний тархалт

№	Сумын нэр	Голын татмын хөрс					
		Алювийн нуга- намгийн хөрс /мян.га/	Алювийн нугын сулавтар хөгжилтэй хөрс /мян.га/	Алювийн нугын хөрс /мян.га/	Алювийн нугын хээршсэн хөрс /мян.га/	Алювийн нугын ялзмаг- глейрхэг хөрс /мян.га/	Алювийн ширэгт үелсэн тогтоцтой хөрс /мян.га/
1	Алдархаан	-	-	37.9	9.8	-	-
2	Асгат	7.7	-	-	-	-	-
3	Баянтэс	9.2	-	0.2	25.9	-	-
4	Баянхайрхан	5.5	-	-	-	-	-
5	Дөрвөлжин	8.8	-	4.6	-	-	-
6	Завханмандал	-	-	-	-	-	6.7
7	Идэр	-	-	3.8	-	-	-
8	Их-Уул	-	-	12.6	11.1	-	-
9	Нөмрөг	3.8	-	0.3	-	-	-
10	Отгон	1.9	1.8	21.7	-	-	-
11	Сантмаргаз	-	-	5.9	-	-	-
12	Сонгино	3.8	-	-	-	-	-
13	Тосонцэнгэл	1.9	-	3.4	4.2	0.3	-
14	Түдэвтэй	-	3.3	6.6	4.8	-	-
15	Тэлмэн	1.7	-	17.1	-	-	-
16	Тэс	8.1	-	-	6.2	1.1	-
17	Ургамал	0.5	3.8	-	-	-	8.9
18	Цагаанхайрхан	-	0.2	10.5	-	-	-
19	Цагаанчулуут	0.003	-	4.1	-	-	-
20	Цэцэн-Уул	-	-	3.5	-	-	-
21	Шилүүстэй	2.9	-	5.7	-	-	-
22	Эрдэнэхайрхан	-	-	-	-	-	4.6
23	Яруу	0.6	26.7	-	-	-	-
24	Улиастай	-	-	23.4	5.2	-	-
<b>Нийт</b>		<b>56.403</b>	<b>35.8</b>	<b>161.3</b>	<b>67.2</b>	<b>1.4</b>	<b>20.2</b>

## Уулын тундрын хөрс:

Уулын тундрын хөрс өндөр уулсын ян оргилуудын цас мөсөн титэмийн хилээс доош уулын нуга, тайгын ойн дээд зааг хүртлэх хад асга, хаг хөвд, өвс сөөг тарлантсан онгот зэлүүд сарьдаг царам газар тогтворжиж уулын хөрсний босоо бүсүүдийн оройд байрладаг жамтай. Их хүйтэн, чийглэг, мөнх цэвдэгтэй, цасан бүрхэвч овоо тогтдог, ургамлан нөмрөг багатай өвөрмөц криогумид нөхцөлд хөрс үүсэх явц үргэлжлэх бөгөөд дулаан дутагдалтайгаас болж хөрсөн дэх биологийн үйл явц идэвхтэй өрнөж чадахгүй, дутуу ялзмагтсан органик бодис хөрсөнд ихээр хуримталж заримдаа хүлрэнцэр давхарга үүсгэдэг.

## Хүснэгт 8. Уулын тундрын хөрсний тархалт

№	Сумын нэр	Уулын тундрын хөрс	
		Уулын тундрын хүлрэнцэр-глейрхэг хөрс /мян.га/	Уулын тундрын ширэгт ухаа шороон хөрс /мян.га/
1	Алдархаан	-	40.1
2	Идэр	-	55.5
3	Отгон	-	119.7
4	Тосонцэнгэл	19.9	42.2
5	Цагаанхайрхан	-	16.9
6	Шилүүстэй	-	3.6
<b>Нийт</b>		<b>19.9</b>	<b>257.5</b>

## Уулын ойн хөрс:

Ойн хөрс байгалийн хоёр бүсэд, тухайлбал уулт-тайгын, уулт-ойт хээрийн бүсэд голлож тархахдаа хил хязгаар нь ихэнхдээ олон жилийн цэвдэгтэй уялдаж байна. Нутгийн хойт зах хөвсгөл орчмын уулс, Хэнтийн нурууны төв хэсгээр тайгын ой уулын бараг бүх хажууг бүрхдэг бол урагшаанаа ойн талбай эрс хумигдаж зөвхөн уулын ар хажуугийн чийглэг газраар араг цоог тархана. Ойн дээд хил Хангай, Монгол Алтайн нуруунд 2450-2500 метрийн үнэмлэхүй өндөрт хүрдэг байхад хамгийн доод түвшин нь Орхон-Сэлэнгийн адаг, Онон-Улзын бэлчээр орчмоор 850-900 метрт байдагаас үзэхэд ойн хөрс харилцан адилгүй нөхцөлд оршино. Уулын шинэсэн ойн тархалтын хамгийн урд цэг манай оронд умард өргөргийн 46°40°-ын орчимд байна.

Хүснэгт 9. Уулын ойн хөрсний тархалт

№	Сумын нэр	Уулын ойн хөрс								
		Уулын ойн үлдмэл хээрийн шинжтэй бараан хөрс /мян.га/	Уулын ойн ширэгт бараан хөрс /мян.га/	Уулын ойн ширэгт ердийн /жинхэнэ/ бараан хөрс /мян.га/	Уулын тайгын цэвдэгт-ухаашороон хөрс /мян.га/	Уулын тайгын цэвдэгт-чандруувтар хөрс /мян.га/	Уулын тайгын цэвдэгт глейрхэг хөрс /мян.га/	Уулын тайгын цэвдэгт хүлрэнцэр-ялзмагт глейрхэг хөрс /мян.га/	Уулын тайгын ширэгт бүүдүүн ялзмагт хөрс /мян.га/	Уулын тайгын ширэгт далд глейрхэг хөрс /мян.га/
1	Алдархаан	-	12.6	20.1	-	-	-	-	-	-
2	Асгат	-	0.7	-	-	-	-	-	-	-
3	Баянтэс	-	62.7	-	1.3	-	-	-	-	-
4	Баянхайрхан	-	16.2	-	12.3	-	-	-	-	2.1
5	Идэр	0.7	19.8	3.3	32.8	7.8	-	-	-	-
6	Их-Уул	34.4	11.7	-	-	-	-	-	-	-
7	Нөмрөг	7.4	0.06	0.02	0.08	-	-	-	23.3	8.8
8	Отгон	-	0.2	-	-	-	-	1.7	-	-
9	Сонгино	-	4.5	-	-	-	-	-	-	-
10	Тосонцэнгэл	52.1	7.8	-	-	4.3	0.04	-	-	5.1
11	Түдэвтэй	-	3.4	-	4.5	-	-	-	0.6	-
12	Тэлмэн	2.6	2.1	0.02	-	-	0.4	-	-	30.1
13	Тэс	-	5.2	0.005	-	-	-	-	-	-
14	Цагаанхайрхан	-	2.9	-	-	-	-	-	8.9	-
15	Цагаанчулуут	-	-	-	-	-	-	-	3.9	-
16	Цэцэн-Уул	-	5.4	-	0.07	-	-	-	-	-
17	Шилүүстэй	-	-	-	-	-	-	-	0.2	-
18	Эрдэнэхайран	0.3	-	-	9.9	-	-	-	-	-
19	Яруу	-	0.08	0.4	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>		<b>97.5</b>	<b>155.3</b>	<b>23.845</b>	<b>60.95</b>	<b>12.1</b>	<b>0.44</b>	<b>1.7</b>	<b>36.9</b>	<b>46.1</b>

## Уулын нугын ба нугат-хээрийн хөрс :

Уулын нугын хөрс өндөр уулын тайгын бүсэд, тундрын бүсийг бодвол дулааны хангамжаар арай илүү, чийглэг, хүйтэн нөхцөлд бушилж, улалж-бушилж, алаг өвс-бушилж, алаг өвс-улалжит нугын өргөн шигүү ургамалшил дор тогтворждог. Энэ хөрс Хангайн гол нуруу болон түүний салбар нуруудаар хамгийн түгээмэл тархалттай бөгөөд Хангайн өмнөт хэсэгт 2750,3200м, төв хэсгээр нь 2300,2600м, хойт хэсгээр нь 2100-2200м, Хөвсгөл орчимд 1800-1900 м-ийн түвшинд тус тус байрлана. Уулын нугын хөрс ихэнхдээ уул нуруудын хавтгайдуу бөмбөгөр оройгоор тархаж уулын босоо бүсүүдийн дээд талд нь байрладаг. Уулын нугат-хээрийн хөрс чийглэгдүү, хүйтэн нөхцөлд алаг өвс-ботуульт, алаг өвс-жижиг үетэнт, заримдаа бушилз-

ботуульт ургамалшил доор тогтворжих бөгөөд ургамал нь их намхан тачир ургасан байдгаараа онцлог.

Хүснэгт 10. Уулын нугын ба нугат хээрийн хөрсний тархалт

№	Сумын нэр	Уулын нугын ба нугат-хээрийн хөрс							
		Нугат-намгийн бүдүүн ялзмагт глейт хөрс	Нугат намгийн лаг шаварт хөрс	Нугат намгийн цэвдэгт хөрс	Нугын ердийн хөрс	Нугын хужир хөрс	Нугын хүрэн хөрс	Уулын нугын бүдүүн ялзмагт бараан хөрс	Уулын нугын бүдүүн ялзмагт глейрхэг хөрс
1	Алдархаан	-	-	3.9	-	-	-	34.9	-
2	Баянтэс	-	-	-	-	-	3.9	-	-
3	Баянхайрхан	-	-	-	-	-	0.3	-	-
4	Дөрвөлжин	-	-	-	-	0.8	-	-	-
5	Идэр	-	-	1.6	-	-	3.2	14.4	-
6	Их-Уул	-	0.7	0.2	-	0.02	-	-	7.3
7	Нөмрөг	-	-	-	-	-	17.1	0.3	-
8	Отгон	-	-	0.2	0.003	-	1.2	157.1	-
9	Сантмаргаз	-	-	-	-	-	2.8	-	-
10	Сонгино	-	-	-	0.01	-	3.3	-	-
11	Тосонцэнгэл	2.6	0.7	6.4	-	-	1.2	-	1.9
12	Түдэвтэй	-	-	-	-	-	7.7	-	-
13	Тэлмэн	-	-	2.4	-	-	10.8	-	-
14	Тэс	-	-	-	-	-	1.4	-	-
15	Ургамал	-	-	-	-	4.9	0.9	-	-
16	Цагаанхайрхан	-	-	-	-	-	-	10.5	-
17	Цэцэг-Уул	-	-	-	-	-	8.1	-	-
18	Шилүүстэй	-	-	-	-	-	-	1.7	-
19	Эрдэнэхайрхан	-	-	-	-	-	4.9	-	-
20	Яруу	-	-	0.4	-	-	5.3	-	-
<b>Нийт</b>		<b>2.6</b>	<b>1.4</b>	<b>15.1</b>	<b>0.013</b>	<b>5.72</b>	<b>72.1</b>	<b>218.9</b>	<b>9.2</b>

### Уулын хээрийн хөрс :

Монгол орны уулархаг нутгийн ихээхэн хэсэг нь уулын хээрийн ландшафттай. Уулын хээр босоо бүс, дэд бүсүүд үүсгэж манай орны төв ба дорнод хэсэгт 1700-1800 м, Хангайн өмнөт ба баруун хэсгээр 2600-2700 м, Монгол Алтай, Говь Алтайн нуруунд 2900-3000 м хүртэл унэмлэхүй өндөрт тархсан байдаг. Уулын хээрийн хөрс улсын бүх нутгийн 29,6%-тай тэнцэх их хэмжээний талбайг хамарна.

Хүснэгт 11. Уулын хээрийн хөрсний тархалт

№	Сумын нэр	Уулын хээрийн хөрс									
		Уулын хар хүрэн хөрс	Уулын хүрэн хөрс	Өндөр уулын нугат хээрийн хөрс	Өндөр уулын нугат ердийн хөрс	Уулын ердийн хар шороон хөрс	Өндөр уулын нугын жинхэнэ хар шороонхуу хөрс	Уулын улирлын цэвдэгт хар шороон хөрс	Өндөр уулын толбот хээрийн бүдүүн ялзмагт хөрс	Өндөр уулын нугын цэвдэгт хөрс	Өндөр уулын толбот хээрийн бүдүүн ялзмагт хөрс
1	Алдархаан	326.4	144.8	38	3.2	-	-	1.3	-	10.1	0.01
2	Асгат	-	103.8	-	-	-	-	-	-	-	-
3	Баянтэс	-	426.4	-	-	-	-	-	-	-	-
4	Баянхайрхан	0.01	305.9	-	-	-	-	-	-	-	-
5	Дөрвөлжин	-	92.1	-	-	-	-	-	-	-	-
6	Завханмандал	-	122.1	-	-	-	-	-	-	-	-

7	Идэр	276.4	22	9.4	23.6	-	-	-	8.2	0.3	0.0003
8	Их уул	157.6	1.6	20.5	0.4	0.4	-	-	-	14.5	0.01
9	Нөмрөг	106.4	38.6	4.5	-	0.8	-	0.3	-	15.7	0.01
10	Отгон	126.8	121.5	46	40.3	0.3	-	0.6	40.3	17.7	0.01
11	Сантмаргац	-	54	-	-	-	-	-	-	-	-
12	Сонгино	-	166.8	-	-	-	-	-	-	-	-
13	Тосонцэнгэл	195.5	-	9.4	22.5	2.8	25	0.7	8.2	29.9	0.02
14	Түдэвтэй	33.6	145.3	-	8.9	0.8	-	0.03	-	-	-
15	Тэлмэн	179.9	5.9	-	2.9	-	-	25.4	-	13.5	0.01
16	Тэс	1.6	-	-	-	-	-	-	-	-	-
17	Ургамал	-	78.7	-	-	-	-	-	-	-	-
18	Цагаанхайрхан	84	111	27.5	-	-	-	-	-	-	-
19	Цагаанчулуут	-	114.2	26.3	-	-	-	-	-	-	-
20	Цэцэн-уул	16.4	123.8	-	-	-	-	-	-	-	-
21	Шилүүстэй	30.4	195.5	7	14.4	-	-	-	21.4	1.4	0.001
22	Эрдэнэхайрхан	81.8	94.2	-	-	-	-	-	-	2.5	0.002
23	Яруу	251	82.2	36.8	3.8	-	-	4.1	-	9.2	0.009
24	Улиастай	54.8	24.2	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт</b>		<b>1922.6</b>	<b>2574.6</b>	<b>225.4</b>	<b>120</b>	<b>5.1</b>	<b>25</b>	<b>32.43</b>	<b>78.1</b>	<b>114.8</b>	<b>0.0823</b>

Уулын хээрийн хөрс үүсч тогтоход хажуугийн үйл явцын нөлөө асар их байна. Зөвхөн нэг жишээг дурьдахад ойн хээрийн бүсэд хийсэн олон жилийн судалгааны дүнгээс иш татвал уулын хар шороон хөрстэй 18<sup>0</sup> хэвгий дээрх гадаргын урсацын хэмжээ дунджаар жилд 80-100м<sup>3</sup>, үүний уршгаар үүсэх хөрсшорооны нил угаагдлын хэмжээ 420-680 кг/га байдаг ажээ. Ууланд ба тал хөндийд тогтворжсон ижил хэв шинжийн хөрс экологийн нөхцөлийн хувьд хоорондоо ихээхэн ялгаатай. Уулын хар шороон хөрс чийгийн нөөцөөр маш бага, температурын хэлбэлзэл ихтэй, дулааны хангамжаар ургамлын биомасс, бүх органик бодисын хэмжээ, ялзмагийн нөөцөөр бага байна.

#### Уулын цөлөрхөг хээрийн ба цөлийн хөрс:

Монгол Алтай, Говь Алтайн нурууны урд захын цөлийн бүстэй залгаа орших салбар уулс, ухаа толгод, түүнчлэн цөлийн бүсэд орших Байтаг Богд, Хавтаг, Тахийн шар, Таян, Эдрэнгийн нуруу, Жинст, Сэврэй, Зөөлөн, Тост, Ноён, Номгон, Хүхэр, Атас, Чингис, Цагаан Богд зэрэг уулст 1500-1600 м-ээс 2400-2500 м хүртэл үнэмлэхүй өндөрт заримдаг цөлийн бор, цөлийн бор саарал хөрс элбэг тархсан байна. Цөлийн бүс дэх бүх уул нуруудын хажуу олон тооны хуурай сайр, хад чулуун хавцлаар хэрчигдэж ер бусын их бартаатай байхын зэрэгцээ хөрсний гадарга нь цөлийн түлэнхий гандаас бүхий сайр чулуугаар бараг битүү бүрхмэл байна.

Хүснэгт 12. Уулын цөлөрхөг хээрийн ба цөлийн хөрс

№	Сумын нэр	Уулын цөлөрхөг хээрийн ба цөлийн хөрс		
		Уулын цөлөрхөг хээрийн бор хөрс	Цөлийн бор саарал хөрс	Цөлөрхөг хээрийн бор хөрс
1	Баянхайрхан	-	6.2	-
2	Дөрвөлжин	-	135.9	-
3	Сантмаргаз	0.4	-	-
4	Сонгино	-	0.4	-
5	Түдэвтэй	-	13.5	-
6	Ургамал	20.8	-	18.7
<b>Нийт</b>		<b>21.2</b>	<b>156</b>	<b>18.7</b>

Хөрсний гадарга бүрхсэн сайр чулуунууд нь томворт хэмжээтэй, тогтвор муутай сул байрлалтай, гадна тал нь цөлийн бараан хүрэн түлнхий гандаасаар хучигдмал байна. Гадаргаасаа эхэлж нунтаг карбонатын хуримтлалтай, бүх үе давхарга нь шүлтлэг урвалын орчинтой, хөрсний дээд үе дэх ялзмагийн хэмжээ 0,8-1% орчим байна. Тал газрын зармдаг цөлийн бор хөрстэй адил хальслаг өнгөн үе, түүний доод үелсэн бүтэцтэй нимгэн үе аль аль нь илэрч ажиглагдахгүй байдаг.

#### Хээрийн ба хуурай хээрийн хөрс:

Хээрийн хөрс Монгод хамгийн өргөн тархалттай. Улсын нийт нутгийн 48%-иас илүүг хээрийн хөрс эзлэх бөгөөд түүний 18,4% нь тал хөндийд, бусад нь ууланд тархжээ. Тал хөндийд тархсан хээрийн хөрс үндсэн хоёр хэв шинжид хамаарна. Зуны хур борооны ид үеэр хөрсөн дэх ус чийгийн доошоо угаагдаж зөөгдөн явагдах нөхцөл хангагддаг байна. Иймээс харшороон, хүрэншороон хөрсний дээд давхаргууд ихэнхдээ карбонатгүй байхаас гадна бүх зе давхарга нь карбонатгүй байх ч тохиолдол бий. Хуурай хээрийн хөрс угаасаа чийг багатай хэдий ч зуны богинохон хугацаанд хур бороо бөөн ордогоос болж хөрсөн дэх карбонатын шилжилт хөдөлгөөн ийнхүү идэвхжихийн зэрэгцжж хялбар уусах даюсны зүйл хөрснөөс бүрмөсөн угаагддаг ажээ. Харшороон хэвшинжийн хөрс Монгол орны умарт, дорнод хэсэгт уулсбн хоорондох нарийвтар ам хөндий, уул хаяалсан нам ухаа гүвээ, голын өндөр днэ газраар 900-1000 м-ээс 1500-1600м хүртэл үнэмлэхүй өндрийн түвшинд багаахан талбайг хамарч алаг цоог байдалтай тархдаг. харшороон хөрс ялзмагаар баялаг, түүний дээд давхарга дахь ялзмагийн бодисын агууламж 5%-иас 17% хүртэл хэлбэлзэнэ. Гүн рүүгээ ялзмагийн хэмжээ түргэн буурна. Ялзмаг хжримтлалын дэвхага дотор ч гсэн дээд, доод хэсэг нь ялзмагийн агууламжаар сүрхий ялгаатай байна. Хүрэншороон хөрс нь Монгол орны тал хээр, уулсын хоорондох хөндий хотгорт өргөргийн ба хотгорын бүс, дэд бүсүүд үүсгэж дорнод хэсэгт 600-700 м-ээс өрнөд хэсэгт 2300-2400 м хүртэл үнэмлэхүй өндөрт хамгийн түгээмэл тархсан байна.

Хүснэгт 13. Хээрийн ба хуурай хээрийн хөрсний тархалт

№	Сумын нэр	Хээрийн бар хуурай хээрийн хөрс (мян.га)		
		Хар хүрэн хөрс	Цайвар хүрэн хөрс	Хүрэн шороон хөрс
1	Алдархаан	2.4	32.1	-
2	Баянтэс	-	0.4	-
3	Баянхайрхан	4.1	-	-
4	Идэр	20.4	-	-
5	Их уул	36.3	-	-
6	Нөмрөг	75.8	-	-
7	Отгон	0.3	5	-
8	Сантмаргац	-	18.4	-
9	Сонгино	9	-	5.7
10	Тосонцэнгэл	70.6	-	-
11	Түдэвтэй	41.5	-	-
12	Тэлмэн	136.1	-	-
13	Тэс	2.2	0.4	7.3
14	Ургамал	-	138.1	-
15	Цагаанхайрхан	-	11.8	-
16	Цагаанчулуут	-	15.1	-
17	Цэцэн-уул	6.5	-	-




18	Шилүүстэй	-	49.1	-
19	Эрдэнэхайрхан	3	79.7	-
20	Яруу	32.1	41.9	-
<b>Нийт</b>		<b>440.3</b>	<b>392</b>	<b>13</b>

## 2.4 ЗАВХАН АЙМГИЙН АН АМЬТАН

Завхан аймаг нь амьтаны газарзүйн мужлалаар Баруун хойт Монголын тойрогт хамаарах бөгөөд энд өндөр уул, ойт хээр, хээрийн бүсийн амьтад тохиолдох тул зүйлийн бүрдэлийн хувьд баялаг юм. Баавгай, зэрлэг гахай, бор гөрөөс, буга, аргаль, янгир, ирвэс, чоно, үнэг, хярс, мануул, дорго, шилүүс, туулай, чандага, тарвага, цагаан болон хар сүүлт зээр зэрэг ан амьтантай. Ойн болон өндөр уулын, тал хээрийн, нүүдлийн шувуу ирдэг. Хойлог, Ятуу, хур сойр, хун, хотон, нислэг сар, тас, шонхор зэрэг ховордсон шувууд бий.

Аймгийн хэмжээнд ан амьтаны тархац нөөцийн судалгаа ховор бөгөөд Улсын тусгай хамгаалалттай газрууд, голуудын ай сав газарт хийгдсэн ан амьтан судалгааг нэгтгэн оруулсан болно. Хяргас нуур-Завхан голын сав газрын сээр нуруутан амьтдын судалгаанаас үзвэл нэн ховор хөхтний зүйлүүдээс Отгон, Алдархаан, Шилүүстэй сумдын нутаг, Отгонтэнгэрийн ДЦГ-аар цоохор ирвэс, Нөмрөг сумын Баянзүрх, Нөмрөг ууланд баданга хүдэр нутагладаг гэсэн мэдээлэл байна. Монгол оронд эрс ховордсон ирвэс, аргаль, янгир, халиун буга, хүдэр зэрэг ан амьтад Отгонтэнгэр ууланд тархсан байна. Аймгийн хэмжээнд тархсан зарим хөхтөн амьтдын судалгааг ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдэмтэд хийсэн байна.

**Аргаль:** Аргаль, угалз бол хонины зэрлэг өвөг бөгөөд өдгөө дэлхийд ховордсон амьтны нэг юм.




Зураг 10. Аргаль амьдрах боломжит ба тархсан газар

Төв азийн уулархаг өндөр бүс нутгаар амьдардаг хамгийн том зэрлэг хонь юм. Өндөр нь 120 см, 140 кг хүртэл жинтэй байх ба биеийн урт 1,8 м хүрнэ. Эр нь маш том угалзалсан эвэртэй бөгөөд 190 см хүртэл урт байдаг аж. Эм нь бас эвэртэй ч жижигхэн байна.

Зургаас харахад Завхан аймгийн 4 сумдуудаар аргаль нь амьдарч буй нь мэдэгдсэн байна. Тухайлбал: Шилүүстэй сумын Завхан голын сав дагуу, Цагаанхайрхан сумын Ширээгийн голын сав дагуух нутагт, Отгон сумын дагуу Рашаантын сав дагуух нутагт мэдэгдсэн байна. Эрдэнэхайрхан сумын нутагт тархан амьдардаг байна.

Мөн зурган дээр тодорхойлсноор Аргаль нь амьдарч болох боломжит газруудыг тодорхойлсон бөгөөд үүнд Завхан аймгийн зүүн талаар тархан амьдрах боломжтой юм. Тухайлбал: Улиастай хот, Цагаанхайрхан сум, Отгон сум, Яруу сум, Их-Уул сум, Тосонцэнгэл сум, мөн Шилүүстэй сумын Цахир мандалт уулын ан агнуурын бүсүүдэд амьдрах боломжтой байна.

**Ойн булга:** Ойн булга нь хүйсийн ялгаатай төрхтэй амьтанд орно. Эр булганы биеийн урт 38-56 см, сүүл нь 9-12 см, 880-1800 гр жинтэй. Эм нь 7,2-11,5 см сүүлтэй, биеийн урт 35-51 см. Өвлийн арьс нь урт сортой, гялалзсан, зуныхаас илүү тансаг байдаг. Өөр өөр дээд зүйлүүд нь газарзүйн бүсээс хамааран ялгаатай өнгийн арьс үстэй. Булга нь ойн суусартай гадаад төрхөөр маш төстэй ч арай урт чих, толгой харьцангуй богино сүүлтэй юм.



Зураг 11. Ойн булганы амьдрах боломжит ба цөм газар


Зурган дээрээс харахад Завхан аймгийн зүүн талаар байршин амьдрах боломжтой юм. Тухайлбал Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Яруу, Улиастай сумууд нь хамгийн их ойн булга амьдрах тохиромжтой нутагт орсон байна.

Мөн зурган дээр тодорхойлсноор Баянтэс сумын хойд зүгт Хусын голын сав дагуу, Түдэвтэй сумын Холбоо нуурын сав дагуу нутагт, бүст нуурын сав дагуу, Идэр сумын Жаргалантын голын нутагт, Цагаанхайрхан сумын Ширээгийн гол дагуу, Нөмрөг

сумын Тахилт нуур болон Холбоо нуурын сав дагуу, Баянхайрхан сумын Тэсийн гол дагуу нутаглан амьдрах боломжтой байна.


**Борцгор хотон /шувуу/:** Борцгор хотон шувууны боломжит үүрэлдэг орчин нь Завхан аймгийн нутаг орж байгаа юм. Мөн боломжит хооллодог сумууд нь Нөмрөг сумын Тэлмэн нуур, мөн Тахилт нуур, Түдэвтэй сумын Шорвог нуур, Баянтэс сумын Тэсийн гол, Зайгал гол, Цэцэн-Уул сумын Цэгээн нуур, Завханмандал сумын Баян нуур, Зэгэстийн нуур, Эрдэнэхайрхан сумын Хар нууруудад хооллох болон амьдрах боломжтой байна.

Бие том, 170 см, 13 кг хүртэл жинтэй. Ерөнхий зүс цагаан, хүчирхэг урт үзүүр лүүгээ нарийссан өргөн хошуутай. Хошуун дороо шар сарьсан ууттай. Орооны үед цул сарьс улаан болж хувирна. Хэвэл цагаан, нуруу бор сааралдуу, дагз, шилний өд буржгар, хөх саарал. Нэгдүгээр зэргийн дэвүүрүүд хар. Зулзган хотонгийн хөл, хошуу хар, дагз, шилний өд буржгардуу, нуруундаа хүрэндүү толбуудтай. Хүзүүгээ гэдрэг нугалж, далавчаа хүчтэй цөөн дэвэн ниснэ. Алдалсан далавч нь 160-180 сантиметр, өргөн богино сүүл нь 24 ширхэг өдтэй.




Зураг 12. Борцгор хотонгийн амьдрах боломжит газар

**Зэрлэг гахай:** Зэрлэг гахайн бueийн урт нь 150-170 см, жинс нь 110-140 кг. Тарга тэвээрэг авсан үедээ 120-170 кг хүрнэ. Эрийг бодон, эмийг мэгж, төлийг тоорой гэнэ. Их азарган гахайг хана, хамгийн том бодонг ногтмол бодон, түүний дараа хангал бодон, хязаалан хадаргаа бодон соёолон залуу бодон гэх мэтээр нэрлэнэ. Зургаас харахад Улиастай хотын Яруугийн гол, Богдын гол, Цагаан нуур болон Хөх нуурын сав дагуу ажиглагдсан байна. Мөн зэрлэг гайхайн амьдрах цөм нутаг нь Тосонцэнгэл сумын Дэлгэрэхийн голын сав, Баянтэс сумын Тэсийн гол болон Хусын голын сав дугуу нутаглан амьдрах цөм нутаг гэж тодорхойлогдсон байна.



Зураг 13. Зэрлэг гахай амьдрах боломжит газар


**Ирвэс:** Ирвэс нь Алдархаан сум болон Улиастайн хотын нутагт тодорхой амьдрах орчин гэж тодорхойлсон байна. Мөн Завхан аймгийн урд зүгт ихэвчлэн боломжит амьдрах орчин юм. Тухайлбал: Отгон сум, Цагаанхайрхан сум, Алдархаан сум, Улиастай хот, Яруу сумдын нутгаар амьдрах тохиромжтой байна



Зураг 14. Ирвэс амьдрах боломжит газар

Биеийн урт 135 см, сэрвээний өндөр 60 см, сүүлний урт 92 см, жин 45 кг хүрнэ. Бие сунагар урт, гинс гэндээс биеэр бага. Мөч богино, сарвууны алга тавхай өргөн, том, нуумал хумстай. Толгой жижиг, чих богино. Нүд том, хүүхэн хараа дугуй. Цайвар шаргал дэвсгэр дээр 6-8 см дугуйвтар хар толбонуудтай эрээн цоохор зүстэй. Хэвэл толбогүй, цагаан цайвар өнгөтэй. Толгой духны хэсэгт жижиг, шигүү хар толбонууд бий.

**Усны нөмрөг бүргэд:** Нас гүйцсэн нь цагаан толгой, цээж, хэвлий, сүүлтэй ба нуруун, бусад хэсэг нь саарал, хар өнгөтэй. Сүүл нь богино ба бусад *Haliaeetus* төрлийн зүйлүүдтэй адил гурвалжиндуу хэлбэртэй. Өндөр мод, эсвэл хад цохионы оройд мөчир зэргээр үүр засаж 2 өндөг гаргадаг. Өндөг нь 73x 55 мм хэмжээтэй. Судалгаанаас харахад Завхан аймгийн баруун зүг, урд зүг, зүүн зүгийн нутгаар ихэвчлэн үүрлэгдэг гэж үзсэн байна. Тухайлбайл: Ургамал сум, Завханмандал сум, Дөрвөлжин сум, Эрдэнэхайрхан сум, Улиастай хот, Цэцэн-Уул сум, Тэс сум, Баянтэс сум, Баянхайрхан сум, Түдэвтэй сум, Нөмрөг сум, Тэлмэн сум, Тосонцэнгэл сум, Их-Уул сум, Идэр зэрэг сумуудаар үүрлэдэг орчны загвар гаргасан байна.




Зураг 15. Усны нөмрөг бүргэд амьдрах боломжит газар

**Халиу буга:** Эр бугын сэрвээний өндөр нь 140-1650 см, биеийн урт 213-247 см, сүүл 7-13 см, зүс бор халиун, хэвлий тан цайвар зогдортой. Дайр хосоор 12 салаалсан том сэргэр эвэртэй, 7 кг хүртэл жинтэй юм.

Судалгаанаас харахад Завхан аймгийн 11 сумаар ихэвчлэн ажиглагдсан байна. Тухайлбал: Ургамал сум, Баянтэс сум, Баянхайрхан сум, Эрдэнэхайрхан сум, Нөмрөг сум, Алдархаан сум, Улиастай сум, Цагаанхайрхайн сум, Идэр сум, Их-Уул сум, Тосонцэнгэл сумуудаар халиун буга нь ажиглагдсаг гэж судлагдсан байна.


Халиун буга амьдрах боломжит газарт нь Хар нуур, Чигэстэйн гол, Богдын гол, Цагаан нуур, Рашааны гол, Буянт гол, Бумбатын гол, Жаргалантын гол, Ямаатын гол,

Дэлгэрэхийн гол, Дээд Цэцүүх гол, Хуянтгийн гол, Холбоо нуур, Бүст нуур, Зайгал гол, Тэсийн голын сав дагуух нутгуудад амьдрах боломжтой гэж судлагдсан байна.



Зураг 16. Халиун буга амьдрах боломжит газар

**Хулан жороо:** Хулан жороо шувуу нь махийсан хошуутай ба магнай хэсэгт хар судалтай.




Зураг 17. Хулан жороо амьдрах боломжит газар

Холоос харахад зулай, сүүлний үзүүр, далавчны ирмэг нь хар мэт боловч сайн харвал гялалзсан гүн ногоон өнгөтэй, цагаан судалтай, нисэхэд далавчин дээрх цагаан судал нь илүү том тод харагддаг. Тэд суурин амьдарна. Биеийн урт 26-28 см, харьцангуй биерхүү, элсэн шаргал бордуу өнгөтэй, хошуу хөл нь хар байдаг.

Зургаас харахад Завхан аймгийн 2 сумуудаар Хулан жороо нь ажиглагдсан байна. Тухайлбал: Ургамал сумын Хүнгий голын баруун хойд зүгт, Улиастай хотын Цагаан нуурын сав дагуу болон Хөх нуурын дагуух нутагт, Богдын голын нутагт ажиглагдсан байна. Мөн боломжит үүрлэх нутаг нь Дөрвөлжин сумын баруун зүгт Бага нуурын сав дагуух газарт нутагладаг ба Завхан голын сав дагуух нутагт үүрлэдэг, Ургамал сумын Хүнгий голын сав дагуу, Сантмаргац сумын Холбоо голын сав дагуу үүрлэдэг, мөн Шилээстэй сумын Завхан голын сав дагуух газарт байршдаг, Алдархаан сумын Төмөрт голын дагуух газарт байршин үүрлэдэг байна.

**Цагаан зээр:** Уудам тал, ухаа толгодоор цагаан зээр хэдэн зуугаараа сүрэглэн амьдардаг. Зээрийн эрийг ооно, эмийг шаргачин, төлийг янзага, эрэгчин шүдлэнг цэнхэр ооно, охин шүдлэнг зусаг шаргачин, сүргийн манлайг цэгц гэдэг дунджаар 30-40 толго нь нэг сүрэг болно. 20 гаруй жилийн өмнө цагаан зээр 10-20 мянга хүрч сүрэглэдэг байжээ. Зээрийн сүрэг долоо хоногт 100-150 километр алсад нүүдэллэдэг. Завхан аймгийн Ургамал сум болон Дөрвөлжин сумын баруун зүг, Завханмандал сум, Сантмаргац сумын нутагт ихээр нутагладаг байна.


Голын халиу амьдрах боломжит газар нь Завхан аймгийн баруун зүгт амьдрах боломжтой гэж судлагдсан байна. Тухайлбал: Ургамал сум, Ургамал сум, Завханмандал сум, Сантмаргац сум, Эрдэнэхайрхан сумуудын нутагт амьдрах боломжтой.



Зураг 18. Цагаан зээр амьдрах боломжит газар







Зураг 20. Өгөөлэй шулганаа амьдрах боломжит газар

**Усны биологийн төрөл зүйл:**

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын үндсэн гол мөрний орчин үеийн амьгүй байгалийн (абиотик) онцлог шинжүүд гэвэл, усны түвшингийн хэлбэлзэл нуур, голын усны эрдэсжилтийн хувьсалт, халуун хүйтний /температурын/ хоног, улирал болон жилийн өөрчлөлт юм. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын загасны зүйлүүд филогенетикийн хувьд залуу бөгөөд хатуу ширүүн нөхцөлд амьдрах чадвар бүхий биологийн өвөрмөц шинжтэй болжээ. Тус бүс нутгийн загасны аймаг нь плиоцен, плейстоны сүйрэл дагуулсан гео-цаг уурын үзэгдлүүдийн дараа үлдэж хоцорсон евросибирийн ба хятадын загасны аймгийн цөөн тооны элементүүдийн суурин дээр плейстоны дунд үеэс өдгөө хүртэлх түүхэн богино хугацаанд хэлбэржин бүрэлдэн тогтсон байна. Загасны өсөлт хооллолт, тархалтанд усны татрал багасалт, агнуур, ашиглалттай холбоотойгоор бий болох сөрөг үр дагаварууд нь загасны нөөцийн хэмжээнд нэн нөлөөтэй. Загас агнуурын ач холбогдолтой зарим нууруудад загасны тоо хэмжээ, тэдгээрийн бөөгнөрөлийг эхолокацийн хэт авиагаар тодорхойлоход Завхан аймгийн нуруудад загасны популяцийн тоо хэмжээ өндөр байгаа ч, энэхүү нөөц нь агналтын хязгаар хэмжээ болон загасны нөөцийн шинжлэх ухааны үндэслэлийг алдагдуулбал амархан дуусах аюултай. Одоогоор гадагш урсгалгүй ай савын нууруудаас өвлийн улиралд эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй ч заасан хэмжээгээ хэтрүүлэх, зөвшөөрөлгүй мөртлөө хууль бусаар загас байнга олборлох үзэгдэл их байна.

Төв Азийн гадагш урсгалгүй ай савын экосистемийг тодорхойлохын тулд эдгээр ай савын биологийн орчин үеийн олон янз байдал, усны хөвөгч ба ёроолын амьтад, загасны бүрэлдэхүүнийг авч үзлээ. Зоопланктоны бүлгэмдэл нь өндөр уулсын системийн хүчтэй бэрхшээлд тэр бүр үл өртөх евросибирийн эвритоп зүйлүүд

тархан нутагшснаас тэдгээрийн биологийн онцлог ба организмуудын амьдралын үечлэлээс түргэн сэргэх, гадны хүчин зүйлүүдийн нөлөөллөөс түргэн өөрчлөгдөх чадвартай. Харин загасны бүлгэмдлийн тухайд гадны хүчин зүйлд удаан дасдаг тул бүлгэмдлийн нөхөн сэргэлт тухайн бүс нутагт миоцен-плиоцены үеийн амьтны аймгаас уулын тасархай усанд үлдэж хоцорсон цөөн тооны зүйлүүдээс үндсэндээ бүрдэж байна. Үүсэл гарлаас шалтгаалан нуурын гүн 4-80 м хүрдэг онцлогтой. Нуурын гарал үүсэл, гүн, эрдэсжилтийн хэмжээ ийм олон янз байгаа нь тэнд амьдрах амьтан ургамал, загасны төрөл зүйлд нөлөөлж морфологи-физиологийн өвөрмөц шинжтэй болгожээ. Төв Азийн гадагш урсгалгүй ай савын нууруудыг гидробиологийн хэв шинжээр нь Алтай бүлэг нуурууд (Хотон, Хоргон, Ачит, Хонгор-Өлөн, Үүрэг, Увс), Их нуурын хотгорынх (Хар, Хар ус, Дөргөн, Айраг, Хяргас), Хангайн нурууны уулархаг тэгш өндөрлөгийн (Хүнгүйн Хар, Улаагчны Хар, Тэлмэн, Сангийн далай, Хөх нуур), Говийн хөндийн нуурууд (Орог, Бөөн цагаан г.м.) гэж дөрвөн бүлэгт ангилдаг.

Эдгээр нуурт 69 зүйл планктон ургамал, 186 зүйл фитобентос байгаагийн дотор 83 зүйл нь замгийн аймгаас, 103 зүйл нь усны дээд ургамал байв (Дулмаа, 2014). Тектоникийн гүн хотост орших уулархаг газрын (Хотон, Хорго, Толбо, Үүрэг, Хяргас, Хөх, Сангийн далай зэрэг) нуурууд харьцангуй их гүн устайгаас литораль бүс маш бага хөгжсөн учир усны дээд ургамлаар нилээд ядмаг. Харин тал хээр, говийн бүсийн (Хар ус, Увс, Бөөнцагаан, Орог г.м.) нуурт усны дээд ургамал ихээхэн талбай эзлэн ургана. Монгол ургамлын аймагт урьд мэдэгдээгүй нэг овог (*Najadaceae*) гурван төрөл зүйл (*Najas major*, *Subularia aquatica*, *Isoetes lacustris*), дөрвөн зүйл цэцэгт ургамал (*Batrachium mongolicum*, *Callitriche autumnalis*, *Potamogeton heterophyllus*, *P.teniifolius*) анх энэхүү тойргоос олдов (Санчир, Дулмаа, 1977). Сүүлийн жилүүдийн судалгаагаар *Myriophyllum verticellatum*, *Potamogeton panormitanus*, *P.berchtoldii*, *Polygonium lapathifolium* зэрэг олон зүйл шинээр олдоод байна. Планктон ургамлын хувьд цахиур, хөх ногоон замаг элбэг. Ховор тохиолдох зарим зүйлээс *Tetraedon trilobatum*, *Caloneis amphisbaena*, *Ankistrodesmus extensus*, *A.densus*, *Pediastrum angulosum*, *Oscillatoria princeps*, *O.kisselevii*, *Lyngbya perelegans*, *L.contorta* дурдаж болно. Энд 103 зүйл планктон амьтад байгаагаас 15,5 хувийг сэлүүр хөлт хавч хэлбэртэн, 28,2 хувийг салаа сахалт, 56,3 хувийг хүрд хорхой тус тус эзэлнэ. Мөн 118 зүйл стенотермик амьтдын дотор Planaria, Nematoda, Oligochaeta, Hirudina, Ostracoda, Gammaris, Mollusca, Hydrocarina, Chironomidae, Trichoptera, Plecoptera, Ephemeroptera, Tabanidae, Hemiptera, Odonata, Coleoptera зэрэг овгийнх байна. Үүнээс Chironomidae, Trichoptera, Ephemeroptera, Plecoptera төрөл давамгайлна.

Планктон амьтад болон ёроолын организмын биомассын хэмжээг олон жилийн дунджаар авч үзэв. Жишээ нь: Алтайн бүлэг нуурын планктон амьтны биомассын хамгийн их байх үе нь 7 сараас 8 сарын эцэс хүртэл үргэлжилнэ. Энэ үед нэг шоо дөрвөлжин метр усанд 0,28-2,0 г оногдоно. Ёроолын амьтны хэмжээ 7-10 кг/га байдаг. Харин биомассын хамгийн бага хэмжээ 2 сард тохиолдох бөгөөд 0,26-0,87 г/м<sup>3</sup> хүртэл буурчээ. Их нуурын хотгорын бүлэгт нуурт планктон амьтны хамгийн их биомасс 0,31-4,19 г/м<sup>3</sup>, ёроолын амьтных 4-20 кг/га, планктон амьтны хамгийн бага хэмжээ нь 0,13-0,62 г/м<sup>3</sup>. Хангайн нуруурхаг тэгш өндөрлөгийн бүлэг нуурт планктон амьтны биомассын дээд хэмжээ 0,21-2,06 г/м<sup>3</sup>, ёроолынх 7-15 кг/га. Говийн нуурын планктоны биомассын хэмжээ 1,28-2,05 г/м<sup>3</sup>, ёроолын амьтных 10-15 кг/га байдаг.

## 2.5 ЗАВХАН АЙМГИЙН ГАДАРГЫН УС

Завхан аймаг нь усзүйн сүлжээгээр Хойт мөсөн далайн ай сав, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагддаг. Хойт мөсөн далайн ай савд Идэрийн гол, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд Тэсийн гол, Хүнгүйн гол, Байдраг голууд орж байна. Монгол орны нутаг дэвсгэрийг 29 усны ай савд хуваасанаас Завхан аймгийн нутаг дэвсгэр нь 4 голын ай савд хамаарагдаж байна.

- Идэр голын сав
- Увс нуур-Тэс голын сав
- Хяргас нуур-Завхан голын сав
- Дэлгэрмөрөн голын сав



Зураг 21. Завхан аймгийн усны сав газрын зураг

Гадаргын усны нөөцөөр хамгийн их нь Увс нуур-Тэс голын сав, хамгийн нөөц байгатай нь Хяргас нуур-Завхан голын сав газар байна. Харин газрын доорхи боломжит усны нөөцөөр хамгийн их нь Хяргас нуур-Завхан голын сав, хамгийн нөөц багатай нь Идэрийн голын сав газар орж байна. Эндээс Завхан аймгийн хэмжээгээр гадаргын усны сүлжээ их байдаг ч усны нөөц баруун бүсийн хэмжээнд бага байгаа нь харагдаж байна. Иймд усны нөөцийг хамгаалах бодлого боловсруулах, гадаргын усанд хамгаалалтын бүс төлөвлөж, ашиглалтыг хязгаарлах бодлого барих нь зүйтэй юм.

Хүснэгт 10. Голын сав газруудын усны нөөцийн мэдээлэл

№	Сав газрын нэр	Нөөц тогтоосон он	Гадаргын усны нөөцийн нийт хэмжээ, сая.м <sup>3</sup> /жил	Гадаргын усны боломжит нөөцийн хэмжээ, сая.м <sup>3</sup> /жил	Газар доорх усны боломжит нөөцийн хэмжээ, сая.м <sup>3</sup> /жил
1	Увс нуур-Тэс	2010	1599.000	64.000	405.000

2	Хяргас нуур-Завхан	2010	599.000	45.000	892.000
3	Идэр	2010	710.000	53.000	129.000
4	Дэлгэрмөрөн	2010	1080.000	81.000	229.000

### Идэрийн голын ай сав:

Идэрийн гол нь Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр уулын ар хажуугаас эх авч, 452 км урсдаг, 30 гаруй гол горхи цутгадаг томоохон голын нэг юм. Идэрийн голын сав газар нь байгалийн мужлалаар Хангайн уулт өндөрлөгийн төв хэсгийн өндөр уулын ян сарьдагийн дэд мужид багтах бөгөөд гүн хөндий, эгц цавчим хажуу бүхий өндөр уулууд нь Идэрийн голын эхээр далайн түвшинээс дээш 4031 м хүртэл өндөрт байдаг (Үндэсний атлас, 2009). Сав газарт Завхан аймгийн Идэр, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул сумдын нутаг дэвсгэр ба Хойд мөсөн далайн ай савд багтана. Идэр голын савын дэвсгэр нутагт Жаргалант, Тарвагатай, Дунд, Эхэн, Зарт, Цэцүйх, Харзат, Нүхт, Шумуултай, Гунз зэрэг олон там, жижиг голууд цутгана.

Голын голдирол нь Тосонцэнгэл сумын төв хүртэл тахирлаж, хэд хэд салаалдаг тул төдийлэн өргөн биш, 10-15 м, үндсэн голоороо 40-60 м өргөнтэй урсдаг. Тосонцэнгэлээс доош 80-100 хүртэл өргөснө (Монгол орны гадаргын ус, 2009). Идэр голын урсацын 20-30 хувь нь газрын доорхи ус, 25 хувь нь хайлсан цас, 45-55 хувь нь борооны усаар тэжээгддэг.

Олон жилийн дундаж урсац Идэр сум орчимд 7,8 м<sup>3</sup>/с, Тосонцэнгэл сум орчимд 16,3 м<sup>3</sup>/с болж нэмэгдэж байна. Голын савд усны нөөц харьцангуй их учир 7-9 саруудад хамгийн их урсац ажиглагддаг.

Хүснэгт 11. Идэр голын урсацын хуваарилалт

Идэр голын үзүүлэлт	Олон жилийн дундаж		Их устай байсан жил /1990 он/		Хамгийн бага устай байсан жил /2004 он/	
	Жилийн дундаж урсац	Нөөц, сая м <sup>3</sup> /жил	Жилийн дундаж урсац	Нөөц, сая м <sup>3</sup> /жил	Жилийн дундаж урсац	Нөөц, сая м <sup>3</sup> /жил
Идэр сум орчимд	7,4	234,6	18,5	584,1	2,2	69,6
Тосонцэнгэл сум орчимд	16,3	514,8	59,7	1883,4	4,0	126,1

Идэр голын уснаас авч болох усны хэмжээг голын усны дунд хэсгийн олон жилийн дундаж урсацын 5- 8 хувь гэж тогтоосон байдаг (Монгол орны гадаргын ус, 1999). Энэ хэмжээгээр авч үзвэл Тосонцэнгэл орчимд 0,81-1,3 м<sup>3</sup>/с буюу жилд 25,7-41,2 сая м<sup>3</sup> ус авч болохоор байна.

### Хяргас нуур-Завхан голын сав:

Сав газарт Завхан аймгийн Алдархаан, Баянхайрхан, Дөрвөлжин, Завханмандал, Нөмрөг, Отгон, Сантмаргац, Сонгино, Түдэвтэй, Тэлмэн, Улиастай, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумд хамрагдаж байна.

Сав газрын хамгийн урт урсах үндсэн гол нь Завхан гол бөгөөд Хангайн нуруунаас эх авч, түүний гол нурууны хажуу хормойг хаяалан урсаж, Хяргас нуурт цутгадаг. Голын эхэндээ уулархаг, дунд хэсэгтээ говийн бэсрэгэ уул, толгодоор, адаг хэсэгтээ элсэн манханаар олон салаалан урсдаг байна.

Тус сав газарт Завхан гол, Тээлийн гол, Хүнгүй гол, Галуут гол, Гүн нуур, Холбоо нуур, Баян нуур, Ойгон нуур, Тэлмэн нуурууд хамрагдаж байгаа бөгөөд гадаргын усны ашиглаж болох боломжит нөөц нь 45 сая м<sup>3</sup>/жил, бага устай жил 23сая м<sup>3</sup>/жил

байна (Хяргас нуур-Завхан голын сав газрын усны нөөц, ус ашиглалтын суурь судалгаа, 2013) .

Уг савд багтаж байгаа Завхан аймгий нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын доорхи усны ордуудын үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 12. Хяргас нуур-Завхан голын сав газрын газрын доорх усны ордуудын гидрогеологийн үзүүлэлтүүд

№	Сумын нэр	Цооногийн ундарга, л/с	Түвшний бууралт, м	Шүүрлийн итгэлцүүр, м/хоног
1	Цагаанчулуут	1,0-3,0	6,2-8,8	0,55-2,2
2	Нөмрөг	3,3-10,0	10,0-14,2	2,15
3	Отгон	1,0-9,0	0,99-3,01	5,7-9,9
4	Улиастай	21,4-28,57	0,85-3,05	31,18-32,09 75,31-106,74

Байгаль орчны яамны гаргасан судалгаагаар Завхан аймаг нь гадаргын усны сүлжээ ихтэй боловч, цэвэр усны нөөцөөр Монгол улсын хэмжээнд гадаргын болон гүний усны нөөцөөр бага аймагт багтаж байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын нийт гадаргын усны нөөцийн 0,12 хувь, ул хөрсний усны 0,16 хувийг Завхан аймаг бүрдүүлж байна (Байгаль орчны мэдээллийн сан [www.eic.mn](http://www.eic.mn)).


Хүснэгт 13. Монгол улсын усны нөөцөд Завхан аймгийн эзлэх хэмжээ

№	Аймгийн нэр	Гадаргын усны нийт нөөц, км <sup>3</sup>	Ул хөрсний усны нийт нөөц, км <sup>3</sup>	Тооллогод авсан огноо
1	Архангай	283.000	1.060	05.02.02
2	Баян-Өлгий	239.000	1.050	05.02.03
3	Баянхонгор	45.000	10.000	05.02.04
4	Булган	175.000	50.000	05.02.05
5	Говь-Алтай	58.000	10.000	05.02.06
6	Говьсүмбэр	1.000	1.000	05.02.23
7	Дархан-Уул	44.000	1.000	05.02.22
8	Дорноговь	5.000	10.000	05.02.07
9	Дорнод	151.000	30.000	05.02.08
10	Дундговь	12.000	8.000	05.02.09
11	<b>Завхан</b>	<b>3.160</b>	<b>1.040</b>	05.02.10
12	Өвөрхангай	56.000	10.000	05.02.11
13	Өмнөговь	38.000	1.000	05.02.12
14	Орхон	5.000	1.000	05.02.21
15	Сүхбаатар	14.000	3.000	05.02.13
16	Сэлэнгэ	3.200	97.000	05.02.14
17	Төв	191.000	59.000	05.02.15
18	Увс	1.200	23.000	05.02.16
19	Улаанбаатар	77.000	30.000	05.02.20
20	Ховд	1.100	25.000	05.02.17
21	Хөвсгөл	659.000	249.000	05.02.18
22	Хэнтий	669.000	270.000	05.02.19
<b>Монгол улсын нийт</b>		<b>2730.660</b>	<b>648.150</b>	

	Их нөөцтэй
	Дунд зэрэг нөөцтэй
	Бага нөөцтэй

Эх сурвалж: Байгаль орчны мэдээллийн сан [www.eic.mn](http://www.eic.mn)

2011, 2015 онуудад Завхан аймгийн гадаргын усны тооллого хийгдсэн бөгөөд 183гол горхи, 87 нуур тойром, 414 булаг харз, 14 рашаан, 8 услалтын систем, 5 усан цахилгаан станц тоологдсон байна (Байгаль орчны мэдээллийн сан, 2011-2015 он).



Зураг 22. Завхан аймгийн усзүйн сүлжээний зураг

Хүснэгт 14. Завхан аймгийн гадаргын усны мэдээлэл

№	Сумын нэр	Гол горхи		Нуур, тойром		Булаг харз		Рашаан		Услалтын систем		Усан цахилгаан	
		Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Ашиглалттай	Тоологдсон	Ашиглалттай
1	Алдархаан	13	13	3	3	27	27	1	1	6	3	1	1
2	Асгат	1	1			1	1						
3	Баянтэс	15	15			38	38						
4	Баянхайрхан	8	8	6	6	32	32						
5	Дөрвөлжин	1	1	1	1	5	5	2	2				
6	Завханмандал	1	1			2	2	1	1			1	1
7	Идэр	8	8	7	7	3	3						
8	Их-Уул	19	19			20	20	2	2				
9	Нөмрөг	8	8	10	10	12	12	1	1				
10	Отгон	16	16	12	12	22	22	2	2				
11	Сантмаргац	4	4	20	20	1	1	1	1				
12	Сонгино	4	4			14	14						
13	Тосонцэнгэл	20	20	1	1	2	2	2	2	1	1	1	1
14	Түдэвтэй	7	7	1	1	21	21						
15	Тэлмэн	7	7	3	3	30	30						

16	Тэс	1	1			7	7						
17	Ургамал	2	2	4	4	2	2						
18	Цагаанхайрхан	9	9	1	1	33	33						
19	Цагаанчулуут	4	4	1	1	11	11						
20	Цэцэн-Уул	5	5	6	6	39	39			1	0	1	1
21	Шилүүстэй	6	6	3	3	44	44	2	2			1	1
22	Эрдэнэхайрхан	8	8	5	5	21	21						
23	Яруу	14	14	3	3	27	27						
24	Улиастай	2	2										
<b>Аймгийн нийт</b>		<b>183</b>	<b>183</b>	<b>87</b>	<b>87</b>	<b>414</b>	<b>414</b>	<b>14</b>	<b>14</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>5</b>

Аймгийн зарим томоохон гол нууруудын товч мэдээлэл:

**Завхан гол:** Хангайн гол нурууны ноён оргил Отгонтэнгэрийн хоёр талаас эх авах гол горхиор усжигдана. Хангайн өмнө хажуугаас эх авдаг Буянт, Шар-Ус хоёр голын хоёр билчирийг Завхан голын эх гэж үздэг. Буянт ба Шар-Ус голын хөндийд мөсдөлийн морены хурдас нь тогтсон хэдэн арван нуур байдгаас хамгийн том нь 20 хавт.дөр.км талбайтай Хөх нуур болно. Эдгээр бүлэг нуур өөр хоорондоо гол горхиор холбогдохоос гадна илүүдэл усаа Завхан голд юүлдэг байна. Завхан гол Хангайн гол нуруунаас мултармагц өмнө зүгийг орхиж баруун хойш их нууруудийн хотгорийг чиглэн урсана. Тайшир сум хүртэл эхний хэсэгт гульдиралын өргөн 30-60 м, усны гүн 0,6-25 м, урсгалын хурд 1-1,5 м/сек байна. Тайшираас доош хэсэг газар гульдирал нь 3-8 хүртэл салаалах тул үндсэн гульдиралыг ялгахад бэрх юм. Завхан голын баруун гараас түүний хамгийн том цутгал болох буюу Шурагын гол нийлнэ. Богд голын цутгалаас доош гульдирал 100-350 м хүртэл өргөсөн задгайрч усны гүн 0,7-1,5 м, урсгалын хурд 0,7-1,2 м/сек болно.

**Идэрийн гол:** Идэрийн гол Хангайн гол нурууны араас эх авч Булнай, Тарвагатайн нуруунуудын хоорондох нилээн давчуу хөндийгөөр урсана. Голын урт 452 км, талбайн хэмжээ 24555 хавт.дөр.км юм. Голын гульдирал Тосонцэнгэл сумын төв хүртэл ихээхэн тахиралж хэд хэд салаалдаг тул тэгтлээ өргөн байж чаддаггүй. Энэ хэсэгт салаа татуурын өргөн 10-15 м, үндсэн голын өргөн 40-60 м орчим байна. Тосонцэнгэлээс доош гульдирал салаалахаа багасч 80-100 м хүртэл өргөснө. Усны гүн 0,7-2 м боловч Чулуут голын цутгалаас доош цээл цүнхэл газраа 3-3,5 м хүрнэ. Идэрийн гол уулын гол учраас ширүүн урсгалтай, урсгалын хурд голын ихэнд цагт 7,2-10,8 км бол адаг руугаа саарсаар цагт 2,0-2,5 км болон буурна. Харин зонхилох хурд нь 1,5-2 м/сек юм. Эхнээсээ Их Жаргалант сум хүртэлх хэсэгт Тарвагатайн нурууны ар хажуугаас усжих, Хожуул, Зарт, Дээд, Доод Цэцүүх, Хөнжил зэрэг урсгал хурдтай услаг гол горхи цутгадаг. Идэрийн голд 30 гаруй гол горхи цутгадгаас хамгийн том нь түүний баруун гараас цутгах Чулуут гол болно.

**Тэс гол:** Булнайн нурууны араас эх авч Увс нуурт цутгах энэ гол 568 км урт бөгөөд 33358 хавт.дөр.км талбайгаас усжина. Тэсийн голд Тагны нурууны өврөөс эх авсан хэдэн арван услаг гол горхи цутгах тул доошлох тутмаа ус элбэгтэй болно. Голын сав газар эхэндээ уулархаг боловч уулс харьцах өндрөөрөө нам юм. Булнайн нурууны араас урсах голуудын билчирт асар их талбайг хамарсан намаг үүсгэх бөгөөд түүнийг Жаргалантайн намаг гэнэ. Тэсийн гол Завхан аймгийн нутгаар ОХУ-н нутаг руу гарч Увс аймгийн Тэс сумын нутгаар эргэн монголдоо орж ирж Увс нуурт цутгана. Адагтаа хэд хэд салаалж намаг бүхий голын садраа адаг үүсгэнэ. Үндсэн голын гульдирал эхэндээ 150-60 м, урсгалын дунд хэсэгт 40-120 м, зарим хэсэгт 200

м хвртэл задгайрч өргөснө. Усны зохилох гүн 0,3-2,5 м, урсгалын хурд 0,7-1,5 м/сек орчим юм.

**Тэлмэн нуур:** Завхан аймаг дахь цэнгэг уст нуур. Энэ нуур 3940 км<sup>2</sup> талбайгаас усжих боловч Хангайн салбар уулсаас хэд хэд горхи нуурын хотгоруу урсдагаас зөвхөн Хоолойн гол хэмээх байнгын урсацтай жижиг горхи л цутгана. Гадагш урсгалгүй. Тэлмэн нуур нь Завхан аймгийн Тэлмэн, Нөмрөг сумын заагт оршдог. Талбайн хэмжээ: 194 км.кв, Урт: 28 км, Өргөн: 16км

**Улаагчны хар нуур:** Завхан аймаг дахь цэнгэг уст нуур. Улаагчны хар нуур гэдэг энэ нуур Эрдэнэхайрхан сумын төвөөс зүүн хойш 80км, Улиастайгаас 110км оршдог. Хойд талаараа элсэн манхан, элсэн шанаагаар хүрээлэгдсэн, урд талаараа эрэг орчимын шанаанууд зэгстэй жаахан нуур Товхошын сүрлэг уулаар хүрээлэгдсэн байдаг. Нуурын гүн нь 48м, уртаашаа 20 гаруй км, өргөн нь 10-аад км сунаж тогтсон нуур. Хар нуур нь Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт оршдог. Талбайн хэмжээ: 84.5 км.кв, Урт: 25 км, Өргөн: 7км

**Баян нуур:** Хангайн нуруунд дээр байрлах цэнгэг уст нуур. Нуурын өмнөд эрэг нь элсэрхэг тул/элсний том нүүдлийн замд байдаг/ илүүдэл ус үүгээр шүүгдэж, үүний ачаар цэнгэг устай байдаг ажээ. Тиймээс урд зах нь элсэн манханд тулж үзэсгэлэнт булан тохой, шугуй, баян бүрд үүсгэсэн байрлалтай, зэлүүд онгон газар аж. Баян нуур нь хэдийгээр бага талбайтай боловч Монголын цэнгэг уст нууруудаас эзлэхүүнээрээ 6-д жагсдаг. Зүүн талаас нь Мухар Хүнгийн гол цутгадаг. Гадагш урсгалгүй. Баян хар нуур нь Завхан аймгийн Сантмаргац сумын нутагт оршдог. Талбайн хэмжээ: 64 км.кв, Урт: 14 км, Өргөн: 8км

Хүснэгт 15. Завхан аймгийн зарим нууруудын дүрсзүйн тодорхойлолт

№	Нуурын нэр	Өндөр, м	Талбай, км <sup>2</sup>	Нуурын урт, км	Нуурын өргөн, км		Нуурын гүн, м		Нуурын эзэлхүүн, км <sup>3</sup>
					Дундаж	Хамгийн их	Дундаж	Хамгийн их	
1	Улаагчны хар нуур	1980	84,5	24,3	3,5	6,6	20	47	1,654
2	Баян нуур	1491	64,2	14	5	8,3	22	50	1,390
3	Ойгон нуур	1664	61,3	18,1	3	8	3,5	8	0,207
4	Бүст нуур	2041	22,1	7	3,1	4,2	5,7	10	0,127
5	Холбоо нуур	1941	14	4,7	3	4,5	4	6	0,052
6	Хөх нуур	2455	11	5,4	2	3	1,6	4,3	0,018
7	Цэгээн нуур	1882	7,7	5,2	1,4	2,4	4,1	8	0,032
8	Бага нуур	1132	7,6	3,9	2	2,7	0,8	1,7	0,006
9	Хунт нуур	1940	7,4	4	1,8	3,9	5	7,2	0,023
10	Хаг нуур	2039	7,1	7,4	1	1,5	1,2	3	0,009
11	Холбоо нуур	1569	6,5	5,5	1,1	2,2	1	2,5	0,007
12	Тахилт нуур	1842	5,1	2,9	1,8	2,1	1	2	0,005
13	Цагаан нуур	2237	3,1	3,6	0,9	1,6	17	28,5	0,055

Эх сурвалж: Монгол орны байгаль орчин, II боть, 2017 он



## 2.6 ЗАВХАН АЙМГИЙН ОЙ

Завхан аймгийн хэмжээгээр ойн санг судлах ажлыг анх 1956-1957 онд хуучнаар ЗХУ-ын техник, мэргэжилтний туслалцаатайгаар агаарын таксацын тоймчилсон судалгааг явуулж ойн сангийн нийт талбай, тархалтын хил хязгаар, таксацын үндсэн үзүүлэлтүүдийг тогтоосон байна.

1973, 1982 онуудад Тосонцэнгэлийн Мод боловсруулах үйлдвэрийн ашиглалтын нөөц бүхий Тосонцэнгэл, Их-Уул сумдын ойн сан бүхий нутагт хэсэгчилсэн судалгаа явагдаж байсан ба 1991 онд ой бүхий сумдыг хамарсан ой зохион байгуулалтын ажлыг Завхан аймгийн хэмжээгээр хийж гүйцэтгэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах төсөл, зураглалын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс хойш 2006 болон 2013 онд аймгийн хэмжээнд ой зохион байгуулалт хайгуул судалгааны ажлыг “Ой, усны хайгуул судалгааны төв” хийж, төсөл зургийн ажлыг гүйцэтгэсэн байна.

2017 онд “Мөнх ногоонжодоо” ХХК аймгийн ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажлыг гүйцэтгэж, 2018-2022 оны хугацаанд баримтлах ойн төлөвлөгөө боловсруулсан байна.

### Ойн ургамалжилт:

Завхан аймгийн ойн сан нь ургамалжилтын ангиллаар “Хангайн ой-ургамалжилтын муж”-ийн “Төв хангайн хошуу”-нд хамаарагдаж уулын цармын тармаг, уулын тайгын, уулын тайганцар ой гэсэн 2 үндсэн өндрийн бүслүүрт хамаарагдаж байна.

*Уулын цармын тармаг ой* - Төв хангайн д.т.д 2200-2400 м өндөр тайгын хүлэнцэр цэвдэгт хөрсөнд тархсан бушилзат (*Kobresia mvosuroides*) шинэсэн ой хоршсон торлогт, ботууль-хөвдөт, сөөгөнцөр-хөвдөт (*Larix sibirica*, *Betula rotundifolia*, *Salix glauca*, *Juniperus pseudosabina*, *Empetrum nigrum*, *Ledum palustre*, *Arctous alpina*, *Hvlocomium splendens*, *aulacomnium palustre*) Ү чансаатай голын эхний хамгаалвал зохих шинэсэн ой.


*Уулын тайгын ойн бүслүүрт* - д.т.д 1800-2000 м өндөрт тайгын жинхэнэ цэвдэгт хөрсөнд тархсан алирс-бадаант, алирс-сургар-ногоон хөвдөт, алирс-ритидиум хөвдөт, хамгаалвал зохих шинэс оролцсон Хушин ой, д.т.д 1700-2000 м өндөрт тайгын жинхэнэ цэвдэгт хөрсөнд тархсан сургар-алирс ногоон хөвдөт, алирс бадаант, алирс ритидиум хөвдөт, ашиглан хамгаалвал зохих Хуштай Шинэсэн ой,

*Уулын тайганцар ойн бүслүүр* - 1800-2200 м өндөрт бүрэн ялзмагжаагүй цэвдэгт хөрсөнд тархсан ритидиут хөвдөт (*Larix sibirica*, *Festuca ovina*, *Festuca altaica*, *Carex amgunensis*, *Lonicera altaica*) шинэсэн ой тархсан байна. Тайгажуу шинэсэн ойн хөвхний зузаан нь 3-6 см, зарим алирс-ритидиум хөвдөт ой хамгийн их хөвхний нөөцтэй 26,2 т/га байхад хангийн бага нөөцтэй 12,3 т/га нь сорвоо-ритидиут хөвдөт ой байна. Тайгажуу шинэсэн ойн нөөц нь 200-300 м<sup>3</sup>/га, заримдаа 130-550 м<sup>3</sup>/га байна.

### Насны бүлэг

Моддын аж ахуйн ач холбогдлыг илэрхийлэх зорилгоор насны бүлэгт хуваадаг. Моддын насны бүлэг тухайн модны биологийн онцлог, өсөлт, хөгжилт, аж ахуйн ач холбогдлоос хамаараад модны төрөл тус бүрт харилцан адилгүй байна. Аймгийн ойн санг насны бүлгээр нь авч үзвэл 85,83 хувь нь болц гүйцсэн хөгшин мод, 8,21 хувь нь

дундаж насны мод, 5,84 хувь нь болц гүйцэж яваа мод, 0,12 хувь нь залуу модод тархсан байна.



Диаграмм 8. Ойн нөөцийн насны бүлгээр тархсан байдал

Дээрх графикаас харахад болц гүйцсэн хөгшин ой зонхилон тархжээ. Иймд ойн экологи-эдийн засгийн ач холбогдол, ойн хэвийн нөхөн ургах нөхцөл боломжийг алдагдуулахгүйгээр огтлолтын зөв арга технологгоор ашиглах, ойжуулалт, ойг нөхөн сэргээх, арчилгаа, цэвэрлэгээ хийх зэрэг ойн аж ахуйн арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлэх замаар ойн санг аажмаар насны зөв жигд бүтэцтэй болгох шаардлагатай байна.

Хүснэгт 14. Байгалийн ойн талбай, насны бүлгээр

Модны төрөл	Насны бүлэг									
	Залуу ой		Дунд насны ой		Болц гүйцэж яваа ой		Болц гүйцсэн ой		Дүн	
	Талбай, га	Нөөц, м.куб	Талбай, га	Нөөц, м.куб	Талбай, га	Нөөц, м.куб	Талбай, га	Нөөц, м.куб	Талбай, га	Нөөц, м.куб
<b>Цармын бүслүүрийн ой</b>										
Шинэс	123	6150	878	44340	353	30520	2780	288910	4134	369920
<b>Дүн</b>	123	6150	878	44340	353	30520	2780	288910	4134	369920
<b>Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн ой</b>										
Шинэс	0	0	437	34630	679	60110	3872	440470	4988	535210
<b>Дүн</b>	0	0	437	34630	679	60110	3872	440470	4988	535210
<b>Байгалийн цогцолборт газрын ой</b>										
Шинэс	23	460	3031	262140	1703	191520	36448	4605090	41205	5059210
Хуш	0	0	0	0	813	96370	645	77950	1458	174320
Бургас	115	2050	112	1720	0	0	0	0	227	3770
<b>Дүн</b>	138	2510	3143	263860	2516	287890	37093	4683040	42890	5237300
<b>Ногоон бүсийн ой</b>										
Шинэс	0	0	6804	595740	4626	570930	57447	8164440	68877	9331110
Бургас	35	530	106	2120	0	0	0	0	141	2650
<b>Дүн</b>	35	530	6910	597860	4626	570930	57447	8164440	69018	9333760
<b>Хориотой зурвасын ой</b>										
Шинэс	424	17090	5705	613120	3227	396230	44161	6369640	53517	7396080
Хуш	0	0	0	0	517	89050	100	19000	617	108050
Гацуур	0	0	0	0	562	68580	3057	414640	3619	483220
Хус	0	0	91	4550	90	3600	0	0	181	8150
Улиас	0	0	26	7800	0	0	0	0	260	7800
Бургас	1845	25070	7068	151580	0	0	0	0	8913	176650
<b>Дүн</b>	2269	42160	13124	777050	4396	557460	47318	6803280	67107	8179950
<b>Хамгаалалтын бүсийн ой 100 га хүртэлх ой сөөг ширэнгэ уулын өвөр энгэр төгөл ой</b>										
Шинэс	43	1080	3756	394950	2132	253340	50606	7114450	56537	7763820
Хус	0	0	18	360	0	0	0	0	18	360
Бургас	18	330	79	790	20	200	0	0	117	1320
<b>Дүн</b>	61	1410	3853	396100	2152	253540	50606	7114450	56672	7765500
<b>Хамгаалалтын бүсийн ой 30 хэмээс дээш Налуу газрын ой</b>										
Шинэс	67	2010	7277	673650	1895	218450	36739	4821320	45978	5715430

Гацуур	0	0	0	0	0	0	156	23250	156	23250
Бургас	147	3080	0	0	0	0	0	0	147	3080
Дүн	214	5090	7277	673650	1895	218450	36895	4844570	46281	5741760
<b>Улсын хилийн дагуух ой</b>										
Шинэс	131	2220	3907	329230	3636	375820	23228	2920480	30902	3627750
Гацуур	0	0	0	0	0	0	302	38730	302	38730
Бургас	0	0	38	380	0	0	0	0	38	380
Дүн	131	2220	3945	329610	3636	375820	23530	2959210	31242	3666860
<b>Ашиглалтын бүсийн ой</b>										
Шинэс	230	7130	17769	1613710	8564	1013830	107069	14090280	133632	16724950
Гацуур	0	0	0	0	0	0	725	86600	725	86600
Улиангар	0	0	0	0	0	0	12	840	12	840
Бургас	0	0	40	800	0	0	0	0	40	800
Дүн	230	7130	17809	1614510	8564	1013830	107806	14177720	134409	16813190
<b>Нийт дүн</b>	3201	67200	57376	4731610	28817	3368550	367347	49476090	456741	57643450

### Ойн насны анги

Ой модод нь эдийн засгийн ач холбогдолоороо илэрхий ялгаа үзүүлэхгүй байж болох жилийн тоог насны анги гэсэн үзүүлэлтээр илэрхийлнэ. Төрөл бүрийн моддын өсөлт, хөгжилтийн эрчмээс хамаараад моддын насны анги харилцан адилгүй байдаг. Байгалийн ойн экологид үзүүлэх эерэг нөлөөг алдагдуулахгүйгээр түүнийг жигд тасралтгүй ашиглаж, мод, модон материалын байнга өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангах бололцоог нэмэгдүүлэх хамгийн гол үндэс нь насны зөв бүтэцтэй ой буй болгох үүний үр дүнд талбай, нөөцийг насны ангиар жигд байршуулах, түүнд чиглэгдсэн ойн аж ахуйн үйл ажиллагаа явуулах нь чухал байна.

### Ойн сангийн таксацийн дундаж үзүүлэлтүүд

Ой нь модны төрөл, нас, өтгөрөл, нөөц болон бусад үзүүлэлтээрээ өөр хоорондоо ялгаатай хэсгүүдээс бүрдэнэ. Нэгэнт дээрх үзүүлэлтүүдээрээ харилцан адилгүй учраас аж ахуйн ач холбогдлоороо ч, тэнд авч хэрэгжүүлвэл зохих ойн аж ахуйн арга хэмжээгээрээ бас харилцан адилгүй байна. Ойг өөр хоорондоо ижил төстэй байдлаар нь ялган тогтоох нь ойн таксацын гол асуудлын нэг бөгөөд түүнийг таксацын үзүүлэлтийн ялгаагаар үндсэнд нь шийддэг.

Ойн таксацын дундаж үзүүлэлтээс үзэхэд тус сумын ойн жилийн бүх дундаж өсөлт 379015 ш.м, дундаж бонитет 4.65, дундаж өтгөрөл 0.50, ойгоор бүрхэгдсэн талбайн 1 га-ийн нөөц 126.20 шоо метр, болц гүйцсэн ойн 1 га-ийн нөөц 134.68 шоо метр, 1 га-ийн дундаж өсөлт 0.82 шоо м байна.

*Ойн бонитет /чансаа/:* Нас, модны төрлөөрөө ижил боловч хөрс, уур амьсгалын өөр өөр нөхцөлд ургаж байгаа ой нь аж ахуй, эдийн засгийн ач холбогдлоороо ихээхэн ялгаатай байдаг учраас таксацын үед ойн ургах орчинд өгч байгаа үнэлгээг бонитет гэсэн үзүүлэлтээр тогтоодог. Тус аймгийн ойн дундаж бонитет нь 4.65 байгаа бөгөөд байгалийн ойн талбай нь нийтдээ IY-Y бонитетын ангид хамаарч байна. Бонитетын анги доогуур байгаа нь ургамал ургалтын хугацаа богино, чийг дутагдалтай зэрэг байгаль цаг уурын хүчин зүйлс нөлөөлөхөөс гадна ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлдэггүй, түймэр хортонд их нэрвэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 15. Байгалийн ойн бонитет, талбайгаар, га

Модны төрөл	Бонитетийн анги, талбайгаар /га/					Нийт талбай, га	Дундаж бонитет
	1	2	3	4	5		
<b>Цармын бүслүүрийн ой</b>							
Шинэс	-	-	-	63	4071	4134	4.98
Дүн	-	-	-	63	4071	4134	4.98

<b>Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн ой</b>							
Шинэс	-	-	-	49	4939	4988	4.99
Дүн	-	-	-	49	4939	4988	4.99
<b>Байгалийн цогцолборт газрын ой</b>							
Шинэс	-	-	-	8512	32693	41205	4.79
Хуш	-	-	-	-	1458	1458	5.00
Бургас	-	-	-	20	207	227	4.91
Дүн	-	-	-	8532	34358	42890	4.80
<b>Ногоон бүсийн ой</b>							
Шинэс	-	-	-	27344	41533	68877	4.60
Бургас	-	-	-	9	132	141	4.93
Дүн	-	-	-	27353	41665	69018	<b>4.60</b>
<b>Хориотой зурвасын ой</b>							
Шинэс	-	-	-	32268	21237	53505	4.39
Хуш	-	-	-	38	579	617	4.93
Гацуур	-	-	-	2694	925	3619	4.25
Хус	-	-	-	-	181	181	5.00
Улиас	-	-	-	-	260	260	5.00
Бургас	-	-	-	1484	7429	8913	4.83
Дүн	-	-	-	36484	30611	67095	4.45
<b>Хамгаалалтын бүсийн ой 100 га хүртэлх ой сөөг ширэнгэ уулын өвөр энгэр төгөл ой</b>							
Шинэс	-	-	-	24866	31671	56537	4.56
Хус	-	-	-	-	18	18	5.00
Бургас	-	-	-	4	113	117	4.96
Дүн	-	-	-	24870	31802	56672	4.56
<b>Хамгаалалтын бүсийн 30 хэмээс дээш Налуу газрын ой</b>							
Шинэс	-	-	-	13008	32970	45978	4.71
Гацуур	-	-	-	136	20	156	4.12
Бургас	-	-	-	-	147	147	5.00
Дүн	-	-	-	13144	33137	46281	4.71
<b>Улсын хилийн дагуух ой</b>							
Шинэс	-	-	-	7734	23168	30902	4.74
Гацуур	-	-	-	-	302	302	5.00
Бургас	-	-	-	-	38	38	5.00
Дүн	-	-	-	7734	23508	31242	4.75
<b>Ашиглалтын бүсийн ой</b>							
Шинэс	-	-	-	38296	95228	133524	4.71
Гацуур	-	-	-	725	-	725	4.00
Улиангар	-	-	-	-	12	12	5.00
Бургас	-	-	-	13	27	40	4.67
Дүн	-	-	-	39034	95267	134301	4.70
<b>Аймгийн нийт</b>	-	-	-	<b>157263</b>	<b>299358</b>	<b>456621</b>	<b>4.65</b>

*Ойн өтгөрөл:* Ой орон зайнхаа боломжийг хэдий чинээ бүрэн ашиглавал модны нөөц, өгөөж нь төдий чинээ их байна. Таксацад ойн орон зайн ашиглалтын түвшинг өтгөрөл гэдэг үзүүлэлтээр илэрхийлдэг. Өтгөрөл нь тухайн ойн бодит бүтээмжийн харьцангуй хэмжээг заах үзүүлэлт юм. Ургаж байгаа талбайнхаа байгалийн боломж, орон зайг бүрэн ашигласан ойг хэвийн ой гэж нэрлэдэг. Хэвийн ой орон зайгаа бүрэн ашиглан ургадаг учир модны нөөц нь нэг төрлийн тухайн нас, бонитетын ойн хувьд хамгийн их байна. Хэвийн ойн өтгөрлийг 1,0 гэж аваад түүнтэй нэг төрлийн ижил нас, бонитеттэй бусад ойн нөөцийг жишиж 0,3- 1.0 хүртэл коэффициентээр илэрхийлдэг. Аймгийн байгалийн ойн ихэнх нөөцийг 0.5-0.6

өтгөрөлтэй ой эзэлж байгаа нь нас гүйцсэн, өтөлсөн ой зонхилж байгааг харуулж байна.

Хүснэгт 16. Байгалийн ойн өтгөрөл, талбайгаар, га

Модны төрөл	Өтгөрөл, талбайгаар /га/							Нийт талбай, га	Дундаж өтгөрөл
	0,3	0,4	0,5	0,6	0,7	0,8	0,9		
<b>Цармын бүслүүрийн ой</b>									
Шинэс	889	1454	1634	157	-	-	-	4134	0.42
Дүн	889	1454	1634	157	-	-	-	4134	0.42
<b>Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн ой</b>									
Шинэс	239	1594	2051	1104	-	-	-	4988	0.48
Дүн	239	1594	2051	1104	-	-	-	4988	0.48
<b>Байгалийн цогцолборт газрын ой</b>									
Шинэс	3743	4039	24316	9107	-	-	-	41205	0.49
Хуш	-	-	1458	-	-	-	-	1458	0.50
Бургас	80	88	59	-	-	-	-	227	0.39
Дүн	3823	4127	25833	9107	-	-	-	42890	0.49
<b>Ногоон бүсийн ой</b>									
Шинэс	4005	6906	28953	27767	1246	-	-	68877	0.52
Бургас	35	32	74	-	-	-	-	141	0.42
Дүн	4040	6938	29027	27767	1246	-	-	69018	0.52
<b>Хориотой зурвасын ой</b>									
Шинэс	1705	7714	25348	17968	782	-	-	53517	0.51
Хуш	-	-	-	477	-	-	-	617	0.56
Гацуур	233	1003	1307	1076	-	-	-	3619	0.48
Хус	-	-	181	-	-	-	-	181	0.50
Улиас	-	-	-	-	-	-	-	260	0.40
Бургас	1916	3453	3127	417	-	-	-	8913	0.42
Дүн	3854	12532	30001	19938	782	-	-	67107	0.50
<b>Хамгаалалтын бүсийн ой 100 га хүртэлх ой сөөг ширэнгэ уулын өвөр энгэр төгөл ой</b>									
Шинэс	1939	5704	22870	25374	650	-	-	56537	0.53
Хус	-	-	-	-	-	-	-	18	0.60
Бургас	-	-	-	-	-	-	-	117	0.40
Дүн	1939	5818	22873	25392	650	-	-	56672	0.53
<b>Хамгаалалтын бүсийн ой 30 хэмээс дээш Налуу газрын ой</b>									
Шинэс	2714	9362	20898	11957	1047	-	-	45978	0.49
Гацуур	20	48	-	-	-	-	-	156	0.50
Бургас	-	-	-	-	-	-	-	147	0.41
Дүн	2734	9534	20921	12045	1047	-	-	46281	0.49
<b>Улсын хилийн дагуух ой</b>									
Шинэс	2819	5962	15837	6284	-	-	-	30902	0.48
Гацуур	71	-	-	-	-	-	-	302	0.45
Бургас	-	-	-	38	-	-	-	38	0.60
Дүн	2890	5962	16068	6322	-	-	-	31242	0.48
<b>Ашиглалтын бүсийн ой</b>									
Шинэс	8886	19530	69627	35163	426	-	-	133632	0.49
Гацуур	-	250	475	-	-	-	-	725	0.46
Улиангар	-	-	12	-	-	-	-	12	0.50
Бургас	-	13	27	-	-	-	-	40	0.46
Дүн	8886	19793	70141	35163	426	-	-	134409	0.49
<b>Нийт дүн</b>	<b>29294</b>	<b>67752</b>	<b>218549</b>	<b>136995</b>	<b>4151</b>	-	-	<b>456741</b>	<b>0.50</b>

## 2.7 ЗАВХАН АЙМГИЙН ТҮҮХИЙН ДУРСГАЛТ ӨВ СОЁЛ


Түүх соёлын дурсгал гэдэг нь хөдөө хээр, байгаль дээр л задгай орших хүний гараар бүтээгдэн бий болсон эртний булш, бунхан, хиргисүүр, хөшөө чулуу, хадны сүг

зураг, сүм хийдийн туурь гэх мэт дурсгалыг хэлэх бөгөөд Завхан аймгийн хэмжээнд 725 түүх соёлын дурсгал байгаагаас 314 нь Неолитын үеийн болон Монгол, Пазырык, Хүннү, Түрэгийн үеийн булш, хиргэсүүрүүд, 171 нь буган, хүн чулуу хөшөө, 93 нь Түрэг, Төвд, Монгол, Манж тамга тэмдэгийн бичгийн дурсгал, сийлмэл, зос, бэхэн зургууд, 88 нь тахилын онгон, 25 нь тахилын овоо, 23 нь хуучны сүм хийдийн туурь, 4 нь хуучин нэгдлийн ул мөр бүхий газар, 3 нь эртний хотын туурь, 3 нь түүхэн дурсгалт байшин, хэрмэн зам, 1 агуй оромж тус тус эзэлж байна.

Хүснэгт 16. Завхан аймгийн түүх соёлын дурсгалт өв

№	Сумын нэр	Хадны зураг, бичгийн дурсгал	Хиргисүүр, булш оршуулгын дурсгал	Тахилын онгон	Тахилын овоо	Суурьшлын ул мөр бүхий газар	Эртний хотын туурь	Сүм хийдийн туурь	Агуй, оромж	Түүхэн дурсгалт байшин, хэрмэн зам	Хөшөө дурсгал
1	Улиастай	1	3				1				3
2	Алдархаан	7	24	8	1			1		2	13
3	Асгат	3	3								
4	Баянтэс	2	12	4				2			3
5	Баянхайрхан	9	15	11	2			1		1	11
6	Дөрвөлжин	9	7	8	2	1					9
7	Завханмандал	3	5								3
8	Идэр	2	4	3	2			2			3
9	Их-Уул	2	10	1				2			6
10	Нөмрөг	2	10	8	1			1			8
11	Отгон	2	30	7	1						8
12	Сантмаргац	2	3	3							2
13	Сонгино	4	6	5	1		1	1			9
14	Тосонцэнгэл	4	12	3	2			4			1
15	Түдэвтэй	3	25	4	2			1			8
16	Тэлмэн	1	9	1		1		2			7
17	Тэс	10	23	2	2		1	2	1		4
18	Ургамал	10	11	1							3
19	Цагаанхайрхан	1	18			1		1			6
20	Цагаанчулуут	8	15	7							17
21	Цэцэн-Уул		11	2				1			7
22	Шилүүстэй	5	24	2	7			2			17
23	Эрдэнэхайрхан	2	21	4							5
24	Яруу	1	13	4	2	1					18
<b>Аймгийн нийт</b>		<b>93</b>	<b>314</b>	<b>88</b>	<b>25</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>23</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>171</b>

Одоогийн байдлаар Соёлын өвийн улсын нэдсэн бүртгэлийн мэдээллийн санд аймгийн хэмжээнд 6 түүх соёлын дурсгалыг улсын хамгаалалтанд, 5 түүх соёлын дурсгалыг аймгийн хамгаалалтанд авсан байна.



Зураг 23. Завхан аймгийн түүх, соёлын дурсгалт өвийн зураг

Хүснэгт 17. Хамгаалалтанд авсан түүх соёлын дурсгалт өв

№	Сумын нэр	Түүх соёлын дурсгал	Төрөл	Онцлог
<b>Улсын хамгаалалтанд авсан түүх соёлын дурсгал</b>				
1	Алдархаан	Богдын гол баг Мөнгөт хясааны хөшөө	Гэрэлт хөшөө	уг дурсгал нь хүрэл түргийн үед хамаарах бөгөөд хөшөөн дээр түргийн үеийн дээл хувцасны загварыг илтгэх 4 хүний дээлтэй зураг зурсан байдаг. хөшөөг босгох нь хүрлийн үед босгосон бололтой. ойролцоо хөшөөний бэлдэцүүд байдаг.
2	Баянтэс	Зайгал баг Хөх хошууны боомын булш	Хиргисүүр	Дугуй хүрээтэй хиргисүүр ухагдсан. хойноо 3 ш булштай. хүрээн дотроо тахилын байгууламжтай.
3	Цэцэн-Уул	Цэцэн Уул сум Янживын шилийн хүн чулуун хөшөө	Хүн чулуун хөшөө	37Баруун талаас 1-р хүн чулуу тахилын байгууламжинд унасан. Ойролцоо 10 ш хиргисүүртэй.
4	Шилүүстэй	Баян улаан баг Өвөр цэцэрлэгийн Дааган дэл	Буган чулуун хөшөө	8-н ширхэг буган чулуун хөшөөтэй . 2-буган чулуу нт унасан
5	Яруу	Тэмээн сүүлийн голын хүн чулуун хөшөө	Хүн чулуун хөшөө	цагаан өнгийн боржин чулуугаар хүний түрс гарган хийсэн түргийн үеийн хүн чулуун хөшөө. Ардаа дагуул тахилын байгууламжтай
6	Яруу	Бумбатын адгийн хүн чулуун хөшөөд	Хүн чулуун хөшөө	улаан өнгийн боржин чулуугаар хүний дүрс гарган сийлж хийсэн.
<b>Аймгийн хамгаалалтанд авсан түүх соёлын дурсгал</b>				

1	Дөрвөлжин	Баян-Айрагийн хадны зураг	Хадны зураг	Цогт багийн Баян-Айргийн хадны зураг нь баянайраг компанийн эзэмшил газарт харъяалагддаг.
2	Тэлмэн	Шургахын амны Буган чулуун хөшөөний цогцолбор	Буган чулуун хөшөө	Өгөөмөр багийн урд талын улаан үзүүрт 2013 онд малтлага хийсэн уг дурсгал юм. буган чулуун хөшөөний цогцолборт газар юм.
3	Улиастай	Жаргалант баг Сангийн хэрэмийн туурь	Эртний хотын туурь	Манж чин улсын үед бүтээн байгуулагдсан. манжийн сайдын газар
4	Эрдэнэхайрхан	Алтан баг Бага хөлийн хадны зураг	Хадны зураг	10 Буга, янгир, чоно зэрэг амьтдыг хаданд сийлэн дүрсэлсэн. уулын арын нуруунд 1 ш булштай. айлын өвөлжөөний чулуун хорооны арын хаданд төвд маанийн үсэгтэй.
5	Эрдэнэхайрхан	Мөсөн баг Гүнгийн ар үзүүрийн хүн чулуун хөшөө	Хүн чулуун хөшөө	Хүн чулуу нь хөх, саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. цагаан саарал өнгийн боржин чулуугаар хийсэн хүн чулуу. Хүн чулууны арын тахилын онгоныг ухаж тоносон.

## 2.8 ЗАВХАН АЙМГИЙН ГЕОЛОГИЙН СУУРЬ СУДАЛГАА

### 2.8.1 Инженер геологийн нөхцөл

Монгол орны нутаг дэвсгэр нь Сибирь, Хойд хятадын тэгш өндөрлөгийн завсарт тогтсон бөгөөд олон хэв шинжтэй янз бүрийн насны хурдас чулуулаг бүхий цогцолбор бүтэц юм. Монгол орны инженер геологийн бүс нутгийг задалж үзвэл:

1. Хойт Монголын
2. Төв Монголын
3. Өмнөговийн
4. Хангай, Хэнтийн
5. Өмнөд Монголын
6. Монгол Алтайн атираат уулсын
7. Дорнодын тэгш өндөрлөг, талархаг бүс бүхий нутгууд гэж ангилж болно. (Д.Дашжамц)

Эдгээрийг хурдас чулуулгуудаар тус бүрд нь геологийн формаци, фазид ангилан хувааж инженер геологийн их муж, муж, дэд муж, хэсгүүд болгон нарийвчилж боловсруулдаг байна. Газрын гадаргад үүсэх инженер-геологийн хүчин зүйлс, байгалийн байдал геологийн бүтцийг бүрэн тодорхойлно.

Инженер геологийн мужлалт бол газрын царцдас давхаргын бүтэц, геологийн хөгжлийн динамик нөхцөлүүдийн зүй тогтлыг харгалзан өөр хоорондоо ялгаатай хэсгүүдэд хуваах явдал бөгөөд энэ зарчмаар монгол орны инженер геологийн картыг 1988 онд доктор Н.Тогтохын удирдлагаар боловсруулж гаргажээ.

Монгол орныг инженер-геологийн талаар мужлахад Их муж, муж, бүс, дэд бүс, хэсэг гэсэн 5 шаттай муж хэсгүүдэд хуваана.

Хүснэгт 17. Завхан аймгийн инженер-геологийн мужуудын тодорхойлолт

№	Их муж	Муж	Инженер-геологийн тодорхойлолт
1	Их нуурын хотгорын	Хар нуурын	Эртний төрмөлийн дунд үеийн атираашил голлосон шинэ төрмөлийн тунамал хурдас, дөрөвдөгч галавын нуурын, салхины болон хормойн хурдас голлон тархсан.






-Элс	16,8%	35,8%	24,1%
-Тоос	4,8%	8,7%	6,6%
-Шавар	2,7%	5,6%	4,2%

Хүснэгт 20. Ул хөрсний физик механик шинж чанарын үзүүлэлтүүд

№	Физик үзүүлэлтүүд	Индекс	Хөрсний нэр, төрөл	
			Элсэн чигжээстэй сайрга, хайрга	Элсэнцэр чигжээстэй хайрга, сайрга
1	Байгалийн чийг, нэгжээр	W	0.045	0.040
2	Урсалтын хязгаар, нэгжээр	W <sub>L</sub>	-	0,197
3	Имрэгдэлийн хязгаар, нэгжээр	W <sub>P</sub>	-	0,144
4	Уян налархайн тоо, нэгжээр	J <sub>P</sub>	-	0,053
5	Эрдэсийн нягт буюу хувийн жин, г/см <sup>3</sup>	P <sub>S</sub>	2.67	2.68
6	Хөрсний нягт буюу эзэлхүүн жин, г/см <sup>3</sup>	P	2,29	2.25
7	Хатуу хэсгийн нягт буюу хэмхэдэсийн эзэлхүүн жин г/см <sup>3</sup>	P <sub>d</sub>	2,19	2,16
8	Сүвшил %	n	18,07	19,41
9	Сүвшлийн коэффициент, нэгжээр	e	0.221	0.241
10	Чийглэгийн зэрэг, нэгжээр	S <sub>r</sub>	0.55	0.44
11	Консистенц, нэгжээр	J <sub>L</sub>	-	<0

Хүснэгт 21. Хөрсний үеийн механик шинж чанарын үзүүлэлтүүд

№	Механик үзүүлэлтүүд	Индекс	Хөрсний нэр, төрөл	
			Элсэн чигжээстэй сайрга, хайрга	Элсэнцэр чигжээстэй хайрга, сайрга
1	Зууралдлын хүч, КПа(кгх/см <sup>2</sup> )	C	2(0.02)	16(0.16)
2	Дотоод үрэлтийн өнцөг, град	φ	40	44
3	Хэв гажилты, модул, МПа(кгх/см <sup>2</sup> )	E	45(450)	45(450)



Зураг 25. Завхан аймгийн геологийн зураг

## 2.8.2 Цэвдэг, түүний тархалт

Дэлхийн 48 улс орны газар нутагт ямаг нэгэн хэмжээгээр цэвдэг орших бөгөөд нийт цэвдэгт бүс нутгийн 95 орчим хувь нь 5 улсын газар нутагт ноогддог. Үүнд: ОХУ, Канад, Хятад, АНУ зэрэг улсуудын дараа Монгол орон цэвдгийн тархалтаараа тавдугаарт ордог байна.

Монгол орны цэвдгийн тархалт Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсад цэвдэг нь төвлөрсөн байхаас гадна Монгол орны хойд бүс нутагт илүү тархалттай.

Хүснэгт 22. Цэвдэгийн тархалтаараа дэлхийд Монгол улсын эзлэх байр

Дэлхийн бөмбөрцгийн хойд хагас	Талбай, (сая км <sup>2</sup> )	Дэлхийн бөмбөрцөгийн өмнөд хагас	Талбай, (сая км <sup>2</sup> )
ОХУ	11,0	Антрактид тив	13,5
Канад улс	5,7		
Хятад улс	2,1		
Аляск муж (АНУ)	1,5		
Монгол	0,8 (Brown) 0,98 (Гравис) 0,46 (Жамбалжав)		
Гренландын арал	1,6		
<b>Нийт</b>	<b>22,7</b>		<b>13,5</b>
<b>Дэлхийн бөмбөрцөгийн нийт цэвдэгтэй талбай</b>			<b>36,2</b>
<b>Дэлхийн бөмбөрцөгийн хуурай газрын талбай</b>			<b>149,0</b>
<b>Дэлхийн бөмбөрцөгийн хуурай газарт цэвдэгийн эзлэх хувь</b>			<b>24,0%</b>

Эх сурвалж: Монгол орны байгаль орчин I боть, 2017 он


Тухайн үеийн нэрээр ЗХУ-БНМАУ-ын Геологийн хамтарсан экспедицийн Геокриологийн отрядын 1968-1971 оны хооронд хийсэн судалгааны ажлын нэг гол үр дүн нь Монгол орны цэвдгийн тархалтын 1:1500 000 масштабтай геокриологийн зураг юм.

Монгол орныг цэвдгийн тархалтаар нь үргэлжилсэн, тасалданги, алаг цоог, ховор алаг цоог, тохиолдлын, өнжмөл, улирлын хөлдөлтийн бүс гэж ангилсан байдаг. Цэвдгийн тархалтын онцлог болон ландшафт, физик газарзүйн мужлалд үндэслэн (Цэгмид, 1969, Даш, 2010) Монгол орныг цэвдэгт бүс нутгуудыг Хөвсгөлийн, Хэнтийн, Хангайн, Монгол алтайн, Говь-Алтайн Хянганы уулархаг цэвдэгт бүс болгон 6 ангилжээ.

Засаг захиргааны нэгж	Аймгийн нутаг дэвсгэр, км <sup>2</sup>	Цэвдэгт бүслүүрийн талбай, км <sup>2</sup>	Аймгийн нутагт эзлэх цэвдэгт бүслүүрийн хувь, %	Цэвдэгт бүслүүрийн нутагт эзлэх талбайн хэмжээ, %
Завхан	83315,0	52888	63,5	11,4

Завхан аймаг нь Хангайн уулархаг бүс нутгийн цэвдгийн тархалтын бүсэд хамрагдах бөгөөд энэхүү бүс нь бусад бүс нутгуудаас хамгийн их талбайг эзэлдэг. Хангайн нол нуруу баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон, салбар Булнай, Тарвагатайн нурууд өргөргийн чиглэлтэй буюу гол нуруутай бараг перпендикуляр байрлалаар тогтсон ажээ. Хангайн төв нурууны хяр нуруу нь ихэвчлэн хавтгай буюу бөмбөгөрдүү хэлбэртэй, зарим газарт өргөн талбай байдгаас үзвэл түүнийг эртний тэгш өндөрлөгийн үлдэгдэл гэж үзэж болохоор байна. Хангайн уулархаг мужид цэвдгийн 25 мониторингийн цэг байдгаас Завхан аймагт 2 цооногт температурын байнгын хэмжилт хийдэг байна. Завхан аймгийн Нөмрөг сумын төвийн цооногийн 10 метрийн гүний температур нь 1981 онд -0,75°C, 2009 онд -0,39°C, 2010 онд -0,39°C,

2011 онд  $-0,39^{\circ}\text{C}$ , 2012 онд  $-0,39^{\circ}\text{C}$ , 2013 онд  $-0,39^{\circ}\text{C}$ , 2014 онд  $-0,39^{\circ}\text{C}$ , 2015 онд  $-0,39^{\circ}\text{C}$ , 2016 онд  $-0,36^{\circ}\text{C}$  болж нэмэгдсэн байна.



Диаграмм 9. Нөмрөг сумын цэвдгийн мониторинг, өөрчлөлт

Хойд талын буюу Нөмрөг, Тэлмэн, Түдэвтэй, Тэс, Тосонцэнгэл зэрэг сумын нутаг дэвсгэрт цэвдэг хөрс алаг цоог болон үргэлжлэн тархсан. Цэвдэг хөрс 2,1-3,0м гүнээс илрэх ба зузаан 10-50м үелэг, торлог текстүртэй, мөлжилт ихтэй тул их хэмжээний суулт үүсгэнэ

Агаарын температурын хамгийн бага утга хасах хэм рүү шилжих үед газар дээрээсээ хөлддөг. Хасах температуртай хугацаа тогтвортой үргэлжлэхийн хэрээр газрын хөлдөлтийн гүн нэмэгддэг ба улирлаар үргэлжлэх тохиолдолд улирлын хөлдөлт болдог. Улирлаар гэсдэг давхаргыг идэвхитэй давхарга гэнэ. Улирлын хөлдөлт, гэсэлтийн гол шалгуур үзүүлэлт нь түүний хөлдөлт гэсэлтийн зузаан болно.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулааралтай холбоотойгоор улирлын гэсэлтийн гүн нэмэгдэх, ялангуяа цэвдэгт бүс нутгийн өмнөд захаар зундаа гэссэн хэмжээндээ өвөлдөө хүрч хөлддөггүй нь ажиглагдах болжээ. Өөрөөр хэлбэл Монгол орны цэвдэгт бүс нутгийн өмнөд захаар гэсгэлүүн үе илрэх үзэгдэл ажиглагдаж байна. (Жамбалжав нар 2013).

Газарзүйн байршил, өндөр, зүг зовхис, хөрсний бүтэц, ус чийгийн хэмжээ зэргээс хамаарч Монгол орны хэмжээнд улирлын хөлдөлт, гэсэлтийн зузаан 1-6 м хүрнэ. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулааралтай холбоотойгоор улирлын гэсэлтийн зузаан 8 м хүрсэн нь хэмжилтээр тогтоогдсон байна (Жамбалжав нар 2013 он).

2001 онд доктор Д.Төмөрбаатар, Я.Жамбалжав, Д.Ундармаа нар Монгол орны төв суурин газруудын улирлын хөлдөлт гэсэлтийн гүнийг Кудрявцевын тэгшитгэл ашиглан тодорхойлж Монгол орны улирлын хөлдөлт, гэсэлтийн зураг зохиосон байна.

Д.Төмөрбаатарын 2001 онд тооцсоноор Завхан аймгийн улирлын хөлдөлт гэсэлтийн норматив гүнийг утгыг оруулав.

Хүснэгт 18. Завхан аймгийн ул хөрсний улирлын гэсэлтийн норматив гүн (м)

№	Сумын нэр	Шавар, шавранцар	Элсэнцэр	Элс	Элсэн дүүргэвчтэй хайрга
1	Их-Уул	2,2	2,8	3,3	3,7

2	Нөмрөг	2,5	2,8	3,0	3,5
3	Сонгино	2,8	3,0	3,3	3,6
4	Түдэвтэй	2,5	2,8	3,0	3,5
5	Тэлмэн	2,9	3,1	3,4	3,7
6	Тэс	2,5	2,8	3,0	3,5
7	Тосонцэнгэл	2,2	2,8	3,3	3,7

Хүснэгт 19. Завхан аймгийн улирлын хөлдөлтийн норматив гүн (м)

№	Сумын нэр	Шавар, шавранцар	Элсэнцэр	Элс	Элсэн дүүргэвчтэй хайрга
1	Улиастай	3	3,5	4	4,5
2	Алдархаан	3	3,5	4	4,5
3	Баянтэс	3	3,4	4	4,5
4	Баянхайрхан	3	3,5	4	4,5
5	Завханмандал	2,7	2,9	3,2	3,8
6	Идэр	3	3,5	4	4,5
7	Отгон	3,6	3,5	4	4,5
8	Сантмаргац	2,7	2,9	3,2	3,8
9	Ургамал	2,7	2,9	3,2	3,8
10	Цагаанхайрхан	3	3,5	4	4,5
11	Цагаанчулуут	2,8	3,2	3,6	4,3
12	Цэцэн-Уул	2,8	3,2	3,6	4,3
13	Шилүүстэй	2,8	3,2	3,6	4,3
14	Эрдэнэхайрхан	2,7	2,9	3,2	3,8
15	Яруу	3	3,5	4	4,6
16	Дөрвөлжин	2,7	2,9	3,2	3,8


### 2.8.3 Геотехникийн нөхцөл

Монгол орны нутаг дэвсгэр байгаль, цаг уурын хувьд өндөр уулын, хээрийн, говь-цөлийн гэсэн үндсэн 3 бүсэд хуваагдах боловч автозам ба дэд бүтэцийн барилгын ажлын төлөвлөлтөд бүс тус бүрийг дэд хэсгүүдтэй авч үзэх шаардлагатай. Энэ нь Монгол орон эх газрын эрс тэс уур амьсгалтайгаас гадна нутаг дэвсгэрийн хэмжээнд инженер-геологийн хувьд нэн тааламжгүй хөрс багагүй тохиолдож байдаг бөгөөд эдгээр нь дэд бүсийн хэмжээнд нилээд ялгаатай байдаг оршиж байна. Энэхүү онцлог нөхцөл байдлыг авто зам барих төсөлд тусгаж иж бүрэн төлөвлөхгүйгээр замын далан, суурийн найдвартай ажиллагааг хангаж, удаан хугацаанд ашиглах боломжгүй.

Уур амьсгал-геотехникийн I бүсэд Монгол орны нутаг дэвсгэрт ялангуяа Хангайн уулсын хэсэгт олон жилийн цэвдэг үргэлжилсэн хэлбэртэй, цэвдгийн зузаан нь 120-150 метр байдаг бол Алтайн уулсын хэсэгт ховор алаг цоог, цэвдгийн зузаан 15-50 метр хүртэл байна.

Уур амьсгал-геотехникийн II бүсийг бүхэлд нь хээрийн бүс гэх боловч ойт хээрийн, тал хээрийн хэсэгт харьяалагдаж байна. Энд ойт хээрийн хэсэгт алаг цоог хэлбэрийн цэвдэг чулуулаг агуулсан улирлын гэсэлттэй болон хөлдөлттэй шаварлаг хурдас элбэг тархдаг бол тал хээрийн хэсэгт ховор алаг хэлбэрийн цэвдэг чулуулагтай улирлын хөлдөлттэй том хэмхдэст агуулга ихтэй хөрстэй. Хөрс нь улирлын гэсэлт болон гүн хөлдөлттэй үедээ овойдог.

Уур амьсгал геотехникийн III бүсэд цөлжүү хээр болон заримдаг цөлийн уур амьсгалтай завсрын хэсэг нь хуурай дулаан зун, намартай, хахирлаг хүйтэн өвөлтэй инженер-геологийн нөхцөлийн хувьд сайрга агуулсан чийг багатай, улирлын хөлдөлтийн гүн харьцангуй их (хөлдөлтийн гүн 2,2-2,3 м) хөрстэй байдаг.



Зураг 26. Монгол орны геотехникийн нөхцөлийн карт

Эх сурвалж: Монгол орны геотехникийн нөхцөл, 2009

Завхан аймгийн Нөмрөг, Тосонцэнгэл, Сонгино сумдуудад олон жилийн цэвдэг хөрсний гэсэлтийн үеийн жигд бус суултаас болж нэлээд барилга эвдэрсэн мэдээлэл байдаг. Монгол орны нутаг өвлийн улиралд бүхэлдээ хөлдөж зун гэсч байдаг боловч улирлын хөлдөлтийн гүн харьцангуй их учир улирлын хөлдөлтөлд өртдөг овойлтгүй хөрсийг барилгын буурт оруулснаас болж барилга эвдрэх шалтгаануудын нэг болж байсан байна.

Хүснэгт 20. Завхан аймгийн уур амьсгал, газарзүйн бүсүүдийн геотехникийн нөхцөлийн ерөнхий тодорхойлолт

Уур амьсгал, газар зүйн бүс	Геотехникийн нөхцөлд харгалзах дэд бүсүүдийн тгөвч тодорхойлолт	Бүсүүдэд харгалзах геотехникийн зонхилох нөхцөл
I. Өндөр уулын бүс	IA. Хангайн, Хөвсгөл, Хан Хэнтий өндөр уулын хэсэгт уур амьсгалын хүйтэн-чийглэг урт өвөлтэй, чийглэг сэрүүн богинохон зунтай хахир уур амьсгалтай.	-Олон жилийн цэвдэг чулуулаг тархмал, цэвдгийн зузаан гол төлөв 15-50 метрт хүрнэ. Улирлын гэсэлттэй. Газар хөдлөл 6-9 балл. -Олон жилийн цэвдэг чулуулаг үргэлжилсэн хэлбэрээр тархдаг, цэвдгийн зузаан гол төлөв 120-150 метрт хүрнэ. Цэвдэг чулуулаг нь 3,0 С хүртэл температуртай тул нилээд тогтвортой тооцогдоно. Ийм хурдас чулуулаг геотехникийн уур амьсгалын улирлын гэсэлттэй. Хур бороо, аянга аадар Цахилгааны эрчимтэй. Газар хөдлөл 6-9 балл.
II. Ойт хээр ба хээрийн бүс	IIA. Хангайн уул, тайга ба Орхон-Сэлэнгийн ойт хээрийн хэсэгт уур амьсгалын чийглэгдүү-сэрүүн, нэн хүйтэн, хахир уур амьсгалтай. IIB. Бэсрэг уулт хээр, хээр талын хэсэгтээ уур амьсгалын хуурай-хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр хүйтэн хахирлаг уур	-Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог болон ховор алаг тархсан, улирлын хөлдөлт-гэсэлттэй, хүйт-ний овойлттой болон суумтгай лёсс маягийн хурдас элбэг тархсан; -Ойт хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, салхитай, хахир хүйтэн жаварлаг. Хөрс чулуулаг гүн хөлддөг; Тал хээрийн хэсэг нь улирлын гүн хөлдөлттэй овойлт болон

	амьсгалтай.	суулт үүсгэнэ. Өвөл цас нимгэн, хахир; -Газар хөдлөл 6-7 балл.
III. Говь, цөлийн бүс	IIIА. Говийн цөлжүү хээр, заримдаг цөлийн хэсэгтээ уур амьсгалын хуурай дулаан зун, хүйтэн хүйтэвтэр хахирлаг өвөлтэй дэд бүс. IIIВ. Цөлийн хэсэгтээ уур амьсгалын нэн хуурай дулаан-халуун хүйтэн хүйтэвтэр, хахирлаг.	-Олон жилийн цэвдэггүй. Хөрөний улирлын хөлдөлтийн гүн харьцангуй их, 2,2-3,2 м., хөөлттэй болон суулттай хурдас элбэг тархсан; -улирлын хөлдөлтийн гүн харьцангуй бага 1,8-2,2 м., хөөлттэй хатуу шаварлаг хурдас элбэг тархсан. Хүчтэй салхи-шороон шуургатай, халуун бүгчим, хуурай онцлогтой; -Газар хөдлөл 6-7 балл.

Завхан аймгийн бас нэг онцлог нь олон жилийн цэвдэг хөрс өргөн тархсан байдагтай холбогдож цэвдгийн үйл явц, үзэгдэл бусад бүс нутгаас илүү идэвхитэй хөгжсөн байдаг. Яруу, Баянтэс сумын нутагт 9 газар илэрч байгаа бол хөрсний гулсалт Завханы Тосонцэнгэл сумын нутагт 2 удаа болж байсныг судлаачид тэмдэглэсэн байна.

Хот төлөвлөх, барилга байгууламж инженерийн нэгдсэн шугам сүлжээ төлөвлөх, барьж байгуулахад хүндрэл учруулах ажлын өртөг зардлыг их хэмжээгээр нэмэгдүүлэх геотехникийн хүндрэлтэй нөхцөлд оршиж буй баруун бүсийн сум суурингуудын жагсаалтыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 21. Геотехникийн хүндрэлтэй нөхцөлд орших суурин газруудын жагсаалт

№	Сумдын нэр	Геотехникийн онцлог нөхцөл
1	Баянхайрхан	<ul style="list-style-type: none"> <li>Ундны усны нөөц тогтоогдоогүй</li> <li>Олон жилийн цэвдэг хөрс газрын гадаргуугаас 3,0 метрийн гүнээс эхэлдэг. Уг хөрс нь мөсжилт ихтэй тул барилга, байгууламж барих ашиглахад бэрхшээлтэй.</li> <li>Газар хөдлөлийн 8 баллын бүсэд оршдог.</li> </ul>
2	Тэлмэн	<ul style="list-style-type: none"> <li>Усны нөөц тогтоогдоогүй</li> <li>Олон жилийн цэвдэг хөрс 2,1-4,9 м-ээс эхэлж 10-11 метрийн зузаантай тохиолдоно. Мөн цэвдэг хөрсний дээр устай тул барилга байгууламж инженерийн нэгдсэн шугам сүлжээ барих асуудал ихээхэн хүндрэлтэй</li> </ul>
3	Отгон	<ul style="list-style-type: none"> <li>Ундны усны эх үүсвэр тогтоогдоогүй</li> <li>Олон жилийн цэвдэг хөрс 2,8-3,0 метрийн гүнээс илэрдэг. Цэвдэг хөрс мөсжилт ихтэй зарим газартаа 1.0-1.5 см-ийн зузаантай цэвэр мөсний үеүд илэрдэг тул хөрсний суулт их хэмжээгээр үүсдэг.</li> <li>Газар хөдлөлийн 8 баллын бүсэд оршдог</li> </ul>
4	Асгат	<ul style="list-style-type: none"> <li>Ундны усны эх үүсвэр тогтоогдоогүй</li> <li>Олон жилийн цэвдэг хөрс тархсан</li> </ul>

**Улиастайн элс, хайрганы орд:** Улиастай хотоос баруун тийш 6-км т Богдын голын хөндийд оршино. Эрэл хайгуулын ажлыг 1972 онд Л.Борис хийжээ. Богдын голын хөндийн баруун талд өргөрөгийн дагуу сунасан 1800x500 м талбайг эзэлнэ. Дөрөвдөгчийн настай, голын гаралтай, давхарга маягын тогтоцтой, давхаргын зузаан 1,4-2,5 м дунджаар 1,5 метр, шаварлаг элсэнцэрийн 0,1-1,4 м зузаантай үеэр хучигдсан байна. Элс хайрганы холимог нь шаравтар саарал өнгөтэй, элс 34,76%,


хайрга 54,7%, бул чулуу 10,54%-ийг эзэлнэ. Элсний эрдсийн найрлаганд кварц 34%, хээрийн жонш 63% хүртэл, гялтгануур тэмдэгтээс 0,05% амфибол-эпидот 0,1-2,3%, магнетит, ильменит ховроор пироксен, турмалин, флюорит, рутил, анатаз, гранат агуулагдана. Хайрга нь голдуу том ширхэгт ягаан боржин-71%, бялхмал чулуулаг-20%, цахиурлаг чулуулаг -5,6%, жижиг ширхэгт биотитот боржингоос 3,5% тогтоно. Элсний химийн найрлага (%):  $\text{SiO}_2$  69.03-70.54,  $\text{Al}_2\text{O}_3$  10.36-14.54,  $\text{Fe}_2\text{O}_3$  2.69-2.89,  $\text{TiO}_2$  0.35-0.45,  $\text{SO}_3$  0.01-0.02. Лаборатори-технологийн туршилтаар “200” маркийн хүнд бетонон эдэлхүүн үйлдвэрлэх боломжийг тогтоосон байна. Нөөц  $\text{A+B+C}_1$  зэргээр 1152 мян.м<sup>3</sup> гэж тогтоогджээ. (эх сурв. П.Шаандар “Барилгын материалын эрдэслэг түүхий эдийн ордын геологийн судалгаа. 2014

#### 2.8.4 Газар хөдлөл

Дэлхийд өнөөдрийн байдлаар 4 төрлийн баллын шаталбарыг хэрэглэж байгаа бөгөөд Монгол орны хувьд Зүүн Европын улс орнуудад ашиглагдаж буй шаталбар болох MSK-64 /Medvedev, Sponheuer and kamik/ буюу 12 баллын шаталбарт оруулж газар хөдлөлтийн баллын үнэлгээг өгдөг байна.


Газар хөдлөлт нь газрын давхарга чичирхийлэх хөдөлгөөн юм. Энэ нь дэлхий дотоод энергийн нөлөөгөөр газрын давхаргад тэлэх, агших үзэгдэл явагдаж уулын чулуулаг асар хүчтэй хүчдэлд автах үзэгдэл юм. Газар хөдлөлт анх эхэлсэн газрын гүн дэх хэсгийг голомт буюу төв гэнэ.

Аливаа улс оронд тохиолдож болох, мөн тохиолдож байсан байгалийн гамшигт үзэгдлүүдээс хаана, хэзээ болох нь тогтоогдоогүй ахар богино хугацаанд хүн төрөлхтөнд ноцтой аюул гамшиг учруулдаг үзэгдэл бол газар хөдлөлт байдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрдөг. Газар хөдлөлийн 7-оос дээш баллын бүсэд Завхан аймгийн бүх сумд суурьшиж байна. Завхан аймгийн 22 сумын 2 сум нь 7 баллын бүсэд, 9 сум нь 8 баллын бүсэд, 10 сум 9 баллын бүсэд хамаарагдаж байна.



Диаграмм 10. Завхан аймгийн газар чичирхийлэл, баллаар





Зураг 27. Монгол орны газар чичирхийллийн зураг

Эх сурвалж: Монгол орны геотехникийн нөхцөл, 2009

Завхан аймгийн хот суурин газруудын газар хөдлөлтийн дэвсгэр баллыг дараах хүснэгтэд заасан байдлаар тооцож болно.

Хүснэгт 23. Завхан аймгийн газар чичирхийллийн хэмжээ

№	Сумдын нэр	Газар хөдлөлийн хүч /балл/	№	Сумдын нэр	Газар хөдлөлийн хүч /балл/
1	Алдархаан	7	12	Түдэвтэй	9
2	Баянтэс	8	13	Цэцэн-Уул	9
3	Эрдэнхайрхан	9	14	Тэлмэн	9
4	Баянхайрхан	9	15	Сантмаргац	9
5	Шилүүстэй	8	16	Нөмрөг	9
6	Их Уул	9	17	Ургамал	8
7	Дөрвөлжин	8	18	Сонгино	9
8	Отгон	8	19	Цагаанчулуут	7
9	Идэр	8	20	Яруу	8
10	Тэс	8	21	Булнай	9
11	Завханмандал	8	22	Цагаанхайрхан	9

## 2.8.5 Гүний ус /гидрогеологи/


Газрын доорх ус нь Монгол орны хамгийн чухал усны эх үүсвэр юм. Нийгэм эдийн бүхий л салбаруудын үйл ажиллагаа газрын доорх усны нөөц, түүний боломжоос шууд хамаардаг. Гадаргын ус байхгүй газруудад малчид худгаас усаа авч ашигладаг, мөн газар тариалангын усалгаанд уул уурхай болон үйлдвэрүүд нь үйл ажиллагаандаа газрын доорх усыг өргөнөөр ашиглаж байна. Газрын доорх ус чанарын хувьд ч ундны усны баталгаатай эх үүсвэр болдог.

Монгол орны гидрогеологийн системээр Завхан аймаг нь Хойт буюу грунтын усны ай савын гидрогеологийн систем болон Баруун буюу грунт, даралтат ус хосолсон ай савын гидрогеологийн системд оршиж байна.

Хүснэгт 24. Аймгийн гидрогеологийн системийн ялгах онцлогууд

№	Гидрогеологийн системийн үзүүлэлтүүд	Хойт буюу грунтын усны ай савын гидрогеологийн систем	Баруун буюу грунт, даралтат ус хосолсон ай савын гидрогеологийн систем
1	Усны төрөл	Грунт	Даралтат ба грунт
2	Тэжээлийн эх үүсвэр	Гадаргын ус, хур тунадас, хажуугийн урсац /оролт/	Хур тунадас, хажуугийн болон гүний урсац /оролт/
3	Гидрохимийн бүсжилт	Үндсэндээ илэрдэггүй	Талбай гүнээр илэрдэг
4	Усны ашиглалтын нөөц	Их	Дунд зэрэг
5	Бусад онцлог	Усны солилцоо сайн, задгай урсацтай	Хагас хаалттай, битүү ай сав

Гидрогеологийн дүүрэгчлэлээр аймгийн нутаг дэвсгэр нь Увс нуурын, Ойгон нуурын, Цавдан нуурын, Тэлмэн нуурын болон, ихэнх нутаг дэвсгэр нь Хяргас нуурын ай савын грунт зонхилж тархсан байна.



Зураг 28. Завхан аймгийн гидрогеологийн зураг

**Аллювийн гаралтай хурдас дахь ус агуулагч үе давхарга:** Ус агуулагч энэ үе дахь харга нь орчин үеийн дөрөвдөгчийн буюу голоцений настай, аллювийн гаралтай сэвсгэр, нүх сүвэрхэг элс, хайрга, заримдаа элсэнцэрийн үетэй хурдасаас тогтдог. Аймгийн Завхан гол, Идэрийн голын хөндийгөөр тархсан бөгөөд өндөр ундаргатай ус агуулсан байдаг. Тосонцэнгэлийн орчимд Идэр голын аллювийн хурдас дотор илэрсэн газрын доорх усны ундарга 1,2 л/сек ба түүнээс илүү байсан байна.

**Салхины гаралтай хурдас дахь ус агуулагч үе давхарга:** Энэ үе нь зонхилж голоцений настай, салхины гаралтай сэвсгэр, нүх сүвэрхэг сэвсүүл элсээс тогдог

бөгөөд өндөр ундаргатай ус агуулагч үе нь Баян нуур, Гүн нуур, Хар нуур, Мухар, Хүнгүй, Галуутын гол орчмоор Бөөрөг дэл, Бор хөөвөрийн элсээр тархсан байна.

*Плейстоцений настай, пролювийн гаралтай хурдас дахь ус агуулагч давхарга:* Уг давхарга нь судаг, жалга, уулын бэл хормойгоор тархсан элс, хайрга, элсэнцэр, шавар, шавранцараас тогтох ба Хүнгүй гол, Хар ус нуур, Завхан голын хөндийн зарим хэсгээр тархсан байна.

*Үндсэндээ газрын доорх усгүй чулуулаг:* Энэ давхарга нь янз бүрийн геологийн насны тунамал, бялхмал, түрмэл, хувирмал чулуулгаас зонхилж тогтох боловч газрын доорх ус агуулаагүй аллювийн гаралтай хурдас олон жилийн зузаан цэвдэг тархсан өндөр уулын ар, салхины урсгалын чиг дагасан хөндий, говь цөлийн бүсийн хуурай сайрт элбэг тохиолддог. Уг салхины гаралтай харьцангуй бага зузаантай, бага талбайтай сэвсүүл элс ихэвчлэн эсгүй хуурай байдаг ба Завхан, Хүнгүй голын хооронд тархсан байна.

## 2.9 ЗАВХАН АЙМГИЙН ХӨРС, УС, АГААРЫН БОХИРДОЛ

Сүүлийн жилүүдэд Монгол орны төдийгүй уул уурхай, хотжилт хөгжсөн томоохон аймгуудад газар ашиглах цар хүрээ нэмэгдэж, хүрээлэн буй орчинд үзүүлэх хүний сөрөг нөлөө их болж байна.

Завхан аймаг хүн ам цөөн, үйлдвэржилт бараг хөгжөөгүй, эдийн засгийн гол салбар нь бэлчээрийн мал аж ахуй болохоор байгаль орчны бохирдол өндөр бус, харьцангуй онгон байгальтай, орчны эрүүл ахуйн хувьд асуудал багатай нутаг. Тус аймагт 2008 онд байгаль орчны шинжилгээний лаборатори байгуулагдан агаар, ус хөрс 3 орчинд химийн болон цацрагийн шинжилгээ хийж байна.

Иймд улсын хэмжээнд судлагдсан судалгааны ажлуудаас Завхан аймгийн нутаг дэвсгэр дэх хөрс, ус, агаарт бохирдолын шинж тэмдэг илэрсэн эсэхийг нэгтгэн дүгнэлээ.

### 2.9.1 Хөрсний бохирдол

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 21 аймгийн төвүүдэд хөрсний бохирдолын судалгаа хийсэн бөгөөд Улиастай хотод хөрсний бохирдолын голлох хүнд металлууд болох кадми, хар тугалга, мөнгөн ус, бор, цайр, зэс, кобальт, стронци зэрэг металлыг 2012-2016 онд шинжлүүлсэн байдаг.

Хөрсний бохирдолын үзүүлэлтийг Хөрсний чанарын MNS5850:2008 стандарттай харьцуулж үзэхэд 2016 онд Улиастай хотын уурын зуух орчимд кадмийн агууламж хамгийн өндөр буюу 6,7 мг/кг буюу стандартаас 3,7мг/кг-өөр өндөр, кобальтийн агууламж стандартаас 66мг/кг-аар өндөр, борын агууламж стандартаас 1,8 мг/кг-аар өндөр, хар тугалганы агууламж стандартаас 47,3 мг/кг-аар өндөр, стронцийн агууламу 1972 мг/кг-аар өндөр, цайрын агууламж стандартаас 747 мг/кг-аар өндөр гарсан байна.


Хүснэгт 25. Улиастай хотын хөрсний бохирдол

Үзүүлэлт	Хөрсөн дэх химийн хүнд элементүүдийн хэмжээ, мг/кг								
	Кадми, Cd	Хар тугалга, Pb	Мөнгөн ус, Hg	Хром, Cr	Бор, B	Зэс, Cu	Кобальт, Co	Цайр, Zn	Строн-ци, Sr
Стандарт MNS5850:2008	3	100	2	150	25	100	20	300	800

Улиастай хот, 2016 он	6,7	147,3	1,67	25,4	26,8	32	86	1047	2772
Стандартаас давсан хэмжээ	3,7	47,3	-	-	1,8	-	66	747	1972

Эх сурвалж: Монгол орны байгаль орчин, V боть, 2017 он

Мөнгөн ус, хорм, кобальт элементийн агууламж нь стандартаас даваагүй байна.



Диаграмм 11. Улиастай хотын хөрсөн дэх зарим хүнд металлын бохирдолын хэмжээ, 2016 он /Co, Cu, B, Cr, Hg, Pb, Cd/



Диаграмм 12. Улиастай хотын хөрсөн дэх заорим хүнд металлын брхидолын хэмжээ, 2016 он /Sr, Zn/

## 2.9.2 Гадаргын усны бохирдол

Гадаргын усыг бохирдуулах эх үүсвэр нь гол төлөв ахуйн хог хаягдал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалтаас үүсдэг. Голын усны бохирдол улирлаас шалтгаалахаас гадна бохирдуулах эх үүсвэрийн байрлал, хэмжээнээс хамаарна.

Гадаргын усыг бохирдуулах эх үүсвэр нь гол төлөв ахуйн хог хаягдал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалтаас үүсдэг. Голын усны бохирдол улирлаас шалтгаалахаас гадна бохирдуулах эх үүсвэрийн байрлал, хэмжээнээс хамаарна.

Тус аймгийн гол мөрний усны химийн найрлага, чанарыг судлах ажил 1970-аад оны эхээс байгаль орчинг хамгаалах асуудал чухалчлагдах болсонтой уялдан гол мөрний усны химийн найрлага, бохирдлын байнгын ажиглалт, хяналт шинжилгээний сүлжээг ус судлалын харуул, өртөөнд түшиглэн өргөтгөснөөс гадна бохирдлыг илтгэгч зарим үзүүлэлтүүдийг тодорхойлдог болжээ.

Усны чанарын үнэлгээнд аливаа химийн элементийн улирлын хэлбэлзэлийн олон жилийн ажиглалт эсвэл богино хугацааны туршилт судалгаа шаардлагатай бөгөөд Монгол улсын хэмжээгээр томоохон голуудын эрдэсжилт, ионы агууламжийг судалсан судалгаанд Завхан аймгийн Богдын голын усны эрдэсжил нь хамгийн бага буюу 80 мг/л, Хүнгүйн гол хамгийн их буюу 357 мг/л байна.

Хүснэгт 26. Зарим голуудын усны эрдэсжил ба гол ионы дундаж агууламж, мг/л

№	Голын нэр	Эрдэсжил	Ca <sup>2+</sup>	Mg <sup>2+</sup>	Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	HCO <sub>3</sub> <sup>-</sup>	SO <sub>4</sub> <sup>2-</sup>	Cl <sup>-</sup>
1	Идэр	163	22,94	6,46	13,95	101	16,56	5,57
2	Богдын гол	80	12,19	2,88	5,66	48	6,94	3,53
3	Чигэстэй	92	14,52	3,57	4,66	56	11,55	1,75
4	Хүнгүй	357	31,06	18,85	43,31	205	43,08	15,33
5	Тэс	276	43,49	7,25	18,79	168	23,94	6,87
6	Завхан	225	29,1	9,11	22,58	96	45,42	14,97

Эх сурвалж: Монгол орны байгаль орчин, II боть, 2017 он

Гадаргын усны чанар, бохирдлын байнгын ажиглалт, судалгаа явуулж гол, харуулын зэрэглэлээс хамааран усны сорьцыг жил тутам 4-8 удаа авч химийн найрлагын Ca<sup>2+</sup>, Mg<sup>2+</sup>, Na<sup>+</sup>+K<sup>+</sup>, HCO<sub>3</sub><sup>-</sup>, SO<sub>4</sub><sup>2-</sup>, Cl<sup>-</sup>, усанд ууссан хүчилтөрөгч O<sub>2</sub>, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, перманганатын исэлдэх чанар (ПИЧ), шим бохирдлын NH<sub>4</sub><sup>4+</sup>-N, NO<sub>2</sub><sup>2-</sup>-N, NO<sub>3</sub><sup>3-</sup>-N, PO<sub>4</sub><sup>3-</sup>-P, хор судлалын нийт Fe, F<sup>-</sup>, Cr<sup>6+</sup>, рН, ЕС, жинлэгдсэн бодис, зэрэг физик, хими, бохирдлын төлөв байдлыг илэрхийлэх 22 орчим үзүүлэлтийг аймгийн байгаль орчны лабораторид шинжилж байна.

Зарим голуудын усны чанарыг авч үзье.

**Богдын гол:** Отгонтэнгэрийн рашаан, түүний ар талын амнаас эх авсан рашааны гол Бага Богдтой, Өвөржоншт, Хөх нуруунаас эх авсан гол горхи нийлж Богдын гол болно. Хамгийн их үер 1979 онд болжээ. Богдын голын ус хураах талбай 1510 ам км, 92км урт, олон жилийн дундаж өнгөрөлт 7.61 шоо м/с байна. 2009-2014 оны дундаж байдлаар аммонийн азот 0.01-0.50 мгN/л, нитритийн азот 0,000-0.011мгN/л, нитратын азот 0,05-0,66мгN/л, эрдэс фосфор 0.001-0.172 мгP/л байна. Харин төмөр 0.01-0.62мг/л, фтор агууламж 0.00-0.91мг/л байсан аж.

**Буянт:** Буянт гол нь Хөх Сэрхий нурууны салбар уулс болох Тахилт уулнаас далайн түвшинээс дээш 3400 м орчим өндрөөс эх авч нийт 8366.9 км<sup>2</sup> талбайгаас усжиж голын нийт урт 171.8 км болно. 2009-2014 оны дундаж байдлаар аммонийн азот 0.02-0.63 мгN/л, нитритийн азот 0.000-0.016мгN/л, нитратын азот 0.06-1.82мгN/л, эрдэс фосфор 0.001-0.092 мгP/л байна. Харин төмөр 0.01-0.39мг/л, фтор агууламж 0.08-0.78мг/л байсан аж.

**Чигэстэй гол:** Чигэстэй гол нь 1050 ам км ус хураах талбайтай, 28 км урт, олон жилийн дундаж өнгөрөлт 4.85 шоо м/с болно. 2009-2014 оны дундаж байдлаар аммонийн азот 0.01-0.74 мгN/л, нитритийн азот 0.000-0.009мгN/л, нитратын азот 0.02-1.09мгN/л, эрдэс фосфор 0.000-0.135мгP/л байв. Харин төмөр 0.01-0.39мг/л, фтор агууламж 0.10-0.86мг/л байжээ.


**Хүнгүй гол:** 2009-2014 оны дундаж байдлаар аммонийн азот 0.03-0.78 мгN/л, нитритийн азот 0.001-0.049мгN/л, нитратын азот 0.06-0.99 мгN/л, эрдэс фосфор 0.004-0.254мгP/л байв. Харин төмөр 0.03-0.55мг/л, фтор агууламж 0.38-1.42мг/л байв.

**Завхан гол:** Завхан гол нь Хангайн нурууны баруун хажууг хормойлон урсаж Айраг нуураар дамжин Хяргас нуурт цутгана. Голын ус хураах тайлбай 71210 ам км, 808 км урт, усны горимын хувьд зуны хур борооны үертэй голд хамрагдана. 2009-2014 оны дундаж байдлаар аммонийн азот 0.02-0.21 мгN/л, нитритийн азот 0.002-0.026мгN/л, нитратын азот 0.06-0.43 мгN/л, эрдэс фосфор 0.002-0.031мгP/л байв. Харин төмөр 0.00-0.11мг/л, фтор агууламж 0.12-0.47мг/л байжээ.

**Тэс гол:** Хангайн нурууны салбар Булнай нурууны ар талаас эх авах Тэс гол нь Хөвсгөлийн уулсын баруун өмнө талаас эх авах ус ихтэй олон гол ихээхэн тэтгэж нэмэгдүүлнэ. Тэс голын жилийн дундаж өнгөрөлт 14.9 шоо м/с байна. 2009-2014 оны дундаж байдлаар аммонийн азот 0.01-0.42 мгN/л, нитритийн азот 0.000-0.012мгN/л, нитратын азот 0.01-0.44 мгN/л, эрдэс фосфор 0.000-0.021мгP/л байжээ. Харин төмөр 0.00-0.12мг/л, фтор агууламж 0.06-1.82мг/л байсан байна.

**Идэр-Тосонцэнгэл харуул:** Энэ гол нь Хангайн нуруунаас эх авах бөгөөд давсны ионы бүтцийн хувьд анионоос гидрокарбонатын ион зонхилж  $\text{HCO}_3 > \text{SO}_4 > \text{Cl}$  байна. Харин катионоос кальцийн ион зонхилох ба катионы харьцаа  $\text{Ca} > \text{Mg} > \text{Na} + \text{K}$  байна. рН-ийн хэмжээ 7.39-7.84 сул шүлтлэг устай. Аммонийн азот 0.02-0.48 мгN/л, нитритийн азот 0.000-0.009мгN/л, нитратын азот 0.00-1.10 мгN/л, эрдэс фосфор 0.001-0.070мгP/л байна. Харин төмөр 0.00-0.16мг/л, фтор агууламж 0.03-0.75мг/л байдаг.


Голын усны бохирдол бохирдуулагч эх үүсвэрийн байрлал, хэмжээнээс голлон хамаарна. Тухайлбал, аммони, нитрит, нитратын азот, эрдэс фосфорын агууламж голын дагууд болон жил бүр өөр өөр байна. Гэхдээ нийт азот, эрдэс фосфорын агууламж зуны улиралд өвлийнхөөс 2-3 дахин нэмэгддэг нь гол мөрнийг бохирдуулагч эх үүсвэрийн тархац жигд бус, усны бохирдлын өөрчлөлт зөвхөн сав газарт явагдах аж ахуйн үйл ажиллагаа болон голын савд нутагших айл өрх, малын тооноос ихэвчлэн хамаарна.



Диаграмм 13. Чигэстэй голын 2009-2015 оны биогены дундаж агууламж

Чигэстэй гол 2009-2015 онуудад аммони 0.04-0.18мг/л, нитрат 0.30-0.48мг/л, нитрит 0.002-0.003мг/л, фосфор 0.004-0.012мг/л дундаж агууламжтай байлаа.

2015 оны гадаргын усны шинжилгээний дүнгээр Завхан аймгийн голуудын усанд зонхилох гол ионы агууламжийг дараахь диаграммд харуулав.




Диаграмм 14. Аймгийн томоохон голуудын гол ионы үзүүлэлт

Эрдэсжилт нь зун борооны улиралд 40-60 мг/л, ус гачиг үед заримдаа 90-139.7 мг/л хооронд хэлбэлзэж байна. Эрдэсжилт нь голын урсацтай урвуу хамааралтай байна. Хамгийн их эрдэсжилт нь өвлийн гачиг урсацтай үед ажиглагдаж, урсац нэмэгдэхийн хирээр усны эрдэсжилт багасах хандлага ажиглагдаж байгаа нь тус голын ус бага эрдэсжилтэй хур борооны усаар сүлэгдэж эрдэсжилт нь багасах ерөнхий горимтой.

Гол мөрний усны химийн найрлага, эрдэсжилтийн хэлбэлзэл урсацын хэмжээнээс гадна тухайн үеийн байгаль, уур амьсгалын нөхцөл, тухайлбал, цас мөсний хайлах эрчимшил, хур тунадасны төрөл, хэмжээ, үргэлжлэх хугацаа, тархац, өмнөх сар, улирал, жилийн уур амьсгалын нөхцөл зэргээс голлон хамаарна. Тухайлбал: удаан хугацааны хуурайшлын үе, гантай жилийн дараа усны эрдэсжилт нэмэгдэж байхад элбэг устай үед үерийн эхэнд нэмэгдэж дараа дараагийн хур борооны үед улам буурна.

**Усны хатуулаг:** Усны хатуулаг эрдэсжилтээс хамаарч их үерийн үед буурч маш зөөлөн устай (1.50мг-экв./л), гачиг үед зөөлөн устай (1.50-3.00мг-экв./л) болно.



Диаграмм 15. Аймгийн зарим голуудын усны хатуулгийн олон жилийн дундаж өөрчлөлт

**Усны бохирдолын индекс:** УБИ-ийг бодохдоо зөвхөн тодорхой тооны бохирдуулах бодисын тоон үзүүлэлтийг ашиглана. Эхлээд үзүүлэлт тус бүрийн арифметик дунджийг олно. Тухайн цэгийн химийн үзүүлэлтээс бодисын тоон үзүүлэлтийг ашиглана. Усны бохирдлыг илэрхийлдэг ууссан хүчилтөрөгч, хялбар исэлдэх органик бодис, хүнд металл, эрдэс азот, фосфорын усан дахь агууламжийг

усны чанарын MNS4586-98 стандартад заасан хүлцэх агууламжтай харьцуулан үнэлнэ. Усны чанарын индекс ( $W_{qi}$ )- ийг дараах томъёогоор илэрхийлнэ.

$$W_{qi} = \frac{\sum_i \left( \frac{C_i}{Pl_i} \right)}{n}$$

Үүнд:  $C_i$  – бохирдуулагч (i) элементийн агууламж,  $Pl_i$  – MNS4586-98 стандартад заасан бохирдуулж буй (i) элементийн усан дахь зөвшөөрөгдөх дээд агууламж ба n – бохирдлын нийт үзүүлэлтийн тоо.

Усны чанарын үнэлгээнд уссан хүчилтөрөгч, биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, химийн хэрэгцээт хүчилтөрөгч, аммони, нитрит, нитрат зэрэг болон бусад бохирдуулагч элементүүдийг хамруулан тооцно.

Гадаргын усны 2015 онд хийсэн шинжилгээний дүнгээр гадаргын усны чанарын индексийг тооцож үзэхэд Идэр, Буянт, Богд, Чигэстэй, Тэс, Завхан, Тээл голууд 0,07-0,27 буюу маш цэвэр, Хүнгүй гол 0,3 буюу цэвэр гэсэн ангилалд багтаж байна.



Диаграмм 16. Аймгийн зарим голуудын гадаргын усны чанарын үнэлгээ, 2015 он

2016 оны байдлаар аймгийн зарим томоохон голуудын усан дахь уссан хүчилтөрөгч, хялбар исэлдэгч органик бодис, эрдэс азот, фосфор, хром, зэс зэрэг элементийн агууламжийг MNS4589-98 “Усны чанарын стандарт”-тай харьцуулан үнэлэхэд бүх Тэс гол маш цэвэр, бусад голууд цэвэр ангилалд багтаж байна.


Хүснэгт 276. Зарим голуудын усны бохирдолын үзүүлэлтийн олон жилийн дундаж агууламж, мг/л

№	Голын нэр	$\text{NH}_4^{4+}$	$\text{NO}_3^{3-}$	$\text{PO}_4^{3-}$	Si	ПИЧ	$\text{BXX}_5$	$\text{O}_2$	Хатуулаг	pH
1	Идэр	0,17	0,28	0,01	4,10	3,17	-	-	1,7	7,9
2	Богдын гол	0,28	0,33	0,02	3,22	3,37	-	-	1,23	7,55
3	Чигэстэй	0,13	3,09	0,01	-	3,00	-	9,88	1,02	7,28
4	Хүнгүй	0,17	0,73	0,04	5,92	5,54	-	-	3,09	8,05
5	Тэс	0,15	0,36	0,01	5,39	2,60	-	-	2,80	8,13
6	Завхан	0,12	0,32	0,01	2,43	3,4	-	-	2,18	7,94

Эх сурвалж: Монгол орны байгаль орчин, II боть, 2017 он

Богдын голын усны чанарын индексийн 2009-2015 оны хоорондох өөрчлөлтийг Зураг 9 – т үзүүлэв.





Диаграмм 17. Богд голын 2009-2015 оны чанарын үнэлгээний өөрчлөлт


Усны чанарын үнэлгээгээр Чигэстэй гол 2009, 2010, 2011, 2014 онуудад цэвэр, 2012, 2013, 2015 онуудад маш цэвэр ангилалд орсон байна.

### 2.9.3 Агаарын бохирдол

Хүн амын нягтаршил нэмэгдэж, хотжилт ихсэхийн хирээр агаарын бохирдол үүсэх бөгөөд энэ асуудал, Улаанбаатар хот төдийгүй хүн ам ихтэй аймгийн төвүүдэд үүсээд байна. Уластай хотод агаарын чанарын хяналт шинжилгээний цэг тогтмол ажиллаж байгаа бөгөөд сүүлийн 20 жилийн байдлаар авч үзэхэд агаар дахь азотын давхар исэл болон хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж нь агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

#### Агаарын чанар:


Агаарын чанарыг хүхэрлэг хий ( $SO_2$ ), азотын давхар исэл ( $NO_2$ )-ийн агаар дахь агууламжаар Улиастай хотод аймгийн цаг уурын өртөө орчимд химийн шинжилгээний аргаар өдөр тутамд (эгшин зуурын буюу 20 минутын агаар соруулалтын дүнгээр) тодорхойлж байна. Улиастай хотын агаар дахь хүхэрлэг хий ( $SO_2$ ), азотын давхар исэл ( $NO_2$ )-ийн агууламжийн олон жилийн өөрчлөлтийг диаграммд үзүүлэв.



Диаграмм 18. Улиастай хотын агаар бохирдуулах бодисын агууламжийн олон жилийн явц


Хүхэрлэг хийн хамгийн бага дундаж агууламж 2011 онд  $2\text{мкг/м}^3$ , хамгийн их дундаж агууламж 2017 онд  $5\text{мкг/м}^3$  байсан бол азотын давхар ислийн хамгийн бага дундаж агууламж 2015 онд  $5\text{мкг/м}^3$ , хамгийн их нь 2011 онд  $12\text{мкг/м}^3$  байсан байна. Өөрөөр хэлбэл суурин хэмжилтээр хүхэрлэг хий, азотын давхар ислийн дүнг MNS4585:2016 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан тохиолдол ажиглагдаагүй байна. Агаарын бохирдлын жилийн доторх хуваарилагдлыг аваад үзвэл галлагаатай холбоотойгоор өвөл ихсэж, жилийн дулаан улиралд багасаж байдаг. Гэхдээ сүүлийн жилүүдэд автомашины, түүний дотор дизель хөдөлгүүртэй машины тоо нэмэгдснээс азотын давхар ислийн хэмжээ зундаа ч гэсэн нэлээд өндөр байдаг болсон байна.

Агаар дахь бохирдуулах бодисын агууламжийг явуул судалгааны аргаар тодорхойлсон дүнгээс харахад хүхэрлэг хийн дундаж агууламж хотын төв орчимд  $12\text{--}36\text{мкг/м}^3$ , арал орчимд  $5\text{--}18\text{мкг/м}^3$ , шинэ хороо орчимд  $5\text{--}14\text{мкг/м}^3$ , бааз орчимд  $5\text{--}12\text{мкг/м}^3$  байсан ба төв орчимд хүхэрлэг хийн хэмжээ стандартаас 1.2-1.8 дахин давсан байна.



Диаграмм 19. Улиастай хотын агаар дахь хүхэрлэг хий /SO<sub>2</sub>-н олон жилийн дундаж агууламж Харин азотын давхар исэл дээр зөвшөөрөгдөх хэмжээнээс давах явдал аль газарт илрээгүй байна.


Агаар дахь том ширхэгт тоосонцор (PM<sub>10</sub>) – ын агууламж суурин харуул дээр 2010-2017 оны хооронд  $0,19\text{--}0,26\text{мкг/м}^3$  – ийн хооронд буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс 3-5 дахин бага байна. Гэхдээ явуул судалгаагаар үе үе зөвшөөрөгдөх хэмжээнээс давдаг байна.



Диаграмм 20. Улиастай хотын агаар дахь том ширхэгт тоосонцорын агууламж /явуул судалгааны үр дүн/

Тухайлбал, дундаж агууламж хотын төв орчимд 31-320мкг/м<sup>3</sup>, арал орчимд 66-258мкг/м<sup>3</sup>, шинэ хороо орчимд 70-266мкг/м<sup>3</sup>, бааз орчимд 43-386мкг/м<sup>3</sup>, байсан ба төв орчимд том ширхэгт тоосонцорын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.1-3.2 дахин, бааз орчимд 1.1-3.9 дахин, арал орчимд 1.0-2.6 дахин, шинэ хороо орчимд 1.4-2.7 дахин давсан байна.

Цацраг идэвхжлийн дэвсгэр түвшний хяналтыг Улиастай, Баянтэс өртөөнд өдөр бүр 08, 14 цагт хөтөлбөрийн дагуу хийж байна. Олон жилийн дунджаар агаар дахь цацраг идэвхжлийн дэвсгэр Улиастайд 0.12 м<sup>2</sup>/цаг, Баянтэсэд 0.11 м<sup>2</sup>/цаг байна. Нийт хэмжилтээр цацраг идэвхжлийн дэвсгэр түвшин 0.08-0.23 м<sup>2</sup>/цаг байна.




Диаграмм 21. Улиастай хотын цацраг идэвхжлийн дэвсгэр түвшин

## 2.10 ЗАВХАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ


### 2.10.1 Хүн ам, өрх гэр

**Хүн амын тоо:** 2016 оны эцэст Завхан аймгийн хүн амын тоо 70.8 мянга болж, баруун бүсийн хүн амын 18 хувийг, Монгол улсын нийт хүн амын 2.3 хувийг тус тус бүрдүүлж байна. Мөн аймгийн нийт хүн амыг өмнөх онтой харьцуулахад 1.03 хувиар буюу 0.7 мянган хүнээр өссөн, 2006 онтой харьцуулахад 11.4 хувиар буюу 8.1 мянган хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хүн амын тоонд гарсан өөрчлөлтийг дараах диаграммаар харуулав.



Диаграмм 22. Завхан аймгийн хүн ам, хүн амын өсөлт, хэлхээ үзүүлэлтээр

2007-2012 он хүртэл хүн ам буурахад хандлагатай байсан ч, сүүлийн жилүүдэд өсөх хандлага ажиглагдаж байна. Мөн Завхан аймгийн хүн амын тоо 2006-2016 оны хооронд жилд дунджаар 1.1 хувиар буюу 711 хүнээр буурахад хүн амын шилжих хөдөлгөөн илүү их нөлөө үзүүлсэн.




Диаграмм 23. Завхан аймгийн хүн амын ердийн болон механик цэвэр өсөлт

Өөрөөр хэлбэл, энэ хугацаанд жилд дунджаар 1665 хүн төрж, 459 хүн нас барсан (ердийн цэвэр өсөлт нь жилд дунджаар 1206 хүн), 820 хүн Завхан аймагт шилжин ирж байхад 2737 хүн явсан (механик цэвэр өсөлт нь жилд дунджаар -1917 хүн) байна. Эндээс үзэхэд хүн ам жилд дундаж (2006-2016 оны хооронд) -аар 711 хүнээр буурахад хүн амын шилжих хөдөлгөөн илүү их нөөцлөсөн нь харагдаж байна.

12-р зургаас харахад 2008 онд хүн амын шилжилт хөдөлгөөн хамгийн өндөр байсан ба 2016 онд нийт 1579 хүн явсаны 27 хувийг Улиастай хотын, 14.8 хувийг Тосонцэнгэл сумын, 8.3 хувийг Баянтэс сумын, 6.7 хувийг Их-Уул сумын хүн амын шилжин явалт тус тус бүрдүүлж байна<sup>7</sup>.

**Хүн амын бүтэц:** Завхан аймгийн хүн амын бүтцийг нас, хүйс, сум, хот хөдөөгөөр нь авч үзэж тайлбарлав.




Диаграмм 24. Хүн амын хүйсийн бүтэц, 2016 он

Эх сурвалж: МУ-ын ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сан.

Завхан аймгийн хүн амын бүтэц (нас, хүйсээр): 2016 оны байдлаар нийт хүн амын 49.9 хувийг эрэгтэйчүүд, үлдсэн хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Энэ нь

<sup>7</sup> 2016 оны шилжин явсан хүн амын бүтцийг тайлбарлахад 100-с дээш хүн ам шилжин явсан сумдыг авч үзэв.

2015 оны үзүүлэлттэй харьцуулахад 0.01 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Мөн 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүд буюу хүйсийн харьцааг нийт хүн амаар авч үзэхэд 2015, 2016 онуудад 99.6 гарсан нь хүн амын нөхөн үржихүйн процесс хэвийн явагдах нэг үндэс болж байна.




Диаграмм 25. Хүн амын насны бүтэц, 2016 он

Эх сурвалж: МУ-ын ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сан

Харин хүн амын насны бүтцийг авч үзэхэд 2016 оны нийт хүн амын 29.6 хувийг 14 болон түүнээс доош насны хүн ам, 63.8 хувийг 15-59 насны хүн ам (хөдөлмөрийн насны), үлдсэн хувийг 60 болон түүнээс дээш насны хүн ам (тэтгэвэрийн насны) тус тус бүрдүүлж байна. Хүн амын насны бүтцийг 2015 оны бүтэцтэй харьцуулахад 14 болон түүнээс доош насны хүн амын бүтэц 0.3 пунктээр өссөн, 15-59 насны хүн амын бүтэц 0.4 пунктээр буурсан, 60 болон түүнээс дээш насны хүн амын бүтэц 0.1 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Завхан аймгийн хүн амын бүтэц (хот хөдөөгөөр): Завхан аймгийн 2016 оны нийт хүн амын 21.9 хувийг хотын, 78.1 хувийг хөдөөний хүн ам бүрдүүлж байна. Мөн сүүлийн 10 жилийн дунджаар Завхан аймгийн нийт хүн амын 22.5 хувийг хотын, 77.5 хувийг хөдөөний хүн ам бүрдүүлж байна.



Диаграмм 26. Хүн амын бүтэц, хот хөдөөгөөр, 2016 он

Эх сурвалж: МУ-ын ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сан.


Завхан аймгийн хүн амын бүтэц (сумаар): 2016 оны хүн амын тархалтыг сумдаар авч үзэхэд 22.2 хувь нь Улиастай хотод, 12.8 хувь нь Тосонцэнгэл суманд, 8.8 хувь нь Их Уул суманд, 4.1 хувь нь Тэс суманд, 4 хувь нь Алдархаан суманд, үлдсэн хувь нь бусад сумдад тархан суурьшсан байна.



Зураг 29. Завхан аймгийн хүн амын бүтэц, 2016 он

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн статистик мэдээлэлд үндэслэн боловсруулсан үр дүн.

**Өрх гэр, ам бүлийн тоо:** Завхан аймгийн өрхийн тоо 2016 онд 21078 болж, өмнөх оноос 1.8 хувиар, 2007 онтой харьцуулахад 2.8 хувиар, сүүлийн 10 жилд дунджаар 0.3 хувиар тус тус өссөн байна.



Диаграмм 27. Завхан аймгийн ам бүл болон өрхийн тоо, 2016 он

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн статистик мэдээлэлд үндэслэн боловсруулсан үр дүн.


Энэ нь гэрлэлт болон нийт хүн амд залуучуудын эзлэх хувь өсөх хандлагатай байгаатай шууд холбоотой. 2016 оны байдлаар 341 гэрлэлт (өрх гэр шинээр) бүртгүүлсэн нь 2010 онтой харьцуулахад 1.6 дахин өссөн үзүүлэлттэй байна. Харин өрхийн ам бүлийн гишүүдийн хувьд 2012-2016 оны хооронд нэг өрх дунджаар 3 гишүүнтэй болж, 2007-2011 оны үзүүлэлттэй харьцуулахад нэг хүнээр буурсан байна. Энэ нь хүн амын тооны өсөлт, өрхийн тооны өсөлтөөс бага байгаатай хамааралтай.

Дээрх диаграммаас хүн амын бүтцээс хамааран Улиастай хот хамгийн олон өрхтэй байхад Асгат сум хамгийн бага өрхтэй, мөн аймгийн дунджаар нэг өрхөд ногдох ам бүлийн тоо 3 гарсан хэдий ч зарим сумдын хувьд тухайн үзүүлэлт 4 гишүүнтэй гарсан нь харагдаж байна.

**Хүн амын дундаж наслалт:** Завхан аймгийн хүн амын дундаж наслалт 2016 онд 70.03 болж, өмнөх оноос 0.4 хувиар буюу 0.31 жилээр, 2007 онтой харьцуулахад 7.9 хувиар буюу 5.15 жилээр өссөн байна. Мөн дундаж наслалтыг хүйсээр авч үзэхэд эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийн дундаж наслалтаас 8.1 хувиар буюу 5.5 жил (2016 оны байдлаар) -ээр өндөр байна.

## 2.10.2 Хүн амын амьжиргааны түвшин, өрхийн орлого зарлага

**Хүн амын амьжиргааны түвшин:** Хүн амын амьжиргааны доод түвшинг нэг хүнд сард ногдох байдлаар авч үзэхэд баруун бүсийн хувьд 2016 онд 166.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 1.03 хувиар буюу 1.7 мянган төгрөгөөр өссөн байна. Хүн амын ядуурлын хамралтын хүрээ 2016 онд 47.5 хувьтай байгаа нь баруун бүсийн дундажтай харьцуулахад 11.5 хувиар, улсын дундажтай харьцуулахад 17.9 хувиар өндөр байна. Үүнээс хамааран ядуурлын гүнзгийрэлт болон ядуурлын мэдрэмжийн коэффициентүүд ч бүс болон улсын дунджаас өндөр гарсан байна.



Диаграмм 28. Ядуурлын үндсэн үзүүлэлт, 2016 он

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

**Өрхийн сарын дундаж орлого, зарлага:** 2016 оны III улирлын өрхийн сарын дундаж орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.8 хувиар буурсан байна. 2016 оны III улиралд өрхийн сарын дундаж орлого 937053 төгрөг байсан ба нийт орлогын 91.1 хувийг мөнгөн орлого, 4.8 хувийг бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн, үлдсэн хувийг өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Мөн мөнгөн орлогын бүтцийг авч үзэхэд нийт мөнгөн орлогын 56.2 хувийг цалин хөлс, 19.4 хувийг тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор, 7.3 хувийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, 8 орчим хувийг хөдөө аж ахуйн бус

үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, үлдсэн хувийг бусад мөнгөн орлого бүрдүүлж байна.

Хүснэгт 8. Нэг өрхийн сарын дундаж орлого, түүний бүтэц /төг/

Орлогын бүтэц	2015	2016		2016 VII-IX / 2015 VII-IX	Орлогын бүтэц, 2016 VII-IX
	VII-IX	IV-VI	VII-IX		
<b>Мөнгөн орлого, бүгд</b>	<b>937675.0</b>	<b>874392.0</b>	<b>853279.0</b>	<b>91.0%</b>	<b>91.1%</b>
Цалин хөлс	507567.0	488310.0	479549.0	94.5%	56.2%
Тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговор	168100.0	160626.0	165373.0	98.4%	19.4%
ХАА-н үйлдвэрлэлийн орлого	100243.0	67899.0	62556.0	62.4%	7.3%
ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	72897.0	74130.0	67878.0	93.1%	8.0%
Бусад	88868.0	83427.0	77923.0	87.7%	9.1%
<b>Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>	<b>55310.0</b>	<b>49553.0</b>	<b>45198.0</b>	<b>81.7%</b>	<b>4.8%</b>
<b>Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>57792.0</b>	<b>46443.0</b>	<b>38576.0</b>	<b>66.7%</b>	<b>4.1%</b>
<b>Нийт дүн</b>	<b>1050777.0</b>	<b>970388.0</b>	<b>937053.0</b>	<b>89.2%</b>	<b>100.0%</b>

Эх сурвалж: Завхан аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулга

2016 оны III улирлын өрхийн сарын дундаж зарлагыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.8 хувиар буурсан хэдий ч өрхийн сарын дундаж орлогоос давсан байна. 2016 оны III улиралд өрхийн сарын дундаж зарлага 1009928 төгрөг байсан ба нийт зарлагын 89.8 хувийг мөнгөн зарлага, 1.9 хувийг бусдад өгсөн бэлэг, тусламж, 4.5 хувийг бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн, үлдсэн хувийг өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Мөн мөнгөн зарлагын бүтцийг авч үзэхэд нийт мөнгөн зарлагын 23.6 хувийг хүнсний бүтээгдэхүүн (хүнсний бүтээгдэхүүний нийт зардлын 56 хувийг мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн эзлэж байна), 76.4 хувийг хүнсний бус бүтээгдэхүүн (хүнсний бус бараа, үйлчилгээний 13.2 хувийг тээвэр, холбооны зардал) худалдан авсан зардал бүрдүүлж байна.

Хүснэгт 8. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, түүний бүтэц, төг

Зарлагын бүтэц	2015	2016		2016 VII-IX / 2015 VII-IX	Нийт дүнд эзлэх хувь, 2016 VII-IX
	VII-IX	IV-VI	VII-IX		
<b>Мөнгөн зарлага, бүгд</b>	<b>913564.0</b>	<b>928123.0</b>	<b>907153.0</b>	<b>99.3%</b>	<b>89.8%</b>
<b>Хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>237051.0</b>	<b>219517.0</b>	<b>213839.0</b>	<b>23.6%</b>	<b>21.2%</b>
Үүн ээс: Мах, махан бүтээгдэхүүн	66304.0	66543.0	63647.0	29.8%	6.3%
Гурил, гурилан бүтээгдэхүүн	60304.0	56687.0	56011.0	26.2%	5.5%
<b>Хүнсний бус бараа, үйлчилгээ болон бусад</b>	<b>676513.0</b>	<b>708606.0</b>	<b>693314.0</b>	<b>76.4%</b>	<b>68.6%</b>
Үүн ээс: Тээвэр	70189.0	61097.0	59577.0	8.6%	5.9%
Холбоо	34944.0	32686.0	31990.0	4.6%	3.2%
<b>Бусдад өгсөн бэлэг, тусламж</b>	<b>23000.0</b>	<b>20792.0</b>	<b>19001.0</b>	<b>82.6%</b>	<b>1.9%</b>
<b>Бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн</b>	<b>55310.0</b>	<b>49553.0</b>	<b>45198.0</b>	<b>81.7%</b>	<b>4.5%</b>
<b>Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн</b>	<b>57792.0</b>	<b>46443.0</b>	<b>38576.0</b>	<b>66.7%</b>	<b>3.8%</b>
<b>Нийт дүн</b>	<b>1049666.0</b>	<b>1044911.0</b>	<b>1009928.0</b>	<b>96.2%</b>	<b>100.0%</b>

Эх сурвалж: Завхан аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулга



2015 оны III улиралд нэг өрхийн сарын дундаж орлого, зарлагын зөрүү 1.1 мянган төгрөг болж эерэг утгатай хуримтлал үүсгэх боломжтой байсан 2016 онд энэхүү үзүүлэлт -72.8 мянган төгрөг болж, орлогоос давсан зарлага (өр зээл) –ыг буй болгосон байна.

### 2.10.3 Нийгмийн зарим үзүүлэлт


Завхан аймагт 2016 онд нийт 3000 эмэгтэй өрх толгойлж, 76 хүүхэд бүтэн өнчин, 930 хүүхэд хагас өнчин, 1797 өндөр настан ганц биеэр өрх үүсгэн амьдардаг гэсэн статистик үзүүлэлт гарсан.



Зураг 30. Завхан аймгийн нийгмийн зарим үзүүлэлт, 2016 он

### 2.10.4 Боловсрол, эрүүл мэнд

**Сургуулийн өмнөх боловсрол:** 2016/2017 оны жилд аймгийн нийт дүнгээр сургуулийн өмнөх боловсролын нийт 39 байгууллага 183 үндсэн багштайгаар үйл ажиллагаа эрхлэн явуулсан байна. Өмнөх онтой харьцуулахад СӨБ-ын тоо 2.6 хувиар, үндсэн багшийн тоо 5.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн СӨБ-ын нийт 39 байгууллагын 25.6 хувь нь аймгийн төвд, үлдсэн хувь нь сумын төвд үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Эндээс үзэхэд багийн төвд үйл ажиллагаа байгаа СӨБ-ын байгууллага байхгүй ба хөдөө орон нутагт амьдарч, ажиллаж буй малчид өөрсдийн хүүхдийг цэцэрлэгт хамруулах боломж байна.




Диаграмм 29. Боловсролын салбарын зарим үзүүлэлт /хамран сургалтын бохир жин/

Эх сурвалж: УСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

**Ерөнхий боловсролын сургууль:** 2016/2017 оны хичээлийн жилд нийт 30 ЕБС 893 үндсэн багштайгаар үйл ажиллагаа явуул ба нэг багшид дунджаар 16.3 суралцагч ногдож байна. Харин бага ангийн багш нарын хувьд нэг багшид 25.4 суралцагч ногдож байна. Мөн нийт 14.6 мянган суралцагчийн 11.4 хувь нь буюу 1.6 мянган хүүхэд дотуур байранд амьдрах хүсэлт гаргаснаас 1.4 мянган хүүхэд нь дотуур байранд амьдарч байна. Мөн нийт суралцагчдын 35.5 хувь нь малчин өрхийн хүүхэд, нийт малчин өрхийн хүүхдийн 19.7 хувь нь дотуур байранд амьдарч байна.

**Эрүүл мэнд:** 2016 онд эрүүл мэндийн салбарт нийт 98 байгууллага үйл ажиллагаа явуулсан ба үүний 48 орчим хувийг эмнэлэгийн байгууллага эзлэж байна. Мөн 182 их эмч эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн ба нэг их эмчид дунджаар 389 хүн (бүсийн дунджаас бага хэдий ч улсын дунджаас өндөр), нэг сувилагчид 253 хүн (бүс, улсын дунджаас бага) ногдож байна.


Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүдээс авч үзэхэд нялхасын эндэгдэл 15.5 болж өмнөх онтой харьцуулахад 39.9 хувиар буурсан, хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 17.3 мянга болж 5.6 хувиар өссөн, хорт хавдраар өвчлөгчид 23.0 мянга болж 15.3 хувиар өссөн, үүнээс нас барсан хүн 18.2 мянга болж, өмнөх онтой харьцуулахад 11.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



Диаграмм 30. Эрүүл мэндийн салбарын зарим гол үзүүлэлт

Эх сурвалж: УСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

**Гэмт хэрэг:** Аймгийн хэмжээнд 2016 онд нийт 261 гэмт хэрэг бүртгэгдэж, өнгөрсөн онтой харьцуулахад 16 хувиар өссөн байна. Мөн нийт гэмт хэргийн 45.2 хувийг өмчлөх эрхийн эсрэг, 37.9 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг эзлэж байна.




- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг
- Өмчлөх эрхийн эсрэг
- Малын хулгайн
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын

Диagramм 31. Гэмт хэрэг, түүний бүтэц, 2016 он

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

### 2.10.5 Хүн амын цаашдын хандлага


ҮСХ-ноос хүн амын хэтийн төлвийг 2010-2040 онд төрөлтийн аажим, дундаж, хурдацтай бууралттай үе гэсэн 3 хувилбараар тооцсон байдаг. Уг аргачлалд үндэслэн Завхан аймгийн нийт хүн амын ойрын, дунд, урт хугацааны төлөвийг дээрх 3 хувилбараар тооцсон үр дүнг дараах диаграммаар харуулав.




Диagramм 32. Завхан аймгийн хүн амын цаашдын хандлага

Эх сурвалж: ҮСХ-ноос тооцсон үр дүн, аргачлалд суурилан тооцсон судалгааны үр дүн

Дээрх үр дүнд үндэслэн хүн амын цаашдын хандлагыг хот, хөдөөний хүн амаар задлан харуулав.



Диаграмм 33. Завхан аймгийн хүн амын цаашдын хандлага, хотын хүн амаар  
Эх сурвалж: ҮСХ-ноос тооцсон үр дүн, аргачлалд суурилсан тооцсон судалгааны үр дүн




Диаграмм 34. Завхан аймгийн хүн амын цаашдын хандлага, хөдөөгийн хүн амаар  
Эх сурвалж: ҮСХ-ноос тооцсон үр дүн, аргачлалд суурилсан тооцсон судалгааны үр дүн

## 2.11 ЗАВХАН АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

**Аймгийн ДНБ, эдийн засгийн өсөлт:** Завхан аймгийн ДНБ 2016 онд 292.2 тэрбум төгрөгт хүрч, эдийн засаг 5.9 хувиар буурсан, 2007 онтой харьцуулахад эдийн засаг даруй 4 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2016 оны үзүүлэлтээр баруун

бүсийн ДНБ-ий 20.1 хувийг, Монгол улсын ДНБ-ий 1.2 хувийг тус тус бүрдүүлсэн байна.




Диаграмм 35. Завхан аймгийн эдийн засгийн өсөлт

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

Дээрх зургаас харахад Завхан аймгийн эдийн засгийн өсөлт 2008 онд оргил үедээ хүрч байсан хэдий ч 2012 оноос хойш эрчимтэй буурч байна.

**Нэг хүнд ногдох ДНБ:** 2016 онд аймгийн нэг хүнд ногдох ДНБ 4.1 сая төгрөг болж, өмнөх оноос 6.9 хувиар буюу 0.31 сая төгрөгөөр буурсан, 2007 онтой харьцуулахад 4.4 дахин их буюу 3.19 сая төгрөгөөр өссөн, сүүлийн 10 жилд дунджаар 18 хувиар буюу 0.4 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлт гарч байна.

**Завхан аймгийн өрсөлдөх чадвар:** Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр тооцдог аймгуудын өрсөлдөх чадварын үр дүнгээс үзэхэд Завхан аймаг 2016 онд 53 оноо (өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ нь) -гоор 16-т эрэмбэлэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 4 оноогоор (эрэмбэ нь 2 байраар ухарсан) буурсан үзүүлэлт байна.




Диаграмм 36. Завхан аймгийн өрсөлдөх чадвар

Эх сурвалж: Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

## 2.11.1 Хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, эдийн засагт эзлэх байр суурь

### 2.11.1.1 Хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

**Салбарын нэмэгдэл өртөг:** Завхан аймгийн 2016 оны ДНБ-ий 45.9 хувийг буюу 134.2 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртгийг хөдөө аж ахуйн салбараас бүрдүүлсэн байна. Сүүлийн 10 жилийн дунжаар салбарын нэмэгдэл өртөг жилд 10.2 хувиар өссөн, мөн жилийн дунджаар ДНБ-ий 54.1 хувийг хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг бүрдүүлж байгаа нь энэхүү салбар Завхан аймгийн эдийн засагт ямар чухал салбар болох нь харагдаж байна.




Диаграмм 37. Хөдөө аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

Дээрх зургаас харахад хөдөө аж ахуй салбарын эдийн засагт эзлэх байр суурь буурч байгаа хэдий ч ДНБ-ий ихэнх хувийг бүрдүүлсэн хэвээр байна.

### 2.11.1.2 Хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал


**Хөдөө аж ахуйн салбарын ажиллах хүч:** 2016 оны байдлаар салбарын ажиллагсадын тоо 14.2 мян.хүн болж, өмнөх оноос 13.2 хувиар, 2009 онтой харьцуулахад 11.1 хувиар, 2009-2016 оны хооронд жилд дунджаар 1.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Мөн Завхан аймгийн нийт ажиллагсадын 47.8 хувийг хөдөө аж ахуйн салбарын ажиллагсад бүрдүүлж байна.



Диаграмм 38. Завхан аймгийн хөдөө аж ахуйн салбарын ажиллагсад

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн статистик мэдээ


**Малчин өрх болон малчдын тоо:** 2016 онд 8.8 мянган малчин өрхтэй болж, өмнөх онтой харьцуулахад өссөн хэдий ч, 2007 онтой харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.



Диаграмм 39. Завхан аймгийн малчин өрхий тоо

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

Дээрх диаграммаас харахад Монгол орны ихэнх нутгийг хамарсан 2009-2010 оны зуднаас эхлэн малчин өрхийн тоо буурсаар 2013 онд 7764 болтол буурсан хэдий ч, 2014 оноос эхлэн эргээд өссөөр 8.8 мянган малчин өрхтэй болсон байна. Харин малчдын тооны хувьд авч үзэхэд 2016 онд 16.9 мянга болж, өмнөх онтой харьцуулахад 5.5 хувиар өссөн хэдий ч, 2007 онтой харьцуулахад 28.6 хувиар буурсан байна. Энэ нь 2009-2010 оны байгалийн ган зуд зэрэг маш олон хүчин зүйлсээс хамааралтай. Малчдын тоог 1000 малчин өрхөд ногдох байдлаар авч үзэхэд 2016 онд 1926 малчин байгаа нь 2015 болон 2007 онтой харьцуулахад буурсан үзүүлэлт байна.




Диаграмм 40. Завхан аймгийн малчдын тоо

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

**Мал сүргийн тоо:** Завхан аймгийн нийт дүнгээр 2016 оны эцэст 3.4 сая толгой мал тоологдож, өнгөрсөн онтой харьцуулахад 8.7 хувиар, 2006 онтой харьцуулахад 33.5 хувиар тус тус өссөн байна. Энэ нь нэг талаас салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл өсөн нэмэгдэж байгааг, нөгөө талаас малын тооны

өсөлтөөс хамааран бэлчээрийн даац жил бүр нэмэгдэж байгааг харуулж байна. Мөн Монгол улсын нийт мал сүргийн 5.5 хувийг, баруун бүсийн мал сүргийн 22.5 хувийг тус тус бүрдүүлж байна. 2016 оны аймгийн мал сүргийн бүтцийг авч үзэхэд 5.5 хувийг адуун сүрэг, 0.2 хувийг тэмээн сүрэг, 5.1 хувийг үхэр сүрэг, 50.8 хувийг хонин сүрэг, 38.5 хувийг ямаан сүрэг тус тус бүрдүүлж байна.




Диаграмм 41. Завхан аймгийн мал сүргийн бүтэц

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

**Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл:** Салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн талаар албан ёсны статистик мэдээлэл хомс байсан тул ҮСХ-ноос батлагдсан аргачлалын дагуу аймгийн нийт дүнгээр малын ашиг шимийн зарим гол бүтээгдэхүүн (сүү бэлтгэл, ноос ноолуур) -ий үйлдвэрлэлийг тооцож харуулав.

**Мах бэлтгэл:** 2016 онд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ 69.8 тн болж, өмнөх оноос 29.8 тн буюу 1.7 дахин өссөн байна.

**Сүү бэлтгэл:** ҮСХ-ноос баталсан аргачлалын дагуу үхрийн сүү болон бөг малын сүү үйлдвэрлэлийг тооцож харуулав.




Диаграмм 42. Завхан аймгийн сүү бэлтгэл

Эх сурвалж: ҮСХ-ны аргачлалаар тооцож гаргасан үр дүн

**Ноос, ноолуур бэлтгэл:** ҮСХ-ноос баталсан аргачлалын дагуу ноос, ноолуурын үйлдвэрлэлийг тооцож харуулав.






Диаграмм 43. Завхан аймгийн ноос ноолуур бэлтгэл

Эх сурвалж: ҮСХ-ны аргачлалаар тооцож гаргасан үр дүн

**Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл:** 2016 оны байдлаар нийт 1.9 мянган га-д тариалалт хийсэн ба 40.4 хувь нь үр тариа, 11.1 хувь нь төмс, 5.8 хувь нь хүнсний ногоо, үлдсэн хувь нь тэжээлийн ургамал тариалсан талбай эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад үр тариа болон хүнсний ногоо тариалсан талбай буурсан, харин төмс болон тэжээлийн ургамал тариалсан талбай нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Харин хураан авсан ургацын хувьд 2016 онд нийт 610 тн үр тариа, 2317.2 тн төмс, 1269.5 тн хүнсний ногоо, 3077.1 тн тэжээлийн ургамал хураан авсан байна. Мөн 44.3 тн жимс, жимсгэнэ, тэжээлийн нэгжид шилжүүлсэнээр 12.9 тн малын тэжээл, 21.6 мянган тн өвс, хадлан бэлтгэсэн байна. Бэлтгэсэн малын тэжээлийн 14.6 хувийг гар тэжээл болон эрдэс тэжээл бүрдүүлж байна.




Диаграмм 44. Завхан аймгийн нийт хураан авсан ургац, ургамлын төрлөөр

Эх сурвалж: ҮСХ-ны статистикийн эмхэтгэл-2016

### 2.11.1.3 САЛБАРЫН ЗАРИМ ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ

ҮСХ-ноос баталсан хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал-ын дагуу салбарын зарим гол бүтээгдэхүүний хэрэгцээг жишсэн хүнд үндэслэн тооцож харуулав.



Диagramм 45. Салбарын зарим гол бүтээгдэхүүний хэрэгцээ

Эх сурвалж: УСХ-ны аргачлалаар тооцож гаргасан үр дүн

#### 2.11.1.4 Хөдөө аж ахуйн салбарын SWOT-АНР шинжилгээ

**Мал аж ахуйн салбар:** Мал аж ахуйн салбарын үр дүнд нөлөөлөх дотоод хүчин зүйлсийн давуу талыг илэрхийлэх 3, сул талыг илэрхийлэх 3, гадаад хүчин зүйлсийн таатай нөхцлийг илэрхийлэх 3, таагүй нөхцлийг илэрхийлэх 3, нийт 12 хүчин зүйлс (гол) -ийг сонгон авч, SWOT-АНР шинжилгээг хийв.

Хүснэгт 22. Мал аж ахуйн салбарын SWOT-АНР шинжилгээ

А.Дотоод хүчин зүйлс							Б.Гадаад хүчин зүйлс			
Давуу тал (S)			Сул тал (W)				Таатай нөхцөл (O)		Таагүй нөхцөл (T)	
I.Малын тэсвэрт чанар өндөр			IV.Нэгжийн ашиг шим багатай				I.Зах зээлийн эрэлт өндөр		IV.Өвөл-хавар өвс, тэжээл дутагдалтай	
II.Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг			V.Эрсдэлд өртөмтгий				II.Байршлын нягтрал бага		V.Бэлчээрийн усан хангамж сул	
III.Зардал харьцангуй хямд			VI.Менежмент сул				III.Нар, салхины эх үүсвэр сайтай		VI.Байгалийн нөхцөл, цаг уураас хамааралтай	
Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц										
PV	0.163	0.063	0.073	0.062	0.237	0.400				
№	I	II	III	IV	V	VI	PV	PA	PA/PV	
I	1	3	3	5	0.2	0.333	0.163	1.064	6.499	
II	0.333	1	1	0.333	0.2	0.333	0.063	0.392	6.219	
III	0.333	1	1	3	0.2	0.2	0.073	0.482	6.604	
IV	0.2	3	0.333	1	0.2	0.142	0.062	0.398	6.416	
V	5	5	5	5	1	0.2	0.237	1.654	6.960	
VI	3	3	5	7	5	1	0.400	2.945	7.359	
Нийлбэр	7.644	16	13.333	19.333	6.8	2.209	1	Lmax	6.676	
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.								CI	0.135	
								CR	0.109	
Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц										
PV	0.090	0.074	0.295	0.060	0.174	0.307				
№	I	II	III	IV	V	VI	PV	PA	PA/PV	
I	1	1	0.333	3	0.333	0.2	0.090	0.562	6.279	
II	1	1	0.333	1	0.2	0.333	0.074	0.459	6.233	
III	3	3	1	3	5	1	0.295	2.142	7.252	
IV	0.333	1	0.333	1	0.333	0.2	0.060	0.382	6.325	
V	3	5	0.2	3	1	0.333	0.174	1.153	6.639	
VI	5	3	1	5	3	1	0.307	2.094	6.812	
Нийлбэр	13.333	14.000	3.200	16.000	9.867	3.067	1	Lmax	6.590	
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.								CI	0.118	
								CR	0.095	

Эх сурвалж: Тооцож гаргасан үр дүн

Мал аж ахуйн салбарын дотоод хүчин зүйлийн нийцтэй байдлын харьцаа нь  $CR=0.109$ , гадаад хүчин зүйлийнх  $CR=0.095$  гарсан байна. SWOT-АНР шинжилгээний

дараагийн шатанд салбарын ойрын, дунд, хэтийн зорилтыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх явдал юм.

### МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ОЙРЫН ХУГАЦААНЫ ЗОРИЛТ (2018-2022)

- ✓ Монгол малын үүлдэр, омгийн цөм сүргийн аж ахуйг өргөжүүлж, удмын сангийн нөөцийг арвижуулах,
- ✓ Мал эмнэлэгийн үржлийн ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах,
- ✓ Малыг гаралт үүслийг тодорхой болгох,
- ✓ Бэлчээр эзэмшүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлэх,
- ✓ Малыг гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарт тохирсон үнэ, урамшууллын системийг нэвтрүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлж байна.

### МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТ (2023-2028)

- ✓ Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах орчинг боловсронгуй болгох,
- ✓ Бэлчээрийн даацад нийцүүлэн малын тоо толгойг өсгөх, сүргийн зохистой бүтцийг хангах замаар мал аж ахуйн салбарын үр ашгийг нэмэгдүүлэх,
- ✓ Ашиг шимийн тодорхой чиглэлээр мал үржүүлэгийн аж ахуй шинээр бий болгох, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх,
- ✓ Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйн чадавхыг хөгжүүлж, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх,
- ✓ Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагаанд тулгуурлан экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх,
- ✓ Бэлчээрийг зохистой ашиглах, бэлчээр, тэжээл, усан хангамж, хашааны хорооны чанарыг сайжруулах байдлаар учирч болох эрсдлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх зэрэг болно.

### МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ХЭТИЙН ЗОРИЛТ (2029-2033)

- ✓ Арвин ашиг шимт мал, амьтны үүлдэрлэг байдал, ашиг шимт чанарыг дээшлүүлэх, шинэ үүлдрийг бий болгох,
- ✓ Бэлчээр, хадланг зохистой ашиглах, хамгаалан сайжруулах, тэжээлийн таримлын төрөл, сортыг олшруулах, үрийн нөөцийг бий болгох, үйлдвэрийн аргаар бэлтгэх тэжээлийг нэмэгдүүлэх,
- ✓ Бэлчээрийн доройтол, цөлжилтийг сааруулахад чиглэсэн стратеги боловсруулж, цогц арга хэмжээ хэрэгжүүлэх эдгээр болно.

**Газар тариалангийн салбар:** Салбарын хөгжилд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг өмнөх аргачлалын дагуу дотоод, гадаад хүчин зүйлсээс хамааруулан нийт 12 үзүүлэлт сонгосон.

Хүснэгт 9. Газар тариалангийн салбарын SWOT-АНР шинжилгээ

А.Дотоод хүчин зүйлс					Б.Гадаад хүчин зүйлс				
Давуу тал (S)		Сул тал (W)			Таатай нөхцөл (O)		Таагүй нөхцөл (T)		
I.Хөрс боловсруулах зэрэг хүчир ажлууд механикжсан		IV.Га-гийн бүтээмж доогуур			I.Зах зээлийн эрэлт өндөр		IV.Цаг уурын эрсдэлтэй бүсэд оршдог		
II.Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг		V.Зардал өртөг их учраас үнэ өндөр			II.Засгийн Газрын дэмжлэг		V.Импортын хямд чанар муутай бүтээгдэхүүн		
III.Усалгаатай тариалан эрхлэх газрын дээрх усны нөөцтэй		IV.Хадгалах, дахин боловсруулах салбар муу хөгжсөн			III.Нар, салхины эх үүсвэр сайтай		VI.Орц импортоос хамааралтай		
Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц									
PV	0.279	0.154	0.105	0.178	0.202	0.079			
№	I	II	III	IV	V	VI	PV	PA	PA/PV
I	1	3	5	1	1	3	0.279	1.888	6.750

II	0.333	1	3	1	1	1	0.154	1.024	6.651
III	0.2	0.333	1	1	1	1	0.105	0.673	6.397
IV	1	1	1	1	1	3	0.178	1.159	6.486
V	1	1	1	1	1	5	0.202	1.318	6.511
VI	0.333	1	1	0.333	0.2	1	0.079	0.532	6.677
SUM	3.866	7.333	12	5.333	5.2	14	1	<b>Lmax</b>	6.579
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.								<b>CI</b>	0.115
								<b>CR</b>	0.093
<b>Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц</b>									
PV	0.296	0.154	0.203	0.132	0.127	0.087			
№	I	II	III	IV	V	VI	PV	PA	PA/PV
I	1	3	3	1	3	3	0.296	2.142	7.218
II	0.333	1	3	1	1	1	0.154	1.207	7.818
III	0.333	0.333	1	3	3	3	0.203	1.391	6.859
IV	1	1	0.333	1	1	1	0.132	0.864	6.539
V	0.333	1	0.333	1	1	3	0.127	0.841	6.637
VI	0.333	1	0.333	1	0.333	1	0.087	0.582	6.694
SUM	3.333	7.333	8	8	9.333	12	1	<b>Lmax</b>	6.961
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.								<b>CI</b>	0.192
								<b>CR</b>	0.155

*Эх сурвалж: Тооцож гаргасан үр дүн*

Дээрх хүснэгтээс харахад дотоод хүчин зүйлсийн нийцтэй байдлын харьцаа  $CR=0.093$ , гадаад хүчин зүйлсийн харьцаа  $CR=0.155$  гарсан.

### **ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ОЙРЫН ХУГАЦААНЫ ЗОРИЛТ (2018-2022)**

- ✓ Тариалангийн техникийн шинэчлэлийг хийх, техникийн бэлэн байдлыг дээшлүүлэх, нарийн ногооны тхеник хангамжийг дээшлүүлэх,
- ✓ Экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, янз бүрийн найрлагат химийн технологийн бодисын хэрэглээг бага түвшинд байлгах, шимт болон био бордооны хэрэглээг нэмэгдүүлэх,
- ✓ Усалгаатай талбай нийт тариаланд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар га-ийн ургацыг дээшлүүлэх зэрэг болно.

### **ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТ (2023-2028)**

- ✓ Ойрын хугацааны зорилтуудыг үргэлжүүлэн хэрэгжүүлэх,
- ✓ Дотоодод үйлдвэрлэж буй газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, импортын бүтээгдэхүүний хувь хэмжээнд төрөөс зохицуулалт хийх, аюулгүй байдалд хяналт тавих зэрэг болно.


### **ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТ (2029-2033)**

- ✓ Ойрын болон дунд хугацааны зорилтуудыг цаашид хэрэгжүүлэх,
- ✓ Аймгийн салбарын бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлагыг тогтмол хангаж, нэр төрлийн га-аас авах ургацыг нэмэгдүүлэх,
- ✓ Таримал тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэжээлийн шимт чанарыг дээшлүүлэх,
- ✓ Газар тариалангийн эрсдэлтэй бүс нутгийг чадавхыг дээшлүүлэх, төрөөс анхаарч ажиллах,
- ✓ Салбарын бүтээгдэхүүний нөөцийг хангалттай хэмжээнд бүрдүүлэх,
- ✓ Салбарын фермерийн аж ахуйн эрх зүйн статусыг бэхжүүлж, бэлчээрийн мал аж ахуйтай харилцан орших хууль эрх зүйн орчинг сайжруулах зэрэг болно.

## 2.11.2 Аж үйлдвэр, барилгын салбарын өнөөгийн байдал, эдийн засагт эзлэх байр суурь

### 2.11.2.1 Аж үйлдвэр, барилгын салбарын эдийн засагт эзлэх байр суурь

**Салбарын нэмэгдэл өртөг:** 2016 онд аймгийн ДНБ-ий 11.5 хувийг буюу 33.6 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртгийг аж үйлдвэр, барилгын салбараас бүрдүүлсэн байна. Салбарын нэмэгдэл өртөг 2010 оноос хойш жилд дунджаар 32.5 хувиар өсч байгаа нь, мөн жил бүрийн ДНБ-ий 10.6 хувийг тухайн салбарын нэмэгдэл өртөг тус тус бүрдүүлж байна. Энэ нь аж үйлдвэр, барилгын салбар хир зэрэг эрчимтэй хөгжиж байгааг, нөгөө талаар аймгийн эдийн засагт салбарын эзлэх байр суурь хэрхэн тэлж байгааг харж болно.




Диаграмм 46. Аж үйлдвэр, барилгын салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

Диаграммаас аж үйлдвэр, барилгын салбарын аймгийн эдийн засагт эзлэх байр суурь нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

### 2.11.2.2 Аж үйлдвэр, барилгын салбарын өнөөгийн байдал

**Салбарын ажиллах хүч:** 2016 оны байдлаар салбарын ажиллагсадын тоо 3.2 мян.хүн болж, өмнөх он болон 2009 онтой харьцуулахад 1.6 дахин өссөн, 2009-2016 оны хооронд жилд дунджаар 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн Завхан аймгийн нийт ажиллагсадын 10.8 хувийг аж үйлдвэр, барилгын салбарын ажиллагсад бүрдүүлж байна.



Диаграмм 47. Завхан аймгийн аж үйлдвэр, барилгын салбарын ажиллагсад

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн статистик мэдээ

**Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл:** 2016 оны байдлаар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 10.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 0.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Мөн оны нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 49.5 хувийг боловсруулах үйлдвэрлэл, үлдсэн хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж бүрдүүлж байна. Боловсруулах үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний ихэнх хувийг буюу 44.6 хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, 33.2 хувийг гутал, хувцасны үйлдвэрлэл эзлэж байна. Харин цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжны 27.6 хувийг цахилгааны үйлдвэрлэл, 61.1 хувийг дулааны үйлдвэрлэл, үлдсэн хувийг усан хангамжны үйлдвэрлэл бүрдүүлсэн байна.

**Барилгын салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл:** Аймгийн албан ёсны статистик мэдээгээр 2016 онд нийт 23.8 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн ба 32.1 хувийг хатуу хучилттай зам, 14.8 хувийг соёлын, 12.3 хувийг конторын, 6.8 хувийг далан, суваг, шугам, 6.3 хувийг цэцэрлэгийн барилга угсралт, их засварын ажил үйлчилгээ, үлдсэн хувийг бусад төрлийн ажил үйлчилгээ бүрдүүлж байна.

### 2.11.2.3 Салбарын зарим гол бүтээгдэхүүний хэрэгцээ

ҮСХ-ноос баталсан хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалын дагуу салбарын зарим гол бүтээгдэхүүний хэрэгцээг жишсэн хүнд үндэслэн тооцож, дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 23. Салбарын зарим гол бүтээгдэхүүний хэрэгцээ

Бүтээгдэхүүн	Аймгийн нийт хүн амын жилийн хэрэгцээ, мян.тн										
	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Сүүн бүтээгдэхүүн	5.19	5.22	5.03	4.92	4.72	4.65	4.58	4.59	4.57	4.61	4.65
Гурил, гурилан бүтээгдэхүүн	8.31	8.36	8.05	7.87	7.56	7.45	7.32	7.34	7.32	7.37	7.45
Хүнсний тос	0.65	0.65	0.63	0.61	0.59	0.58	0.57	0.57	0.57	0.57	0.58

Эх сурвалж: ҮСХ-ны аргачлалаар тооцож гаргасан үр дүн

Дээрх хүснэгтээс харахад эдгээр бүтээгдэхүүний хэрэгцээ 2006 оноос 2012 он хүртэл буурсан хэдий ч, 2013 оноос эргээд өсөх хандлагатай байна. Энэ нь эдгээр үечлэлээр хүн амын тоонд гарсан өөрчлөлттэй шууд холбоотой юм.

### 2.11.2.4 Аж үйлдвэрийн салбарын SWOT-АНР шинжилгээ

Салбарын үр дүнд нөлөөлөх дотоод хүчин зүйлсийн давуу талыг илэрхийлэх 2, сул талыг илэрхийлэх 3, гадаад хүчин зүйлсийн таатай нөхцлийг илэрхийлэх 4, таагүй нөхцлийг илэрхийлэх 3, нийт 12 хүчин зүйлс (гол) -ийг сонгон авч, SWOT-АНР шинжилгээг хийв.

Хүснэгт 24. Аж үйлдвэрийн салбарын SWOT-АНР шинжилгээ

Давуу тал	Сул тал
I. Газарзүйн баршлын хувьд Баруун аймгууд руу явах зам дагуу, ОХУ-руу гарах гарцтай тул үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гадаад, дотоод зах зээлд гаргах боломжтой.	III. Аймгийн 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн улсын дунджаас 100.0 мян төг-өөр бага байна.
II. Монгол улсын хэвтээ тэнхлэгийн мянганы замд холбогдож байгаа, найдвартай цахилгааны эх үүсвэрт бүх сумдууд холбогдсон.	IV. Боловсруулах үйлдвэр сул хөгжсөн V. Аймгийн хүн ам нь Монгол улсын нийт хүн амын 3 хувийг эзэлдэг хэдий ч улсын ДНБ-ий 1,6 хувийг үйлдвэрлэж байна.
Боломж	Эрсдэл
I. Баруун аймгууд руу явах улсын чанартай төв зам дайран өнгөрч байгаа тул анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрүүд хөгжих боломжтой.	V. Засгийн газрын түвшинд шийдвэрлэж чадахгүй бол мах экспортлох асуудал хэрэгжихгүй байх магадлалтай.
II. Арц суурийн боомтоор махыг экспортлох боломжтой.	VI. Яамнаас бодлогын чанартай баруун бүсийн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг цуглуулах, анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийг байгуулах ажлыг дэмжихгүй бол хөгжихгүй байх магадлалтай.
III. Нутгийн брэнд бүтээгдэхүүн улаан хальст сармис нь зах зээлд өндөр үнээр борлогддог тул түүнийг тариалж зах зээлд гаргах боломжтой.	VII. Шинээр хөгжих үйлдвэрүүдийн хог хаягдал, бохир усны асуудлыг ТЭЗҮ-ийн шатанд сайн төлөвлөхгүй бол
IV. Жимс жимсгэний нөөц ихтэй тул жимс боловсруулах үйлдвэр хөгжих боломжтой	

байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц										
PV	0.104	0.124	0.250	0.050	0.472					
№	I	II	III	IV	V	PV	PA	PA/PV		
I	1	1.000	0.333	3.000	0.200	0.104	0.555	5.319		
II	1.000	1	0.300	5.000	0.200	0.124	0.647	5.211		
III	3.000	3.333	1	5.000	0.333	0.250	1.383	5.534		
IV	0.333	0.200	0.200	1	0.200	0.050	0.254	5.101		
V	5.000	5.000	3.000	5.000	1	0.472	2.613	5.536		
Нийлбэр	10.333	10.533	4.833	19.000	1.933	1	<b>Lmax</b>	5.340		
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.							<b>CI</b>	0.085		
							<b>CR</b>	0.076		

Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц										
PV	0.178	0.046	0.162	0.110	0.230	0.049	0.225			
№	I	II	III	IV	V	VI	VII	PV	PA	PA/PV
I	1	5.000	1.000	3.000	0.333	3.000	1.000	0.178	1.351	7.609
II	0.200	1	0.333	0.333	0.200	1.000	0.333	0.046	0.343	7.388
III	1.000	3.000	1	3.000	1.000	3.000	0.333	0.162	1.261	7.783
IV	0.333	3.000	0.333	1	1.000	3.000	0.333	0.110	0.815	7.399
V	3.000	5.000	1.000	1.000	1	5.000	1.000	0.230	1.737	7.559
VI	0.333	1.000	0.333	0.333	0.200	1	0.333	0.049	0.366	7.452
VII	1.000	3.000	3.000	3.000	1.000	3.000	1	0.225	1.736	7.718
Нийлбэр	6.867	21.000	7.000	11.667	4.733	19.000	4.333	1	<b>Lmax</b>	7.558
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.							<b>CI</b>	0.093		
							<b>CR</b>	0.070		


### Хүснэгт 25. Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх үйл ажиллагааны стратеги

Хугацаа	Стратеги
Ойрын хугацааны (2018-2023)	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын давуу талуудад тулгуурлан гадаад орчны таатай нөхцлийг дээд зэргээр ашиглах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.</li> <li>Салбарын сул талуудыг сайжруулан гадаад орчны таатай нөхцлийг дээд зэргээр ашиглах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.</li> </ul>
Дунд хугацааны (2024-2029)	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын давуу талуудад тулгуурлан гадаад орчны таагүй нөхцлийн сөрөг нөлөөг бууруулах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.</li> </ul>
Хэтийн (2030-2033)	<ul style="list-style-type: none"> <li>Гадаад орчны таагүй нөхцөлд салбарын сул талуудыг сайжруулах замаар гарах сөрөг үр дагаварыг аль болох багасгах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.</li> </ul>

## 2.11.3 Үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, эдийн засагт эзлэх байр суурь

### 2.11.3.1 Үйлчилгээний салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Завхан аймгийн эдийн засгийн салбаруудаас үйлчилгээний салбар нь эдийн засагт тогтвортой байр суурийг хадгалсаар ирсэн салбар бөгөөд 2016 онд ДНБ-ий 42.6 хувийг буюу 124.5 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртгийг үйлчилгээний салбараас бүрдүүлсэн байна. Мөн үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг жилд дунджаар 17.7 хувиар өссөн ба жил бүрийн ДНБ-ий 42.8 хувийг (2007-2016 оны дунджаар) үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг бүрдүүлж байгаа нь аймгийн эдийн засагт тогтвортой байр суурь хадгалсаар ирсэн, ямар чухал салбар болохыг илэрхийлж байна.




Диаграмм 48. Үйлчилгээний салбарын эдийн засагт эзлэх байр суурь

Эх сурвалж: ҮСХ-ны 2016 оны статистикийн эмхэтгэл

Дээрх зургаас харахад үйлчилгээний салбарын эдийн засагт эзлэх байр суурь 2014 онд хамгийн доод цэгтээ хүрч, 2015 оноос эргээд өсч байгаа бөгөөд ДНБ-ний ихэнх хувийг бүрдүүлсэн хэвээр байна.

### 2.11.3.2 Үйлчилгээний салбарын өнөөгийн байдал

**Үйлчилгээний салбарын ажиллах хүч:** 2016 оны байдлаар салбарын ажиллагсадын тоо 12.3 мян.хүн болж, өмнөх оноос 7.2 хувиар өссөн, харин 2009 онтой харьцуулахад 8.7 хувиар буурсан, 2009-2016 оны хооронд жилд дунджаар 1.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн Завхан аймгийн нийт ажиллагсадын 41.4 хувийг үйлчилгээний салбарын ажиллагсад бүрдүүлж байна.



Диаграмм 49. Завхан аймгийн үйлчилгээний салбарын ажиллагсад

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн статистик мэдээ

### 2.11.3.3 Үйлчилгээний салбарын SWOT-АНР шинжилгээ

**Аялал жуулчлалын салбар:** Аялал жуулчлалын салбарын үр дүнд нөлөөлөх дотоод хүчин зүйлсийн давуу талыг илэрхийлэх 4, сул талыг илэрхийлэх 4, гадаад хүчин зүйлсийн таатай нөхцлийг илэрхийлэх 4, таагүй нөхцлийг илэрхийлэх 4, нийт 16



хүчин зүйлс (гол) -ийг сонгон авч, SWOT-АНР шинжилгээг аялал жуулчлалын салбарт тулгуурлан хийв.

Хүснэгт 26. Үйлчилгээ (Аялал жуулчлал) -ний салбарын SWOT-АНР шинжилгээ

А. Дотоод хүчин зүйлс		Б. Гадаад хүчин зүйлс	
Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл (O)	Таагүй нөхцөл (T)
I. Үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалт газрууд, геологийн өвөрмөц тогтоц бүхий газрууд, эмчилгааны рашаан, агнуурын ач холбогдолтой болон ховор ан амьтан ургамалын нөөцтэй.	V. Орон нутгийн иргэд жуулчдад үйлчлэх, аялал жуулчлал эрхлэх талаар ойлголт муу байна.	I. Хутагтуудын төрсөн газар, түүх археологийн үнэт олдворууд, эртний сүм хийдийн туурийг түшиглэн соёл, танин мэдэхүйн аялал жуулчлал хөгжүүлэх боломж байна.	V. Жуулчны бааз, ангийн отог, амралт сувилалын газруудын тоог нэмэгдүүлэхгүй бол байгаль орчин бохирдох эрсдэлтэй.
II. Орон нутгийн иргэд нүүдлийн зан үйл, уламжлалт ёс заншлаа хадгалан үлдсэн.	VI. Жуулчдын амрах бааз, амралтын газар цөөн байна.	II. Өндөр уул, гол, нууруудыг түшиглэн спортын аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.	VI. Менежментийн буруу бодлого, хэт ачааллаас үүдэн, түүхийн үнэт олдвор, дурсгалт зүйлсүүд сүйдэх
III. Аймгийн нутаг дэвсгэр нь уул уурхайд хөндөгдөөгүй, эрүүл, унаган дүр төрхөө хадгалан үлдсэн байна.	VII. Дэд бүтэц, зам харилцаа муу хөгжсөн.	III. Байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн эко аялал жуулчлал хөгжүүлэх	VII. Уур амьсгалын хувьд эрт цас орох, цочир хүйтрэл, зуд болох магадлал өндөр
IV. ОХУ-руу гарах боомттой. /Арц суурийн боомт/	VIII. Эрт хүйтэрч, орой дулаарах тул аялал жуулчлалын улирал богино	IV. Жуулчдын урсгалыг Завхан аймаг руу татах боломжтой.	VIII. Жуулчдын замбараагүй байдлаас ой түймэрт өртөх магадлалтай.

Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц											
PV	0.108	0.278	0.096	0.208	0.124	0.063	0.034	0.089			
№	I	II	III	IV	V	VI	VII	VIII	PV	PA	PA/PV
I	1	0.200	1.000	0.333	1.000	3.000	3.000	3.000	0.108	1.011	9.371
II	5.000	1	3.000	1.000	3.000	5.000	7.000	3.000	0.278	2.505	9.006
III	1.000	0.333	1	0.333	1.000	3.000	3.000	1.000	0.096	0.870	9.029
IV	3.000	1.000	3.000	1	1.000	3.000	5.000	3.000	0.208	1.848	8.898
V	1.000	0.333	1.000	1.000	1	3.000	5.000	1.000	0.124	1.076	8.700
VI	0.333	0.200	0.333	0.333	0.333	1	1.000	3.000	0.063	0.599	9.494
VII	0.333	0.143	0.333	0.200	0.200	1.000	1	0.333	0.034	0.301	8.917
VIII	0.333	0.333	1.000	0.333	1.000	3.000	3.000	1	0.089	0.798	8.926
Нийлбэр	12.000	3.543	10.667	4.533	8.533	22.000	28.000	15.333	1	<b>Lmax</b>	9.043
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.										<b>CI</b>	0.149
										<b>CR</b>	0.106
Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц											
PV	0.181	0.045	0.041	0.043	0.227	0.123	0.196	0.145			
№	I	II	III	IV	V	VI	VII	VIII	PV	PA	PA/PV
I	1	3.000	3.000	3.000	0.200	0.333	3.000	3.000	0.181	1.676	9.267
II	0.333	1	1.000	1.000	0.333	0.333	0.200	0.333	0.045	0.393	8.759
III	0.333	1.000	1	1.000	0.200	0.333	0.200	0.333	0.041	0.363	8.831
IV	0.333	1.000	1.000	1	0.333	0.333	0.200	0.200	0.043	0.373	8.781
V	5.000	3.000	5.000	3.000	1	3.000	1.000	1.000	0.227	2.308	10.177
VI	3.000	3.000	3.000	3.000	0.333	1	0.333	0.333	0.123	1.240	10.109
VII	0.333	5.000	5.000	5.000	1.000	3.000	1	1.000	0.196	1.638	8.362
VIII	0.333	3.000	3.000	5.000	1.000	1.000	1.000	1	0.145	1.221	8.406
Нийлбэр	10.667	20.000	22.000	22.000	4.400	9.333	6.933	7.200	1	<b>Lmax</b>	9.086
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.										<b>CI</b>	0.155
										<b>CR</b>	0.110

Эх сурвалж: Тооцож гаргасан үр дүн

Хүснэгт 27. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх үйл ажиллагааны стратеги

Хугацаа	Стратеги
Ойрын хугацааны (2018-2023)	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын давуу талуудад тулгуурлан гадаад орчны таатай нөхцлийг дээд зэргээр ашиглах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.</li> <li>Салбарын сул талуудыг сайжруулан гадаад орчны таатай нөхцлийг дээд зэргээр ашиглах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.</li> </ul>
Дунд хугацааны (2024-2029)	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын давуу талуудад тулгуурлан гадаад орчны таагүй нөхцлийн сөрөг нөлөөг бууруулах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.</li> <li>Гадаад орчны таагүй нөхцөлд салбарын сул талуудыг сайжруулах замаар гарах сөрөг үр дагаварыг аль болох багасгах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.</li> </ul>
Хэтийн (2030-2033)	

#### **2.11.4 Нийгэм, эдийн засгийн хэрэгцээ**

Ажлын даалгаврын дагуу газар төлөвлөлтөнд тооцож үзэх дараахь үндсэн хэрэгцээнүүдийг тооцлоо. Үүнд:

1. Хүн амын төрийн болон төрийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээ
  - Сургуулийн хэрэгцээ
  - Цэцэрлэгийн хэрэгцээ
  - Эмнэлэгийн хэрэгцээ
  - Халуун усны хэрэгцээ
2. Амины болон нийтийн орон сууцны хэрэгцээ
  - Амины орон сууцны хэрэгцээ
  - Нийтийн орон сууцны хэрэгцээ
3. Ажлын байрны хэрэгцээ
  - Хөдөө аж ахуйн салбар дахь ажлын байрны хэрэгцээ
  - Аж үйлдвэрийн салбар дахь ажлын байрны хэрэгцээ
  - Аялал жуулчлалын салбар дахь ажлын байрны хэрэгцээ
  - Дуд бүтцийн салбар дахь ажлын байрны хэрэгцээ
  - Төрийн үйлчилгээний салбар дахь ажлын байрны хэрэгцээ
4. Хүнсний хэрэгцээ
  - Мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээ
  - Сүү, сүүн бүтээгдэхүүнийн хэрэгцээ
  - Гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээ
  - Төмс, хүнсний ногооний хэрэгцээ
  - Жимс жимсгэний хэрэгцээ
  - Хүнсний тосны хэрэгцээ
  - Өндөгний хэрэгцээ
5. Мод, модон эдлэлийн хэрэгцээ
6. Хадлан, малын тэжээлийн хэрэгцээ
7. Худаг, усан сангийн хэрэгцээ
8. Газар өмчлүүлэх хэрэгцээ
9. Ан амьтаны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хэрэгцээ

№	Үзүүлэлт	Өнөөдөр	Төлөвлөлтийн хугацаа					
			Ойрын (2018-2022)		Дунд (2023-2028)		Хэтийн (2029-2033)	
			Жилд дунджаар	Нийт	Жилд дунджаар	Нийт	Жилд дунджаар	Нийт
<b>1</b>	<b>Хүн амын төрийн болон төрийн үйлчилгээний байгууллагын хэрэгцээ</b>							
<b>1,1</b>	<b>Ерөнхий боловсролын сургуулийн хэрэгцээ</b>							
1.1.1	Ерөнхий боловсролын сургуулийн тоо	30	1-2	7	1	5	2	11
1.1.2	Нэгжийн үнэ, сая.төг		13000	13000	13000	13000	13000	13000
1.1.3	Нийт дүн, тэрбум.төг		18,2	91	10,83	65	28,6	143
<b>1,2</b>	<b>Цэцэрлэгийн хэрэгцээ</b>							
1.2.1	Цэцэрлэгийн тоо	43	3	16	2	12	1-2	9
1.2.2	Нэгжийн үнэ, сая.төг		5700	5700	5700	5700	5700	5700
1.2.3	Нийт дүн, тэрбум.төг		18,24	91,2	11,4	68,4	10,26	51,3
<b>1,3</b>	<b>Эмнэлэгийн хэрэгцээ</b>							
1.3.1	Эмнэлэгийн тоо	27	1	3	1	6	2-3	14
1.3.2	Нэгжийн үнэ, сая.төг		1400	1400	1400	1400	1400	1400
1.3.3	Нийт дүн, тэрбум.төг		0,75	3,7435	1,4	8,4	3,92	19,6
<b>1,4</b>	<b>Халуун усны хэрэгцээ</b>							
1.4.1	Халуун усны тоо		1	6	1	7	2	9
1.4.2	Нэгжийн үнэ, сая.төг		15	15	15	15	15	15
1.4.3	Нийт дүн, тэрбум.төг		0,02	0,09	0,02	0,11	0,03	0,14
<b>2</b>	<b>Амины болон нийтийн орон сууцны хэрэгцээ</b>							
<b>2,1</b>	<b>Амины орон сууц</b>							
2.1.1	Аймгийн нийт өрх гэр	21 078	23841	143049	27526	165156	30597	122386
2.1.2	Амины орон сууцны хэрэгцээ, өрхөөр (нийт өрхийн 5%)	1054	1192	7152	1376	8258	1530	6119
<b>2,2</b>	<b>Нийтийн орон сууц</b>							
2.2.1	Аймгийн нийт өрх гэр	21 078	23841	143049	27526	165156	30597	122386
2.2.2	Нийтийн орон сууцны хэрэгцээ, өрхөөр (нийт өрхийн 10%)	2108	2384	14305	2753	16516	3060	12239
<b>3</b>	<b>Ажлын байрны хэрэгцээ</b>							
<b>3,1</b>	<b>Хөдөө аж ахуйн салбар</b>							
3.1.1	Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын тоо		17,236	1377	10,821	1897	11,087	3429
3.1.2	Аж үйлдвэрийн салбарт ажиллагсадын тоо		1235,6	525	495,1	245	495,1	260

3.1.3	Аялал жуулчлалын салбарт ажиллагсадын тоо		1,281	31	1,697	39	2,197	50
3.1.4	Дэд бүтцийн салбарт ажиллагсадын тоо		941,6	375	277,9	255	1446,8	255
3.1.5	Төрийн үйлчилгээний байгууллагад ажиллагсадын тоо	2777	186,2	930	129,0	648	214,0	1358
<b>4</b>	<b>Хүн амын хүнсний хэрэгцээ</b>							
4,2	Мах, махан бүтээгдэхүүн, мян.тн	4,65	5,27	31,59	6,08	36,47	6,76	27,03
	Сүү, мян.тн	3,49	3,95	23,72	4,56	27,38	5,07	20,29
	Сүүн бүтээгдэхүүн, мян.тн	4,65	5,27	31,59	6,08	36,47	6,76	27,03
	Гурил, гурилан бүтээгдэхүүн, мян.тн	7,45	8,42	50,55	9,73	58,36	10,81	43,25
	Төмс, мян.тн	3,26	3,69	22,11	4,26	25,53	4,73	18,92
	Хүнсний ногоо, мян.тн	4,65	5,27	31,59	6,08	36,47	6,76	27,03
	Жимс, жимсгэнэ, мян.тн	4,19	4,74	28,43	5,47	32,83	6,08	24,33
	Хүнсний тос, мян.тн	0,58	0,66	3,94	0,76	4,55	0,84	3,37
	Өндөг, мян.тн	0,44	0,50	2,99	0,57	3,45	0,64	2,55
<b>5</b>	<b>Мод, модон эдлэлийн хэрэгцээ</b>							
5,1	Аймгийн нийт өрх гэр	21078	23841	143049	2 526	165156	30597	122386
5,2	Нэг өрхийн хэрэгцээ, мян.төг	500,0	500,0	500,0	1000,0	1000,0	1000,0	1000,0
5,3	Нийт хэрэгцээ, сая.төг	10539,0	11920,7	71524,3	27526,0	165156,2	3 596,5	122386,1
<b>6</b>	<b>Хадлан, малын тэжээлийн хэрэгцээ</b>							
6,1	Тэжээлийн хэмжээ, мян.тн	24,52		3902		3980,04		2926,5
<b>7</b>	<b>Худаг, усан сангийн хэрэгцээ</b>							
<b>7,1</b>	<b>Худаг</b>							
7.1.1	Тоо хэмжээ		17	101	18	105	26	105
7.1.2	Нэгжийн үнэ, сая.төг		16,0	16,0	16,0	16,0	16,0	16,0
7.1.3	Нийт дүн, тэрбум.төг		0,27	1,62	0,28	1,68	0,42	1,68
<b>7,2</b>	<b>Хөв цөөрөм</b>							
7.2.1	Тоо хэмжээ		2	10	2	11	3	11
7.2.2	Нэгжийн үнэ, сая.төг		150,0	150,0	150,0	150,0	150,0	150,0
7.2.3	Нийт дүн, тэрбум.төг		0,25	1,50	0,28	1,65	0,41	1,65
<b>7</b>	<b>Газар өмчилж авах хэрэгцээ</b>							
7,1	Иргэний тоо	8821	3877	19385	3877	23262	3877	19385
7,2	Өмчлөлийн хувь, %	12,45	6,78	33,9	5,6	33,6	5,32	26,6
7,3	Газрын хэмжээ, га	1112,498	271,39	1356,95	271,39	1628,34	271,39	1356,95
<b>8</b>	<b>Ан, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хэрэгцээ</b>							
<b>8,1</b>	<b>Эмчилгээний зориулалттай ан, амьтдын түүхий эдийн хэрэгцээ</b>							
8,2	Хүн амын тоо	70852	80141	623895	92527	555159	66722	411391
8,3	Нийт хүн амын 1 хувиар	709	801	6239	925	5552	667	4114

	Чононы хэл, кг	70,9	80,1	623,9	92,5	555,2	66,7	411,4
	Чононы мах, кг	70,9	80,1	623,9	92,5	555,2	66,7	411,4
8,4	Нийт хүн амын 0.5 хувиар	354	401	3119	463	2776	334	2057
	Туулайны тос, мах, өөх, кг	17,7	20,0	156,0	23,1	138,8	16,7	102,8
	Үнэгний нүд, хос ш	354	401	3119	463	2776	334	2057
8,5	Бусад ан, амьтдын хувьд	хориотой						

## 2.12 ГАЗАР АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


### 2.12.1 Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл

2016 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 6990227,32 га буюу 84.7 хувийг, хот тосгон бусад суурин газар нь 18851,9 га буюу 0,22 хувь, ойн сан бүхий газар нь 490562 га буюу 5,9 хувь, усны сан бүхий газар 80536 га буюу 0,97 хувь, зам шугам сүлжээний газар 6502,9 га буюу 0,07 хувь, тусгай хэрэгцээний газар нь 658886,5 га буюу 7,9 хувийг тус тус эзэлж байна.




Диаграмм 50. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал

2011 оны газрын нэгдмэл сангийн тайлангийн дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 3315,2 га-аар буурч, хот тосгон бусад суурины газар 3097 га-аар нэмэгдсэн ба ойн сан бүхий газар 167,5 га-аар буурсан, усны сан бүхий газар нь 509 га-аар хасагдаж, шугам сүлжээний газар 894,3 га-аар нэмэгдэж, улсын тусгай хэрэгцээний газар нь өөрчлөлт ороогүй байна.



Диаграмм 51. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын талбайн өөрчлөлт /2011-2016/



Зураг 3. Завхан аймгийн газрын нэгдмэл сангийн зураг

Хүснэгт 28. Завхан аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллын талбайн өөрчлөлт, га-аар

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2011 он	2016 он	Зөрүү
<b>I</b>	<b>Хөдөө аж ахуйн газар</b>	6993542.5	6990227.3	-3315.2
1	Бэлчээрийн газар	6917293,6	6923782,04	6491.44
2	Хадлангийн талбай	7758,5	7676	-82.5
3	Тариалангийн талбай	1756,7	2535.71	779.01
4	Атаршсан газар	62138,5	52843.1	-9295.4
5	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	4595	3390,47	1204.5
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	0	0	0
<b>II</b>	<b>Хот тосгон бусад суурины газар</b>	15754.6	18851.9	3097.3
7	Барилга байгууламжийн дэвсгэр газар	860.3	196.9	-663.4
8	Нийтийн эдэлбэр газар	13643.9	13936	292.1
9	Үйлдвэрийн газар	67	67.4	0.4
10	Уурхайн газар	10	2906.9	2896.9
11	Гэр хорооллын газар	1179.2	1744.6	565.4
<b>III</b>	<b>Зам шугам сүлжээний газар</b>	5608.6	6502.9	894.3
12	Авто замын газар	4822.2	4726.5	-95.7
13	Төмөр замын газар	0	0	0
14	Агаарын тээврийн газар	64	206	142
15	Шугам сүлжээний газар	722.4	1570.3	847.9
16	Усан тээврийн буудлын газар	0	0	0
<b>IV</b>	<b>Ойн сан бүхий газар</b>	490729.5	490562	-167.5
17	Ой модоор бүрхэгдсэн газар	463235	464057	822
18	Ой модыг нь огтолсон газар	5039	5067	28
19	Мод үржүүлгийн газар	50.5	63	12.5
20	Ой тэлэн ургах нөөц газар	0	270	270

21	Ойн сангийн бусад газар	22405	21105	1300
V	<i>Усны сан бүхий газар</i>	81045	80536	-509
22	Гол мөрний эзлэх газар	51045	51045	0
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	30000	29491	-509
24	Горхи, булаг, шандны эзлэх газар	0	0	0
25	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	0	0	0
VI	<i>Улсын тусгай хэрэгцээний газар</i>	658886.5	658886.5	0
26	Улсын тусгай хамгаалалттай газар	581369	581369	0
27	Улсын хилийн зурвас газар	8950	8950	0
28	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	0	0	0
29	ШУ, туршиот, цаг уурын ажиглалтын талбай	72	72	0
30	Аймаг дундын отрын бэлчээр	68300	68300	0
31	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	0	0	0
32	Газрын тосны гэрээт талбай	0	0	0
33	Чөлөөт бүсийн газар	0	0	0
<b>НИЙТ ДҮН</b>		<b>8245566.7</b>	<b>8245566.7</b>	<b>0</b>


### 2.12.2 Хөдөө аж ахуйн газар

Хөдөө аж ахуйн газар 6990227.3 га буюу нутаг дэвсгэрийн 84,7 хувийг эзэлж байна. Хөдөө аж ахуйн газарт бэлчээрийн газар нь 6923782,04 га буюу 99 хувь, хадлангийн газар 7676 га буюу 0,1 хувь, тариалангийн газар 2535.71 га буюу 0,03 хувь, атаршсан газар 52843.1 га буюу 7,5 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 3390,47 га буюу 0,04 хувийг тус тус үзүүлж байна.

Хүснэгт 29 Хөдөө аж ахуйн газрын өөрчлөлт /га/


№	ХАА-н газрын төрөл	2011 он	2016 он	Зөрүү
1	Бэлчээрийн газар	6917293,6	6923782	6488.4
2	Хадлангийн талбай	7758,5	7676	-82.5
3	Тариалангийн талбай	1756,7	2535.71	779
4	Атаршсан газар	62138,5	52843.1	-9295.4
5	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	4595	3390,4	-1204.6
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	0	0	0
<b>Нийт хөдөө аж ахуйн газар</b>		<b>6993542,5</b>	<b>6990227,3</b>	<b>-3315.2</b>

Харин ХАА-н газрын ангилалд багтах бэлчээр нь нийт нутаг дэвсгэрийн 83,9 хувийг, хадлангийн газар 0,09 хувь, тариалангийн газар 0,30 хувь, атаршсан газар нь 0,64 хувь, ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар 0,04 хувийг тус тус 2016 оны байдлаар эзэлж байна.



Диаграмм 52. Бэлчээрийн газрын талбайн өөрчлөлт





Диаграмм 53. Хөдөө аж ахуйн бусад газрын өөрчлөлт

Бэлчээрийн газар нь 2011 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 6488.4 га-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 30 Бэлчээрийн дэд ангилалын талбайн өөрчлөлт /га/

№	Бэлчээрийн газрын дэд ангилал	Талбай, га		
		2011 он	2016 он	Зөрүү
1	Өвөл хаврын бэлчээр	3812929.5	3819326.60	-6397.1
2	Зун намрын бэлчээр	3104364.1	3104455.4	91.3
3	Аймаг дундын отрын бэлчээр	68300	68300	0.00
4	Өвөлжөө хаваржааны доорхи газар	4595	3390.47	-1204.6
<b>Нийт бэлчээрийн газар</b>		<b>6990188.6</b>	<b>6995472.4</b>	<b>7510.4</b>

Дээрх хүснэгтээс харахад 2011 оноос хойш өвөл хавар намрын бэлчээр 6397,1 га буюу 0,1 хувиар буурсан бол зун намрын бэлчээр 91,3 га буюу 0,002 хувиар нэмэгдсэн, өвөлжөө хаваржааны доорхи газар нь 1204,6 га буюу 26,2 хувиар буурсан байна.

Хадлангийн газар нь 2011 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 7758,5 га байснаас 2016 он хүртэлх хугацаанд 82.5 га хасагдсан байна.

Тариалангийн газар: Тариалангийн газар нь 2011 он тайлангийн дүнтэй харьцуулахад 779 га-аар нэмэгдсэн байна.

Тус аймгийн газрын нэгдмэл сангийн 2011 оны тайлангаас харахад нийт нутаг дэвсгэрийн маш бага буюу 0,09 хувийг тариалангийн газар эзэлж байна. Тариалангийн газрын 2016 оны ангилалын төрөл хэмжээг хүснэгтэнд дэлгэрэнгүйгээр харуулав.

Хүснэгт 31 Тариалангийн газрын дэд ангиллын талбайн өөрчлөлт /га/

№	Тариалангийн газрын төрөл	Талбай, га		
		2011 он	2016 он	Зөрүү
1	Үр тариалсан талбай	275.5	125,50	-150
2	Төмс хүнсний ногоо тариалсан талбай	904.07	1046,24	+142.17
3	Тэжээлийн ургамал тариалсан талбай	286.2	836,41	-550.21
4	Таримал ургамал, жимс жимсгэнэ тариалсан талбай	0	90,16	+90.16
5	Уриншилсан талбай	62	60	-2
6	Өнжөөсөн талбай	229	377,40	+148.4
7	Атаршсан газар	62138.5	52843,10	-9295.4
<b>Нийт</b>		<b>63895.27</b>	<b>2535,71</b>	<b>-61359.56</b>


Дээрх хүснэгтээс харахад нийт тариалангийн талбайн 4,9 хувь нь үр тариа тариалсан талбай, 41,2 хувь нь төмс хүнсний ногоо тариалсан талбай, 2,3 хувь нь уриншилсан талбай, 14,8 хувь нь өнжөөсөн талбай, 0,75 хувь нь атаршсан талбай тус тус эзэлж байна. Диаграммаас харахад 2011 оны нь 1808,2 га байсан ба 2016 оны тариалангийн газар 2535,71 га болж нэмэгдсэн буюу 0,7 хувиар өссөн байна.

### 2.12.3 Хот тосгон бусад суурины газар

Хот, тосгон бусад суурины газар 1885,9 га буюу нийт нутаг дэвсгэрийн 0,02 хувийг эзэлж байна. Хот, тосгон бусад суурины газарт барилга, байгуулалмжийн дэвсгэр газар 196,9 га буюу 0,002 хувийг, нийтийн эдэлбэр газар 13936 га буюу 0,16 хувийг, үйлдвэрийн газар 67,4 га буюу 8,1 хувийг, уурхайн газар 2906,9 га буюу 0,03 хувийг, гэр хорооллын газар 1744,6 га буюу 0,02 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 32. Хот тосгон бусад суурин газрын талбайн өөрчлөлт /га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2011 он	2016 он	Зөрүү
1	Барилга байгууламжийн дэвсгэр газар	860.3	196.9	-663.4
2	Нийтийн эдэлбэр газар	13643.9	13936	292.1
3	Үйлдвэр газар	67	67.4	0.4
4	Уурхайн газар	10	2906.9	-2896.9
5	Гэр хорооллын газар	1173.2	1744.6	571.4
<b>Нийт хот тосгон бусад суурин газар</b>		<b>15754.6</b>	<b>18851.9</b>	<b>-3097.3</b>



Диаграмм 54. Хот тосгон бусад суурин газрын талбайн өөрчлөлт

Хот тосгон бусад суурины газрын талбай нь 5 жилийн хугацаанд 16,4 хувиар нэмэгдсэн бөгөөд барилга байгууламжийн дэвсгэр газар 77,1 хувиар буурсан бол нийтийн эдэлбэрийн газар 2 хувиар нэмэгдсэн бол гэр хорооллын газар нь 32,7 хувиар нэмэгдсэн бол үйлдвэрийн газар нь 0,5 хувиар нэмэгдэж уурхайн газар нь 99,6 хувиар огцом өссөн байна.

Хот тосгон бусад суурины газрыг дэд ангилалуудаар харвал барилга байгууламжийн газрын 68,2 хувийг иргэн, аж ахуй нэгж байгууллагын өмчлөл, эзэмшил ашиглалтанд байгаа барилга байгууламжийн доорхи газар эзэлж, үлдсэн хувийг амралт рашаан сувилалын газар эзэлж байна.

Нийтийн эдэлбэр газрын 86,8 хувийг эзэмшил ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар эзэлж байгаа бол үлдсэн хувийг иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн бус амралт зугаалга биеийн тамирын зориулалттай цэцэрлэгт хүрээлэнгийн газар гудамж, талбай замын газар, цэвэрлэх байгууламжийн талбай, оршуулгын газар, хог хаягдлын газар эзэлж байна.

#### 2.12.4 Зам, шугам сүлжээний газар


Зам, шугам сүлжээний газар нь 6502,9 га буюу нийт нутаг дэвсгэрийн 0,07 хувийг эзлэх бөгөөд 2011 он тоотой харьцуулахад 894,3 га-аар нэмэгдсэн байна.

Зам, шугам сүлжээний газарт авто замын газар нь нийт 4726,5 га буюу 72,6 хувийг, агаарын тээврийн газар 206 га буюу 3,1 хувийг, шугам сүлжээний газар 1570,3 га буюу 24,1 хувийг тус тус эзэлж байна. Усан тээвэр болон төмөр замын газар нь тус аймагт одоогоор байхгүй байна.

Хүснэгт 33 Зам, шугам сүлжээний газрын ангиллын өөрчлөлт /га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2011 га	2016 га	Зөрүү
1	Авто замын газар	4822.2	4726.5	-95.7
2	Агаарын тээврийн газар	64	206	142
3	Шугам сүлжээний газар	722.4	1570.3	847.9
<b>Нийт зам шугам сүлжээний газар</b>		<b>5608.6</b>	<b>6502.9</b>	<b>894.3</b>

Жил тутам нэмэгдэж байгаа дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалтуудыг дагаад зам, шугам сүлжээний газарын хэмжээ мөн адил өсөн нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд авто зам, шугам сүлжээний газрын хэмжээ тогтмол нэмэгдэж ирсэн нь тус салбар дахь бүтээн байгуулалт болоод тухайн газруудыг холбогдох журмын дагуу газрын улсын бүртгэлд бүртгэж, хариуцах эзэнтэй болсонтой холбоотой юм.



Диаграмм 55. Зам шугам сүлжээний газрын талбайн өөрчлөлт


2011 онд 46% байсан бол 2016 онд 54% болж өссөн буюу 8%-иар нэмэгдсэн байна. График 10-аас харахад 2011 оны байдлаар авто замын газар 86%-ийг, агаарын тээврийн газар 1%, шугам сүлжээний газар 15%-ийг тус тус эзэлж байсан бол 2016 оны байлаар авто замын газар 73% /8%-иар буурсан/, агаарын тээврийн газар 3% /2%-иар нэмэгдсэн/, шугам сүлжээний газар 24% /9%-иар нэмэгдсэн/.

## 2.12.5 Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газар 490562 га буюу нийт нутаг дэвсгэрийн 5,9 хувийг эзэлж байна. Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 464057 га буюу 94,5 хувийг, ойн модыг нь огтолсон газар 5067 га буюу 1 хувийг, мод үржүүлгийн газар 63 га буюу 0,01 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 270 га буюу 0,05 хувийг, ойн сангийн бусад газар 21105 га буюу 4,3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 34. Ойн санг бүхий газрын өөрчлөлт /га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2011	2016	Зөрүү
1	Ой модоор бүрхэгдсэн газар	463235	464057	822
2	Ой модыг нь огтолсон газар	5039	5067	28
3	Мод үржүүлгийн газар	50.5	63	12.5
4	Ой тэлэн ургах нөөц газар	0	270	270
5	Ойн сангийн бусад газар	22405	21105	-1300
<b>Ойн сан бүхий газар</b>		<b>490729.5</b>	<b>490562</b>	<b>-167.5</b>



	2011 он	2016 он
■ Ой модоор бүрхэгдсэн газар	463235	464057
■ Ой модыг нь огтолсон газар	5039	5067
■ Мод үржүүлгийн газар	50,5	63
■ Ой тэлэн ургах нөөц газар	0	270
■ Ойн сангийн бусад газар	22405	21105

Диаграмм 56. Ойн сан бүхий газрын талбайн өөрчлөлт

Тус хүснэгтээс харахад ойн сан бүхий газар нь 2016 оны байдлаар 490563,06 га ба 2011 оны байдлаар 490729,5 га болсон байна. Харин 2011-2016 оны хоорондохь 5 жилийн хугацаанд тус аймгийн ойн сан бүхий газар нь 167,44 га-гаар буюу 0,03%-иар хасагдсан байна.


## 2.12.6 Усны сан бүхий газар

Усны сан бүхий газар 80536 га буюу нийт газар нутгийн 1 хувийг эзэлж байна. Усны сан бүхий газарт мөрөн, гол горхи 51045 га буюу 63,3 хувийг, нуур цөөрөм 29491 га буюу 36,6 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 35. Усны сан бүхий газрын өөрчлөлт /га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2011	2016	Зөрүү
1	Гол мөрний эзлэх газар	51045	51045	0
2	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	30000	29491	-509

3	Горхи, булаг, шандны эзлэх газар	0	0	0
4	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	0	0	0
<b>Усны сан бүхий газар</b>		<b>81045</b>	<b>80536</b>	<b>-509</b>



Дээрх хүснэгтээс харахад гол мөрний эзлэх талбайд өөрчлөлт ороогүй ба нуур, тойрмын эзлэх талбай нь 5 жилийн дотор -509 га-гаар буюу 0,63 хувиарсан буурсан байна.

Диаграммаас харахад 2011-2016 оны хооронд гол мөрөний газар нь өөрчлөлт ороогүй байна. Харин нуур цөөрөм, тойрмын газарт 509 га газар хасагдсан байна.

Диаграмм 57. Усны сан бүхий газрын дэд ангилалын талбайн өөрчлөлт

### 2.12.7 Улсын тусгай хэрэгцээний газар

Улсын тусгай хэрэгцээний нийт газрын хэмжээ 658886,5 га буюу нийт нутаг дэвсгэрийн 8 хувийг эзэлж байна.

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 581369 га буюу 88,2 хувийг, улсын хилийн зурвас газар 8950 га буюу 1,3 хувийг, Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 195,5 га буюу 0,02 хувийг, шинжлэх ухаан технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 72 га буюу 0,01 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 68300 га буюу 10,3 хувийг тус тус эзэлж байна. Тус аймагт гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгийн газар болон улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, газрын тосны гэрээт талбай, чөлөөт бүсийн газрууд нь байдаггүй байна.

Хүснэгт 36 Улсын тусгай хэрэгцээний газрын өөрчлөлт /га/

№	Газрын нэгдмэл сангийн дэд ангилал	2011он	2016он	Зөрүү
1	Улсын тусгай хамгаалалттай газар	581369	581369	0
2	Улсын хилийн зурвас газар	8950	8950	0
3	Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	195.5	195.5	0
4	Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар	0	0	0
5	Шинжлэх ухаан технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	72	72	0
6	Аймаг дундын отрын бэлчээр	68300	68300	0
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	0	0	0
8	Газрын тосны гэрээт талбай	0	0	0
9	Чөлөөт бүсийн газар	0	0	0
<b>Улсын тусгай хэрэгцээний газар</b>		<b>658886.5</b>	<b>658886.5</b>	<b>0</b>

## ГУРАВ. ЗАВХАН АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН НӨӨЦ, НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### 3.1 ГАЗАР БҮРХЭВЧИЙН АНГИЛАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Завхан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний бэлчээрийн газрыг төлөвлөх гол зорилго нь газрын бүрхэвч болон бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээнд тулгуурлан мал сүргийн зохистой бүтцийг бий болгох боломжийг судлахад оршино.

Тус ажилд орон зай, цаг хугацааны шийдийн хувьд дунд зэргийн нарийвчлалтай, байгаль орчны судалгаанд түгээмэл хэрэглэгддэг Landsat хиймэл дагуулын мэдээллийг Завхан аймгийн газрын бүрхэвчийн ангилал хийхэд ашигласан.

Газрын бүрхэвчийн ангилал хийхдээ Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн байгалийн бүс бүслүүрт тулгуурласан ангиллын системийг ашиглан хийсэн.

Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийж зураглахдаа 2015 он ГХГЗЗГ-аас гаргасан арга зүйн дагуу малын идэмж, бүс бүслүүр, газрын гадарга, налуу, чулуулаг, бут сөөг гэх мэт хүчин зүйлүүдээр малын 5 төрөл тус бүр дээр үнэлгээ өгч, бэлчээрт тохиромжтой байдлыг 1-5 баллаар үнэлж, нэн тохиромжтой, тохиромжтой, дунд зэргийн тохиромжтой, тохиромж муутай, бэлчээрт ашиглах боломжгүй гэсэн ангиллаар үнэлгээний зураглал үйлдсэн.

Мал сүргийн бүтцийг гаргахдаа 2006, 2016 оны Завхан аймгийн малын тоог авч газарзүйн мэдээллийн системийг ашиглан картодиаграммын аргаар малын тоо толгойг малын төрлөөр дүрслэн харуулав.

Газрын бүрхэвч болон бэлчээрийн газрын тохиромжтой байдалд тулгуурлан орон зайн шинжилгээний давхцуулах аргаар Завхан аймгийн мал сүргийн бүтцийн чиг хандлагыг тодорхойлон гаргасан.

Завхан аймгийн газрын бүрхэвчийн ангиллыг ландсат хиймэл дагуулын 2000 болон 2015 оны мэдээг ашиглан хамгийн бага зайн ангиллын аргаар 19 ангид ангилсан.


Газрын бүрхэвчийн өөрчлөлтийн дүнгээс харахад жинхэнэ хээр 1154906 га, сөөгт хээр 1225 га-аар хасагдаж, хуурай хээр 663350 га, цөлийн хээр 345175 га, цөл 2825 га-аар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 37 . Аймгийн газрын бүрхэвчийн өөрчлөлт


Анги	Газрын бүрхэвчийн ангиллын нэр	Талбай га-аар (2015)	Талбай га-аар (2000)	2000-2015 оны өөрчлөлт (га-аар)
1	Мөнх цас, мөсөн гол	106.25	2518.75	-2413
2	Өндөр уулын ян сарьдаг	38887.5	39037.5	-150
3	Өндөр уулын нуга ба хээр	860056.25	473775	386281
4	Мөнх ногоон ой	150	0	150
5	Шилмүүст болон навчит ой	195612.5	140156.25	55456
6	Жинхэнэ хээр	4610868.75	5765775	-1154906
7	Сөөгт хээр	873293.75	874518.75	-1225
8	Хуурай хээр	2872993.75	2209643.75	663350

9	Цөлийн хээр	2979793.75	2634618.75	345175
10	Заримдаг цөл	225356.25	327437.5	-102081
11	Цөл	30200	27375	2825
12	Нүцгэрсэн газар	3212.5	13375	-10163
13	Элс	1134893.75	1355068.75	-220175
14	Гол хөндийн нуга, шугуй	40675	21637.5	19038
15	Тариалангийн газар (уринш)	62887.5	65681.25	-2794
16	Тариалангийн газар	68475	39812.5	28663
17	Тариалангийн газар (атаршсан)	11631.25	27631.25	-16000
18	Хот тосгон	368.75	87.5	281
19	Нуур гол	90350	81662.5	8688

Зургийн боловсруулалтын хувьд суурь нөхцөлийн үнэлгээг хийсний дараа газарзүйн мэдээллийн системийн дүн шинжилгээний аргаар олон шалгуур үзүүлэлт тус бүрийн нөлөөллийг харуулсан бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зургуудыг малын 5 төрлөөр хийсэн. Олон шалгуурт дүн шинжилгээнд хүчин зүйлүүдийн жинлэсэн утгыг тодорхойлж, орон зайн шинжилгээний давхцуулах аргаар тохиромжтой байдлын үнэлгээний нэгдсэн зургийг боловсрууллаа.



Зураг 31. 2000 оны газрын бүрхэвчийн ангилал



Зураг 32. 2015 оны газрын бүрхэвчийн ангилал

Газар бүрхэвчийн ангилалын өөрчлөлтөөр “Жинхэнэ хээр” гэсэн ангилалын газар 1,1 сая талбайгаар багассан бөгөөд “хуурай хээр”, “цөлийн хээр” гэсэн ангилал 1 сая га талбайгаар нэмэгдсэн дүр төрх ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь уур амьсгалын дулаарлын нөлөөгөөр хуурайшиж байгааг илтгэж байна. Энэхүү өөрчлөлтөд хамгийн ихээр нэрвэгдэж байгаа газар нутгаар Баянтэс сумын нутаг дэвсгэр гарсан бөгөөд харин говийн сумдын нөхцөл байдал эсрэгээрээ эерэг нөлөө үзүүлсэн байна. Иймд ялангуяа ойт хээрийн бүсэд газар ашиглалтын эрчмийг зохистой ашиглалтын түвшинд барих нь нэн тэргүүний бодлого юм.

### 3.2 БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН НӨӨЦ, НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах баримт бичигт “уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлж, хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх”-ээр тусгасан нь Монгол улсын энэхүү салбарын цаашдын чиг хандлагыг тодорхойлж өгсөн байна.

Монголчууд олон мянган жилийн турш нутаг бэлчээрийг мал аж ахуйд улирлаар тохируулан нүүдэллэн маллаж, ирсэн дэлхийн цөөн улс үндэстний нэг билээ. Манай нутаг бэлчээр бол монгол улс, түүний язгуур аж ахуй болох мал сүргийн оршин хөгжих үндэс юм. Өөрөөр хэлбэл монгол малын идэш тэжээлийн эх булаг бэлчээр байдаг учраас ургац нь шинэчилэгдсэн, сайн бэлчээрийг даган нүүдэллэж байгаль орчиндоо халгүй, хямд өртөгтэй экологийн цэвэр бүтээгдэхүүнийг өнөөг хүртэл хэрэглэж ирсэн улс юм.



Газрын менежментийн томоохон салбар хэсгийн төлөөлөл болох бэлчээрийн менежмент, удирдлага, зохицуулалт нь бэлчээрийн нөөцийг ашиглах, сэргээн сайжруулах, хамгаалахад чиглэгдсэн цогц үйл ажиллагааг өөртөө багтаадаг.

Сүүлийн жилүүдэд бэлчээрийн зориулалтын газрын нөөц байнга багасахын зэрэгцээ бэлчээрийн төлөв байдал, чадавхийн үнэлгээ буурч, бэлчээрийн доройтол цаашид улам эрчимжих төлөв байдал харагдаж байна. Малын өсөлтийг зохистой арга замаар зохицуулах, тоо толгойг тогтвортой түвшинд барих бодлого, зах зээлийн зарчимд нийцсэн урамшуулал байхгүй учраас эрсдлээс хамгаалах, орлогоо нэмэгдүүлэхийн тулд зөвхөн малын тоо толгойг өсгөх өрөөсгөл хандлага давамгайлж, улмаар малын тоо жил бүр нэмэгдсээр бэлчээрийн даац хэтэрч, мал сүргийн бүтэц алдагдаж байна. Иймээс бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээнд тулгуурласан мал сүргийн бүтцийн чиг хандлагыг тодорхойлох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

### 3.2.1 Бэлчээрийн газар ашиглалтын өнөөгийн байдал

ХАА-н газрын ангилалд багтах бэлчээр нь нийт нутаг дэвсгэрийн 83,9 хувийг, хадлангийн газар 0,09 хувь, тариалангийн газар 0,30 хувь, атаршсан газар нь 0,64 хувь, ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар 0,04 хувийг тус тус 2016 оны байдлаар эзэлж байна.

Хүснэгт 38. Аймгийн ХАА-н газрын өөрчлөлт

№	Газрын ангилал	2011 он	2016 он	5 жилийн өөрчлөлт
1.	Бэлчээр	6917456,1	6923782,04	6325,94
2.	Хадлан	7853.5	7676	-177.5
3.	Тариалан	1808.2	2535.71	727.51
4.	Атаршсан газар	61924.5	52843.1	-9081.4
5.	ХАА-н барилга байгууламжийн дэвсгэр газар	4498,1	3390,47	-1107,36
<b>Бүгд</b>		<b>6993540.4</b>	<b>6990227,32</b>	<b>-17419,71</b>

Дээрх хүснэгтээс харахад ХАА-н газар ашиглалтад ХАА-н барилга байгууламжийн талбай, хадлангийн газар багассан үзүүлэлттэй гарч байгаа бөгөөд энэ нь МАА-н үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг удаашралтай, дан ганц байгалийн бэлчээр хэлбэрээр ашиглаж байгааг илэрхийлж байна.

Завхан аймгийн ХАА-н үйлдвэрлэлийн өнөөгийн байдал сул хөгжилтэй бөгөөд бүх бүс нутагт уламжлалт МАА-н салбар эдийн засагт жин дарах хэлбэрээр хөгжсөн байна.

Хүснэгт 39. Аймгийн ХАА-н үйлдвэрлэл, төрөлжилт

№	Сумын нэр	УМАА	Сүү	Жимс	Үр тариа	Тэжээл	Ногоо	Загас
1	Улиастай							
2	Алдархаан							
3	Асгат							
4	Баянтэс							
5	Баянхайрхан							
6	Дөрвөлжин							
7	Завханмандал							
8	Идэр							
9	Их Уул							
10	Нөмрөг							
11	Отгон							
12	Сантмаргац							

13	Сонгино						
14	Тосонцэнгэл						
15	Түдэвтэй						
16	Тэлмэн						
17	Тэс						
18	Ургамал						
19	Цагаанхайрхан						
20	Цагаанчулуут						
21	Цэцэн-Уул						
22	Шилүүстэй						
23	Эрдэнэхайрхан						
24	Яруу						

Бэлчээрийн менежментийн олон улсын төслүүд болон байгаль орчны чиглэлээр судалгаа хийдэг байгууллагуудын мэдээллээр Завхан аймгийн бэлчээрийн газрын 67% буюу 4,6 сая бэлчээр байгалийн унаган төрхөөсөө ямар нэгэн хэмжээгээр өөрчлөгдөж доройтсон гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Бэлчээрийн мал аж ахуйн нийгэмлэгүүд хязгаарлагдмал, хувьсамтгай, урьдчилан тааварлашгүй байгалийн нөөцийн хомсдол (жишээлбэл, нүүдлийн мал аж ахуй эрхлэх замаар) дасан зохицох стратегиудыг боловсруулсан боловч хүн ам зүйн дарамт, газар тариалангийн хөрсний өөрчлөлтөөс үүдэн гарч буй өөрчлөлтөд эмзэг байдал, уур амьсгалын өөрчлөлт, хур тунадас, гангийн хэлбэлзэл нь бэлчээрийн асуудлуудыг улам хүндрүүлж байна.


Завхан аймгийн газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлын тайлан 2011, Бэлчээрийн менежментийн ногоон алт төслийн судалгаа 2017, Ус цаг уур орчны шинжилгээний газрын бэлчээрийн ургацын мэдээ 2017, Ургамал хамгааллын хүрээлэнгийн үлийн цагаан оготны тархалтын судалгаа 2017 зэргийг нэгтгэн бэлчээрийн доройтлын төлөв байдлын зураглалыг газарзүйн мэдээллийн системийн программ хангамжийн тусламжтайгаар боловсрууллаа.

Завхан аймгийн бэлчээрийн газрын төлөв байдлыг судлан үзэхэд бэлчээрийн талхлагдал болон бэлчээрийн хортон мэрэгчдийн нөлөөгөөр доройтсон газар нутаг дийлэнхи хувийг эзэлж байна.

Хүснэгт 40. Завхан аймгийн бэлчээрийн доройтлын төлөв байдал

№	Сумын нэр	Бэлчээрийн төлөв байдал (га-аар)					
		Бэлчээрийн талхлагдал	Хортон мэрэгчид	Элсний нүүлт	Автоген	Гуу жалга үүссэн	Усны эвдрэл үүссэн
1	Их Уул	40389.9	108058.7	10.6	1076.6	0	0
2	Тосонцэнгэл	85405.1	143747.8	0	0	0	0
3	Тэлмэн	190189.0	178194.8	0	0	0	0
4	Идэр	144568.3	80986.6	0	0	0	0
5	Отгон	169903.9	134764.8	0	0	0	0
6	Нөмрөг	177622.8	137173.1	0	0	0	0
7	Цагаанхайрхан	149274.8	90486.8	48697.6	0	0	0
8	Яруу	82342.1	146370.8	27415.4	1796.2	0	0
9	Шилүүстэй	215762.6	234158.9	0	0	0	0
10	Цагаанчулуут	137362.7	182129.6	518.8	0	0	0
11	Баянтэс	73218.7	48582.2	0	0	0	0
12	Асгат	0.0	35099.3	0	0	0	0
13	Баянхайрхан	77175.4	65606.0	0	0	0	0
14	Алдархаан	98582.8	139521.8	57466.7	3838.77	0	0

15	Түдэвтэй	75501.2	85435.5	0	0	0	0
16	Сонгино	33663.9	79900.6	0	0	0	0
17	Эрдэнэхайрхан	108579.9	129596.4	41157.33	906.39	210.22	0
18	Тэс	16286.8	3923.4	0	0	0	0
19	Сантмаргац	38038.5	57881.0	49884.72	0	512.69	0
20	Завханмандал	128798.5	2416.9	7427.23	0	0	0
21	Дөрвөлжин	188138.7	0.0	110207.06	0	988.51	3433.32
22	Ургамал	140216.9	2649.5	34555.92	0	1225.57	0
23	Цэцэн-Уул	11844.1	91851.2	43388.81	1597.76	0	0
<b>ДҮН</b>		<b>2382866.5</b>	<b>2178535.7</b>	<b>420730.2</b>	<b>9215.7</b>	<b>2937.0</b>	<b>3433.3</b>




Зураг 33. Завхан аймгийн бэлчээрийн газрын төлөв байдал

Бэлчээрийн доройтолд өртөж их бага хэмжээгээр талхлагдалын зэрэгт орсон бэлчээрийн хэмжээ 2.4 сая газарт хүрсэн байгаа бөгөөд цаашид малын тоог бэлчээрийн даацад тохируулан бэлчээрийн менежментийн алтан дүрэм /үл хэтрүүлэх, үл шавхах, сэлгэн амрах/ -ийг мөрдлөг болгохгүйгээр уламжлалт МАА-н салбарын байгаль цаг уураас хамааралтай эрсдэлд өртөмтгий байдал үлэмж хэмжээгээр нэмэгдэхэд хүрээд байна.

Мал сүргийн дарамтыг ихэсгэснээр бэлчээрийн менежмент муудаж хуурай газраас ихээхэн хэмжээний нүүрстөрөгч алдагдаж байна. Доройтлын улмаас хуурай газрын хөрс нүүрстөрөгчинд нэвчих чадваргүй бөгөөд нүүрстөрөгчийг саармагжуулах боломж нь маш өндөр байдаг. Сайжруулсан бэлчээрийн менежмент нь дэлхий дээр 1 300-2 000 сая тонн CO<sub>2</sub>eq-ийг даруй 2030 он хүртэл үргэлжлэх биофизикийн хүчин чадалтай (Tennigkeit and Wilkes, 2008). Талбай дахь нүүрстөрөгчийн агууламжийг нэмэгдүүлэх стратеги нь хөрсний органик биологи, хөрсний биомассыг нөхөн сэргээх, улмаар хөрсний биотехнологийг сайжруулах (жишээ нь сайжруулсан буурцаг, өвс

ногоо тарих, бордоо, agroforestry зэрэг нөхөн сэргээлт, элэгдлийг хянах, нөхөн сэргээх, ой нөхөн сэргээх, малын нягтралыг оновчтой болгох, усны хамгаалал ургац хураах, газар тариалан гэх мэт газар ашиглалтын өөрчлөлт, өвс ургамал, мод бэлтгэх гэх мэт). Гэсэн хэдий ч хуурайшилтын нүүрстөрөгчийг шингээх чадварын талаарх мэдлэг, жижиг хэмжээний хөдөөгийн фермерүүд, малчдад зориулсан нүүрстөрөгчийн аргаар боловсруулсан аргын зардал, үр ашгийн дүн шинжилгээний талаархи мэдлэг дутмаг байна.




Диаграмм 58. Завхан аймгийн бэлчээрийн доройтлын төлөв байдал, 2016 он

Завхан аймгийн нутаг дэвсгэрт мал бэлчээрлэхэд зориулалттай газар 83,5%-ийг эзлэх бөгөөд хангай, хээр, говь хосолсон өвөрмөц тогтоц бүхий нутаг дэвсгэр болно. Завхан аймгийн бэлчээр нь хөрс, температур, усны хүртээмжтэй холбоотой хязгаарлалтын улмаас биомасс үйлдвэрлэх хүчин чадал бага байдаг.

Ургамалжил нь гол төлөв өвс, бут, мод зэрэг олон наст, жил бүрийн ургамлын бүлгэмдэлд давамгайлдаг. Тэдний шинж чанараар бэлчээр нь эмзэг экосистем бөгөөд буруу менежмент нь доройтолд хүргэж, биологийн олон янз байдлын алдагдал, ус хадгалах чадавхи, нүүрстөрөгчийн ялгаралт, бүтээмж буурах зэрэгт хүргэдэг.

Монгол орны бэлчээрт 103 овог, 620 шахам төрөлд хамаарагдах бөгөөд 2500 орчим ургамал ургаж 200 гаруй хэв шинжийг бүрдүүлж байдаг байна. (Монгол орны малын тэжээл 2011)

Экосистемийн функц, биологийн олон янз байдлыг хадгалахад нөлөөлж буй хувь нэмэр чухал ач холбогдолтой. Малын тэжээлээр хангахын зэрэгцээ тэдгээр нь зэрлэг амьтдын амьдрах орчны нэгэн адил чухал үүрэг гүйцэтгэдэг, усыг хадгалах, ургамлын генетикийн нөөцийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Бэлчээрийн ургамлууд нь асар их баялаг бөгөөд ойролцоогоор 750 төрөл зүйл, 12 000 өвс ургамал дэлхийд байна. Эдгээр экосистем нь амьтны аймгийг хамгаалахад чухал үүрэгтэй. Тухайлбал, тал хээрт дэлхийн шувууны талбайн 11 хувийг эзэлдэг (White et al., 2000: 40), мөн чухал зохицуулалтын үүрэгтэй тоос дарагч, бусад шавьжийг хамгаалахад хувь нэмэр оруулдаг. Экосистемийн ашиг тус, ялангуяа усны нэвчилт, ариутгал, цаг уурын зохицуулалт (жишээ нь нүүрстөрөгчийг шингээх), тоосжилтын зохицуулалт зэрэг нь эдийн засгийн үнэ цэнийг тогтоож, хөгжиж буй болон хөгжиж буй орнуудын аль алиных нь системтэй мэдээллийн системтэй байх нь дэлхийн тэргүүлэх ач холбогдолтой байх ёстой.



Зураг 34 . Өвөл хаврын бэлчээрийн багтаамж, сумаар

Завхан аймгийн хувьд бэлчээрийн багтаамж өндөртэй сумдад Отгон, Цагаанхайрхан, Алдархаан, Яруу, Сантмаргац, Их уул сумд бол говийн бүсэд багтах Дөрвөлжин, Завханмандал, Эрдэнэхайрхан, Ургамал зэрэг сумд бэлчээрийн багтаамж багатай байгаа нь дээрх зургаас харагдаж байна. Иймд малын тоо толгойн өсөлтийг хязгаарлах бодлогыг эхний ээлжинд бэлчээрийн багтаамж бага бүс нутгаас эхэлж авч хэрэгжүүлэх нь илүү ач холбогдолтой

Хүснэгт 41. Аймгийн бэлчээрийн багтаамж

№	Сумын код	Сумын нэр	Талбай, га	Дундаж ургац, цн	Бэлчээрийн багтаамж, хонин толгойгоор, өвөл-хавар
1	81010	Их-Уул	148176.35	5.17	175207.81
2	81030	Тосонцэнгэл	153570.79	3.23	121704.67
3	81050	Тэлмэн	200084.30	2.44	120272.93
4	81060	Идэр	111141.07	2.69	73048.43
5	81070	Отгон	477716.75	2.25	210972.23
7	81110	Нөмрөг	141755.08	2.61	94500.41
8	81120	Цагаанхайрхан	191011.99	4.17	165315.25
9	81130	Яруу	355436.09	1.68	134307.1
10	81140	Шилүүстэй	247014.01	2.00	83383.48
11	81150	Цагаанчулуут	150180.70	3.21	97778.88
12	81160	Баянтэс	94629.80	3.40	70205.05
13	81170	Асгат	16988.75	3.16	12432.14
14	81180	Баянхайрхан	118113.14	3.47	76459.06
15	81190	Алдархаан	365395.82	2.93	230331.42
16	81210	Түдэвтэй	115844.33	2.68	79697.82

17	81230	Сонгино	152721.91	3.25	91456.26
18	81240	Эрдэнэхайрхан	241962.51	1.95	88801.98
19	81250	Тэс	35888.52	4.72	32536.96
20	81260	Сантмаргац	171968.35	3.19	99033.85
21	81270	Завханмандал	133388.30	1.22	28485.79
22	81280	Дөрвөлжин	221063.89	1.11	45155.73
23	81290	Ургамал	198910.17	2.12	76332.79
24	83220	Цэцэн-Уул	137673.87	1.96	53572
<b>Нийт</b>			<b>4180636.49</b>	<b>2.81</b>	<b>2260992.04</b>

Завхан аймгийн хэмжээнд 12,9 мянган малтай өрх үүнээс 8,8 мянган малчин өрх буюу 55.1 мянган хүн амьжиргаагаа залгуулж байна.

Аймгийн нийгэм эдийн засгийн мэдээллээс харахад Завхан аймгийн хувьд мал бүхий өрхөөс малын хөлийн татвар авдаггүй бөгөөд малчин өрх, мал бүхий өрхүүдийн малын тоог нарийвчлан гаргаж мал бүхий өрхийг татварын системд холбох нь зүйтэй байна.


Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны тайлан, бэлчээрийн фотомониторингийн тайлан, ус цаг уурын хүрээлэнгийн хэмжилтийн цэгийн утгыг ашиглан бэлчээрийн багтаамжийг тодорхойлоход Завхан аймгийн Дөрвөлжин, Алдархаан, Цагаанхайрхан, Отгон, Их-Уул сумдын бэлчээр багтаамж өндөртэй буюу ачаалал авах чадвартай бүс нутаг гэж ойлгож болохоор байна. Харин Тэс, Асгат, Идэр, Цэцэн уул сумд бэлчээрийн багтаамж багатай буюу бэлчээрийн ургац бага бүс нутаг байна.



Зураг 35 . Завхан аймгийн бэлчээрийн нийт багтаамжийн үнэлгээний зураг

2016 оны статистикийн малын тооны мэдээгээр бэлчээр ашиглалтын эрчмийг тодорхойлоход Асгат, Тэс, Завханмандал, Идэр, Шилүүстэй сумд байх ёстой


малын тооноос хамгийн ихээр хэтэрсэн буюу 3 дахин хэтэрсэн үзүүлэлттэй гарч байна.



Зураг 36. Завхан аймгийн бэлчээрийн даацын үнэлгээний зураг

### 3.2.2 Завхан аймгийн бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

ГХГЗЗГ-ын 2015 оны “Тохиромжтой байдлын үнэлгээ хийх арга зүйн заавар, шалгуур үзүүлэлтүүд”-д бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд уур амьсгалын нөхцөл, өндөршилт, уул нуруудын байршил, өвс ургамлын шинж чанар, талхлалт, өвчин хортонд нэрвэгдсэн байдал, хад асга, бут сөөг зэрэг ашиглахад бэрхшээл учруулах зүйлүүд зэрэг хүчин зүйлүүдийг харгалзахаар тусгажээ.




Зураг 37. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний загвар

Дээрх аргачлалаар зун намрын улиралд Завхан аймгийн адуунд тохиромжтой бэлчээрийг GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд Баянтэс, Сонгино, Түдэвтэй, Нөмрөг, Тэлмэн, Яруу, Алдархаан сумдын нутаг дэвсгэр бусад сумдаас илүү нөхцөл сайтай, тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь нь өндөр байна.

Хүснэгт 42. Зун намрын улиралд адуунд тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	134,9	1,6
3	Дунд зэргийн тохиромжтой	2	1126,6	13,5
4	Тохиромжтой	3	2392,2	28,7
5	Нэн тохиромжтой	4	3307,2	39,7
	<b>ДҮН</b>		<b>8245,6</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харахад зун намрын улиралд адуунд тохиромжтой газар нутгийн хэмжээ 68,4% буюу 5,7 сая га бэлчээр нутаг Завхан аймгийн хэмжээнд гарч ирж байна.




Зураг 38. Адуунд тохиромжтой бэлчээр, зун намрын улиралаар

Харин өвөл хаврын улиралд Завхан аймгийн адуунд тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд нэн тохиромжтой бүс нутгийн хэмжээ үлэмж багасан 1,5 сая га талбай болон даруй 50 орчим хувь буурч байна. Аймгийн нутаг дэвсгэрийн 58,6% буюу 4,8 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд аймгийн хэмжээнд жигд тархалттай байна.



Хүснэгт 43. Өвөл хаврын улиралд адуунд тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	236,7	2,9
3	Дунд зэргийн тохиромжтой	2	1836,2	22,0
4	Тохиромжтой	3	3351,8	40,2
5	Нэн тохиромжтой	4	1536,3	18,4
<b>ДҮН</b>			<b>8245,6</b>	<b>100</b>




Зураг 39. Адуунд тохиромжтой бэлчээр, өвөл хаврын улиралаар

Завхан аймгийн хонинд тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд зун намрын улиралд нутаг дэвсгэрийн 73.4 % буюу 6,1 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд аймгийн хэмжээнд жигд тархалттай байна.

Хүснэгт 44. Зун намрын улиралд хонинд тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	177,5	2,1
3	Дунд зэргийн тохиромжтой	2	665,6	8,0
4	Тохиромжтой	3	1895,4	22,8
5	Нэн тохиромжтой	4	4208,6	50,6
<b>ДҮН</b>			<b>8245,6</b>	<b>100</b>




Зураг 40. Хонинд тохиромжтой бэлчээр, зун намрын улиралаар

Завхан аймгийн хонинд тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд өвөл хаврын нутаг дэвсгэрийн 73.4 % буюу 6,1 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд аймгийн хэмжээнд жигд тархалттай байна.

Хүснэгт 45. Өвөл хаврын улиралд хонинд тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	254,6	3,1
3	Дунд зэргийн тохиромжтой	2	1159,4	13,9
4	Тохиромжтой	3	3218,6	38,6
5	Нэн тохиромжтой	4	2328,4	27,9
<b>ДҮН</b>			<b>8245,6</b>	<b>100</b>




Зураг 41. Хонинд тохиромжтой бэлчээр, өвөл хаврын улиралаар

Завхан аймгийн тэмээнд тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд зун намрын бэлчээр нийт нутаг дэвсгэрийн 45,4 % буюу 3,8 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд Ургамал, Дөрвөлжин сумдын нутаг дэвсгэр таатай, Алдархаан, Шилүүстэй, Цагаанчулуут сумдын өмнөд хэсгээр хэсэгчилсэн тохиромжтой байна.

Хүснэгт 46 . Зун намрын улиралд тэмээнд тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	546,9	6,6
3	Дунд зэргийн тохиромжтой	2	2626,8	31,5
4	Тохиромжтой	3	2774,1	33,3
5	Нэн тохиромжтой	4	1013,1	12,1
	<b>ДҮН</b>		<b>8245,6</b>	<b>100</b>




Зураг 42. Тэмээнд тохиромжтой бэлчээр, зун намрын улиралаар

Завхан аймгийн тэмээнд тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS программ хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд өвөл хаврын нутаг дэвсгэрийн 35,2 % буюу 2,9 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд Ургамал, Дөрвөлжин, Завханмандал сумдын нутаг дэвсгэр таатай, Алдархаан, Шилүүстэй, Цагаанчулуут, Эрдэнэхайрхан сумдын өмнөд хэсгээр хэсэгчилсэн тохиромжтой байна.

Хүснэгт 47.Өвөл хаврын улиралд тэмээнд тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	1646,9	23,4
3	Дунд зэргийн тохиромжтой	2	2073,9	24,9
4	Тохиромжтой	3	1841,9	22,1
5	Нэн тохиромжтой	4	1098,3	13,1
<b>ДҮН</b>			<b>8245,6</b>	<b>100</b>




Зураг 43. Тэмээнд тохиромжтой бэлчээр, өвөл хаврын улиралаар

Завхан аймгийн Үхэрт тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд зун намрын бэлчээр нийт нутаг дэвсгэрийн 65,6 % буюу 5,4 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд аймгийн хэмжээнд жигд тархалттай байна.

Хүснэгт 48. Зун намрын улиралд үхэрт тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	132,9	1,6
3	Дунд зэргийн тохиромжтой	2	1358,9	16,3
4	Тохиромжтой	3	2662,7	31,9
5	Нэн тохиромжтой	4	2806,5	33,7
	<b>ДҮН</b>		<b>8245,6</b>	<b>100</b>




Зураг 44. Үхэрт тохиромжтой бэлчээр, зун намрын бэлчээр

Завхан аймгийн үхэрт тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд өвөл хаврын бэлчээр нийт нутаг дэвсгэрийн 73.4 % буюу 6,1 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд аймгийн хэмжээнд жигд тархалттай байна.

Хүснэгт 49. Өвөл хаврын улиралд үхэрт тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	269,6	3,2
3	Дунд зэргийн тохиромжтой	2	2220,8	26,7
4	Тохиромжтой	3	2718,6	32,6
5	Нэн тохиромжтой	4	1752,0	21,0
<b>ДҮН</b>			<b>8245,6</b>	<b>100</b>




Зураг 45. Үхэрт тохиромжтой бэлчээр, өвөл хаврын улиралаар

Завхан аймгийн ямаанд тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд зун намрын бэлчээр нийт нутаг дэвсгэрийн 74.3 % буюу 6,1 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд аймгийн хэмжээнд жигд тархалттай байна.

Хүснэгт 50. Зун намрын улиралд ямаанд тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	177,5	2,1
3	Дунд зэргийн тохиромжтой	2	594,4	7,1
4	Тохиромжтой	3	1960,1	23,6
5	Нэн тохиромжтой	4	4213,0	50,7
<b>ДҮН</b>			<b>8245,6</b>	<b>100</b>




Зураг 46. Ямаанд тохиромжтой бэлчээр, зун намрын улиралаар

Завхан аймгийн хонинд тохиромжтой бэлчээрийг аргачлалын дагуу GIS програм хангамжийн тусламжтайгаар боловсруулалт хийн үр дүнг үзэхэд өвөл хаврын нутаг дэвсгэрийн 66,5 % буюу 5,5 сая га талбай тохиромжтой, нэн тохиромжтой бүс нутаг байна. Нутаг дэвсгэр хуваарилалтын хувьд аймгийн хэмжээнд жигд тархалттай байна.

Хүснэгт 51. Өвөл хаврын улиралд ямаанд тохиромжтой бэлчээрийн нөөц, хэмжээ

№	Тохиромжтой байдал	Оноо	Талбай /мян.га/	Нийт талбайд эзлэх хувь /%/
1	Хориглох нөхцөлтэй	0	1369,6	16,5
2	Тохиромж муу	1	254,6	3,1
3	Дунд зэргийн тохиромжтой	2	1159,4	13,9
4	Тохиромжтой	3	3218,6	38,6
5	Нэн тохиромжтой	4	2328,4	27,9
<b>ДҮН</b>			<b>8245,6</b>	<b>100</b>






**Зураг 47. Ямаанд тохиромжтой бэлчээр, өвөл хаврын улиралаар**

Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнгээс харахад Завхан аймгийн нийт нутаг дэвсгэрийн 50% буюу 4208632.8 га хонь, ямаанд нэн тохиромжтой, 2.1% буюу 177522.0 га тохиромж муутай байхад 39.7% буюу 3307235.6 га адуунд нэн тохиромжтой, 1.6% буюу 134936.2 га тохиромж муутай байна. Харин үхэрт 33.6 % буюу 2806479.9 га нэн тохиромжтой, 1.6 % буюу 132980.9 га тохиромж муутай байхад тэмээнд нийт дэвсгэрийн 12.1% буюу 1013111.5 га нэн тохиромжтой, 6.5% буюу 546976.8 га тохиромж муутай байна.


**Хүснэгт 52. Малд тохиромжтой бэлчээрийн хэмжээ**

Тохиромжтой байдал	Таван төрлийн малд тохиромжтой бэлчээрийн хэмжээ /мян.га/									
	Адуу	%	Үхэр	%	Хонь	%	Ямаа	%	Тэмээ	%
Хориглох нөхцөл	1369.6	16.4	1369.6	16.4	1369.6	16.4	1369.6	16.4	1369.6	16.4
Тохиромж муу	134.9	1.6	1329.8	1.6	177.5	2.1	177.5	2.1	546.9	6.5
Дунд зэрэг тохиромжтой	1126.6	13.5	1358.9	16.3	665.6	8.0	594.4	7.1	2626.8	31.5
Тохиромжтой	2392.2	28.7	2662.6	31.9	1895.4	22.7	1960.1	23.5	2774.1	33.3
Нэн тохиромжтой	3307.2	39.7	2806.5	33.6	4208.6	50.6	4213.0	50.6	1013.1	12.1
<b>ДҮН</b>	<b>8245,6</b>	<b>100</b>	<b>8245,6</b>	<b>100</b>	<b>8245,6</b>	<b>100</b>	<b>8245,6</b>	<b>100</b>	<b>8245,6</b>	<b>100</b>

2006, 2016 оны малын тоог малын төрөл тус бүрээр картодиаграммын аргаар харуулав. 2006-2016 оны хоорондын 10 жилийн малын тоо толгойн өөрчлөлтийг сум тус бүрээр гаргахад Идэр, Нөмрөг, Шилүүстэй сумууд 100000 дээш тоо толгойгоор өссөн бол Сантмаргац сумын хувьд 51000 тоо толгой малаар буурсан үзүүлэлттэй байна. (Завхан аймгийн статистикийн эмхэтгэл 2006, 2016)



Зураг 48. Аймгийн мал сүргийн бүтэц, 2006 он




Зураг 49. Аймгийн мал сүргийн бүтэц, 2016 он

Хүснэгт 53. Аймгийн малын тооны өөрчлөлт

Малын төрөл	2006 он	2016 он	Өөрчлөлт	Өсөлтийн хувь
Адуу	113.240	185.639	72.399	63.93
Үхэр	127.233	174.193	46.960	36.91

Хонь	1,251.468	1,764.38	512.911	40.98
Ямаа	1052.259	1,248.77	196.513	18.68
Тэмээ	6.593	4.939	-1.654	-25.09
<b>Нийт</b>	<b>2,550.793</b>	<b>3377.922</b>	<b>827.129</b>	<b>32.43</b>

Мал сүргийн зохистой бүтэц, цаашдын чиглэлийг тодорхойлохын тулд газрын бүрхэвч, байгалийн бүс бүслүүр болон бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг өнөөгийн малын тоо толгойн зурагтай давхцуулан орон зайн шинжилгээ хийсэн. Энэ шинжилгээний үр дүнд Завхан аймгийн мал аж ахуйг цаашид эрхлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлон гаргав.



Зураг 50. Завхан аймгийн мал сүрэг эрхлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэл

### 3.2.3 Бэлчээрийн усан хангамжийн нөөц нөхцөлийн төлөвлөлт

Үндэслэл: УИХ-ын “Ус” (2010) үндэсний хөтөлбөр, Байгаль орчин ногоон хөгжлийн яамны “Идэр голын сав газрын усны нөөц, экологи, нийгэм эдийн засгийн суурь судалгаа” (2014) зэрэг томоохон баримт бичигт:

- Богдын гол дээр тохируулга хийх,
- Мал аж ахуйн ус хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийг усжуулах арга хэмжээг тасралтгүй явуулж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, бэлчээр ашиглагч, хөдөө аж ахуйн салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулан жилд 800-1000 худгийг шинээр гаргаж, сэргээн засварлах,
- Усны нөөцийн хуримтлал бий болгож ашиглах чиглэлээр усны нөөцийг хуримтлуулах усан сан Хангайн нурууны ай сав түүний цутгал голуудын доод

талд байгуулах замаар 700 000 -800 000 сая шоо метр тогтонги усны нөөцийг өндөр уулын бүсэд бүрдүүлж ашиглах,


- Монгол орны нутаг дэвсгэрт хөв, цөөрөм байгуулж ашиглах боломжийн талаархи хайгуул, судалгааны үр дүн, орон нутгийн эрэлт хэрэгцээ, захиалга дээр үндэслэн 130-аас доошгүй газарт хөв, цөөрөм байгуулж ашиглах талаар тусгажээ.

Хүснэгт 54. Завхан аймгийн усны нөөц, шоо.метр

№	Аймгийн нэр	Гадаргын ус		Газрын доорх ус	
		Нийт	Ашиглаж болох	Ул хөрсний	Ашиглах боломжит
1	Завхан	3,16	0,2	1,14	0,37
2	Говь-Алтай	0,058	0,01	0,1	0,03
3	Хөвсгөл	6,59	0,16	2,49	1,95
4	Ховд	1,10	0,19	0,25	0,06
<b>Улсын дүн</b>		<b>34,6</b>	<b>4,96</b>	<b>12,0</b>	<b>5,60</b>

(эх сурв. www.forum.mn)

Газрын доорх ус нь Монгол орны хамгийн чухал усны эх үүсвэр юм. Нийгэм эдийн бүхий л салбаруудын үйл ажиллагаа газрын доорх усны нөөц, түүний боломжоос шууд хамаардаг. Гадаргын ус байхгүй газруудад малчид худгаас усаа авч ашигладаг, мөн газар тариалангын усалгаанд уул уурхай болон үйлдвэрүүд нь үйл ажиллагаандаа газрын доорх усыг өргөнөөр ашиглаж байна. Газрын доорх ус чанарын хувьд ч ундны усны баталгаатай эх үүсвэр болдог.



Зураг 51. Аймгийн газрын доорхи усны нөөц

Газрын доорх усны нөхөн сэргээгддэг нөөц гэж жил бүр хур тунадасны нэвчилт, гадаргын усны нэвчилт шүүрэлт, хажуугийн урсацын нөлөөгөөр дахин бүрэлдэх боломжтой усны хэмжээг хэлнэ. Нөхөн сэргээгддэггүй нөөц гэж хур тундасын нэвчилт хажуугийн урсацаас тэжээгдэх боломжгүй газрын доорх (дарагдмал ус) усны хуримтлалыг хэлнэ.

Газрын доорх усны ашиглаж болох боломжит нөөц гэж газрын доорх усны нөхөн сэргээгдэх ба нөхөн сэргээгддэггүй нөөцөөс олборлож болох хэмжээг хэлнэ. Ашиглаж болох боломжит нөөц нь ус агуулагч бүрдэл, бүс, үеийн зузаан, тархсан талбай, төрөл (нүх сүвэрхэг, ан цавлаг) зэргээс хамааралтай бөгөөд нөхөн сэргээгддэг нөөц болон нөхөн сэргээгддэггүй нөөцөөс олборлож болох хэмжээгээр тодорхойлогдоно. (эх сурв. Байгаль орчны яам)

Малын ус хэрэглээний нормыг Байгаль орчны сайдын 1995 оны 153-р тушаалын дагуу авч дундаж утгаар сумдын 2016 оны малын тооллогын дүнгээр малын ус хангамжийг тооцооллоо.

Хүснэгт 55. Сумдын малын ус хэрэглээ, мян.тн /2016 он/


№	Сумын нэр	Ус хэрэглээ /мян.тонн жил/	Үүнээс				
			Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1	Улиастай	194.1	25.9	38.3	0.6	60.3	69.1
2	Алдархаан	424.8	80.4	73.4	8.1	110.4	152.5
3	Асгат	75.3	14.8	19.8	0.1	23.7	17.0
4	Баянтэс	209.7	34.8	47.6	2.1	62.1	63.0
5	Баянхайрхан	175.8	34.2	38.4	0.0	67.1	35.9
6	Дөрвөлжин	326.4	69.0	21.7	29.8	82.7	123.2
7	Завханмандал	185.2	28.3	14.4	2.8	65.3	74.4
8	Идэр	233.2	56.0	53.4	0.4	77.2	46.2
9	Их-Уул	484.1	101.7	158.7	1.1	156.8	65.9
10	Нөмрөг	239.9	75.5	53.4	0.3	74.8	35.9
11	Отгон	327.0	70.5	68.5	2.8	106.9	78.3
12	Сантмаргац	246.7	50.0	30.7	8.9	88.6	68.6
13	Сонгино	166.5	37.3	31.0	0.7	57.9	39.7
14	Тосонцэнгэл	355.6	88.1	102.4	0.3	96.2	68.7
15	Түдэвтэй	193.6	55.3	42.1	0.1	61.0	35.1
16	Тэлмэн	304.6	82.8	64.2	3.4	109.4	44.7
17	Тэс	174.4	41.0	40.5	0.6	52.5	39.8
18	Ургамал	206.1	33.3	13.1	23.4	69.0	67.4
19	Цагаанхайрхан	128.4	13.9	24.4	0.3	44.0	45.7
20	Цагаанчулуут	145.9	33.1	17.1	3.9	46.9	44.8
21	Цэцэн-Уул	223.0	35.6	34.5	3.8	91.9	57.2
22	Шилүүстэй	173.4	27.9	29.2	3.4	54.2	58.8
23	Эрдэнэхайрхан	292.1	47.9	33.7	2.5	135.6	72.4
24	Яруу	274.9	65.5	33.2	1.0	120.7	54.4
	<b>ДҮН</b>	<b>5760.8</b>	<b>1202.8</b>	<b>1083.6</b>	<b>100.5</b>	<b>1915.0</b>	<b>1459.0</b>

Дээрх хүснэгтээс харахад Завхан аймгийн МАА-н салбарт жилдээ 5,7 сая тн ус хэрэглэгдэхээр гарч байна. Байгалийн бэлчээрт түшиглэсэн нүүдлийн МАА эрхэлдэг манай орны хувьд бэлчээр усжуулалтын арга хэмжээ онцгой ач холбогдолтой. Бэлчээр усжуулалтын зорилго нь усжуулж байгаа нутаг дэвсгэрт оршин амьдрагч хүн, мал болон бусад ус хэрэглэгчдийн хэвийн амьдрал, үйл ажиллагаанд шаардагдах усыг байнга, тасралтгүй хангахад оршино.

№	Бэлчээрийн ургац (цн/га)		1 уст цэгээс усжуулагдсан бэлчээр (мян.га)		Мал услах радиус (км)		
	Зун-Намар	Өвөл-Хавар	Зун-Намар	Өвөл-Хавар	Зун-Намар	Өвөл-Хавар	Дээд хэмжээ
1	5,4	3,1	2,24	3,62	2,7	3,2	4,5

(эх сурв. Ж.Чогдон “Байгалийн янз бүрийн нөхцөлд мал услах радиус” 1980)

Завхан аймгийн бэлчээрийн усан хангамжийг тооцоолон үзэхэд нийт нутаг дэвсгэрийн 61,0% усаар хангагдсан байна.




Зураг 52. Зун намрын бэлчээрийн усан хангамж

№	Сумын нэр	Усжуулагдсан талбай, мян.га	Эзлэх хувь
1	Алдархаан	395,1	6,0
2	Асгат	13,7	0,2
3	Баянтэс	140,6	2,1
4	Баянхайрхан	134,7	2,1
5	Дөрвөлжин	386,0	5,9
6	Завханмандал	121,1	1,8
7	Идэр	132,6	2,0
8	Их-Уул	136,7	2,1
9	Нөмрөг	166,2	2,5
10	Отгон	372,8	5,7
11	Сантмаргац	132,4	2,0
12	Сонгино	127,2	1,9
13	Тосонцэнгэл	181,3	2,8
14	Түдэвтэй	170,2	2,6
15	Тэлмэн	197,2	3,0
16	Тэс	35,6	0,5
17	Ургамал	135,3	2,1

18	Цагаанхайрхан	168,8	2,6
19	Цагаанчулуут	136,3	2,1
20	Цэцэн-Уул	134,7	2,1
21	Шилүүстэй	217,6	3,3
22	Эрдэнэхайрхан	170,1	2,6
23	Яруу	192	2,9
Аймгийн нийт		6923,8	100

(эх сурв. Ш.Баранчулуун, Д.Чандмань Бэлчээр усжуулалт 2000)



Зураг 53. Өвөл хаврын бэлчээрийн усан хангамж

Хүснэгт 58. Аймгийн бэлчээрийн усжуулагдсан талбай, га

№	ЭХ ҮҮСВЭР	УСЖУУЛАГДСАН ТАЛБАЙ (МЯН.ГА)	ХУВЬ %
1	Гол	1637,4	40,9
2	ГОРХИ, БУЛАГ	796,2	19,9
3	Нуур	297,3	7,4
4	ХУДАГ	1267,8	31,7
5	ХӨВ ЦӨӨРӨМ	0,3	0,1
<b>ДҮН</b>		<b>3999</b>	<b>100</b>

### Бэлчээрийн усан хангамжийн зохицуулалт

Завхан аймгийн усжуулагдаагүй бэлчээр 2,5 сая буюу нийт бэлчээрийн 35% - ийг эзэлж байгаа бөгөөд бүрэн усжуулахад 696 худаг шаардагдах тооцоо гарч байгаа бөгөөд төлөвлөлтийн хугацаанд 311 худаг ус гаргаж 1,1 сая га бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэхээр төлөвлөв.

Хүснэгт 59. Бэлчээр усжуулалтын төлөвлөлт

№	Сумын нэр	2022		2028		2033		ДҮН	
		мян.га	худаг /ш/	мян.га	худаг /ш/	мян.га	худаг /ш/	мян.га	худаг /ш/
1	Алдархаан	10,9	3	14,5	4	14,5	4	39,9	11

2	Баянтэс	10,9	3	10,9	3	10,9	3	32,7	9
3	Баянхайрхан	14,5	4	18,1	5	18,1	5	50,7	14
4	Дөрвөлжин	36,2	10	36,2	10	36,2	10	108,6	30
5	Завханмандал	29,0	8	29,0	8	29,0	8	87	24
6	Идэр	7,2	2	7,2	2	7,2	2	21,7	6
7	Их Уул	7,2	2	7,2	2	7,2	2	21,7	6
8	Нөмрөг	21,7	6	21,7	6	21,7	6	65,1	18
9	Отгон	18,1	5	18,1	5	21,7	6	57,9	16
10	Сантмаргац	10,9	3	14,5	4	14,5	4	39,9	11
11	Сонгино	21,7	6	21,7	6	21,7	6	65,1	18
12	Тосонцэнгэл	3,6	1	3,6	1	7,2	2	14,5	4
13	Түдэвтэй	18,1	5	18,1	5	18,1	5	54,3	15
14	Тэс	7,2	2	7,2	2	3,6	1	18,1	5
15	Тэлмэн	21,7	6	21,7	6	21,7	6	65,1	18
16	Ургамал	25,3	7	25,3	7	25,3	7	75,9	21
17	Цагаанхайрхан	7,2	2	3,6	1	3,6	2	18,1	5
18	Цагаанчулуут	21,7	6	21,7	6	18,1	5	61,5	17
19	Цэцэн-Уул	3,6	1	7,2	2	3,6	1	14,5	4
20	Шилүүстэй	14,5	4	14,5	4	18,1	5	47,1	13
21	Эрдэнэхайрхан	14,5	4	18,1	5	14,5	4	47,1	13
22	Яруу	32,3	9	32,3	9	32,3	9	96,9	27
23	Асгат	7,2	2	7,2	2	7,2	2	21,7	6
	<b>ДҮН</b>	<b>365,2</b>	<b>101</b>	<b>379,6</b>	<b>105</b>	<b>379,6</b>	<b>105</b>	<b>1124,4</b>	<b>311</b>



Зураг 54. Бэлчээр усжуулалтын төлөвлөлт



### 3.2.4 ХАА-н зориулалттай цөөрөм төлөвлөх.

Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтод баталгаатай усны эх үүсвэртэй болох, хуурай газрын экосистемийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, далай тэнгисийн нөөцийг хамгаалах зэрэг зорилтууд орсон байдаг бөгөөд энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нэг арга хэмжээ нь хөв цөөрөм байгуулах явдал юм.

ХАА-н зориулалттай 4 төрлийн цөөрөм байдаг. Үүнд:

1. Хур борооны усаар тэжээгддэг цөөрөм /хөв/
2. Газрын доорх усаар тэжээгддэг цөөрөм
3. Урсгал ус буюу булаг шандны усаар тэжээгддэг цөөрөм
4. Үндсэн голдирлоос салаалан, дөхүүлэх сувгаар усаа татаж авдаг цөөрөм


Завхан аймгийн хувьд 2-р зориулалтын цөөрөм төдийлөн тохиромжтой бус бөгөөд бусад 3 төрлийн цөөрмийг бий болгон ХАА-н салбарт хэрэглэх бүрэн боломжтой.



Зураг 55. Урсгал усаар тэжээгддэг цөөрөм (Цагаанчулуут сум 2016)

Тунадасны болон гадаргын урсацын усыг цуглуулан нөөцлөх зориулалтаар жижиг нүх, хонхор газруудыг ашиглан хөв цөөрөм байгуулдаг. Энэхүү аргыг уурхайн нөхөн сэргээлт хийсэн талбайд үр дүнтэй ашигладаг байна.

Хөв цөөрмийн тохиромжтой байдлын үнэлгээний арга зүйгээр Завхан аймгийн нутаг дэвсгэрт бороо цасны усаар тэжээгддэг хөв цөөрөм барихад тохиромжтой газрыг тооцоолоход 12 мянган га талбай гарч байгаа бөгөөд үүнээс 5,7 мянган талбай нэн тохиромжтой гарч байна.




Зураг 56. Хөв цөөрмийн тохиромжтой байдлын үнэлгээ

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийтдээ 32 байршил буюу жил бүр тогтмол 2 бороо цасны усаар тэжээгддэг хөв цөөрмийг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөлөө. Ингэснээр МАА-н салбарын болон байгалийн зэрлэг ан амьтадын амьдрах нөхцөлд ч үлэмж тустай төдийгүй ирээдүйн усны бодит хомсдолоос урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой ажил болно.


Хүснэгт 60 . Хөв цөөрмийн төлөвлөлт

№	Сумын нэр	Бэлчээрийн талбай (мян.га)	Шинээр гаргах хөв (байршил)	Хүрэх түвшин			Шаардагдах хөрөнгө оруулалт (сая.төг)
				Ойрын 2022он	Дундын 2028он	Хэтийн 2033он	
1	Алдархаан	3,6	1	1			150
2	Асгат	3,6	1		1		150
3	Баянтэс	3,6	1			1	150
4	Баянхайрхан	3,6	1		1		150
5	Дөрвөлжин	10,8	3	1	1	1	450
6	Завханмандал	10,8	2	1	1		300
7	Идэр	3,6	1		1		150
8	Их-Уул	3,6	1			1	150
9	Нөмрөг	3,6	1	1			150
10	Отгон	3,6	1			1	150
11	Сантмаргац	10,8	2	1	1		150
12	Сонгино	3,6	1			1	150
13	Тосонцэнгэл	3,6	1		1		150
14	Түдэвтэй	3,6	1	1			150
15	Тэлмэн	3,6	1		1		150
16	Тэс	3,6	1			1	150
17	Ургамал	10,8	2	1	1		300
18	Цагаанхайрхан	3,6	1			1	150
19	Цагаанчулуут	10,8	2	1		1	300
20	Цэцэн-Уул	10,8	2	1		1	300
21	Шилүүстэй	7,6	2		1	1	300
22	Эрдэнэхайрхан	7,6	2		1	1	300

23	Яруу	3,6	1	1			150
	<b>ДҮН</b>	<b>133,2</b>	<b>32</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>11</b>	<b>4800</b>



Зураг 57. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр хөв цөөрөм байгуулах бүс нутаг



Диаграмм 59. Хөв цөөрөм байгуулах газрын төлөвлөлт

### 3.2.5 Бэлчээрийн сайжруулах, хамгаалах арга хэмжээ


Хүн амын өсөлт, газар ашиглалтын төрөл хэлбэрийн өсөлт, хот суурины тэлэлт зэргээс үүдэн хөдөө аж ахуйн газрын нөөц жилээс жилд буурч байгаа бөгөөд энэ нь дан ганц бэлчээрийн МАА салбарт ч бус мөн зэрлэг амьтад болон биологийн төрөл зүйлд ч сөрөг нөлөө үзүүлж байгаа билээ. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө болон бэлчээрийн малын тооны өсөлт нь бэлчээрийн даац, багтаамжаасаа давсан, бэлчээрийн нутаг дэвсгэрийн 67% нь талхлагдал, доройтолд орсон өнөөгийн нөхцөлд бэлчээр сайжруулалтын оновчтой аргыг сонгон хэрэглэх нь бэлчээр тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх нэг үндэс болно.

Хүснэгт 61. Бэлчээр сайжруулалтын арга хэмжээ

№	Арга хэмжээ	Тайлбар
1	Тэжээлийн нөхцөлийг сайжруулах, сийрүүлэлт хийх	Усалж тордохоос гадна эрдэс, бууцан бордоогоор бордож ургамлын тэжээл хангамж, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ. Хөрсний хатуурч нягтарсан хэсгийг буталж сийрүүлэх зорилгоор механик аргаар сийрүүлэлт хийх
2	Чөлөөлөн сэлгэх	Бэлчээрийн хэт ачаалал үүсгэсэн хүчтэй эрчимжилттэй ашиглаж байгаа бүс нутгийг ашиглалтаас чөлөөлөн бэлчээрийн ургамал нөхөн сэргээсний эцэст ашиглалтад оруулах
3	Хог ургамал, хортон мэрэгчидтэй тэмцэх	Бэлчээрт тархсан малын хортой эсвэл шим тэжээл муутай ургамлыг ( <i>Малын бие махбод бүтээгдэхүүнд хор хөнөөлтэй ургамал, малыг хордуулдаг ургамал, малын арь үс, туурай, амны салст бүрхэвчийг гэмтээдэг, сүүний амт муутгадаг</i> ) бэлчээр ашиглах үед нь мөн бэлчээр сүйтгэдэг хортон мэрэгчидийг механик болон химийн бодисын тусламжтайгаар устгах
4	Элсний нүүлтээс хамгаалах	Бэлчээрийг элсний нүүлтээс хамгаалах зорилгоор бэлчээр хамгаалах ойг бий болгох Механик хамгаалалт хийх,
5	Автоген нөлөөллийг бууруулах	Үерийн усны үйлчлэлээс үүссэн газрын эвдрэлийг нөхөн сэргээх, усны урсгалыг тараах байгууламж (габион) барих
6	Бэлчээрийн даацад тохируулах	Бэлчээрт байх ёстой малыг зохистой түвшинд барих арга хэмжээг авч хэрэгжүүлэх (тоо толгойг цөөлөх, сүргийн бүтцийг өөрчлөх, бэлчээрийн бүтээмжийг нэмэгдүүлэх)

#### Тэжээлийн нөхцөлийг сайжруулах:

Завхан аймгийн хэмжээнд 1687,5 мянган га талбайд энэхүү арга хэмжээ төлөвлөгдөж байгаа бөгөөд 2022 он гэхэд 586,2 мянган га, 2028 онд 518,4 мянган га бэлчээр, 2033 онд 582,9 мянган га бэлчээрийг малчдын бүлэг бэлчээр ашиглалтын хэсэг шат дараатайгаар бордох, хяналттай шатаах, сийрүүлэх, үрээр хачирлаж тарих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.




Зураг 58. Бэлчээр сайжруулах арга хэмжээний төлөвлөлт

Хүснэгт 29. Бэлчээр сайжруулах арга хэмжээний хөрөнгө оруулалт

№	Сумын нэр	Нийт талбай (мян.га)	Үүнээс (мян.га)			Шаардагдах хөрөнгө оруулалт (сая.төг)
			Ойрын 2022он	Дундын 2028он	Хэтийн 2033он	
1	Их-Уул	35.8	6.5	23.4	5.9	179.0
2	Тосонцэнгэл	54.9	19.3	28	7.6	274.5
3	Тэлмэн	117.3	67	16.2	34.1	586.5
4	Идэр	137.5	15.3	23.4	98.8	687.5
5	Отгон	158.3	42.8	31.7	83.8	791.5
6	Нөмрөг	102.7	54	33.4	15.3	513.5
7	Цагаанхайрхан	158.6	17.2	75.9	65.5	793.0
8	Яруу	33.3	11.1	4.2	18	166.5
9	Шилүүстэй	187.7	71.8	49.8	66.1	938.5
10	Цагаанчулуу	109.9	53.8	27.6	28.5	549.5
11	Баянтэс	26.1	10.1	11.8	4.2	130.5
12	Асгат	7.7	3.3	2.7	1.7	38.5
13	Баянхайрхан	64.5	17.5	38.7	8.3	322.5
14	Алдархаан	73	16.4	16.2	40.4	365.0
15	Түдэвтэй	61.7	23.4	18.8	19.5	308.5
16	Сонгино	24.7	8.6	11.6	4.5	123.5
17	Эрдэнэхайрхан	77.7	21.9	47.2	8.6	388.5
18	Тэс	11.3	9	1.9	0.4	56.5
19	Сантмаргац	32.3	17.8	9.4	5.1	161.5
20	Завханмандал	67.6	35.9	8.6	23.1	338.0
21	Дөрвөлжин	76.1	42.4	14.4	19.3	380.5
22	Ургамал	56.5	18.4	19.3	18.8	282.5
23	Цэцэн-Уул	9	1.6	3.1	4.3	45.0
	<b>ДҮН</b>	<b>1684.2</b>	<b>585.1</b>	<b>517.3</b>	<b>581.8</b>	<b>8421.0</b>

## Чөлөөлөн сэлгэх төлөвлөлт:

Завхан аймгийн хэмжээнд 738,5 мянган га талбайд энэхүү арга хэмжээ төлөвлөгдөж байгаа бөгөөд 2022 он гэхэд 236,0 мянган га, 2028 онд 286,6 мянган га бэлчээр, 2033 онд 215,8 мянган га бэлчээрийг малчдын бүлэг бэлчээр ашиглалтын хэсэг шат дараатайгаар өнжөөх, чөлөөлөх арга хэмжээ авч малын ачааллыг тухайн бүс нутагт бууруулах арга хэмжээ авна.



Зураг 59. Завхан аймгийн бэлчээр чөлөөлөн сэлгэх төлөвлөлт

## Хүснэгт 62. Бэлчээр чөлөөлөн сэлгэх арга хэмжээний төлөвлөлт

№	Сумын нэр	Нийт талбай (мян.га)	Үүнээс (мян.га)			Шаардагдах хөрөнгө оруулалт (сая.төг)
			Ойрын 2022он	Дундын 2028он	Хэтийн 2033он	
1	Улиастай	-				
2	Алдархаан	25.6	4.7	11.6	9.3	25,6
3	Асгат					
4	Баянтэс	46.9	13.5	22.8	10.6	46,9
5	Баянхайрхан	12.5	2.9	9.6		12,5
6	Дөрвөлжин	111.9	26.0	59.4	26.5	111,9
7	Завханмандал	60.1	31.1	13.9	16.1	60,1
8	Идэр	6.9	6.9			6,9
9	Их-Уул	4.5	1.1	3.4		4,5
10	Нөмрөг	74.8	13.2	25.0	36.6	74,8
11	Отгон	27.1	6.8	17.3	3.0	27,1
12	Сантмаргац	5.6	3.8	1.3	0.5	5,6
13	Сонгино	8.9	7,9	1		8,9
14	Тосонцэнгэл	30.3	11,0	3,4	15,9	30,3
15	Түдэвтэй	13.6	6,4	3,5	3,7	13,6
16	Тэлмэн	72.7	11,3	24,9	36,5	72,7
17	Тэс	4.7		4,7		4,7
18	Ургамал	83.5	33,2	38,3	12,0	83,5
19	Цагаанхайрхан	10	0,6	8,6	0,8	10
20	Цагаанчулуут	27	14,7	12,0	0,3	27
21	Цэцэн-Уул	2.6	0,5	1,8	0,3	2,6



5	Сантмаргац	49,9	24,7	11,4	13,8	848.3
6	Ургамал	34,6	23,4	10,4	0,8	588.2
7	Цагаанхайрхан	48,6	1,1	3,1	44,4	826.2
8	Цагаанчулуут	0,6	0,2	0,2	0,2	10.2
9	Цэцэн-Уул	43,3	19,3	14,5	9,5	736.1
10	Эрдэнэхайрхан	41,0	9,0	32,0	-	697.0
11	Яруу	27,3	1,9	11,7	13,7	464.1
	<b>ДҮН</b>	<b>431,1</b>	<b>151,3</b>	<b>133</b>	<b>146,8</b>	<b>7328.7</b>



Зураг 61. Бэлчээрийг элсний нүүлтээс хамгаалах төлөвлөлт

### Бэлчээр хамгаалах ойн төлөвлөлт:

Энэхүү зурвас нь цасыг жигд хуваарилах бичил уур амьсгалыг сайжруулан тэжээлийн эдэлбэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, мал сүргийг хүчтэй салхи, шороон шуурганаас хамгаалах, бэлчээрийн эргэлтийг нэвтрүүлэхэд илүү тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх, бэлчээрийг дээд зэргээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Хүснэгт 30. Бэлчээрийн хамгаалах ойн зурвасын хөрөнгө оруулалт

№	Сумын нэр	Нийт талбай (га)	Үүнээс (га)			Шаардагдах хөрөнгө оруулалт (сая.төг)
			Ойрын 2022он	Дундын 2028он	Хэтийн 2033он	
1	Алдархаан	35,0	5,0	11,0	19,0	59,5
2	Дөрвөлжин	23,6	3,2	10,2	10,2	40,1
3	Завханмандал	15,2	4	5,2	6,0	25,8
4	Их-Уул	23,0	7,0	8,0	8,0	39,1
5	Сантмаргац	99,8	22,8	27,6	49,4	169,7
6	Ургамал	64,8	10,6	20,4	33,8	110,2
7	Цагаанхайрхан	97,2	22,2	26,2	48,8	165,2
8	Цагаанчулуут	9,0	3	3	3	15,3
9	Цэцэн-Уул	87,6	19,6	28,5	39,5	148,9
10	Эрдэнэхайрхан	82,0	18,0	32,0	32,0	139,4
11	Яруу	54,6	3,8	23,4	27,4	92,8
	<b>ДҮН</b>	<b>591,8</b>	<b>119,2</b>	<b>195,5</b>	<b>277,1</b>	<b>1006</b>




Ой бэлчээрийн цогц нь мод, сөөг ургуулахаас гадна малын тэжээл (бэлчээр эсвэл хадлан) үйлдвэрлэн, МАА-тай хослуулдаг агро-ойжуулалтын систем бөгөөд үүнийг ойт бэлчээр гэдэг. Энэ нь ой модыг МАА-тай зориуд холбон уялдуулсан олон талт, зорилтот, цогц арга хэмжээ юм. Энэхүү цогц системд мод, тэжээл, МАА-н үйлдвэрлэл гэсэн 3 дэд систем бие биенийгээ нөхдөг онцлогтой. Эгнээ хоорондын өргөн зайд мал бэлчихээр тооцож, моддыг нэг юм уу олон эгнээгээр зурваслан тарьдаг. Энэхүү систем нь бичил уур амьсгал үүсгэн, шим тэжээлийн бодисын эргэлт болон хөрс, усны харилцан үйлчлэлийг сайжруулж, нүүрстөрөгч шингээлтийг нэмэгдүүлэн, хүлэмжийн хийн ялгарлыг багасгаж амьтан амьдрах орчин нөхцлийг бүрдүүлдэг.



Зураг 62. Бэлчээр хамгаалалтын ойн зурвас


#### **Автоген нөлөөлөл, гуу жалга, усны эвдрэлийг багасгах төлөвлөлт:**

Аймгийн хэмжээнд 420,8 мянган га талбайд энэхүү арга хэмжээ төлөвлөгдөж байгаа бөгөөд 2022 он гэхэд 140,8 мянган га, 2028 онд 133,1 мянган га бэлчээр, 2033 онд 146,8 мянган га бэлчээрийг малчдын бүлэг бэлчээр ашиглалтын хэсэг шат дараатайгаар мод тарих, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг авах, МАА-Ойн аж ахуйн хослол хөгжүүлэх арга хэмжээ авч малын ачааллыг тухайн бүс нутагт бууруулах арга хэмжээ авна.



Зураг 63. Бэлчээр хамгаалах төлөвлөлт

Дээрх зургаас харахад Завхан аймгийн бэлчээрийн газрын 67,5% буюу 4,8 сая га бэлчээр ямар нэгэн байдлаар нөлөөлөлд өртөн унаган шинж чанараа алдаж байгаа нь харагдаж байна.



Зураг 64. Аймгийн бэлчээрийг сайжруулах, хамгаалах арга хэмжээний нэгдсэн төлөвлөлт

Хүснэгт 64. Бэлчээр сайжруулах, хамгаалах арга хэмжээний нэгдсэн төлөвлөлт

№	Арга хэмжээ	Талбай (мян.га)	Үүнээс (мян.га)			Нийт зардал (сая.төг)
			Ойрын 2022он	Дундын 2028он	Хэтийн 2033он	
1	Тэжээлийн нөхцөлийг сайжруулах	1687,5	586,2	518,4	582,9	8421,0
2	Чөлөөлөн сэлгэх	738,5	236,0	286,6	215,8	738,5
3	Хог ургамал, хортон мэрэгчидтэй тэмцэх	74,9	43,1	18,2	13,6	11501,0
4	Элсний нүүлтээс хамгаалах	420,8	140,8	133,1	146,8	8334,7
5	Автоген нөлөөллийг бууруулах	15,6	6,7	2,7	6,2	421,0
6	Бэлчээрийн даацад тохируулах	4554,3	6478,8	6532,6	6526,3	-
	<b>ДҮН</b>	<b>7491,6</b>	<b>7491,6</b>	<b>7491,6</b>	<b>7491,6</b>	<b>29416,2</b>

### 3.2.6 Эрчимжсэн мал аж ахуйн нөөц нөхцөлийн төлөвлөлт

УИХ-аас баталж гаргасан “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр” (2003), “Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөр” (2009), “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” (2015), Монгол улсын Засгийн газрын 2016-2020 хөтөлбөр (2016) зэрэг томоохон баримт бичгүүдэд хот хөдөөгийн хүн амын хүнсний хэрэглээний зөрүү ихтэй, хүнсэнд хэрэглэж байгаа мах сүүний 10 хүрэхгүй хувийг үйлдвэрийн аргаар боловсруулж байгаа бөгөөд цаашид хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд тодорхойлох чадавхи бий болгох хэрэгцээ урган гарч байна. Иймээс бүсийн тулгуур төв болон аймаг, сум бүр эрчимжсэн мал аж ахуй эрхлэх нутгийг нарийвчлан тогтоож, хяналтдаа авах, сүү, махны чиглэлийн төрөлжсөн мал болон гахай, шувууны фермерийн аж ахуй байгуулах төслийг сонгон шалгаруулж, тэргүүн ээлжинд дэмжлэг үзүүлэх талаар тусгажээ.

Хүснэгт 65.Завхан аймгийн МАА-н гаралтай хүнсний хэрэгцээ (жишсэн хүнээр 2016)

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл		Мах, махан бүтээгдэхүүн	Сүү	Сүүн бүтээгдэхүүн	Өндөг	2016 оны жишсэн хүн ам
	Жишсэн нэг хүний хоногийн хүнсний хэрэгцээ /кг/						
	Жишсэн нэг хүний жилийн хүнсний хэрэгцээ /кг/						
1	Улиастай	хэрэгцээ, тн	1035.1	777.1	1035.1	97.8	14180
2	Их-Уул	хэрэгцээ, тн	409.8	307.6	409.8	38.7	5614
3	Тосонцэнгэл	хэрэгцээ, тн	594.4	446.2	594.4	56.2	8142
4	Тэлмэн	хэрэгцээ, тн	179.5	134.8	179.5	17.0	2459
5	Идэр	хэрэгцээ, тн	163.0	122.4	163.0	15.4	2233
6	Отгон	хэрэгцээ, тн	174.5	131.0	174.5	16.5	2390
7	Нөмрөг	хэрэгцээ, тн	123.2	92.5	123.2	11.6	1688
8	Цагаанхайрхан	хэрэгцээ, тн	83.7	62.9	83.7	7.9	1147
9	Яруу	хэрэгцээ, тн	132.8	99.7	132.8	12.6	1819
10	Шилүүстэй	хэрэгцээ, тн	119.4	89.7	119.4	11.3	1636
11	Цагаанчулуут	хэрэгцээ, тн	79.1	59.4	79.1	7.5	1084
12	Баянтэс	хэрэгцээ, тн	169.9	127.6	169.9	16.1	2328
13	Асгат	хэрэгцээ, тн	62.6	47.0	62.6	5.9	857
14	Баянхайрхан	хэрэгцээ, тн	116.9	87.8	116.9	11.1	1602
15	Алдархаан	хэрэгцээ, тн	185.0	138.9	185.0	17.5	2534
16	Түдэвтэй	хэрэгцээ, тн	121.3	91.0	121.3	11.5	1661
17	Сонгино	хэрэгцээ, тн	101.3	76.0	101.3	9.6	1387
18	Эрдэнэхайрхан	хэрэгцээ, тн	107.5	80.7	107.5	10.2	1472
19	Тэс	хэрэгцээ, тн	188.9	141.8	188.9	17.9	2588
20	Сантмаргац	хэрэгцээ, тн	99.4	74.6	99.4	9.4	1362



Тооцооллоос үзэхэд мах, махан бүтээгдэхүүний эрэлт 5,4 мян.тн-оос 7,1 мян тн, сүү 4,1 мян.тн-оос 5,3 мян.тн, сүүн бүтээгдэхүүн 5,4-7,1 мян.тн болж нийт хүнсний бүтээгдэхүүний хангамж 76,2 хувиар нэмэгдэхээр байна.

Завхан аймгийн бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхдээ нутаг дэвсгэр, байгалийн бүс бүслүүрийн онцлогийг харгалзан МАА-н үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх бодлогыг дэмжихээр төлөвлөлтийн хувилбарыг боловсруулсан.

### **3.3 ХАДЛАНГИЙН ГАЗРЫН НӨӨЦ НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

Өвлийн улиралд мал аж ахуйн үйлдвэрлэлийн тэжээлийн эх үүсвэр болох өвс тэжээлийг байгалийн бэлчээрээс бэлтгэдэг бөгөөд энэ нь цас ихтэй жилүүдэд илүү чухал үүрэгтэй.

Өвсөн тэжээл нь бараг 55 мянган хүн ам, түүний дотор 8.5 мянга гаруй малчин өрхийн амьжиргаанд чухал ач холбогдолтой юм. Малын тэжээл, тэжээлийн тэжээл, холимог өвс ургамал, үр тариа, шимт бодисын менежментийг үр ашигтайгаар ашиглах, тариалан, мал аж ахуйг төрөлжүүлэн тариалах зэргээр тариалангийн эрчимжүүлэлт, төрөлжүүлэлтийг сайжруулах замаар эдгээр хүмүүст орлогын тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд нь туслах болно.


Хөрс, усны нөөцийн ашиглалтыг сайжруулах, хөдөө аж ахуйн практикт сөрөг нөлөөг бууруулах, дасан зохицох чадварыг сайжруулахад хадлангийн талбайн зохион байгуулалтын хугацааны болон талбайн сэлгээг санал болгодог бөгөөд бид Завхан аймгийн хадлангийн талбайны хэмжээ, тархалтыг харгалзан хугацааны сэлгээг сонгон авлаа.

Манай орны зарим эрдэмтдийн үзэж байгаагаар Монгол орны хадлан бэлчээрийн ургамал вегетатив эрхтэнээр үржих чадвар өндөртэйг дурдсан байдаг бөгөөд хугацааны сэлгээнд 4-5 жилд нэг удаа үрээ хаях боломжийг олгох бусад жилүүдэд хадлан сайжруулалтын арга хэмжээ авах нь тогтвортой өндөр ургац авах нөхцөлийг бүрдүүлнэ.

Завхан аймгийн мал сүргийг өвлийн улиралд хорогдолгүй даван туулахад 780 мян.тн өвс тэжээлийн хэрэгцээ гарч байгаа бөгөөд хэрэгцээт тэжээлийн тооцоог сум бүрээр тооцоолон гаргалаа.

Завхан аймгийн Алдархаан, Баянтэс, Нөмрөг, Тосонцэнгэл, Тэлмэн сумдууд аймгийн байгалийн хадлан бэлтгэлийн дийлэнхи хувийг буюу 12,38 мянган тн буюу нийт хадлангийн 57,9 хувийг бэлтгэж байна. (эх.сурв Завхан аймгийн статистикийн эмхэтгэл 2017).

Аймгийн говийн бүсийн сумдуудад хадлан бэлтгэлийн хэмжээ үлэмж бага байгаа бөгөөд Аймаг орон нутгийн зүгээс хадлангийн газрыг бий болгоход онцгой анхаарах шаардлагатай байна.



Диаграмм 60. Завхан аймгийн хадлан бэлтгэлийн өнөөгийн байдал, тн /2017 он/

Завхан аймгийн хэмжээнд нийтдээ 805 мян.тн тэжээл шаардагдахаас 2017 оны байдлаар байгалийн хадлан болон таримал тэжээл хэлбэрээр 21,3 мян.тн бэлтгэж байгаа бөгөөд 780 мян.тн өвс тэжээл хэрэгцээтэй болох нь тогтоогтож байна (хүснэгт 65). Гэсэн хэдий ч дээрх хэрэгцээт өвс тэжээлийн тодорхой хувийг бэлчээрлүүлэх замаар нөхөж авдаг бөгөөд хадлангийн талбайг аймгийн эдийн засгийн хүчин чадалд уялдуулан тодорхой түвшинд өсгөхөөр төлөвлөсөн болно.


Хүснэгт 67. Аймгийн нийт малд хэрэгцээт тэжээлийн нөөц

№	Сумын нэр	Малын тоо /мян х.толгой/	Тэжээх хоног /дундаж/	Хэрэгцээт тэжээл /мян.тн/			
				Нийт	Үүнээс Завханд		хэрэгцээт
					хадлан	таримал тэжээл	
1	Улиастай	174.8	120	25.2	0.99	0.26	23.9
2	Алдархаан	271.5	120	39.1	3.28	0.02	35.8
3	Асгат	70.0	120	10.1	0.58	1.06	8.4
4	Баянтэс	190.6	120	27.5	2.22	0	25.2
5	Баянхайрхан	163.2	120	23.5	1	0	22.5
6	Дөрвөлжин	279.6	120	60.4	0.28	0	60.1
7	Завханмандал	164.1	120	35.5	0.08	0.05	35.3
8	Идэр	218.5	120	31.5	0.71	0.20	30.6
9	Их Уул	456.1	120	65.7	1.05	0.01	64.6
10	Нөмрөг	229.1	120	33.0	1.94	0	31.1
11	Отгон	302.1	120	43.5	0.12	0.16	43.2
12	Сантмаргац	221.5	120	47.8	0.04	0	47.8
13	Сонгино	154.3	120	22.2	0.40	0.03	21.8
14	Тосонцэнгэл	335.1	120	48.3	2.69	0.32	45.3
15	Түдэвтэй	193.3	120	27.8	0.79	0.10	26.9
16	Тэлмэн	286.6	120	41.3	2.25	0.33	38.7
17	Тэс	162.7	120	23.4	1.1	0.03	22.3
18	Ургамал	173.0	120	37.4	0.10	0	37.3
19	Цагаанхайрхан	115.0	120	16.6	0.40	0.02	16.1
20	Цагаанчулуут	132.0	120	19.0	0.31	0.02	18.7
21	Цэцэн-Уул	201.6	120	29.0	0.10	0.26	28.7
22	Шилүүстэй	155.4	120	22.4	0.52	0.02	21.8
23	Эрдэнэхайрхан	265.3	120	38.2	0.15	0	38.1
24	Яруу	255.5	120	36.8	0.28	0.26	36.2
<b>ДҮН</b>		<b>5170.8</b>	<b>120</b>	<b>805.0</b>	<b>21.38</b>	<b>3.14</b>	<b>780.4</b>


(эх сурв. Р.Цэрэндулам “Монгол орны малын тэжээл”,)

Завхан аймагт өнөөдрийн байдлаар 20 суманд хадлангийн газар албан ёсоор бүртгэлтэй байгаа бөгөөд 8,0 мян.га талбайг хамарч байна. (зураг 49) Завхан

аймгийн хадлангийн газрын гол цөм нь Идэр, Нөмрөг, Баянтэс, Тэлмэн сумдуудад байгаа бөгөөд нийт хадлангийн газрын 65,0%-ийг эзэлж байна.



Зураг 66. Завхан аймгийн хадлангийн газрын өнөөгийн байдал



Диаграмм 61. Завхан аймгийн хадлангийн газрын талбай, га

Хадлангийн талбайн менежментийг хэрэгжүүлэхдээ сум орон нутгийн удирдлага, бэлчээр ашиглалтын бүлгүүд нь хадлангийн газартаа газар сайжруулалтын дараах арга хэмжээг жил бүр шат дараатай сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган зохион байгуулна.


Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын хадлангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний аргачлалын дагуу GIS технологийн тусламжтай боловсруулалт хийсэн бөгөөд суурь мэдээллийг Завхан аймгийн газрын төлөв

байдал чанарын улсын хянан баталгаа (2011)-ны үр дүнгээс авсан бөгөөд дараах үр дүн гарч байна.

Хүснэгт 68. Хадланд тохиромжтой газрын хэмжээ (мян.га)

№	Тохиромжтой байдал	Талбай, (мян.га)	Нийт талбайд эзлэх хувь (%)
1	Хадланд ашиглах боломжгүй	1341,5	16,3
2	Тохиромжгүй	2555,6	31,0
3	Тохиромж муутай	1727,0	20,9
4	Дунд зэрэг тохиромжтой	961,9	11,7
5	Тохиромжтой	868,2	10,5
6	Нэн тохиромжтой	791,0	9,6
<b>ДҮН</b>		<b>8256,9</b>	<b>100</b>

Дээрх хүснэгтээс харахад Завхан аймгийн хэмжээнд хадланд тохиромжтой бөгөөд сайжруулалт тордолгоо хийвэл 1,7 сая хадлангийн зориулалт бүхий талбайг бий болгох боломжтой нь харагдаж байна.



Зураг 67. Хадлангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Дээрх зургаас харахад хадланд тохиромжтой газрууд нь өнөөдөр бэлчээр ашиглалтын эрчим өндөртэй МАА-н гол бэлчээрлүүлэлтийн хэсэг болон тусгай хэрэгцээний газруудад үлэмж хэмжээгээр байгаа нь харагдаж байна.

Хадлангийн газар нь 2011 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 7758,5 га байснаас 2016 он хүртэлх хугацаанд 82,5 га хасагдсан үзүүлэлттэй гарсан байна.

Завхан аймгийн хадлангийн газрын хэмжээг 2033 онд 20,7 мян.га талбайд хүргэхээр зорилт тавин төлөвлөсөн бөгөөд 2022 онд 5,5 мян.га, 2028 онд 4,5 мян.га, 2033 онд 2,6 мян.га талбайнуудыг тус тус хадлангийн газарт шилжүүлэх бөгөөд хуулийн дагуу мал амьтан бэлчээрлүүлэхээс сэргийлэх зохицуулалтаас гадна




хадлангийн газрын менежментийн тодорхой арга хэмжээнүүдийг талбайн онцлог, шаардлагад тохируулан авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 69. Хадлангийн талбайн төлөвлөлт, га


Зураг 125. Тосонцэнгэл сумын төвийн газар ашиглалт




Зураг 126. Цагаанчулуут сумын төвийн газар ашиглалт




Зураг 127. Цагаанхайрхан сумын төвийн газар ашиглалт




Зураг 128. Цэцэн-Уул сумын төвийн газар ашиглалт




Зураг 129. Түдэвтэй сумын төвийн газар ашиглалт



Зураг 130. Ургамал сумын төвийн газар ашиглалт



Зураг 131. Яруу сумын төвийн газар ашиглалт




Зураг 132. Тосонцэнгэл сумын төвийн газар ашиглалт

Сумын төвүүдийн газар ашиглалтын байдлыг судалж үзэхэд газар ашиглалтын коэффициент нь 0,01-0,35, барилгажилтын бүрхэцийн утга нь 1,21-28,36 хувьтай гарч байна. Эдгээр үзүүлэлт нь хот төлөвлөлт барилгажилтын норм дүрэмд тусгагдсан жижиг хотод байх ёстой утгаас 2-7 дахин бага байгаа нь хот суурины тэг гортигийн хил хязгаар дотор хот сууринд тохиромжгүй газар /уулархаг газар, элс, гол, нуур, үерийн зам газар / нилээд их талбай эзэлж байгаа болон одоогийн газар ашиглалт нь нягтшил маш байгааг харуулж байна.


Хүснэгт 40. Хот суурин газруудын газар ашиглалтын үзүүлэлтүүд

№	Сумын нэр	Хот суурины нийт талбай, га	Ашиглалттай талбай, га	Газар ашиглалтын коэффициент	Барилгажсан талбай, га	Барилгажилтын бүрхэц, хувь
1	Улиастай	2776,7	981,75	<b>0,35</b>	761,05	<b>27,41</b>
2	Алдархаан	343,1	40,68	<b>0,12</b>	22,68	<b>6,61</b>
3	Асгат	227,3	38,904	<b>0,17</b>	32,90	<b>14,48</b>
4	Баянтэс	381,6	70,789	<b>0,19</b>	57,29	<b>15,01</b>
5	Баянхайрхан	318,1	86,293	<b>0,27</b>	79,29	<b>24,93</b>
6	Дөрвөлжин	590,5	113,258	<b>0,19</b>	103,16	<b>17,47</b>
7	Завханмандал	595	45,78	<b>0,08</b>	26,48	<b>4,45</b>
8	Идэр	604,6	60,01	<b>0,10</b>	49,61	<b>8,21</b>
9	Их-Уул	440,3	89,794	<b>0,20</b>	45,49	<b>10,33</b>
10	Нөмрөг	434,8	94,863	<b>0,22</b>	74,86	<b>17,22</b>
11	Отгон	383	50,604	<b>0,13</b>	21,60	<b>5,64</b>
12	Сантмаргац	265,2	86,051	<b>0,32</b>	50,05	<b>18,87</b>
13	Сонгино	413,2	47,46	<b>0,11</b>	32,06	<b>7,76</b>
14	Тосонцэнгэл	3639,8	596,191	<b>0,16</b>	440,19	<b>12,09</b>
15	Түдэвтэй	584,6	45,96	<b>0,08</b>	17,96	<b>3,07</b>
16	Тэлмэн	426,4	64,736	<b>0,15</b>	26,74	<b>6,27</b>
17	Тэс	489,9	59,149	<b>0,12</b>	25,15	<b>5,13</b>
18	Ургамал	592,5	57,229	<b>0,10</b>	50,63	<b>8,54</b>

19	Цагаанхайрхан	426,2	29,758	0,07	16,76	3,93
20	Цагаанчулуут	292,8	42,202	0,14	30,20	10,31
21	Цэцэн-Уул	214,9	32,031	0,15	18,23	8,48
22	Шилүүстэй	561	48,183	0,09	33,18	5,91
23	Эрдэнэхайрхан	407,8	35,408	0,09	25,61	6,28
24	Яруу	351,8	27,854	0,08	20,65	5,87




Диagramм 67. Сумын төвүүдийн газар ашиглалтын коэффициент



Диagramм 68. Сумын төвүүдийн барилгажилтын бүрхэц

#### 4.2.2 Хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Хот суурин байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийдээ ГХГЗЗГ-ын даргын 2015 оны 200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүй”-г баримталж хийсэн.




### Байгаль орчны үнэлгээ:

Завхан аймгийн байгаль орчны үнэлгээг хийхийн тулд дараахь 3 төрлийн үнэлгээ аргачлалын дагуу нэгтгэн гаргасан.

- Байгалийн нөхцөл нөөцийн үнэлгээ
- Байгаль экологийн үнэлгээ
- Инженер-геологийн үнэлгээ

Байгалийн нөхцөл нөөцийн үнэлгээний гадаргын хүчин зүйлийн үнэлгээнд гадаргын налуу, налуугийн чиглэл, өндөржилт гэсэн 3 үзүүлэлтийг нэгтгэн үнэлсэн бөгөөд аймгийн нийт нутгийн 60,67 хувь буюу 5002549,47 га талбай тохиромжтой, 39,31 хувь буюу 3241627,29 га хязгаарлагдмал тохиромжтой, 1,05 хувь буюу 86514,48 га тохиромжгүй үнэлгээтэй гарч байна.




Зураг 133. Хот суурин газрын гадаргын нөхцөл

Уур амьсгалын үнэлгээнд барилгын уур амьсгалын муж, цасан шуурга, шороон шуурга, хүчтэй салхитай өдрийн тоо гэсэн 4 үзүүлэлтийг нэгтгэн үнэлсэн ба аймгийн




нийт нутаг дэвсгэрийн 49,71 хувь буюу 4098490,65 га талбай тохиромжтой, 51,14 хувь буюу 4216752,27 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 0,18 хувь буюу 15217,47 га нь тохиромжгүй гарсан.




Зураг 134. Хот суурин газрын уур амьсгалын нөхцөл

Хөрсний хүчин зүйлийн үнэлгээнд хөрсний чанарын дундаж үзүүлэлт, хөрсний элэгдэх байдал, нурулт гулсалт, хөдөлгөөнт элс, хөрсний давсжилт гэсэн 5 үзүүлэлтийг нэгтгэн үнэлсэн ба нийт нутаг дэвсгэрийн 63,47 хувь буюу 5233812,57 га талбай тохиромжтой, 19,92 хувь буюу 1642860,63 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 17,63 хувь буюу 1453961,34 га нь тохиромжгүй гарсан /Зураг 135/

Ургамалжилтын үнэлгээнд ойжилт, ургамлан бүрхэвч гэсэн 2 үзүүлэлтийг нэгтгэн үнэлсэн ба аймгийн нийт нутаг дэвсгэрийн 22,83 хувь буюу 1882736,22 га талбай тохиромжтой, 65,67 хувь буюу 5414949,31 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 12,53 хувь буюу 1033005,71 га нь тохиромжгүй гарсан. /Зураг 136 /




Зураг 135. Хот суурин газрын хөрсний нөхцөл



Зураг 136. Хот суурин газрын ургамлын нөхцөл

## Инженер-геологийн үнэлгээ:


Инженер-геологийн үнэлгээнд газар хөдлөл, ул хөрсний шинж, олон жилийн цэвдэг, намагжилт, үерлэлт, хөрсний ус, усны нөөц гэсэн 7 үзүүлэлтийг нэгтгэн үнэлсэн бөгөөд хот суурин байгуулахад хамгийн гол үзүүлэлтийн нэг болох усны нөөцийг усан хангамжийн эх үүсвэрээс алслагдсан байдал, гадаргын болон гүний усны нөөцөөр нь үнэлсэн.




Зураг 137. Хот суурин газрын усны нөөцийн нөхцөл

Усны нөөцийн үнэлгээгээр аймгийн нийт нутаг дэвсгэрийн 32,33 хувь буюу 2665543,14 га талбай тохиромжтой, 42,24 хувь буюу 3482672,76 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 25,45 хувь буюу 2098609,56 га нь тохиромжгүй гарсан.

Үнэлгээгээр аймгийн нийт нутаг дэвсгэрийн 26,16 хувь буюу 2157209,01 га талбай тохиромжтой, 62,76 хувь буюу 5174677,71 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 12,08 хувь буюу 996048,90 га нь тохиромжгүй гарсан.



Зураг 138. Хот суурины инженер-геологийн нэгдсэн үнэлгээ  
Инженерийн дэд бүтцийн үнэлгээ:




Зураг 139. Хот суурины инженерийн дэд бүтцийн хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээ

Инженерийн дэд бүтцийн үнэлгээнд улсын чанартай авто зам, төмөр зам, агаарын тээврээр хангагдсан байдал, цахилгаан, дулаан эх үүсвэрээр хангагдсан байдал, хот суурин газраас алслагдсан байдал гэсэн 6 үзүүлэлтээр үнэлэхэд нийт нутаг дэвсгэрийн 82,72 хувь буюу 6903504,45 га талбай хязгаарлагдмал тохиромжтой, 10,86 хувь буюу 895122,90 га нь тохиромжтой, 6,53 хувь буюу 538616,79 га талбай тохиромжгүй гарч байна.

### Нэгдсэн үнэлгээ:


Хот суурин байгуулах тохиромжтой газрын нэгдсэн үнэлгээнд олон хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээг, суурь нөхцлийн үнэлгээтэй давхцуулан хийсэн бөгөөд суурь нөхцлийн үнэлгээнд 9 үзүүлэлт, хүчин зүйлийн үнэлгээнд 17 хүчин зүйлийг ашиглан үнэлсэн.

Хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 48,49 хувь нь хязгаарлагдмал тохиромжтой, 46,24 хувь нь тохиромжтой, 6,69 хувь нь тохиромжгүй гарсан.




Зураг 140. Хот суурины олон шалгуурт хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээ

Суурь нөхцлийн үнэлгээгээр 70,0 хувь нь зөвшөөрөх, 30,0 хувь нь хориглох бүсэд орж байна.



Зураг 141. Хот суурины суурь нөхцөлийн үнэлгээ



Зураг 142. Хот суурины газрын тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

Нэгдсэн үнэлгээнд суурь нөхцөлийг хасаж тооцоход аймгийн нийт нутаг дэвсгэрийн 30,57 хувь буюу 2520752,46 га талбай тохиромжтой, 35,37 хувь буюу 2916329,89 га

талбай хязгаарлагдмал тохиромжтой, 5,11 хувь буюу 421546,97 га талбай тохиромжгүй үнэлгээтэй гарсан.

#### 4.2.3 Хот суурины хэрэгцээт байдлын үнэлгээ

Хэрэгцээт байдлын үнэлгээг хот суурин газарт нийгмийн байгууламжийн хангамжаар үнэлдэг бөгөөд аймгийн хэмжээнд одоогоор 43 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас Завханмандалаас бусад бүх сумдын цэцэрлэгийн хүчин чадал хэтэрсэн байна. Иймд даац хэтрэлт болон хүн амын өсөлттэй уялдуулан 240 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг төлөвлөлтийн ойрын хугацаанд 16 цэцэрлэг, дундын хугацаанд 12 цэцэрлэг, хэтийн хугацаанд 9 цэцэрлэг барихаар төлөвлөсөн бөгөөд үүнд 210,9 тэрбум төг-ийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна.

Хүснэгт 41. Цэцэрлэгийн хэрэгцээт байдлын үнэлгээ

№	Сумын нэр	Одоо байгаа			Төлөвлөлтөөр			Хэрэгжүүлэх хугацаа		
		Тоо	Хүчин чадал, хүүхдийн тоогоор	Суралцагсдын тоо /2016 он/	Сумын хүн ам	Цэцэрлэгийн насны хүүхэд	Шаардлагатай цэцэрлэгийн тоо	Ойрын 2022 он	Дундын 2028 он	Хэтийн 2033 он
1	Алдархаан	1	50	75	4127	297	1		1	
2	Асгат	1	50	139	1760	158	1	1		
3	Баянтэс	2	100	218	3936	283	2	1		1
4	Баянхайрхан	1	50	114	2873	207	1	1		
5	Дөрвөлжин	1	50	112	3358	242	2	1		1
6	Завханмандал	1	100	82	1789	129	0			
7	Идэр	1	100	138	3710	267	1		1	
8	Их-Уул	4	200	341	9035	651	2	1		1
9	Нөмрөг	1	75	117	2841	205	1	1		
10	Отгон	1	50	162	3926	283	2	1		1
11	Сантмаргац	1	100	148	2382	172	1		1	
12	Сонгино	1	100	120	2464	177	1		1	
13	Тосонцэнгэл	6	300	909	12891	928	3	2	1	
14	Түдэвтэй	1	100	126	2907	209	1		1	
15	Тэлмэн	1	50	170	4136	298	2	1	1	
16	Тэс	1	100	217	4208	303	2	1		1
17	Ургамал	1	100	105	2051	148	1			1
18	Цагаанхайрхан	1	50	82	2121	153	1		1	
19	Цагаанчулуут	1	100	115	2004	144	1		1	
20	Цэцэн-Уул	1	50	128	2623	189	1	1		
21	Шилүүстэй	1	50	152	2845	205	1	1		
22	Эрдэнэхайрхан	1	50	81	2657	191	1		1	
23	Яруу	1	100	96	3061	220	1			1
24	Улиастай	11	890	2195	22239	2662	7	3	2	2
<b>Аймгийн нийт</b>		<b>43</b>	<b>2965</b>	<b>6142</b>	<b>105944</b>	<b>4767</b>	<b>37</b>	<b>16</b>	<b>12</b>	<b>9</b>
<b>Хөрөнгө оруулалт, тэрбум төг</b>							<b>210.9</b>	<b>91.2</b>	<b>68.4</b>	<b>51.3</b>

Аймгийн хэмжээнд 30 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас Идэр, Их-Уул, Сантмаргац, Тосонцэнгэл, Тэлмэн, Тэс, Шилүүстэй,

Улиастайн сургуулиудын даац хэтэрсэн бөгөөд одоо байгаа даац хэтрэлт болон ирээдүйд өсөх хүн амын тоонд уялдуулан 640 сурагчийн хүчин чадалтай сургуулийг төлөвлөлтийн ойрын хугацаанд 7 сургууль, дундын хугацаанд 4 сургууль, хэтийн хугацаанд 11 сургуулийг нийт 286,0 тэрбум төг-ийн санхүүжилтээр байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 42. Ерөнхий боловсролын сургуулийн хэрэгцээт байдлын үнэлгээ

№	Сумын нэр	Одоо байгаа			Төлөвлөлтөөр /2033 он/			Хэрэгжүүлэх хугацаа		
		Тоо	Хүчин чадал, хүүхдийн тоогоор	Суралцагсдын тоо /2016 он/	Сумын нийт хүн ам	Сургуулийн насны хүүхэд	Шаардлагатай сургуулийн тоо	Ойрын 2022 он	Дундын 2028 он	Хэтийн 2033 он
1	Алдархаан	1	160	90	4127	867	0			
2	Асгат	1	320	211	1760	370	0			
3	Баянтэс	1	640	595	3936	827	1	1		
4	Баянхайрхан	1	320	228	2873	603	1			1
5	Дөрвөлжин	1	160	224	3358	705	1			1
6	Завханмандал	1	320	191	1789	376	0			
7	Идэр	1	320	436	3710	779	1		1	
8	Их-Уул	1	640	1305	9035	1897	2	1		1
9	Нөмрөг	1	640	364	2841	597	0			
10	Отгон	1	480	390	3926	824	1		1	
11	Сантмаргац	1	320	344	2382	500	1			1
12	Сонгино	1	320	300	2464	517	1			1
13	Тосонцэнгэл	2	1440	2205	12891	2707	2	1		1
14	Түдэвтэй	1	480	349	2907	610	1			1
15	Тэлмэн	1	320	493	4136	869	1	1		
16	Тэс	1	480	605	4208	884	1	1		
17	Ургамал	1	420	202	2051	431	0			
18	Цагаанхайрхан	1	440	100	2121	445	0			
19	Цагаанчулуут	1	320	170	2004	421	0			
20	Цэцэн-Уул	1	320	305	2623	551	1			1
21	Шилүүстэй	1	320	366	2845	597	1		1	
22	Эрдэнэхайрхан	1	160	108	2657	558	1			1
23	Яруу	1	320	113	3061	643	1			1
24	Улиастай	6	3705	4876	22239	6237	4	2	1	1
<b>Аймгийн нийт</b>		<b>30</b>	<b>13365</b>	<b>14570</b>	<b>105944</b>	<b>22248</b>	<b>22</b>	<b>7</b>	<b>4</b>	<b>11</b>
<b>Хөрөнгө оруулалт, тэрбум төг</b>							<b>286</b>	<b>91</b>	<b>52</b>	<b>143</b>

Аймгийн хэмжээнд нэгдсэн 1 эмнэлэг, сум дундын 4 эмнэлэг, 19 сумын эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төлөвлөлтийн хугацаанд хүн амын өсөлтыг даган ойрын хугацаанд 3 эмнэлэг, дундын хугацаанд 6 эмнэлэг, хэтийн хугацаанд 14 эмнэлэг байгуулахаар төлөвлөсөн.



## Хүснэгт 43. Эмнэлэгийн хэрэгцээт байдлын үнэлгээ

№	Сумын нэр	Одоо байгаа		Төлөвлөсөн					Төлөвлөлтийн хугацаа		
		Төрөл	Хүчин чадал, ор	Нийт хүн ам	Хэрэгцээ, ор	Эмнэлэгийн тоо	Төрөл	Хүчин чадал, ор	Ойрын 2022 он	Дундын 2028 он	Хэтийн 2033 он
1	Алдархаан	сумын	5	4127	33	1	сумын	30	1		
2	Асгат	сумын	6	1760	14	1	сумын	10			1
3	Баянтэс	сумын	8	3936	31	1	сум дундын	30		1	
4	Баянхайрхан	сумын	8	2873	23	1	сумын	10			1
5	Дөрвөлжин	сумын	7	3358	27	1	сумын	10		1	
6	Завханмандал	сум дундын	10	1789	14	1	сум дундын	10	1		
7	Идэр	сумын	8	3710	30	1	сумын	10			1
8	Их-Уул	сум дундын	15	9035	72	1	сумын	30			1
9	Нөмрөг	сумын	7	2841	23	1	сумын	10			1
10	Отгон	сумын	7	3926	32	1	сумын	30		1	
11	Сантмаргац	сумын	7	2382	19	1	сумын	10			1
12	Сонгино	сумын	7	2464	20	1	сумын	10	1		
13	Тосонцэнгэл	сумын	75	12891	103	1	сум дундын	30		1	
14	Түдэвтэй	сум дундын	18	2907	23	1	сумын	10		1	
15	Тэлмэн	сумын	7	4136	3	-	сумын	-	-	-	-
16	Тэс	сумын	8	4208	34	1	сумын	30			1
17	Ургамал	сумын	5	2051	16	1	сумын	10			1
18	Цагаанхайрхан	сумын	5	2121	17	1	сумын	10			1
19	Цагаанчулуут	сумын	5	2004	16	1	сумын	10			1
20	Цэцэн-Уул	сумын	6	2623	21	1	сумын	10			1
21	Шилүүстэй	сум дундын	10	2845	23	1	сумын	10		1	
22	Эрдэнэхайрхан	сумын	6	2657	21	1	сумын	10			1
23	Яруу	сумын	5	3061	24	1	сумын	10			1
24	Улиастай	нэгдсэн эмнэлэг	205	22239	178	1	Оношл огооны төв эмнэлэг	60			1
<b>Аймгийн нийт</b>			<b>450</b>	<b>105944</b>		<b>23</b>		400	3	6	14
<b>Хөрөнгө оруулалт, тэрбум төг</b>						<b>31,74</b>			<b>3,74</b>	<b>8,4</b>	<b>19,6</b>

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулан хот суурины хүн амын төлөвлөлтийг тооцоолсон бөгөөд хүн амын өсөлтийн хэрэгцээнд үндэслэн хот төлөвлөлтийн норм дүрмийн дагуу нийгмийн байгууламжуудад шаардагдах эдэлбэр газрын хэрэгцээг төлөвлөсөн.

**Олон нийт, ажил хэргийн бүсийн хэрэгцээ:** 240 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгүүдийг хот төлөвлөлтийн нормоор 1 хүүхдэд ноогдох талбайг 35 м.кв-аар тооцоход 1 цэцэрлэгийн хэрэгцээт эдэлбэр газрын талбай 0,84 га байна.

640 сурагчийн хүчин чадалтай ерөнхий боловсролын сургуулийг хот төлөвлөлтийн нормоор 1 хүүхдэд ноогдох талбайг 25м.кв-аар тооцоход 1 сургуулийн хэрэгцээт эдэлбэр газрын талбай 1,6 га байна.

Эмнэлэгийн хэрэгцээт эдэлбэр газрыг хот төлөвлөлтийн нормын дагуу 1 ор тутамд 300 м.кв талбайгаар тооцож 10 ортой сумын эмнэлэгийг 0,3 га, 30 ортой сум дундын

эмнэлэгийг 0,9 га, аймгийн нэгдсэн оношлогооны төв эмнэлэгийг 1,2 га талбайтай байхаар төлөвлөсөн.

**Суурьшлын бүсийн хэрэгцээ:** Хуваарьт эдлэнт хувийн сууц болон гэр хорооллын хэрэгцээт газрын хэмжээг Улиастай хотод 1 өрхөд хамгийн ихдээ 0,35 га, хамгийн багаар 0,07 га-аар, сумын төвүүдэд 1 өрхөд 0,07-0,5 га-аар тооцож төлөвлөсөн.


**Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн бүсийн хэрэгцээ:** Биеийн тамир, спортын байгууламжийг хот төлөвлөлтийн нормоор 1000 хүнд 0.7га-аар хэрэгцээт газрыг төлөвлөсөн. Ногоон байгууламжийг 1 хүнд 5 м.кв талбайгаар тооцож төлөвлөсөн.

Бусад бүсүүдийн хэрэгцээг хот төлөвлөлтийн нормоор тооцох боломжгүй, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр шийдвэрлэх тул хэрэгцээт талбайг тооцоогүй.

**Иргэнд өмчлүүлэх газрын хэрэгцээ, төлөвлөлт:**

Төлөвлөлтийн хугацаанд дахь хүн амын өсөлтийг даган иргэн бүрт газар өмчлүүлэх хэрэгцээг тооцсон. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 8821 хүн газар өмчилж, өмчлөлийн хувь 12,4 хувьтай байгаа бол одоогийн хүн амд 0,5 га-аар газар өмчлүүлбэл 25119,5 га газар, 0,35 га-аар өмчлүүлбэл 21710,9 га, 0,07 га-аар өмчлүүлбэл 4342,2 га газар шаардлагатай байна. Харин хүн амын өсөлтийг тооцож үзэхэд 0,5 га-аар газар өмчлүүлбэл 39424 га газар, 0,35 га-аар өмчлүүлбэл 33993,05 га, 0,07 га-аар өмчлүүлбэл 6798,61 га газар шаардлагатай байна /Хүснэгт 45 /.

БХБЯ-аас баталсан мянганы зам дагуу шинээр иргэнд өмчлүүлэх газрын төлөвлөлтөөр Завхан аймгийн 8 суманд 20 байршил дээр 11863,12 га талбайг иргэнд өмчлүүлэхээр төлөвлөгдсөн.



Зураг 143. Улсын чанартай авто зам дагуу иргэнд шинээр өмчлүүлэх газрын байршлын төлөвлөлт

№	Сумын нэр	Ойрын 2022 он					Дундын 2028 он					Хэтийн 2033 он				
		Цэцэрлэг	ЕБСургууль	Эмнэлэг	Биеийн тамир, спортын цогцолбор	Ногоон байгууламж	Цэцэрлэг	ЕБСургууль	Эмнэлэг	Биеийн тамир, спортын цогцолбор	Ногоон байгууламж	Цэцэрлэг	ЕБСургууль	Эмнэлэг	Биеийн тамир, спортын цогцолбор	Ногоон байгууламж
1	Улиастай	2,52	3,2		11,78	8,41	1,68	1,6		11,91	8,50	1,68	1,6	1,2	12,04	8,6
2	Алдархаан			0,9	0,77	0,55	0,84			0,8	0,57				0,83	0,59
3	Асгат	0,84			0,32	0,23				0,32	0,23			0,3	0,33	0,23
4	Баянтэс	0,84	1,6		0,95	0,68			0,9	0,97	0,69	0,84			0,99	0,7
5	Баянхайрхан	0,84			0,45	0,32				0,47	0,33		1,6	0,3	0,48	0,35
6	Дөрвөлжин	0,84			0,44	0,31			0,3	0,46	0,33	0,84	1,6		0,49	0,35
7	Завханмандал			0,3	0,3	0,21				0,31	0,22				0,32	0,23
8	Идэр				0,42	0,30	0,84	1,6		0,42	0,3			0,3	0,43	0,3
9	Их-Уул	0,84	1,6		0,97	0,69				0,99	0,71	0,84	1,6	0,9	1,02	0,73
10	Нөмрөг	0,84			0,34	0,24				0,36	0,26			0,3	0,38	0,27
11	Отгон	0,84			0,30	0,21		1,6	0,9	0,30	0,21	0,84			0,3	0,22
12	Сантмаргац				0,29	0,21	0,84			0,29	0,21		1,6	0,3	0,3	0,21
13	Сонгино			0,3	0,35	0,25	0,84			0,36	0,25		1,6		0,37	0,26
14	Тосонцэнгэл	1,68	1,6		3,15	2,25	0,84		0,9	3,21	2,29		1,6		3,27	2,33
15	Түдэвтэй				0,4	0,28	0,84		0,3	0,4	0,28		1,6		0,4	0,29
16	Тэлмэн	0,84	1,6		0,34	0,24	0,84			0,35	0,25				0,36	0,25
17	Тэс	0,84	1,6		0,9	0,65				0,93	0,66	0,84		0,9	0,95	0,68
18	Ургамал				0,54	0,39				0,57	0,41	0,84		0,3	0,59	0,42
19	Цагаанхайрхан				0,25	0,18	0,84			0,26	0,19			0,3	0,27	0,19
20	Цагаанчулуут				0,24	0,17	0,84			0,24	0,17			0,3	0,25	0,18
21	Цэцэн-Уул	0,84			0,26	0,19				0,26	0,19		1,6	0,3	0,27	0,19
22	Шилүүстэй	0,84			0,27	0,19		1,6	0,3	0,28	0,2				0,3	0,21
23	Эрдэнэхайрхан				0,38	0,27	0,84			0,41	0,29		1,6	0,3	0,44	0,32
24	Яруу				0,39	0,28				0,42	0,3	0,84	1,6	0,3	0,44	0,32
<b>Аймгийн нийт</b>		<b>13,44</b>	<b>11,2</b>	<b>1,5</b>	<b>24,79</b>	<b>17,71</b>	<b>10,08</b>	<b>6,4</b>	<b>3,6</b>	<b>25,29</b>	<b>18,07</b>	<b>7,56</b>	<b>17,6</b>	<b>6,3</b>	<b>25,81</b>	<b>18,44</b>

№	Хот суурины нэр	Одоо байгаа, 2016 он						Төлөвлөлтийн эцэст 2033 он			
		Сумын нийт хүн амын тоо	Өмчилсөн иргэдийн тоо	Өмчлөлийн хувь	Шаардлагатай газрын хэрэгцээ			Сумын нийт хүн амын тоо	Шаардлагатай газрын хэрэгцээ		
					Дээд 0,5га	Дунд 0,35га	Доод 0,07га		Дээд 0,5га	Дунд 0,35га	Доод 0,07га
1	Улиастай	15756	3964	25,2		4127,2	825,4	22239		6396,25	1279,25
2	Алдархаан	2816	58	2,1	1379,0	965,3	193,1	4127	2034,5	1424,15	284,83
3	Асгат	952	32	3,4	460,0	322,0	64,4	1760	864	604,8	120,96
4	Баянтэс	1780	165	9,3	807,5	565,3	113,1	3936	1885,5	1319,85	263,97
5	Баянхайрхан	2587	179	6,9	1204,0	842,8	168,6	2873	1347	942,9	188,58
6	Дөрвөлжин	2153	232	10,8	960,5	672,4	134,5	3358	1563	1094,1	218,82
7	Завханмандал	1095	44	4,0	525,5	367,9	73,6	1789	872,5	610,75	122,15
8	Идэр	2481	259	10,4	1111,0	777,7	155,5	3710	1725,5	1207,85	241,57
9	Их-Уул	6238	529	8,5	2854,5	1998,2	399,6	9035	4253	2977,1	595,42
10	Нөмрөг	1875	258	13,8	808,5	566,0	113,2	2841	1291,5	904,05	180,81
11	Отгон	2656	365	13,7	1145,5	801,9	160,4	3926	1780,5	1246,35	249,27
12	Сантмаргац	1513	226	14,9	643,5	450,5	90,1	2382	1078	754,6	150,92
13	Сонгино	1541	141	9,1	700,0	490,0	98,0	2464	1161,5	813,05	162,61
14	Тосонцэнгэл	1845	108	5,9	868,5	608,0	121,6	12891	6391,5	4474,05	894,81
15	Түдэвтэй	2732	279	10,2	1226,5	858,6	171,7	2907	1314	919,8	183,96
16	Тэлмэн	2875	389	13,5	1243,0	870,1	174,0	4136	1873,5	1311,45	262,29
17	Тэс	9047	551	6,1	4248,0	2973,6	594,7	4208	1828,5	1279,95	255,99
18	Ургамал	1264	160	12,7	552,0	386,4	77,3	2051	945,5	661,85	132,37
19	Цагаанхайрхан	1274	138	10,8	568,0	397,6	79,5	2121	991,5	694,05	138,81
20	Цагаанчулуут	1204	235	19,5	484,5	339,2	67,8	2004	884,5	619,15	123,83
21	Цэцэн-Уул	1694	172	10,2	761,0	532,7	106,5	2623	1225,5	857,85	171,57
22	Шилүүстэй	1818	274	15,1	772,0	540,4	108,1	2845	1285,5	899,85	179,97
23	Эрдэнэхайрхан	1635	28	1,7	803,5	562,5	112,5	2657	1314,5	920,15	184,03
24	Яруу	2021	35	1,7	993,0	695,1	139,0	3061	1513	1059,1	211,82
<b>Аймгийн нийт</b>		<b>70852</b>	<b>8821</b>	<b>12,4</b>	<b>25119,5</b>	<b>21710,9</b>	<b>4342,2</b>	<b>105944</b>	<b>39424</b>	<b>33993,05</b>	<b>6798,61</b>

#### 4.2.4 Хот, суурины функциональ бүсийн төлөвлөлт

##### Хүн амын төлөвлөлт:

Аймгийн хэмжээнд сумын төвийн хүн амын өсөлт нь ихэнх сумдуудад буурах үзүүлэлттэй гарч байгаа тул хүн амын өсөлтийг сумын нийт хүн амын дундаж өсөлтөөр тооцсон.

Хүснэгт 46. Хот суурингийн хүн амын судалгаа


№	Сумын нэр	2014 он		2015 он		2016 он		Жилийн дундаж өсөлт, хувь
		Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	
1	Улиастай			16006	4855	15756	4792	1,1
2	Алдархаан	847	267	848	270	879	282	3,8
3	Асгат	421	131	408	134	414	138	1,5
4	Баянтэс			1203	401	1230	412	1,7
5	Баянхайрхан	518	148	518	148	524	157	3,5
6	Дөрвөлжин	993	281	450	137	469	149	5,0
7	Завханмандал	325	100	312	96	329	107	4,3
8	Идэр	543	166	543	168	550	169	1,3
9	Их-Уул	1199	330	1202	339	1170	333	2,8
10	Нөмрөг	290	103	319	104	320	104	7,0
11	Отгон	414	135	389	122	400	121	1,0
12	Сантмаргац	383	117	436	116	376	120	1,5
13	Сонгино			401	116	417	118	2,9
14	Тосонцэнгэл	4271	1354	4342	1356	4048	1305	1,8
15	Түдэвтэй	554	173	557	170	545	170	0,6
16	Тэлмэн	450	125	443	122	430	120	2,1
17	Тэс	1192	404	1103	365	1108	369	2,6
18	Ургамал	309	93	302	91	597	175	4,5
19	Цагаанхайрхан	264	90	281	102	296	103	3,4
20	Цагаанчулуут	255	78	271	83	276	85	3,4
21	Цэцэн-Уул	434	184	370	168	356	103	0,8
22	Шилүүстэй	277	88	279	89	294	95	4,7
23	Эрдэнэхайрхан	311	86	313	89	355	105	7,5
24	Яруу	385	118	381	115	396	120	6,0

Хүн амын хэтийн төлөвийг тооцохдоо жилийн дундаж өсөлтийг ашиглан статистикийн томъёогоор тооцсоноор аймгийн хэмжээнд төлөвлөлтийн ойрын хугацаанд 35417 хүн ам, 317 өрх, дундын хугацаанд 36134 хүн ам, 355 өрх, хэтийн хугацаанд 36873 хүн ам, 389 өрх болж өсөх хандлагатай байна.

Хүснэгт 47. Хот суурин газрын хүн амын төлөвлөлт

№	Сумын нэр	Одоогийн байдал, 2016 он		Ойрын 2022 он		Дундын 2028 он		Хэтийн 2033 он	
		Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх	Хүн ам	Өрх
1	Улиастай	15756	4792	16825	5117	17010	5173	17197	5230
2	Алдархаан	879	282	1099	353	1141	366	1185	380
3	Асгат	414	138	453	151	459	153	466	155
4	Баянтэс	1230	412	1361	456	1384	464	1408	471
5	Баянхайрхан	524	157	644	193	667	200	690	207
6	Дөрвөлжин	469	149	629	200	660	210	693	220
7	Завханмандал	329	107	424	138	442	144	461	150
8	Идэр	550	169	594	183	602	185	610	187

9	Их-Уул	1170	333	1381	393	1420	404	1459	415
10	Нөмрөг	320	104	480	156	514	167	550	179
11	Отгон	400	121	425	128	429	130	433	131
12	Сантмаргац	376	120	411	131	417	133	424	135
13	Сонгино	417	118	495	140	509	144	524	148
14	Тосонцэнгэл	4048	1305	4505	1452	4586	1479	4669	1505
15	Түдэвтэй	545	170	565	176	568	177	572	178
16	Тэлмэн	430	120	487	136	497	139	508	142
17	Тэс	1108	369	1292	430	1326	442	1361	453
18	Ургамал	597	175	777	228	812	238	849	249
19	Цагаанхайрхан	296	103	362	126	374	130	387	135
20	Цагаанчулуут	276	85	337	104	349	107	361	111
21	Цэцэн-Уул	356	103	373	108	376	109	379	110
22	Шилүүстэй	294	95	387	125	405	131	425	137
23	Эрдэнэхайрхан	355	105	548	162	589	174	633	187
24	Яруу	396	120	562	170	595	180	631	191
<b>Аймгийн нийт</b>		<b>31535</b>	<b>9752</b>	<b>35417</b>	<b>10957</b>	<b>36134</b>	<b>11179</b>	<b>36873</b>	<b>11408</b>



Диagramм 69. Аймгийн хот суурин газрын хүн амын өсөлтийн төлөвлөлт

### Ерөнхий төлөвлөгөөний шийдэл буюу функциональ бүсийн төлөвлөлт:

Хот суурингийн газрыг зөв оновчтой ашиглаж, хамгаалахын тулд суурьшилийн тэг гортиг болон тэлэх нөөц бүсийн доторх нутаг дэвсгэрийг хотын функциональ бүсүүдэд төрөлжүүлэн төлөвлөж, тэдгээрийн ерөнхий чиг, үүрэг онцлогийг тодорхойлох шаардлагатай бөгөөд Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд төлөвлөгдсөн хотын функциональ бүсийн ангилалаар сумын төвүүдийн төлөвлөлтийг хийсэн. /П.Мягмарцэцэрэн, И.Мягмаржав, 2013 он/

2033 он хүртэл ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн хугацаанд аймгийн хот суурин газруудад ажиллаж, амьдрах оршин суугчдын орон сууцны хангамжийг дээшлүүлэх, сумын хүн амд шаардагдах соёл, олон нийтийн болон ахуй үйлчилгээний барилга байгууламж нэмэгдүүлэх, эмх замбараагүй газар ашиглалтыг цэгцлэх, орц гарцгүй олголттой эдэлбэр газруудыг дахин төлөвлөх, эдийн засгийн хөгжлийн үндэс суурь болох орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг

эрчимжүүлэхээр тооцож төлөвлөлтийн хүчин чадалд тулгуурлан функциональ бүсүүдийг төлөвлөсөн.

Хот суурины ерөнхий төлөвлөгөөнд дараахь үндсэн зарчимуудыг баримталсан. Үүнд:

- Хүн амын амьдрах, хөдөлмөрлөх нөхцөл, экологийн тэнцвэрт байдлын шаардлагыг бүрэн хангасан байх
- Монгол улсын “Үндсэн хууль” “Газрын тухай багц хууль” болон бусад хууль эрхзүйн баримт бичигт бүрэн нийцсэн байх
- Иргэдийн үл хөдлөх хөрөнгө болон газрын эрхийг аль болох хөндөхгүй байх
- Иргэдийн оролцоон дээр тулгуурлах
- Тэгш шударга хандах

Төлөвлөлтөнд дараахь үндсэн шийдлүүдийг тусгасан. Үүнд:

- Сумын газар нутгийн үүрэг зориулалтын хувьд одоо байгаа газар ашиглалтыг аль болох хэвээр хадгалан үлдээлээ. Энэ ялангуяа сургууль, цэцэрлэг, эмнэлэг, гэр хорооллын орчимд энэ зарчмыг барьсан болно. Цаашид ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөлд ч энэ зарчмыг хэвээр хадгалж үргэлжлүүлэх нь зүйтэй.
- Судалгааны үед зарим сумын төвийн барилгууд нь байршлын хувьд гол, нуурын эрэг, элсэн манханы эргээр байрлаж байгаа нь хот тэлэх нөөц газрын хэмжээг бууруулах нөхцөлийг бүрдүүлж байна.
- Хамгийн сонирхол татах суурьшлын хэсэг нь гэр хороолол бөгөөд ихэнх сумын төвийн гэр хороолол нь урт сунасан байрлалтай байгаа тул, босоо гудам төлөвлөхөд зайлшгүй айлуудыг нүүлгэх шаардлага үүсч байна.
- Сумын төвүүд нь газар ашиглалтын нягтшил бага тул аль болох нягтшилийг нэмэгдүүлэхийг зорьсон.
- Нийгэм – эдийн засгийн шинэ харилцааны өнөөгийн байдлаас шалтгаалан орон сууцны хангамжийн асуудал нэлээд шинэлэг байдлаар тавигдаж байгаа бөгөөд орон сууцны хангамж, төрөл хэлбэрийн хувьд тохилог, сумын төвийн барилгажилтанд нийцсэн нам давхар орон сууцны зэрэгцээ хувийн эзэмшлийн амины орон сууц барих сонирхол илүү давамгайлах хандлагатай болсон бөгөөд амины орон сууцны хувьд оршин суугчид эдэлбэр газар бүхий орон сууцыг илүү түлхүү сонирхох болсонтой уялдуулан зарим сумын төвүүдэд амины орон сууцыг төлөвлөсөн.
- Мөн одоо байгаа гэр хороолол болон төвийн төлөвлөлтийг сайжруулах зорилгоор дахин төлөвлөлтөөр хөгжүүлэх бодлогын бүсийг төлөвлөсөн.
- Хамгаалалтын бүсэд одоо байгаа газар ашиглалтуудыг боломжтой бол нүүлгэн шилжүүлэх, цаашид газар ашиглалтыг хязгаарлах бодлогын бүс төлөвлөсөн.
- Төлөвлөлтийн хугацаанд хуучин наадмын талбайг цэнгэлдэх хүрээлэн болгож тохижуулж, түүнтэй уялдуулан ногоон байгууламж /цэцэрлэгт хүрээлэн/ төлөвлөж өгснөөр сумын төвийн хот байгуулалтын нүүр царай үндсэндээ өөрчлөгдөх болно гэж үзлээ.
- Одоо байгаа ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамир – спортын талбай болон шинээр сургууль, цэцэрлэгийг хот төлөвлөлтийн норм дүрмийн дагуу тооцож төлөвлөсөн бөгөөд цаашдаа газрын харилцааны үүднээс газар олголтын хувьд сургалтын зориулалттай биеийн тамир – спортын талбай нь

төлөвлөлтийн дагуу ашиглагдаж, эзэмшигдэх ёстой бөгөөд энэ байдал Монгол улсын хэмжээнд хэмжээнд нийтлэгээр норм дүрмийн болон төлөвлөгдсөн зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа байдал томоохон аймгийн төв – хотуудын жишээн дээр тод харагдаж байгааг цаашид давтахгүй байх нь чухал байна.

- Сумын төвийн гол магистраль авто зам болон туслах авто замууд нь эмх замбараагүй байрласан тул гол замыг түшиглэн авто замын сүлжээг аль болох өртөг зардал бага байхаар төлөвлөсөн.
- Сумын ерөнхий төлөвлөгөөгөөр одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр сумын төвийн эдэлбэр газрын ашиглалт зохион байгуулалтыг улам сайжруулж, нягтруулах, гудамж талбайн өнгө үзэмж, тохижилтыг дээшлүүлэхийн тулд соёл, ахуй үйлчилгээний болон олон нийтийн зориулалттай барилгыг төвийн хэсгийн зохистой талбайд байрлуулан төвийн архитектур, гоо зүй-орон зайн шийдлийг иж бүрнээр нь хэрэгжүүлэхийг зорьж төлөвлөсөн.
- Цаашид ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд сумын төв бүрт жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх хөнгөн үйлдвэрийн бүсийг төвийн салхины зонхилох чиглэлийн доор төлөвлөсөн.
- Шинээр өмчлүүлэх байршил дээр эрчим хүчний тооцоог хийн, цаашдын хэрэгцээн дээр үндэслэн шугам сүлжээний газрыг төлөвлөсөн.

Хүн амын амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлсэн аль болох автомашинаас хамааралгүй байхаар холимог функциональ бүсүүдийг ландшафтын байдал, гадаргын тогтоцтой уялдуулан Хот, тосгоны төлөвлөлт барилгажилт БНБД 30-01-04, Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар УББ 30-201-09, Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт-зохион байгуулалт, барилгажуулалт БД 30-101-05 зэрэг бусад холбогдох норм дүрмийг мөрдлөг болгон төлөвлөсөн.

Нийгэм соёлын үйлчилгээний түвшин хангалтгүй, үйлдвэрлэл аж ахуйн уялдаа холбоо сул, зөвхөн засаг захиргааны үүрэг давамгайлсан сумын төвийг зах зээлийн харилцааны нийтлэг шаардлагын үүднээс нутаг дэвсгэрээр бүсчлэн , эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн чиг баримжаатай болгох асуудал хөдөөгийн хөгжлийн тулгамдсан асуудал болоод байна. Төвийн болон хязгаар нутгийн хөгжлийн ялгааг тэнцвэржүүлэх, хүн амын хэт төвлөрөл, их нүүдлийг сааруулах, бүс нутгууд харьцангуй бие дааж хөгжих, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх угтвар нөхцлийг бүрдүүлэх асуудал дэд бүтцийн оновчтой сүлжээнд суурилах тул одоогийн байгаа сууршлийн бүсүүдийн хил заагийг тэлэн өргөжүүлэхэд болохгүй зүйл үгүй боловч энд байгаа шаардлагагүй сул чөлөөтэй зориулалтын бус газруудыг суурьших үйл явцад ашиглах, аль болох нягтралыг сайжруулах замаар зохистой ашиглах, суурингуудын орчныг экологийн тэнцвэржүүлэх бүс болгож хамгаалалтын дэглэмийг сайтар мөрдөх хэрэгтэй.

Хот суурингийн газрыг зөв оновчтой ашиглаж, хамгаалахын тулд суурьшилийн тэг гортиг болон тэлэх нөөц бүсийн доторх нутаг дэвсгэрийг хотын функциональ бүсүүдэд төрөлжүүлэн төлөвлөж, тэдгээрийн ерөнхий чиг , үүрэг онцлогийг тодорхойлов. Үүнд:



Хүснэгт 48. Төлөвлөж буй функциональ бүсүүд

Үндсэн бүс:	Дэд бүс:
Суурьшлын бүс	Гэр хорооллын бүс
	Хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс
Олон нийт, ажил хэргийн бүс	Хотын олон нийт, ажил хэргийн төв бүс
	Хотын олон нийт, ажил хэргийн дэд бүс
Үйлдвэрийн бүс	Хөнгөн үйлдвэрийн бүс
Холимог ашиглалтын бүс	Үйлдвэр сууцны холимог бүс
	Худалдаа, үйлдвэр сууцны холимог бүс
Инженерийн шугам сүлжээ, зам тээврийн бүс	Гудамж зам тээврийн бүс
Ногоон байгууламжийн бүс	Ногоон байгууламж, задгай талбай
	Цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламжийн бүс
Хот орчмын хөдөө аж ахуйн бүс	Эрчимжсэн аж ахуйн бүс

Хүснэгт 49. Төлөвлөж буй бодлогын бүсүүд

Газрын бодлогын бүсүүд	Цаашид авах арга хэмжээ
Дахин төлөвлөлтөөр хөгжүүлэх бүс	Газар дахин төлөвлөлт хийж, орц гарц, гудам замын сүлжээг сайжруулах
Ашиглалтыг хязгаарлах бүс	Боломжтой бол одоо байгаа ашиглалтыг шилжүүлэх, цаашид газар олгохгүй байх
Ашиглалтыг хориглох бүс	Одоо байгаа ашиглалтыг шилжүүлж, цаашид газар олгот хийхгүй байх
Аж ахуйн зориулалтаар олгох нөөц газар	Аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар газар олголт хийх
Гэр бүлийн зориулалтаар олгох нөөц газар	Гэр бүлийн зориулалтаар өмчлүүлж, эзэмшүүлэх

Хот суурингуудын тэлэх нөөц газрыг, иргэнд өмчлүүлэх нөөц газартай нь уялдуулан эдгээр функциональ бүсүүдийг төлөвлөсөн.

**Суурьшлын бүс:**

Сумын төвүүдэд гэр хорооллын бүс болон хуваарьт эдлэнт хувийн сууцны бүсийг төлөвлөсөн.

Энд сумын төвүүдэд орших айл өрхийн дангаараа буюу хэд хэдээрээ тодорхой эзэмшил газар, хашаатайгаар нэг буюу хэд хэдэн байр орон сууцыг блоклон барьсан хөршийн хэлбэрээр оршин сууж байгаа амины орон сууцны барилгын газрыг багтаасан бөгөөд хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс нь өвөрмөц архитектур дизайнтай байхаар дэд бүтцэд бүрэн холбогдох боломжтой байршилүүдэд төлөвлөсөн.

**Олон нийт ажил хэргийн төв болон дэд бүс:**

Хотын олон нийт ажил хэргийн төв бүс нь холимог газар ашиглалт бүхий сумын төвийн төв хэсгийг хэлэх бөгөөд хамгийн их нягтшилтай, мөн орц гарц нь зарим нь сумын төвд хүндрэлтэй байгаа тул энэ бүсийг дахин төлөвлөлтөөр хөгжүүлэхээр төлөвлөсөн. Цаашид нийгмийн болон үйлчилгээний байгууламжийн газрууд нэмэгдэх хэрэгцээтэй тул эдгээр шинэ байгууламжуудыг аль болох хотын олон нийт ажил хэргийн дэд бүсэд оруулан төлөвлөсөн.

**Хөнгөн үйлдвэрийн бүс:**

Уг бүсийн газрыг төлөвлөхдөө хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд чухал ач холбогдолтойн үүднээс хотын салхин дор байрлахаар төлөвлөсөн.

Эхний ээлжинд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цогцолбор төв, мод боловсруулах үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, ХАА-н тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төв, биобордоо, чацаргана боловсруулах

үйлдвэр зэрэг төлөвлөгдсөн үйлдвэрүүдэд газар олголт хийх зарчмаар төлөвлөсөн. Зраим сумын төвийн өвчний тэжээлийн фондын агуулахыг түшиглэн үйлдвэр, сууцны холимог бүс төлөвлөсөн.

#### **Ногоон байгууламжийн бүс:**

Уг бүсэд сумын төвийн эзэмшил доторх зориудаар байгуулсан цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн паркийг хамруулав. Уг бүс нь хүн амын эрүүл мэнд, нөхөн сэргээх, алжаал ядаргаагаа тайлах, агаарын бохирдлыг багасгахад чухал үүрэг гүйцэтгэх учир хот төлөвлөлтөнд байх зайлшгүй бүс юм. Эхний ээлжинд цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн бүсэд хөрөнгө оруулалт хийж тохижуулах шаардлагатай ба цаашид ногоон байгууламж, задгай талбайг тохижуулах замаар шийдвэрлэнэ.

#### **Хамгаалалтын бүс:**

Хамгаалалтын бүсүүдийг гол, нуур, худаг, цаг уурын ажиглалтын талбай, шатахуун түгээх станц, өндөр хүчдэлийн шугам, кабелийн шугам, нисэх буудалд татсан бөгөөд дараахь эрхзүйн баримт бичигт заасны дагуу 50-200 м-ийн өргөнтэйгээр төлөвлөсөн.

Хүснэгт 50. Хот суурины газарт төлөвлөсөн хамгаалалтын бүсийн стандарт утга

Хамгаалалтын бүс төлөвлөсөн объект	Хамгаалалтын бүсийн төрөл	Хэмжээ, метр	Эрхзүйн баримт бичиг
Худаг	Эрүүл ахуйн бүс	100	Усны тухай хууль"-ийн 33-р зүйлийн 1 заалт
Гол, нуур, мөрөн	Онцгой хамгаалалтын бүс	50	Усны тухай хууль"-ийн 22-р зүйлийн 2 заалт
	Энгийн хамгаалалтын бүс	200	Усны тухай хууль"-ийн 22-р зүйлийн 3 заалт
Шатахуун түгээх станц	Хамгаалалтын бүс	100	Монгол улсын стандарт MNS 4628-98
Цаг уурын ажиглалтын талбай	Хамгаалалтын бүс	100	"Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль"-ийн 11-р зүйлийн 3 заалт
Нисэх буудал	Аэродром орчмын аюулгүй бүс буюу тусгай бүс	Аэродромын хөөрч буух зурвасын дагуу 1 болон 2 чиглэлд 4км 300м урттай, өргөн нь 1км	МУ-ын Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2001 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 55 тоот тушаал

#### **Гудамж, зам тээврийн бүс:**

Сумын төвүүдэд орших барилга байгууламж, зам талбайг холбосон одоо байгаа бусад авто замууд нь ач холбогдлоор бага, биеэ дааж тодорхой түвшинд зохицуулагдаагүй хөрсөн хучилттай буюу шороон авто замууд байна. Иймд замын сүлжээг төлөвлөхдөө торон системийг сонгон, гол болон туслах замын сүлжээний эргэлтийн радиусыг 15.0м-ээр төлөвлөсөн. Гудамж замын сүлжээний хувьд дараахь төлөвлөлтийн шийдлийг баримталсан:

1. Одоо байгаа шороон замыг өргөтгөж, сайжруулах
2. Шинэ зам гаргах

Хот төлөвлөлт барилгажилтын норм ба дүрмийн /БНБД 30-01-03/ 6.18-д заасны дагуу шинээр дараахь 2 зэрэглэлийн замуудыг төлөвлөсөн.

Хүснэгт 51. Авто зам төлөвлөлтийн стандарт үзүүлэлт

Гудамж замын зэрэглэл	Хөдөлгөөний тооцоот хурд, км/цаг	Замын нэг зурвасны өргөн, м	Замын эгнээний тоо	Тойруугийн хамгийн бага радиус, м	Хамгийн их дагуу налуу, %	Явган замын өргөн, м
Нутаг дэвсгэрийн гол гудамж зам	60	3.5	2	150	60	1,5
Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам	50	3.5	2	150	60	1,5

Төвийн хэсгийн гудамж, зам тээврийн сүлжээг одоо байгаа болон төлөвлөж байгаа барилга байгууламжтай уялдуулан одоо нэгэнт тогтсон авто замуудыг босоо чиглэлд 170-500м, харин хэвтээ чиглэлд 120-300м алгасалтайгаар холбож, төлөвлөлтийн гудамж, зам тээврийн сүлжээг төлөвлөсөн ба энэ замууд нь 7.0 м-ийн өргөнтэйгээр төлөвлөгдсөн болно.

**АЛДАРХААН СУМ**

**Сумын төвийн тэг гортиг:** БХБЯ-аас батлагдсан иргэнд өмчлүүлэх газрын төлөвлөлттэй уялдуулан 343,1 га талбайтай байсан сумын төвийг тэлж 8906,24 га талбайтай болгон төлөвлөсөн. Ингэснээр хүн амын нягтшил нь 1 хүнд 0,4 га талбай ноогдож байсан бол төлөвлөлтөөр нэмэгдэн 7,5 га талбай ноогдохоор болсон.

Хүснэгт 52. Алдархаан сумын төвийн тэг гортиг /төлөвлөлтөөр/

Эргэлтийн цэгүүд	Талбай, га	Уртраг	Өргөрөг
1	8906,24	96° 30' 57.47"	47° 37' 55.402"
2		96° 26' 4.453"	47° 42' 30.969"
3		96° 26' 1.441"	47° 43' 32.274"
4		96° 33' 44.923"	47° 43' 44.814"
5		96° 34' 58.644"	47° 42' 45.627"
6		96° 36' 18.416"	47° 41' 17.566"
7		96° 31' 52.133"	47° 37' 28.984"

Алдархаан сумын төвд дараахь функциональ болон бодлогын бүсүүдийг төлөвлөсөн.

Хүснэгт 53. Алдархаан сумын төвийн төлөвлөлтийн бүсүүдийн талбай, га

№		Төлөвлөлтийн бүс	Талбай /га/	Эзлэх хувь
1	Сумын төв	Хуваарьт эдлэн хувийн сууцны бүс	14,08	0,16
2		Гэр хорооллын бүс	365,95	4,11
3		Олон нийт, ажил хэргийн төв бүс	53,30	0,60
4		Үйлдвэрийн бүс	33,30	0,37
5		Ногоон байгууламж задгай талбай	3946,52	44,32
6		Голын энгийн хамгаалалтын бүс	25,69	0,29
7		Голын онцгой хамгаалалтын бүс	1,65	0,02
8		Гудамж, зам тээврийн бүс	8,04	0,09
9	Шинээр өмчлүүлэх газар /тэлэх нөөц бүс/	Иргэнд өмчлүүлэх газар	551,35	6,19
10		Голын энгийн хамгаалалтын бүс	204,03	2,29
11		Голын онцгой хамгаалалтын бүс	71,55	0,80
12		Нийтийн эзэмшлийн бусад газар	616,35	6,92
13		Ногоон байгууламж	211,66	2,38

14	Сул чөлөөтэй газар	728,42	8,18
15	Төр захиргааны байгууллага	48,01	0,54
16	ААНБ-д эзэмшүүлэх газар	294,78	3,31
17	Амины орон сууц	26,40	0,30
18	ИААНБ-д төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газар	164,49	1,85
19	ИААНБ-д дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газар	18,11	0,20
20	Онгоц нисэх, буух зурвас газар	442,21	4,97
21	Аэродромын тусгай бүс	488,87	5,49
22	Усалгаатай газар тариалан	344,05	3,86
23	Шугам сүлжээ хамгаалалтын бүс	26,94	0,30
24	Зам	218,85	2,46
<b>Нийт</b>		<b>8906,24</b>	<b>100,0</b>

**Олон нийт ажил хэргийн төв бүс:** Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, цагдаагийн газар, соёлын төв, банк зэрэг байна. Энэхүү бүс нь төлөвлөлтөөр нийт 53,3 га газрыг эзэлж байгаа бөгөөд үүний 1,74 га талбайг төлөвлөж буй цэцэрлэг, эмнэлэг, 0,83 га талбайг биеийн тамир, спортын цогцолборийн эдэлбэр газар эзэлнэ.


**Суурьшлын бүс:** Төлөвлөлтөөр 365,95 га гэр хороолол, 14,08 га хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс болон иргэнд өмчлүүлэх байршил дээр 551,35 га гэр хорооллын эзэлж байна. Төлөвлөлтийн эцэст 4127 иргэнд 0,07 га-аар өмчлүүлэхэд 284,83га шаардагдах бөгөөд иргэнд өмчлүүлэх 931,38 га талбайн 60 хувийг хашааны эдэлбэр газар эзэлж, үлдэх 40 хувийг нийтийн эзэмшлийн, ногоон байгууламж, зам эзэлнэ. Иймд хашааны эдэлбэр газар болох 558,8 га талбайг иргэн бүрт хуваарилан тооцоолоход 0,13 га-аас дээш хэмжээгээр олгож болохгүй болно. Иймд цаашид өмчлүүлэх газрын хэмжээг 0,1 га-аас хэтрүүлэхгүй байх бодлогыг баримтлах нь зүйтэй.

**Үйлдвэрийн бүс:** Энэ бүсийг сумын төвийн баруун урд 33,3 га-д буюу 1 блок талбайг төлөвлөв. Энэ бүсэд барилгын материалын үйлдвэр, худалдааны зах байрлана.

**Ногоон байгууламж задгай талбай:** Энэхүү бүс нь төлөвлөлтөөр нийт 3946,52 га газрыг эзэлж байна. Иргэнд өмчлүүлэх байршил дээр 940,08 га газрыг төлөвлөсөн.

**Голын хамгаалалтын бүс:** Голын онцгой хамгаалалтын бүс нь 73,2 га, энгийн хамгаалалтын бүс нь 229,72 га газрыг эзэлж байна. Онцгой хамгаалалтын бүсийн газар ашиглалтыг чөлөөлөх, энгийн хамгаалалтын бүсэд газар ашиглалтыг хязгаарлах бодлого баримтлах нь зүйтэй.

**Гудамж, зам тээврийн бүс** нь 226,89 га-г төлөвлөлтөөр эзэлж байна.



Зураг 144. Алдархаан сумын төвийн функциональ бүсийн төлөвлөлт

**Шинээр өмчлүүлэх суурин газар:** Шинээр өмчлүүлэх суурин газар нь 4456,07 га нутаг дэвсгэрийг эзлэх бөгөөд үүний 26,94 га талбайг шугам сүлжээний газрын хамгаалалтын бүс эзэлж байна.

Хүснэгт 54. Алдархаан сумын төвийн эрчим хүчний шугам сүлжээний төлөвлөлт

№	Байршил	10 кВ-ын агаарын шугам (км)	10/0.4 кВ-ын дэд станцын тоо			Хөрөнгө оруулалт (сая.төг)		
			250кВ	400кВ	630кВ	Ойрын 2022 он	Дундын 2028 он	Хэтийн 2033 он
1	Алдархаан1	12	4	2	2		770,4	
2	Алдархаан2	0,7	1	4				310,2
3	Алдархаан3	9	2	1				490,7
<b>Нийт</b>		<b>21,7</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>2</b>		<b>770,4</b>	<b>800,9</b>

### АСГАТ СУМ

**Сумын төвийн тэг гортиг:** Сумын төвийн одоогийн газар ашиглалт нь тэг гортигийн хилээс гадагшаа хөгжсөн байгаагаас гадна, БХБЯ-аас иргэнд өмчлүүлэх боломжтой газрын хил хязгаарыг үндэслэн 227,3 га талбайтай байсан сумын төвийг тэлж 489,68 га талбайтай болгон төлөвлөсөн. Ингэснээр хүн амын нягтшил нь 1 хүнд 0,2 га талбай ноогдож байсан бол төлөвлөлтөөр нэмэгдэн 0,3 га талбай ноогдохоор болсон.

Хүснэгт 55. Асгат сумын төвийн тэг гортиг/ төлөвлөлтөөр/

Эргэлтийн цэгүүд	Талбай, га	Уртраг	Өргөрөг
1	489,68	96° 35' 53.131"	49° 24' 54.181"
2		96° 36' 57.381"	49° 25' 01.665"

3		96° 38' 04.978"	49° 24' 53.470"
4		96° 36' 49.693"	49° 23' 39.505"
5		96° 35' 20.491"	49° 24' 10.849"

Сумын төвд дараахь функциональ болон бодлогын бүсүүдийг төлөвлөсөн.

Хүснэгт 56. Асгат сумын төвийн төлөвлөлтийн бүсүүдийн талбай, га

№		Төлөвлөлтийн бүсүүд	Талбай, га	Эзлэх хувь
1	Сумын төв	Гэр хорооллын бүс	72,9	14,9
2		Олон нийт ажил хэргийн төв бүс	65,44	13,4
3		Үйлдвэрийн бүс	31,21	6,4
4		Ногоон байгууламж, задгай талбай	51,43	10,5
5		Гудамж, зам тээврийн бүс	6,29	1,3
6	Тэлэх нөөц бүс	Гэр хорооллын бүс	156,91	32,0
7		Үйлдвэрийн бүс	76,58	15,6
8		Ногоон байгууламж, задгай талбай	25,67	5,2
9		Гудамж, зам тээврийн бүс	3,25	0,7
<b>Нийт</b>			<b>489,68</b>	<b>100</b>


**Олон нийт ажил хэргийн бүс:** Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, цагдаагийн газар, соёлын төв, банк зэрэг байна. Энэхүү бүс нь төлөвлөлтөөр нийт 2 блокод хамрагдаж байгаа бөгөөд нийт 65,44 га газрыг эзэлж байна. Үүний 1,24 га талбайг төлөвлөж буй цэцэрлэг, эмнэлэг, 0,33 га талбайг биеийн тамир, спортын цогцолборийн эдэлбэр газар эзэлнэ. Энэ бүсийн сургуулийн орчмын газар ашиглалт нь орц гарцгүй, мухар гудамтай тул дахин төлөвлөлтөөр хөгжүүлэх бодлогын бүсэд оруулан төлөвлөсөн.

**Гэр хорооллын бүс:** Төлөвлөлтөөр нийт 7 блок буюу 229,81 га газрыг эзлэх бөгөөд одоогийн байдлаар 30,1 га газрыг эзэлж байна. Төлөвлөлтийн эцэст 1760 иргэнд 0,07 га-аар өмчлүүлэхэд 120,96 га шаардагдах тул, цаашид өмчлүүлэх газрын хэмжээг 0,1 га-аас хэтрүүлэхгүй байх бодлогыг баримтлах нь зүйтэй.

**Үйлдвэрийн бүсийг** сумын төвийн зүүн урд 107,7 га-г буюу 4 блок талбайг төлөвлөв.

**Ногоон байгууламж задгай талбай:** Энэхүү бүс нь төлөвлөлтөөр нийт 2 блок буюу 65,4 га газрыг эзэлж байна. Хот төлөвлөлтийн нормоор 0,23 га ногоон байгууламжийн талбай зайлшгүй шаардлагатай бөгөөд төлөвлөсөн хэмжээгээр тооцоход төлөвлөлтийн эцэст 1 хүнд 371,6 м.кв талбай ноогдож байна.

**Гудамж, зам тээврийн бүс** нь 9,5 га-г төлөвлөлтөөр эзэлж байна.



Зураг 145. Асгат сумын төвийн функциональ бүсийн төлөвлөлт

### БАЯНТЭС СУМ

**Сумын төвийн тэг гортиг:** Сумын төвийн газар ашиглалтын коэффициент нь 0,19 байгаа тул сумын төвийн тэг гортигийг тэлэхгүйгээр, газар ашиглалтыг сайжруулан төлөвлөсөн.

Баянтэс сумын төвд дараахь функциональ болон бодлогын бүсүүдийг төлөвлөсөн.

Хүснэгт 57. Баянтэс сумын төвийн төлөвлөлтийн бүсүүдийн талбай, га

№	Төлөвлөлтийн бүсүүд	Талбай /га/	Эзлэх хувь
1	Гэр хорооллын бүс	247,84	64,94
2	Олон нийт ажил хэргийн төв бүс	16,75	4,39
3	Олон нийт ажил хэргийн дэд бүс	15,38	4,03
4	Ногоон байгууламж задгай талбай	33,58	8,80
5	Үйлдвэрийн бүс	50,63	13,27
6	Гудамж, зам тээврийн бүс	17,46	4,57
	<b>Нийт</b>	<b>381,64</b>	<b>100,00</b>

**Олон нийт, ажил хэргийн бүс:** Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, цагдаагийн газар, соёлын төв, банк зэрэг байна. Бүсийн нутаг дэвсгэрийн нь нийт 2 блокыг эзлэх бөгөөд 16,7 га газрыг эзлэх юм. Энэ бүс нь газар ашиглалт нь нягт байрласан тул шинээр 0,84 га талбайд 1 цэцэрлэг төлөвлөсөн. Одоогийн үйлчилгээ төвлөрсөн төв замын 2 талд байрлах газар ашиглалтууд нь орц гарц муутай, хот төлөвлөлтийн нормоор сургуулийн аюулгүй байдал алдагдсан тул цаашид дахин төлөвлөлтөөр хөгжүүлэх бодлогын бүсэд оруулан төлөвлөсөн.


**Олон нийт, ажил хэргийн дэд бүс:** Энэ бүс нь үйлдвэрийн бүс болон шинээр тэлж байгаа суурьшлын хороонд 2 блокийг эзлэн, нийт 15,38 га талбайд байрлах бөгөөд үүний 3,41 га талбайг төлөвлөж буй 240 хүүхдийн 1 цэцэрлэг, 640 хүүхдийн хүчин чадалтай 1 сургууль, сум дундын 30 ортой 1 эмнэлэг, 0,95 га талбайг биеийн тамир, спортын цогцолбор эзэлнэ.

**Гэр хорооллын бүс** газрын нийт хэмжээ одоогоор 56,5 га байна. Төлөвлөлтөөр 247,84 га буюу 9 блокийг эзлэх юм. Төлөвлөлтийн эцэст 3936 хүн амд 0,07 га-аар тооцоход 263,97 га талбай шаардлагатай бөгөөд төлөвлөсөн талбайг одоогийн хүн амд өмчлүүлэхэд 100 хувь хангах бөгөөд цаашид хүн амын өсөлтийг даган, шинээр өмчлүүлэх нөөц газрыг тухайн үед нь шийдвэрлэх байдлаар байршлыг сонгох нь зүйтэй.

**Үйлдвэрийн бүс:** Энэ бүсийг сумын төвийн зүүн талд байрлах бөгөөд нийт 3 блок буюу 50,63 га газрыг эзэлнэ. Энэ бүсэд барилгын материалын үйлдвэр, бордооны үйлдвэрийг төвлөрүүлэн, хөгжүүлнэ. Мөн хэтийн хугацаанд төлөвлөж байгаа ХАА-н Үйлдвэрлэл технологийн паркийг үйлдвэрийн бүсээс холгүй төлөвлөх шаардлагатай.

**Ногоон байгууламж задгай талбай:** Нийт төлөвлөлтөөр 33,58 га буюу 4 блокийг эзэлж байна. Хүн амын хэрэгцээгээр 0,7 га-аас доошгүй ногоон байгууламж шаардлагатай бөгөөд төлөвлөлтөөр 1 хүнд 85,3 м.кв талбай ноогдож байна.

**Гудамж, зам тээврийн бүс:** Бүс нь 17,46 га газрыг төлөвлөлтөөр эзэлж байна.



Зураг 146. Баянтэс сумын төвийн функциональ бүсийн төлөвлөлт


## БАЯНХАЙРХАН СУМ

**Сумын төвийн тэг гортиг:** Сумын төвийн газар ашиглалтын коэффициент нь 0,27 байгаа тул сумын төвийн тэг гортигийг тэлэхгүйгээр, газар ашиглалтыг сайжруулан төлөвлөсөн. Баянхайрхан сумын төвд дараахь функциональ болон бодлогын бүсүүдийг төлөвлөсөн.



Хүснэгт 58. Баянхайрхан сумын төвийн төлөвлөлтийн бүсийн талбай, га

	Төлөвлөлтийн бүс	Талбай /га/	Эзлэх хувь
Сумын төв	Гэр хорооллын бүс	130,39	40,99
	Олон нийт ажил хэргийн дэд бүс	17,86	5,61
	Олон нийт ажил хэргийн төв бүс	35,8	11,25
	Үйлдвэрийн бүс	52,23	16,42
	Хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс	35,1	11,03
	Ногоон байгууламж задгай талбай	38,08	11,97
	Гудамж, зам тээврийн бүс	8,65	2,72
<b>Нийт</b>		<b>318,11</b>	<b>100,00</b>



Зураг 147. Баянхайрхан сумын төвийн функциональ бүсийн төлөвлөлт

**Олон нийт, ажил хэргийн төв бүс:** Энэ бүс нь одоогийн захиргаа, суурьшлын хэсгийг хамрах бөгөөд төлөвлөлтөөр нийт 4 блок буюу 35,8 га газрыг эзлэх юм.

Бүсийн төвийн хэсгийг дахин төлөвлөлтөөр хөгжүүлэн, шинээр төлөвлөгдөж байгаа 240 хүүхдийн 1 цэцэрлэгийн 0,84 га талбайг төлөвлөсөн.

**Олон нийт, ажил хэргийн дэд бүс** нь нийт 1 блокийг эзлэх бөгөөд 17,86 га газрыг эзлэх юм. Энэ бүсэд төлөвлөлтийн хэтийн хугацаанд төлөвлөгдсөн сумын 10 ортой эмнэлэг, 640 хүүхдийн хүчин чадалтай ерөнхий боловсролын сургуулийн нийт 1,9 га талбайг нийгмийн дэд бүтцэд зориулана.

**Суурьшлын бүс:** Энэ бүсэд гэр хорооллын бүс болон хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс орох бөгөөд төлөвлөлтөөр 165,49 га газрыг буюу 10 блокийг эзлэх бөгөөд одоогийн байдлаар 38,4 га-г эзэлж байна. Төлөвлөлтийн эцэст сумын нийт хүн ам 2873 болж өсөх тул иргэн бүрт газар өмчлүүлэхэд 0,07 га хэмжээгээр тооцоолоход 188,58 га гэр хорооллын газар хэрэгцээтэй байна. Иймд төлөвлөлтийн эцэст газар өмчлөлийг 87,7 хувьд хүргэхээр төлөвлөсөн.

**Үйлдвэрийн бүсийг** сумын төвийн урд зүгт 52,23 га буюу 2 блок газрыг эзэлж байхаар төлөвлөв. Энд жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн түүхий эд цуглуулах бирж байгуулахаар төлөвлөсөн.

**Ногоон байгууламж задгай талбай:** Төлөвлөлтөөр нийт 3 блок буюу 38,08 га газрыг эзлэнэ.

**Гудамж, зам тээврийн бүс** нь 8,6 га газрыг төлөвлөлтөөр эзэлж байна.

### ДӨРВӨЛЖИН СУМ

**Сумын төвийн тэг гортиг:** Сумын төвийн газар ашиглалтын коэффициент нь 0,19 байгаа тул сумын төвийн тэг гортигийг тэлэхгүйгээр, газар ашиглалтыг сайжруулан төлөвлөсөн. Дөрвөлжин сумын төвд дараахь функциональ болон бодлогын бүсүүдийг төлөвлөсөн.

Хүснэгт 59. Дөрвөлжин сумын төвийн төлөвлөлтийн бүсийн талбай, га

№		Төлөвлөлтийн бүсүүд	Талбай /га/	Эзлэх хувь
1	Сумын төв	Гэр хорооллын бүс	215,42	36,55
2		Олон нийт ажил хэргийн төв бүс	13,38	2,27
3		Олон нийт ажил хэргийн дэд бүс	17,9	3,04
4		Ногоон байгууламж задгай талбай	267,2	45,33
5		Үйлдвэрийн бүс	62,65	10,63
6		Гудамж, зам тээврийн бүс	12,9	2,19
		<b>Нийт</b>	<b>589,45</b>	<b>100,00</b>

**Олон нийт, ажил хэргийн төв бүс:** Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, цагдаагийн газар, соёлын төв, банк зэрэг байна. Нийт төлөвлөлтөөр 13,38 га газрыг эзлэнэ. Үүний 0,84 га талбайг төлөвлөж буй 240 хүүхдийн хүчин чадалтай 1 цэцэрлэг эзэлнэ.


**Олон нийт, ажил хэргийн дэд бүс:** Төлөвлөлтөөр 17,9 га –г буюу 1 блокийг эзлэнэ. Үүний 2,74 га талбайг цэцэрлэг, сургууль, эмнэлэг ийн эдэлбэр газар эзэлнэ.

**Гэр хорооллын бүс:** Одоогийн байдлаар 99,9 га газрыг эзэлж байгаа бөгөөд төлөвлөлтөөр 215,42 га буюу 8 блокийг эзлэнэ. Төлөвлөлтийн эцэст 3358 хүн амд 218,82 га гэр хорооллын газар шаардлагатай бөгөөд цаашид 1 хүнд 0,07 га-аар газар өмчлүүлэх нь зүйтэй.

**Үйлдвэрийн бүсийг** сумын төвийн зүүн урд байхаар төлөвлөсөн бөгөөд нийт 3 блокыг эзлэнэ.

**Ногоон байгууламж задгай талбай** нийт төлөвлөлтөөр 5 блок буюу 267,2 га газрыг эзлэх юм.

**Гудамж, зам тээврийн бүсийг** төлөвлөлтөөр 12,9 га газрыг эзэлж байна.



Зураг 148. Дөрвөлжин сумын төвийн функциональ бүсийн төлөвлөлт

### ЗАВХАНМАНДАЛ СУМ


**Сумын төвийн тэг гортиг:** Сумын төвийн газар ашиглалтын коэффициент нь 0,08 байгаа тул сумын төвийн тэг гортигийг тэлэхгүйгээр, газар ашиглалтыг сайжруулан төлөвлөсөн. Завханмандал сумын төвд дараахь функциональ болон бодлогын бүсүүдийг төлөвлөсөн.

Хүснэгт 60. Завханмандал сумын төвийн төлөвлөлтийн бүсийн талбай, га

№		Төлөвлөлтийн бүсүүд	Талбай /га/	Эзлэх хувь
1	Сумын төв	Хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс	103,9	17,46
2		Гэр хорооллын бүс	84,27	14,16
3		Олон нийт ажил хэргийн төв бүс	23,5	3,95
4		Олон нийт ажил хэргийн дэд бүс	35,54	5,97
5		Ногоон байгууламж задгай талбай	227,17	38,18
6		Үйлдвэрийн бүс	69,91	11,75
7		Гудамж, зам тээврийн бүс	9,9	1,66
8		Голын онцгой хамгаалалтын бүс	5,06	0,85
9		Голын энгийн хамгаалалтын бүс	35,75	6,01
		<b>Нийт</b>	<b>595,0</b>	<b>82,54</b>

**Олон нийт, ажил хэргийн төв бүс:** Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа

үйлчилгээ, цагдаагийн газар, соёлын төв, банк зэрэг байна. Төлөвлөлтөөр 23,5 га-г эзэлж байна.



Зураг 149. Завханмандал сумын төвийн функциональ бүсийн төлөвлөлт

**Олон нийт, ажил хэргийн дэд бүс:** Энэ бүс нь нийт 35,54 га газрыг эзлэх бөгөөд 3 блок газрыг эзлэнэ. Үүний 0,3 га талбайг төлөвлөж буй эмнэлэгийн эдэлбэр газар эзэлж байна.

**Суурьшлын бүс:** Энэ бүсэд гэр хорооллын бүсийн 84,27 га, хуваарьт эдлэнт хувийн сууцны бүсийн 103,9 га талбай орно. Төлөвлөлтөөр 188,17га эзлэх ба одоогийн байдлаар 18,2 га газрыг эзэлж байгаа юм. Төлөвлөлтийн эцэст 1789 хүн амд 122,15 га өмчлүүлэх газрын хэрэгцээ байгаа бөгөөд төлөвлөсөн гэр хорооллын бүс нь одоогийн байгаа хүн амд хангалттай хүрэх тул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах үе шатанд зарим блокийг нам давхар орон сууцны зориулалтаар төлөвлөх шаардлагатай.

**Голын хамгаалалтын бүс:** Голын онцгой хамгаалалтын бүс нь 19,0 га, энгийн хамгаалалтын бүс нь 46,43 га газрыг эзэлж байна. Онцгой хамгаалалтын бүсийн газар ашиглалтыг чөлөөлөх, энгийн хамгаалалтын бүсэд газар ашиглалтыг хязгаарлах бодлого баримтлах нь зүйтэй.

**Гудамж, зам тээврийн бүс:** Нийт 5,38 га-г эзэлж байхаар төлөвлөсөн байна.



Зураг 166. Яруу сумын төвийн функциональ бүсийн төлөвлөлт

#### 4.2.6 Улиастай хотын төлөвлөлт

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө-2033-д Улиастай хотын хөгжлийн хэтийн төлөвийг дараах байдлаар тодорхойллоо.

- Хэтийн төлөв\_1** Хүчтэй эдийн засагтай, мэдээлэл, боловсрол, технологийн өндөр түвшинтэй улсын зэрэглэлтэй хот байна.
- Хэтийн төлөв\_2** Иргэдийн аюулгүй, амгалан, эрүүл амьдрах нөхцлийг хангасан, дэд бүтцийн оновчтой шийдэлтэй, газар ашиглалтын зохистой бүтцийг бий болгосон нягшил сайтай цомхон эко- хот байна.
- Хэтийн төлөв\_3** Тогтвортой хөгжлийн зорилтыг дэмжсэн иргэддээ ээлтэй, сэргээгдэх эрчим хүч, байгалийн нөөцийн ашиглалтыг дэмжсэн, нийгмийн сайн, сайхан амьдарлыг цогцлуулсан нээлттэй эрх зүйн орчин бүхий хот байна.
- Хэтийн төлөв\_4** Олон нийтийн оролцоо, хувийн хэвшлийг төрийн үйлчилгээнд татан оролцуулдаг, үр ашигтай төрийн удирдлагатай хот байна.
- Хэтийн төлөв\_5** Бүс нутагтаа аялал жуулчлалыг дэмжсэн жуулчдад ээлтэй, уламжлалт соёл наадмын төв байна.

##### 4.2.6.1 Улиастай хотын геотехникийн нөхцөл:

Монгол улсын баруун бүсэд Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай, Завхан аймгууд хамаарагдана. Энэ бүсэд оршиж буй хот суурин газрууд нь эдийн засгийн чадавхи хөгжлийн түвшин, хүн амын нутагшилт суурьшлийн байдал, байгаль цаг уур, геологи, геотехникийн нөхцлөөрөө зарим бүс нутгуудаас ялгагдах сөрөг ба эерэг талуудтай.

**Сөрөг талууд нь:**

- Манай орны хот суурин газруудад хийж буй “Хот байгуулалтын үнэлгээ”-ээр авч үзэхэд газрын гадаргуугын хэлбэр төрх, геологи, ландшафт, инэенер-геологи, геотехнизийн нөхцөл байдлаараа тухайн бүсийн нутаг дэвсгэрийн ихэнх хувь нь байгуулалтанд тохиромж муутай буюу ихэнхдээ сөрөг үзүүлэлт гардаг.
- Баруун бүсийн Их нууруудын хотгорт Монгол орны нийт элсэн массивын 50-аас илүү хувь нь байдаг бөгөөд энэ нь цөлжилт идэвхитэй явагдаж цаашид хөрөнгө оруулалт ихээр шаардах бүс болох магадлал өндөртэй.

### Эерэг талууд нь:

- Байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдал харьцангуй сайн хадгалагдаж байгаа.
- Бүс нутагт дархан цаазат газар-5, байгалийн тусгай цогцолборт газар-2, байгалийн нөөц газар-4, түүх дурсгалт газар хэд хэд байгаа бөгөөд эдгээр газар нь нийт нутаг дэвсгэрийн 18,5 хувь буюу 78750 км<sup>2</sup> талбай буюу эзэлж байгаа зэрэг нь аялал жуулчлал, уулын спорт, ан агнуур зэрэг байгаль орчинд сөрөг нөлөө багатай эдийн засгийн ашигтай салбаруудыг хөгжүүлэх боломжтой.
- Нөөц нь тогтоогдсон бөгөөд одоо ашигт малтмал, төрөл бүрийн нүүрсний ордууд элбэг байгаа нь цаашид Уул-уурхайн салбарыг хөгжүүлэх боломж сайтайд тооцогдоно.

### Баруун бүсийн хот, суурин газруудын инженер-геологийн нөхцөл, ул хөрсний геохникийн шинж чанар:

Улиастай хотын эргэн тойронд далайн түвшинээс дээш 2800 м-ээс дээш өргөгдсөн Товцогт хайрхан, Ямаа майлдаг, Баян-Улаан, Жинст зэрэг уул нуруудаар хүрээлэх бөгөөд хотын төв хэсэг буюу голуудын хөндий хэсгээрээ 2100-2200м-ийн үнэмлэхүй өндөртэй болж газрын гадаргуу харьцангуй тэгширдэг.

Хотын нутаг дэвсгэр дээгүүр Богдын гол, Чигэстэй гол, Яруу, Шар усны, Шургын голууд өнгөрөх бөгөөд эдгээр нь нийлж Завхан голд цутгадаг. Эдгээр гол нь Төв Азийн гадагш урсацгүй гол мөрний ай савд багтана. Голын ус нь гидрокарбонат-кальци-магниий найрлагатай бөгөөд өнгө, үнэр, амт, тундас үгүй тунгалаг чанартай.

Хүснэгт 93. Зарим голуудын ус цуглуулах талбай, тэжээгдлийн үзүүлэлт

№	Голуудын нэр	Ус цуглуулах талбай км <sup>2</sup>	Голуудын тэжээгдэл хувь		
			Хөрсний ус	Цас мөсний ус	Хур борооны ус
1	Богд	1610	15	36	49
2	Чигэстэй	1050	16	32	52

Улиастай хотын нутаг дэвсгэрт аллюви, пролювийн болон пермийн настай боржин чулуулаг буюу хадан ул хөрсний гэсэн 3 уст үе шалгагддаг бөгөөд хадан хөрсний уст давхраг нь газар доорхи уст талбайн 40%-ийг эзэлдэг. Тухайн хэмжээнд физик-геологийн үзэгдэл, үйл явц идэвхитэй хөгжсөн. Тухайлбал: Богд, Чигэстэй голууд хур бороо ихтэй үед үерлэж гольдролоосоо хальж улмаар хотын төв хэсэг, нисэх буудлын авто зам, цэнгэлдэх хүрээлэнгийн орчмын газрууд, үйлдвэрийн бааз, гал

команд, энэ орчмын гэр хороолол, зарим албан байгууллагуудын контор зэрэг газрууд буюу хотын нийт нутаг дэвсгэрийн 40-60 хувь нь үерт автагддаг байна. Богд, Чгэстэй голын хөндийд эргээ идэх процесс /эргийн элэгдэл, идэгдэл/ идэвхитэй явагддаг бөгөөд энэ нь голуудын тохойрч, эргэсэн хэсгүүдэд илүү илэрдэг, эргийн идэгдлийн мөргөцөгийн өндөр 6,0-10,0 м хүрдэг. Чигэстэй голын зүүн, баруун талын татам, Богдын голын арлын хэсэг, хотын төвийн өмнөт хэсгээр алаг цоог байдлаар намагжих процесс явагдсан байна. Намгийг үүсгэгч хурдас нь хар хүрэн өнгөтэй урсамтхай байдалтай шаварлаг хөрсний төрлөөр илэрнэ. Хөлдөхдөө хүчтэй овойж хүйтний овойлтын дов, сондуул, гадаргуугийн хагарлууд үүсгэдэг. Дов сондуулын өндөр 15-30 см, голч нь 0,4-1,0 м, намгийн зузаан 1,5-2,0 метр байна.

Хүйтний улиралд голын татам, эргийн хэсгээр мөсөн халиа тошин идэвхтэй явагддаг. Тухайлбал: Чигэстэй голын зүүн, баруун талын татам, татмын нам дэнж, тэр орчмын гэр хороолол байрлах захын хашаанууд хүртэл 0,5-1,0 км<sup>2</sup> орчим талбайд, Богд, Чигэлтэй голүүд нийлсэн захын хэсгээс баруун тийш хотын төвийн урд хэсгээр 0,3-0,5 км<sup>2</sup> талбайг тус тус хамаарч мөсөн халиа үүсдэг. Хур тундас ихтэй жилд халианы зэрэг 2800 мээс дээш өргөгдсөн өндөр уулсын налуу хажуу, бэл хормойн хэсгээр хэд хэдэн удаагийн нуралт үүсэж байсан байна. Энэ үзэгдэл, үйл явц цаашдаа ч явагдах бүрэн боломжтой байна.

Улиастай хотын одоогийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайлбал, одоогийн байгаа гэр хорооллын орчим, хотын зах хязгаараар газрын хэрчигдэл, угаагдал, гуу жалга үүсэх үзэгдэлүүд идэвхитэй явагдаж байна. Энэ нь Зуслангийн ам, Ямаа майлдаг, Шар хөтлийн ам, Худгийн ам, Баянулааны ам, Элтэй ам зэрэг уулс хоорондын хөндийн хэсгээр үүсэж байна. Цаашдаа өргөжих магадлал өндөртэй гэж үздэг. Улиастай хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах төрлийн хөрс чулуулагууд ангилагдсан байна.

- Дээд болон орчин үеийн дөрөвдөгчийн аллювийн гаралтай, элсээр чигжигдсэн сайрган хөрс Богд, Чигэстэйн голын татам, татмын дээрхи дэнжийн хэсэгт өргөн тархалттай бөгөөд зузаан нь 50-60 м хүрнэ.
- Дээд-орчин үеийн дөрөвдөгчийн настай делюви, пролювийн настай элс, сайргархаг элсэн болон элсэнцэр хөрс хотыг хүрээлэн орших уулсын бэл хормойн хэсгээр тархсан байна. Зузаан нь 10-50м байдаг.
- Ангилагдаагүй настай элювийн хурдас уул нуруудын орой, хяр хэсгээр гүний чулуулагыг хучиж тогтоно. Зузаан нь 1,50-3,70м-ээр тогтоогдсон болно.

Зонхилох хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

Хүснэгт 94. Улиастай хотын нутаг дэвсгэрт тархсан хөрс

№	Төрөл бүрийн ширхэгтэй элсэн хөрс			
	Хэмхдэс материал хувь	Янз бүрийн ширхэгтэй элс хувь	Тоосорхог хэсэг хувь	Шаварлаг хэсэг хувь
1	<u>24.5-39.4</u> 34.1	<u>53.2-55.1</u> 54.9	<u>4.8-7.2</u> 7.0	<u>2.6-5.5</u> 4.0
	Сайр, сайргархаг хөрс			
2	<u>73.3-75.3</u> 74.3	<u>22.9-24.1</u> 23.5	<u>2.1-1.8</u> 1.5	<u>0.6-0.8</u> 0.7


**Физик шинж чанарын нэгдсэн үзүүлэлт**

№	Физик шинж чанарын үзүүлэлт	Индекс	Хэмжих нэгж	Хөрсний нэр төрөл		
				Сайрган хөрс	Элсэн хөрс	Хадан хөрс
1	Байгалийн чийг	W	Нэгжээр	<u>0.023-0.10</u> 0.06	<u>0.021-0.06</u> 0.052	
2	Урсалтын хязгаарын чийг	W <sub>L</sub>	...	...	...	
3	Имрэгдлийн хязгаарын чийг	W <sub>P</sub>	...	...	...	
4	Уян налархайн тоо	J <sub>P</sub>	...	...	...	
5	Эрдэслэг хатуу хэсгийн нягт	P <sub>3</sub>	г-см <sup>3</sup>	54-2.73 2.67	1.72-2.16 1.78	
6	Нягт	P <sub>n</sub>	...	<u>1.90-2.48</u> 2.17	<u>1.72-2.16</u> 1.75	<u>2.14-2.65</u> 2.57
7	Хуурай үеийн /хэлхээсийн/ нягт	P <sub>d</sub>	...	<u>1.83-2.36</u> 2.072	<u>1.59-2.12</u> 1.75	
8	Сүвшил	n	Нэгжээр	<u>17.40-37.63</u> 19.89	<u>21.19-42.59</u> 28.88	
9	Сүвшлийн илтгэлцүүр	e	...	<u>0.172-0.483</u> 0.350	<u>0.281-0.654</u> 0.471	
10	Чийглэгийн зэрэг	S <sub>r</sub>	...	<u>0.05-0.93</u> 0.54	<u>0.14-0.55</u> 0.28	
11	Хам байдал /консистем/	I <sub>L</sub>	...	...	...	

**Хөрсний механик чанарын норматив үзүүлэлт**

№	Механик шинж чанарын үзүүлэлт	Индекс	Хэмжих нэгж	Хөрсний нэр төрөл		
				Сайрган хөрс	Элсэн хөрс	Хадан хөрс
1	Барьцалдах хуч	C <sub>n</sub>	<u>кПа</u> кг/см <sup>2</sup>	<u>2</u> 0.02	<u>25</u> 0.025	...
2	Дотоод үрэлтийн онцлог	φ	Град	43	39	...
3	Хэв гажилтын модуль	E <sub>o</sub>	<u>МПа</u> кг/см <sup>2</sup>	<u>50</u> 500	<u>45</u> 450	...
4	Баримжаалсан Тооцооны эсэргүүцэл	R <sub>o</sub>	<u>МПа</u> кг/см <sup>2</sup>	<u>500</u> 50	<u>400</u> 40	...
5	Нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх эсэргүүцэл	R <sub>v</sub>	<u>МПа</u> кг/см <sup>2</sup>	...	...	<u>150</u> 1500
6	Хадан хөрсний өгөршлийн зэрэг	K <sub>9</sub>	Нэгжээр	...	...	0.85

**Улиастай хотын геотехникийн нөхцөлийн гол онцлог:** Хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрсний ус голуудын татмын хэсгээр 0,5-0,30м-ийн гүнд илэрэх бөгөөд голуудын устай хобоотойгоор хөрсний усны байрлах түвшин өндөр хэлбэлзэлтэй байдаг. Газар хөдлөлтийн 6-8 баллын бүс ангилагддаг. Хөрс чулуулагын тархалт, зузаан, насны ангилал болон бусад үзүүлэлүүдийг тус хотын инженер-геологийн нөхцлийн зургаар үзүүлэв.



Зураг 167. Улиастай хотын инженер геологийн нөхцөл

Таксономын нэгжийн индекс		Геологийн тогтоц	Геоморфологийн онцлог	Гидрогеологийн нөхцөл	Физикгеологийн нөхцөл	Инженер геологийн нөхцөл	Хот байгуулалтанд өгөх инженер геологи газарзүйн үнэлгээ
I	1	a	Олон голын хөндийн татам дээрхи данжид хамрагдах гадаргуутай бөгөөд налуу нь харчигдсан /1.5 км/км/ болно. Ерөнхийдөө хурамтлалын хэв шинжид гадаргуутай.	Хөрсний ус 3.0м-ээс их гүнд тохиолдоно.	Гадаргуугийн талбайн угаалт сулавтраас дунд зэрэг явагдана. Улиралын халдалтийн бүсэнд овойлт үүсгээгүй	Дунд зэрэг	Газрын гадаргуугийн хувьд хот байгуулалтанд нян тохиромжтой боловч голын үер, намагжилтын болон голын эргийн эвдрэлийн эсрэг инженерийн бэлтгэл арга хэмжээ авах Голын урсгалын чиглэлд эргийн дагуу чиглүүлэгч далан барих Хот байгуулалтын эргийн өндөрлөгт 15% орчим шинжид гадаргуутай.
	2	a		Хөрсний ус 3.0м-ээс их гүнд тохиолдоно.	Голын эргийн илэгдэл хүчтэй явагдана. Голын үерт автагдах ба намагтай. Өвлийн улиралд голын усны халив, дошин гидролаколит үүснэ. Улирлаар хөлдөх үед овойлт үүснэ.		
		b		Хөрсний ус 3.0м-ээс их гүнд тохиолдоно.	Гадаргуугийн талбайн угаалт сулавтар явагдана. Улиралын хөлдөлтийн бүсэнд овойлттой		
II	1		Денудаци-хуримтлалын хэв шинжит гадаргуутай 8-10 орчим налууутай хэрчигдэлгүй	Хөрсний ус 6.0м-ээс гүнд тохиолдоно.	Гадаргуугийн талбайн угаалт дунд зэрэг явагдана. Улирлын хөлдөлтийн бүсэнд овойлт үүсгэхгүй.	Энгийн	Гадаргуугийн налуу дунд зэрэг дунд хэрчигдэлтэй Газар шорооны ажлын хэжээ 1.5 дахин ихэснэ. Гадаргуугийн угаалтын эсрэг арга хэмжээ төлөвлөх Хот байгуулалтын өртгийн өндөрсөлт 5-10%
	2		Зөөгдөл хуримтлалын хэв шинжит гадаргуутай 5-8 орчим налууутай сул хэрчигдсэн.				
	3		Зөөгдөл хуримтлалын хэв шинжит				

		гaдaргуутaй 8-12 нaлуутaй хүчтэй хэрчигдэн эвдэрсэн.				
III	Орчин үеийн пролювн /хормойн/ гаралтай элсэнцэр шавранцар чигжаастай хайрга, элсэнцэр хөрс тархана.	Дүнд өндөрлөг бэсрэг уулс, голын өндөр дэнжийн хормойн хэсгээр үүссэн пролювиаль шлейф.	Хөрсний ус 4.0м-ийн гүндээс тохиолдоно.	Түр зуурын урсгал усны үйл ажиллагаагаар байнга хурдас хуримтлагдана. Улирлын хөлдөлтийн бүсэнд сулавтраас дунд зэрэг овойлт үүсгэнэ.	Дунд зэрэг	Гадаргуугийн налуу дунд зэрэг дунд хэрчигдэлтэй Газар шорооны ажлын хэжээ 1.5 дахин ихэснэ. Гадаргуугийн угаалтын эсрэг арга хэмжээ төлөвлөх Хот байгуулалтын өртгийн өндөрсөлт 5-10%
IV	Ангилалдаагүй пермийн настай ягаан өнгөтэй том ширхэгтэй боржин. Гадаргад илран тархсан хасагтаа 1.0-1.5м хүртэл өгөршсөн /k=0.8/ түүнээс доош ан цавшсан.	Денудаци гаралтай дунд өндөрлөг уулсын үлдэгдэл оройн ба хажуугийн хэсэг гадаргуу 10-15 орчим налуу хэрчигдэлгүй болно.	Хөрсний ус тохиолдохгүй.	Хажуугийн үйл явуу болох талбайн угаалт хүчтэй явагдана. Гуу жалга үүсэх боломжтой улирлын хөлдөлт гүн явагдана.	Энгийн	Гадаргуугийн налуу дунд зэрэг дунд хэрчигдэлтэй Газар шорооны ажлын зэрэг өндөр Огцөм налуутай учир хот байгуулалтын төлөвлөтөнд тохиромжгүй
Геологи орчны өнөөгийн шинж байдал		Энэ хот геологийн төрөл бүрийн цогцлол дээр байрлана. Голын хөндий, бэсрэг уулийн бал хормой, бэлийн болон эх газрын гүний чулуулгууд барилгын суурт болдог. Чулуулгийн цогцосоо барилгын элс, хайрга олборлох зэргээр геологийн орчинд өргөн нөлөөлж байна. Олон голын хөндийн бэлчээрт газрын доорхи ус бохирдох нөхцөл бүрдсэн. үүнийг хамгаалахын тулд ногоон бүс ихээр байгуулах шаардлагатай.				



#### 4.2.6.2 УЛИАСТАЙ ХОТЫН ГАЗРЫН ДООРХ УСТ ДАВХАРГЫН ЭМЗЭГ БАЙДАЛ


Улиастай хотын газрыг бохирдуулагч эх үүсвэрээр газрын ашиглалтын төрлөөр ангилан газрын доорх уст давхаргын эмзэг байдлыг тодорхойлсон бөгөөд ингэхдээ Улиастай хотод урьд өмнө нь хийгдсэн суурь судалгааны мэдээлэл болон хиймэл дагуулын мэдээг ашиглан газрын доорх уст давхаргын эмзэг байдлын үнэлгээг хийлээ. АНУ-ын эрдэмтэн Жэн Маргатын анхлан хөгжүүлсэн оноо тоололтын DRASTIC аргаар үнэлэн газар ашиглалтыг бохирдуулагч эх үүсвэрээр 9 ангиллаар төрөлжүүлэн давхцуулах замаар газрын доорх уст давхаргад аюул учруулах газар ашиглалтын бүсийг тодорхойлон түүн дээр орших газар ашиглагчдын тоо хэмжээг гаргахад бохирдолтод өртөх магадлал их бүсэд 238,7 га талбайд 2023 нэгж талбар байгааг тогтоосон нь хотын хүн амын эрүүл, аюулгүй амьдрах орчинд амьдрах нөхцлийг алдагдуулах аюул заналын сэрэмжлүүлэх дохио болж байна.

Завхан аймгийн нийт хүн амын 30,2 хувь буюу 21,2 мянган хүн Улиастай хотод төвлөрөн суурьшсан нь Улиастай хэмээх энэхүү айлд хөгжил дэвшил, шинэчлэлийн нүүр царайг илэрхийлэх боломж олгосон ч үүнийг даган багагүй бэрхшээл хүндрэлийг дагуулж байна. Үүний нэг жишээ нь Улиастай хотын газар ашиглалтад тулгарч байгаа бөгөөд зарим бүсэд газрын доорх уст давхаргад бохирдлын аюул үүсэх хандлагатай байгаа талаар иргэд сануулсаар байна.


Монголчуудын уламжлалт газар ашиглалтын хэв маягаас үүдэлтэй гэр хороолол хэмээх өвөрмөц хэлбэр нь Улиастай хотыг үүссэн цагаас өнөөг хүртэл оршин буй систем бөгөөд бохирын нэгдсэн системгүй учир хөрсөнд шингээж булшлах замаар өдийг хүртэл явж ирлээ. Энэ нь хөрс бохирдуулах, газрын доорх уст давхаргыг бохирдуулах нэг үндсэн шалтгаан болж агаарын бохирдлын араас аюул дагуулах түгшүүрийн харанга дэлдэж байна. Өнөөдрийг хүртэл газрын менежментийн асуудал гэхээр гэр хороолол, барилгажсан хэсэг гэх мэт иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж буй газрын эрх зүйн харилцааны асуудлыг чухалчлан үзсэн ойлголт амь бөхтэй байсаар байна. Иймээс Улиастай хотын усан хангамжийн өнөөгийн байдалд яаралтай үнэлэлт өгч холбогдох арга хэмжээг шуурхай арга хэмжээ авах нь дан ганц чиглэлийн байгууллага бус газрын менежментийн анхаарах чухал асуудал болж байна.

Газрын доорх уст давхаргын эмзэг байдал гэдэг нэр томъёог гидрогеологич Жэн Маргат 1690 оны сүүлээр гаргаж тавьсан бөгөөд “бохирдолд өртөх эмзэг байдал” гэдэг томъёог уст давхаргад бохирдуулах бодис нэвтрэн орохоос сэргийлэх хамгаалалтын зэргийг тогтоох зорилгоор хэрэглэдэг байна.

Газрын доорх уст давхаргын бохирдолд эмзэг байдал гэдэг ойлголт нь уст давхарга орчмын физик орчин нь бохирдуулах бодис өнгөн хөрсөнд нэвтрэн орж эхэлмэгц түүний эсрэг өөрийгөө хамгаалах чадвартай буюу хамгаалалтын зэрэгтэй байдаг гэсэн онол дээр үндэслэгдэх бөгөөд энэ нь газар нутгийн шинж чанар, налуу, суурь хөрсний чулуулаг зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг байна.



Зураг 168. DRASTIC аргаар эмзэг байдлыг тодорхойлох аргачлал




Зураг 169. Улиастай хотын газрын доорх уст давхаргын эмзэг байдлын үнэлгээ

Улиастай хотын газрын доорх уст давхаргын эмзэг байдлын үнэлгээг 3 шаталбараар гаргахад нийт нутаг дэвсгэрийн 46,65 хувь нь бага, 6,96 хувь нь дунд, 46,39 хувь нь их гэсэн ангилалд багтаж байгаа бөгөөд Улиастай хотын нутаг дэвсгэрийн 62 хувь нь бохирдолд өртөх аюултай бүсэд байгааг харуулж байна.

Хүснэгт 96. Улиастай хотын газрын доорхи уст давхаргын эмзэг байдлын ангилал

№	Бохирдолд эмзэг байдлын ангилал	Талбай	Эзлэх хувь
		(га)	(%)
1	Бага	1119,48	40
2	Дунд	421,38	16
3	Их	1232,81	44
4	ДҮН	2773.67	100

**Улиастай хотын газар ашиглалт уст давхаргын эмзэг байдлын индекс**тэй уялдах нь: Газар ашиглалтын янз бүрийн байдал нь өөрийн шинж чанараас хамааран их бага хэмжээгээр газрын доорх уст давхаргыг бохирдуулах бөгөөд эдгээр нь олон хүчин зүйлээс хамаардаг байна.




Зураг 170. Гүний ус бохирдуулагч хүчин зүйлс (Foster et al., 2002)

Улиастай хотын гэр хорооллын үүсэл хөгжил нь 700 гаран (Чанчунь бумба Улиас хотоор дайран гарсан түүх байдаг) жилийн түүхтэй бөгөөд анх үүссэн гэр хорооллоос өнөөдрийг хүртэл оршин тогтнож буй гэр хороолол үлдсэн, гэр хорооллын огцом тэлэлтээс өнөөдөр 5 мянга нүхэн жорлон газрын хөрсөнд шингээх зориулалттай хөрс, ус бохирдуулагч бий болсон байна.

Хүснэгт 97. Улиастай хотын газрын гүний ус бохирдуулагч эх үүсвэрээр

Объект		Газар ашиглалтын төрөл								
		Гэр хороолол	Хог хаягдал	Оршуулгын газар	Үйлдвэр	Эрчимжсэн ХАА	Цэвэрлэх байгууламж	Бохирын системтэй бүс	Хиймэл нуур, цөөрөм	ШТС
Улиастай хот	га	493.63	21	11.34	8.77	46.2	0.5	125.15	0.36	2.1
	тоо	5057	1	6	3	25	1	242	4	7
ДҮН	га	493.63	21	11.34	8.77	46.2	0.5	125.15	0.36	2.1
	тоо	5057	1	6	3	25	1	242	4	7

Бид Улиастай хотын газар ашиглалтын зориулалтуудыг газрын доорх уст давхаргыг бохирдуулагч эх сурвалжаар нь ангилан гаргахад хэмжээ, цар хүрээ, тархалтаар гэр хорооллын газар>бохирын нэгдсэн системтэй бүс>Эрчимжсэн ХАА-н салбар>Оршуулгын газар>Үйлдвэрийн бүс>Хог хаягдал булшлах зориулалттай газар>Шатахуун түгээх станц>Цэвэрлэх байгууламжын зориулалттай газар гэсэн дарааллаар тогтоогдлоо.



Зураг 171. Улиастай хотын газрын доорх уст давхаргын бохирдолд эмзэг байдал

Хүснэгт 98. Улиастай хотын уст давхаргын эмзэг байдлын ангилал, газар ашиглалтаар

№	Газар ашиглалтын төрөл /бохирдуулагч эх үүсвэрээр/	Нийт		Бохирдолд эмзэг байдал					
		Талбай, га	Тоо	бага		дунд		Их	
				Талбай, га	Тоо	Талбай, га	Тоо	Талбай, га	Тоо
1	Гэр хороолол	493.63	5057	307.03	3407	30.1	700	156.5	950
2	Хог хаягдлын газар	21	1	21	1	-	-	-	-
3	Оршуулгын газар	11.34	6	11.34	6	-	-	-	-
4	Үйлдвэр /бохир усны систем/	8.77	3	5	2	1.77	1	-	-
5	Эрчимжсэн ХАА-н үйлдвэрлэл	46.2	25	-	-	-	-	46.2	25
6	Цэвэрлэх байгууламж /лагийн талбай/	0.5	1	-	-	-	-	0.5	1
7	Бохирын системтэй бүс /систем гэмтэхэд/	125.15	242	55.73	110	47.37	86	22.05	46
8	Усан сан /ил задгай/	0.36	4			0.12	1	0.24	3
9	ШТС	2.1	7	0.3	1	0.6	2	1.2	4
	<b>ДҮН</b>	<b>709.05</b>	<b>5346</b>	<b>311.73</b>	<b>2508</b>	<b>74.57</b>	<b>815</b>	<b>320.75</b>	<b>2023</b>


Газрын доорх уст давхаргын бохирдолд өртөх магадлал өндөртэй бүс нь Богдын голын дагуу болон Чигэстэй голын хөндий болон түүний цутгал голын хөндий, нугыг дагуу байрлах бөгөөд тус бүсэд Богдын гол баг байрлах бөгөөд дээрх бүс нутгийг нэн тэргүүн ээлжинд инженерийн шугам сүлжээнд холбох шаардлагатайг харуулж байна. Иймд газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд Богдын гол

баг болон Жинст багийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь инженерийн шугам сүлжээнд холбох дахин төлөвлөлтийн аргаар нягтшил сайтай холимог бүс байхаар төлөвлөв.

**Улиастай хотын газар ашиглалтад тулгарч буй хүндрэл:** Улиастай хотын газар ашиглалтад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг Улиастай хотын иргэд болон төрийн захиргааны холбогдох байгууллага (Эрүүл мэндийн газар, онцгой байдлын газар, Алтай-Улиастайн эрчим хүчний төв, тохижилт үйлчилгээний алба г.м)-аас авсан империк дүгнэлтэд тулгуурлан цуглуулсан мэдээллийг боловсруулахад дараах зураглал гарч байна.

Хүснэгт 99. Улиастай хотын эрсдэлийн үнэлгээ

№	Байршил	Саад бэрхшээл	Талбай, га
1	Товцог, Ямаа майлдаг	Үерийн эрсдэл	0,3
2	Богдын гол, Үерийн далангийн хэсэг	Үерийн эрсдэл	0.4
3	Жаргалант, Тээвэрчдийн хэсэг	Үерийн эрсдэл	0.1
4	Жаргалант, Алтангийн хэсэг	Үерийн эрсдэл	
5	Жинст, МУИС-ын хойд хэсэг	Үерийн эрсдэл	1.1
6	Жинст, ЭОН,ЧЭЛ сургуулийн хойд хэсэг	Үерийн эрсдэл	0.5
7	Жинст, Ногоочдын хэсэг- гүүр	Үерийн эрсдэл	0.1
8	Богдын гол, дүнзэн	Гэдэсний өвчин	14.5
9	Шинэ суурьшлын бүс	Газар олгогдсон боловч суурьшил үүсээгүй	16.5
10	Жаргалант, Хог хаягдлын хэсэг	Хог хаягдлын бохирдолттой	4.8
11	Жинст, Баян Улаан	Эрчим хүчгүй	0.2
12	Жинст, Лааны булан (цэвэршүүлэх байгууламж хальсан)	Хөрс, усны гүн бохирдолттой	1.5



Зураг 172. Улиастай хотын эрсдэлийн зураг

#### 4.2.6.3 УЛИАСТАЙ ХОТЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН АНГИЛАЛ, БҮСЧЛЭЛ

Улиастай хотын газар ашиглалтын төрлийг аймгийн газрын албаны мэдээллийн сангийн бүртгэлээр ангилан авч төрөлжүүлэн талбайн хэмжээг тодорхойллоо.


Хүснэгт 100. Улиастай хотын газар ашиглалтын байдал

№	Газар ашиглалт	Талбай, га	№	Газар ашиглалт	Талбай, га
1	Гэр хороолол	308.54	49	Мах комбинат	1.83
2	Театр	0.63	50	Хоосон хашаа	3.71
3	Их дээд сургууль	7.54	51	Зоорь	0.26
4	Сургууль	8.29	52	Дэд станц	0.01
5	Цэцэрлэг	3.87	53	Шатахуун түгээх станц	8.93

6	Зах	2.44	54	Хөдөлмөрийн хэлтэс	0.12
7	Ашиглалтгүй	21.63	55	Спорт хороо	0.46
8	Уурын зуух	1.76	56	Ногооны талбай	31.63
9	Үйлчилгээ	4.6	57	Тариалангийн талбай	10.77
10	Дэлгүүр	1.06	58	Тахианы цех	0.04
11	Халуун ус	0.29	59	Тоглоомын талбай	0.94
12	Багийн байр	0.29	60	Ферм	0.7
13	Тэжээлийн фонд	2.47	61	Эмийн сан	0.39
14	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	0.41	62	Модны үйлдвэр	2.95
15	Мэргэжлийн хяналтын газар	0.18	63	Баруун бүсийн худалдааны төв	0.67
16	Банк	0.59	64	Цэргийн анги	4.31
17	Татварын хэлтэс	0.37	65	үйлдвэр	4.68
18	Худаг	0.09	66	өлөнгийн цех	2.56
19	Эмнэлэг	3.87	67	пост	0
20	Зоогийн газар	0.41	68	Тахианы ферм	1.3
21	Улаан загалмай	0.32	69	Хутагтын хүрээлэн	0.17
22	Отгонтэнгэр дархан цаазат газрын захиргаа	0.04	70	Музей	0.27
23	Хүүхэд залуучуудын ордон	0.23	71	Амь ус	0.08
24	Онцгой байдлын газар	0.59	72	Ресторан	0.32
25	Стандарт хэмжилзүйн газар	0.41	73	Амины орон сууц	4
26	Барилга баригдаж байгаа	0.24	74	Авто сургуулийн дрон	0.54
27	Орон сууцны контор	0.18	75	Хорих газар	0.29
28	Байгаль орчин аялал жуулчлалын газар	0.28	76	Засаг даргын тамгын газар	0.32
29	Алтай-Улиастайн эрчим хүч	1.05	77	Тоглоомын төв	0.07
30	Зочид буудал	1.36	78	Сувиллын газар	0.29
31	Ахмадын ордон	0.14	79	Амралтын газар	1.37
32	Цагдаагийн газар	1.91	80	Чацарганы талбай	0.2
33	Авто сургуулийн контор	0.07	81	Улиастай сумын тамгын газар	0.16
34	Шүүх	0.21	82	Адууны жүчээ	3.51
35	Хөдөө аж ахуйн газар	1.18	83	Мод үржүүлгийн газар	0.1
36	Авто тээврийн ерөнхий газар	3.84	84	Цэнгэлдэх хүрээлэн	1.64
37	Гандан	1.06	85	Суврага	0.59
38	Авто оношилгооны газар	0.18	86	Спорт цогцолбор	0.57
39	Эрүүл мэндийн газар	0.06	87	Прокурорын газар	0.1
40	Тагнуулын ерөнхий газар	0.02	88	Алдартнуудын талбай	0.12
41	Орон сууц	3.21	89	Буудал	0.3
42	Нийгмийн даатгал	0.02	90	Гурилын үйлдвэр	2.24
43	Гарааш	0.19	91	Аялал жуулчлалын бааз	0.5
44	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	0.04	92	Улиастай ресторан	0.32
45	Бохирын шугам	0	93	Монгол даатгал	0.11
46	Телевизийн станц	0	94	Цэвэр усны газар	0.62
47	Мэдээлэл холбооны газар	0.08	95	Цэцэрлэгт хүрээлэн	1.23
48	Намын байр	0.31	<b>ДҮН</b>		<b>386.55</b>

Газар ашиглалтын төрөл хэлбэрийг авч үзэхэд нийт газар ашиглалтын дийлэнхи хувийг гэр хорооллын газар ашиглалт эзэлж байгаа бөгөөд нийт газар

ашиглалтын 90 гаруй хувийг дангаар эзэлж байна. Энэ нь газар ашиглалтын олон төрөл хэлбэр байгаа боловч жигд хөгжөөгүй байгааг илэрхийлж байна.




Зураг 173. Улиастай сумын /хотын/ газар ашиглалтын одоогийн байдал

Улиастай хотын одоогийн газар ашиглалтын ялгарч буй хэв шинжүүд дээр тулгуурлан газар ашиглалтын ангилал бүсчлэлийг тодорхойлон цаашдын хөгжлийн хэтийн төлөвийг харгалзан үндсэн болон дэд бүсүүдэд хуваалаа. Газар ашиглалтын үндсэн болон дэд бүсийг Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий



төлөвлөгөө (П.Мягмарцэрэн, И.Мягмаржав 2011)-ний бүсүүдэд тулгуурлан ангилал тархалтыг тогтоолоо.

Газар ашиглалтын ангилал бүсчлэлийг гаргахдаа газар ашиглалтын зориулалтын төсөөтэй байдал, тэдгээрийн нягтшил зэргийг харгалзан бүлэглэх, төрөлжүүлэх замаар газар ашиглалтын бүсчлэлийн зураглалыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 174. Улиастай хотын газар ашиглалтын бүсчлэл, одоогийн байдал

Дээрх зургаас харахад хот орчмын хөдөө аж ахуйн бүс 113,9, Бизнесийн төв 53,6, гэр хорооллын бүс 77,28, холимог бүс 117,7, нийтийн эдэлбэрийн газар 58,8,


үйлдвэрийн бүс 142,9 нийтдээ сумын одоогийн тэг гортигоор 2817,7 га газар ашиглалтын бүс үүсгэн байршиж байна.

#### 4.2.6.4 Улиастай хотын функциональ бүсийн төлөвлөлт

Улиастай хотын газар ашиглалтыг оновчтой менежмент хэрэгжүүлэхгүй уламжлалт аргаар тэлэлтийг цааш үргэлжлүүлбэл өнөөдрийн Улаанбаатар хотын хүндрэл бэрхшээлүүд тулгарах аюултай байна. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр газар ашиглалтын бүсийн нягтаршилыг нэмэгдүүлж нягт суурьшилтай цомхон хотыг байгуулахаар зорилоо.

Улиастай хотын өнөөгийн өнгө төрх нь суурьшлын бүсийн тэг гортигоос даван гарсан бөгөөд Алдархаан сумын нутаг дэвсгэр дээр тус хотын иргэд газар эзэмшиж ашиглаж байна. Бид газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр Улиастай хотын тэг гортигийг өргөтгөх замаар хотын хилийг 7459 га талбайд хүргэлээ. Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх зорилтыг хангах үүднээс Мянганы замын тэнхлэгийг дагуулах, аймгуудын төвүүдийг түшиглэн иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэхээр төлөвлөсөн.

Орчин үед нягт суурьшилтай цомхон хот, эко хотыг хотын хүн ам өсөж байгаа нөхцөлд байгаль орчны тогтвортой тогтолцоо буюу эрчим хүчний хэмнэлттэй хотын бүтцийг бий болгох төлөвлөлтийн хандлага гэдэг утгаар ойлгож байна. Дараах зурагт суурьшлын бүсийг ялгаж өгөх болон суурьшлын бүсийг холимог болгосноор иргэдийн шилжилт хөдөлгөөн (ажилдаа ирэх, буцах, үйлчилгээ, үзвэр г.м) эрс багасан хөдөлгөөний хамаарал, түгжрэл болон автомашины хэрэглээ буурч байгааг харж болно.



Дээрх үзэл баримтлалыг Улиастай хотын ирээдүйн өнгө төрхийг тогтооход ашигласан бөгөөд энэхүү нягт суурьшилтай хотын тодорхойлолтыг Данзвик, Саатинар (1978) анх удаа тодорхойлолт өгсөн байдаг. Үүнд:


- Нягтрал сайтай суурьшилтай
- Автомашины хамаарал багатай
- Зэрэгцэн орших нутаг дэвсгэрээс тодорхой хилээр зааглагдсан
- Нийгмийн шударга ёс
- Өдөр тутмын бие даасан байдал
- Бие даасан засаглалтай байх
- Газар ашиглалтын зориулалт өөр өөр

Улиастай хотын газар ашиглалтын бүсийн хуваарилалтын газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дараах байдлаар гарч байна.

Хүснэгт 101. Улиастай хотын функциональ бүсийн төлөвлөлтийн талбай, га

№	Функциональ бүсүүд	Талбай (га)
1	Ашиглалтыг хязгаарлах бүс	161.1
2	Инженерийн шугам сүлжээнд хамруулах бүс	86.3
3	Амралтын газар	12.4
4	Ус дамжуулах хоолой	10.3
5	Өмчийн газар	217.6
6	Төрийн захиргааны байгууллага	58.4
7	Нөөц газар	64.3
8	Ногоон байгууламж	6.1
9	Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газар	30.1
10	Дулааны хоолой	8.2
11	Аж ахуй нэгжид эзэмшүүлэх газар	41.1
12	Чөлөөт бүсийн газар	1662.4
13	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар	787.2
14	Усны нөөц газар	0.1
15	Цэвэр усны хамгаалалтын бүс	314.1
16	Худгийн хамгаалалтын бүс	18.0
17	Үйлдвэрийн бүс	124.0
18	Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн бүс	17.8
19	Гэр хороолол	409.1
20	Ажил хэрэг, сууцны холимог бүс	67.2
21	Олон нийт, ажил хэргийн дэд бүс	12.1
22	Үйлчилгээний төрөлжсөн бүс	12.6
23	Олон нийт, ажил хэргийн төв бүс	19.6
24	Худалдаа үйлчилгээ, дунд давхарын орон сууцны холимог	30.2
25	Нам давхарын орон сууц	139.0
26	Тариалангийн бүс	357.3
27	Уламжлалт ёс заншлын бүс	18.5
28	Дунд давхарын орон сууцны бүс	97.6
29	Чөлөөт ашиглалтын бүс	24.7
30	Зам харилцааны бүс	80.2
31	Батлан хамгаалах аюулгүй байдлын бүс	5.7
32	Хуваарьт эдлэнт хувийн сууцны бүс	37.4
33	Тусгай зориулалтын бүс	22.2
34	Худалдаа үйлчилгээ, ажил хэргийн холимог бүс	7.0
35	Үйлдвэр, ажил хэргийн холимог бүс	30.6
36	Голын хамгаалалтын бүс	2468.7
<b>ДҮН</b>		<b>7459.1</b>

## УЛИАСТАЙ ХОТЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН БҮСЧЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗУРАГ



Зураг 175. Улиастай хотын функциональ бүсчлэлийн төлөвлөлт

### Улиастай хотын газар ашиглалтын бүсийн шинэчлэлийн бүтэц:

**Инженерийн шугам сүлжээнд бүрэн хамруулсан шинэ бүс** – Улиастай хотын “арал” буюу Богдын гол Чигэстэй голын салаанд байрлах (хотын төв хэсэг) суурьшлын бүсийг инженерийн шугам сүлжээнд бүрэн холбосон спорт амралт, амины орон сууц, бизнесийн төв байна.

**Улиастай хотын газар ашиглалтын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх**- Үерийн ус зайлуулах системгүйгээс хот тойрсон уулын амнуудаас их хэмжээний үер бууж газар эзэмшигч ашиглагчдад багагүй хохирол учруулдаг. Иймээс Улиастай хотод

үерийн хамгаалалтын далан 15 км, үерийн ус зайлуулах суваг байгуулахаас гадна үерт дайрагдаж буй айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлнэ.

**Тээврийн сүлжээг сайжруулах-** Улиастай хотын замын сүлжээг сайжруулж одоогийн босоо болон хэвтээ тэнхлэгийн “Т” хэлбэрийн замын сүлжээг Богдын гол-Жинст-Шинэ суурьшлын бүс- лааны булан гэсэн тойрог хэлбэрийн авто замын сүлжээтэй бөгөөд хэт нь нийтийн тээврийн системийг уг тойргийг түшиглэн хөгжүүлнэ.

#### 4.3 ЗАВХАН АЙМГИЙН ГАЗРЫН ҮНЭЛГЭЭ ТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Засгийн газрын 152-р тогтоолоор Улиастай хотын газрын суурь үнэлгээ 50 сая төгрөг, сумдын төвүүдийн газрын суурь үнэлгээ 8 сая төгрөгөөр тогтоогдсон бөгөөд газрын төлбөрийг хуулийн дагуу суурь үнийн 0,1-1%-ийн хооронд тогтоох бөгөөд Улиастай хот 0,2%-иар сумдууд 1%-иар тооцож газрын төлбөрийг авч байна.

Завхан аймаг нь 2017 оны байдлаар газрын төлбөрийн орлогоос 98 сая төгрөг татан төвлөрүүлэхээс Улиастай хот нь газрын төлбөрөөс 10 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлэх үүрэг хүлээж байна.



Диаграмм 70. Сумдын газрын төлбөрт эзлэх хувь

Улиастай хот нь газрын үнэлгээ төлбөрийн нарийвчилсан бүс тогтоогоогүй бөгөөд аж ахуйн зориулалтаар жигд 0,2%-иар тооцож газрын төлбөр тогтоож байна. Дэлхийн жишгээр томоохон бүх хот суурин газрын үнэлгээний хэд хэдэн бүстэй байдгийг харгалзан газрын үнэлгээ төлбөрийн 3 бүсийг санал болгож байна.

Хүснэгт 102. Улиастай хотын газрын үнэлгээ, төлбөрийн хувь хэмжээ

№	Газрын нэр, байршил	Одоо			Төлөвлөлтөөр			
		бүс	%	Төлбөр /төг/	хугацаа	бүс	%	Төлбөр /төг/
1	Улиастай, Жинст, Богдын гол	I	0.2	10	ойрын	I	0.4	20

	баг				дунд хэтийн	I	0.7	35
					ойрын дунд хэтийн	II	0.3	15
2	Улиастай, Жаргалант, Чигэстэй, Өлзийт, Товцог багийн одоогийн байгаа суурьшлын хил заагаар	I	0.2	10	дунд хэтийн	II	0.5	25
					ойрын дунд хэтийн	III	0.2	10
3	Шинээр бий болох суурин				дунд хэтийн	III	0.4	20
						III	0.6	30

Дээрх үнэлгээний бүс, төлбөрийн өөрчлөлтийг төлөвлөлтийн дагуу өөрчлөн мөрдөхөд газрын төлбөрийн хувь хэмжээ дараах байдлаар өөрчлөгдөхөөр тооцоологдлоо.

Хүснэгт 103. Улиастай хотын газрын төлбөрийн өсөлт, хувь хэмжээ

№	Газрын нэр, байршил	Газрын төлбөр (мян.төг)				Өсөлт (%-иар) суурь оныг 2016 оноор авав.		
		2016 он	2022 он	2028 он	2033 он	2022 он	2028 он	2033 он
1	Улиастай, Жинст, Богдын гол баг	6765.3	13530.5	23678.4	33826.3	200.0	350.0	500.0
2	Улиастай, Жаргалант, Чигэстэй, Өлзийт, Товцог багийн одоогийн байгаа суурьшлын хил заагаар	5081.5	7622.2	12703.6	17785.1	150.0	250.0	350.0
3	Шинээр бий болох суурин	0	1392.7	3050.2	6345	100.0	219.0	455.6
<b>Дүн</b>		<b>11846.8</b>	<b>22545.4</b>	<b>39432.2</b>	<b>57956.4</b>	<b>190,3</b>	<b>332,8</b>	<b>489,2</b>

Дээрх тооцооллоос харахад төлөвлөлтийн 1-р үе шатанд газрын төлбөр 22,5 сая төгрөг, 2-р үе шатанд 39,4 сая төгрөг, төлөвлөлтийн эцсийн хугацаанд 57,9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэн 190-490 хувиар төлбөрийн хэмжээ өсөн нэмэгдэхээр гарч байна.


Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр хэрэгжих газар ашиглалтын төрөл, хэмжээг ойрын дунд хэтийн хугацаанд тооцон газрын төлбөрийн урьдчилсан балансыг тооцож гаргалаа.

Хүснэгт 104. Завхан аймгийн газрын төлбөрийн өсөлтийн тооцоолол


№	Сумдын нэрс	Талбай, га				Газрын төлбөр, мян.төг			
		2016 он	2022 он	2028 он	2033 он	2016 он	2022 он	2028 он	2033 он
1	Улиастай	118.5	133.7	153.7	183.6	11850	22545.4	39432.2	57956.3
2	Алдархаан	37.5	37.5	37.5	37.5	3000	3000	3000	3000
3	Асгат	27.5	27.5	27.5	27.5	2200	2200	2200	2200
4	Баянхайрхан	23.75	23.75	23.75	23.75	1900	1900	1900	1900
5	Баянтэс	37.5	37.5	37.5	37.5	3000	3000	3000	3000
6	Дөрвөлжин	437.5	1637.5	3137.5	5237.5	35000	131000	171000	187800
7	Завханмандал	20	23.5	30.5	37.5	1600	1880	2440	3000
8	Идэр	28.75	28.75	28.75	28.75	2300	2300	2300	2300
9	Их Уул	25	32	46	63.5	2000	2560	3680	5080
10	Нөмрөг	25	32	42.5	60	2000	2560	3400	4800
11	Отгон	35	36.5	38	39.5	2800	2920	3040	3160
12	Сантмаргац	26.25	27.75	30.75	32.25	2100	2220	2460	2580
13	Сонгино	22.5	22.5	22.5	22.5	1800	1800	1800	1800

14	Тідэвтэй	22.5	29	37	47	1800	2320	2960	3760
15	Тэлмэн	25	31.5	38	51	2000	2520	3040	4080
16	Тэс	31.25	31.25	31.25	31.25	2500	2500	2500	2500
17	Тосонцэнгэл	75	80	86.5	95	6000	6400	6920	7600
18	Ургамал	26.25	30.75	35.25	7.5	2100	2460	2820	600
19	Цагаанхайрхан	20	21.5	23	24.5	1600	1720	1840	1960
20	Цагаанчулуут	25	26.5	28	29.5	2000	2120	2240	2360
21	Цэцэн-уул	22.5	31	39.5	56.5	1800	2480	3160	4520
22	Шилүүстэй	20	23	26	29	1600	1840	2080	2320
23	Эрдэнэхайрхан	63.75	68.25	72.75	77.25	5100	5460	5820	6180
24	Яруу	22.5	25.5	28.5	31.5	1800	2040	2280	2520
<b>Аймгийн дүн</b>		<b>1218.5</b>	<b>2498.7</b>	<b>4102.2</b>	<b>6311.35</b>	<b>99850</b>	<b>211745.4</b>	<b>275312,2</b>	<b>316976,3</b>
Зөрүү		-	+1280,2	+1603,5	+2209,1	-	+111895,4	+63566,8	+41664,1

Завхан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний үе шатанд эзэмшил ашиглалтын газар 1280,2 га талбайгаар нэмэгдэж газрын төлбөр 111,8 сая төгрөгөөр нэмэгдэхээр гарч байгаа нь Улиастай хотын газрын төлбөрийн хувь хэмжээ өөрчлөгдөж байгаа болон Дөрвөлжингийн уурхайн газар эзэмшлийн хэмжээ нэмэгдүүлж байгаатай холбоотой. Төлөвлөлтийн эцсийн хугацаанд газрын төлбөрөөс олох орлого 316,9 сая төгрөгт хүрч одоо байгаагаас 3 дахин нэмэгдэж байна.



Диаграмм 71. Эзэмшүүлэх, ашиглуулах газрын талбай, төлөвлөлтөөр



Диаграмм 72. Газрын төлбөрийн орлого, төлөвлөлтөөр

Завхан аймгийн газрын төлбөрөөс олж байгаа төлбөрийн тодорхой хувийг газрын сайжруулалт, нөхөн сэргээлтийн ажилд зарцуулах шаардлагатай

#### 4.4 ҮЙЛДВЭР УУРХАЙН БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Газрын нэгдмэл сангийн ангилалаар үйлдвэр, уурхайн газар нь хот тосгон бусад суурин газарт багтах бөгөөд Завхан аймгийн хэмжээнд үйлдвэр уурхайн бүсийг төлөвлөхдөө дараахь эрхзүйн баримт бичгийг үндэслэсэн.

**Үндэслэл:** УИХ-аас баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” (2016 он), УИХ-ын “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” (2015 он), Засгийн газрын тогтоол “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөр (2016), Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 18 дугаар тогтоол “Завханд үйлдвэрлэж, Завханчууд хэрэглэж, экспортлох” хөтөлбөр (2015 он), “Завхан аймгийн тогтвортой хөгжлийн стратеги” онол практикийн бага хурлын зөвлөмж (2013 он) тус тус үндэслэв.

##### 4.4.1 Үйлдвэр, уурхайн салбарын өнөөгийн байдал

Завхан аймагт олон төрлийн үйлдвэрлэл төдийлэн хөгжөөгүй бөгөөд хүнсний бүтээгдэхүүн, хувцас, модон эдлэл, сүлжмэл, нэхмэл, суран эдлэл, бэлэг дурсгалын зүйл, эсгий, эсгий эдлэл, гэрийн мод, барилгын ханын материал, гурилын үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулж байна. Мал аж ахуй, газар тариалан, хүнс, ахуй үйлчилгээ, мод, модон эдлэл, барилга угсралт, барилгын материалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 300 гаруй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

##### Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн:


Улсын хэмжээнд 2016 оны байдлаар 11067028,4 сая төг-ийн бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэгдсэнээс Завхан аймаг нь 0,74 хувь буюу 864422,5 сая төг-ний бүтээгдэхүүн борлуулсан байна.

Хүснэгт 105. Монгол улсын ДНБ, 2016 он

Байр	Аймгийн нэр	ДНБ, сая төг	Эзлэх хувь
1	Улаанбаатар	15620117,5	65,39




2	Орхон	1204146,7	5,04
3	Дорнод	646797,2	2,71
4	Сэлэнгэ	607435,8	2,54
5	Төв	533951,6	2,24
6	Хөвсгөл	485781,8	2,03
7	Өвөрхангай	402322	1,68
8	Архангай	381718,4	1,60
9	Дархан-Уул	378562,9	1,58
10	Баянхонгор	353492,8	1,48
11	Сүхбаатар	339435,5	1,42
12	Хэнтий	332832,5	1,39
13	Увс	322092,8	1,35
14	Баян-Өлгий	307007,7	1,29
15	Ховд	300730,2	1,26
16	Булган	294493,2	1,23
17	<b>Завхан</b>	<b>292176,9</b>	<b>1,22</b>
18	Өмнөговь	280671	1,18
19	Дорноговь	258654,1	1,08
20	Говь-Алтай	233111,2	0,98
21	Дундговь	229410,9	0,96
22	Говьсүмбэр	81466,8	0,34
<b>Улсын нийт</b>		<b>23886409,5</b>	<b>100,00</b>



Диаграмм 73. Монгол улсын ДНБ-д Завхан аймгийн эзлэх байр суурь

Баруун бүсийн аймгууд улсын нийт ДНБ-ий 6,1 хувийг бэлтгэж байгаагаас Завхан аймаг нь баруун бүсийн хэмжээнд 20,1 хувийг үйлдвэрлэж байгаа нь баруун бүсийн аймгууд нь үйлдвэрлэл сул хөгжсөн байгааг харуулж байна. Баруун бүсийн аймгууд нь үйлдвэрлэлийн түвшин, хангамж ойролцоо хөгжилтэй байгаа нь үйлдвэрлэж буй ДНБ-ий хэмжээнээс харагдаж байна.

Аймгийн хэмжээгээр 2005-2016 онд үйлдвэрлэсэн ДНБ-ийн хэмжээг харьцуулж үзвэл сүүлийн 5 жилд тогтмол өсөлттэй харагдж байгаа нь үйлдвэрлэл хөгжих хандлага байгааг илтгэж байна.



Диаграмм 74. Завхан аймгийн ДНБ-ий өөрчлөлт /сүүлийн 10 жилээр/

Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбар 52.5 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 0.8 хувь, үйлчилгээний салбар 46.7 хувийг тус тус эзэлж байна. Аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх жилээс 0,8 хувиар өсч, аймгийн нийт үйлдвэрлэлд хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын үйлдвэрлэл давамгайлж байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлийн салбарт чиглэгдэж буй бодлого шийдвэр, хөрөнгө оруулалтын хэмжээ өсч үйлдвэрлэл нэмэгдэх таатай нөхцөл бүрдэж байна.

Нийт үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 38,6 хувийг, хүнсний үйлдвэрлэл 15,2 хувь, хувцас үйлдвэрлэл 7,3 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 4,5 хувь, барилгын ханын материал 2,0 хувь, гурил үйлдвэрлэл 0,5 хувь, эсгий, эсгий эдлэл 0,4 хувь, бусад үйлдвэрлэл 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 106. Завхан аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн

Аж үйлдвэрийн салбар	Нийт бүтээгдэхүүн, сая төг	Эзлэх хувь
Боловсруулах үйлдвэр	4849,5	31,1
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	2374,3	15,2
Гутал, хувцас үйлдвэрлэл	1135,3	7,3
Модон эдлэл үйлдвэрлэл	703,8	4,5
Блок тоосгоны үйлдвэрлэл	304,3	2,0
Гурил үйлдвэрлэл	73,4	0,5
Эсгий, эсгий эдлэл үйлдвэрлэл	69,8	0,4
Бусад /төмөр/	56,6	0,4
Цахилгаан, дулааны, эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	6020,9	38,6
<b>Аймгийн нийт</b>	<b>15587,9</b>	<b>100,0</b>



Диаграмм 75. Завхан аймгийн нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, сая.төг

Одоо аймагт 2 иоджуулсан давсны үйлдвэр ажиллаж, жилдээ дунджаар 100 гаруй тн давс үйлдвэрлэн, аймгийн хэрэгцээний 80-90 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.

Энэ онд хураан авсан төмс, хүнсний ногоо нь аймгийн жилийн нийт хэрэгцээний 60,0 гаруй хувийг хангаж, Алдархаан, Улиастай, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэлмэн, Цагаанхайрхан сумд өөрийн хэрэгцээний 40.0-өөс дээш хувийг ханган, бусад сумд жилийн хэрэгцээгээ хангаж чадахгүй тооцоо гарч байна. Манай аймаг жилд 7509.0 тн төмс, хүнсний ногоо хураан авбал жилийн хэрэгцээг бүрэн хангах боломжтой юм.

Аймагт хоногт 25,0 тн гурил үйлдвэрлэх хүчин чадал бүхий 2 үйлдвэр ажиллаж, жилд дундажаар 300,0 гаруй тн гурил үйлдвэрлэн, аймгийн нийт гурилын хэрэглээний 10 хүртэл хувийг хангаж, бусад гурилын хэрэглээг Улаанбаатарын болон импортын гурил хэрэглэж байна.

Хөдөөгийн сумдад нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан талхны жижиг цехүүд үйл ажиллагаа явуулж байна. Талх, нарийн боовны цехүүдийн техник технологийг шинэчлэх, мэргэжилтэй ажилтанаар хангах замаар үйл ажиллагааг нь өргөжүүлэн тухайн сумынхаа хүн амын хэрэгцээг бүрэн хангах боломжтой.

Ахуй үйлчилгээний салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ ихэнх сумдад хатуу, зөөлөн оёдолын чиглэлээр өрхийн үйлдвэрлэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 30 гаруй иргэд, аж ахуйн нэгж байгаа бөгөөд эдгээр нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн захиалгын үйлдвэрлэл явуулж байна. Үсчин гоо сайхны үйлчилгээ эрхэлж байгаа 45 салбар байна. Цаашид аймгийн төв болон бүсийн төвүүдэд ахуй үйлчилгээний иж бүрэн цогцолборуудыг бий болгон хөгжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Улиастай суманд талх, нарийн боов, чихэр, жимсний чанамал, зайрмаг, өндөг, цэвэр ус, экологийн цэвэр жимсний шүүс, хиам, мах, гурил, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 37, сүү цагаан идээний 15 фермер, эсгий, ноосон бүтээгдэхүүний 14, барилгын материалын 15, хувцас оёдлын 17, мод, төмөр эдлэлийн 4 үйлдвэрлэл тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

Томоохон үйлдвэрлэлээс дурьдвал “Завханбаялаг” ХК нь жилд 300 тн архи, ундаа, жүүс, 100 тн жимсний дарс, 20 тн жимсний чанамал, 300 тн цэвэр ус, 30 тн нарийн боов, 1000 тн давс үйлдвэрлэх хүчин чадалтай хүнсний ууган үйлдвэр, 1000 бог, 250 бод нядлах хүчин чадалтай Мах боловсруулах “Завхан хүнс групп” ХХК, 5000 өндөглөгч тахиатай “Ган залаа” ХХК, хоногт 20 тн гурил үйлдвэрлэх хүчин чадалтай “Өгөөмөр” ХХК, тавилга үйлдвэрлэлийн “Ойн баялаг” ХХК, тоосго, блок үйлдвэрлэлийн “Боду” ХХК, бялуу, хиам, дарс, талх, нарийн боов үйлдвэрлэлийн “Мөнхөд мандаг” ХХК-ууд үйлдвэрлэлээ улам өргөжүүлэн, ажлын байрыг тогтмол нэмэгдүүлэн ажиллаж байна.

Худалдаа, үйлчилгээний чиглэлээр худалдааны төв 5, хүнсний бөөний болон дэлгүүр 191, нийтийн хоол үйлдвэрлэлээр зоогийн газар, кафе, баар, гуанз, байгууллагын дэргэдэх цайны газар 53, ахуйн үйлчилгээний чиглэлээр нийт 96 үйлчилгээний цэг салбарууд тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Завхан аймгийн эдийн засгийн хөгжлийн түвшин ихээхэн доогуур байна. Нэг хүнд ногдох ДНБ 2008 онд 1206 мян.төг байгаа нь улсын дунджаас 100 мянган төгрөгөөр бага байна. Манай улсын ДНБ-ий 1.6 хувийг Завхан аймагт үйлдвэрлэж байгаа бөгөөд улсын нийт хүн амын 3 хувь оршин сууж байгаа нөхцөлд энэ нь ихээхэн чамлалттай үзүүлэлт юм. Аймгийн эдийн засгийн салбарын бүтэц ч ихээхэн хоцрогдсон байна. Аймгийн ДНБ-ий үйлдвэрлэлд 2008 оны байдлаар бэлчээрийн МАА-д суурилсан хөдөө аж ахуйн салбар 72.5 хувийг, аж үйлдвэр, барилгын салбар 3.6 хувийг, бөөний болон жижиглэн худалдаанд суурилсан үйлчилгээний салбар 23.9 хувийг тус тус эзэлж байна.

#### Аймгийн уул уурхайн газар:

Аймгийн урд сумдуудад уул уурхайн газрууд төвлөрсөн байгаа бөгөөд Дөрвөлжин, Завханмандал, Сантмаргац, Сонгино, Ургамал сумдуудад нийт 12380,71га буюу нийт нутаг дэвсгэрийн 0,15 хувьд ашиглалтын лиценз олгосон байна. Хайгуулын лицензийг Алдархаан, Асгат, Баянхайрхан, Дөрвөлжин, Завханмандал, Идэр, Отгон, Сантмаргац, Ургамал, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан сумдуудад нийт 67 талбай, 531131 га буюу нийт нутаг дэвсгэрийн 6,4 хувьд олгосон байна.

#### Хүснэгт 107. Аймгийн уул уурхайн газрын судалгаа

№	Лицензийн дугаар	Сумын нэр	Лиценз эзэмшигч	Талбайн нэр	Талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн хугацаа	
						Олгосон	Дуусах
<b>Ашиглалтын лицензтэй талбай</b>					<b>12380,71</b>		
1	МУ-017666	Дөрвөлжин	Баян айраг эксплоейшн	Баруун бор толгой -1	3910,87	2014.11.06	2044.11.06
2	МУ-013409	Дөрвөлжин	Баян айраг эксплоейшн	Баян айраг	6100,29	2008.3.24	2038.3.24
3	МУ-003883	Завханмандал	Дэлгэрхангай трейд	Зүрхийн хуудас	399,88	2001.12.03	2031.12.03
4	МУ-011790	Завханмандал	Шувуун уул	Баруун шувуун уул	153,1	2006.5.23	2036.5.23
5	МУ-001130	Сантмаргац	Монголхан	Дэвтээр нуур	151,57	1998.04.20	2028.04.20
6	МУ-005877	Сонгино	Мөнх ням хайрхан	Цавдан	20,3	2003.06.05	2033.06.05
7	МУ-020628	Ургамал	Форс голд майнинг	Од	1644,7	2016.09.20	2046.09.20
<b>Хайгуулын лицензтэй талбай</b>					<b>5090672,5</b>		
1	XV-020300	Алдархаан	Эрчит ресорсиз	Зүүнбаян	234180,0	2016.03.18	2019.03.18
2	XV-018299	Алдархаан	Ган	Бүрд	7746,0	2015.06.15	2018.06.15

3	XV-018237	Алдархаан	Цагдуулт ресурс	Тас	374741,8	2015.06.22	2018.06.22
4	XV-017762	Алдархаан	Маргад инженеринг	Хашаат	43115,5	2015.04.21	2018.04.21
5	XV-017928	Асгат	Нэр тодорхойгүй	Шийрт	70456,6	2016.04.06	2019.04.06
6	XV-018001	Баянхайрхан	Зэмүүжин	Урт	4093,4	2015.10.15	2018.10.15
7	XV-017774	Баянхайрхан	Адексмайн	Оюут	1678,6	2015.10.21	2018.10.21
8	XV-018503	Дөрвөлжин	Эм Си Эй Ди	Алаг	8516,1	2015.11.16	2018.11.16
9	XV-018458	Дөрвөлжин	Эф Эйч Эл	Дэл	48846,8	2015.12.02	2018.12.02
10	XV-018119	Дөрвөлжин	Эс Ди Ти И Эм	Дөрвөлжин	22878,0	2015.05.12	2018.05.12
11	XV-017981	Дөрвөлжин	Ньюмон ривер	Дааган дэл	56954,8	2015.02.27	2018.02.27
12	XV-017941	Дөрвөлжин	ЗААКИ	Аргал	37247,7	2015.04.27	2018.04.27
13	XV-017847	Дөрвөлжин	Түүчээ тэрэг	Од	68668,4	2016.08.04	2019.08.04
14	XV-017776	Дөрвөлжин	Буман олз дриллинг	Дөр	44479,7	2015.04.27	2018.04.27
15	XV-017769	Дөрвөлжин	Касс таун	Ханын худаг	270160,1	2015.03.09	2018.03.09
16	XV-017734	Дөрвөлжин	Түүчээ тэрэг	Од	195947,5	2016.08.04	2019.08.04
17	XV-020705	Завханмандал	Болдгянтболд	Завхан	10024,8	2015.11.02	2018.11.02
18	XV-018627	Завханмандал	Топдаймонд дриллинг	Мандал	15606,3	2016.04.22	2019.04.22
19	XV-018532	Завханмандал	Ханбогд эксплорейшн	Гал	65254,1	2015.11.13	2018.11.13
20	XV-018447	Завханмандал	Ханбогд эксплорейшн	Овгор	107108,6	2015.11.16	2018.11.16
21	XV-018444	Завханмандал	Ханбогд эксплорейшн	Бага хайрхан	26765,6	2015.10.22	2018.10.22
22	XV-018380	Завханмандал	Будар минералс	Мандал	48762,2	2015.11.04	2018.11.04
23	XV-018369	Завханмандал	Баян-Алт	Баян-1	75162,7	2015.11.18	2018.11.18
24	XV-018282	Завханмандал	ДУО	Элст	39219,2	2015.06.11	2018.06.11
25	XV-018269	Завханмандал	Ханбогд эксплорейшн	Ханбогд	53433,6	2015.10.20	2018.10.20
26	XV-018248	Завханмандал	Кенросс майнинг	Паглагар	13564,5	2015.11.16	2018.11.16
27	XV-018161	Завханмандал	Талын үчимбэр	Хага	18522,8	2015.10.22	2018.10.22
28	XV-017827	Завханмандал	Мегатонминера лс	Хонгилт	216876,6	2015.04.15	2018.04.15
29	XV-017822	Завханмандал	Ибараки	Бага буурал уул	134880,5	2015.11.13	2018.11.13
30	XV-017759	Завханмандал	Нью оюут майнинг	Паглагар	20345,8	2015.04.22	2018.04.22
31	XV-017756	Завханмандал	Ханбогд эксплорейшн	Мандал	35678,1	2015.08.10	2018.08.10
32	XV-017721	Завханмандал	Монганитминер алс	Цагаанхайрхан	131374,3	2017.02.17	2020.02.17
33	XV-017957	Идэр	Анарболор эрдэс	Энгэр	13989,1	2015.10.15	2018.10.15
34	XV-018377	Отгон	ЖАСКО	Ширийн толгой	62439,2	2015.10.14	2018.10.14
35	XV-020370	Сантмаргац	Боролзой	Ихэр майхан	65877,2	2016.02.24	2019.02.24
36	XV-018515	Сантмаргац	Тиара- Эксплорейшн	Шивээт	93039,7	2015.10.26	2018.10.26
37	XV-018509	Сантмаргац	Саяардриллинг	Хөдөө	218356,9	2015.11.05	2018.11.05
38	XV-019026	Ургамал	Форс голд майнинг	Од	13781,1	2015.05.18	2018.05.18
39	XV-019025	Ургамал	Форс голд майнинг	Од	9294,5	2015.05.18	2018.05.18
40	XV-018788	Ургамал	Соларнано энержи	Хар толгой	29533,7	2016.04.15	2019.04.15
41	XV-018646	Ургамал	Арголд	Элст	6476,5	2015.04.28	2018.04.28

42	XV-017836	Ургамал	Касс таун	Од	77420,7	2015.04.17	2018.04.17
43	XV-017831	Ургамал	Дэнжийн солонго	Хар	15073,4	2015.04.27	2018.04.27
44	XV-017820	Ургамал	Баян талст эрдэнэ тур	Ургамал	108026,0	2015.06.18	2018.06.18
45	XV-017773	Ургамал	Арголд	Толгой	53991,0	2015.04.22	2018.04.22
46	XV-017729	Ургамал	Форс голд майнинг	Од	41413,6	2015.05.18	2018.05.18
47	XV-017718	Ургамал	Эйжаминералз	Тос	426188,2	2015.04.17	2018.04.17
48	XV-018302	Цагаанчулуут	Эмералд-Экспедишн	Салхит	207342,8	2016.02.03	2018.02.03
49	XV-018270	Цагаанчулуут	Эс И И Ди	Их	196489,7	2016.08.02	2019.08.02
50	XV-018197	Цагаанчулуут	Эрдэнийн эх хувь	Талын цахир	30809,8	2015.11.23	2018.11.23
51	XV-018173	Цагаанчулуут	ЖАСКО	Бумба	206238,9	2016.02.03	2019.02.03
52	XV-018180	Цэцэн-Уул	Мөнхбичигт	Бэрх	55935,0	2016.02.03	2019.02.03
53	XV-018691	Шилүүстэй	Отгонбогд	Мөнгөт-1	79604,0	2016.05.23	2019.05.23
54	XV-018586	Шилүүстэй	Фейстмедиа групп	Од	11464,5	2015.10.26	2018.10.26
55	XV-018446	Шилүүстэй	Их хүрмэн	Цахир	11552,5	2016.03.01	2016.03.01
56	XV-018332	Шилүүстэй	Улиастайчулуу	Ботгын хоолой	15285,8	2015.10.12	2018.10.12
57	XV-018236	Шилүүстэй	Батшандас	Өвгөн овоо	26126,1	2015.11.05	2018.11.05
58	XV-018181	Шилүүстэй	Боролзой	Тамгат	129334,9	2016.07.19	2019.07.19
59	XV-018147	Шилүүстэй	Милленумсинер жи ресурс	Баяндулаан	23445,1	2015.11.05	2018.11.05
60	XV-018108	Шилүүстэй	ЖАСКО	Баян-улаан	87586,9	2016.02.03	2019.02.03
61	XV-020267	Эрдэнэхайрхан	Зая кристал	Эрдэнэт	78390,3	2016.04.01	2019.04.01
62	XV-018938	Эрдэнэхайрхан	Зэд алт	Эрдэнэт	38159,8	2016.01.19	2019.01.19
63	XV-018256	Эрдэнэхайрхан	Нэр тодорхойгүй	Худаг	29142,1	2015.11.10	2018.11.10
64	XV-018160	Эрдэнэхайрхан	Улиастайчулуу	Цахир	43963,6	2015.10.12	2018.10.12
65	XV-018105	Эрдэнэхайрхан	Аксикос	Хадат	7098,0	2015.11.02	2018.11.02
66	XV-018103	Эрдэнэхайрхан	Чанд-Үйлс	Тал	43918,0	2015.10.26	2018.10.26
67	XV-018025	Эрдэнэхайрхан	Сайхан улаан оргил	Хадат оргил	31593,2	2015.05.11	2018.05.11



Зураг 176. Завхан аймгийн үйлдвэр, уурхайн газрын байршлийн зураг

### Уурхайн нөлөөллийн бүс:

Уул уурхайн үйл ажиллагааны үр дүнд ихэвчлэн хүдэрт агуулагддаг хүнцэл /As/, кадми /Cd/, хар тугалга /Pb/, мөнгөн ус /Hg/ зэрэг хүнд металл хүрээлэн буй орчинд тоосонцор хэлбэрээр тархаж агаар, ус, хөрс, хоол хүнсийг бохирдуулж, улмаар тэдгээрээр дамжин оршин суугчдын эрүүл мэндэд эрсдэл учирдаг. Хорт бодисуудаас хүнцэл, хар тугалга хүрээлэн буй орчинд маш бага түвшинд байсан ч хүн, амьтанд хортой нөлөө үзүүлж, хорт хавдар үүсэхэд нөлөөлдөг учраас уурхайн нөлөөллийн бүсийг тогтооц, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авах нь чухал юм. Дүйцүүлэн хамгаалал хийх аргачлалаар говийн бүсэд 6 км, хээрийн бүсэд 5 км радиусаар нөлөөллийн бүсийг тогтооно.

Хүснэгт 108. Ашигт малтмал, газрын тосны ашиглалтын талбайн нөлөөллийн бүсийн утгууд

№	Байгалийн бүс	Нөлөөлөл буурах зэрэг	Нөлөөллийн эрчим	Нөлөөлөл буурах зая, м
1	Говийн бүс	Алгуур	500	6000
2	Хээрийн бүс	Алгуур	500	5000

Иймд аймгийн хэмжээгээр ашиглалтын лицензтэй 7 уурхайн газарт дүйцүүлэн хамгаалал хийх аргачлалын дагуу уурхайн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоож үзэхэд, нийт 110392,19 га талбай нөлөөлөлд өртөхөөр гарсан.

Хүснэгт 109. Уурхайн газрын нөлөөллийн бүс

№	Сумын нэр	Лиценз эзэмшигч	Талбайн нэр	Урхайн ашиглалтын талбай, га	Нөлөөллийн бүс	
					Хэмжээ, м	Талбай, га
1	Дөрвөлжин	Баян айраг эксплорейшн	Баруун бор толгой -1	3910,87	6000	47384,39

2	Дөрвөлжин	Баян айраг эксплорейшн	Баян айраг	6100,29	6000	
3	Завханмандал	Дэлгэрхангай трейд	Зүрхийн хуудас	399,88	6000	20987,1
4	Завханмандал	Шувуун уул	Баруун шувуун уул	153,1	6000	
5	Сантмаргац	Монголхан	Дэвтээр нуур	151,57	5000	10548,9
6	Сонгино	Мөнням	Цавдан	20,3	5000	8207,9
7	Ургамал	Форс голд майнинг	Од	1644,7	6000	23263,9
<b>Аймгийн нийт</b>				<b>12380,71</b>		<b>110392,19</b>



Зураг 177. Уурхайн газрын нөлөөллийн бүс

#### 4.4.2 Үйлдвэрийн салбарийн SWOT-АНР шинжилгээ

Салбарын үр дүнд нөлөөлөх дотоод хүчин зүйлсийн давуу талыг илэрхийлэх 2, сул талыг илэрхийлэх 3, гадаад хүчин зүйлсийн таатай нөхцлийг илэрхийлэх 4, таагүй нөхцлийг илэрхийлэх 3, нийт 12 хүчин зүйлс (гол) -ийг сонгон авч, SWOT-АНР шинжилгээг хийв.

Хүснэгт 110. Аймгийн үйлдвэрийн салбарын SWOT-АНР шинжилгээ

Давуу тал	Сул тал
I. Газарзүйн баршлын хувьд Баруун аймгууд руу явах зам дагуу, ОХУ- руу гарах гарцтай тул үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гадаад, дотоод зах зээлд гаргах боломжтой.	III. Аймгийн 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн улсын дунджаас 100.0 мян төг-өөр бага байна.
II. Монгол улсын хэвтээ тэнхлэгийн мянганы замд холбогдож байгаа, найдвартай цахилгааны эх үүсвэрт бүх сумдууд холбогдсон.	IV. Боловсруулах үйлдвэр сул хөгжсөн V. Аймгийн хүн ам нь Монгол улсын нийт хүн амын 3 хувийг эзэлдэг хэдий ч улсын ДНБ-ий 1,6 хувийг үйлдвэрлэж байна.
Боломж	Эрсдэл
I. Баруун аймгууд руу явах улсын чанартай төв зам дайран	V. Засгийн газрын түвшинд шийдвэрлэж чадахгүй



өнгөрч байгаа тул анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрүүд хөгжих боломжтой.						бол мах экспортлох асуудал хэрэгжихгүй байх магадлалтай.				
II. Арц суурийн боомтоор махыг экспортлох боломжтой.						VI. Яамнаас бодлогын чанартай баруун бүсийн хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг цуглуулах, анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрийг байгуулах ажлыг дэмжихгүй бол хөгжихгүй байх магадлалтай.				
III. Нутгийн брэнд бүтээгдэхүүн улаан хальст сармис нь зах зээлд өндөр үнээр борлогддог тул түүнийг тариалж зах зээлд гаргах боломжтой.						VII. Шинээр хөгжих үйлдвэрүүдийн хог хаягдал, бохир усны асуудлыг ТЭЗҮ-ийн шатанд сайн төлөвлөхгүй бол байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй.				
IV. Жимс жимсгэний нөөц ихтэй тул жимс боловсруулах үйлдвэр хөгжих боломжтой										
Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц										
PV	0.104	0.124	0.250	0.050	0.472					
№	I	II	III	IV	V	PV	PA	PA/PV		
I	1	1.000	0.333	3.000	0.200	0.104	0.555	5.319		
II	1.000	1	0.300	5.000	0.200	0.124	0.647	5.211		
III	3.000	3.333	1	5.000	0.333	0.250	1.383	5.534		
IV	0.333	0.200	0.200	1	0.200	0.050	0.254	5.101		
V	5.000	5.000	3.000	5.000	1	0.472	2.613	5.536		
Нийлбэр	10.333	10.533	4.833	19.000	1.933	1	<b>Lmax</b>	5.340		
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.								<b>CI</b>	0.085	
										<b>CR</b>
Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц										
PV	0.178	0.046	0.162	0.110	0.230	0.049	0.225			
№	I	II	III	IV	V	VI	VII	PV	PA	PA/PV
I	1	5.000	1.000	3.000	0.333	3.000	1.000	0.178	1.351	7.609
II	0.200	1	0.333	0.333	0.200	1.000	0.333	0.046	0.343	7.388
III	1.000	3.000	1	3.000	1.000	3.000	0.333	0.162	1.261	7.783
IV	0.333	3.000	0.333	1	1.000	3.000	0.333	0.110	0.815	7.399
V	3.000	5.000	1.000	1.000	1	5.000	1.000	0.230	1.737	7.559
VI	0.333	1.000	0.333	0.333	0.200	1	0.333	0.049	0.366	7.452
VII	1.000	3.000	3.000	3.000	1.000	3.000	1	0.225	1.736	7.718
Нийлбэр	6.867	21.000	7.000	11.667	4.733	19.000	4.333	1	<b>Lmax</b>	7.558
Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно.								<b>CI</b>	0.093	
										<b>CR</b>

Дээрх анализийн үр дүнд аймгийн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааны стратегийг баримтлах шаардлагатай болно.

[Хүснэгт 111. Үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх үйл ажиллагааны стратеги](#)

Төлөвлөлтийн хугацаа	Стратеги
Ойрын 2022 он	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын давуу талуудад тулгуурлан гадаад орчны таатай нөхцлийг дээд зэргээр ашиглах замаар аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх.</li> <li>Салбарын сул талуудыг сайжруулан гадаад орчны таатай нөхцлийг дээд зэргээр ашиглах замаар аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх.</li> </ul>
Дундын 2028 он	<ul style="list-style-type: none"> <li>Салбарын давуу талуудад тулгуурлан гадаад орчны таагүй нөхцлийн сөрөг нөлөөг бууруулах замаар аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх.</li> <li>Гадаад орчны таагүй нөхцөлд салбарын сул талуудыг сайжруулах замаар гарах сөрөг үр дагаварыг аль болох багасгах замаар аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх.</li> </ul>
Хэтийн 2033 он	

#### 4.4.3 Үйлдвэрийн газрын хэрэгцээ

Үйлдвэрийн газрыг төлөвлөхдөө хүн амын хүнсний болон мод модон эдлэлийн хэрэгцээг статистикийн тайлангаас үр дүнг авч ашиглан, математик загварчлалын аргаар хэтийн хэрэгцээг төлөвлөлтийн хугацаанд тооцож гаргасан. Төлөвлөлтийн хугацаанд мах махан бүтээгдэхүүни хэрэгцээ одоо байгаагаас 22,38 мян. тн-оор, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ 39,7 мян тн-оор, гурил гурилан бүтээгдэхүүн хэрэгцээ

35,8 мян.тн-оор, төмс хүнсний ногооны хэрэгцээ 38,03 мян. тн-оор, жимс жимсгэний хэрэгцээ 20,14 мян.тн-оор, хүнсний тос, өндөгний хэрэгцээ 4,9 мян.тн-оор нэмэгдэж байгаа тул хүнсний хэрэгцээг хангах үйлдвэрийн газруудыг төлөвлөх шаардлагатай болно.

Хүснэгт 112. Хүнсний болон модон эдлэлийн хэрэгцээ

Үзүүлэлт	Одоо байгаа	Төлөвлөлтийн хугацаа					
		Ойрын 2022 он		Дундын 2028 он		Хэтийн 2033 он	
		Жилд дунджаар	Нийт	Жилд дунджаар	Нийт	Жилд дунджаар	Нийт
<b>Хүн амын хүнсний хэрэгцээ</b>							
Мах, махан бүтээгдэхүүн, мян.тн	4.65	5.27	31.59	6.08	36.47	6.76	27.03
Сүү, мян.тн	3.49	3.95	23.72	4.56	27.38	5.07	20.29
Сүүн бүтээгдэхүүн, мян.тн	4.65	5.27	31.59	6.08	36.47	6.76	27.03
Гурил, гурилан бүтээгдэхүүн, мян.тн	7.45	8.42	50.55	9.73	58.36	10.81	43.25
Төмс, мян.тн	3.26	3.69	22.11	4.26	25.53	4.73	18.92
Хүнсний ногоо, мян.тн	4.65	5.27	31.59	6.08	36.47	6.76	27.03
Жимс, жимсгэнэ, мян.тн	4.19	4.74	28.43	5.47	32.83	6.08	24.33
Хүнсний тос, мян.тн	0.58	0.66	3.94	0.76	4.55	0.84	3.37
Өндөг, мян.тн	0.44	0.50	2.99	0.57	3.45	0.64	2.55
<b>Мод, модон эдлэлийн хэрэгцээ</b>							
Аймгийн нийт өрх гэр	21,078	23,841	143,049	27,526	165,156	30,597	122,386
Нэг өрхийн хэрэгцээ, мян.төг	500.0	500.0	500.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0
Нийт хэрэгцээ, сая.төг	10539.0	11920.7	71524.3	27526.0	165156.2	30596.5	122386.1

Хүн ам нэмэгдэхийн хирээр мод, модон эдлэлийн хэрэгцээ нэмэгдэх бөгөөд төлөвлөлтийн эцэст одоогийнхоос 111847,1 сая төг-ийн хэрэгцээ үүсэж байна.

#### 4.4.4 Үйлдвэр, уурхайн бүсийн төлөвлөлт

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д:

- Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэлийг дэмжих,
- Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд бий болгох /2021-2025 он/
- Аж үйлдвэрийн хөгжлийн тэргүүлэх бүсийг тогтоох /2021-2025 он/
- Газар нутаг ашиглалтын мастер төлөвлөгөөг аймаг, сумын түвшинд боловсруулж мөрдүүлэх /2021-2025 он/ гэсэн 3 үндсэн зорилтыг аж үйлдвэрийн салбарт тавьсан байна.

Хүснэгт 113. Аж үйлдвэрийн салбарт баримтлах бодлого

Зорилт	I үе шат /2016-2020 он/	II үе шат /2021-2025 он/	III үе шат /2026-2030 он/
1.Аж үйлдвэрийн дэвшилтэт техник технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн хувийн жинг 15 хувьд хүргэх</li> <li>• Хөдөө аж ахуйн биржийг байгуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн хувийн жинг 25 хувьд хүргэх</li> <li>• Экспортын чиглэлийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын баримжаатай боловсруулах</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• Экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх</li> <li>• Арьс, шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх</li> </ul>	боловсруулах үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх <ul style="list-style-type: none"> <li>• Арьс, шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 70 хувьд хүргэх</li> </ul>	үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх <ul style="list-style-type: none"> <li>• Арьс, шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 80 хувьд хүргэх</li> </ul>
2. Хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл баталгаат, хүнс хэрэглэх нөхцлийг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангах</li> <li>• Хот суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерийг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд махны 30 хувь, сүүний 40 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангах</li> <li>• Хот суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерийг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд махны 50 хувь, сүүний 60 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах</li> <li>• Олон улсын зах зээлд “Монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүн гаргах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангах</li> <li>• Хот суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерийг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд махны 70 хувь, сүүний 80 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах</li> <li>• Олон улсын зах зээлд “Монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх</li> </ul>

### Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогод:

Бодлогыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

- Аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх
- Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон "Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал"-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах
- Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх
- Аж үйлдвэрийн салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих
- Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих
- Бүтээлч аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх
- Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчныг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх.

Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон “Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах зорилтын хүрээнд:

- Экосистем, геополитик, хүн амын нутагшил, суурьшил, дэд бүтэц, ашигт малтмал, үндсэн түүхий эдийн нөөцөд үндэслэн аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлох
- “Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг боловсруулж, батлуулах
- Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, нэгдсэн мэдээллийн санг бий болгох





Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

- Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоох
- Хүнд, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх, кластерийн талаар баримтлах стратегийг боловсруулах
- Хөдөө аж ахуй, уул уурхайн түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулах үйлдвэрлэлийг үе шаттайгаар хөгжүүлэх
- Түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоо, бараа бүтээгдэхүүнийг борлуулах тээвэр логистикийн сүлжээг кластерийн тогтолцоотой уялдуулан хөгжүүлэх
- Кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор барих байршил, жагсаалтыг баталж, хэрэгжүүлэх
- Газрын тос, нүүрс хими, кокс хими, өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэрийг дагалдах үйлдвэрийн хамт цогцоор нь байгуулах.

Энэ зорилтын хүрээнд Монгол улсын Аж үйлдвэрийн яамнаас гаргасан Монгол улсыг бүс нутгийн аж үйлдвэрийн хөгжлийн чиглэлийн хувьд аж үйлдвэрийн хөгжлийн тэргүүлэх салбарыг 5 бүс, 27 нутгаар, 19 аж үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтын ач холбогдолыг тодорхойлж өгсөн байдаг.

Хүснэгт 114. Завхан аймгийн аж үйлдвэрийн салбарын тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалт


Аж үйлдвэрийн салбарууд	Мах, махан бүтээгдэхүүн	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Арьс арьсан бүтээгдэхүүн	Ноос ноосон бүтээгдэхүүн	Ноолуур, ноолууран бүтээгдэхүүн	Үр тариа, тэжээлийн ургамлын	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл	Жимс жимсгэний үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Модон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Нүүрс-химийн үйлдвэрлэл	Кокс-химийн үйлдвэрлэл	Газрын тосны бүтээгдэхүүн	Хар төмөрлөг, дагалдах бүтээгдэхүүн	Өнгөт төмөрлөг, дагалдах үйлдвэр	Барилгын материалын үйлдвэр	Машин байгууламж, металл хийцийн	Хиймийн үйлдвэр	Аж үйлдвэрийн парк
Завхан-Тосонцэнгэл	2	3	2	2	1	3	3	2	3	4	4	4	4	4	3	4	4	4	4
Завхан-Улиастай	2	3	2	2	1	3	3	2	3	4	4	4	4	4	4	4	4	4	4

Таних тэмдэг		Хөрөнгө оруулалтыг ихээр нэмэгдүүлэх	1	Тэргүүн ээлжинд дэмжих салбар
		Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2	Хоёрдугаар ээлжинд дэмжих салбар
		Хөрөнгө оруулалтыг зохистой түвшинд барих	3	Гуравдугаар ээлжинд дэмжих салбар
		Хөрөнгө оруулалтыг хязгаарлах	4	

Төрөөс аж үйлдвэрийг төвлөрүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлохдоо ХАА-н боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой ХАА-н үйлдвэр, технологийн парк (Agro Industrial Technology Park) байгуулахаар төлөвлөгдсөн.

ХАА-н үйлдвэрлэл технологийн парк нь газар тариалангийн бүтээгдэхүүн (хүнсний ногоо), арьс, шир, ноос, ноолуур, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүний 4 төрлийн боловсруулах салбарыг нэг дор төлөвлөснөөр бүтээмжийг нэмэгдүүлэх, логистикийн хүртээмжийг дээшлүүлэх зорилт тавин улсын хэмжээнд 8 газрыг эхний ээлжинд хөрөнгө оруулалт хийн байгуулахаар төлөвлөсөн.

Энэ 8 газарт Завхан аймгийн Тосонцэнгэл сум орсон бөгөөд дараагийн ээлжинд санхүүжүүлэгдэх ХАА-н үйлдвэрлэл технологийн паркийг Баянтэс сум, Алдархаан суманд төлөвлөгдсөн байна.



Зураг 178. Монгол улсын хөнгөн үйлдвэр хөгжүүлэх бүсийн төлөвлөлтийн зураг

Эх сурвалж. МУ-ын Аж үйлдвэрийн яам

Тэргүүн ээлжинд хөгжих ХААҮТП нь Тэлмэн сум руу шилжиж, 800 га талбайд төлөвлөгдсөн байна.

#### Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого:

Завхан аймгийн хөгжлийн цогц бодлогод аймгийн эдийн засгийн хөгжлийг үйлдвэрлэлтэй холбон гаргасан бөгөөд төлөвлөлтийн хоёрдугаар үе шат (2016-2021он) жилд дунджаар 8.6 хувиас доошгүй өсгөж, аймгийн ДНБ-ий 35.3 хувийг аж үйлдвэр барилгын салбарт, 14.7 хувийг ХАА-н салбарт, 50.0 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ:

- Өндөр технологид тулгуурласан, экспортын баримжаатай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх ;
- Уул уурхайн салбарт эрдэс баялгийг боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;
- Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох;

**Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого:** Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

#### Нэгдүгээр үе шат (2009-2015 он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 8.8 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 84.9 хувийг үйлдвэрлэж, экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина:

- Улиастай хотод “Завхан үйлдвэрлэл, технологийн парк”-ийг байгуулан ажиллуулж мах, арьс шир, ноос, ноолуур, барилгын материалын болон хүнсний үйлдвэрлэлийг экспортын баримжаатай хөгжүүлэх;
- Улиастай, Тосонцэнгэл сумдын мах боловсруулах үйлдвэрүүдийг сэргээж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- Махны үйлдвэрийг түшиглэн өлөн боловсруулах үйлдвэр байгуулах;
- Тосонцэнгэл суманд мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах;

- Улиастай, Тосонцэнгэл сумдад гурилын болон малын тэжээлийн үйлдвэрүүд байгуулах;
- Тосонцэнгэл, Отгон, Баянтэс, Түдэвтэй сумдад барилгын материал, гэрийн модон эдлэлийн жижиг, дунд үйлдвэр байгуулах;
- Тосонцэнгэл, Тэс сумдад байгалийн гаралтай хүнсний бүтээгдэхүүн , жимс, жимсгэнэ боловсруулах, савлах жижиг, дунд үйлдвэр байгуулах;
- Түдэвтэй, Идэр сумдад хөрөө рам ажиллуулж, модон эдлэлийн бэлдэц бэлтгэдэг болох;
- Сантмаргац сумын “Дэвтээрийн давс”-ны ордыг түшиглэж, баруун бүсийг хангадаг иоджуулсан давсны болон эрдэс тэжээлийн үйлдвэр байгуулах;
- Эрдэнэхайрхан сумын “Хар нуур”-т загасны аж ахуй хөгжүүлэх;
- Сантмаргац, Дөрвөлжин зэрэг хонь, ямаан сүргээрээ тэргүүлдэг сумдад ноос, ноолуур боловсруулах, эсгий, эсгий эдлэлийн үйлдвэрүүд байгуулах;
- Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, Завханы улаан хальст сармисны тариалалтыг нэмэгдүүлж, сармисны ханд бэлтгэх үйлдвэр байгуулах;
- Сумдад талх, нарийн боов, сүү цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүн боловсруулдаг жижиг үйлдвэр, цехийг зах зээлийн хэрэгцээтэй нийцүүлэн оновчтой хэлбэрээр байгуулан ажиллуулахыг дэмжих;
- Сумдад зах зээлийн хэрэгцээтэй нийцүүлэн төрөл бүрийн оёдлын үйлдвэрлэл бий болгохыг дэмжих;
- Нийт сумдад хүнсний ногооны хүлэмж байгуулах;
- “Нэг сум-нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг улам эрчимжүүлэх;
- Өндөр технологи нутагшуулах төвийг байгуулан ажиллуулах;

Стратегийн зорилт 2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно:

- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулахад зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төвийг байгуулж ажиллуулах;
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бизнес инкубатор байгуулж ажиллуулах;
- Алслагдсан бүс нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээг татварын ялгавартай бодлогоор дэмжих саналыг боловсруулж Засгийн газар, УИХ-д хүргүүлж шийдвэр гаргуулах;
- Үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэмжээ авах;
- Завхан аймгийн “брэнд” бүтээгдэхүүнийг гадаад, дотоодод сурталчлах ажлыг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах,

**Хоёрдугаар үе шат (2016-2021 он):**

Стратегийн зорилт 1. Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 8.4 хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 82.9 хувийг үйлдвэрлэж, экспортын баримжаатай боловруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлнэ:

- “Улиастай” үйлдвэрлэл, технологийн паркийг өргөтгөн хөгжүүлэх;

- Экспортын баримжаатай, оюуны шингэц бүхий өрсөлдөх чадвартай, бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

Завхан аймгийн тогтвортой хөгжлийн стратеги” онол практикийн бага хурлын зөвлөмж:

1. Экспортын бараа болон импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бренд бүтээгдэхүүнийг бий болгохыг дэмжих, аймгийн төсвийн хөрөнгөөр орон нутагтаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн худалдан авалтыг дэмжих
2. Үйлдвэрлэлийг бүсчилсэн байдлаар хөгжүүлэх. /Улиастай, Тосонцэнгэл, Тэс/
3. Завхан аймагт үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-үүдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх. /Нутгийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх талаар шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх/
4. “Завханд үйлдвэрлэв” шошго бүхий брэнд бүтээгдэхүүнийг зах зээлийн багтаамж өндөртэй /Орхон, Дархан, Улаанбаатар гэх мэт хүн ам олноор суурьшсан/ газруудад борлуулалтын сувгийг бий болгох.
5. Түүхий эд материал дээр тулгуурласан нэмүү өртөг шингээсэн хувийн хэвшлийг дэмжих.
6. Завхан аймагт брокер, диллерийн компаний үйл ажиллагаа идэвхижүүлэх. Бизнес эрхлэгчид хөрөнгийн зах зээлд үнэт цаас гаргах замаар шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох боломжийг бүрдүүлэх.
7. Худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийг жигд хосолсон байдлаар хөгжүүлэх.
8. Завханы брендийг хамтдаа бүтээх уриан дор нэгдэн ажиллаж, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод “Завханд үйлдвэрлэв” дэлгүүр ажиллуулах
9. Завханы Эрдэнэхайрхан сумын нутаг дахь Хярс нуурын загас, байгаль орчныг улсын хамгаалалтанд авах, байгаль хамгаалагчийг байнга ажиллуулах, загас агнуурын ажлыг зохих технологи, хяналтын дор явуулах арга хэмжээ авахыг БОНХЯ-д танилцуулж шийдвэрлэх
10. Барилгын материалын үйлдвэрлэлийн талаар нарийвчилсан суурь судалгаа хийх багийг бүрдүүлэн ажиллах.
11. Тэлмэний суурьшлын бүсэд үйлдвэр технолгийн парк байгуулах бэлтгэл хангаж эхлүүлэх

Үйлдвэрийн бүсийг төлөвлөхдөө дараахь хүчин зүйлсийг харгалзсан. Үүнд:

1. Монгол улсын батлагдсан үзэл баримтлал, баримтлах бодлого
2. Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого, онол практикийн бага хурлын зөвлөмж
3. Орон нутгийн санал
4. Хүн амын нутагшил суурьшил
5. Түүхий эдийн нөөц
6. Дэд бүтэц

Сумдын удирдлага, иргэдээс өгсөн саналыг нэгтгэж үзвэл Монгол улсын хэвтээ тэнхлэгийн мянганы зам дагуу байгаа сумдууд үйдвэрлэлийн бүстэй болох, бусад сумдууд хөнгөн, хүнсний үйлдвэртэй болох санал өгсөн байна.

Хүснэгт 115. Үйлдвэрийг хөгжүүлэх талаар өгсөн орон нутгийн санал

№	Санал өгсөн сум, мэргэжилтэнүүд	Үйлдвэрлэл
1	Алдархаан	<ul style="list-style-type: none"> <li>• Шохой, тоосго, гэрийн мод, монгол гутлын үйлдвэрлэл хөгжүүлэх</li> <li>• Махны үйлдвэр хөгжүүлэх</li> </ul>
2	Баянтэс	<ul style="list-style-type: none"> <li>• Жимс жимсгэнэ боловсруулах, хүнсний үйлдвэр, МАА-н гаралтай</li> </ul>




		түүхий эд цуглуулах төв, мод модон эдлэл боловсруулах үйлдвэр, махны үйлдвэр төлөвлөх • Сумын төвдөө үйлдвэрлэлийн бүстэй болох
3	Их-Уул	• Сумын 6 багийн онцлогт тохирсон үйлдвэрлэл хөгжүүлэх. (1-р баг арьс ширний үйлдвэр, 2 баг-хүнсний ногоо, 3 баг-цагааны идээний үйлдвэр, 4 баг-эсгий ,эсгий эдлэлийн үйлдвэр, 5 баг-жимс жимсний үйлдвэр, 6 баг-модон эдлэлийн үйлдвэр)
4	Отгон	• Мах, сүү, ноосны үйлдвэр баригдаж байгаа 50 хувийн гүйцэтгэлтэй • Нутгийн брэнд эзгий чихэр үйлдвэрлэх
5	Тосонцэнгэл	• Сумын төвийн зүүн урд хэсэгт үйлдвэрлэлийн бүс байгуулах
6	Түдэвтэй	• Мянганы зам дагуу үйлдвэрийн бүс гаргах /Баруун бүсийн МАА-н гаралтай бүтээгдэхүүнд анхан шатны боловсруулалт хийх/
7	Тэс	• Арц суурийн боомтыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах
8	Цагаанчулуут	• Жавцаг багийн орчим ингэний ферм байгуулах • Ингэний хоормогийн үйлдвэр байгуулах • ХАА-д суурилсан үйлдвэр байгуулах
9	Цэцэн-Уул	• Тэжээлийн фондыг ашиглалтанд оруулах
10	Шилүүстэй	• Хуурай сүүний үйлдвэр байгуулах
11	Эрдэнэхайрхан	• Хайгуулын 13 лицензийг хүчингүй болгох
12	Яруу	• Ноос, ноолуур, оёдол, модон эдлэлийн үйлдвэр хөгжүүлэх
13	Газрын даамлуудын өгсөн	• Яруу, Алдархаан суманд барилгын материалын үйлдвэр хөгжүүлэх • Аймгийн төвийн Өлзийт баг-үйлдвэрийн бүс

Завхан аймаг нь аялал жуулчлал, үйлдвэрлэл хөгжсөн мал аж ахуйн уламжлалт хэлбэрээ алдахгүй байх хөгжлийн чиглэл тавьж зорьж байгаа тул аж үйлдвэрийн салбарыг тэргүүлэх эгнээнд хөгжүүлэх бодлоготойгоор төлөвлөлтийн хувилбарыг боловсруулсан. Үйлдвэрийн төлөвлөлтийг дараахь үзүүлэлтүүдээр төлөвлөсөн. Үүнд:

1. Аймгийн үйлдвэрийн бүс нутаг /төрөлжүүлэн/
2. Бүс нутагт төлөвлөсөн үйлдвэрлэл технологийн парк, үйлдвэрийн газрууд

Мөн аймгийн бүлэг суурингийн тогтолцоотой уялдуулан үйлдвэрлэлийг төрөлжүүлсэн бүс болгон төлөвлөсөн. Үүнд:

- Тэжээл үйлдвэрлэлийн бүс нутаг - Тэс, Асгат
- Хөдөө аж ахуйн үйлдвэр хөгжүүлэх бүс-Баянтэс, Алдархаан, Тэлмэн
- Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр хөгжүүлэх бүс нутаг –Тосонцэнгэл
- Хөнгөн үйлдвэрийн бүс нутаг-Улиастай, Отгон, Түдэвтэй
- Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх бүс нутаг –Баянхайрхан, Нөмрөг, Яруу, Идэр, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй, Их-Уул
- Үйлдвэр, уурхайн хосолмол бүс нутаг-Дөрвөлжин, Ургамал, Завханмандал, Сантмаргац, Сонгино




Зураг 179. Үйлдвэрийн бүсчлэлийн төлөвлөлт

Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь 16 жилийн хэрэгжих үйл явцыг төлөвлөх тул үйлдвэрийн бүсэд төлөвлөгдөх үйлдвэрийн газруудыг бүлэг суурингийн тогтолцоо, хатуу хучилттай замын хөгжлийг түшиглэн дараахь байдлаар төлөвлөсөн. Нөгөөтэйгүүр үйлдвэрийн газрыг байгуулахад хөрөнгө оруулалт ихээр шаардагдах тул тэргүүн эгнээнд хөгжүүлэх үйлдвэрийг төлөвлөсөн. Үүнд:

Хүснэгт 116. Аймгийн хэмжээнд төлөвлөсөн үйлдвэрүүд

Бүлэг суурингийн төвийн эрэмбэ	Байршил, сумаар	Төлөвлөж буй үйлдвэр	Төлөвлөлтийн хугацаа			Үндэслэсэн баримт бичиг, санал
			Ойрын 2022 он	Дундын 2028 он	Хэтийн 2033 он	
Бүсийн тулгуур төв	Улиастай	Гурилын үйлдвэр	+			Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого
		Махны үйлдвэр	+			
		Сармисны ханд бэлтгэх үйлдвэр	+			
		Хөрсний бордооны үйлдвэр			+	Орон нутгийн санал
		Хог дахин боловсруулах үйлдвэр		+	+	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
Бүлэг суурингийн төв	Асгат	Тэжээлийн үйлдвэр		+		Түүхий эдийн нөөцөд түшиглэн хөгжүүлэх
Орон нутгийн тулгуур төв	Тэс	Тэжээлийн үйлдвэр	+			Түүхий эдийн нөөцөд түшиглэн хөгжүүлэх
		Эдийн засгийн чөлөөт бүс			+	Арц суурийн боомтыг хөгжүүлэх
Бүлэг суурингийн төв	Баянтэс	ХАА-н үйлдвэрлэл технологийн парк			+ /улсын хөрөнгө оруулалт /	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого
		Барилгын	+			Завхан аймгийн

		материалын үйлдвэр				хөгжлийн цогц бодлого
		Бордооны үйлдвэр	+			Орон нутгийн санал
Орон нутгийн тулгуур төв	Завханмандал	Махны үйлдвэр			+	Түүхий эдийн нөөцөд түшиглэн, бодлоготойгоор хөгжүүлэх
		МАН-н гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр		+		
Орон нутгийн тулгуур төв	Тосонцэнгэл	Махны үйлдвэр	+			Хуучин байсан махны үйлдвэрийг сэргээх
		Мод, модон эдлэлийн үйлдвэр		+		Түүхий эдийн нөөцөд түшиглэн хөгжүүлэх
		Жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэр	+			Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого
		Барилгын материалын үйлдвэр	+			Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого
Орон нутгийн тулгуур төв	Түдэвтэй	Махны үйлдвэр			+	Түүхий эдийн нөөцөд түшиглэн, бодлоготойгоор хөгжүүлэх
		МАН-н гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр		+		
		Барилгын материалын үйлдвэр	+			Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого
Бүлэг суурингийн төв	Сантмаргац	Давс, эрдэс тэжээлийн үйлдвэр	+			Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого
		Ноос боловсруулах үйлдвэр			+	Түүхий эдийн нөөцөд түшиглэн, бодлоготойгоор хөгжүүлэх
Бүлэг суурингийн төв	Тэлмэн	ХАА-н үйлдвэрлэл технологийн парк	+/улсын хөрөнгө оруулалт /			Төрөөс ажүйлдвэрийн талаар баримтлах бодлого
Бүлэг суурингийн төв	Алдархаан	ХАА-н үйлдвэрлэл технологийн парк		+/улсын хөрөнгө оруулалт /		Төрөөс ажүйлдвэрийн талаар баримтлах бодлого
		Барилгын материалын үйлдвэр			+	Орон нутгийн санал
Бүлэг суурингийн төв	Отгон	Махны үйлдвэр	+			Одоо баригдаж байгаа /гүйцэтгэл 50 хувь/
		Ноос боловсруулах үйлдвэр	+			
		Сүүний үйлдвэр	+			



Зураг 180. Завхан аймгийн үйлдвэрийн газрын төлөвлөлт

#### 4.4.5 Үйлдвэр, уурхайн бүсийн хөрөнгө оруулалтын тооцоо

Төлөвлөлтийн хугацаанд шинээр 3 ХАА-н Үйлдвэрлэл технологийн парк, 10 боловсруулах болон хүнсний үйлдвэр байгуулахаар төлөвлөсөн бөгөөд төлөвлөлийн ойрын хугацаанд 1,2 их наяд төг, дундын хугацаанд 495,1 тэрбум төг, хэтийн хугацаанд 495,1 тэрбум төг шаардагдахаар байна.

Хүснэгт 117. Төлөвлөж буй үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтын тооцоо

№	Төлөвлөж буй үйлдвэрийн газрууд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж хөрөнгө оруулалтын дүн, сая.төг	Нийт хөрөнгө оруулалтын дүн, тэрбум.төг	Хөрөнгө оруулалтын үе шат			Байнгын ажлын байрны тоо
						Ойрын	Дунд	Хэтийн	
1	Гурилын үйлдвэр	багц	1	1000.0	1.0	1.0	0.0	0.0	25
2	Махны үйлдвэр	багц	5	1300.0	6.5	3.9	0.0	2.6	100
3	Сармисны ханд бэлтгэх үйлдвэр	багц	1	350.0	0.4	0.4	0.0	0.0	15
4	ХААҮТПарк	багц	2	490000.0	980.0	0.0	490.0	490.0	300
5	ХААҮТПарк-1	багц	1	1225000.0	1225.0	1225.0	0.0	0.0	300
6	Малын тэжээлийн үйлдвэр	багц	3	1200.0	3.6	2.376	1.224	0.000	45
7	Барилгын материалын үйлдвэр	багц	4	500.0	2.0	1.5	0.0	0.5	60
8	Түүхий эд боловсруулах	багц	4	800.0	3.2	0.8	1.6	0.8	80

	үйлдвэр								
9	Сүү боловсруулах үйлдвэр	багц	1	800.0	0.8	0.0	0.0	0.8	20
10	Жимс, жимсгэнэ боловсруулах	багц	1	350.0	0.4	0.4	0.0	0.0	15
11	Мод, модон эдлэлийн үйлдвэр	багц	1	500.0	0.5	0.0	0.5	0.0	15
12	Бордооны үйлдвэр (ГТ)	багц	2	350.0	0.7	0.4	0.0	0.4	30
13	Хог хаягдал дахин боловсруулах	багц	1	1800.0	1.8	0.0	1.8	0.0	25
<b>Аймгийн нийт</b>			<b>27</b>		<b>2225,8</b>	<b>1235,6</b>	<b>495,1</b>	<b>495,1</b>	<b>1030</b>

## 4.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮСИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### 4.5.1 Аялал жуулчлалын салбарын одоогийн байдал

Дэлхийн улс орнууд даяарчилагдахын хэрээр түүнийг даган аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж байна. Манай улс мөн адил хөгжлийг даган урагшилсаар байгаа билээ. Манай улсын аялал жуулчлалын салбарын хөгжил нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр илүү хурдацтай болж ирсэн. Гадаад болон дотоодын судлаачид Монгол улс нь олон улсын тавцанд өрсөлдөхүйц үйлдвэрлэлийн таван салбарыг хөгжүүлэх боломжтой гэж үзсэн байдаг. Эдгээр таван салбарын нэг нь аялал жуулчлал юм. Аялал жуулчлалын салбар нь үл шавхагдах нөөцүүдийг ашиглан үлэмж хэмжээний орлого олох боломжтой. Тиймээс манай улс “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-доо эдийн засгийн үндсэн тулгуур, орлогын томоохон эх сурвалж нь аялал жуулчлал байх болно гэж заажээ.

“Монгол Улсын аялал жуулчлалын тухай” хуулийн 3.1.3–т аялал жуулчлалын бүс нутаг гэж Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тохирсон байгаль, түүх, соёлын нөөц бүхий газар нутаг байна гэж заасан байдаг. Энэ дагуу Монгол улсын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үндсэн зургаан бүсийг төлөвлөсөн байна. Үүнд:

- Цэнгэг устай нуур, байгалийн үзэсгэлэн бүхий Хөвсгөлийн бүс
- Түүх соёлын үнэт дурсгалууд бүхий Орхон голын бүс
- Эх газрын өвөрмөц, онгон байгаль, палеонтологийн олдвор, ховор ан амьтан бүхий Говийн бүс
- Чингис хааны түүхтэй холбоотой дурсгалт газрууд бүхий Хэнтийн бүс
- Олон ястны зан заншил, соёлын онцлог бүхий өндөр уулын бүсийн экосистемт Алтайн бүс
- Улаанбаатар хот орчмын бүс зэрэг болно.



Зураг 181. Монгол орны аялал жуулчлалын бүс нутгийн одоогийн байдлын зураг

Эх сурвалж. Аялал жуулчлалын салбарын Нийслэлийн нийгэм, соёлд үзүүлэх нөлөөллийн судалгааны тайлан, 2015 он

Монгол улсад бодлогоор хөгжүүлэх аялал жуулчлалын бүс нутагт Завхан аймаг ороогүй байна.

Монгол улсын баруун бүсийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд гарсан “Аялал жуулчлалыг 2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд Завхан аймагт улсын хэмжээний аялалын 3 үндсэн маршрутыг гарган, Отгонтэнгэр, Булнай, Хангайн нурууны өндөр уулс, Их монголын элсэн манхан, Завхан, Идэр, Тэсийн түргэн урсгалт голууд, Отгон, Тэлмэн, Түдэвтэй сумын үзэсгэлэнт газрууд болон нуруудыг түшиглэн аялал жуулчлалын бааз, отгууд байгуулах, Улиастай хотод баруун бүсийн соёл урлагийн болон спортын төв цогцолборуудыг барих гэсэн 3 үндсэн ажлыг төлөвлөсөн байна.

**Маршрут-1:** Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр (4021м) уул, Их Монголын элсэн манхан, тал хээрийн бүсийг багтаасан аяллын маршрут-650 км

**Аялал:**

- Улиастай хотоос Богдын гол Мөнгөт хясаа, Богдын голын хүрхрээ, Цагаан нуур, Даян уулын үдлэх цэгт амарна. Туулах зам 50км.
- Даян уулаас Отгонтэнгэр уул харах, вансэмбэрүү цэцэг үзэх, Долоогийн даваа, Ширээгийн голын үдлэх цэг, Хөндлөнгийн даваа, Отгон сум, Буянт багаар дайран Отгонтэнгэр уулын өвөрт ирнэ. 160км
- Цагаан чулуут сумын Бурханы цогцолбор, Жавцаг баг Завхан голоор гаран Эрээн нуурт ирнэ. Нийт 150км.
- Эрээн нуур Завхан голын Далтын гарам, Ханийн худагийн хясаа, Ямаан усны үдэх цэг, Алдархаан сум, Улиастай хотод ирнэ. 140км.

**Нэмэлт маршрут:**

- Отгонтэнгэрээс Отгон сум, Шилүүстэйн дааган дэлийн буган чулуун хөшөөт цогцолборын үдлэх цэг, Шилүүстэй сумын төв. Нийт 140км.

- Шилүүстэй сум, Мандалт нуур, Нарбанчин хийдийн туурь, Гэгээн нуур, Завхан голын усан цахилгаан станц. Нийт 80км.
- Тайшир сум, Харандаа хад Хүнхэрийн амралт. Нийт 50км
- Хүнхэрийн амралт Жаргалан сум, Эрээн нуур жуулчны бааз. Нийт 80км.

**Маршрут-2** Байгалийн өвөрмөц тогтоц бүхийн Хангай, Говь хосолсон тусгай сонирхлын аялалыг багтаасан маршрут-665 км


*Аялал:*

- Завхан аймгийн Улиастай хотоос эхэлнэ.
- Улиастай сумаас Их Монгол жуулчны бааз, Хатавчийн амны хүн чулуун хөшөө, Загастайн даваа, Идэр сумын төв Ногоон нуур дахь Маргад ембүү жуулчны бааз. Туулах зам 95 км.
- Ногоон нуураас Идэр сумын төв, Тун, Жаргалангийн гол, Бөхөн шарын даваа Тэгшийн голын үдлэх цэг. Туулах зам 50км.
- Тэгшийн голоос Баяжихын даваа, Хангайн нурууны Марз уул, Хажуулын рашаан сувиллын газар ирнэ. Туулах зам 80км.
- Хажуулын голоо уруудан байгалийн үзэсгэлэнт газраар аялан Тосонцэнгэл сумын төвд ирнэ. Туулах зам 80 км.
- Тосонцэнгэл сумаас Мэргэний давааны үдлэх цэг дээр буун цааш Долоон товгор Элсэн манхан Ангирт нуурын хөвөөнд орших Замбага жуулчны баазад хүрнэ. Туулах зам 80км.
- Замбага жуулчны баазаас Нарийний даваа, Дахтын даваа, Тээлийн гол уруудан Хар нуур жуулчны баазад ирнэ. Мөн Улаагчны голын үдлэх цэг, Гол мод, Тээлийн гол уруудан Хар нуурт ирж болно. Туулах зам 120км.
- Хар нуураас Сэнжит цохио, Их, Бага Хатавчийн ам, Мухартын үдлэх цэгт очно. Туулах зам 50км
- Мухартаас Сээрийн дөрөлжөөр давж, Донойн хөндий, Яруугийн хүрээг үзэн Улиастайд ирнэ. Туулах зам 110км.

**Маршрут-3:** Тал хээр, говийн бүс нутгийн өвөрмөц, тогтоцтой нутгаар аялах-350 км

*Аялал:*

- Улиастай хотоос Яруугийн хүрээ, Алагийн даваа, Ханын худаг, Их хайрхан үдлэх цэгт амарна. 80км
- Их хайрханаас Эрдэнэ- Хайрхан сум мухартын элсэн манхан үдлэх цэгт амарна. 100км
- Мухартаас Сэнжит хадны үдлэх цэг, Бургастайгаар даван Хар нуур жуулчны баазад ирнэ. 50км (Хар нуурын орчмын аялалын маршрутаар аялаж болно)
- Хар нуураас Тээлийн гол, Намын давааны үдлэх цэг Дэнхэн чулуугаар дайран Улиастай хотод ирнэ. 120км



Зураг 182. Завхан аймгийн аялал жуулчлалын маршрут

Аймгийн нутаг дэвсгэрт жилд дунджаар 40 мянга гаруй дотоод, гадаадын жуулчид аялаж байна гэсэн судалгаа байдаг.

Аялал жуулчлалын хөгжилд дэд бүтцийн хөгжил голлох байр суурийг эзлэх бөгөөд одоогоор аймагт ирж буй жуулчид 3 чиглэлээр ирж байгаа судалгаа байна.

- Хүннү эйр 7 хоногт 2 удаа Улаанбаатар-Улиастай, Улиастай-Улаанбаатар чиглэлийн нислэг хийж байна.
- Нийтийн зорчигч тээврийн автобус нэгдсэн графикаар өдөрт 2 удаа явж байна.
- Хувийн машинаар явж байна.

Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын 14 бааз, 1 хүүхдийн зуслан үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа ч хүчин чадлын хувьд төдийлэн хөгжөөгүй байна.

Хүснэгт 118. Аялал жуулчлалын бааз, амралт сувилал, хүүхдийн зуслангийн судалгаа

№	Жуулчны бааз	Байршил	Талбай, га	Хүчин чадал	Үндсэн үйлчилгээ
1	Замбага	Тэлмэн сум, Ангир нуурын эрэг	2,34	25 ор	Нууранд загасчлах, завиар зугаалах
2	Их монгол	Алдархаан сумын Баруун салааны эхэнд ой модны захад	1,53	70-80 ор	Отгонтэнгэр хайрханы орчинтой танилцах
3	Маргад ембүү	Идэр сум, Идэр голын эрэг дээр.	0,5	40- 50 ор	Тарвагатайн нурууны байгалын цогцолборт газраар аялах
4	Ногоон тохой	Улиастай сумаас 10 км Солооний аманд байрладаг.	1,75	70 ор	Байгальд амрах
5	Оргих	Улиастай хот, Товцог уулын ард	1,75	45-55 ор	Монголчуудын эртний нүүдлийн зан үйлтэй



					танилцах
6	Отгон буянт хангай	Отгон сум, Отгонтэнгэр уулын бэлд	2,3	45-55 ор	Отгонтэнгэр хайрханы орчинтой танилцах, уулын аялал хийх
7	Хар нуур	Эрдэнэхайрхан сум, Улаагчны хар нуурын эрэг дээр	4,5	60-80 ор	Хар нууранд загасчлах, завиар зугаалах
8	Баян цавдан	Сонгино сум, Ногоон нуур	5		Нууранд загасчлах, байгальд аялах
9	Бар үр	Тосонцэнгэл сум, Хожуулын гол	2,21		Байгалийн үзэсгэлэнт газраар аялах
10	Хожуулын гол	Тосонцэнгэл сум, Дугуй модны доор	4,3	60 ор	Байгалийн үзэсгэлэнт газраар аялах
11	Их тэнгэрийн хүрээ	Эрдэнэхайрхан сум, Хар нуурын эрэг	10,0	56 ор	Нууранд загасчлах, морь, тэмээгээр аялах
12	Номин	Алдархаан сум, Чавганцын хонхор			Байгалийн үзэсгэлэнт газраар аялах
13	Таван булаг	Алдархаан сум, Зуслангийн ам			Байгалийн үзэсгэлэнт газраар аялах
14	Мөстийн ам	Алдархаан сум, Мөстийн ам			Байгалийн үзэсгэлэнт газраар аялах
15	Даян хүүхдийн зуслан	Алдархаан сум, Богдын гол			Хүүхдүүд амраах
Нийт			36,18		





Зураг 183. Аймгийн аялал жуулчлалын бааз, рашаан сувилалын газрын байршил

Аймгийн хэмжээнд олон улсын рашааны үнэлэмж хангахуйц 20 гаруй орд байгаагаас 18 рашааныг шинжилж 6 халуун, 12 хүйтэн рашаан байгааг тогтоосон байдаг. Рашааны ордыг түшиглэсэн орчин үеийн тохилог рашаан сувилалын газрууд цөөхөн байдаг бөгөөд зөвхөн монгол уламжлалт маягаар рашааныг хэрэглэж байна. Одоогоор сувилалын үйл ажиллагаа эрхэлж байгаа 5 рашаан сувилал байна. Эдгээр нь Их-Уул, Нөмрөг, Алдархаан, Тосонцэнгэл сумдад байрлах ба 80-210 хүн хүлээн авах хүчин чадалтай болно. Аймгийн нутаг дэвсгэрт 14 рашаан байгаагаас 28,5 хувь нь амралтын газартай болсон байна.


Хүснэгт 119. Завхан аймгийн рашаан сувилалын газрын судалгаа

№	Рашаан сувилал	Байршил	Талбай, га	Хүчин чадал, хүн	Эмчилгээний ач холбогдол
1	Зартын рашаан амралт	Их-Уул сум, Зарт багийн Халуун усны ам	1,5	100-150	Таван цул, хий шар, бөөр, зүрх, ходоод, элэг цөс, мэдрэл, үе мөч (+47), ядаргаа (+25), хоолой, нүд, тархи, эмэгтэйчүүдийн өвчинд тустай рашаануудтай. Харшил гоо сайханд хэрэглэдэг халуун рашаан бий. Заман ба шавар эмчилгээ хийдэг. Мөн үе мөч болон ядаргаанд ордог нууртай.
2	Баянзүрхийн рашаан сувилал	Нөмрөг сум, Баянзүрх уулын ар бэл	1,2	120	Элэг цөс, ходоод гэдэсний аргаг өвчнүүд болон үе мөч, уушигны бүх төрлийн өвчинд сайн.
3	Отгонтэнгэрийн	Алдархаан	2,3	150-210	Тулгуур хөдөлгөөний эрхтэний

	рашаан сувилал	сум, бага Отгонтэнгэр уулын ар хормойд			өвчин, зүрх судас, цусны эргэлтний дутмагшил, 1 үеэс хэтрээгүй үед, зах мэдрэлийн системийн өвчин, судасны өвчин, арьсны өвчин, (хайрст үлдийн эдгэрэлт, хязгаарлагдмал нейродермит, намарс, арьсны загатнаат өвчнүүд, харшлын гаралтай арьсны үрэвсэлт өвчний хурц биш үе), гуурсан хоолойн архаг үрэвсэл, дунд чихний архаг үрэвсэлд сайн.
4	Улаан хаалгын рашаан	Алдархаан сум, Хаалгын эм	2,1	80-100	Үе мөч, бөөр, сав дотор, элэг цөс, ходоодны өвчинд сайн
5	Хожуулын эхэн рашаан амралт	Тосонцэнгэл сум	1,6		
Нийт			8,7		

#### 4.5.2 Аялал жуулчлалын нөөц

Судалгаагаар Монголд аялаж буй жуулчдын 70 орчим хувь нь үзэсгэлэнт байгалийг, 50 орчим хувь нь нүүдлийн соёл, уламжлалт ахуйг, 25 орчим хувь нь Чингэс хааны түүх, 15 орчим хувь нь адал явдалт аялалыг сонирхдог гэж гарсан байна. Энэ судалгааны үр дүнгээс үндэслээд аймгийн нутаг дэвсгэрт байгалийн дурсгал, түүх соёлын дурсгал бүхий аялал жуулчлалын нөөцийг судалгааг нэгтгэсэн.



Зураг 184. Завхан аймгийн байгаль, түүх соёлын дурсгалт газар

Хүснэгт 120. Завхан аймгийн түүх соёлын дурсгалт газрын судалгаа

	Сумын нэр	Хадны зураг, бичгийн дурсгал	Хиргисүүр, булш оршуулгын дурсгал	Тахилын онгон	Тахилын овоо	Суурьшлын ул мер бүхий газар	Эртний хотын туурь	Сүм хийдийн туурь	Агуй, оромж	Түүхэн дурсгалт байшин, хэрмэн зам	Хөшөө дурсгал	Байгалийн үзэсгэлэнт газар	Суварга	Музей	Нутгийн тахилгат уул	Төрийн тахилгат уул	Сумын нийт
1	Улиастай	1	3				1				3			1			9
2	Алдархаан	7	24	8	1			1		2	13	6			1		63
3	Асгат	3	3														6
4	Баянтэс	2	12	4				2			3	5					28
5	Баянхайрхан	9	15	11	2			1		1	11	1			1		52
6	Дөрвөлжин	9	7	8	2	1					9	1					37
7	Завханмандал	3	5								3						11
8	Идэр	2	4	3	2			2			3	4					20
9	Их-Уул	2	10	1				2			6	2	1				24
10	Нөмрөг	2	10	8	1			1			8	2		1			33
11	Отгон	2	30	7	1						8	2				1	51
12	Сантмаргац	2	3	3							2	2					12
13	Сонгино	4	6	5	1		1	1			9	1					28
14	Тосонцэнгэл	4	12	3	2			4			1	1					27
15	Түдэвтэй	3	25	4	2			1			8	2	1				46
16	Тэлмэн	1	9	1		1		2			7	2		1			24
17	Тэс	10	23	2	2		1	2	1		4	1					46
18	Ургамал	10	11	1							3	1					26
19	Цагаанхайрхан	1	18			1		1			6						27
20	Цагаанчулуут	8	15	7							17						47
21	Цэцэн-Уул		11	2				1			7			1			22
22	Шилүүстэй	5	24	2	7			2			17	1	1				59
23	Эрдэнэхайрхан	2	21	4							5	3					35
24	Яруу	1	13	4	2	1					18	2					41
	<b>Аймгийн нийт</b>	<b>93</b>	<b>314</b>	<b>88</b>	<b>25</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>23</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>171</b>	<b>39</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>774</b>

## Аялал жуулчлалын байгалийн нөөц:



**Отгонтэнгэр хайрхан:** Монголчууд энэ хайрханаа эртнээс тахиж шүтэж ирсэн 1995 онд төрийн тахилгатай болж 4 жилд нэг удаа тахидаг уламжлал тогтсон байна. Хайрхан нь хангай нурууны ноён оргил дтд- 4021 м өргөдсөн Эргэн тойрон битүү ой хөвч, ширүүн урсаглт, нуураар элбэг ойр орчмын уулсууд байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрууд, ан амьтан биосфер экосистемийн бүрдэл маш сайн бүрдсэн, ховор ургамал амьтан элбэг, олонд алдаршсан рашаан сувилал, хойд

талаас эх авч урсах Богдын голын баруун эрэгт байдаг. Завхан аймгийн Отгон, Цагаан хайрхан, Алдархаан, сумдын нутгийн заагт оршдог Аймгийн төвөөс Отгоны амралт хүртэл 78км, Отгон сумаас Хайрханы өвөр Бадархундага нуур хүртэл 65 км байдаг байна.

**Даян хайрхан:** Отгон тэнгэрийн баруун талд харуул мэт сүндэрлэх Их даян, Бага даян гэсэн 2500 метр өндөртэй 2 сүрлэг хайрхан бий. Даянгийн 2 талд хөх, бага гэсэн 2 нуур байх ба энэ ууланд Отгонтэнгэрийн бүсийн ховор ургамал болох Вансэмбэрүү, хонин арц, алтан гагнуур, жамьянмядаг зэрэг эмийн бусад ховор ургамалтай. Оройн дээрээ хэсэг хавтгай газартай ба голд нь тайхар чулуу байдаг..



**Цагаан нуур:** Даян хайрханы баруун бэлд хөх нуураас холгүй 2230 метр өндөрт оршдог. Морены хурдсанд хөөгдөж тогтсон Цэнгэг устай 3,1 км. Кв талбайтай 3,6 км урт, өргөн гүн нь 28 метр, Их бага даян хайрханд тулж хойг булан тохой үүсэх тул эргийн хэрчигдэл ихтэй, урт нь 12 км, өмнөөс нь нуурын хоолой хэмээх

гол хэдэн булгийн хамт цутгадаг.

**Ногоон нуур:** Овоот уулын бэл. Тусгалтын ар бэлээр урссан Идэр голын зүүн талд байрлаж тогтсон нуур. Ногоон нуур гэсэн нэрний учир нь Овоотын өвөрт байгаа эрдэнийн туяа энэ хуурт туссанаас нуурын ус ногоон харагддаг гэсэн домог яриа байдаг. Нуурын ус нь аль ч талын эргээсээ



дотогш 5-8 метр орчмын зайд хар харагдаад үүнээс цааш ногоон өнгөтэй харагддаг байна. Энэ нь эргэн тойрны ногоон ой модны тусгал байж болох юм. Яг хажууд нь очиход нуурын ус нь маш тунгалаг бөгөөд дотор нь явж буй загас тод харагддаг байна. Нуурын эргээс ус байнга шүүрч усны түвшингөө хадгалдаг ба нуураас жижиг цутгэл урсан гарч голд нийлдэг байна.

**Улаагчны хар нуур:** Эрдэнэ-хайрхан сумын төвөөс зүүн хойш 80 км, аймгийн төвөөс



110 км, оршдог. Хойд талаараа элсэн манхан, элсэн шанаагаар хүрээлэгдсэн, урд талаараа эрэг орчмын шанаанууд зэгэстэй жаахан нуур Товхошын сүрлэг уулаар хүрээлэгдсэн байдаг. Нуурын гүн нь 48 метр, уртаашаа 30 орчим км, өргөн нь 5-10 км сунаж тогтсон нуур. Уг нууранд Омуй, Фельд гэсэн 2 төрлийн загас үрждэг бөгөөд нуурын голд ДТД-2600 метр, өргөгдсөн Их бага 2 Авгаш аралтай байдаг.

Энд 13 төрлийн нүүдлийн шувууд ирдэг. Мөн нуурын дээгүүр шунх хэмээх цэцэг ургаж гарч ирсэн нь үзэсгэлэнтэй харагддаг.

**Тэлмэн нуур** нь Завхан аймагийн Тэлмэн суманд оршдог давстай нуур. Нууранд гурван арал байх ба нүүдлийн шувуудын цугларах цэг болдог. Уг нуурын урт нь 26, өргөн нь 12, гүн нь 27 км, нуур дунд торойх гурван авгаш аралтайгаа 194 км талбайг эзлэх агаад далайн төвшнөөс 1700 гаруй метр өндөрт оршдог байна. Нуурын үндсэн тэжээл нь хур бороо, ул хөрсний урсац боловч гадаргын урсац багагүй ач холбогдолтой.



Энэ нуур 3940 км<sup>2</sup> талбайгаас усжих боловч Хангайн салбар уулсаас хэд хэд горхи нуурын хотгоруу урсдагаас зөвхөн Хоолойн гол хэмээх байнгын урсацтай жижиг горхи л цутгана. Усны хагалбар уулсын хамгийн өндөр нь Төв Азийн гадагш гарах урсгалгүй гол мөрөн нууруудын ай сав, Умард мөсөн далайн ай сав хоёрын зааг болох Булнайн нуруунаа орших бөгөөд 2433 м өндөрт хүрнэ. Нутаг усныхан нь болон Хотгойд ястнууд "Тэлмэн ээж", "Нуур ногоон Тэлмэн" гэлцдэг.



**Баян нуур** нь Завхан аймгийн Сантмаргац сумын нутаг дэвсгэр дээр байрлах цэнгэг уст нуур.

Нуурын өмнөд эрэг нь элсэрхэг тул илүүдэл ус үүгээр шүүгдэж, үүний ачаар цэнгэг устай байдаг ажээ. Баян нуур нь хэдийгээр бага талбайтай боловч Монголын цэнгэг уст нууруудаас эзлэхүүнээрээ 6-д жагсдаг. Нуурын тэн хагас нь 20 м гүнтэй бөгөөд гуравны нэг орчим нь 30 м гүнтэй. Найман

хувь нь 40 м гүнтэй. Тус нуур нь өвөл хөлдөх бөгөөд 1.5 м зузаан мөсөн бүрхүүл

тогтдог. Зуны улиралд нуурын гадаргын температур 17 - 25°C, 20-25 метрийн гүнд 8°C орчим байна.



**Бөмбөрцөг чулуу:** Эрдэнэхайрхан сумаас хойд зүгт 135км, Аймгийн төвөөс 138кмт уулын энгэрт байдаг гарал үүсэл нь элэгдэл, өгөршилөөр үүссэн бөөрөнхий боржин чулуу юм.

**Хүнгүйн гол:** Бор хярын элсэн манхнаас эх авч Эрдэнэхайрхан, Завханмандал, Ургамал сум, Увс аймгийн Завхан сумын нутгаар урсч айраг нуурт цутгадаг гол. Урт нь 200км, ай савын талбай нь 21,6 мянган км/кв. Усны жилийн дундаж зарцуулалт 2,1м/сек, 3м. Уг гол нь эргийн дагуурх хүнхээл, элсэн толгодууд, хүнгүйн, түнгээ зэрэг байгалийн өвөрмөц тогтоцыг бүрдүүлсэн газрууд олонтой Завхан аймгийн говийн бүсийн сумдуудын тэжээгдмэл гол юм.



**Мухартын гол:** Уг гол нь Эрдэнэхайрхан сумын төвөөс зүүн тийш Бор хярын элсний өмнө талд дтд-450 метр өдөр элсэн манханаас эх авч урсдаг, хөвөөгөөрөө бургасан шугуйтай, гоньд, дэгд, улаалзгана, нохойн хошуу зэрэг жимс жимсгэнтэй байгалийн өвөрмөц тогтоц бүхий цогцолбор газар.

**Сэнжит цохио:** Сумын төвөөс зүүн хойд зүгт оршдог. ДТД-2773 метр өндөрт өргөгдсөн байна. Энэ газар элсэн манхат бүхий уулын оройд 10 метр өндөр, 6-8 метр өргөн, ойр орчмын үзэсгэлэнт газар элбэгтэй байдаг. Мөн энд мосстой тээврийн хэрэгсэлээр гарч болох ба цааш давж 30 км Хар нуурын үзэсгэлэнт газар руу очдог.





**Дэнхэн чулуу:** Алдархаан сумын нутагт, сумаас 18 км, аймгийн төвөөс 18 км зайд орших Дэнхэн чулуу нь багйалийн хачин өвөрмөц тогтоц бүхий боржин чулуун хад юм.

**Монгол элс:** Завхан аймгийн Алдархаан сумын нутагт орших 600км үргэлжилсэн 3000 орчим ам дөрвөлжин км талбай эзлэн орших Монгол Элс нь манай улсын хамгийн том элсэн

тарамцаг юм. Элсэн хуримтлалд бөөрөг, хонхорт бөөрөг, манханжсан хонхорт бөөрөг манхан хэлхээ, цац суварган оргил бүхий өндөр манхан, бүрхэвч зэрэг хоорондоо ялгарах хотгор гүдгэрийн бүхий л хэлбэрүүд байдаг бөгөөд Монгол элсний хойд захаар Завхан гол эмжин урсахын хамт Эрээн, Ажиг, Сангийн далай, Гүн зэрэг олон нуур тогтсон байдаг нь байгалийн үзэсгэлэнт байдал эко системийн өвөрмөц хослолыг бий болгожээ. Монгол элсэнд элсний бэлчээрийн үндсэн ургамал болох хар, цагаан суль нь хур бороо, ган гачигаас үл хамааран зөвхөн хөрсний чийгээр ургадаг онцлогтой. Иймээс ч нутгийн ард иргэд Монгол элсийг ган зудын аюулаас хамгаалдаг хэмээн их шүтдэг.



**Бор хярын элс:** Завхан аймгийн Ургамал суманд орших бор хярын элс нь Баруун Зүүн Монгол хэмээх хоёр уулын өмнөхөн байдаг бөгөөд Завхан аймгийн Ургамал сумын араар зүүн тийш үргэлжлэн, Хунгийн голыг хөвөөлдөг. Тэндээс Эрдэнэ хайрхан сумын хойгуур өгсөж, Яруу нутаг хүртэл тэлж тариан шаргал үтрэм шиг санагдах 300 орчим км урт үргэлжилнэ. Эл

манхан элсийг хөндлөн туулах Монгол хотгор. Олгой, Цэцэний сүв гэж бий. Элсэн манхан далай болсон энэ алтан шижир элсийг ирээдүйн Монголын барагдашгүй алтан чулууд гэж нутгийн олон хэлцдэг.

**Цайз хэрмийн туурь:** Завхан аймгийн Тэс сумын Дооно багын нутаг сумаас баруун хойш 5км зайд уулын оройд байдаг түүх соёлын том өв болсон газар, 14-17-р зууны барилга, архитектурын





ховор дурсгал , цэрэг шашин зориулалттай ашиглагдаж байсан ул мөртэй. Харуулын цамхаг ч болж байсан ,уулын доод бэл хийдийн туурь, гэрийн буурь байдаг. Хийдээр ашиглагдахдаа сүмийн оройд 2 дугана байсан, урд үзүүрт 1 жижиг суврагатай, хойд талд нь арай том суврагатай дуган байсан байна. Нутгийн ард Сүмт толгой гэж нэрлэдэг. Сүмт толгойн доод бэлд 2гэрийн буурь байдаг.

**Дуут чулуу:** Завхан аймгийн Тэс суманд байдаг. Сумын төвөөс 3үүн хойно 23кмт байдаг. Уг дурсгал нь одоо байгаа төрхөөрөө дуут буюу дэрэн чулуу гэж нэрлэдэг. Учир нь 3ш жижиг чулуун дээр хар хөх чулууг хэвтээгээр нь байрлуулсан , чулууны хэмжээ нь урт нь 85см, өргөн нь 55см, зузаан нь 32см ба чулууны дээд хэсэгт 23 хонхор цэгэн тойргон бүслүүртэй, хоёр хажуу талд яг ижил хэмжээтэй дугуй хэлбэрийн хонхойлгож



дүрсэлсэн нь МЭӨ 3000 жилийн үеийн хүрлийн үеийн буган чулуун . Уг чулууны нэг онцлог нь мод чулуугаар цохиход яг хөндий төмөр шиг дуугардаг байна.



**Зүрхэн чулуу:** Түдэвтэй сумын Богдын гол багийн нутаг Даян уулын оройн дэвсгэр хэсэгт үхэр чулууны дунд нэгэн том хадан дээр зүрх хэлбэрийн хонхорхой үүсч ус тогтсоныг нутгийн иргэд зүрхэн чулуу хэмээн нэрлэдэг. Ус нь цэвэр тунгалаг ариун учир очсон хүн бүхэн эрүүл энхийг бэлэгдэн амсах нь олонтой. Зүрхэн хонхорын дээхэн талд очир алмазан дүрстэй шигтгээн жижиг чулуу тогтсон нь уран дархны гараар бүтсэн гэлтэй харагддаг. Зүрхэн чулуу нь дархан цаазат газрын бүсэд багтдаг.

**Аялал жуулчлалын түүх соёлын дурсгал:**



**Донойн цогцолбор:** Завхан аймгийн Алдархаан сумбнд байрладаг. Хөшөөний дээд хэсэгт морины бурхан Дамдин янсан бурхны шүтээн 3 морины толгой энх цаг дөрвөн зүгийг билэгдсэн дөрвөн тулгууртай. Монгол гэрийн нэгэн адил хорол тооныг хөшөөний дээд хэсэгт байрлуулж өгсөн нь ихээхэн билэгдэл юм.

**Яруугийн хүрээ:** Завхан аймаг Алдархаан сумын Мандаат багийн нутаг. Яруугийн хүрээ /Дашпунцаглин хийд/ Завхан аймгийн төв Улиастай хотоос баруун тийш 17 кмт Яруугийн голын эрэг Улиастай- Донойн нисэх буудлын замын урьд талд энэхүү Яруугийн хүрээ төвхнөж байжээ. Анх ялгасан хутагт Лувсанданзангийн харьяа сум гэгдсэн нэгэн дацангаас эхлэлтэй. Газар зүйн солбилцол 47° 42' 96° 37'



**Богдын голын усан цахилгаан станц:** Алдархаан суманд байрлах УЦС нь толгойн барилга, ус дөхүүлэх суваг, түрэлтийн сан, түрэлтийн хоолой, станцын барилга, хаях суваг зэрэг барилга байгууламжаас бүрддэг. УЦС-аас 35кВ-ын 36км урт цахилгаан дамжуулах шугамаар Улиастай хоттой холбосон байна. УЦС-ын техникийн үндсэн үзүүлэлтүүд:  
Станцын суурилагдсан хүчин чадал: 200 кВт

Ус дөхүүлэх сувгийн урт: 2.5 км

Ус дөхүүлэх сувгийн хөндлөн огтлол: Трапец

Тооцоот түрэлт: 35м

Тооцоот зарцуулга: 7.0м<sup>3</sup>/с

Турбины төрөл, марк: Францис, HL240-WJ-71

Генераторын төрөл: SFW-J1000-10/143С

**Аажаа гэгээний төрсөн газар:** Баянтэс сумын нутагт байрладаг. Гончигийн Гэндэнжамц нь XVI-р жарны Төмөр бичин жилийн өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн буюу 1920 оны 11-р сарын 11-нд Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошууны Баян булаг харуул, одоогийн Баянтэс сумын Жавхлан багийн нутаг болох “Хүртэн” гэдэг газар малчин



ард эцэг Гончиг, эх Маани /Сольхүү/ нарын гурав дугаар хүү нь болон ер бусын гайхамшиг үзүүлэн мэндэлжээ.

**Эвэртэй мод:** Баянтэс сумын нутаг дэвсгэрт байрладаг. Сумын иргэд Овооны арын харзнаас хэрэглээнийхээ усыг авдаг юм билээ. Сумын төвийн ойролцоо эвэртэй мод, нүхэн хад, сүүж хад зэрэг өвөрмөц тогтоцтой байгалын үзэсгэлэнт газар олонтой сайхан нутаг

ажээ. Эвэртэй мод анх ургахдаа л ингэж тогтсон гэж нутгийнхан хэлсэн. Мөн мод өндөрсөхийн хэрээр эвэр ч томорч байгаа гэсэн юм.



**Хачигийн хүрээний туурь:** Завхан аймаг. Баянтэс сум. Хачигийн хийд /Гэжээлин сүм/ Хуучин Засагт хан аймгийн Дүүрэгч вангийн хошуу одоогийн Завхан аймгийн Баянтэс сумын Хачиг багийн нутаг Хачигийн голын баруун бие их Жаргаланат, бага Жаргалант уулын бэлд энэ хийд төвхнөж байжээ.1860-аад оны үед байгуулагдсан гэх Хачигийн хийд нь 3 дугантай, 30 гаруй лам байнга сууж хурдаг

байв.

**Буга согоот:** Сантмаргац сумын нутаг дэвсгэрт оршдог.

Сумын төвөөс баруун тийш 6 км зайд оршдог. Буга согоо дүрсэлсэн олон зурагтай.

1. Хөшөөт хүн чулуу
2. Бичигт хад
3. Их Маргаз уул
4. Давааны ар
5. Шивээт ганц мод



**Дилав хутагтийн төрсөн газар:** Түдэвтэй сумын Дилав хутагт Жамсранжав одоогийн Завхан аймгийн Түдэвтэй сум Ойгон нуурын ар хөвөө, "Түшлэгийн булаг" гэдэг газар 1883 онд мэндэлжээ.

#### 4.5.3 Аялал жуулчлалын салбарын SWOT-АНР шинжилгээ

Аялал жуулчлалын салбарын үр дүнд нөлөөлөх дотоод хүчин зүйлсийн давуу талыг илэрхийлэх 4, сул талыг илэрхийлэх 4, гадаад хүчин зүйлсийн таатай нөхцлийг илэрхийлэх 4, таагүй нөхцлийг илэрхийлэх 4, нийт 16 хүчин зүйлс (гол) -ийг сонгон авч, SWOT-АНР шинжилгээг аялал жуулчлалын салбарт тулгуурлан хийв.

Хүснэгт 121. Аялал жуулчлалын салбарын SWOT-АНР шинжилгээ

А. Дотоод хүчин зүйлс		Б. Гадаад хүчин зүйлс	
Давуу тал (S)	Сул тал (W)	Таатай нөхцөл (O)	Таагүй нөхцөл (T)
I. Үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалт газрууд, геологийн өвөрмөц тогтоц бүхий газрууд, эмчилгааны рашаан, агнуурын холбогдолтой ан амьтан, ховор амьтан ургамалын нөөцтэй.	V. Орон нутгийн иргэд аялал, жуулчлал эрхлэх үйлчлэх талаар ойлголт муу байна.	II. Жуулчдын урсгалыг Завхан аймаг руу татах боломжтой.	VI. Жуулчны бааз, ангийн отог, амралт сувилалын газруудын тоог нэмэгдүүлэхгүй бол байгаль орчин бохирдох эрсдэлтэй.

II. Орон нутгийн иргэд нүүдлийн зан үйл, уламжлалт ёс заншлаа хадгалан үлдсэн.	VI. Жуулчдын амрах бааз, амралтын газар цөөн байна.	II. Өндөр уул, гол, нууруудыг түшиглэн спортын аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.	VI. Менежментийн буруу бодлого, хэт ачааллаас үүдэн, түүхийн үнэт олдвор, дурсгалт зүйлсүүд сүйдэх
III. Аймгийн нутаг дэвсгэр нь уул уурхайд хөндөгдөөгүй, эрүүл, унаган дүр төрхөө хадгалан үлдсэн байна.	VII. Дэд бүтэц, зам харилцаа муу хөгжсөн.	III. Байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн эко аялал жуулчлал хөгжүүлэх	VII. Уур амьсгалын хувьд эрт цас орох, цочир хүйтрэл, зуд болох магадлал өндөр
IV. ОХУ-руу гарах боомттой. /Арц суурийн боомт/	VIII. Эрт хүйтэрч, орой дулаарах тул аялал жуулчлалын улирал богино	IV. Хутагтуудын төрсөн газар, түүх археологийн үнэт олдворууд, эртний сүм хийдийн туурийг түшиглэн соёл, танин мэдэхүйн аялал жуулчлал хөгжүүлэх боломж байна.	VIII. Жуулчдын замбараагүй байдлаас ой түймэрт өртөх магадлалтай.

Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц

PV	0.108	0.278	0.096	0.208	0.124	0.063	0.034	0.089			
№	I	II	III	IV	V	VI	VII	VIII	PV	PA	PA/PV
I	1	0.200	1.000	0.333	1.000	3.000	3.000	3.000	0.108	1.011	9.371
II	5.000	1	3.000	1.000	3.000	5.000	7.000	3.000	0.278	2.505	9.006
III	1.000	0.333	1	0.333	1.000	3.000	3.000	1.000	0.096	0.870	9.029
IV	3.000	1.000	3.000	1	1.000	3.000	5.000	3.000	0.208	1.848	8.898
V	1.000	0.333	1.000	1.000	1	3.000	5.000	1.000	0.124	1.076	8.700
VI	0.333	0.200	0.333	0.333	0.333	1	1.000	3.000	0.063	0.599	9.494
VII	0.333	0.143	0.333	0.200	0.200	1.000	1	0.333	0.034	0.301	8.917
VIII	0.333	0.333	1.000	0.333	1.000	3.000	3.000	1	0.089	0.798	8.926
Нийлбэр	12.000	3.543	10.667	4.533	8.533	22.000	28.000	15.333	1	<b>Lmax</b>	9.043

Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно. **CI** 0.149  
**CR** 0.106

Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц

PV	0.181	0.045	0.041	0.043	0.227	0.123	0.196	0.145			
№	I	II	III	IV	V	VI	VII	VIII	PV	PA	PA/PV
I	1	3.000	3.000	3.000	0.200	0.333	3.000	3.000	0.181	1.676	9.267
II	0.333	1	1.000	1.000	0.333	0.333	0.200	0.333	0.045	0.393	8.759
III	0.333	1.000	1	1.000	0.200	0.333	0.200	0.333	0.041	0.363	8.831
IV	0.333	1.000	1.000	1	0.333	0.333	0.200	0.200	0.043	0.373	8.781
V	5.000	3.000	5.000	3.000	1	3.000	1.000	1.000	0.227	2.308	10.177
VI	3.000	3.000	3.000	3.000	0.333	1	0.333	0.333	0.123	1.240	10.109
VII	0.333	5.000	5.000	5.000	1.000	3.000	1	1.000	0.196	1.638	8.362
VIII	0.333	3.000	3.000	5.000	1.000	1.000	1.000	1	0.145	1.221	8.406
Нийлбэр	10.667	20.000	22.000	22.000	4.400	9.333	6.933	7.200	1	<b>Lmax</b>	9.086

Тайлбар: Нийцтэй байдлын харьцаа нь зөвшөөрөгдөх түвшинд гарсан тул шинжилгээнд сонгож авсан хүчин зүйлс нь оновчтой болно. **CI** 0.155  
**CR** 0.110

Эх сурвалж: Тооцож гаргасан үр дүн

#### Хүснэгт 122. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх үйл ажиллагааны стратеги


Хугацаа	Стратеги
Ойрын хугацааны (2018-2023)	• Салбарын давуу талуудад тулгуурлан гадаад орчны таатай нөхцлийг дээд зэргээр ашиглах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.
Дунд хугацааны (2024-2029)	• Салбарын сул талуудыг сайжруулан гадаад орчны таатай нөхцлийг дээд зэргээр ашиглах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх. • Салбарын давуу талуудад тулгуурлан гадаад орчны таагүй нөхцлийн сөрөг нөлөөг бууруулах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.
Хэтийн (2030-2033)	• Гадаад орчны таагүй нөхцөлд салбарын сул талуудыг сайжруулах замаар гарах сөрөг үр дагаварыг аль болох багасгах замаар аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх.

Эх сурвалж: Тооцооны үр дүнд үндэслэсэн.

#### 4.5.4 Аялал жуулчлалын бүсийн тохиромжтой байдлын үнэлгээ

Аялал жуулчлал эрхлэх газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийдээ ГХГЗЗГ-ын даргын 2015 оны 200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүй”-г баримталж хийсэн. Байгаль аялал-рекреацийн үнэлгээг хийхийн өмнө аялалын нөөцүүдийг судлахаас эхэлнэ (Л.Баясгалан, 2010).

Учир нь байгаль дахь аялалын нөөцүүд хир зэрэг байгаагаас үнэлгээний үр дүн, тохиромжтой толбайн хэмжээ хамаарна. Иймд аргачлалын дагуу үнэлгээг:



Диаграмм 76. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

### Ландшафтын үнэлгээ:


Завхан аймгийн ландшафтын үнэлгээг хийхийн тулд дараахь 5 төрлийн үнэлгээ аргачлалын дагуу нэгтгэн гаргана.

- Газрын гадаргын аялал –рекреацийн үнэлгээ
- Уур амьсгалын аялал –рекреацийн үнэлгээ
- Гадаргын ус, рашааны аялал –рекреацийн үнэлгээ
- Био нөөцийн аялал –рекреацийн үнэлгээ
- Ландшафтын гоо зүйн үнэлгээ

**Газрын гадаргын аялал –рекреацийн үнэлгээ:** Газрын гадаргын хотгор гүдгэр, тухайлбал гадаргын налуу, хэрчигдэлийн шигүү нь тухайн нутагт аялал жуулчлалын бааз байгуулах, зам тавих, аялал хийхэд тодорхойлогч гол хүчин зүйл болдог. Ялангуяа барилга байгууламж барих, тээврийн хэрэгсэлийн туулах чадварт сөргөөр нөлөөлөх тул гадаргын бүтэц, сулуулаг, хотгор, гүдгэрийг зайлшгүй тооцох шаардлагатай. Үнэлгээнд аймгийн гадаргын налуу, хэрчигдэлийн шигүү гэсэн 2 үзүүлэлтийг аргачлалын дагуу үнэлсэн.

Хүснэгт 123. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээний үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тохиромжтой 3 балл	Хягаарлагдмал тохиромжтой 2 балл	Тохиромжгүй 1 балл	Мэдээллийн эх сурвалж
Гадаргын налуу	Градус	12-аас доош	12-20	20-аас дээш	SRTM-ийн мэдээнд боловсруулалт хийн гаргасан.
Хэрчигдэлийн шигүү	км <sup>2</sup> /км	0,6-оос доош	0,6-1,0	1,0-ээс дээш	




**Зураг 185. Газрын гадаргын аялал-рекреацийн нэгдсэн үнэлгээ**

Судалгааны үр дүнд тус аймаг гадаргын хувьд аялал рекреацийн үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 67,43 хувь буюу 5560018,18 га талбай тохиромжтой, 21,52 хувь буюу 1774631,41 га нь хязгаарлагдмал тохиромжтой, 11,04 хувь буюу 910857,11 га нь тохиромжгүй гарсан байна. Алдархаан сумын ихэнх талбай тохиромжгүй, Тосонцэнгэл, Завханмандал, Сонгино, Цагаанчулуут, Баянтэс сумдаар хязгаарлагдмал тохиромжтой гарсан. Хэдийгээр уулархаг газар нь тохиромжгүй үнэлгээтэй гарсан хэдий ч уулын спортын болон байгалийн аялал жуулчлал эрхлэх боломжтой нутаг юм.

**Уур амьсгалын аялал –рекреацийн үнэлгээ:** Уг үнэлгээний шалгуурыг мөн аргачлалын дагуу хийсэн бөгөөд судалгаанд Завхан аймгийн цаг уурын харуулуудын олон жилийн дундаж мэдээ, ГЗБГЗЗГ-ийн суурь судалгааны материалуудыг ашиглан үнэлсэн.

**Хүснэгт 124. Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээний үзүүлэлт**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тохиромжтой 3 балл	Хязгаарлагдмал тохиромжтой 2 балл	Тохиромжгүй 1 балл	Мэдээллийн эх сурвалж
Агаарын дундаж температур	хоног	130-аас дээш	90-130	90-ээс бага	ГЗБГЗЗГ-ийн суурь судалгаа болон аймгийн цаг уурын станцын ОЖ-ийн мэдээ
Жилд нар гийгүүлэх хугацаа	цаг	3100-аас дээш	2700-3100	2700-аас доош	
Харьцангуй чийгшлийн дундаж утга, 13 цагт	хувь	50-аас дээш	40-50	40-өөс доош	
Тогвортой бүрхүүлийн үргэлжлэх хугацаа	өдөр	50-аас доош	50-150	150-аас дээш	



Зура

г 186. Уур амьсгалын аялал –рекреацийн үнэлгээ


Судалгаагаар аймгийн зүүн урдаас, баруун хойшоо чиглэсэн аялал жуулчлал хөгжихөд тохиромжтой уур амьсгал бүхий бүс нутаг илэрч байгаа бөгөөд нийт нутгийн 28,2 хувь буюу 2325316,48 га талбай тохиромжтой, 30,49 хувь буюу 2514328,2 га талбай хязгаарлагдмал тохиромжтой, 41,3 хувь буюу 3405922,02 га талбай тохиромжгүй үнэлгээтэй гарсан. Энд Шилүүстэй, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Улиастай, Яруу, Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул, Сантмаргац, Сонгино, Түдэвтэй болон Дөрвөлжин, Ургамал гэсэн 2 бүс нутаг байна. Тосонцэнгэл, Тэлмэн, Нөмрөг, Асгат, Баянтэс сумдуудад харьцангуй эрт хүйтэрч, цас орох тул өвлийн аялал жуулчлалын хөтөлбөрүүдийг /тухайлбал цас, мөсний баяр, чаргатай аялал гэх мэт/ гаргах шаардлагатай.

**Гадаргын ус, рашааны аялал –рекреацийн үнэлгээ:** Завхан аймгийн нутаг дэвсгэр нь Идэр, увс нуур-Тэсийн болон Хяргас нуур-Завхан голын 3 томоохон голын сав газарт багтаж, Хар нуур, Тэлмэн нуур, Баяннуур, Тэс гол, Завхан гол гэх мэт Монгол улсын том гол нуур ихтэй, гадаргын усны сүлжээ сайн хөгжсөн аймаг юм. Иймд гадаргын ус-рашааны рекреацийн үнэлгээг дараахь үзүүлэлтээр хийлээ.

Хүснэгт 125. Гадаргын ус-рашааны аялал-рекреацийн үнэлгээний үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тохиромжтой 3 балл	Хязгаарлагдмал тохиромжтой 2 балл	Тохиромжгүй 1 балл	Мэдээллийн эх сурвалж
Гол мөрний нийлбэр урсац	л/с км <sup>2</sup>	3-аас дээш	0,5-3	0,5-аас доош	ГЗБГЗЗГ-ийн суурь судалгаа
Нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт	км/км <sup>2</sup>	0,2-оос дээш	0,01-0,2	0,01-ээс доош	
Хүний биед тохиромжтой	°C	24-ээс дээш	17-24	16-аас бага	

байгалийн температур	усны				
Гол нуур		өдөр	Усанд сэлэхэд тааламжтай гол нууртай Халуун, хүйтэн рашаан хосолсон	Усанд сэлэхэд тохиромжтой жижиг гол, усан сантай  Ямар нэг рашаантай	байхгүй  байхгүй



Зураг 187. Гадаргын ус-рашааны аялал-рекреацийн үнэлгээ

Ус-рашааны хослолын хувьд аялал жуулчлал хөгжүүлэхэд тохиромжтой үнэлгээтэй гарсан нутаг дэвсгэр нь нийт нутгийн 13,08 хувь буюу 1078846,7 га, хязгаарлагдмал тохиромжтой нь 54,1 хувь буюу 4461056 га, тохиромжгүй 32,81 хувь буюу 2705664 га гарч байна.


**Био нөөцийн аялал –рекреацийн үнэлгээ:** Аймгийн ойн болон ургамал, амьтны аймгийн талаархи мэдээллийн Байгаль орчны мэдээллийн сан, ГЗБГЗЗГ-ын суурь судалгаа, судлаачдын түүвэрлэсэн судалгааны материалуудыг ашиглан үнэлсэн. Завхан аймаг нь улсын хэмжээнд ойн нөөц дунд зэрэг, самар, жимс элбэгтэй, ховор ургамал, амьтны аймагтай нутаг болно.

Хүснэгт 126. Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээний үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй	Мэдээллийн эх сурвалж
Бонитетийн анги	-	3 балл	2 балл	1 балл	Завхан аймгийн ой зохион
Ойн бүтэц, хэлбэр	-	I, II Төрөл зүйлийн	III, IV Төрөл зүйлийн хувьд дунд	V, Va Нэг хэв шинжийн	



Модлогийн зонхилогч зүйл	-	хувьд баялаг, гайхагдам ой	Царс, нарс	зэрэг, үзэсгэлэн ой	Гацуур, хус, эвэрлэг мод, шинэс, хуш	мододтой	Улиас, нигүүрс	байгуулалтын тайлан, 2013 он болон ГЗБГЗЗГ-ийн суурь судалгаа
Ойн цоорхой ба зах	-	Өвслөг ургамлаар баялаг		Ойн цоорхой ба зах		Ойн цоорхой байхгүй, захаас хол		
Ойн хомсдол	Хувь	Ойн шигүүрэлт 10-аас бага		Ойн шигүүрэлт 10-60		Ойн шигүүрэлт 60-аас их		
Ойрхог чанар	Хувь	5,1-10		1,1-5		1 хүртэл		
Ойн дагалт баялаг		Самар, мөөг, жимс жимсгэнэ элбэгтэй		Ховор		Байхгүй		
Нэн ховор, ховор ургамлын зүйл		Элбэг		Хэвийн		Ховор		
Нэн ховор, ховор амьтаны зүйл		Элбэг		Хэвийн		Ховор		



Зураг 188. Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ


Судалгааны үр дүн ойтой сумдуудаараа аялал жуулчлал эрхлэхэд тохиромжтой, говийн сумд болох Дөрвөлжин, Завханмандал, Сантмаргац, Ургамал, Шилүүстэй сумд бүтнээрээ, Отгон, Цагаанхайрхан, Алдархаан, Яруу, Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул сумдын урд хэсгээр био нөөц хомс үнэлгээтэй гарсан. Нийт нутгийн 92,09 хувь буюу 7593489,18 га талбайг тохиромжгүй, 2,59 хувь буюу 213603,42 га талбай

хязгаарлагдмал тохиромжтой, 5,31 хувь буюу 438474,1 га талбай тохиромжтой үнэлгээтэй гарч байна.

**Ландшафтын гоо зүйн үнэлгээ:** Энэ үнэлгээгээр аялал-рекреацийн хувьд онцгой ач холбогдолтой газруудыг олж тогтоох, ашиглаж байгаа болон ашиглаж болох газруудад учирч буй эрсдэл, түүнийг арилгах боломж, антропоген, техногений нөлөөлөлд ороогүй нутаг дэвсгэрийн систем бүрэлдэх урьдчилсан нөхцөлийг илрүүлэх ажлыг гүйцэтгэнэ. Иймээс Завхан аймгийн ландшафтын гоозүйн үнэлгээг байгалийн иж бүрдэлүүдийн үзүүлэлт бүрээр дараахь байдлаар үнэлж, нэгтгэсэн.

Хүснэгт 127. Ландшафтын гоо зүйн үнэлгээний үзүүлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тохиромжтой 3 балл	Хязгаарлагдмал тохиромжтой 2 балл	Тохиромжгүй 1 балл	Мэдээллийн эх сурвалж
Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	-	БЦГ болон БДГ-тай	БДГ-тай	байхгүй	АМХЭГ-ийн кадастрын мэдээллийн сан /www.mram.com/
Дэлхийн өв газар	-	Дэлхийн байгалийн болон соёлын өвд бүртгэгдсэн газартай	Дэлхийн аль нэг өвд бүртгэгдсэн газартай	байхгүй	-
Бохирдолын түвшин	-	Физик, хими, биологийн бохирдол илрээгүй	Бохирдолын түвшин амралтын ая тухтай байдалд нөлөөлөхөөргүй	Хэт бохирдсон.	Монгол орны байгаль орчин, 2017 он болон ГЗБГЗЗГ-ын суурь судалгаа



Зураг 189. Ландшафтын гоо зүйн үнэлгээ

Аймгийн хэмжээнд улсын тусгай хамгаалалттай газар нутаг болох Улаагчны хар нуурын байгалийн цогцолборт газар, Тарвагатайн нурууний байгалийн цогцолборт газар орчимд 836718,75 га талбай аялал жуулчлал эрхлэхэд тохиромжтой үнэлгээтэй гарсан. Нийт нутгийн 87,55 хувь буюу 7251718,75 га талбай хязгаарлагдмал тохиромжтой үнэлгээ гарсан нь Дэлхийн өвд бүртгэгдсэн газар байхгүйтэй холбоотой болно. Харин тохиромжгүй газар 194375 га буюу нийт нутгийн 2,34 хувь нь цэгэн байдлаар илэрч гарсан байна.

**Ландшафтын нэгдсэн үнэлгээ:** Дээрх үзүүлэлт бүрийн нэгдсэн үнэлгээгээр аймгийн нийт нутгийн 20,83 хувь буюу 1718334,7 га талбай аялал жуулчлалд тохиромжтой, 58,11 хувь буюу 4792064 га хязгаарлагдмал тохиромжтой, 21,04 хувь буюу 1735168 га тохиромжгүй үнэлгээтэй гарч байна.



Зураг 190. Байгаль аялал-рекреацийн ландшафтын нэгдсэн үнэлгээ

### Байгаль, түүх соёлын дурсгалт газрын үнэлгээ:

Завхан аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд болон түүх соёлын дурсгалуудын үнэлгээг хийхийн тулд орон нутаг дахь түүх соёлын дурсгалт газрын улсын тооллогын материалуудыг ашиглан зурагласан.

Хүснэгт 128. Байгаль, түүх соёлын дурсгалт газрын үнэлгээний үзүүлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тохиромжтой 3 балл	Хязгаарлагдмал тохиромжтой 2 балл	Тохиромжгүй 1 балл	Мэдээллийн эх сурвалж
Байгаль соёлын дурсгалт газрууд	-	Агуйн галт уул, хүрхрээ, нуур хосолсон	Ямар нэг байгаль соёлын өвтэй	байхгүй	Түүх соёлын үйл хөдлөх дурсгалт зүйлсийн улсын тооллого, 2007 он,
Түүх соёлын	-	Эртний	Ямар нэг түүх	байхгүй	Монгол улсын

дурсгалт газрууд

хотын туур,  
хэрэм,  
балгас, сүм  
хийд,  
суварга,  
хиргэсүүр,  
хадны зураг,  
гэрэлт  
хөшөө,  
бунхан, овоо,  
буган хөшөө  
хосолсон

соёлын  
дурсгалт  
газартай

соёлын өвийн  
улсын нэгдсэн  
мэдээллийн сан



Зураг 191. Байгаль, түүх соёлын дурсгалт газрын аялал-рекреацийн үнэлгээ

Аймгийн нутаг дэвсгэрт байгалийн болон түүх соёлын дурсгалт газар элбэг бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 45,32 хувь буюу 3737600 га талбай хязгаарлагдмал тохиромжтой, 11,36 хувь буюу 937278,7 га талбай тохиромжтой гарсан. Харин бүх сумдын нутаг дэвсгэрт тохиромжгүй үнэлгээтэй газар зурваслаж гарсан ба нийт нутгийн 43,3 хувь буюу 3570688 га талбайг хамарч байна.


**Дэд бүтцийн үнэлгээ:**

Завхан аймаг нь даваа гүвээ ихтэй, зах харилцаа сул хөгжсөн, хэдий ч байгалийн урочиш ихтэй, хот суурин газар элбэг тул дэд бүтцийн үнэлгээгээр аялал жуулчлал эрхлэхэд тохиромжтой газрыг үнэлэх боломжтой бөгөөд аргагүйн дагуу дараахь үзүүлэлтүүдээр үнэлсэн.

Хүснэгт 129. Дэд бүтцийн үнэлгээний үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй	Мэдээллийн эх сурвалж
----------	-------------	-------------	----------------------------	-------------	-----------------------

		3 балл	2 балл	1 балл	
Гатлага зам	-	Харьцангуй онгон зам, жимийн сүлжээтэй	Явган аялалын жим болон замын сүлжээ дунд зэрэг хөгжсөн	Замгүй, гатлахад бэрхшээлтэй	ГЗБГЗЗГ-ын суурь судалгаа
Хот болон байнгын суух ойрхон эсэх	-	Яг дэргэд	1 цагийн дотор хүрэх боломжтой	1 цагаас илүү хугацаа шаардана.	
Тохижилтын түвшин	-	Тохижуулсан нутаг дэвсгэр болон байгалийн хослолтой	Дунд зэрэг тохижуулсан	Ундны ус хомстой, огт тохижуулаагүй	



Зураг 192. Аялал-рекреацийн дэд бүтцийн үнэлгээ

Үнэлгээгээр нийт нутгийн 24,35хувь буюу 2008089,48 га талбай тохиромжтой, 56,13 хувь буюу 4628349,12 га талбай хязгаарлагдмал тохиромжтой, 19,51 хувь буюу 1609128,1 га нь тохиромжгүй үнэлгээтэй гарсан байна. Шилүүстэй, Цагаанчулуут, Алдархаан, Завханмандал, Ургамал, Асгат, Баянтэс, Тэс, Түдэвтэй, нөмрөг, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-уул сумд гэсэн 4 бүсээр тохиромжтой бус нутаг илэрсэн байна.

#### Аялал –рекреацийн чадавхийн нэгдсэн үнэлгээ:


Аялал рекреацийн чадавхийн нэгдсэн үнэлгээг хийхдээ үнэлгээний хүчин зүйл бүрийн жигнэсэн утгыг олж тодорхойлсноор хүчин зүйл тус бүрийг жингийн утгаар үржүүлж давхарга бүрийн нийлбэрээр тохиромжтой байдлын индексийг гаргасан. Индексийн утгуудаар аялал рекреацийн өндөр чадавхитай буюу тохиромжтой үнэлгээтэй бүсэд Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Идэр, Улиастай, Отгон, Шилүүстэй,

Цагаанчулуут, Эрдэнэхайрхан, Завханмандал, Цэцэн-Уул, Нөмрөг, Түдэвтэй, Сонгино, Тэс, Баянтэс, Асгат сумдууд, чадавхи сул, тохиромжгүй бүс нутагт Дөрвөлжин, Яруу, Алдархаан сумдын зарим хэсэг орсон.

Хүснэгт 130. Аялал-рекреацийн нэгдсэн үнэлгээний талбай, сумуудаар

№	Сумын нэр	Нийт талбай, га	Тохиромжтой байдлын үнэлгээ		
			Тохиромжгүй	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжтой
1	Алдархаан	715829,00	123717	520704	71408
2	Асгат	65400,00	17016	38144	10240
3	Баянтэс	433898,00	128522	245760	59616
4	Баянхайрхан	255822,00	52814	172544	30464
5	Дөрвөлжин	726022,00	307974	343040	75008
6	Завханмандал	361137,00	39377	225792	95968
7	Идэр	370805,00	55413	246784	68608
8	Их-Уул	377598,00	113662	177408	86528
9	Нөмрөг	327741,00	87165	156160	84416
10	Отгон	600867,00	222499	342272	36096
11	Сантмаргац	239183,00	59743	123136	56304
12	Сонгино	248953,00	42905	99840	106208
13	Тосонцэнгэл	530233,00	129929	336640	63664
14	Түдэвтэй	267182,00	49390	132864	84928
15	Тэлмэн	344605,00	28445	229888	86272
16	Тэс	87229,00	6333	56832	24064
17	Ургамал	349199,00	16399	242432	90368
18	Улиастай	2810,00	120	1005	1685
19	Цагаанхайрхан	265332,00	53620	188160	23552
20	Цагаанчулуут	257103,00	15439	156160	85504
21	Цэцэн-Уул	237286,70	67800,7	131859	37627
22	Шилүүстэй	268990,00	30718	175872	62400
23	Эрдэнэхайрхан	416728,00	65752	248832	102144
24	Яруу	495614,00	189182	258048	48384
<b>Аймгийн нийт</b>		<b>8245566,70</b>	<b>1903934,7</b>	<b>4850176</b>	<b>1491456</b>
<b>Нийт нутаг дэвсгэрт эзлэх хувь</b>		<b>100,0</b>	<b>23,09</b>	<b>58,82</b>	<b>18,08</b>

Аймгийн хэмжээгээр аялал жуулчлал хөгжүүлэх тохиромжтой нутаг 23,09 хувь буюу 1903934,7 га, хязгаарлагдмал тохиромжтой нь 58,82 хувь буюу 4850176,0 га, тохиромжгүй нутаг 18,08 хувь буюу 1491456,0 га талбай байна.



Зураг 193. Аялал-рекреацийн тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

#### 4.5.5 Аялал жуулчлалын бүсийн төлөвлөлт

Үндэслэл: УИХ-аас баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” (2016 он), Засгийн газрын “Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр” (2005 он), Засгийн газрын “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2015 он), “Аялал жуулчлал XXI зуун-Үндэсний чуулган”-аас гарсан зөвлөмж (2012 он), “Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого 2009-2021” (2008 он), “Завхан аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр, 2016-2020 он” (2016он), Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө (2014 он), Олон улсын Мерси Кор байгууллага, Аялал жуулчлалын тогтвортой хөгжил төвтэй хамтран боловсруулсан “Хариуцлагатай аялал жуулчлалыг дэмжих төсөл” (2008 он)-ийн үр дүнтэй уялдуулан аймгийн аялал жуулчлалын бүсийг төлөвлөсөн.

“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д 2016-2020 оны хугацаанд эко аялал жуулчлалын бүсүүдтэй болох зорилт тавьсан бөгөөд энэ хүрээнд Завхан аймаг нь эко аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийг тэргүүлэх чиглэл болгосон байна.

Орчин үед аялал жуулчлал нь нийгэм, эдийн засгийн өндөр өсөлттэй салбаруудын нэг болж, зугаа цэнгэл, чөлөөт цагаа өнгөрөөх арга төдий бус орон нутгийн хөгжилд эерэг нөлөөлөх хүчин зүйл болгон хөгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Ялангуяа тогтвортой аялал жуулчлал нь орон нутгийн ард иргэд, бизнес эрхлэгчдээс бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах, тэдэнд зориулан ажлын байр бий болгох

замаар тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах хамгийн боломжит нөөц юм. Энэ нь орон нутгийн иргэдийн ажиллаж, амьдрах орчныг сайжруулж, мэргэжилгүй болон хагас мэргэшсэн ажиллах хүчийг чадавхжуулж, улмаар орон нутгийн соёл, байгаль, нийгэмд үзүүлэх шууд болон шууд бус нөлөөллийг эерэг болгох боломжтой.

Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоол “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” –т аялал жуулчлалын газрын төлөвлөлттэй холбоо бүхий дараахь 2 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг 2016-2025 он хүртэл 10 жилийн хугацаагаар төлөвлөсөн байна. Үүнд:

1. Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх
2. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх.

Нэгдүгээр зорилтын хүрээнд аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлж, нутгийн иргэд болон тусгай хамгаалалттай газар нутагт түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- Аялал жуулчлалыг Монгол орны байгаль, түүх, соёлын үнэт өв, нүүдэлчин ахуй, уламжлалт зан заншлыг тусгасан өөр өөрийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгаатайгаар бүсчлэн хөгжүүлэх
- Соёлын өв, түүх, соёлын дурсгалт газарт суурилсан соёлын аялал жуулчлалын шинэ үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх
- Хөдөө аж ахуйн уламжлалт өв соёл, газар нутагт суурилсан агро-аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Зочид буудал, жуулчны бааз, үйлчилгээний байгууллагуудад зэрэглэл тогтоох стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох

Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд тусгай хамгаалалттай болон соёлын өвийн бүс нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудлыг тусгасан байна.

Аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021 он/-д аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох зорилт тавин, аялал жуулчлалыг хөгжүүлэх ойрын /2009-2015 он/ болон хэтийн /2016-2021 он/ хугацаанд хийгдэх ажлуудыг төлөвлөсөн бөгөөд төлөвлөгдсөн үйл ажиллагаануудыг уялдуулан төлөвлөлтийн бодлогыг тодорхойлон гаргасан. 2016-2021 оны хугацаанд аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэн жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 7.0 хувьд хүргэх стрөтеги тавин, дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Аймагт жил бүр хүрэлцэн ирэх жуулчдын тоог аймгийн хүн амын тоотой тэнцэх хэмжээнд хүргэх;
- Орчин үеийн зочид буудал, жуулчны бааз, нүүдлийн отог шинээр барьж тохижуулан үйлчилгээний нэр төрлийг олшруулах;
- Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулах;


Аялал жуулчлалын дэд хөтөлбөрт аймгийн аялал жуулчлалыг дараахь аялалын төрлүүдээр хөгжүүлнэ гэж тусгасан байна. Үүнд:



- Аядал явдалт аялал жуулчлал
- Эко аялал жуулчлал
- Тусгай сонирхолын аялал жуулчлал
- Бүс нутгаар дамжин өнгөрөх, тойрон аялал жуулчлал
- Соёл-танин мэдэхүйн аялал жуулчлал
- Рашаан сувилалын аялал жуулчлал
- Эмчилгээ оношлогооны аялал жуулчлал

### Аялал жуулчлалын бүсчлэлийн төлөвлөлт:

Монгол улсын аялал жуулчлалын бүс нутагт *Мөнх цаст Отгонтэнгэр хайрхан, байгалийн үзэсгэлэн бүхий Завханы бүс* болгон оруулах зорилт тавин төлөвлөсөн.



Диаграмм 77. Завхан аймгийн аялал жуулчлалын бүсийн төлөвлөлтийн зорилго

Завхан аймгийг Монгол улсын аялал жуулчлалын бүс нутаг болгох зорилт тавин төлөвлөлтийн хувилбарыг боловсруулсан бөгөөд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын газраас гаргасан аялал жуулчлалын дараахь бүсчлэлийг баримтлан төлөвлөлтийг хийсэн. Үүнд:

1. Аялал жуулчлалын төвийн бүс
2. Аялал жуулчлалын Хангайн бүс
3. Аялал жуулчлалын Говийн бүс

Хүснэгт 131. Аялал жуулчлалын бүсчлэлийн төлөвлөлт


Аялал жуулчлалын бүс	Хамрагдаж байгаа газрууд	Талбай, га	Хөгжүүлэх аялал жуулчлалын чиглэл	Үндэслэл
Аялал жуулчлалын төвийн бүс	Улиастай, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Отгон, Шилүүстэй, Алдархаан	2078375,1	<ul style="list-style-type: none"> <li>•Тусгай сонирхолын АЖ</li> <li>•Соёл-танин мэдэхүйн АЖ</li> </ul>	Завхан аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр
Аялал жуулчлалын Хангайн бүс	Идэр, Тэлмэн, Нөмрөг, Түдэвтэй, Баянхайрхан, Баянтэс, Тэс, Тосонцэнгэл, Их-Уул, Асгат	3006186,12	<ul style="list-style-type: none"> <li>•Тусгай сонирхолын АЖ</li> <li>•Спорт, агнуурын АЖ</li> <li>•Эмчилгээ сувилгааны АЖ</li> </ul>	Завхан аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр
Аялал	Алдархаан, Дөрвөлжин,	3161005,48	<ul style="list-style-type: none"> <li>•Экстрем АЖ</li> </ul>	Завхан аймгийн

жуулчлалын Говийн бүс	Ургамал, Завханмандал, Эрдэнэхайрхан, Сантмаргац, Цэцэн-Уул, Яруу, Сонгино		•Загас агнуурын АЖ •Эко АЖ	аялал жуулчлалын дэд хөтөлбөр
-----------------------	--	--	-------------------------------	-------------------------------

Аялал жуулчлалын Төвийн бүсэд Улиастай, Цагаанчулуут, Цагаанхайрхан, Отгон, Шилүүстэй, Алдархаан сумд орох бөгөөд энд мөнх цаст Отгонтэнгэр уул, өвөрмөц тогтоц бүхий гол, нуур, халуун, хүйтэн рашаан, биологийн төрөл зүйлтэй танилцах, малчдын аж ахуйг сонирхох аялал, зорилтот аялалуудыг хөгжүүлэх боломжтой.

Аялал жуулчлалын Хангайн бүсэд Идэр, Тэлмэн, Нөмрөг, Түдэвтэй, Баянхайрхан, Баянтэс, Тэс, Тосонцэнгэл, Их-Уул сумдын үзэсгэлэнт нуурууд, газрын хагарал, нүүдлийн шувууд, хийдийн балгас, рашаан эмчилгээ, сувилгаа хийх, завиар зугаалах, шувуу амьтан ажиглах, спорт агнуурын болон тусгай зориулалтын аялалуудыг хөгжүүлэх боломжтой.

Аялал жуулчлалын Говийн бүсэд Алдархаан, Дөрвөлжин, Ургамал, Завханмандал, Эрдэнэхайрхан, Сантмаргац, Цэцэн-Уул, Яруу, Сонгино сумд орох бөгөөд энд говийн унгана төрхөөрөө байгаа эмзэг байгаль, байгалийн элдэв сонин тогтоц, тэмээний аж ахуйтай танилцах, загас агнуур, шувуу ажиглах аялалуудыг хөгжүүлэх боломжтой.




Зураг 194. Завхан аймгийн аялал жуулчлалын бүсчлэлийн төлөвлөлт

### Аялал жуулчлалын маршрут, ашиглалтын төлөвлөлт

Завхан аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийн 7.5-д аялалын төрөл, хэлбэрийг хөгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгаараа бахархах үзлийг төлөвшүүлж, дотоодын аялалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилтын

хүрээнд тусгагдсан орон нутгийн аялалын маршрутыг гарган хүүхэд, залуучуудыг аялуулан, төрсөн нутаг орноороо бахархах үзлээр төлөвшүүлэх ажлыг төлөвлөлтийн ойрын хугацаанд хэрэгжүүлэхээр, орон нутгийн санал дээр тулгуурлан маршрутыг төлөвлөсөн.



Зураг 195. Завхан аймгийн аялал жуулчлалын төлөвлөлт

Орон нутгийн иргэд, удирдлагуудын санал болон аялал жуулчлалын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнд үндэслэн аймгийн хэмжээнд 21 байршилд 111 га талбайг аялал жуулчлалын баазийн зориулалтаар олгохоор төлөвлөсөн бөгөөд төлөвлөлтийн ойрын хугацаанд 31,5 га, дундын хугацаанд 37,5 га, хэтийн хугацаанд 42 га талбайг аялал жуулчлалын бааз байгуулах зориулалтаар олгоно.

Хүснэгт 132. Төлөвлөсөн аялал жуулчлалын бааз

Сумын нэр	Төлөвлөж буй аялал жуулчлалын бааз, амралтын газрын байршил	Олгох газрын хэмжээ, га		
		Ойрын 2022 он	Дундын 2028 он	Хэтийн 2033 он
Отгон	Хүрэнгийн аманд	1,5	1,5	1,5
Сантмаргаз	Баян нуурын зүүн хойд эрэгт	1,5	3	1,5
Тосонцэнгэл	Ойлгой нуурын эрэг дээр	1,5	3	1,5
Түдэвтэй	Ойгон бригад урд	1,5	1,5	1,5
	Хунт нуур	1,5	3	1,5
Тэлмэн	Тэлмэн нуурын эрэг	1,5	1,5	3
	Бүст нуурын эрэг	1,5	1,5	3
Ургамал	Гүн нуурын эрэг	1,5	1,5	3
	Зөөхий нуурын эрэг	1,5	1,5	3
	Баян улаан уулын бэлд	1,5	1,5	1,5
Цагаанхайрхан	Бэрх цахир уулын урд бэлд	1,5	1,5	1,5
Цагаанчулуут	Сэмжит хад, Хяларын өвөлжөөнд	1,5	1,5	1,5

	Алаг эрэгт	1,5	1,5	1,5
Цэцэн-Уул	Цэгээн нууранд	1,5	1,5	3
Шилүүстэй	Буган хөшөөны хажууд	1,5	1,5	1,5
	Мандалт уулын баруун хойд бэлд	1,5	1,5	1,5
Эрдэнэхайрхан	Хар нуурын зүүн урд эрэг	1,5	3	3
	Мухартын голд	1,5	1,5	1,5
	Нарийн голын эрэг	1,5	1,5	1,5
Яруу	Хаг нуурын эрэг	1,5	1,5	3
	Бугат нуурын эрэг	1,5	1,5	1,5
<b>Аймгийн нийт</b>		<b>31,5</b>	<b>37,5</b>	<b>42</b>

Орон нутгийн иргэд, удирдлагуудын санал болон аялал жуулчлалын тохиромжтой байдлын үнэлгээний үр дүнд үндэслэн аймгийн хэмжээнд эмчилгээний чанартай 18 рашааны ордын 10 байршилд нийт 161 га талбайг рашаан сувилалын зориулалтаар олгохоор төлөвлөснөөс, төлөвлөлтийн ойрын хугацаанд 35 га, дундын хугацаанд 49 га, хэтийн хугацаанд 77 га талбайг олгоно.

#### Хүснэгт 133. Төлөвлөсөн рашаан сувилалын газар

Сумын нэр	Төлөвлөж буй рашаан сувилалын газрын байршил	Олгох газрын хэмжээ, га		
		Ойрын 2022 он	Дундын 2028 он	Хэтийн 2033 он
Завханмандал	Гацааны УЦС-ын хойд талд бөөрний рашаан	3,5	7	7
Их-Уул	Цэцүүхийн рашаан	3,5	7	10,5
	Зартын рашаан	3,5	7	7
Нөмрөг	Баянзүрх рашаан	3,5	7	7
	Үстийн рашаан	3,5	3,5	10,5
Тосонцэнгэл	Баруун хожуулын голд халуун усны рашаан	3,5	3,5	7
Түдэвтэй	Ойгон нуур /шавар эмчилгээ, саамны/	3,5	3,5	7
Тэлмэн	Гангын рашаан	3,5	3,5	7
Цэцэн-Уул	Түлэнхийн рашаан	3,5	3,5	7
	Хярын рашаан	3,5	3,5	7
<b>Нийт</b>		<b>35</b>	<b>49</b>	<b>77</b>

#### Орон нутгийн аялал жуулчлалын төлөвлөлт:

Алдархаан, Баянтэс, Завханмандал, Их-Уул, Сантмаргац, Түдэвтэй, Тэс, Цагаанчулуут, Шилүүстэй, Яруу сумдад танин мэдгүй аялал жуулчлал хөгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд аялал маршрутын дагуу Донойн цогцолбор, Яруугийн хүрээ, Дэлхэн чулуу, Арслантай хад, усан цахилгаан станц, Бичигт хад, Гурван тогоо, Уст улааны 33 агуй, Аажаа гэгээн болон Нораванчингийн төрсөн газар, Эвэртэй мод, Хулганатай харз, Хачигийн хүрээний туурь, Хүрээний талын хүн чулуу, агуйн цахир, Алтангадас, Цагаан ботго, хадны сүг зураг, Хуягт багийн төв, сумын төвийн анхны туурь, Гэр хөндий, Хөшөөт хүн чулуу, Дилав хутагт, Ар гэгээнтэн Дамдинжав, Жалханз хутагт Дамдинбазар, Ерөнхийлөгч Очирбатын төрсөн газар, Зосон зураг, хүрээлийн үеийн Дуут чулуу, Барчгар хадны сүг зураг, авгай чулуу, Түрэгийн үеийн хүн чулуу, Буган хөшөө зэрэг түүх соёлын болон байгалийн соёлын үнэт зүйлсүүд,

алдартай хүмүүсийн төрсөн газрууд, эртний хүрээний тууриуд, онцлог бүтээн байгуулалтыг үзэх боломжтой.

Харин эко аялал жуулчлал хөгжүүлэхээр төлөвлөгдсөн Алдархаан, Дөрвөлжин, Их-Уул, Сантмаргац, Сонгино, Тэлмэн, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Яруу сумдуудад төлөвлөгдсөн аялал жуулчлалын маршрутын дагуу Бага ямаат, Ямаан ус, Завхан Тээлийн бэлчир, Буга хайрхан, Бут уул, бага нуур, Эрдэний хясаа, Гурван голын бэлчир, Гүнжийн хясаа, Тэхийн хясаа, давааны ар, Цавдан нуур, Тэлмэн нуур, Бүст нуур, Гангын булаг, Гүн нуур, Цайдам нуур, зөөхий нуур, Харцагтын улааны бөгс хад, Цэцэн нуур, Боргио, Бага Отгонтэнгэр, Хар нуур, Сэгс уул, Бугат уул, Хаг нуур, Хулгайчийн үүр зэрэг байгалийн өвөрмөц тогтоц, ландшафтын олон хэлбэр бүхий газруудыг харж, байгалийн сайхнаас таашаал авах боломжтой.

Агнуурын аялал жуулчлал хөгжүүлэхээр төлөвлөгдсөн Алдархаан, Тэлмэн, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, сумдуудын Эрээн нуур, Хар нуур, Бүст нууранд загас агнуур болон Бэрхийн уул, Хуримтын зүүн нуруунд янгир агнах аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.

Экстрем болон спортын аялал жуулчлал хөгжүүлэхээр төлөвлөгдсөн Алдархаан, Отгон, Цагаанчулуут сумдын Монгол элс, Отгонтэнгэр хайрхан, Бага Отгонтэнгэр ууланд уулын спорт болон экстрем хөгжүүлэх боломжтой.

Эмчилгээний аялал жуулчлал хөгжүүлэхээр төлөвлөгдсөн Түдэвтэй, Нөмрөг, Сонгино, Цэцэн-Уул сумдуудад Ойгон нуур, Баянзүрхийн рашаан, Үстийн рашаан, Гивантий рашаан, Түлэнхийн рашаан, Хярын рашааныг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.

Сумын түвшинд орон нутгийн санал дээр үндэслэн бүс нутгаар бус аялалын маршрутаар хөгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд ихэвчлэн морин, тэмээн аялалууд, танин мэдэхүй, эко, экстрем, спорт, агнуурын аялал жуулчлал зонхилно.

Хүснэгт 134. Орон нутгийн аялал жуулчлалын маршрутын төлөвлөлт

Сум	Маршрут	Замын урт, км	Аялалын төрөл
Алдархаан	Сумын төв- Донойн цогцолбор- Яруугийн хүрээ- Дэлхэн чулуу- Арслантай хад	29	Танин мэдэхүйн АЖ
	Сумын төв- Донойн цогцолбор- Яруугийн хүрээ- Өлзийтийн ам- Усан цахилгаан станц- Даян уул- Отгоны амралт	108,33	Танин мэдэхүй АЖ
	Сумын төв- Донойн цогцолбор- Явуухулангийн төрсөн газар- Бага ямаат- Ямаан ус	46,63	Эко АЖ
	Сумын төв- Өгөөмөр овоо- Монгол элс- Эрээн нуур	73,6	Экстрем, загас агнуур АЖ
Баянтэс	Сумын төв-Бичигт хадны бичиг-Гурван тогоо-Уст улааны 33 агуй-Аажаа гэгээний төрсөн газар	52,09	Танин мэдэхүй АЖ
	Сумын төв-Эвэртэй мод-Хулганатай харз-Хачигийн хүрээний туурь-Хүрээний талын хүн чулуу	49,66	Танин мэдэхүй АЖ
Дөрвөлжин	Сумын төв- Буга хайрхан- Аргалантын рашаан- Бут уул- Бага нуур- Хар нуурын станц- Завхан тээлийн бэлчир	99.67	Эко болон эмчилгээний АЖ
Завханмандал	Сумын төв-Баян нуур	12.86	Морин болон тэмээн аялал


	Сумын төв- Гацааны УЦС – Донойн чулуу-Хөтгөрийн сүв-Олон түрүүний булаг	47.27	Танин мэдэхүй АЖ, тэмээн аялал
	Сумын төв-Агуйн цахир-Сумын анхны туурь-Алтангадас-Цаган ботго-Сүг зураг-Хадны сүг зураг-сумын төв	147.05	Танин мэдэхүй АЖ
Их-Уул	Сумын төв-Эрдэнийн хясаа-3 голын бэлчир-Цэцүүхийн рашаан-Цохиот бригадын төв	66,4	Эко АЖ, морин аялал
	Сумын төв-Гүнжийн хясаа-Тэхийн хясаа-Зартын рашаан	56,1	Эко АЖ, морин аялал
	Сумын төв-Хуягт багийн төв-Тарвагатайн нурууны БЦГ-Сангийн далай	66,7	Танин мэдэхүйн АЖ
Нөмрөг	Сумын төв-Баянзүрх рашаан	33.3	Эмчилгээний АЖ
	Сумын төв-Үстийн рашаан, Алаг чулуугийн рашаан	2979	Эмчилгээний АЖ
Отгон	Сумын төв- Улаан богочийн даваа- Цөөн мод-Отгонтэнгэр	57.76	Экстрем, спортын АЖ
Сантмаргац	Сумын төв-Буга согоот-Гэр хөндий- Хөшөөт хүн чулуу-Баян нуур-Бичигт хад-Их Маргаз уул	85	Танин мэдэхүйн АЖ
	Сумын төв-Давааны ар-Шивээт ганц мод	29	Эко АЖ
Сонгино	Сумын төв-Буган чулуу-Хиргэсүүр-Гивантий рашаан-Хуучин сумын төв-Сартуул үндэсний овоо тахилга-Тариатийн гол-Цавдан нуур	140.06	Эмчилгээний болон эко АЖ
Тосонцэнгэл	Сумын төв-Хошууны голын аялал жуулчны бааз-Бор үр аялал жуулчны бааз-Халуун усны рашаан-Хошууны эхийн рашаан сувилал-Ойлгой нуур	99.67	Эмчилгээний АЖ
Түдэвтэй	1.Сумын төв-Хутагтын газар-Шавар эмчилгээ-Ойгон нуур-Дилав хутагтын төрсөн газар-Ар гэгээнтэн Дамдинжавын төрсөн газар-Ойгон бригад-Жалханз хутагт Дамдинбазарын төрсөн газар- Зүрх чулуу	102.89	Танин мэдэхүйн болон эмчилгээний АЖ
	Сумын төв-Нуралтын хавцал-Хунт нуур-Ерөнхийлөгч Очирбатын төрсөн газар	64.69	Танин мэдэхүйн АЖ
Тэлмэн	Сумын төв-Замбага аялал жуулчны бааз-Тэлмэн нуур-Гангын булаг-Бүст нуур	113.61	Агнуурын болон эко АЖ
Тэс	Сумын төв-Түрэгийн бичээс-Хиргисүүр-Сүмийн туурь-Сэмжит хад-Цацтай агуй	37	Танин мэдэхүйн АЖ
	Сумын төв-Лансын агуй-Нисэхийн шугуй-Арц суурийн боомт-Зосон зураг/ Хүрлийн үеийн/-Дуут чулуу-Барчгар хадны зураг-сумын төв	91	Танин мэдэхүйн АЖ
Ургамал	Сумын төв- Гүн нуур, Цайдам нуур- Зөөхий нуур	30.3	Эко АЖ
	Сумын төв- Харцагтын улааны бөгс хад- Зуух хад	18.1	Эко АЖ
	Сумын төв- Гүн нуур- Шийр хайрхан- Баян улаан рашаан	49.3	Морин болон тэмээн аялал
Цагаанхайрхан	Сумын төв- Бэрхийн уул- Яглайн хөндий- Бэрх цахир	53.06	Агнуурын АЖ
	Сумын төв- Биндэр хайрхан	21.73	Эко АЖ
	Сумын төв- Хуримтын зүүн нуруу- Отгон улаан уул-Уужим салааны гол	45.87	Агнуурын АЖ
Цагаанчулуут	Сумын төв- Авгай чулуу- Түрэгийн үеийн чулуун хөшөө	37.15	Танин мэдэхүй АЖ
	Сумын төв-Бага Отгон тэнгэр- Адууны мөртэй чулуу- Алаг эрэг	44.2	Спортын болон эко АЖ
Цэцэн-Уул	Сумын төв-Цэцэн нуур-Хунгай-Хөдөөнуур-Боргио	97.99	Эко АЖ
	Сумын төв-Түлэнхийн рашаан-Хярын рашаан	34.38	Эмчилгээний АЖ
Шилүүстэй	Сумын төв- Милова богдын төрсөн газар- Уртын	93	Танин мэдэхүй АЖ

	чандмань- Шар хөтөл- Суварга (туурь)- Буган хөшөө- Гарьдийн даваа		
	Сумын төв- Норованчины төрсөн газар- Гэгээн овоо	19	Танин мэдэхүйн АЖ
	Сумын төв- Мандал нуур- Норованчины туурь- Улаан боом	55	Танин мэдэхүйн АЖ
Эрдэнэхайрхан	Сумын төв- Мухартын гол- Их хатавч- Сэмжит хад- Хар нуур- Бөөрөнхий чулуу	93.44	Агнуур болон эко АЖ
	Мухартын гол- Хар нуур тэмээн аялал	21.3	Эко АЖ
	Сумын төв- Сэгс уул- Их хайрхан 208 агуй	73.05	Эко АЖ
	Сумын төв-Нарийн гол-Хар нуур	47.67	Тэмээн аялал
Яруу	Сумын төв- Хаг нуур- Онгоцны буудал	60.01	Эко АЖ
	Сумын төв-Байцийн эх- Хулгайчийн үүр	53.93	Эко АЖ
	Сумын төв-Бугат нуур-Хаг нуур	65.73	Эко АЖ



Зураг 196. Алдархаан сумын аялал жуулчлалын төлөвлөлт


Баянтэс сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:350 000

Зураг 197. Баянтэс сумын аялал жуулчлалын төлөвлөлт

Дөрвөлжин сумын аялал жуулчлалын төлөвлөлт




Масштаб 1:500 000

Зураг 198. Дөрвөлжин сумын аялал жуулчлалын төлөвлөлт




### Завханмандал сумын аялал жуулчлалын төлөвлөлт




Зураг 199. Завханмандал сумын аялал жуулчлалын төлөвлөлт

### Сантмаргац сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Зураг 200. Сантмаргац сумын аялал жуулчлалын төлөвлөлт


### Сонгино сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:350 000

Зураг 201. Сонгино сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг


### Ургамал сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:300 000


Зураг 202. Ургамал сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг

### Цагаанхайрхан сумын аялал жуулчлалын төлөвлөлт




Зураг 203. Цагаанхайрхан сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг

### Эрдэнэхайрхан сумын аялал жуулчлалын төлөвлөлт




Зураг 204. Эрдэнэхайрхан сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг

Их-Уул сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Зураг 205. Их-Уул сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг

Нөмрөг сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Зураг 206. Нөмрөг сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг

Отгон сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:600 000

Зураг 207. Отгон сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг


Тосонцэнгэл сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:400 000

Зураг 208. Тосонцэнгэл сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг


Түдэвтэй сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:450 000

Зураг 209. Түдэвтэй сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг

Тэлмэн сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:450 000

Зураг 210. Тэлмэн сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг

Тэс сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:250 000

Зураг 211. Тэс сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг


Цагаанчулуут сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:270 000

Зураг 212. Цагаанчулуут сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг

Шилүүстэй сумын аялал жуулчлалын төлөвлөлт



Масштаб 1:300 000

Зураг 213. Шилүүстэй сумын аялал жуулчлалын төлөвлөлтийн зураг



## ТАВ. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

Үндэслэл: УИХ-ын баталсан “Усны тухай хууль” 2012 он, УИХ-ын баталсан “Ус-Үндэсний хөтөлбөр” 2010 он, “Монгол улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө” ЗГ-ын 2013 оны 38-р тогтоол, Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51/75 дугаар хамтарсан тушаал “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийг тус тус үндэслэн хамгаалалтын бүс, түүнийг хэрэжүүлэх арга хэмжээг төлөвлөсөн.

### 5.1 УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Завхан аймаг нь усзүйн сүлжээгээр Хойт мөсөн далайн ай сав, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагддаг. Хойт мөсөн далайн ай савд Идэрийн гол, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд Тэсийн гол, Хүнгүйн гол, Байдраг голууд орж байна. Монгол орны нутаг дэвсгэрийг 29 усны ай савд хуваасанаас Завхан аймгийн нутаг дэвсгэр нь 4 голын ай савд хамаарагдаж байна.

- Идэр голын сав
- Увс нуур-Тэс голын сав
- Хяргас нуур-Завхан голын сав
- Дэлгэрмөрөн голын сав

Гадаргын усны нөөцөөр хамгийн их нь Увс нуур-Тэс голын сав, хамгийн нөөц байгатай нь Хяргас нуур-Завхан голын сав газар байна. Харин газрын доорхи боломжит усны нөөцөөр хамгийн их нь Хяргас нуур-Завхан голын сав, хамгийн нөөц багатай нь Идэрийн голын сав газар орж байна. Эндээс Завхан аймгийн хэмжээгээр гадаргын усны сүлжээ их байдаг ч усны нөөц баруун бүсийн хэмжээнд бага байгаа нь харагдаж байна. Иймд усны нөөцийг хамгаалах бодлого боловсруулах, гадаргын усанд хамгаалалтын бүс төлөвлөж, ашиглалтыг хязгаарлах бодлого барих нь зүйтэй юм.

Хүснэгт 135. Голын сав газруудын усны нөөцийн мэдээлэл

№	Сав газрын нэр	Нөөц тогтоосон он	Гадаргын усны нөөцийн нийт хэмжээ, сая.м <sup>3</sup> /жил	Гадаргын усны боломжит нөөцийн хэмжээ, сая.м <sup>3</sup> /жил	Газар доорх усны боломжит нөөцийн хэмжээ, сая.м <sup>3</sup> /жил
1	Увс нуур-Тэс	2010	1599.000	64.000	405.000
2	Хяргас нуур-Завхан	2010	599.000	45.000	892.000
3	Идэр	2010	710.000	53.000	129.000
4	Дэлгэрмөрөн	2010	1080.000	81.000	229.000

#### Идэрийн голын ай сав:

Идэрийн гол нь Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр уулын ар хажуугаас эх авч, 452 км урсдаг, 30 гаруй гол горхи цутгадаг томоохон голын нэг юм. Идэрийн голын сав газар нь байгалийн мужлалаар Хангайн уулт өндөрлөгийн төв хэсгийн өндөр уулын ян сарьдагийн дэд мужид багтах бөгөөд гүн хөндий, эгц цавчим хажуу бүхий өндөр уулууд нь Идэрийн голын эхээр далайн түвшинээс дээш 4031 м хүртэл өндөрт байдаг (Үндэсний атлас, 2009). Сав газарт Завхан аймгийн Идэр, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул сумдын нутаг дэвсгэр ба Хойд мөсөн далайн ай савд

багтана. Идэр голын савын дэвсгэр нутагт Жаргалант, Тарвагатай, Дунд, Эхэн, Зарт, Цэцүйх, Харзат, Нүхт, Шумуултай, Гунз зэрэг олон там, жижиг голууд цутгана.

Голын голдирол нь Тосонцэнгэл сумын төв хүртэл тахирлаж, хэд хэд салаалдаг тул төдийлэн өргөн биш, 10-15 м, үндсэн голоороо 40-60 м өргөнтэй урсдаг. Тосонцэнгэлээс доош 80-100 хүртэл өргөснө (Монгол орны гадаргын ус, 2009). Идэр голын урсацын 20-30 хувь нь газрын доорхи ус, 25 хувь нь хайлсан цас, 45-55 хувь нь борооны усаар тэжээгддэг.

Олон жилийн дундаж урсац Идэр сум орчимд 7,8 м<sup>3</sup>/с, Тосонцэнгэл сум орчимд 16,3 м<sup>3</sup>/с болж нэмэгдэж байна. Голын савд усны нөөц харьцангуй их учир 7-9 саруудад хамгийн их урсац ажиглагддаг.

Хүснэгт 136. Идэр голын урсацын хуваарилалт

Идэр голын үзүүлэлт	Олон жилийн дундаж		Их устай байсан жил /1990 он/		Хамгийн бага устай байсан жил /2004 он/	
	Жилийн дундаж урсац	Нөөц, сая м <sup>3</sup> /жил	Жилийн дундаж урсац	Нөөц, сая м <sup>3</sup> /жил	Жилийн дундаж урсац	Нөөц, сая м <sup>3</sup> /жил
Идэр сум орчимд	7,4	234,6	18,5	584,1	2,2	69,6
Тосонцэнгэл сум орчимд	16,3	514,8	59,7	1883,4	4,0	126,1

Идэр голын уснаас авч болох усны хэмжээг голын усны дунд хэсгийн олон жилийн дундаж урсацын 5- 8 хувь гэж тогтоосон байдаг (Монгол орны гадаргын ус, 1999). Энэ хэмжээгээр авч үзвэл Тосонцэнгэл орчимд 0,81-1,3 м<sup>3</sup>/с буюу жилд 25,7-41,2 сая м<sup>3</sup> ус авч болохоор байна.

#### Хяргас нуур-Завхан голын сав:

Сав газарт Завхан аймгийн Алдархаан, Баянхайрхан, Дөрвөлжин, Завханмандал, Нөмрөг, Отгон, Сантмаргац, Сонгино, Түдэвтэй, Тэлмэн, Улиастай, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумд хамрагдаж байна.

Сав газрын хамгийн урт урсах үндсэн гол нь Завхан гол бөгөөд Хангайн нуруунаас эх авч, түүний гол нурууны хажуу хормойг хаяалан урсаж, Хяргас нуурт цутгадаг. Голын эхэндээ уулархаг, дунд хэсэгтээ говийн бэсрэг уул, толгодоор, адаг хэсэгтээ элсэн манханаар олон салаалан урсдаг байна.

Тус сав газарт Завхан гол, Тээлийн гол, Хүнгүй гол, Галуут гол, Гүн нуур, Холбоо нуур, Баян нуур, Ойгон нуур, Тэлмэн нуурууд хамрагдаж байгаа бөгөөд гадаргын усны ашиглаж болох боломжит нөөц нь 45 сая м<sup>3</sup>/жил, бага устай жил 23 сая м<sup>3</sup>/жил байна (Хяргас нуур-Завхан голын сав газрын усны нөөц, ус ашиглалтын суурь судалгаа, 2013) .

Уг савд багтаж байгаа Завхан аймгий нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын доорхи усны ордуудын үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 137. Хяргас нуур-Завхан голын сав газрын газрын доорх усны ордуудын гидрогеологийн үзүүлэлтүүд

№	Сумын нэр	Цооногийн ундарга, л/с	Түвшний бууралт, м	Шүүрлийн итгэлцүүр, м/хоног
1	Цагаанчулуут	1,0-3,0	6,2-8,8	0,55-2,2
2	Нөмрөг	3,3-10,0	10,0-14,2	2,15
3	Отгон	1,0-9,0	0,99-3,01	5,7-9,9
4	Улиастай	21,4-28,57	0,85-3,05	31,18-32,09 75,31-106,74



Зураг 214. Завхан аймгийн усны сав газар

Байгаль орчны яамны гаргасан судалгаагаар Завхан аймаг нь гадаргын усны сүлжээ ихтэй боловч, цэвэр усны нөөцөөр Монгол улсын хэмжээнд гадаргын болон гүний усны нөөцөөр бага аймагт багтаж байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын нийт гадаргын усны нөөцийн 0,12 хувь, ул хөрсний усны 0,16 хувийг Завхан аймаг бүрдүүлж байна (Байгаль орчны мэдээллийн сан [www.eic.mn](http://www.eic.mn)).

Хүснэгт 138. Монгол улсын усны нөөцөд Завхан аймгийн эзлэх хэмжээ

№	Аймгийн нэр	Гадаргын усны нийт нөөц, км <sup>3</sup>	Ул хөрсний усны нийт нөөц, км <sup>3</sup>	Тооллогод авсан огноо
1	Архангай	283.000	1.060	05.02.02
2	Баян-Өлгий	239.000	1.050	05.02.03
3	Баянхонгор	45.000	10.000	05.02.04
4	Булган	175.000	50.000	05.02.05
5	Говь-Алтай	58.000	10.000	05.02.06
6	Говьсүмбэр	1.000	1.000	05.02.23
7	Дархан-Уул	44.000	1.000	05.02.22
8	Дорноговь	5.000	10.000	05.02.07
9	Дорнод	151.000	30.000	05.02.08
10	Дундговь	12.000	8.000	05.02.09
11	<b>Завхан</b>	<b>3.160</b>	<b>1.040</b>	05.02.10
12	Өвөрхангай	56.000	10.000	05.02.11
13	Өмнөговь	38.000	1.000	05.02.12
14	Орхон	5.000	1.000	05.02.21
15	Сүхбаатар	14.000	3.000	05.02.13
16	Сэлэнгэ	3.200	97.000	05.02.14
17	Төв	191.000	59.000	05.02.15
18	Увс	1.200	23.000	05.02.16
19	Улаанбаатар	77.000	30.000	05.02.20
20	Ховд	1.100	25.000	05.02.17
21	Хөвсгөл	659.000	249.000	05.02.18


22	Хэнтий	669.000	270.000	05.02.19
<b>Монгол улсын нийт</b>		<b>2730.660</b>	<b>648.150</b>	

	Их нөөцтэй
	Дунд зэрэг нөөцтэй
	Бага нөөцтэй

2011, 2015 онуудад Завхан аймгийн гадаргын усны тооллого хийгдсэн бөгөөд 306 гол горхи, 100 нуур тойром, 467 булаг харз, 14 рашаан, 8 услалтын систем, 4 усан цахилгаан станц тоологдсон байна (Байгаль орчны мэдээллийн сан, 2011-2015 он).

Хүснэгт 139. Завхан аймгийн гадаргын усны мэдээлэл

№	Сумын нэр	Гол горхи		Нуур, тойром		Булаг харз		Рашаан		Услалтын систем		Усан цахилгаан	
		Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Устай	Тоологдсон	Ашиглалттай	Тоологдсон	Ашиглалттай
1	Алдархаан	23	23	4	4	61	61	1	1	6	3	1	1
2	Асгат	3	3	-	-	2	2	-	-	-	-	-	-
3	Баянтэс	64	64	-	-	39	39	-	-	1	-	-	-
4	Баянхайрхан	14	14	6	6	32	32	-	-	-	-	-	-
5	Дөрвөлжин	2	2	2	2	5	5	2	2	-	-	-	-
6	Завханмандал	2	2	-	-	2	2	1	1	-	-	1	1
7	Идэр	12	12	20	20	3	3	-	-	-	-	-	-
8	Их-Уул	38	38	-	-	20	20	2	2	-	-	-	-
9	Нөмрөг	12	12	17	17	12	12	1	1	-	-	-	-
10	Отгон	22	22	20	20	22	22	2	2	1	1	-	-
11	Сантмаргац	4	4	3	3	1	1	1	1	1	1	-	-
12	Сонгино	6	6	-	-	14	14	-	-	1	1	-	-
13	Тосонцэнгэл	26	26	1	1	2	2	2	2	1	1	-	1
14	Түдэвтэй	9	9	1	1	21	21	-	-	1	1	-	-
15	Тэлмэн	10	10	3	3	42	42	-	-	1	1	-	-
16	Тэс	1	1	-	-	12	12	-	-	-	-	-	-
17	Ургамал	3	3	4	4	2	2			1	1		
18	Цагаанхайрхан	9	9	1	1	33	33						
19	Цагаанчулуут	4	4	1	1	11	11						
20	Цэцэн-Уул	6	6	6	6	39	39			1	1	1	1
21	Шилүүстэй	10	10	3	3	44	44	2	2				
22	Эрдэнэхайрхан	9	9	5	5	21	21						
23	Яруу	17	17	3	3	27	27			1	1		
24	Улиастай												
<b>Аймгийн нийт</b>		<b>306</b>	<b>306</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>467</b>	<b>467</b>	<b>14</b>	<b>14</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>4</b>



Зураг 215. Завхан аймгийн усзүйн сүлжээ

## 5.2 УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН АШИГЛАЛТ


Газрын тухай хуульд зааснаар усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, мөрөн, гол, горхи, булаг, шанд, мөнх цас, мөсөн голын эзэлж байгаа газар хамаарна гэж заасан байдаг.

Завхан аймгийн нийт нутаг дэвсгэрийн 0,98 хувь буюу 81045га талбайг усны сан бүхий газар эзэлж байна. Үүнээс 63,4 хувь буюу 51045 га талбайг гол, 36,6 хувь буюу 29491 га талбайг нуур цөөрөм, тойром эзэлж байна.

Хүснэгт 140. Усны сан бүхий газрын талбай, 2016 он

№	Усны сан бүхий газрын дэд ангилал	Талбай, га		5 жилийн өөрчлөлт
		2011 он	2016 он	
1	Гол мөрөн	54045	51045	0
2	Нуур, цөөрөм, тойром	30000	29491	-509
<b>Нийт дүн</b>		84045	80536	-509

Дээрх хүснэгтээс харахад гол мөрөнгийн эзлэх талбайд өөрчлөлт оруугүй ба нуур, тойромын эзлэх талбай нь 5 жилийн дотор 509 га-гаар буюу 0,63 хувиар буурсан байна.



Диаграмм 78. Завхан аймгийн усны сан бүхий газрын талбайн өөрчлөлт

### 5.3 УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ


Аймгийн усны сан бүхий газарт төлөвлөлт хийдээ БХБЯ-ны Сайдын 2007 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан "Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар"-ыг баримтласан бөгөөд усны хамгаалалтын бүсүүдийг холбогдох хууль тогтоомжид заасан хамжээгээр зурагласан.

Мөн ЗГ-ын 2013 оны 38-р тогтоол "Монгол улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө"-нд сумын төвийн хүн амын унд-ахуйн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоох, усны сан бүхий газруудын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоох, гол мөрний урсац бүрэлдэх эхийн хамгаалалтын бүсийг тогтоох, ажлыг 2014-2021 оны хугацаанд хийхээр тусгасан байна.

Усны тухай хуульд зааснаар усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газарт онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрт эрүүл ахуйн бүс, рашаанд эрүүл ахуйн болон хориглох бүс тогтоон төлөвлөсөн.

Хүснэгт 141. Хамгаалалтын бүсийн хэмжээ

Гадаргын ус	Хамгаалалтын бүсийн төрөл	Хэмжээ, метр	Эрхзүйн баримт бичиг
Худаг	Эрүүл ахуйн бүс	100	Усны тухай хууль"-ийн 33-р зүйлийн 1 заалт
Рашаан	Эрүүл ахуйн бүс	100	Усны тухай хууль"-ийн 22-р зүйлийн 10.1 заалт
	Хориглох бүс	200	Усны тухай хууль"-ийн 22-р зүйлийн 10.2 заалт
	Хязгаарлах бүс	Усны мэргэжлийн байгууллага тогтооно.	Усны тухай хууль"-ийн 22-р зүйлийн 10.2 заалт
Гол, нуур, мөрөн	Онцгой хамгаалалтын бүс	50	Усны тухай хууль"-ийн 22-р зүйлийн 2 заалт
	Энгийн хамгаалалтын бүс	200	Усны тухай хууль"-ийн 22-р зүйлийн 3 заалт



Зураг 216. Усны сан бүхий газрын төлөвлөлт

Гадаргын усны хамгаалалтын бүс нь нийт нутаг дэвсгэрийн 5,8 хувь буюу 483720,4 га талбайг хамгаалалтын бүс эзэлж байна. Гадаргын усны бохирдол, нөөцийг хомсдохоос сэргийлэх зорилгоор хамгаалалтын бүсэд байгаа газар ашиглалтуудыг шилжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.

Хүснэгт 142. Хамгаалалтын бүсийн талбай

Гадаргын ус	Хамгаалалтын бүс	Хэмжээ, м	Талбай, га
Гол	Онцгой хамгаалалтын бүс	50	89337,62
	Энгийн хамгаалалтын бүс	200	360863,78
Нуур	Онцгой хамгаалалтын бүс	50	5272
	Энгийн хамгаалалтын бүс	200	24259,2
Булаг	Эрүүл ахуйн бүс	100	797,56
	Хориглох бүс	200	3190,24
Худаг	Эрүүл ахуйн бүс	100	

### **Хамгаалалтын бүсүүдийн дэглэм:**

Усны тухай хууль болон Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51/75 дугаар хамтарсан тушаал “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийг баримтлан усны сан бүхий газрын хамгаалалтын бүсүүдэд дараахь үйл ажиллагаануудыг явуулах болон газар олгохыг хориглоно.

Хүснэгт 143. Хамгаалалтын бүсийн дэглэм

Гадаргын ус	Хамгаалалтын бүсийн төрөл	Хориглох үйл ажиллагаа
Худаг	Эрүүл ахуйн бүс	<ul style="list-style-type: none"> <li>Унд, ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног ерөмдөх</li> <li>Хөрсөнд төрөл бүрийн бордоо хэрэглэх</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис хадгалах</li> <li>Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барих</li> <li>Байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөөгүй бордоо ашиглан таримал ургамал тарих, бодис, арга технологи хэрэглэн хөнөөлт шавьж, мэрэгчийг устгах.</li> </ul>
Рашаан	Эрүүл ахуйн бүс	<ul style="list-style-type: none"> <li>Рашаан шууд авч ашиглахаас өөр зориулалтаар барилга байгууламж барих, тоног төхөөрөмж суурилуулах</li> <li>Хог хаягдал хаях, химийн бодис хадгалах.</li> </ul>
	Хориглох бүс	<ul style="list-style-type: none"> <li>Газар тариалан эрхлэх</li> <li>Мал бэлчээрлүүлэх</li> <li>Хадлан бэлтгэх</li> <li>Хог хаягдал хаях, хадгалах, бохирын цооног байгуулах</li> </ul>
	Хязгаарлах бүс	<ul style="list-style-type: none"> <li>Ус, рашаан ашиглахтай шууд холбоогүй барилга байгууламж барих</li> <li>Хог хаягдлын болон хаягдал ус зайлуулах байгууламж, цэг байрлуулах, нефтийн бүтээгдэхүүн, химийн бодис хадгалах</li> </ul>
Гол, нуур, мөрөн	Онцгой хамгаалалтын бүс	<ul style="list-style-type: none"> <li>Барилга, байгууламж барих</li> <li>Газар хагалах</li> <li>Газар тариалан эрхлэх</li> <li>Тэсэлгээ хийх</li> <li>Ашигт малтмал хайх, олборлох</li> <li>Зэгс, шагшуурга, мод огтлох</li> <li>Элс, хайрга, чулуу авах</li> <li>Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх</li> <li>Мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах</li> </ul>
	Энгийн хамгаалалтын бүс	<ul style="list-style-type: none"> <li>Үйлдвэр, барилга байгууламж /цэвэрлэх байгууламж, нефть бааз, цахилгаан станц/ барьж ашиглах</li> <li>Химийн хорт бодис, төрөл бүрийн бордоо, цацраг идэвхт бодис болон түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах</li> <li>Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг ашиглах, барилгын карьер гаргах</li> <li>Мод бут огтлох, эрэг гулдиралыг эвдэх</li> <li>Гахай, шувууны байр, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх</li> <li>Шатахуун түгээх станц байгуулах</li> <li>Ахуйн бохир уснаас бусад төрлийн бохир ус цэвэрлэх төхөөрөмж, шүүх талбай барих</li> </ul>

#### **5.4 УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТ, АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЕ ШАТУУД, ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ**

Усны ай сав, усан хагалбарын доторх газар нутгаас угагдсан туугдас нь биогеохимийн элементүүд усны хөвөө газарт тогтох ба зарим хэсэг уст цэгүүд орж улмаар усны болон усны хөвөө газрын биологийн төрөл зүйлсийн хүн тэжээл, амьдрах орчныг баяжуулж, ус сэлгэх явцад найрлага төрөл тоо хэжээ нь зохицуулагдаж байдаг. Усны хөвөө газар нь зэрлэг ан амьтан, мал сүрэг усанд орох



сэрүүцэх үедээ түр саатан тогтох нутаг болдог. Тэрчлэн бэлчээрийн мал аж ахуйн нөхцөл дулааны улирлын нутгийн гол цөм нь болдог онцлогтой. Усны хөвөө газрын ашиглалтын хэлбэр, ашиглалтын горим, ялангуяа ургамалжилт нь нуур тойром, гол горхины усны урсгал болон ус сэлэх чадавх усны чанар найрлагад нөлөөлдөг бол усны урсгал, ус сэлгэх чадавх хэлбэр маяг нь усны хөвөө газрын биологийн төрөл зүйлийн нэр төрөл, тоо хэмжээ ялангуяа ургамлын бүрэлдэхүүн, ургамлан нөмрөгийн хэв шинж бүрэлдэхүүн чанар зэрэгт нөлөөлдөг.

Усалгааны эх үүсвэрт гадаргуугийн усыг өргөн ашиглаж байна. Гадаргын ус нутаг дэвсгэртээ харилцан адилгүй тархах тул зарим усны эх үүсвэрийн нөөц нь усалгаанд хүрэлцэхгүй тохиолдол нилээд тохиолдоно. Иймд усан сан, цөөрөм байгууламж, усыг хуримтлуулан ашиглах нь усны нөөцийг нэмэгдүүлэн усалгааны хэрэгцээг найдвартай хангах үндэс нь болно.

Манай орны голуудын урсацын ихэнх нь хур борооны уснаас бүрддэг учраас зуны үерийн ус болон хаврын шар усны үерийн усыг хуримтлуулан усалгаанд ашиглахад голлон анхаарвал зохино.

- Жижиг гол горхийн урсацад тохируулга хийж хэрэглээний усыг хуримтлуулах
- Хуучин ашиглаж байсан усан сан, цөөрмийг сэргээх
- Хаврын шар ус, зуны борооны ус хуримтлуулах сан, цөөрөм байгуулах
- Баян бүрдүүдийг сэргээх
- Гол гоорхийн хөндийн мод, бут, сөөг, хөрс, ургамлын бүрхэвчийг хамгаалах, нөхөн сэргээх
- Усалгаанд ашигласан илүүдэл усыг эргүүлэн ашиглах
- Усны эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах зэрэг болно

Ус ашиглагч байгууллага нь тухайн эх үүсвэрт өөрийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөлөлд нарийвчилсан үнэлгээ хийлгэж, экологийн урсацын хэмжээг тогтоох, хэрвээ авч ашиглах усны хэмжээ хүрэлцэхгүй, экологийн урсацын зарим хэсгийг бага хугацаанд ашиглахад хүрвэл ус хуримтлуулж, нөөцөлж ашиглах хувилбарыг сонгож, ялангуяа хуурай улиралд дутагдал усыг нөхөх эзлэхүүн бүхий усан сан, цөөрөм байгуулах замаар голын экологийн нөхцлийг хангах шаардлагатай байна.

Усны эх үүсвэрээс усыг эмх замбараагүй, их хэмжээгээр авч ашигласнаар усны түвшин буурах, горим нь алдагдах, улмаар нөөц нь хомсдох, бүр ширгэж алга болох зэрэг нөлөөллүүд гарах магадлалтай. Мөн тухайн орон нутгийн гол, горхи, нуурын загас, шувуу, усны амьтан ургамлын төрөл зүйл хорогдоход хүрдэг. Иймд усыг авахдаа орчны экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр батлагдсан хэм хэмжээг /урсацын 5-10%/ баримтлах шаардлагатай.

Хүснэгт 144. Монгол улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд 2014-2021 онд Завхан аймагт төлөвлөгдсөн арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр
1. Хүн амыг баталгаат, эрүүл аюулгүй усаар хангах үндсэн зорилтын хүрээнд:						
1.2	Усны нөөцийн эрэл хайгуул хийж, нөөцийг баталгаажуулах	Аймгийн төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийг шинэчилж, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулж	БОНХЯ	ЭЗХЯ, СЯ, СГЗ	2014-2021	Улсын төсөв

		дотоодын хяналтыг тогтмолжуулна.				
1.4	Бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр байгуулах, шинэчлэх, өргөтгөх	Аймгийн төвүүд, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэнэ.	БХБЯ	БОНХЯ, ЭЗХЯ, СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
1.7	Батлан хамгаалах салбарын анги, нэгтгэл, хилийн боомтуудын ус хангамжийг сайжруулах	Завхан аймгийн Сонгино сумын Хил хамгаалах ерөнхий газрын харъяа хилийн цэргийн харуул, анги, заставын ус хангамжийг сайжруулах, усны чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, худаг, уст цэгийг шинээр барьж ашиглалтад оруулна.	БХЯ, БОНХЯ	ЭЗХЯ, СЯ	2014-2021	Улсын төсөв
1.8	Сумын төвүүдийн хүн амын унд-ахуйн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ.	Сумын төв, хөдөөгийн ус хангамжийн эх үүсвэрүүдэд онцгой болон энгийн, эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ. Нийт 560 булаг шандын эхийг хашиж хамгаална.	БОНХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	ЭМЯ, СЯ, МХЕГ, ОБЕГ, СГЗ	2014-2021	Орон нутгийн төсөв
1.9	Сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийж, усны нөөцийг тогтоох	2021 он дуустал 36 сумын төвд, 3380 цэгт газрын доорхи усны хайгуул судалгаа хийнэ.	аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	БОНХЯ, ЭЗХЯ, СЯ	2014-2021	Улсын төсөв
1.10	Сумын төв, хөдөөгийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх	2021 он дуустал 36 сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийг шинэчилнэ.	БХБЯ, ҮХААЯ	ЭЗХЯ, СЯ, ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
1.11	Сумдын төвд бохир ус цэвэрлэх бага оврын байгууламж шинээр барих, цэвэрлэсэн усыг дахин ашиглах шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх	2021 он дуустал 36 сумын төвд бохир ус цэвэрлэх бага оврын байгууламж шинээр барина.	БХБЯ	ЭЗХЯ, ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
1.13	Аялал жуулчлал, амралт, сувиллын газруудын ус хангамжийн нөхцлийг сайжруулах	Хот суурин газраас алслагдмал байрлах аялал жуулчлалын баазууд, зочид буудлууд болон амралт сувиллын газруудын ус хангамжийг сайжруулна.	ССАЖЯ	ЭЗХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Орон нутгийн төсөв -Хувийн болон бусад
1.14	Аялал жуулчлал, амралт сувиллын газруудад бохир ус цэвэрлэгээний шинэ дэвшилтэт	Хар-Ус нуурын орчим жуулчны баазуудад бага оврын ус хангамж, ариутгах татуургын байгууламж, бохир ус	ССАЖЯ	ЭЗХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн	2014-2021	Хувийн болон бусад

	технологийг нэвтрүүлэх	цэвэрлэгээний шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.		н ЗДТГ, СГЗ		
1.15	Рашаан түшиглэн амралт, сувиллын үйлчилгээг хөгжүүлэх	Шинээр нийт 12 рашааны ашиглалтыг сайжруулан, сувиллын чиглэлээр ашиглана.	ЭМЯ	ЭЗХЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Хувийн болон бусад
3. Үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний салбарыг хэрэгцээт усаар хангах үндсэн зорилтын хүрээнд:						
3.11	Усан цахилгаан станцын усны горимд байнгын хяналт тавих	Усан цахилгаан станцуудын усан сангийн үйл ажиллагаанаас голын усны горимд нөлөөлөх нөлөөлөлд хяналт тавина.	СГЗ	БОНХЯ, СЯ	2014-2021	Улсын төсөв
3.12	Одоо байгаа болон шинээр байгуулагдах дулааны цахилгаан станцын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх	Шинээр байгуулагдах ДЦС-уудын усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа хийж шинэ эх үүсвэрүүд байгуулна	ЭХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
4. Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах, усны нөөцийг хамгаалах үндсэн зорилтын хүрээнд:						
4.1	Гол мөрний урсац бүрэлдэх эхийн хамгаалалтын бүсийн дэглэмийг тогтоож, мөрдүүлэх	Монгол орны гадаргын усны нөөцийн 70 хувь бүрдэх сав газрын эхэд хамаарах хэсгийг улсын болон орон нутгийн хамгаалалтад авч, ой, ургамлан нөмрөгийг нөхөн сэргээх ажлыг хийнэ. (Завхан, Идэр, Тэс голууд)	БОНХЯ, СГЗ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв
4.2	Усны сан бүхий газруудын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, мөрдүүлэх	Усны сан бүхий газруудын хамгаалалтын бүсийг тогтоож, тэмдэгжүүлнэ.	БОНХЯ, СГЗ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв
4.5	Хот, суурины эзэмшил газарт хамаарах голын эргийг тохижуулах	Хот суурин газрын суурьшлын бүс дэх голын эргийн дагуух орчны бохирдлыг бууруулах ажлыг зохион байгуулна.	БХБЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв
4.7	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах	Бохирдуулагч эх үүсвэрүүдийг тооллого судалгаа хийнэ.	БОНХЯ	СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв
4.9	Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах	Хот, суурины газруудын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулна.	БОНХЯ, БХБЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж -Хувийн болон бусад

4.10	Томоохон голуудын экологийн урсацыг тодорхойлох судалгаа хийх	Монгол орны томоохон голууд болох Завхан, Идэр, Тэс голуудын экологийн урсацыг тодорхойлох судалгаа хийнэ.	БОНХЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	-Улсын төсөв -Гадаадын зээл тусламж
4.14	Хүний буруутай үйл ажиллагааны улмаас газрын доорх усны түвшин буурахаас урьдчилан сэргийлэх	Газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, уст цэгийн орчмын ногоон байгууламжийг сайжруулна.	БОНХЯ	БХБЯ, ҮХААЯ, ССАЖА, УУЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, СГЗ	2014-2021	Улсын төсөв
4.15	Байгалийн горим эвдэгдсэн, бохирдсон голуудын голдрилд үзлэг хийж, нөхөн сэргээх	Голын голдрилд, татам, хөндийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан, байгалийн горим алдагдсан газруудад нөхөн сэргээлт хийж, усны нөөцийг хамгаална.	БОНХЯ, СГЗ	ҮХААЯ, УУЯ, СЯ, МХЕГ, ОБЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Хувийн болон бусад
4.16	Экологийн өөрчлөлтөнд орж буй гол, нууруудыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, нөхөн сэргээх арга хэмжээ авах	Усны сав газар дахь ой, ус, намгархаг газруудыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, нөхөн сэргээх арга хэмжээ авна.	БОНХЯ, СГЗ	ҮХААЯ, УУЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	-Улсын төсөв -Орон нутгийн төсөв -Гадаадын зээл тусламж
4.17	Үерийн хамгаалалтын байгууламжийг засварлах, шинээр байгуулах	Аймгийн төвүүд, томоохон хот суурин газруудын үерийн хамгаалалтын далан, сувгийг сэргээн засварлана.	БХБЯ	СЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2014-2021	Улсын төсөв

Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого /2009-2021/ баримт бичгийн стратеги зорилт 3-ийн хүрээнд аймгийн усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, зохистой ашиглан хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангана гэсэн зорилт тавьсан байдаг. Энэ зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг төлөвлөсөн байдаг.

- Жил бүр 60-аас доошгүй уст цэгт засвар шинэчлэлтийг үргэлжлүүлэн хийж, бэлчээр усжуулалтын түвшинг 50-аас доошгүй хувьд хүргэх;
- Хурын усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулах;
- Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоог нэмэгдүүлэх

# ЗУРГАА. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН НӨӨЦ НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

## 6.1 ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### Ойн сангийн судлагдсан байдал:

Завхан аймгийн хэмжээгээр ойн санг судлах ажлыг анх 1956-1957 онд хуучнаар ЗХУ-ын техник, мэргэжилтний тусалцаатайгаар агаарын таксацын тоймчилсон судалгааг явуулж ойн сангийн нийт талбай, тархалтын хил хязгаар, таксацын үндсэн үзүүлэлтүүдийг тогтоосон байна.

1973, 1982 онуудад Тосонцэнгэлийн Мод боловсруулах үйлдвэрийн ашиглалтын нөөц бүхий Тосонцэнгэл, Их-Уул сумдын ойн сан бүхий нутагт хэсэгчилсэн судалгаа явагдаж байсан ба 1991 онд ой бүхий сумдыг хамарсан ой зохион байгуулалтын ажлыг Завхан аймгийн хэмжээгээр хийж гүйцэтгэн ойг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах төсөл, зураглалын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнээс хойш 2006 болон 2013 онд аймгийн хэмжээнд ой зохион байгуулалт хайгуул судалгааны ажлыг “Ой, усны хайгуул судалгааны төв” хийж, төсөл зургийн ажлыг гүйцэтгэсэн байна.

2017 онд “Мөнх ногоонжодоо” ХХК аймгийн ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажлыг гүйцэтгэж, 2018-2022 оны хугацаанд баримтлах ойн төлөвлөгөө боловсруулсан байна.

### Ойн ургамалжилт:

Завхан аймгийн ойн сан нь ургамалжилтын ангиллаар “Хангайн ой-ургамалжилтын муж”-ийн “Төв хангайн хошуу”-нд хамаарагдаж уулын цармын тармаг, уулын тайгын, уулын тайганцар ой гэсэн 2 үндсэн өндрийн бүслүүрт хамаарагдаж байна.

*Уулын цармын тармаг ой* - Төв хангайн д.т.д 2200-2400 м өндөр тайгын хүлэнцэр цэвдэгт хөрсөнд тархсан бушилзат (*Kobresia mvosuroides*) шинэсэн ой хоршсон торлогт, ботууль-хөвдөт, сөөгөнцөр-хөвдөт (*Larix sibirica*, *Betula rotundifolia*, *Salix glauca*, *Juniperus pseudosabma*, *Empetrum nigrum*, *Ledum palustre*, *Arctous alpina*, *Hvlocomium splendens*, *aulacomnium palustre*) Ү чансаатай голын эхний хамгаалвал зохих шинэсэн ой.

*Уулын тайгын ойн бүслүүрт* - д.т.д 1800-2000 м өндөрт тайгын жинхэнэ цэвдэгт хөрсөнд тархсан алирс-бадаант, алирс-сургар-ногоон хөвдөт, алирс-ритидиум хөвдөт, хамгаалвал зохих шинэс оролцсон Хушин ой, д.т.д 1700-2000м өндөрт тайгын жинхэнэ цэвдэгт хөрсөнд тархсан сургар-алирс ногоон хөвдөт, алирс бадаант, алирс ритидиум хөвдөт, ашиглан хамгаалвал зохих Хуштай Шинэсэн ой,


*Уулын тайганцар ойн бүслүүр* - 1800-2200 м өндөрт бүрэн ялзмагжаагүй цэвдэгт хөрсөнд тархсан ритидиут хөвдөт (*Larix sibirica*, *Festuca ovina*, *Festuca altiaca*, *Carex amgunensis*, *Lonicera altaica*) шинэсэн ой тархсан байна. Тайгажуу шинэсэн ойн хөвхний зузаан нь 3-6 см, зарим алирс-ритидиум хөвдөт ой хамгийн их хөвхний нөөцтэй 26,2 т/га байхад хангийн бага нөөцтэй 12,3 т/га нь сорвоо-ритидиут хөвдөт ой байна. Тайгажуу шинэсэн ойн нөөц нь 200-300м<sup>3</sup>/га, заримтдаа 130-550 м<sup>3</sup>/га байна.

### Ойн таксацийн үзүүлэлт:

#### Насны бүлэг

Моддын аж ахуйн ач холбогдлыг илэрхийлэх зорилгоор насны бүлэгт хуваадаг. Моддын насны бүлэг тухайн модны биологийн онцлог, өсөлт, хөгжилт, аж ахуйн ач холбогдлоос хамаараад модны төрөл тус бүрт харилцан адилгүй байна. Аймгийн ойн санг насны бүлгээр нь авч үзвэл 85,83 хувь нь болц гүйцсэн хөгшин мод, 8,21 хувь нь

дундаж насны мод, 5,84 хувь нь болц гүйцэж яваа мод, 0,12 хувь нь залуу модод тархсан байна.



Диаграмм 79. Ойн нөөцийн насны бүлгээр тархсан байдал

Дээрх графикаас харахад болц гүйцсэн хөгшин ой зонхилон тархжээ. Иймд ойн экологи-эдийн засгийн ач холбогдол, ойн хэвийн нөхөн ургах нөхцөл боломжийг алдагдуулахгүйгээр огтлолтын зөв арга технологгоор ашиглах, ойжуулалт, ойг нөхөн сэргээх, арчилгаа, цэвэрлэгээ хийх зэрэг ойн аж ахуйн арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлэх замаар ойн санг аажмаар насны зөв жигд бүтэцтэй болгох шаардлагатай байна.

Хүснэгт 98. Байгалийн ойн талбай /га-аар/, насны бүлгээр

Модны төрөл	Насны бүлэг									
	Залуу ой		Дунд насны ой		Болц гүйцэж яваа ой		Болц гүйцсэн ой		Дүн	
	Талбай, га	Нөөц, м.куб	Талбай, га	Нөөц, м.куб	Талбай, га	Нөөц, м.куб	Талбай, га	Нөөц, м.куб	Талбай, га	Нөөц, м.куб
<b>Цармын бүслүүрийн ой</b>										
Шинэс	123	6150	878	44340	353	30520	2780	288910	4134	369920
<b>Дүн</b>	123	6150	878	44340	353	30520	2780	288910	4134	369920
<b>Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн ой</b>										
Шинэс	0	0	437	34630	679	60110	3872	440470	4988	535210
<b>Дүн</b>	0	0	437	34630	679	60110	3872	440470	4988	535210
<b>Байгалийн цогцолборт газрын ой</b>										
Шинэс	23	460	3031	262140	1703	191520	36448	4605090	41205	5059210
Хуш	0	0	0	0	813	96370	645	77950	1458	174320
Бургас	115	2050	112	1720	0	0	0	0	227	3770
<b>Дүн</b>	138	2510	3143	263860	2516	287890	37093	4683040	42890	5237300
<b>Ногоон бүсийн ой</b>										
Шинэс	0	0	6804	595740	4626	570930	57447	8164440	68877	9331110
Бургас	35	530	106	2120	0	0	0	0	141	2650
<b>Дүн</b>	35	530	6910	597860	4626	570930	57447	8164440	69018	9333760
<b>Хориотой зурвасын ой</b>										
Шинэс	424	17090	5705	613120	3227	396230	44161	6369640	53517	7396080
Хуш	0	0	0	0	517	89050	100	19000	617	108050
Гацуур	0	0	0	0	562	68580	3057	414640	3619	483220
Хус	0	0	91	4550	90	3600	0	0	181	8150
Улиас	0	0	26	7800	0	0	0	0	260	7800
Бургас	1845	25070	7068	151580	0	0	0	0	8913	176650
<b>Дүн</b>	2269	42160	13124	777050	4396	557460	47318	6803280	67107	8179950
<b>Хамгаалалтын бүсийн ой 100 га хүртэлх ой сөөг ширэнгэ уулын өвөр энгэр төгөл ой</b>										
Шинэс	43	1080	3756	394950	2132	253340	50606	7114450	56537	7763820
Хус	0	0	18	360	0	0	0	0	18	360
Бургас	18	330	79	790	20	200	0	0	117	1320
<b>Дүн</b>	61	1410	3853	396100	2152	253540	50606	7114450	56672	7765500
<b>Хамгаалалтын бүсийн ой 30 хэмээс дээш Налуу газрын ой</b>										
Шинэс	67	2010	7277	673650	1895	218450	36739	4821320	45978	5715430

Гацуур	0	0	0	0	0	0	156	23250	156	23250
Бургас	147	3080	0	0	0	0	0	0	147	3080
Дүн	214	5090	7277	673650	1895	218450	36895	4844570	46281	5741760
<b>Улсын хилийн дагуух ой</b>										
Шинэс	131	2220	3907	329230	3636	375820	23228	2920480	30902	3627750
Гацуур	0	0	0	0	0	0	302	38730	302	38730
Бургас	0	0	38	380	0	0	0	0	38	380
Дүн	131	2220	3945	329610	3636	375820	23530	2959210	31242	3666860
<b>Ашиглалтын бүсийн ой</b>										
Шинэс	230	7130	17769	1613710	8564	1013830	107069	14090280	133632	16724950
Гацуур	0	0	0	0	0	0	725	86600	725	86600
Улиангар	0	0	0	0	0	0	12	840	12	840
Бургас	0	0	40	800	0	0	0	0	40	800
Дүн	230	7130	17809	1614510	8564	1013830	107806	14177720	134409	16813190
<b>Нийт дүн</b>	<b>3201</b>	<b>67200</b>	<b>57376</b>	<b>4731610</b>	<b>28817</b>	<b>3368550</b>	<b>367347</b>	<b>49476090</b>	<b>456741</b>	<b>57643450</b>

### Ойн насны анги

Ой модод нь эдийн засгийн ач холбогдолоороо илэрхий ялгаа үзүүлэхгүй байж болох жилийн тоог насны анги гэсэн үзүүлэлтээр илэрхийлнэ. Төрөл бүрийн моддын өсөлт, хөгжилтийн эрчмээс хамаараад моддын насны анги харилцан адилгүй байдаг. Байгалийн ойн экологид үзүүлэх эерэг нөлөөг алдагдуулахгүйгээр түүнийг жигд тасралтгүй ашиглаж, мод, модон материалын байнга өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангах бололцоог нэмэгдүүлэх хамгийн гол үндэс нь насны зөв бүтэцтэй ой буй болгох үүний үр дүнд талбай, нөөцийг насны ангиар жигд байршуулах, түүнд чиглэгдсэн ойн аж ахуйн үйл ажиллагаа явуулах нь чухал байна.

### Ойн сангийн таксацийн дундаж үзүүлэлтүүд

Ой нь модны төрөл, нас, өтгөрөл, нөөц болон бусад үзүүлэлтээрээ өөр хоорондоо ялгаатай хэсгүүдээс бүрдэнэ. Нэгэнт дээрх үзүүлэлтүүдээрээ харилцан адилгүй учраас аж ахуйн ач холбогдлоороо ч, тэнд авч хэрэгжүүлвэл зохих ойн аж ахуйн арга хэмжээгээрээ бас харилцан адилгүй байна. Ойг өөр хоорондоо ижил төстэй байдлаар нь ялган тогтоох нь ойн таксацийн гол асуудлын нэг бөгөөд түүнийг таксацийн үзүүлэлтийн ялгаагаар үндсэнд нь шийддэг.

Ойн таксацийн дундаж үзүүлэлтээс үзэхэд тус сумын ойн жилийн бүх дундаж өсөлт 379015 ш.м, дундаж бонитет 4.65, дундаж өтгөрөл 0.50, ойгоор бүрхэгдсэн талбайн 1 га-ийн нөөц 126.20 шоо метр, болц гүйцсэн ойн 1 га-ийн нөөц 134.68 шоо метр, 1 га-ийн дундаж өсөлт 0.82 шоо.м байна.

*Ойн бонитет /чансаа/:* Нас, модны төрлөөрөө ижил боловч хөрс, уур амьсгалын өөр өөр нөхцөлд ургаж байгаа ой нь аж ахуй, эдийн засгийн ач холбогдлоороо ихээхэн ялгаатай байдаг учраас таксацийн үед ойн ургах орчинд өгч байгаа үнэлгээг бонитет гэсэн үзүүлэлтээр тогтоодог. Тус аймгийн ойн дундаж бонитет нь 4.65 байгаа бөгөөд байгалийн ойн талбай нь нийтдээ IY-Y бонитетын ангид хамаарч байна. Бонитетын анги доогуур байгаа нь ургамал ургалтын хугацаа богино, чийг дутагдалтай зэрэг байгаль цаг уурын хүчин зүйлс нөлөөлөхөөс гадна ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлдэггүй, түймэр хортонд их нэрвэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 99. Байгалийн ойн бонитет, талбайгаар /га/

Модны төрөл	Бонитетийн анги, талбайгаар /га/					Нийт талбай, га	Дундаж бонитет
	1	2	3	4	5		
<b>Цармын бүслүүрийн ой</b>							
Шинэс	-	-	-	63	4071	4134	4.98
Дүн	-	-	-	63	4071	4134	4.98
<b>Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн ой</b>							
Шинэс	-	-	-	49	4939	4988	4.99
Дүн	-	-	-	49	4939	4988	4.99

<b>Байгалийн цогцолборт газрын ой</b>							
Шинэс	-	-	-	8512	32693	41205	4.79
Хуш	-	-	-	-	1458	1458	5.00
Бургас	-	-	-	20	207	227	4.91
Дүн	-	-	-	8532	34358	42890	4.80
<b>Ногоон бүсийн ой</b>							
Шинэс	-	-	-	27344	41533	68877	4.60
Бургас	-	-	-	9	132	141	4.93
Дүн	-	-	-	27353	41665	69018	<b>4.60</b>
<b>Хориотой зурвасын ой</b>							
Шинэс	-	-	-	32268	21237	53505	4.39
Хуш	-	-	-	38	579	617	4.93
Гацуур	-	-	-	2694	925	3619	4.25
Хус	-	-	-	-	181	181	5.00
Улиас	-	-	-	-	260	260	5.00
Бургас	-	-	-	1484	7429	8913	4.83
Дүн	-	-	-	36484	30611	67095	4.45
<b>Хамгаалалтын бүсийн ой 100 га хүртэлх ой сөөг ширэнгэ уулын өвөр энгэр төгөл ой</b>							
Шинэс	-	-	-	24866	31671	56537	4.56
Хус	-	-	-	-	18	18	5.00
Бургас	-	-	-	4	113	117	4.96
Дүн	-	-	-	24870	31802	56672	4.56
<b>Хамгаалалтын бүсийн 30 хэмээс дээш Налуу газрын ой</b>							
Шинэс	-	-	-	13008	32970	45978	4.71
Гацуур	-	-	-	136	20	156	4.12
Бургас	-	-	-	-	147	147	5.00
Дүн	-	-	-	13144	33137	46281	4.71
<b>Улсын хилийн дагуух ой</b>							
Шинэс	-	-	-	7734	23168	30902	4.74
Гацуур	-	-	-	-	302	302	5.00
Бургас	-	-	-	-	38	38	5.00
Дүн	-	-	-	7734	23508	31242	4.75
<b>Ашиглалтын бүсийн ой</b>							
Шинэс	-	-	-	38296	95228	133524	4.71
Гацуур	-	-	-	725	-	725	4.00
Улиангар	-	-	-	-	12	12	5.00
Бургас	-	-	-	13	27	40	4.67
Дүн	-	-	-	39034	95267	134301	4.70
<b>Аймгийн нийт</b>	-	-	-	<b>157263</b>	<b>299358</b>	<b>456621</b>	<b>4.65</b>

*Ойн өтгөрөл:* Ой орон зайнхаа боломжийг хэдий чинээ бүрэн ашиглавал модны нөөц, өгөөж нь төдий чинээ их байна. Таксацад ойн орон зайн ашиглалтын түвшинг өтгөрөл гэдэг үзүүлэлтээр илэрхийлдэг. Өтгөрөл нь тухайн ойн бодит бүтээмжийн харьцангуй хэмжээг заах үзүүлэлт юм. Ургаж байгаа талбайнхаа байгалийн боломж, орон зайг бүрэн ашигласан ойг хэвийн ой гэж нэрлэдэг. Хэвийн ой орон зайгаа бүрэн ашиглан ургадаг учир модны нөөц нь нэг төрлийн тухайн нас, бонитетын ойн хувьд хамгийн их байна. Хэвийн ойн өтгөрлийг 1,0 гэж аваад түүнтэй нэг төрлийн ижил нас, бонитеттэй бусад ойн нөөцийг жишиж 0,3- 1.0 хүртэл коэффициентээр илэрхийлдэг. Аймгийн байгалийн ойн ихэнх нөөцийг 0.5-0.6 өтгөрөлтэй ой эзэлж байгаа нь нас гүйцсэн, өтөлсөн ой зонхилж байгааг харуулж байна.



Модны төрөл	Өтгөрөл, талбайгаар /га/							Нийт талбай, га	Дундаж өтгөрөл
	0,3	0,4	0,5	0,6	0,7	0,8	0,9		
<b>Цармын бүслүүрийн ой</b>									
Шинэс	889	1454	1634	157	-	-	-	4134	0.42
Дүн	889	1454	1634	157	-	-	-	4134	0.42
<b>Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн ой</b>									
Шинэс	239	1594	2051	1104	-	-	-	4988	0.48
Дүн	239	1594	2051	1104	-	-	-	4988	0.48
<b>Байгалийн цогцолборт газрын ой</b>									
Шинэс	3743	4039	24316	9107	-	-	-	41205	0.49
Хуш	-	-	1458	-	-	-	-	1458	0.50
Бургас	80	88	59	-	-	-	-	227	0.39
Дүн	3823	4127	25833	9107	-	-	-	42890	0.49
<b>Ногоон бүсийн ой</b>									
Шинэс	4005	6906	28953	27767	1246	-	-	68877	0.52
Бургас	35	32	74	-	-	-	-	141	0.42
Дүн	4040	6938	29027	27767	1246	-	-	69018	0.52
<b>Хориотой зурвасын ой</b>									
Шинэс	1705	7714	25348	17968	782	-	-	53517	0.51
Хуш	-	-	-	477	-	-	-	617	0.56
Гацуур	233	1003	1307	1076	-	-	-	3619	0.48
Хус	-	-	181	-	-	-	-	181	0.50
Улиас	-	-	-	-	-	-	-	260	0.40
Бургас	1916	3453	3127	417	-	-	-	8913	0.42
Дүн	3854	12532	30001	19938	782	-	-	67107	0.50
<b>Хамгаалалтын бүсийн ой 100 га хүртэлх ой сөөг ширэнгэ уулын өвөр энгэр төгөл ой</b>									
Шинэс	1939	5704	22870	25374	650	-	-	56537	0.53
Хус	-	-	-	-	-	-	-	18	0.60
Бургас	-	-	-	-	-	-	-	117	0.40
Дүн	1939	5818	22873	25392	650	-	-	56672	0.53
<b>Хамгаалалтын бүсийн ой 30 хэмээс дээш Налуу газрын ой</b>									
Шинэс	2714	9362	20898	11957	1047	-	-	45978	0.49
Гацуур	20	48	-	-	-	-	-	156	0.50
Бургас	-	-	-	-	-	-	-	147	0.41
Дүн	2734	9534	20921	12045	1047	-	-	46281	0.49
<b>Улсын хилийн дагуух ой</b>									
Шинэс	2819	5962	15837	6284	-	-	-	30902	0.48
Гацуур	71	-	-	-	-	-	-	302	0.45
Бургас	-	-	-	38	-	-	-	38	0.60
Дүн	2890	5962	16068	6322	-	-	-	31242	0.48
<b>Ашиглалтын бүсийн ой</b>									
Шинэс	8886	19530	69627	35163	426	-	-	133632	0.49
Гацуур	-	250	475	-	-	-	-	725	0.46
Улиангар	-	-	12	-	-	-	-	12	0.50
Бургас	-	13	27	-	-	-	-	40	0.46
Дүн	8886	19793	70141	35163	426	-	-	134409	0.49
<b>Нийт дүн</b>	<b>29294</b>	<b>67752</b>	<b>218549</b>	<b>136995</b>	<b>4151</b>	-	-	<b>456741</b>	<b>0.50</b>

### 6.1.1 Ойн сан бүхий газар

Газрын тухай хуулинд зааснаар ойн сан бүхий газар нь ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас, ойг өсгөн үржүүлэхэд зориулсан, ой тэлэн ургах боломжийг хангахуйц газраас бүрдэх ба Улсын газрын нэгдмэл сангийн

тайлангаар Завхан аймаг нь 490562,1 га ойн сан бүхий газартай ба энэ нь Монгол улсын нийт ойн сан бүхий газрын 3,4 хувийг эзэлж байна.



Хүснэгт 101. Монгол улсын ойн сан бүхий газрын талбай, га


№	Аймгийн нэр	Ойн сан бүхий газрын талбай, га	Монгол улсын ОСБГ-т эзлэх хувь
1	Хөвсгөл	4005365	28,1
2	Булган	1905007,9	13,4
3	Сэлэнгэ	1534003,8	10,8
4	Говь-Алтай	1221267	8,6
5	Хэнтий	1130081,7	7,9
6	Архангай	1082621	7,6
7	Өмнөговь	746681,8	5,2
8	Төв	573123,2	4,0
9	<b>Завхан</b>	<b>490562,1</b>	<b>3,4</b>
10	Ховд	467373,4	3,3
11	Баянхонгор	330670,8	2,3
12	Дорнод	174619,4	1,2
13	Дорноговь	158508,7	1,1
14	Өвөрхангай	150793,6	1,1
15	Увс	110217,5	0,8
16	Дархан-Уул	72034,8	0,5
17	Дундговь	68699,6	0,5
18	Баян-Өлгий	22577	0,2
19	Орхон	15884,4	0,1
20	Сүхбаатар	81,7	0,0
21	Говьсүмбэр	0	0

Газрын нэгдмэл сангийн тайлангаар ойн сан бүхий газар нь аймгийн нийт нутаг дэвсэрийн 5,9 хувийг эзэлж байгаа нь ойн нөөцөөр бага байгааг илтгэж байна.

Хүснэгт 102. Ойн сан бүхий газрын талбайн өөрчлөлт, ГНС-ийн тайлангаар

№	Ойн сан бүхий газрын дэд ангилал	2013 он	2014 он	2015 он	2016 он	ОСБГ-т эзлэх хувь
1	Ойгоор бүрхэгдсэн талбай	463235	463235	463235	464057,1	94,60
2	Ой модыг нь огтолсон газар	5039	5039	5039	5067	1,03
3	Мод үржүүлгийн газар	50,5	50,5	50,5	63	0,01
4	Ой тэлэн ургах нөөц газар	0	0	0	270	0,06
5	Ойн сангийн бусад газар	22405	22405	22405	21105	4,30
<b>Нийт</b>		<b>490729,5</b>	<b>490729,5</b>	<b>490729,5</b>	<b>490562,1</b>	<b>100,00</b>





Диаграмм 80. Аймгийн ойн сан бүхий газрын өөрчлөлт

Аймгийн 2016 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар ойн нийт 490562,1 га талбайн 94,6 хувь буюу 464057,1 га талбайг ой мод, 0,01 хувь буюу 63 га-г мод үржүүлгийн газар, 1,03 хувь буюу 5067 га талбайг огтлогдсон ой, 4,3 хувь буюу 21105 га-г бусад газар, 0,06 хувь буюу 270 га-г ой тэлэн ургах нөөц газар эзэлж байна.

2013 оны ой зохион байгуулалтын үр дүнг сансрын зурагтай давхцуулан аймгийн ойн сан бүхий газрын талбайн хэмжээг засварлан, 2016 оны газрын нэгдмэл сангийн тайлангийн талбайтай харьцуулан үзэхэд ойгоор бүрхэгдсэн талбай 42200,55 га, модыг нь огтолсон газар 5493,14 га, ой тэлэн ургах нөөц газар 354439,31 га, ойн сангийн бусад газар 124392,22 га талбайгаар нэмэгдэж, мод үржүүлгийн газар 47,68 га-аар багассан байна.

Аймгийн нийт нутаг дэвсгэр 8245566,7 га талбайн 12,3 хувийг ойн сан бүхий газар эзэлж байна. Талбайн өсөлтөнд ой тэлэн ургах нөөц газар болох ойн захаас гадагш 100 м газар ихээр нөлөөлсөн болно.

Хүснэгт 103. Аймгийн ойн сан бүхий газрын талбай, га

№	Ойн сан бүхий газрын дэд ангилал	2016 оны ГНС-ийн тайлангаар	Судалгаагаар	Зөрүү	ОСБГ-т эзлэх хувь
1	Ойгоор бүрхэгдсэн талбай	464057,1	506257,65	+42200,55	49,8
2	Ой модыг нь огтолсон газар	5067	10560,14	+5493,14	1,0
3	Мод үржүүлгийн газар	63	15,32	-47,68	0,0
4	Ой тэлэн ургах нөөц газар	270	354709,31	+354439,31	34,9
5	Ойн сангийн бусад газар	21105	145497,22	+124392,22	14,3
<b>Нийт</b>		<b>490562,1</b>	<b>1017039,64</b>	<b>+526477,54</b>	<b>100,0</b>

### 6.1.2 Ойн сангийн талбай

Завхан аймаг нь ойн сан бүхий 20 сумтай, 2017 оны байдлаар аймгийн нийт нутаг дэвсгэрийн 8,8 хувь буюу 736603,98 га талбайг ойн сан эзэлж байна. Үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай нь 506257,7 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 6,1 хувийг эзэлж байгаа нь ойн баялгаар хомс байгааг харуулж байна.

Аймгийн нийт ойн сангийн талбайн 65,2 хувийг Тосонцэнгэл, Их-Уул, Баянтэс, Идэр гэсэн 4 сум эзэлж байна. Ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайг нийт нутаг дэвсгэрт харьцуулж, хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ойрхог чанар гэх ба аймгийн нийт 8245566,74 га талбайг ойгоор бүрхэгдсэн 506257,65 га талбайд харьцуулан үзэхэд аймгийн ойрхог чанар 6,1 хувь гарч байгаа нь сул үзүүлэлт юм.

Хүснэгт 104. Ойн сангийн талбай, нөөц


№	Сумдын нэр	Ойн сангийн нийт талбай, га	Талбайд эзлэх хувь	Сумын нийт ойн нөөц /м <sup>3</sup> /	Нөөцөд эзлэх хувь
1	Алдархаан	56373,19	7,7	3369900	5,5
2	Асгат	1886,95	0,3	241500	0,4
3	Баянтэс	99171,10	13,5	9106120	14,7
4	Баянхайрхан	31635,31	4,3	4550647,35	7,4
5	Дөрвөлжин	1081,44	0,15	13330	0,02
6	Идэр	80769,56	11,0	4827500	7,8
7	Их-Уул	124982,61	17,0	11781130	19,1
8	Нөмрөг	50483,18	6,9	5168750	8,4
9	Отгон	1981,03	0,3	35950	0,06
10	Сонгино	5571,07	0,8	868440	1,4
11	Тосонцэнгэл	174987,46	23,8	11845310	19,2
12	Түдэвтэй	11804,71	1,6	1106940	1,8
13	Тэлмэн	27366,51	3,7	3295510	5,3
14	Тэс	11227,59	1,5	866330	1,4
15	Цагаанхайрхан	20001,97	2,7	1718150	2,8
16	Цагаанчулуут	5042,86	0,7	399630	0,6
17	Цэцэн-Уул	7733,79	1,0	606270	1,0
18	Шилүүстэй	214,65	0,03	13620	0,02
19	Эрдэнэхайрхан	6185,09	0,8	25630	0,04
20	Яруу	18103,91	2,5	1927820	3,1
<b>Аймгийн дүн</b>		<b>736603,98</b>	<b>100</b>	<b>61768477,35</b>	<b>100</b>

Ойн нөөц гэдэг нь ойг талбай, ургаа модны эзлэхүүнээр нь илэрхийлсэн үзүүлэлтийг хэлэх бөгөөд аймгийн хэмжээгээр нийт ойн нөөц нь 61,7 сая м.куб байгаа ба энэ нь Монгол улсын 1,4 тэрбум м.куб ойн нөөцийн 4,4 хувийг эзэлж байгаа нь ойн нөөц багатайг харуулж байна.

Хүснэгт 105. Сумдуудын ойн сангийн талбай, га


№	Сумдын нэр	Ойн талбай /га/								Ойн бус талбай /га/			Сумдын нийт ойн талбай, га
		Ойгоор бүрхэгдсэн			Ойгоор бүрхэгдээгүй					Цагаан энгэр	Мод үржүүлгийн газар	Таг царам	
		Байгалийн ой	Бут сөөг	Таримал ой	Тармаг	Шатсан	Мод бэлтгэлийн талбай	Ойжих	Хортон шавьж өвчинд нэрвэгдсэн талбай				
1	Алдархаан	29174,37	17643,47	0	4549,21	1144,34	488,29	2896,44	0	413,94	14,04	49,09	<b>56373,19</b>
2	Асгат	1737,30	0	0	130,93	13,22	0	0	0	5,50	0	0	<b>1886,95</b>
3	Баянтэс	72147,58	6270,73	0	6646,79	3030,32	90,78	4766,34	725,15	5493,41	0	0	<b>99171,10</b>
4	Баянхайрхан	27638,21	0	0	1446,31	255,02	2,90	1286,03	0	1006,84	0	0	<b>31635,31</b>
5	Дөрвөлжин	1080,07	0	1,37	0	0	0	0	0	0	0	0	<b>1081,44</b>
6	Идэр	31048,56	6730,06	0	5186,44	32925,04	2324,54	0	0	2112,38	0	442,54	<b>80769,56</b>
7	Их-Уул	83389,71	1542,97	0	4020,13	27914,01	3043,74	347,21	228,76	4436,37	0	59,71	<b>124982,61</b>
8	Нөмрөг	39124,34	2526,00	0	3909,18	926,81	295,23	1527,59	0	1795,99	0	378,04	<b>50483,18</b>
9	Отгон	327,96	1653,07	0	0	0	0	0	0	0	0	0	<b>1981,03</b>
10	Сонгино	5416,53		0	32,95	0	66,85	0	0	54,74	0	0	<b>5571,07</b>
11	Тосонцэнгэл	83075,37	6602,13	0	8186,61	65474,45	3496,64	2294,84	195,03	5515,70	1,28	145,41	<b>174987,46</b>
12	Түдэвтэй	9557,20	594,09	0	886,03	54,82	49,07	568,15	0	95,35	0	0	<b>11804,71</b>
13	Тэлмэн	23774,90	616,48	0	620,13	1386,32	118,54	376,28	0	473,86	0	0	<b>27366,51</b>
14	Тэс	6710,26	979,88	0	933,58	579,50	0	1566,71	0	457,66	0	0	<b>11227,59</b>
15	Цагаанхайрхан	14900,07	103,85	0	2193,88	0	0	927,75	0	1828,07	0	48,35	<b>20001,97</b>
16	Цагаанчулуут	3539,16		0	33,05	0	8,31	171,00	0	1291,34	0	0	<b>5042,86</b>
17	Цэцэн-Уул	5301,77	1235,35	0	877,37	0	55,17	235,17	0	28,96	0	0	<b>7733,79</b>
18	Шилүүстэй	121,29	91,10	0	0	0	2,26	0	0	0	0	0	<b>214,65</b>
19	Эрдэнэхайрхан	260,18	5883,68	0	41,23	0	0	0	0	0	0	0	<b>6185,09</b>
20	Яруу	15176,96	281,63	0	805,09	84,29	517,82	1194,49	0	43,63	0	0	<b>18103,91</b>
<b>Аймгийн дүн</b>		<b>453501,79</b>	<b>52754,49</b>	<b>1,37</b>	<b>40498,91</b>	<b>133788,14</b>	<b>10560,14</b>	<b>18158,00</b>	<b>1148,94</b>	<b>25053,74</b>	<b>15,32</b>	<b>1123,14</b>	<b>736603,98</b>

Аймгийн нийт ойн талбайн 68,7 хувийг ойгоор бүрхэгдсэн талбай, 27,7 хувийг ойгоор бүрхэгдээгүй ойн талбай, 3,6 хувийг ойн бус талбай эзэлж байна /Диаграмм 4/. Ойгоор бүрхэгдсэн талбайн 89,6 хувьд ой мод, 10,4 хувьд сөөг, таримал ой ургаж байна. Ойгоор бүрхэгдээгүй талбайн 65,5 хувийг шатсан талбай, 19,8 хувийг тармаг ой, 8,9 хувийг ойжих талбай, 0,6 хувийг хөнөөлт шавьж өвчинд нэрвэгдсэн талбай, 5,2 хувийг мод бэлтгэсэн талбай эзэлж байна. Ойн бус талбайн 95,7 хувийг цагаан энгэр, 4,3 хувийг таг царам, 0,1 хувийг мод үржүүлгийн газар эзэлж байна.



Диаграмм 81. Аймгийн ойн сангийн талбай төрлөөр ангилагдсан байдал

Хамгийн их байгалийн ойтой сум нь Их-Уул, Тосонцэнгэл, Баянтэс сумд, хамгийн бага ойтой нь Эрдэнэхайрхан, Шилүүстэй сум, харин Завханмандал, Сантмаргац, Ургамал сумд огт ойгүй болно.




Зураг 217. Завхан аймгийн ойн сан, 2017 он

Тус аймгийн ойн бүрэлдэхүүнд гацуур, улиангар, хуш, шинэс, улиас мод бүхий холимог ой ургах ба голын дагуу бут сөөг, бургас болон жимс жимсгэний модод тархан ургана. Байгалийн ойн талбайг модны төрлөөр авч үзвэл шинэсэн ойн нөөц 56,5 сая м.куб, бусад моддын нөөц 1,1 сая м.куб эзэлж байна.

Хүснэгт 106. Аймгийн ойн нөөц

№	Сумдын нэр	Ойн нөөц, мян. шоо метр						
		Шинэс	Хус	Улиас	Улиангар	Бургас	Хуш	Гацуур
1	Алдархаан	3161,52	8,15	7,8	0,84	13,62	-	-
2	Асгат	221,37	-	-	-	-	-	20,13
3	Баянтэс	8359,23	-	-	-	37,49	-	482,2
4	Баянхайрхан	4550,64	-	-	-	-	-	-
5	Дөрвөлжин	-	-	-	-	13,33	-	-
6	Идэр	3869,37	-	-	-	0,4	-	-
7	Их-Уул	10700,48	-	-	-	0,64	174,34	-
8	Нөмрөг	5128,04	-	-	-	-	-	-
9	Отгон	35,95	-	-	-	-	-	-
10	Сонгино	863,65	-	-	-	-	-	-
11	Тосонцэнгэл	9968,47	-	-	-	5,11	108,03	-
12	Түдэвтэй	1106,1	-	-	-	-	-	-
13	Тэлмэн	3233,51	-	-	-	-	-	-
14	Тэс	679,25	-	-	-	30,66	-	129,47

15	Цагаанхайрхан	1673,63	-	-	-	1,77	-	-
16	Цагаанчулуут	391,26	-	-	-	-	-	-
17	Цэцэн-Уул	606,27	-	-	-	-	-	-
18	Шилүүстэй	13,62	-	-	-	-	-	-
19	Эрдэнэхайрхан	51,97	-	-	-	84,8	-	-
20	Яруу	1909,15	0,36	-	-	0,83	-	-
<b>Аймгийн дүн</b>		<b>56523,48</b>	<b>8,51</b>	<b>7,8</b>	<b>0,84</b>	<b>188,65</b>	<b>282,37</b>	<b>631,8</b>



Зураг 218. Завхан аймгийн ойн төрөл

**Ойн дундаж үзүүлэлт :**

Аймгийн ойн сангийн жилийн бүх дундаж өсөлт 379015 шоо.метр

Дундаж бонитет /чансаа/ 4,65

Ойн дундаж өтгөрөл 0.50

Болц гүйцсэн ба хөгширсөн ойн 1 га-н дундаж нөөц 134,68 шоо. метр

Ойгоор бүрхэгдсэн талбайн 1 га-н дундаж нөөц 126,2 шоо. метр

1 га-н жилийн дундаж өсөлт 0,82 шоо. метр

**Ойн сангийн талбайн өөрчлөлт:**

Монгол орны ойн экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгалийн ойн талбай буурч байгаа шалтгаан нь ойн түймэр, хуль бус мод бэлтгэлийн ажил, ойн хортон шавьжийн тархалт, хүний болон малын нөлөө байдаг байна. Завхан аймгийн ойн сангийн талбайд гарсан өөрчлөлтийг гаргахдаа 2013 онд хийгдсэн ой зохион



байгуулалтын үр дүнг, 2017 оны 7 сарын Landsat хиймэл дагуулын зураг дээр боловсруулалт хийн, тодруулж харьцуулан, ангилал бүрээр гаргав.

Хүснэгт 107. Ойн сангийн талбайн өөрчлөлт, га-аар

Ойн сангийн талбайн төрөл	Газрын төрөл	2013 оны ой зохион байгуулалт	2017 оны сансрын зургийн давхцуулалтаар	Зөрүү
Ойгоор бүрхэгдсэн талбай	Байгалийн ой	456741	453501,79	-3239,21
	Бут сөөг	43495	52754,49	+9259,49
	Таримал ой	2	1,37	-0,63
Ойгоор бүрхэгдээгүй талбай	Тармаг	43108	40498,91	-2609,09
	Шатсан	133089	133788,14	+699,14
	Мод бэлтгэлийн талбай	10522	10560,14	+38,14
	Ойжих	17984	18158	+174
	Хортон шавьж, өвчинд нэрвэгдсэн	1148	1148,94	+0,94
Ойн бус талбай	Цагаан энгэр	24815	25053,74	+238,74
	Мод үржүүлгийн газар	16	15,32	-0,68
	Таг царам	1115	1123,14	+8,14
<b>Аймгийн нийт</b>		<b>732035</b>	<b>736603,98</b>	<b>+4568,98</b>

Ойн сангийн байгалийн ой 3239,21 га, таримал ой 0,63 талбайгаар багасч, бут сөөг, торлог 9259,49 га талбайгаар нэмэгдсэн байна. Ойгоор бүрхэгдээгүй талбайн шатсан ой 699,14 га, мод бэлтгэлийн талбай 38,14 га, ойжих талбай 174 га, хортон шавьж өвчинд нэрвэгдсэн талбай 0,94 га талбайгаар нэмэгдэж, тармаг ой 2609,09 га-аар багассан байна. Ойн бус талбайн цагаан энгэр 238,74 га, таг царам 8,14 га талбайгаар нэмэгдэж байхад, мод үржүүлгийн газар 0,68 га талбайгаар буурсан байна. Аймгийн нийт ойн сангийн талбай 4568,98 га-аар нэмэгдсэн байгаа боловч, байгалийн ой нь буурч, огтлогдсон болон шатсан, хортон шавьж өвчинд нэрвэгдсэн ойн талбай ихэссэн нь ойн чанарыг бууруулж байна.

### 6.1.3 Ойн хомсдол ба доройтол

Ойн доройтол гэдэг нь хүний шууд үйл ажиллагаанаас үүдэн ойн бүтэц, үйл ажиллагаанд өөрчлөлт гарч, тодорхой жилийн туршид удаан хугацааны алдагдалд орохыг хэлнэ. Ихэнх тохиолдолд ойн доройтол нь ойн талбайн хэмжээг өөрчилдөггүй боловч ойн нөөц, биомассыг бууруулдаг. Завхан аймгийн хэмжээгээр ойн доройтолд хүргэж байгаа шууд нөлөөлөх хүчин зүйлст ойн түймэр, замбараагүй мод бэлтгэл, хортон өвчин, хөнөөлт шавьжийн тархалт, байгалийн ойн талбайн бууралт байна.

Хүснэгт 145. Аймгийн ойн доройтолд орсон талбай, га-аар

№	Хүчин зүйлс	Талбай, га	Эх сурвалж
1	Ойн түймэр	133788,14	Ой зохион байгуулалтын тайлан, 2016 оны ГНС-ийн тайлан
2	Замбараагүй мод бэлтгэл	51059,05	Ой зохион байгуулалтын тайлан, 2016 оны ГНС-ийн тайлан
3	Хөнөөлт шавьжийн хор хөнөөл	1148,94	Ой зохион байгуулалтын тайлан, 2016 оны ГНС-ийн тайлан

4	Үргэлжилсэн доройтолоос үүдсэн ойн хомсдол	3239,21	2013 оны ой зохион байгуулалтын үр дүнг, сансрын зурагтай давхцуулах байдлаар гаргасан
<b>Ойн доройтолд орсон нийт талбай, га</b>		<b>189235,34</b>	

Ойн доройтлоос байгаль орчинд үүсэх хүлэмжийн хийн ялгаралын үнэлгээг Монгол орны UN-REDD үндэсний хөтөлбөрийн аргазүйгээр тооцож гаргасан дараахь нормыг ашигласан.

**Хүснэгт 146. Ойн доройтлоос байгаль орчин үүсэх хүлэмжийн хийн ялгаралын тооцоо**

Хүчин зүйл	Өөрчлөгдөхөөс өмнөх газрын бүрхэвч	Өөрчлөгдсөний дараахь газрын бүрхэвч	Өөрчлөгдөхөөс өмнөх нүүрстөрөгчийн шингээлт, tCO <sub>2</sub> e/га	Өөрчлөгдсөний дараахь нүүрстөрөгчийн шингээлт, tCO <sub>2</sub> e/га	Хүлэмжийн хийн ялгарал, шингээлт tCO <sub>2</sub> e/га
Ойн түймэр	Байгалийн ой	Түймэрт нэрвэгдсэн ой	191,70	161,03	30,67
Замбараагүй мод бэлтгэл, дараалсан огтлол	Байгалийн ой	Тармаг мод, мод бэлтгэсэн талбай	191,70	158,16	33,55
Хөнөөлт шавьжийн хор хөнөөл	Байгалийн ой	Хөнөөлт шавьжид нэрвэгдсэн ой	191,70	158,16	33,55
Үргэлжилсэн доройтолоос үүдсэн ойн хомсдол	Байгалийн ой	Бэлчээр	191,70	0	191,70
Мод тарих	Бэлчээр, мод бэлтгэсэн талбай, шатсан ой	Таримал ой	0	22,79	-22,79

*Эх сурвалж: Монгол орны ойн сангийн өөрчлөлтийн хүчин зүйлсийн урьдчилсан үнэлгээ, 2014 он*


Аймгийн хэмжээнд 189235,34 га ой доройтож, 16,69 га ойн талбай нэмэгдсэнээр жилд 6475,4 мян tCO<sub>2</sub>e хүлэмжийн хий агаарт тархаж байна.

**Хүснэгт 147. Аймгийн жилийн хугацаан дахь хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн тооцоолол**

№	Хүчин зүйл	Өөрчлөлтийн төрөл	Нэрвэгдсэн талбай, га	Хүлэмжийн хийн ялгарал, шингээлт tCO <sub>2</sub> e/га	Хүлэмжийн хийн нийт ялгарал, шингээлт tCO <sub>2</sub> e
1	Ойн түймэр	Ойн доройтол	133788,14	30,67	4103282,25
2	Замбараагүй мод бэлтгэл, дараалсан огтлол	Ойн доройтол	51059,05	33,55	1713031,13
3	Хөнөөлт шавьжийн хор хөнөөл	Ойн доройтол	1148,94	33,55	38546,94
4	Үргэлжилсэн доройтолоос үүдсэн ойн хомсдол	Ойн хомсдол	3239,21	191,70	620956,56
5	Мод тарих	Нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх	16,69	-22,79	-380,37
<b>Аймгийн нийт</b>			<b>189235,34</b>		<b>6475436,51</b>


## 6.2 ОЙН САНГИЙН ТОХИРОМЖТОЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Ой ургах тохиромжтой байдлын үнэлгээг хийхдээ ГХГЗЗГ-ын даргын 2015 оны 200 тоот тушаалаар батлагдсан “Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүй”-г баримталж хийсэн. Завхан аймгийн ойн сан нь ургамжилтын ангиллаар ”Хангайн ой-ургамалжилтын муж”-ийн ”Төв хангайн хошуу”-нд хамаарагдаж уулын цармын тармаг, уулын тайгын, уулын тайганцар ой гэсэн 2 үндсэн өндрийн бүслүүрт хамаарагдаж байгаа тул тохиромжтой байдлын үнэлгээг тохируулан үзүүлэлтийг үнэлсэн.



Диаграмм 82. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ

### Газрын гадаргын үнэлгээ:




Зураг 219. Ойн сангийн тохиромжтой байдлын гадаргын үнэлгээ

Газрын гадаргын үнэлгээг гадаргын хэвгий, зүг зовхис, гадаргын өндөршил гэсэн 3 үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд аймгийн нийт нутгийн 28,7 хувь буюу 2366721,6 га талбай тохиромжтой, 14,3 хувь буюу 1181649 га хязгаарлагдмал тохиромжтой, 53,9 хувь буюу 4451803,7 га тохиромжгүй үнэлгээтэй гарч байна.

### Хөрсний физик-химийн хүчин зүйлийн үнэлгээ:


Хөрсний физик-химийн хүчин зүйлийн үнэлгээг хөрсний хэв шинж, механик бүрэлдэхүүн, ялзмагт үеийн зузаан, ялзмагийн агууламж, хөрсний ус нэвчүүлэх чадвар, хөрсний урвалын орчин, кальцийн карбонат, хөрсний цахилгаан дамжуулах чадвар, хөрсний чийг гэсэн 9 үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд аймгийн нийт нутгийн 8,0 хувь буюу 663267,9 га талбай тохиромжтой, 5,6 хувь буюу 466194,7 га хязгаарлагдмал тохиромжтой, 83,3 хувь буюу 6870711,7 га тохиромжгүй үнэлгээтэй гарч байна.



Зураг 220. Ойн сангийн тохиромжтой байдлын хөрсний физик-химийн хүчин зүйлийн үнэлгээ

### Нэгдсэн үнэлгээ:

Ойн сангийн тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээнд олон хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээг, суурь нөхцлийн үнэлгээтэй давхцуулан хийсэн бөгөөд суурь нөхцлийн үнэлгээнд 5 үзүүлэлт, хүчин зүйлийн үнэлгээнд 14 хүчин зүйлийг ашиглан үнэлсэн. Хүчин зүйлийн нэгдсэн үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 2,8 хувь буюу 235547,5 га талбай тохиромжтой, 33,2 хувь буюу 2744158,2 га талбай хязгаарлагдмал тохиромжтой, 60,9 хувь буюу 5020468,6 га нь тохиромжгүй үнэлгээтэй гарсан.



Зураг 221. Ойн сангийн тохиромжтой байдлын нэгдсэн үнэлгээ

### 6.3 ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Үндэслэл: Ойн сан бүхий газрын ашиглалт, хамгаалалтын төлөвлөлтийг хийхдээ Төрөөс ойн талаар баримтлах бодлого (2015 он), Завхан аймгийн ойн менежментийн төлөвлөгөө (2017 он), Завхан аймгийн ой зохион байгуулалтын ажлын тайлан (2013 он), Завхан аймгийн хөгжлийн стратегийн асуудлууд (2013 он) зэрэг эрхзүйн болон судалгааны баримт бичгүүдийг үндэслэсэн.

Аймгийн ойн сан бүхий газрын ашиглалт хамгаалалтын төлөвлөлтийг ойн бүсчлэл, ойн ашиглалтын төлөвлөлт, хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн үндсэн 3 хэсгээр, хэрэгжүүлэх хугацааг ойрын /2018-2022 он/, дундын /2023-2028 он/, хэтийн /2029-2033 он/ гэж хуваарилан хийсэн.

#### 6.2.1 Ойн бүсчлэлийн төлөвлөлт

Ойн тухай хуулийн 2.8-р зүйлийн 8.1-д зааснаар ойн санг хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи эдийн засгийн ач холбогдолыг харгалзан хамгаалалтын бүс болон ашиглалтын бүсэд төлөвлөх бөгөөд хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна.

Хориотой зурвасын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ой хамаарна.

Хамгаалалтын бүсэд ороогүй бусад ой нь ашиглалтын бүсийн ойд орно.

#### **Хамгаалалтын бүсийн ой:**

Хамгаалалтын бүсийн ойд зам гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглодог ба дараахь ач холбогдолтой. Үүнд:

- *Ногоон бүсийн ой:* Гол үүрэг ач холбогдол нь төв суурин газрын ойр орчмын байгаль орчны тэнцэл, амралт, сувилалын болоод хүн амын эрүүл ахуйн нөхцлийг хангахад оршино. Шинэчилэн батлагдсан “Ойн тухай хууль”-ийн 8.5.3-д зааснаар Сумдын ногоон бүсийн хилийн заагийг аймгийн ИТХ, 8.5.2-д зааснаар аймгийн ногоон бүсийн хилийг төрийн захиргааны төв байгууллага тогтоох ёстой. Гэвч одоог хүртэл 2006 оны ой зохион байгуулалтын судалгааны үед тогтоосон хилийн заагийг ашиглаж байгаа тул уг хилээр авч төлөвлөсөн.
- *Хориотой зурвасын ой:* Ой нь ургаж байх хугацаандаа олон чухал үүрэг гүйцэтгэдгийн нэг нь гадаргын болон газар доорх усны горимыг зохицуулах, усны чанарыг дээшлүүлэх, ус хамгаалалтын үүрэг юм. Ойн тухай хуульд зааснаар нуур, рашаан, булаг, шандын ундрагын эргэн тойрны болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторхи ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 метрийн доторх ойг хориотой зурвасын ойд оруулан төлөвлөсөн.
- 100 га хүртэлх ой, сөөг ширэнгэ, өвөр энгэрийн төгөл ой: Эх ойгоосоо таслагдмал бага хэмжээтэйгээр төгөл хэлбэрээр тархсан жижиг зураа, ширэнгэ, уулын өвөр энгэрийн төгөл ой хамаарах ба цаашид тэлж урган ойн сангийн талбай нэмэгдэхэд ихээхэн ач холбогдолтойн дээр талбайгаар нь хавтгайруулан огтолвол шууд хээржих хандлагатай байдаг тул хамгаалалтын бүсэд оруулдаг. Иймд ойн талбайгаар 100 га хүрээгүй бүх ой, бут, сөөг, торлогийг оруулан төлөвлөсөн.
- 30 хэмээс дээш налуу газрын ой: Энэ аж ахуйн төрлийн ой нь ихэвчлэн ус хагалбарын шугам дагуу байрлах учраас хөрсийг салхи, усны элэгдэл эвдрэлээс хамгаалах, гол үүрэг ач холбогдолтой бөгөөд ургах орчных нь тохиромжтой нөхцлийг алдагдуулахгүй байх, ойн хэвийн өсөлт, өөрөө аясаараа сэргэн ургах нөхцлийг хангах үүднээс хамгаалалтын бүсэд оруулдаг. Иймд аймгийн гадаргын налуугийн зургаар 30 градусаас дээш налуу газар ургаж байгаа ойн хэсгийг оруулан төлөвлөсөн.


#### **Ашиглалтын бүсийн ой:**

Ашиглалтын бүсийн ойд иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь мод, ойн дагалт баялгийг зохих төлбөр, хураамжийг төлсний үндсэн дээр ашиглах эрхтэй бөгөөд цаашид ашиглалтын бүсийн ойд ойн нөхөрлөлүүдэд гэрээгээр эзэмшүүлэх, мод, болон дагалт баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэхээр газар олголтыг төлөвлөх шаардлагатай.

Хүснэгт 108. Аймгийн ойн бүсчлэлийн төлөвлөлт, талбайгаар

№	Сумдын нэр	Талбай, га							Хамгаалалтын бүсийн нийт ой	Ашиглалтын бүсийн ой
		Ногоон бүсийн ой	Хориотой зурвасын ой	100 га хүртэлх төгөл, бут сөөг	ТХГН-ын ой	Цармын бүслүүрийн ой	30 хэмээс дээш налуу газрын ой	Улсын хилийн зурвас газрын ой		
1	Алдархаан	6832,77	13523,33	20702,3	12685,76	196,36	1478,98	0	55419,50	953,69
2	Асгат	433,31	181,25	0	0	0	24,37	0	638,93	1248,02
3	Баянтэс	9594,96	5365,99	10552,8	0	0	4375,21	41630	71518,96	27652,14
4	Баянхайрхан	6183,67	3325,73	0	0	0	1005,67	0	10515,07	21120,24
5	Дөрвөлжин	14,31	106,99	960,14	0	0	0	0	1081,44	0
6	Идэр	6232,26	4882,98	10187,22	55412,26	1770,16	1804,77	0	80289,65	479,91
7	Их-Уул	13580,32	25338,85	2628,6	72622,05	238,84	2384,95	0	116793,61	8189,00
8	Нөмрөг	8238,33	4663,91	2740,98	0	1512,16	824,47	0	17979,85	32503,33
9	Отгон	76,27	68,4	1827,03	0	0	9,33	0	1981,03	0
10	Сонгино	1267,32	1502,64	0	0	0	162,24	0	2932,20	2638,87
11	Тосонцэнгэл	25255,77	44187,13	21823,9	42739,16	581,64	1812,36	0	136399,96	38587,50
12	Түдэвтэй	2181,59	1291,15	1585,59	0	0	339,57	0	5397,90	6406,81
13	Тэлмэн	1791,83	6481,14	616,82	0	0	216,82	0	9106,61	18259,90
14	Тэс	1989,27	1845,89	1959,76	0	0	335,11	0	6130,03	5097,56
15	Цагаанхайрхан	3418,91	3401,29	3440,12	0	193,4	819,14	0	11272,86	8729,11
16	Цагаанчулуут	776,95	547,92	0	0	0	99,14	0	1424,01	3618,85
17	Цэцэн-Уул	1399,53	508,06	2037,84	404,07	0	236,07	0	4585,57	3148,22
18	Шилүүстэй	9,99	0	182,18	0	0	12,86	0	205,03	9,62
19	Эрдэнэхайрхан	32,02	90,16	5688,58	338,25	0	36,08	0	6185,09	0
20	Яруу	2196,22	6560,18	563,26	0	0	1119,13	0	10438,79	7665,12
<b>Аймгийн дүн</b>		<b>91505,61</b>	<b>103942,54</b>	<b>87497,12</b>	<b>184247,69</b>	<b>4492,56</b>	<b>65405,2</b>	<b>41630</b>	<b>550296,10</b>	<b>186307,88</b>
<b>Эзлэх хувь</b>		<b>16,6</b>	<b>18,9</b>	<b>15,9</b>	<b>33,5</b>	<b>0,8</b>	<b>11,9</b>	<b>7,6</b>	<b>74,7</b>	<b>25,3</b>

Аймгийн нийт ойн сангийн 74,7 хувь буюу 550296,1 га ойн талбайг хамгаалалтын бүсийн ой, 25,3 хувь буюу 186307,88 га талбайг ашиглалтын бүсийн ой эзэлж байна.



Зураг 222. Ойн бүсчлэлийн төлөвлөлтийн зураг

### Шинээр ойжуулах бүс газрын төлөвлөлт:

Ойг нөхөн сэргээх ажлын гол зорилго нь ойн нөөцийг арвижуулах, ойн удмын санг хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, ойн хортон, түймэрт нэрвэгдсэн мод бэлтгэсэн талбайд нэн тэргүүнд мод тарьж ургуулах явдал юм.

Аймгийн хэмжээнд ойжуулах шаардлагатай, ойгоор бүрхэгдээгүй талбай 203005,19 га талбай байна. Үүний 133788,14 га нь шатсан ой, 10560,14 га нь огтлогдсон ой, 40498,91 га нь тармаг ой, 18158 га нь ойжих талбай байна. Эдгээрээс 10560,14 га огтлогдсон талбайд огтлолт явагдаад олон жил болж, хөрс нь хээрших төлөв бий болсон тул эхний ээлжинд ойжуулалт хийх шаардлагатай байна.


Аймгийн хэмжээнд огтлогдсон, шатсан, ойн ХШӨ-нд нэрвэгдсэн ойн талбйгаас гадна шинээр Цагаанхайрхан сумын Хуримтын нурууны 4188,42 га, Цагаанчулуут сумын Намагтай, Өвөр намагийн ар, Цоорт, Цахир, Ихэр, Хар чулуу, Улаан овоо, Хөх чулууны 3412,18 га, Идэр сумын 2153,18 га, нийт 155251,0 га талбайг ойжуулах, 591,8 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 109. Ойжуулалт хийхээр төлөвлөсөн байршил

№	Сумын нэр	Талбай, га					Нийт талбай, га
		Огтлогдсон ой, га	Шатсан ой	ХШӨ-нд нэрвэгдсэн ой	Шинээр ойжуулалт хийх	Ойн зурвас	
1	Алдархаан	488,29	1144,34	-	-	35	1667,63
2	Асгат	-	13,22	-	-	-	13,22
3	Баянтэс	90,78	3030,32	725,15	-	-	3846,25
4	Баянхайрхан	2,9	255,02	-	-	-	257,92



5	Дөрвөлжин	-	-	-	-	23,6	23,6
6	Завханмандал	-	-	-	-	15,2	15,2
7	Идэр	2324,54	32925,04	-	2153,18	-	37402,76
8	Их-Уул	3043,74	27914,01	228,76	-	23	31209,51
9	Нөмрөг	295,23	926,81	-	-	-	1222,04
10	Сантмаргац	-	-	-	-	99,8	99,8
11	Сонгино	66,85	-	-	-	-	66,85
12	Тосонцэнгэл	3496,64	65474,45	195,03	-	-	69166,12
13	Түдэвтэй	49,07	54,82	-	-	-	103,89
14	Тэлмэн	118,54	1386,32	-	-	-	1504,86
15	Тэс	-	579,5	-	-	-	579,5
16	Ургамал	-	-	-	-	64,8	64,8
17	Цагаанхайрхан	-	-	-	4188,42	97,2	4285,62
18	Цагаанчулуут	8,31	-	-	3412,18	9	3429,49
2	Алдархаан	Төвийн эрчим хүчний систем	"Тэлмэн-Улиастай" 110кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Улиастай" дэд станц
3	Асгат	Төвийн эрчим хүчний систем	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц

4	Баянтэс	Төвийн эрчим хүчний систем	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
5	Баянхайрхан	Төвийн эрчим хүчний систем	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
6	Дөрвөлжин	Тайширийн УЦС, Дизель станц, Нарны цахилгаан станц	Тайширийн УЦС, Дизель станц, Нарны цахилгаан станц	2012	4200 кВ-ын Дизель станц
7	Завханмандал	Хүнгүйн УЦС, Төвийн эрчим хүч	"Тэлмэн-Улиастай" 110кВ-ын ЦДАШ, УЦС-ын 250 кВ-ын дэд станц	2012	110/35/10кВ-ын "Улиастай" дэд станц
8	Идэр	Төвийн эрчим хүчний систем	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
9	Их-Уул	Тайширийн УЦС	УЦС-ын 110 кВ-ын ЦДАШ	2012	
10	Нөмрөг	Төвийн эрчим хүчний систем	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
11	Отгон	Тайширийн УЦС	УЦС-ын 110 кВ-ын ЦДАШ	2012	
12	Сантмаргац	Галуутайн УЦС, Төвийн эрчим хүч	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ УЦС-ын 250кВ-ын дэд станц	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
13	Сонгино	Төвийн эрчим хүчний систем	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
14	Тосонцэнгэл	Тосонцэнгэлийн УЦС, Төвийн эрчим хүч	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
15	Түдэвтэй	Төвийн эрчим хүчний систем	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
16	Тэлмэн	Төвийн эрчим хүчний систем	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
17	Тэс	Тайширийн УЦС	УЦС-ын 110 кВ-ын ЦДАШ	2012	
18	Ургамал	Тайширийн УЦС, Дизель станц, Нарны цахилгаан станц	Тайширийн УЦС, Дизель станц, Нарны цахилгаан станц	2012	4200 кВ-ын Дизель станц
19	Цагаанхайрхан	Төвийн эрчим хүчний систем	"Тэлмэн-Улиастай" 110кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Улиастай" дэд станц
20	Цагаанчулуут	Тайширийн УЦС	УЦС-ын 110 кВ-ын ЦДАШ	2012	
21	Цэцэн-Уул	Галуутайн УЦС, Төвийн эрчим хүч	"Мөрөн" Дэд станцийн 110 кВ-ын ЦДАШ УЦС-ын 250кВ-ын дэд станц	2012	110/35/10кВ-ын "Тэлмэн" дэд станц
22	Шилүүстэй	Гуулингийн УЦС	УЦС-ын 110 кВ-ын ЦДАШ	2011	
23	Эрдэнэхайрхан	Хүнгүйн УЦС, Төвийн эрчим хүч	"Тэлмэн-Улиастай" 110кВ-ын ЦДАШ, УЦС-ын 250 кВ-ын дэд станц	2012	110/35/10кВ-ын "Улиастай" дэд станц



24	Яруу	Төвийн эрчим хүчний систем	"Тэлмэн-Улиастай" 110кВ-ын ЦДАШ	2012	110/35/10кВ-ын "Улиастай" дэд станц
----	------	----------------------------	---------------------------------	------	-------------------------------------

Тайширын УЦС-аас дамжуулалтаар цахилгаан эрчим хүч худалдан авч, Завхан аймгийн 11 сумыг хангаж эхэлсэн ба 2012 онд төвлөрсөн эрчим хүчинд холбогдоогүй байсан Отгон, Асгат Баянхайрхан, Баянтэс зэрэг сумдыг холбон, 2012 оны эхний 11 сарын байдлаар нарны цахилгаан станц, дизель станцаар хавсарсан байдлаар Ургамал, Дөрвөлжин зэрэг сумдыг, Тайширын УЦС-аас аймгийн 17 сум бүрэн хэмжээгээр, Улиастай Тосонцэнгэл зэрэг сумдыг хэсэгчилсэн байдлаар цахилгаан эрчим хүчээр хангаж байсан.

2012 оны 12 дугаар сарын 18-аас эхлэн Хөвсгөл аймгийн Мөрөн хотод байрлах 110/35/10 кВ-ын "Мөрөн" дэд станцаас 110 кВ-ын ЦДАШ-аар Тэлмэн дэх 110/35/10 кВ-ын "Тэлмэн" дэд станцад холболт хийснээр Тэлмэн сумаас Нөмрөг, Түдэвтэй, Цэцэн-Уул, Сонгино, Сантмаргаз, Баянтэс, Баянхайрхан, Асгат, Тосонцэнгэл, Идэр зэрэг 11 сумдыг, "Тэлмэн-Улиастай" 110кВ-ын ЦДАШ-аар 110/35/10 кВ-ын "Улиастай" дэд станцад холболт хийгдснээр Алдархаан, Эрдэнэхайрхан, Завханмандал, Яруу, Цагаанхайрхан, Улиастай сумын /Төв, Шинэ ногоон хашаа, Паралелль/ чиглэлүүдэд хэрэглэгчдийг Төвийн эрчим хүчний системээс цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа ба Цагаанчулуут, Отгон сумдыг Тайширын УЦС-аас, Шилүүстэй сумыг Гуулингийн УЦС-аас тус тус цахилгаан эрчим хүчээр ханган ажиллаж байна

**Богдын голын УЦС:** УЦС нь толгойн барилга, ус дөхүүлэх суваг, түрэлтийн сан, түрэлтийн хоолой, станцын барилга, хаях суваг зэрэг барилга байгууламжаас бүрддэг. УЦС-аас 35кВ-ын 36км урт цахилгаан дамжуулах шугамаар Улиастай хоттой холбосон байна. УЦС-ын техникийн үндсэн үзүүлэлтүүд:

Станцын суурилагдсан хүчин чадал: 200 кВт

Ус дөхүүлэх сувгийн урт: 2.5 км

Ус дөхүүлэх сувгийн хөндлөн огтлол: Трапец

Тооцоот түрэлт: 35м

Тооцоот зарцуулга: 7.0м<sup>3</sup>/с

Турбины төрөл, марк: Францис, HL240-WJ-71

Генераторын төрөл: SFW-J1000-10/143С

**Тосонцэнгэлийн УЦС:** Тосонцэнгэл сумын Идэрийн гол дээр ХБНГУ-ын буцалтгүй тусламжаар 2006 онд баригдаж ашиглалтанд орсон. Голын усны төвшинг 62м урт, 17м өргөн 3.0м өндөр бетонон далангаар өргөж, 3.3м-ийн түрэлт үүсгэнэ. УЦС ус халиах далан, усан сан, загас өнгөрүүлэх байгууламж, станцын байшин, ус хаях хэсэг зэргээс бүрдэнэ. Энэ УЦС нь Монгол орны хамгийн анхны далантай УЦС юм. УЦС-ын зураг төсөл боловсруулахад ашигласан голын ус зүй, техник-эдийн засгийн үзүүлэлтүүд:

Станцын төрөл: Гольдролын

Суурилагдсан хүчин чадал: 210+165кВт

Тооцоот түрэлт: 3.3м

Тооцоот зарцуулга: 14м<sup>3</sup>/с

Турбины төрөл: Каплан /босоо/

**Галуутайн УЦС:** Завхан аймгийн Цэцэн-Уул сумын нутагт сумын төвөөс 25 км зайтай газар Галуутайн гол дээрх усан цахилгаан станцын барилгын ажлыг Дани улсын тусламжийн хөрөнгөөр ГТХАН-ийн "Сэргээгдэх эрчим хүчийг Монголын хөдөөд

дэмжих” төслөөр 2006 онд эхлүүлсэн бөгөөд 2008 онд ашиглалтанд оруулна. УЦС-ын барилга байгууламжийн ажлын зураг төсвийг Герман улсад боловсруулсан байна. УЦС-ын барилга байгууламж дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Усны түвшин өргөх чулуун далан h=12м  
 Үерийн ус өнгөрүүлэх ус халиагуур  
 Хагшаас цэвэрлэгч  
 Турбины камер  
 Турбин, генератор  
 Ус хаях камер  
 Станцын барилга

Усан цахилгаан станцын үйлдвэрлэх эрчим хүчийг 250кВт-ийн дэд өртөөгөөр Сантмаргац сумруу 25км, Цэцэн-Уул сум руу 25км зайд тус тус 10кВ-ын цахилгаан дамжуулах шугамаар дамжуулна.

**Хүнгүйн УЦС:** Завхан аймгийн Завханмандал сумын нутагт сумын төвөөс 12 км зайтай газар Хүнгүйн гол дээрх усан цахилгаан станцын барилгын ажлыг Дани улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр барьж байгаа бөгөөд БНХАУ-ын ӨМӨЗО-ны “Шар мөрөн Ляо мөрөн барилгын товчоо” ХХК-ийг гүйцэтгэгчээр шалгаруулж барилгын ажлыг 2007 онд эхлүүлсэн . УЦС-ын барилга байгууламжийн ажлын зураг төсвийг Герман улсад боловсруулсан.УЦС-ын барилга байгууламж дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Усны түвшин өргөх чулуун далан h=7м  
 Үерийн ус өнгөрүүлэх ус халиагуур  
 Хагшаас угаах ёроолын хаалт  
 Турбины ус авах камер  
 Турбин, генератор  
 Ус хаях камер  
 Энерги унтраагч  
 Станцын барилга

Усан цахилгаан станцын үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг 250кВ-ийн дэд өртөөгөөр Эрдэнэхайрхан сум руу 20км, Завханмандал сум руу 12км зайд тус тус 10кВ-ын цахилгаан дамжуулах шугамаар дамжуулна.

Хүснэгт 154. Завхан аймгийн цахилгаан дамжуулах шугам

№	Эрчим хүчний шугамын чиглэл	Шугамын хүчин чадал, кВт	Шугамын урт, км
1	Богдын голын УЦС-Улиастай	35	14
2	Улиастай-Донойн хөндий	20	25
3	Улиастай-Цагаанхайрхан-Цагаанчулуут	110	98
4	Алархаан-Яруу-Эрдэнэхайрхан-Завханмандал-Дөрвөлжин	220	230,55
5	Архангай-Их-Уул-Тосонцэнгэл-Тэлмэн-Идэр-Алдархаан	400	230,55
6	Галуутайн УЦС-Сантмаргац	10	18
7	Галуутайн УЦС-Цэцэн-Уул	10	25
8	Хүнгүйн УЦС-Эрдэнэхайрхан	10	39
9	Хүнгүйн УЦС-Завханмандал	10	12
<b>Нийт</b>			<b>692,1</b>

Одоогоор аймгийн хэмжээнд нийт 692,1 км урттай 10-400 кВ-ын хүчин чадалтай цахилгаан дамжуулах шугамууд байрлаж байна.

### Холбоо мэдээллийн сүлжээ:


Завхан аймгийн Улиастай хотод “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК байрлаж байгаа бөгөөд Улиастай хот нь Улаанбаатар хоттой шилэн кабелиар холбогдсон бөгөөд нийт 23 сум /Отгоноос бусад бүх сумын төв/ шилэн кабелиар аймгийн төвтэйгээ холбогдсон байна.

Улиастай, Тосонцэнгэл, Тэлмэн, Дөрвөлжин сумдад Мобиком 3G, Жимобайл 3.99G сүлжээ, Алдархаан, Баянтэс, Баянхайрхан, Түдэвтэй, Тосонцэнгэл, Яруу, Идэр, Тэлмэн, Их-Уул, Нөмрөг, Сонгино, Тэс, Цэцэн-Уул, Сантмаргац, Дөрвөлжин, Ургамал, Завханмандал, Эрдэнэхайрхан, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй сумдад Скайтел 3G, Юнител 4G сүлжээгээ нэвтэрүүлсэн.

Аймгийн төвд 8,5 км шилэн кабелиар интернетийн үйлчилгээг хүргэдэг ба ХААН, ХАС, Төрийн банкууд салбар шилэн кабелиар сүлжээндээ холбогдсон. Боловсролын яамын шугамаар аймгийн төвийн 1,2,3,4,5-р бүрэн дунд боловсролын сургуулиуд, Боловсрол соёлын газар интернетэд холбогдсон. Аймгийн ЗДТГ, Нэгдсэн Эмнэлэг, Иргэний бүртгэлийн хэлтэс, ХХҮХ, НДХ, Татварын хэлтэс, Тагнуулын газар, Аудитын газар, Прокурорын газар, Шуудан үйлчилгээний газар, Цагдаагийн газар, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Мобиком ХХК, Юнител ХХК, Жи-Мобайл ХХК, Иргэний танхим, Аудитын хэлтэс, зэрэг байгууллагуудад VPN сүлжээний үйлчилгээ үзүүлдэг.

Хүснэгт 155. Завхан аймгийн шилэн кабелийн одоогийн байдал

№	Шугамын чиглэл	Шугамын урт, км
1	Архангай-Их-Уул-Тосонцэнгэл-Тэлмэн-Идэр-Яруу-Улиастай	495,53
2	Улиастай-Цагаанхайрхан-Цагаанчулуут	88,35
3	Улиастай-Алдархаан-Эрдэнэхайрхан-Завханмандал-Ургамал	216,69
4	Завханмандал-Дөрвөлжин	74,56
5	Тэлмэн-Нөмрөг-Түдэвтэй-Сонгино-Увс	163,51
6	Түдэвтэй-Баянхайрхан-Асгат-Баянтэс-Тэс	136,38
7	Сонгино-Цэцэн-Уул-Сантмаргац	75,2
8	Говь-Алтай-Шилүүстэй-Баянхонгор	42,54
<b>Нийт</b>		<b>1292,76</b>



Зураг 230. Завхан аймгийн шугам сүлжээний газар

### 7.1.3 Зам шугам сүлжээний газрын SWOT шинжилгээ

#### Давуу тал:

- Баруун 5 аймаг руу явах зам дайран өнгөрч байгаа
- Монгол улсын хэвтээ тэнхлэгийн зам дайран өнгөрдөг.
- Улаанбаатар-Улиастай чиглэлийн зам хэд хэдэн сумын төвүүдийг (Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн) дайран өнгөрдөг.
- Увс аймаг руу явдаг улсын чанартай зам хойд сумдуудаар дайран өнгөрдөг.
- Аймгийн дийлэнх сумд шилэн кабельд холбогдсон.
- Хямд зардалтай, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр олонтой.
- 13 сум Төвийн эрчим хүчний системд холбогдсон.

#### Сул тал:

- Нийслэл Улаанбаатар хотоос зайтай оршдог
- Аймгийн төв нь хатуу хучилттай замаар холбогдож дуусаагүй байна.
- Аймгийн төв нь ихэнх сумдуудтай хөрсөн замаар холбогддог.
- Хойд хэсгийн сумдууд нь шороон замаар холбогддог.
- Байгалийн бартаа саад, даваа ихтэй.
- Аялал жуулчлал хөгжих хамгийн их боломжтой Отгон сум интернетэд холбогдоогүй байна.
- Эрчим хүчний найдвартай эх үүсвэр байхгүй.

#### Боломж:

- Баруун бүсийн зам дайран өнгөрөх тул хөдөлгөөний эрчимжилт ихтэй замыг хатуу хучилттай болгох боломжтой.
- Замын барилгын материалын нөөцтэй.
- ОХУ-руу гарц (Арц суурийн боомт)-тай тул хатуу хучилттай зам төлөвлөснөөр экспортыг нэмэгдүүлэх боломжтой.
- 4 замын уулзвар-Хөвсгөл чиглэлийн зам нь аялал жуулчлалын ач холбогдолтой тул хатуу хучилттай зам болгох боломжтой.
- Найдвартай дулаан эх үүсвэртэй болсоноор аймгийн үйлдвэржилт нэмэгдэж, эдийн засаг хөгжинө.
- Усан цахилгаан станцуудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.

#### **Эрсдэл:**

- Зэрлэг ан амьтад ихтэй тул тэдний амьдралд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
- Газрын гадарга нь хэрчигдэл ихтэй тул үер усны аюулаар зам эвдэрч болзошгүй.
- Өндөр даваа /Ганц, Дахт, Загастай/-тай газраар зам тавихад хөрөнгө оруулалт их шаардагдана.

## **7.2 ЗАМ ТЭЭВРИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**

Засгийн газрын “Хөгжлийн зам” үндэсний хөтөлбөрт 2017-2021 онд аймгийн 4 замын уулзварыг Нөмрөг, Сонгино сумын төвтэй холбосон 167 км замыг хатуу хучилттай болгох, Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 181 км хатуу хучилттай замыг дуусгах ажил тусгагдсан байна.

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бүх аймгийн төвүүдийг авто буудалтай болгох, улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд авто зам дагуу үйлчилгээний цогцолбор байгуулах ажлууд тусгагдсан бөгөөд төмөр замын тээврийг босоо болон хэвтээ тэнхлэгийн дагуу коридор гарган төлөвлөсөн байна. донойн хөндийн нийсэх онгоцны буудлын хөөрч буух хатуу хучилтан зурвас, үерийн далан байгуулахаар тусгагдсан байна.

Завхан аймгийн хөгжлийн цогц бодлогод 2021 он хүртэл Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж эдийн засаг, нийгмийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх хүрээнд аймгийн авто замын сүлжээг сайжруулж, зарим чиглэлийн замыг хатуу хучилттай болгох зорилт тавьсан байна.

- Их Уул-Тосонцэнгэл-Улиастайг хатуу хучилттай авто замаар холбох;
- Тосонцэнгэл – Нөмрөг- Сонгино чиглэлд сайжруулсан шороон зам тавьж цаашид хатуу хучилттай болгох;
- Босоо, хэвтээ тэнхлэгийн дагуу сумдын хооронд сайжруулсан шороон зам тавих;
- Тэс-Арц суурийн боомтыг хатуу хучилттай замаар холбох;
- Тэс сумын Тэсийн гол, Тосонцэнгэл сумын Идэрийн гол, Нөмрөг сумын Өвөр шивэртийн гол, Цагаанхайрхан сумын Ширээгийн гол, Төмөртийн голд төмөр бетон гүүр барих;
- Загастай, Ганцын даваануудын замыг сайжруулж, Цэцэн-Уул сумын Марзын дөрөлжийг засах;

- Улиастай хотыг Мянганы замтай угтуулан холбох;
- Бусад аймгийн төвүүд болон хилийн боомт, уул уурхайн зарим ордуудтай холбосон хатуу хучилттай зам тавих;

Дээрх эрхзүйн баримт бичгээс гадна орон нутгийн удирдлагуудын саналыг харгалзсан.

Хүснэгт 134. Орон нутгийн өгсөн санал

Сумын нэр	Орон нутгийн санал
Алдархаан	<ul style="list-style-type: none"> <li>• Хөх хошуунаас Цахир хошуу хүртэл зам сайжруулах</li> <li>• Яруугийн голд гүүр барих</li> </ul>
Асгат	<ul style="list-style-type: none"> <li>• ОХУ-тай холбох босоо тэнхдэгийн замыг сумын төвөөр дайруулах /өмнө нь Райдор Серч компани судалгаа хийсэн/</li> </ul>
Завханмандал	<ul style="list-style-type: none"> <li>• Эрдэнэхайрхан-Завханмандал чиглэлийн замыг сайжруулах</li> <li>• Аймгийн төв-Ховд чиглэлийн хатуу хучилттай замд сумын төвийг хатуу хучилттай замаар холбох /50 км/</li> </ul>
Идэр	<ul style="list-style-type: none"> <li>• Сумын төвийг Улаан үзүүрийн төв замтай холбох</li> </ul>
Нөмрөг	<ul style="list-style-type: none"> <li>• Баруун бүсийн мянганы замыг сумын төв гудмаар дайруулах</li> <li>• Улаанбаатар, Улиастай руу явсан төв замыг тохижуулах</li> </ul>
Отгон	<ul style="list-style-type: none"> <li>• Улиастай-Отгон чиглэлийн замыг хатуу хучилттай болгох</li> </ul>
Сантмаргац	<ul style="list-style-type: none"> <li>• Хатуу хучилттай замд холбох</li> </ul>
Сонгино	<ul style="list-style-type: none"> <li>• Баруун аймгууд дайран өнгөрөх замд сумын төвийг холбох /2 км/</li> </ul>
Тосонцэнгэл	<ul style="list-style-type: none"> <li>• Сумын төвийн хуучин замын дагуу замын сүлжээг төлөвлөх</li> </ul>
Тэс	<ul style="list-style-type: none"> <li>• Арц суурийн боомтоос Нөмрөг сум хүртэл хатуу хучилттай зам тавих</li> </ul>
Ургамал	<ul style="list-style-type: none"> <li>• Ховд-Улиастай чиглэлийн мянганы замд сумын төвийг хатуу хучилттай замаар холбох</li> <li>• Завханмандал-Ургамал чиглэлийн замыг сайжруулах</li> <li>• Сумын төвийн урд, хойд 2 гүүрэнд төмөр бетонон гүүр шинээр барих</li> </ul>
Цагаанчулуут	<ul style="list-style-type: none"> <li>• Цагаанчулуутаас Шилүүстэй, Цагаанчулуутаас Алтай чиглэлийн замыг сайжруулах</li> <li>• Цагаанчулуутаас Цагаанхайрхан чиглэлийн замыг хатуу хучилттай болгох</li> <li>• Булангийн гүүр засварлах</li> <li>• Дааган дэлийн арын Төмөртийн голд шинээр гүүр төлөвлөх</li> </ul>
Шилүүстэй	<ul style="list-style-type: none"> <li>• Говь-Алтай, Ховд аймаг руу сайжруулсан зам холбох</li> </ul>
Яруу	<ul style="list-style-type: none"> <li>• Сумын төв рүү ирсэн авто замыг сайжруулах</li> </ul>
Газрын даамлуудын өгсөн	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн төвийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбох</li> <li>• Тэс, Баянхайрхан, Түдэвтэй, Нөмрөг, Яруу, Улиастай, Цагаанхайрхан, Отгон, Шилүүстэй сумдыг хатуу хучилттай замд холбох</li> <li>• Тэс. Их-Уул сумдыг төмөр замд холбох</li> <li>• Аймгийн төвийн замыг өргөсгөх</li> <li>• Донойн хөндий рүү хатуу хучилттай зам тавих /Энэ замын дагуу эрчимжсэн МАА хөгжүүлэх/</li> </ul>

## 7.2.1 Төмөр замын төлөвлөлт

2010 онд батлагдсан “Төрөөс төмөр замын баримтлах бодлого”-д төлөвлөлтийн 3-р ээлжинд баруун аймгуудаар төмөр замын баруун коридор байгуулахаа төлөвлөгдсөн бөгөөд замын чиглэл нь өөрчлөгдөж Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ний өдрийн 296-р тоот тогтоолоор аймгийн баруун хэсгээр Дөрвөлжин, Ургамал сумдуудыг дайран өнгөрөхөөр, мөн төмөр замын хойд коридор нь Асгат-Баянтэс-Арц суурийн боомт, Баянтэс-Тэс-Увс аймаг гэсэн чиглэлээр тавигдахаар төлөвлөгдсөн байна.

Хүснэгт 156. Төлөвлөсөн төмөр зам

№	Чиглэл	Замын урт, км	Төлөвлөлтийн хугацаа			Хөрөнгө оруулалт, сая.төг
			2022 он	2028 он	2033 он	
1	Сэлэнгэ-Булган-Хөвсгөл-Завхан-	113,82				362516,7

	ОХУ /Баянтэс-Арц суурийн боомт/					
2	Завхан-Увс-Баян-Өлгий-ОХУ /Баянтэс-Тэс/	73,0				232505,0
3	Сэлэнгэ-Булган-Хөвсгөл-Завхан /Их-Уул/	30,42				96887,7
4	ОХУ-Монгол-БНХАУ /Завхан аймгийн Дөрвөлжин-Ургамал сумд/	128,66				409782,1
<b>Аймгийн нийт</b>		<b>345,94</b>	<b>-</b>	<b>144,24</b>	<b>201,66</b>	<b>1101691,5</b>


## 7.2.2 Авто замын төлөвлөлт

Авто замын хөгжил нь аймгийн аялал жуулчлал, бүтээн байгуулалт, эдийн засаг өсөх хамгийн гол тулгуур бөгөөд улсын хэмжээний болон аймгийн, орон нутгийн санал дээр үндэслэн 814,48 км хатуу хучилттай авто зам, 712,82 км сайжруулсан авто зам болгохоор төлөвлөсөн. Төлөвлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаагаар тодотгосон.

Хүснэгт 135. Төлөвлөсөн авто зам

№	Төлөвлөж буй авто замын төрөл	Чиглэл	Замын урт, км	Төлөвлөлтийн хугацаа			Хөрөнгө оруулалт, сая.төг
				2022 он	2028 он	2033 он	
1	Хатуу хучилттай болгох	Улиастай-Тосонцэнгэл	182,49				182490
2		4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино	216,10				216100
3		Түдэвтэй-Баянхайрхан-Баянтэс-Арц суурийн боомт	184,92				184920
4		Улиастай-Цагаанхайрхан-Алтай хот	115,31				115310
		Цагаанхайрхан-Цагаанчулуут	13,04				13040
5		Улиастай-Яруу-Улаагчны хар нуур	102,62				102620
6	Сайжруулсан зам болгох	Улиастай-Отгон	69,36				2774,4
7		Улиастай-Эрдэнэхайрхан-Завханмандал-Ургамал	268,36				10734,4
8		Ургамал-Увс	37,47				1498,8
9		Цагаанхайрхан-Шилүүстэй	55,07				2202,8
10		Завханмандал-Дөрвөлжин	84,09				3363,6
11		Улиастай-Тосонцэнгэлийн замаас Идэр	26,31				1052,4
12		Нөмрөг-Сонгино чиглэлийн замаас Цэцэн-Уул	33,43				1337,2
13		Баянтэс-Тэс-Увс	76,03				3041,2
14		Цэцэн-Уул-Сантмаргац	47,95				1918
15		Баянхайрхан-Асгат	14,75				590
<b>Аймгийн нийт</b>			<b>1527,3</b>	<b>494,26</b>	<b>713,9</b>	<b>319,14</b>	<b>842992,8</b>


№	Байршил	Тоо /ш/	Тайлбар	Урт /м/	Хэрэгжүүлэх хугацаа	Хөрөнгө оруулалт, сая.төг
1	Ургамал сумд Төмөр бетонон гүүр	2	төлөвлөх	250	дундын	5000,0
2				200	хэтийн	4000,0
3	Алдархаан сумын Яруугийн голд	1	төлөвлөх	50	хэтийн	100,0
4	Цагаанчулуут сумын Төмөртийн голд	1	төлөвлөх	50	ойрын	100,0
5	Шилүүстэй сумын Завхан голд	1	төлөвлөх	200	хэтийн	4000,0
6	Цагаанчулуут сумын Дугантын гүүр	1	засварлах	50	ойрын	100,0
7	Дөрвөлжин сумын Завхан голд	2	төлөвлөх	200	дундын	4000,0
8	Дөрвөлжин сумын Завхан голд			150	дундын	3000,0
<b>Аймгийн нийт</b>		<b>8</b>		<b>1150</b>		<b>20300,0</b>



Зураг 231. Авто болон төмөр замын төлөвлөлт

Төлөвлөлтийн ойрын хугацаанд 398,59 км замыг хатуу хучилттай болгох, 95,67 км замыг сайжруулах, дундын хугацаанд 313,27 км замыг хатуу хучилттай болгох, 400,63 км замыг сайжруулах, 144,24 км төмөр зам тавих, хэтийн хугацаанд 102,62 км замыг хатуу хучилттай болгох, 216,52 замыг сайжруулсан зам, 201,66 км төмөр зам тавихаар төлөвлөсөн.





Зураг 232. Авто болон төмөр замын газрын төлөвлөлт, хэрэгжүүлэх хугацаагаар

**Төлөвлөлтийн ойрын хугацаа буюу 2018-2022** онд Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 179,52 км, Улиастай-Донойн нисэх онгоцны буудлыг холбох 110,99 км зам, аймгийн 4 замын уулзварыг-Нөмрөг, Сонгино сумын төвүүдтэй холбох 198,95 км замын хатуу хучилттай болгохоор төлөвлөсөн. Ингэснээр аймгийн төвөөр дамжин аялал жуулчлал хөгжих, ачаа эргэлт нэмэгдэх зэргээр эдийн засагт эерэгээр нөлөөлнө. Мөн Хөвсгөл-Завхан-баруун аймаг чиглэлийн аялал жуулчлалын маршрут гарах бүрэн боломжтой.

**Төлөвлөлтийн дундын хугацаа буюу 2023-2028** онд Түдэвтэй-Баянхайрхан-Баянтэс-Арц суурийн боомт чиглэлийн 113,24 км замыг хатуу хучилттай болгохоор төлөвлөсөн. Энэ замыг ашиглалтанд оруулсанаар ОХУ-тай хатуу хучилттай замаар хилийн гарцтай болж, гадаад худалдаа хөгжих боломжтой болно.

Улиастай-Цагаанхайрхан-Алтай чиглэлийн 101,86 км замыг хатуу хучилттай болгосноор Цагаанхайрхан сумын төв аймгийн төвтэй хатуу хучилттай замаар холбогдож, уг замаас Цагаанчулуут сумын төвийг 3,3 км замаар хатуу хучилттай болгохоор төлөвлөсөн.

**Төлөвлөлтийн хэтийн хугацаа буюу 2028-2033** онд Улиастай-Яруу-Улаагчны хар нуурын чиглэлийн 156,74 км замыг хатуу хучилттай болгохоор төлөвлөсөн. Энэ зам баригдсанаар Хар нуурын чиглэлд улсын хэмжээний аялал жуулчлал хөгжих бүрэн боломжтой болно.

Төлөвлөлтийн эцэст Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Алдархаан сумын төвүүд дээр нэмээд Улиастай, Нөмрөг, Сонгино, Түдэвтэй, Баянхайрхан, Баянтэс, Яруу, Цагаанхайрхан, Цагаанчулуут сумдын төвүүд хатуу хучилттай замд холбогдож, бусад 11 сумын төвүүд сайжруулсан замаар холбогдохоор төлөвлөсөн.

## Хүснэгт 157. Сумдын авто зам 2033 оны байдлаар

№	Авто замын чиглэл	Замын урт, км	Замын төрөл	Төлөвлөлтийн эцэст байх замын төрөл
1	Улиастай-Яруу	55,8	Хөрсөн зам	Хатуу хучилттай
2	Улиастай-Цагаанхайрхан	45,8	Хөрсөн зам	Хатуу хучилттай
3	Цагаанхайрхан-Отгон	77,4	Хөрсөн зам	Сайжруулсан зам
4	Цагаанхайрхан-Шилүүстэй	87,1	Хөрсөн зам	Сайжруулсан зам
5	Цагаанхайрхан-Цагаанчулуут	196,5	Хөрсөн зам	Хатуу хучилттай
6	Цагаанчулуут-Шилүүстэй	45,8	Хөрсөн зам	Хөрсөн зам
7	Улиастай-Алдархаан	29,5	Хатуу хучилттай	Хатуу хучилттай
8	Алдархаан-Дөрвөлжин	126,8	Хөрсөн зам	Хөрсөн зам
9	Алдархаан-Эрдэнэхайрхан	82,4	Хөрсөн зам	Сайжруулсан зам
10	Эрдэнэхайрхан-Завханмандал	51,0	Хөрсөн зам	Сайжруулсан зам
11	Завханмандал-Ургамал	67,2	Хөрсөн зам	Сайжруулсан зам
12	Завханмандал-Дөрвөлжин	84,09	Хөрсөн зам	Сайжруулсан зам
13	Улиастай-Тэлмэн	161,1	Сайжруулсан зам	Хатуу хучилттай
14	Тэлмэн-Тосонцэнгэл	59,5	Сайжруулсан зам	Хатуу хучилттай
15	Тосонцэнгэл-Их-Уул	45,1	Хатуу хучилттай	Хатуу хучилттай
16	Их-Уул	65,26	Хатуу хучилттай	Хатуу хучилттай
17	Тосонцэнгэл-Нөмрөг	106,0	Сайжруулсан зам	Хатуу хучилттай
18	Нөмрөг-Сонгино	86,1	Сайжруулсан зам	Хатуу хучилттай
19	Түдэвтэй	15,0	Шороон зам	Хатуу хучилттай
20	Түдэвтэй-Баянхайрхан	43,6	Шороон зам	Хатуу хучилттай
21	Баянхайрхан-Асгат	27,1	Шороон зам	Сайжруулсан зам
22	Баянхайрхан-Баянтэс	59,4	Шороон зам	Хатуу хучилттай
23	Баянтэс-Тэс	43,6	Шороон зам	Сайжруулсан зам

## 7.2.3 Төмөр болон авто замын хамгаалалтын зурвас газрын төлөвлөлт

Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх аргачилсан зааврын дагуу төмөр замд 120 м, улсын чанарта авто замд 100 м, орон нутгийн чанартай авто замд 60 м, аж ахуйн дотоодын зам 20 м-ээр хамгаалалтын зурвас газар төлөвлөсөн.

## Хүснэгт 158. Төмөр болон авто замын хамгаалалтын зурвас газар

№	Замын чиглэл	Замын урт, км	Замын төрөл	Хамгаалалтын зурвасын хэмжээ, м	Хамгаалалтын зурвасын талбай, га
<b>Нийт төмөр замын газар</b>		<b>345,9</b>			<b>8301,6</b>
1	Сэлэнгэ-Булган-Хөвсгөл-Завхан-ОХУ /Баянтэс-Арц суурийн боомт/	113,82	Төмөр зам	120	2731,68
2	Завхан-Увс-Баян-Өлгий-ОХУ /Баянтэс-Тэс/	73	Төмөр зам	120	1752
3	Сэлэнгэ-Булган-Хөвсгөл-Завхан /Их-Уул/	30,42	Төмөр зам	120	730,08
4	ОХУ-Монгол-БНХАУ /Завхан аймгийн Дөрвөлжин-Ургамал сумд/	128,66	Төмөр зам	120	3087,84
<b>Нийт улсын чанартай авто зам</b>		<b>968,66</b>			<b>9686,6</b>
5	Улиастай-Яруу	55,8	Хатуу хучилттай	100	558
6	Улиастай-Цагаанхайрхан	45,8	Хатуу хучилттай	100	458
7	Цагаанхайрхан-Цагаанчулуут	196,5	Хатуу хучилттай	100	1965
8	Улиастай-Алдархаан	29,5	Хатуу хучилттай	100	295
9	Баянхайрхан-Баянтэс	59,4	Хатуу хучилттай	100	594
10	Улиастай-Тэлмэн	161,1	Хатуу хучилттай	100	1611

11	Тэлмэн-Тосонцэнгэл	59,5	Хатуу хучилттай	100	595
12	Тосонцэнгэл-Их-Уул	45,1	Хатуу хучилттай	100	451
13	Их-Уул	65,26	Хатуу хучилттай	100	652,6
14	Тосонцэнгэл-Нөмрөг	106	Хатуу хучилттай	100	1060
15	Нөмрөг-Сонгино	86,1	Хатуу хучилттай	100	861
16	Түдэвтэй	15	Хатуу хучилттай	100	150
17	Түдэвтэй-Баянхайрхан	43,6	Хатуу хучилттай	100	436
<b>Нийт орон нутгийн чанартай авто зам</b>		<b>519,89</b>			<b>3119,34</b>
18	Цагаанхайрхан-Отгон	77,4	Сайжруулсан зам	60	464,4
19	Цагаанхайрхан-Шилүүстэй	87,1	Сайжруулсан зам	60	522,6
20	Алдархаан-Эрдэнэхайрхан	82,4	Сайжруулсан зам	60	494,4
21	Эрдэнэхайрхан-Завханмандал	51	Сайжруулсан зам	60	306
22	Завханмандал-Ургамал	67,2	Сайжруулсан зам	60	403,2
23	Завханмандал-Дөрвөлжин	84,09	Сайжруулсан зам	60	504,54
24	Баянхайрхан-Асгат	27,1	Сайжруулсан зам	60	162,6
25	Баянтэс-Тэс	43,6	Сайжруулсан зам	60	261,6
<b>Нийт аж ахуйн дотоодын авто зам</b>		<b>172,6</b>			
26	Цагаанчулуут-Шилүүстэй	45,8	Хөрсөн зам		
27	Алдархаан-Дөрвөлжин	126,8	Хөрсөн зам		

#### 7.2.4 Экологийн гарцын төлөвлөлт

Экологийн гарц гэдэг нь авто болон төмөр зам дагуу нүүдлийн зэрлэг ан амьтдын чөлөөтэй зорчих нөхцөлийг хангасан гарцыг хэлэх бөгөөд замын сүлжээ тэлэх тусам нутаг дэвсгэр янз бүрийн хэсгүүдэд хуваагдан, зэрлэг ан амьтдын шилжилт хөдөлгөөнд сөрөг нөлөө үзүүлэн, устаж үгүй болох аюул нүүрлэдэг байна.

Экологийн гарцын үндсэн үүрэг нь:

- Зэрлэг ан амьтдын нүүдэллэх таатай нөхцөлийг бүрдүүлэх
- Тухайн газар нутгийн амьтдыг хамгаалах, популяцийн өөрчлөлтөнд орохоос сэргийлэх
- Экологийн цөм харилцааг бий болгох
- Бэлчээрийн малыг нүүдэллэх таатай нөхцөлийг хангах
- Мал, ан амьтдыг эрсдэлд оруулахаас урьдчилан сэргийлэх

Завхан аймгийн хойд болон зүүн, төвийн хэсгийн нутаг дэвсгэр нь аргаль, янгирийн нутаг, баруун хэсэг нь хулан жороо, цагаан зээрийн гол нутаглах газар тул төлөвлөж буй төмөр зам, хатуу хучилттай замууд нь амьтдын амьдрах нутаг дэвсгэрийг хэд хэдэн хэсгүүдэд хувааж байна. Иймд 2015 онд батлагдсан Монгол улсын стандарт MNS 6515:2015 /Тал, хээр, говь, цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц/-ын дагуу хот суурин, ашиглалтын лиценз бүхий уурхайн эдэлбэр газраас 5 км радиус дотор экологийн гарц төлөвлөхгүй байх заалтыг баримтлан, олон улсын стандартыг мөрдлөг болгон 25-50 км тутамд улсын чанартай авто болон, төмөр зам дагуу нийт 17 байрлалд экологийн гарц төлөвлөсөн. Төлөвлөлтийн байршлыг сонгохдоо ландшафтын тогтоц, зэрлэг ан амьтдын тархац нутаг, байршлыг харгалзсан.

Хүснэгт 159. Төлөвлөж буй экологийн гарцын байршил

№	Сумын нэр	Төлөвлөж буй газрын нэр	Координат	
			Уртраг	Өргөрөг
1	Алдархаан	Загастайн даваа, хатуу хучилттай	97°10'11.69"	48°04'17.07"

		замаар нэвтрэх		
2	Алдархаан	Ганцын даваа, хатуу хучилттай замаар нэвтрэх	96°55'11.80"	47°37'13.90"
3	Асгат	Хүйсийн хөндий, төмөр замаар нэвтрэх	96°44'01.63"	49°37'05.64"
4	Баянтэс	Модот уулын баруун талд, хатуу хучилттай авто замаар нэвтрэх	96°21'16.33"	49°35'14.81"
5	Баянтэс	Могой голын элс, төмөр замаар нэвтрэх	95°59'57.41"	49°51'10.39"
6	Баянхайрхан	Дөрөлж уулын баруун талд, төмөр замаар нэвтрэх	96°02'35.71"	49°30'30.60"
7	Дөрвөлжин	Байшинтын эргийн голын урд, төмөр замаар нэвтрэх	93°33'04.88"	48°22'50.87"
8	Дөрвөлжин	Бор хошууны зүүн хойд талд, төмөр замаар нэвтрэх	93°25'13.61"	48°07'52.44"
9	Идэр	Шургахын улаан үзүүр, хатуу хучилттай замаар нэвтрэх	97°23'15.75"	48°25'39.67"
10	Сонгино	Тариатын булаг, хатуу хучилттай авто замаар нэвтрэх	95°36'50.49"	48°57'31.75"
11	Түдэвтэй	Талын улаан хоолой, хатуу хучилттай авто замаар нэвтрэх	96°21'18.05"	48°53'50.64"
12	Түдэвтэй	Их-Улаан уулын урд, хатуу хучилттай авто замаар нэвтрэх	96°27'25.09"	49°01'57.63"
13	Цагаанчулуут	Ембүүгийн хөндий, хатуу хучилттай зам	96°47'51.23"	47°01'20.42"
14	Цагаанхайрхан	Мэргэн сонгино уул, хатуу хучилттай зам	96°45'27.78"	47°20'49.15"
15	Ургамал	Хар үзүүрийн тал, төмөр замаар нэвтрэх	93°51'00.00"	48°30'29.76"
16	Ургамал	Духын бэл, төмөр замаар нэвтрэх	94°06'29.35"	48°39'48.02"
17	Яруу	Уужим булгийн даваа	96°34'29.60"	48°13'53.26"

Сэлэнгэ-Булган-Хөвсгөл-Завхан-ОХУ /Баянтэс-Арц суурийн боомт/ чиглэлийн 113,82 км төмөр замд 2 экологийн гарц, Завхан-Увс-Баян-Өлгий-ОХУ /Баянтэс-Тэс/ чиглэлийн 73 км камд 1 экологийн гарц, төмөр замын баруун коридорын дагуу /Завхан аймгийн Дөрвөлжин-Ургамал сумд/ 4 экологийн гарц төлөвлөсөн.

Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 182,49 км улсын чанартай зам дагуу 2 экологийн гарц, Улиастай-Цагаанхайрхан-Алтай хот чиглэлийн 115,31 км замд 3 экологийн гарц, Улиастай-Яруу-Улаагчны хар нуур чиглэлийн 102,62 км замд 1 экологийн гарц, замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 216,1 км замд 2 экологийн гарц, Түдэвтэй-Баянхайрхан-Баянтэс-Арц суурийн боомт чиглэлийн 184,92 км замд 2 экологийн гарц төлөвлөсөн /Зураг 120/.

### 7.3 ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

*Үндэслэл: 2010 оны УИХ-аас баталсан Концессийн гэрээ болон төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого /2015-2030 он/-ыг үндэслэсэн.*

#### Эрчим хүчний шугам сүлжээ:

2015 онд Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг 2015-2030 оны баримжаатайгаар батлан мөрдөж байгаа бөгөөд бодлогын эхний үе шат нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний ойрын хугацаатай, бодлогын 2-р үе шат нь ерөнхий төлөвлөгөөний дундын болон хэтийн хугацаатай ойролцоо төлөвлөгдсөн байна.



Зураг 233. Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системийн төлөвлөлт /2015-2030 он/

**Нэгдүгээр үе шат /2015-2023 он/:** Түлш, эрчим хүчний эх үүсвэрийн чадлын нөөцийг бүрдүүлж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх суурийг бий болгох, эрчим хүчний нормативын баримт бичгийн тогтолцоог төгөлдөржүүлж, олон улсын стандартыг нутагшуулах, эрх зүйн орчныг сайжруулах зорилт тавин дараахь арга хэмжээнүүдийг төлөвлөсөн байна. Үүнд:

- Монгол Улсын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадлыг хоёр дахин нэмэгдүүлж, үр ашиг өндөртэй өндөр параметрийн тоноглолыг ашиглаж эхлэх бөгөөд нийт суурилагдсан чадлын 10-аас доошгүй хувийг усны эх үүсвэрээр бүрдүүлж, нөөц чадлыг 10 хувьд хүргэн, сэргээгдэх эрчим хүчийг эрчимтэй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Баруун бүсэд дулааны цахилгаан станц, Ховд голд усан цахилгаан станц, зүүн бүсэд Дорнодын дулааны цахилгаан станц баригдсан байх
- Багануур-Чойр, Улаанбаатар-Мандалговь, Багануур-Улаанбаатар, Багануур-Өндөрхаан- Чойбалсан, Чойр-Сайншанд, Мандалговь Арвайхээр, Дөргөн-Улиастай-Улаанбаатарын бүс нутгийг Холбосон цахилгаан дамжуулах агаарын шугамууд баригдсан байх

**Хоёрдугаар үе шат /2024-2030 он/:** Энэ хугацаанд цахилгаан, эрчим хүч экспортлох, сэргээгдэх эрчим хүчийг тогтвортой хөгжүүлэх зорилт тавин дараах арга хэмжээг төлөвлөсөн байна.

- Монгол Улсын эрчим хүчний эх үүсвэрийн аюулгүйн нөөцийг 20-оос доошгүй хувьд хүргэж, нийт суурилагдсан чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээ 30 хувьд хүрнэ.

- Бүсүүдийг өндөр хүчин чадалтай цахилгаан дамжуулах шугамаар холбож, мэдээллийн хяналт удирдлагыг цогц систем бүхий эрчим хүчний нэгдсэн ухаалаг системийг бий болгоно.
- Хөрш орнуудтай их чадлын тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугамаар холбогдож цахилгаан эрчим хүч экспортлох үе.
- Монгол Улсыг бүхэлд нь хамарсан эрчим хүчний нэгдсэн систем байгуулагдсан байх

Дээрх бодлогын хүрээнд Завхан аймгийн нутаг дэвсгэрт 100 мв-ын хүчин чадалтай Дулааны цахилгааны станц байгуулах, Монгол улсын эрчим хүчний нэгдсэн системд холбогдох ЦДАШ-уудыг төлөвлөсөн.

Монгол улсын Засгийн газрын Төрийн өмчийн хороотой 2011 онд байгуулсан концессийн гэрээний дагуу Тэлмэн сумын Хүрэн талын хөндийд 100мВ-ын хүчин чадалтай ДЦС-ыг /шууд үлээлгийн системтэй, тоосруулах галын хотолтой 2 зуухтай, 50 МВт-ын конденсацийн 2 турбинтэй, иж бүрэн автомат удирдлагатай, агаарын хөргөлттэй, ус бага хэрэглэдэг, байгаль орчинд ээлтэй технологитой/ төлөвлөлтийн ойрын хугацаанд барихаар шийдвэрлэсэн.

Уг ДЦС-ыг байгуулсанаар:

- Завхан, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн алслагдсан бүс нутгийн хэрэглэгчид найдвартай, тасралтгүй, чанартай цахилгаан эрчим хүчээр хангагдана.
- Дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ өснө.
- Баруун бүсийн эрчим хүчний систем нэгдсэн системд холбогдоно.
- ОАТ, ХХОАТ, НДШ-ээр улсын болон орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ.
- Нийгмийн суурь үйлчилгээг ард иргэдэд хүргэснээр тэдний амьдрах ая тух сайжрахаас гадна төрөл бүрийн бизнес, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломж нээгдэнэ.
- Орон нутгийн дэд бүтэц сайжирна.
- Залуучуудын нийгмийн оролцоог дээшлүүлнэ.

Ажлын байр нэмэгдэж хөдөөнөөс хот руу шилжигсдийн тоог бууруулж, амьжиргааны түвшин дээшилнэ.

Хүснэгт 160. Эрчим хүчний шугам сүлжээ, станцын төлөвлөлт

№	Төлөвлөж буй ЦДАШ-ийн чиглэл	Хүчин чадал, кВ	Шугамын урт, км	Нэгжийн зардал, сая. төг	Хөрөнгө оруулалт, тэрбум.төг
<b>Цахилгаан станц</b>					
1	Тэлмэний дулааны цахилгаан станц	100мВ	205,0 га	444800,0	448,8
<b>Цахилгаан дамжуулах шугам</b>					
1	Эрдэнэхайрхан-Завханмандал-Ургамал-Дөрвөлжин	15	141,29	27,179	3,84
2	Говь-Алтай-Шилүүстэй-Баянхонгор	110	40,99	291,87	11,96
3	Улиастай-Дөргөн-Ховдын Мянгад сум	500	535,71	335,795	179,89
4	Улаанбаатар-Архангай-Тэлмэн	600	257,35	335,795	86,42
<b>Нийт</b>					<b>730,91</b>

Төлөвлөлтийн ойрын хугацаанд Тэлмэний Дулааны цахилгаан станцийг барих, Улаанбаатар-Архангай-Тэлмэн чиглэлийн 600кВ-ийн ЦДАШ-ийг байгуулахаар

төлөвлөсөн. Дундын хугацаанд Эрдэнэхайрхан-Завханмандал-Ургамал-Дөрвөлжин чиглэлийн 10 кВ-ийн ЦДАШ, Говь-Алтай-Шилүүстэй-Баянхонгор чиглэлийн 110кВ-ийн ЦДАШ болон хэтийн хугацаанд Улиастайгаас Дөргөн, Ховдын Мянгад сум чиглэлийн 500кВ-ийн ЦДАШ-ийг байгуулахаар төлөвлөсөн.

### Холбооны шугам:

Одоогийн байдлаар Отгон сумаас бусад бүх сумд аймгийн төвтэйгээ шилэн кабелиар холбогдсон бөгөөд төлөвлөлтийн ойрын хугацаанд Шилүүстэй-Отгон чиглэлийн 10 кВ-ийн хүчдэлтэй, XLPE тусгаарлагчтай, хөнгөн цагаан судалтай, сувагт 1 кабельд холбохоор төлөвлөсөн.

Хүснэгт 161. Холбооны шугамын төлөвлөлт

№	Чиглэл	Шилэн кабелийн урт, км	Төлөвлөлтийн хугацаа	Нэгжийн зардал, сая. төг	Хөрөнгө оруулалт, тэрбум.төг
1	Шилүүстэй-Отгон	55,51	Ойрын	61,428	3,41

### Шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсийн төлөвлөлт:

Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй бадлыг хангах, хүн, амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-д зааснаар аймгийн хэмжээнд одоо байгаа болон төлөвлөж буй ЦДАШ—ийн хамгаалалтын бүсийг төлөвлөсөн.

Хүснэгт 162. Одоогийн шугам сүлжээний газрын хамгаалалтийн бүсийн төлөвлөлт

№	Шугам сүлжээний чиглэл болон дэд станц	Шугамын хүчин чадал, кВт	Шугамын урт, км	Хамгаалалтын зурвасын өргөн, м	Талбай, га
<i>Цахилгаан дамжуулах агаарын шугам</i>					
1	Богдын голын УЦС-Улиастай	35	36	14	41,0
2	Улиастай-Донойн хөндий	20	25	25	50,0
3	Улиастай-Цагаанхайрхан-Цагаанчулуут	110	105	98	420,0
4	Алдархаан-Яруу-Эрдэнэхайрхан-Завханмандал-Дөрвөлжин	220	278	230,55	1390,0
5	Архангай-Их-Уул-Тосонцэнгэл-Тэлмэн-Идэр-Алдархаан	400	278	230,55	1668,0
6	Галуутайн УЦС-Сантмаргац	10	25	18	35,0
7	Галуутайн УЦС-Цэцэн-Уул	10	25	25	51,0
8	Хүнгүйн УЦС-Эрдэнэхайрхан	10	20	39	79,0
9	Хүнгүйн УЦС-Завханмандал	10	12	12	24,0
<i>Цахилгаан станц</i>					
1	Богдын голын УЦС	200		25	0,19
2	Тосонцэнгэлийн УЦС	210+165		30	0,28
3	Хүнгүйн УЦС	250		25	0,19
4	Галуутайн УЦС	250		25	0,19
5	"Тэлмэн" дэд станц	110/35/10		20	0,13
6	"Улиастай" дэд станц	110/35/10		20	0,13
<i>Кабелийн шугам</i>					
1	Архангай-Их-Уул-Тосонцэнгэл-Тэлмэн-Идэр-Яруу-Улиастай		495,53	2	198,21
2	Улиастай-Цагаанхайрхан-Цагаанчулуут		88,35	2	35,34


3	Улиастай-Алдархаан-Эрдэнэхайрхан-Завханмандал-Ургамал		216,69	2	86,68
4	Завханмандал-Дөрвөлжин		74,56	2	29,82
5	Тэлмэн-Нөмрөг-Түдэвтэй-Сонгино-Увс		163,51	2	65,40
6	Түдэвтэй-Баянхайрхан-Асгат-Баянтэс-Тэс		136,38	2	54,55
7	Сонгино-Цэцэн-Уул-Сантмаргац		75,2	2	30,08
8	Говь-Алтай-Шилүүстэй-Баянхонгор		42,54	2	17,02

Хүснэгт 163. Төлөвлөсөн шугам сүлжээний газрын хамгаалалтын бүсийн төлөвлөлт

№	Шугам сүлжээний чиглэл болон дэд станц	Шугамын хүчин чадал, кВт	Шугамын урт, км	Хамгаалалтын зурвасын өргөн, м	Талбай, га
<i>Цахилгаан дамжуулах агаарын шугам</i>					
1	Эрдэнэхайрхан-Завханмандал-Ургамал-Дөрвөлжин	15	141,29	10	282,6
2	Говь-Алтай-Шилүүстэй-Баянхонгор	110	40,99	20	164,0
3	Улиастай-Дөргөн-Ховдын Мянгад сум	500	535,71	30	3214,3
4	Улаанбаатар-Архангай-Тэлмэн	600	257,35	30	1544,1
<i>Цахилгаан станц</i>					
1	Тэлмэний Дулааны цахилгаан станц	100 мВ	205 га	30	218,0
<i>Кабелийн шугам</i>					
1	Шилүүстэй-Отгон		55,51	2	20,25

Энэ зурвас газарт ямар ч байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд эдэлбэр газар олгох, дур мэдэн барилга байгууламж, хашаа гэр, агуулах сав барих, мал амьтан үржүүлэх, бэлчээх болон бусад ямар ч ажил үйлчилгээ хийхийг хатуу хориглосон байдаг.





Зураг 234. Шугам сүлжээний газрын төлөвлөлт

## 7.4 ЗАМ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТАЛБАЙН БАЛАНС

### Хөрөнгө оруулалт:

Шугам сүлжээний газрын төлөвлөлтийн дагуу хөрөнгө оруулалтыг тооцохдоо Эрчим хүчний яамны 2014 оны 01/14 дугаар ажлын даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн захирлын 2014 оны 14/62 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулаан дамжуулах шугам, дэд станц, дулаан дамжуулах төвийн угсралтын ажлын нэгж хүчин чадлын жишиг үнэ боловсруулах ажлыг гүйцэтгэх аргачлал”-ыг баримтлан цахилгаан, дулаан дамжуулах шугам, дэд станц, дулаан дамжуулах төвийн угсралтын ажлын нэгж хүчин чадлын төсөвт өртгийг барилга байгууламжийн нэр төрөл тус бүрээр тооцоолж гаргав.

Зам, шугам сүлжээг сайжруулахад ойрын хугацаанд 1029,83 тэрбум төг, дундын хугацаанд 291,9 тэрбум төг, хэтийн хугацаанд 1624,89 тэрбум төг-ийн хөрөнгө оруулалт шаардлагатай болно.

Хүснэгт 137. Төлөвлөсөн зам, шугам сүлжээний хөрөнгө оруулалтын тооцоо

№	Төлөвлөж буй авто замын төрөл	Замын урт, км	Нэгжийн зардал, сая төг	Хөрөнгө оруулалт, тэрбум төг /хэрэгжүүлэх хугацаагаар/			
				Нийт	Ойрын 2022 он	Дундын 2028 он	Хэтийн 2033 он
1	Төмөр зам	408,32	3185,0	1300,5	-	31,2	1269,3
2	Хатуу хучилттай болгох	861,3	1000,0	861,3	489,2	215,3	156,8
3	Сайжруулсан зам болгох	753,63	40,0	31,5	4,0	17,6	9,9

4	Гүүр	1150м	20,0	23,0	2,0	12,0	9,0
5	Дулааны цахилгаан станц	205 га	444800,0	444,8	444,8	-	-
6	15/110/500/600 кВ-ын ЦДАШ	975,34	27,179-335,795	282,11	86,42	15,8	179,89
7	Шилэн кабель	55,51	61,428	3,41	3,41	-	-
<b>Аймгийн нийт</b>				<b>2949,62</b>	<b>1029,83</b>	<b>291,9</b>	<b>1624,89</b>

### Талбайн баланс:

Аймгийн хэмжээнд шинээр зам төлөвлөснөөр 2033 онд төмөр замын газар 5199,72 га-аар, авто замын газар 9299,56 га-аар, шугам сүлжээний газар 5648,25 га-аар нэмэгдэж, агаарын тээврийн зориулалттай газар төдийлэн нэмэгдэхгүй болно.

Хүснэгт 138. Төлөвлөсөн дэд бүтцийн газрын талбай, га

Зам шугам сүлжээний газрын дэд ангилал		2016 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар	Төлөвлөлтөөр /2033 он/	Зөрүү, +, -
<b>Авто замын газар, бүгд</b>		<b>4726,54</b>	<b>13104,94</b>	<b>+8378,4</b>
Үүнээс	Улсын чанартай	0	9686,6	+9686,6
	Орон нутгийн чанартай	4139,62	3119,34	-1020,28
	Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын зориулалттай	586,92	299,0	-287,92
	Авто тээврийн барилга байгууламж, зогсоолын талбай	-	-	-
<b>Төмөр замын газар, бүгд</b>		<b>-</b>	<b>8601,6</b>	<b>+8601,6</b>
Үүнээс	Төмөр замын далангийн талбай, хамгаалалтын зурвас газар	-	8301,6	+8301,6
	Өртөө зөрлөгийн барилга байгууламжийн талбай	-	300	+300
<b>Агаарын тээврийн газар, бүгд</b>		<b>206</b>	<b>206</b>	<b>0</b>
Үүнээс	Нислэгийн аюулгүй байдлыг хамгаалах бүсийн газар	206	206	0
	Барилга байгууламж, төхөөрөмжийн газар	-	-	-
<b>Шугам сүлжээний газар, бүгд</b>		<b>1570,39</b>	<b>7218,64</b>	<b>+5648,25</b>
Үүнээс	Холбооны шугам, холбоо мэдээлэл	808,34	828,59	+20,25
	Эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай	762,05	6390,05	+5628,0
	Ус, дулаан дамжуулах хоолойн эзлэх талбай	-	-	-
	Ус шахах, өргөх байгууламжийн доорхи газар	-	-	-
	Үерээс хамгаалах далан, сувгийн эзлэх талбай	-	-	-
<b>Нийт</b>		<b>6502,93</b>	<b>29131,18</b>	<b>+22628,25</b>

## **НАЙМ. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**

Улсын тусгай хэрэгцээний газарт улсын тусгай хамгаалалттай газар, улсын хилийн зурвас газар, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар, шинжлэх ухаан технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай, аймаг дундын отрын бэлчээр, улсын тэжээлийн сангийн хадлангын талбай, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай, чөлөөт бүсийн газар, цөмийн төхөөрөмж барих ашиглах зориулалтаар олгосон газар, бичил уурхайн зориулалтаар олгосон газар, хилийн боомтын бүс, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар хамаарна.

### **8.1 ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН НӨӨЦ, НӨХЦӨЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

Улсын Их хурлаас баталсан “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” (1998), “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр” (1998), “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” (2001), “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтууд” (2008), “Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний цогц бодлого” (2008), “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (2008), “Ус үндэсний хөтөлбөр” (2010), Ногоон хөгжлийн бодлого” (2014), Завхан аймгийн ИТХ-аас баталсан “Завхан аймгийн хөгжлийн цогц бодлого” (2009), Байгаль орчин аялал жуулчлалын яамны “Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх боломж” (2016), “Монгол орны хангай, хөвсгөлийн экологийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь” (2017), Байгаль орчин аялал жуулчлалын яам, Газрын харилцаа геодези зураг зүйн газрын хамтарсан “Монгол алтайн нуруу, их нууруудын хотгор, нууруудын хөндийн экологийн бүс нутагт хөгжлийг байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх нь” (2017) зэрэг томоохон баримт бичигт байгалийн бүс бүслүүрийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, түүх соёлын үнэт өв, ховордсон амьтан, ургамлыг хамгаалахад онцгой ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалалтад авч түүний нэгдсэн сүлжээг бүрдүүлэн өргөжүүлэх, уг газар нутгийн хамгаалалтын менежментийг дэлхий жишигт хүргэх бодлогын цогц зорилтуудыг тусгажээ.


Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэж ангилна. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар гэж тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, нэн ховор, ховор амьтан, ургамал, түүх соёлын дурсгалт, үнэт зүйлсийг хадгалан хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх, тогтвортой ашиглах зорилгоор аймаг, сумын хамгаалалтад авсан газрыг хэлэх бөгөөд зориулалтаар нь:

1. Байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц бүхий газар
2. Нэн ховор, ховор амьтан, ургамлын хамгаалалттай газар
3. Байгалийн нөөц газар
4. Ойн хамгаалах хамгаалалттай газар
5. Усны хамгаалалттай газар

6. Түүх, соёлын дурсгалт газар
7. Амралт, сувилал, аялал жуулчлалын газар
8. Ан агнуурын бүс нутаг
9. Доройтсон орчныг нөхөн сэргээх газар
10. Ард иргэдийн шашин, шүтлэгтэй мод, хад, хайрханыг хамгаалах газар гэж тус тус ангилна.

Завхан аймагт Отгонтэнгэрийн дархан цаазат газар, Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газар, Улаагчны хар нуурын байгалийн цогцолборт газар, Багахайрханы байгалийн цогцолборт газар, Хар ус нуурийн байгалийн цогцолборт газар, Увс нуурын ай сав-Алтан элс байгалийн цогцолборт газраас гадна 113,2 мян. га орон нутгийн тусгай хамгаалалттай газар байна.

Одоогийн байдлаар газрын нэгдмэл сангийн тайланд аймгийн нийт нутаг дэвсгэрийн 7,05 хувь буюу 581369,0 га талбайг улсын тусгай хамгаалалттай газар эзэлнэ гэж байгаа боловч ГЗБГЗЗГ-ын мэдээллийн санд уг газар нь 905107,22 га буюу 11,0 хувийг эзэлж байна. Завхан аймгийн хувьд 2016 оны байдлаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 905,1 мянган га, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 113,3 мянган га бөгөөд нийтдээ 1 сая талбайд хүрч байна.



Зураг 235. Завхан аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн өнөөгийн байдал

Хүснэгт 164. Завхан аймгийн улсын тусгай хамгаалалттай газрын талбай, га

№	Улсын тусгай хамгаалалттай газрын ангилал	ГНС-ийн тайлангаар	ГЗБГЗЗГ-ийн мэдээллийн сангаар	Зөрүү
1	Дархан цаазтай газар	95510	89825,49	-5684,51
2	Байгалийн цогцолборт газар	485859	815281,73	329422,73
3	Байгалийн нөөц газар	0	0	0

4	Дурсгалт газар	0	0	0
	Нийт	581369	905107,22	323738,22

Монгол улс тогтвортой хөгжлийн зорилтдоо улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад 2032 он гэхэд нийт нутаг дэвсгэрийнхээ 30 хувийг авах зорилт тавьсан бөгөөд энэхүү зорилтыг хэрэгжүүлэхдээ байгалийн үзэсгэлэнт ландшафт тогтоц бүхий газар нутаг, байгалийн ховор ургамал, ан амьтан, түүх соёлын үнэт өв, дурсгал зэргийг харгалзсан бөгөөд мөн түүнчлэн “TNC” олон улсын байгууллагын хийсэн судалгаа шинжилгээнд тулгуурлан нийт нутаг дэвсгэрийн 46 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авахаар төлөвлөлөө.


Хууль тогтоомжийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх дараах төлөвлөлтийг хийж байна.

1. Улсын тусгай хамгаалалтад 10 байрлалд нийт **14255662,2** га газрыг 3 үе шаттайгаар хамрууллаа. Ингэснээр байгалийн үндсэн бүс бүслүүрийн унаган төрхийг хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой үүрэг гүйцэтгэнэ.
2. Аймгийн тусгай хамгаалалтад 6 байрлалд нийт **433109.3** га газрыг 3 үе шаттайгаар хамрууллаа. Ингэснээр экологийн тэнцлийг хадгалах, биологийн олон янз байдлыг хамгаалах, доройтсон газар нутгийг байгалийн жамаар нөхөн сэргээх боломжийг хангана. Үүнээс 427947,82 га талбай ангилал дээшилж дунд болон хэтийн хугацаанд улсын тусгай хамгаалалтад шилжинэ.
3. Сумын тусгай хамгаалалтад 163 байрлалд нийт **1307870,57** га газрыг төлөвлөлтийн үе шатуудад хамгаалалтад авахаар төлөвлөлөө. Ингэснээр бүс нутгийн байгалийн унаган төрхийг хадгалаад зогсохгүй биологийн төрөл зүйл болон газар нутгийн доройтлыг бууруулах, аялал жуулчлалыг дэмжих эерэг үзүүлнэ.

УТХ	Улсын тусгай хамгаалалттай газар	V	Усны хамгаалалттай газар
АТХ	Аймгийн тусгай хамгаалалттай газар	VI	Түүх, соёлын дурсгалт газар
СТХ	Сумын тусгай хамгаалалттай газар	VII	Амралт, сувилал аялал жуулчлалын газар
I	Байгалийн унаган төрх өвөрмөц тогтоц бүхий газар	VIII	Ан агнуурын бүс нутаг
II	Нэн ховор, ховор амьтан, ургамлын хамгаалалттай газар	IX	Доройтсон орчны нөхөн сэргээх газар
III	Байгалийн нөөц газар	X	Ард иргэдийн шашин шүтлэгтэй мод, хад, хайрханыг хамгаалах газар
IV	Ойн хамгаалах хамгаалалттай газар		

### 8.1.1 Улсын тусгай хамгаалалттай газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн эхний үе шатанд улсын тусгай хамгаалалттай газар нутагт Отгонтэнгэрийн дархан цаазат газрын өргөтгөл, Булнайн нуруу, Тарвагатайн нурууны өргөтгөл, Хомын талыг хамруулахаар төлөвлөлөө. Төлөвлөлтийн 2-р үе шатанд Ойгон нуур, Дөрвөлжин уул, Шилүүстэй, Цонхогийн хоолойг хамруулах бол төлөвлөлтийн 3-р үе шатанд Тэсийн гол-1, Тэсийн гол-2, Дугант их мянганы уулсыг тус тус улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамруулахаар төлөвлөлөө.



Зураг 236. Улсын тусгай хамгаалалттай газрын төлөвлөлт

Хүснэгт 15. 2018-2022 онд (1-р үе шат) улсын тусгай хамгаалалтад авах газрын жагсаалт

№	Газрын нэр	Харьяалагдах сум	Талбай, га	Зэрэглэл	Ангилал
1	Отгонгэрийн ДЦГ-ийн өргөтгөл	Отгон	367914,43	УТХ	ДЦГ
2	Булнай нуруу	Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул	192046,82	УТХ	БЦГ
3	Тарвагатайн нурууны өргөтгөл	Идэр, Тосонцэнгэл	228683,82	УТХ	БЦГ
4	Хомын тал	Дөрвөлжин	212849,96	УТХ	БЦГ
<b>2018-2022</b>			<b>1001495,03</b>		

Хүснэгт 16. 2023-2029 онд (2-р үе шат) улсын тусгай хамгаалалтад авах газрын жагсаалт

№	Газрын нэр	Харьяалагдах сум	Талбай, га	Зэрэглэл	Ангилал
1	Ойгон нуур	Түдэвтэй	68884,8	Улсын	БЦГ
2	Шилүүстэй	Шилүүстэй, Отгон	144626,44	Улсын	БЦГ
3	Дөрвөлжин уул	Дөрвөлжин, Ургамал, Завханмандал	43137,54	Улсын	БЦГ
4	Цонхгийн хоолой	Дөрвөлжин	46466,08	Улсын	БЦГ
<b>2023-2029</b>			<b>303114,86</b>		


Хүснэгт 17. 2029-2033 онд (3-р үе шат) улсын тусгай хамгаалалтад авах газрын жагсаалт

№	Газрын нэр	Харьяалагдах сум	Талбай, га	Зэрэглэл	Ангилал
1	Тэсийн гол-1	Баянтэс	34914,39	Улсын	БЦГ

2	Тэсийн гол-2	Баянтэс	3032,51	Улсын	БЦГ
3	Дугант-Их Мянган	Шилүүстэй, Цагаанчулуут	83105,41	Улсын	БЦГ
<b>2029-2033</b>			<b>121052,31</b>		
<b>Улсын тусгай хамгаалалтанд авах нийт талбай</b>			<b>1425662,2</b>		

### 8.1.2 Аймгийн тусгай хамгаалалттай газрын нөөц, нөхцөлийн төлөвлөлт

Аймгийн тусгай хамгаалалттай газар нутагт нийт 8 байршлын 433,1 мянган га газрын авах бөгөөд эдгээр газрууд нь газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дунд болон хэтийн хугацаанд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд орж зэрэглэлийг дээшлүүлэхээр төлөвлөлтөд тусгалаа.



Зураг 237. Аймгийн тусгай хамгаалалтад авах газрын төлөвлөлт

Хүснэгт 18. 2018-2022 онд (1-р үе шат) аймгийн тусгай хамгаалалтад авах газрын жагсаалт

№	Газрын нэр	Харьяалагдах сум	Талбай, га	Зэрэглэл	Ангилал
1	Ойгон нуур		68884,8	АТХ	Байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц бүхий газар
2	Шилүүстэй	Шилүүстэй	144626,44	АТХ	
3	Дөрвөлжин уул	Дөрвөлжин	43137,54	АТХ	
4	Цонхогийн хоолой		46466,08	АТХ	
<b>2018-2022</b>			<b>303114,86</b>		

Хүснэгт 19. 2023-2029 онд (2-р үе шат) аймгийн тусгай хамгаалалтад авах газрын жагсаалт

№	Газрын нэр	Харьяалагдах сум	Талбай, га	Зэрэглэл	Ангилал


1	Хөтөл Ус	Завханмандал, Ургамал	3834,26	АТХ	Байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц бүхий газар
2	Тэсийн гол		37946,9	АТХ	
3	Дугант их мянган		83105,41	АТХ	
<b>2023-2029</b>			<b>125992,53</b>		

Хүснэгт 20. 2029-2033 онд (3-р үе шат) аймгийн тусгай хамгаалалтад авах газрын жагсаалт

№	Газрын нэр	Харьяалагдах сум	Талбай, га	Зэрэглэл	Ангилал
1	Аргалын ар, Шар хад	Завханмандал, Ургамал	5797,87	АТХ	Байгалийн нөөц газар
<b>2029-2033</b>			<b>5797,87</b>		
<b>Аймгийн тусгай хамгаалалтанд авах нийт талбай</b>			<b>433109,3</b>		

### 8.1.3 Сум, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц нөхцөлийн төлөвлөлт

Сумын буюу орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт нийт 163 байршлын 1751,7 мянган га газрын авахаар төлөвлөсөн бөгөөд орон нутгийн санал болон түүх соёлын дурсгал, байгалийн тогтоц, ховор ан амьтны тархалт зэргийг харгалзан сонгон авлаа. Төлөвлөлтийн хугацаанд зарим орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг зэрэглэл дээшилж улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд орох тул газрын нэгдсэн тооцооллыг хасагдсан дүнгээр нь оруулсан болно.



Зураг 238. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газрын төлөвлөлт



